

Мал аж ахуйн Онцгой байдалд баримтлах Заавар, Стандартууд

Гурав дахь хэвлэл



Мал аж ахуйн Онцгой байдалд баримтлах Заавар, Стандартууд

Гурав дахь хэвлэл

Монгол хэлрүү хөрвүүлсэн баг:

Орчуулгын багийг Б.Энхтуяа ахлан, энэхүү гарын авлагын 1,2 дугаар бүлгийг С.Лхагвацэрэн (Мал эмнэлгийн ухааны доктор), 3,4 дүгээр бүлгийг Д.Мөнхтуяа (Гамшгийн удирдлагын магистр), хавтас, эхлэл хэсэг, 5 дугаар бүлгийг Б.Энхтуяа (LEGS-н итгэмжлэгдсэн сургагч), 6 дугаар бүлгийг Ц.Пүрэвхүү (Мал эмнэлгийн ухааны доктор), 7,8 дугаар бүлгийг Ө.Эрдэнэбилэг (Мал эмнэлгийн ухааны доктор) 9 дүгээр бүлэг, хавсралт хэсгийг Д.Ганхуяг (Орчуулагч) нар орчуулав.

Орчуулгыг шүүн тунгаасан: LEGS-н итгэмжлэгдсэн сургагч багш нар: С.Жигжидпүрэв (НҮБ-ын ХХААБ), Н.Өлзиймаа (Дэлхийн Зөн Монгол)



LEGS

Практикал Акшн Паблишинг компани (Practical Action Publishing Ltd)
Альберт 25 гудамж, Рагби, Варвикшир, Их Британи

www.practicalactionpublishing.com

© Мал аж ахуйн онцгой байдалд баримтлах заавар, стандартууд – LEGS, 2023
Анх хэвлэгдсэн 2009. Хоёрдугаар хэвлэлт 2014. Гуравдугаар хэвлэлт 2023

Энэ номыг эрхлэн гаргасан хүмүүсийг “хянан тохиолдуулсан”, хувь нэмэр оруулсан хүмүүсийг “хувь нэмэр оруулагчид” хэмээн тооцох ёс суртахууны эрх 1988 оны Зохиогчийн эрх, загвар, патентын тухай хуулийн 77 болон 78 дугаар зүйлийн дагуу баталгаажсан болно.

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэхүү хэвлэлийн аль ч хэсгийг хэвлэн нийтлэгчдээс бичгээр зөвшөөрөл авалгүйгээр хуулбарлах, бичлэг хийх, мэдээлэл хадгалах, хайлтын системд оруулах, одоогоор мэдэгдэж байгаа эсвэл цаашид цахим, механик болон бусад хэлбэрээр гарах хувилбаруудыг дахин хэвлэх, хуулбарлах, ашиглахыг хориглоно.

Бүтээгдэхүүн эсвэл компанийн нэр нь барааны тэмдэг эсвэл бүртгэлтэй барааны тэмдэг байж болох бөгөөд тэдгээрт хамаарах эрхийг зөрчих зорилгогүйгээр зөвхөн таних, тайлбарлахад ашигласан болно.

Энэхүү номын каталог нь Британийн номын санд бүртгэгдсэн.

ISBN 978-1-78853-246-4 Цаасан

ISBN 978-1-78853-248-8 Цахим ном

Эшлэл: LEGS (2023) Мал аж ахуйн онцгой байдалд баримтлах заавар, стандартууд, Гуравдугаар хэвлэлт. Рагби, Их Британи: Практикал Акшн Паблишинг. <http://doi.org/10.3362/9781788532488>

Практикал Акшн Паблишинг (Practical Action Publishing Ltd) нь 1974 оноос хойш дэлхий нийтэд явагдаж буй олон улсын хөгжлийн үйл ажиллагаанд дэмжлэг болох ном, мэдээллийг хэвлэн нийтэлж, түгээж байна. Практикал Акшн Паблишинг нь Практикал Акшн хэвлэлийн компанийн эзэмшдэг Practical Action Publishing Ltd (Бүртгэлийн дугаар No. 1159018) компанийн худалдааны нэр юм. Практикал Акшн Паблишинг нь Практикал Акшны зорилгыг дэмжиж арилжаа хийдэг бөгөөд аливаа ашгийг Практикал Акшн (Сайн санааны байгууллагын бүртгэл. No. 247257, НӨАТ төлөгчийн бүртгэл No. 880 9924 76)-д зарцуулдаг.

Энэхүү хэвлэлтэд илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн редакцын зөвлөлийн үзэл бодол бөгөөд Практикал Акшн Паблишинг (Practical Action Publishing Ltd) эсвэл үүний толгой сайн санааны байгууллага болох Практикал Акшн (Practical Action) байгууллагын үзэл бодлыг илэрхийлээгүй болно. Бодит тоо, мэдээллийг тусгах чиглэлээр боломжит хүчин чармайлтыг гаргасан ч редакц болон хэвлэн нийтлэгч нь өгөгдсөн материалуудын баталгаат байдал, үүнээс үүдэн гарах үр дагаврыг хариуцахгүй болно.

Хянан тохиолдуулсан: Helen de Jode болон Cathy Watson

Дизайныг: www.truedesign.co.uk

Өрөлт: River Valley Technologies

www.livestock-emergency.net

Ерөнхий агуулга

LEGS хүрээ



Гарын авлагыг
хэрхэн ашиглах
вэ? х.14



Бүлэг 1:
LEGS-н
танилцуулга
х.20



Бүлэг 2:
LEGS-н
Зарчмууд
х. 48



Бүлэг 3: Онцгой
байдлын хариу
арга хэмжээний
төлөвлөлт
х. 80

Техникийн стандартууд



Бүлэг 4: Малын
тэжээлд
баримтлах
техникийн
стандартууд
х.134



Бүлэг 5: Усаар
хангахад
баримтлах
техникийн
стандартууд
х.172



Бүлэг 6: Мал
эмнэлгийн
тусламжид
баримтлах
техникийн
стандартууд
х. 208



Бүлэг 7: Малын
байр,
байршуулалтад
баримтлах
техникийн
стандартууд
х. 258



Бүлэг 8: Малын
тоог
бууруулахад
баримтлах
техникийн
стандартууд
х. 298



Бүлэг 9:
Малжуулах үйл
ажиллагаанд
баримтлах
техникийн
стандартууд
х. 330

Хавсралтууд
хуудас. 372

Индекс
хуудас. 388

Агуулга

Гарын авлагыг хэрхэн ашиглах тухайд

- 15 Мал аж ахуйн онцгой байдалд баримтлах заавар, стандартууд (LEGS) гарын авлагын зориулалт юу вэ?
- 15 LEGS-г хэн хэрэглэх шаардлагатай вэ?
- 16 LEGS гарын авлага юуг агуулсан бэ?
- 17 LEGS гарын авлагыг ашигласнаар ямар өөрчлөлт гарах вэ?
- 17 LEGS бусад ямар эх сурвалжуудаар хангадаг вэ?

Бүлэг 1: LEGS-н танилцуулга

- 21 LEGS-н үндэс юу вэ?
- 24 LEGS ямар төрлийн мал, мал аж ахуй эрхлэгч, хөрөнгийг хамаарах вэ?
- 27 LEGS-н амьжиргааны зорилтууд юу вэ?
- 29 LEGS онцгой байдал ба түүний үр нөлөөг хэрхэн тодорхойлдог вэ?
- 34 LEGS-т хамаарах бусад чухал үзэл санаа, асуудлууд юу вэ?
- 38 LEGS Sphere болон Хүмүүнлэгийн Стандартуудын Түншлэл (ХСТ)-тэй хэрхэн холбогддог вэ?
- 40 LEGS-н талаар илүү ойлголт авах мэдээлэл, ямар эх сурвалжууд байдаг вэ?
- 44 LEGS-т хамаарахгүй сэдвүүдийн талаар нэмэлт ямар мэдээлэл байдаг вэ?

Бүлэг 2: LEGS-н Зарчмууд

- 49 Танилцуулга
- 49 Зарчим 1: Амьжиргаанд суурилсан хөтөлбөрийг дэмжих
- 53 Зарчим 2: Олон нийтийн оролцоог хангах
- 56 Зарчим 3: Уур амьсгалын өөрчлөлтөд хариу үзүүлэх болон хүрээлэн буй орчныг хамгаалах
- 59 Зарчим 4: Бэлэн байдал ба эрт арга хэмжээг дэмжих
- 61 Зарчим 5: Хариу арга хэмжээнүүдийн зохицуулалтыг хангах
- 64 Зарчим 6: Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрийг дэмжих
- 66 Зарчим 7: Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих
- 69 Зарчим 8: Хяналт, Үнэлгээ, Хариуцлагатай байдал, Суралцах амлалт (ХҮХС)

Үргэлжлэл

- 72** Хавсралт 2.1: LEGS ба Sphere-н Хамгааллын Зарчмуудын уялдаа
- 73** Хавсралт 2.2: LEGS-н Зарчмууд Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт (ХҮС)-ын амлалтуудыг дэмжих нь
- 75** Эх сурвалж, цаашид нэмж унших материалууд

Бүлэг 3: Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөлт

- 81** Танилцуулга
- 82** Үе шат 1: Анхдагч үнэлгээ
- 90** Үе шат 2: Хариу арга хэмжээг тодорхойлох
- 93** Үе шат 3: Техникийн үйл ажиллагаанууд, тэдгээрийн хувилбаруудад дүн шинжилгээ хийх
- 99** Үе шат 4: Хариу арга хэмжээний төлөвлөгөө
- 102** LEGS-н үйл ажиллагаануудын хяналт, үнэлгээ, хариуцлагатай байдал, суралцах (ХҮХС)
- 108** Хавсралт 3.1: Анхдагч үнэлгээ – санал болгох оролцооны аргачлалууд
- 112** Хавсралт 3.2: Анхдагч үнэлгээ – шалгах хуудасны жишээ (хэсэгчлэн бөглөсөн)
- 114** Хавсралт 3.3: Анхдагч үнэлгээ – мэдээлэл цуглуулах загвар
- 115** Хавсралт 3.4: Хариу арга хэмжээг оролцоотойгоор тодорхойлох (PRIM) – загварууд
- 117** Хавсралт 3.5: PRIM – жишээнүүд
- 122** Хавсралт 3.6: Бэлэн мөнгө, эрхийн бичиг олгох тусламж– хариу арга хэмжээний хэлбэрүүд, хүргэх арга замууд, шийдвэрийн мод
- 127** Хавсралт 3.7: Хариу арга хэмжээний төлөвлөгөө – загвар
- 128** Хавсралт 3.8: Хариу арга хэмжээний төлөвлөгөө – малын тоог бууруулах үйл ажиллагааны жишээ
- 129** Эх сурвалж, цаашид унших материалууд

Бүлэг 4: Малын тэжээлд баримтлах техникийн стандартууд

- 136** Танилцуулга
- 139** Тэжээлээр хангах хувилбарууд
- 144** Үйл ажиллагааг хэрэгжүүлэх цаг хугацаа
- 145** LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн Стандартуудын Түншлэл (ХСТ)-ийн стандартуудтай холбогдох байдал
- 146** LEGS-н зарчмууд болон бусад анхаарах асуудлууд
- 151** Малын тэжээл хангамжийн хувилбаруудын шийдвэрийн мод
- 154** Стандартууд
- 164** Хавсралт 4.1: Тэжээлээр хангах үйл ажиллагааны хяналт үнэлгээний шалгах хуудас
- 166** Хавсралт 4.2: Малыг тэжээх үйл ажиллагааны хяналт үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн жишээнүүд
- 168** Эх сурвалж, цаашид унших материалууд

Бүлэг 5: Усан хангамжид баримтлах техникийн стандартууд

- 173** Танилцуулга
- 176** Усаар хангах хувилбарууд
- 180** Үйл ажиллагааг хэрэгжүүлэх цаг хугацаа
- 181** LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн Стандартуудын Түншлэл (ХСТ)-ийн стандартуудтай холбогдох байдал
- 182** LEGS-н зарчмууд болон бусад анхаарах асуудлууд
- 186** Усаар хангах хувилбаруудын шийдвэрийн мод
- 189** Стандартууд
- 202** Хавсралт 5.1: Уст цэгүүдийн үнэлгээний шалгах хуудас
- 204** Хавсралт 5.2: Усаар хангах үйл ажиллагааны хяналт үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн жишээнүүд
- 205** Хавсралт 5.3: Уст цэгүүдийг ажиллуулахад анхаарах асуудлууд
- 206** Эх сурвалж, цаашид унших материалууд

Бүлэг 6: Мал эмнэлгийн тусламжид баримтлах техникийн стандартууд

- 210** Танилцуулга
- 212** Мал эмнэлгийн тусламжийн хувилбарууд
- 221** Үйл ажиллагааг хэрэгжүүлэх цаг хугацаа
- 222** LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн Стандартуудын Түншлэл (ХСТ)-ийн стандартуудтай холбогдох байдал
- 223** LEGS зарчмууд болон бусад анхаарах асуудлууд
- 230** Мал эмнэлгийн тусламжийн хувилбаруудын шийдвэрийн мод
- 232** Стандартууд
- 249** Хавсралт 6.1: Мал эмнэлгийн тусламжийг үнэлэх аргууд, шалгах хуудас
- 251** Хавсралт 6.2: Мал эмнэлгийн тусламжийг хянах, үнэлэх шалгуур үзүүлэлтийн жишээнүүд
- 253** Эх сурвалж, цаашид унших материалууд

Бүлэг 7: Малын байр, байршуулалтад баримтлах техникийн стандартууд

- 260** Танилцуулга
- 263** Малын байр, байршуулалтын хувилбарууд
- 268** Үйл ажиллагааг хэрэгжүүлэх цаг хугацаа
- 269** LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн Стандартуудын Түншлэл (ХСТ)-ийн стандартуудтай холбогдох байдал
- 271** LEGS-н зарчмууд ба бусад анхаарах асуудлууд
- 274** Малын байр, байршуулалтын хувилбаруудын шийдвэрийн мод
- 277** Стандартууд
- 292** Хавсралт 7.1: Малын байр, байршуулах үйл ажиллагааг үнэлэх шалгах хуудас
- 294** Хавсралт 7.2: Малын байр, байршуулах үйл ажиллагааг хянах, үнэлэх шалгуур үзүүлэлтийн жишээнүүд
- 295** Хавсралт 7.3: Малын байр ба уур амьсгалын сорилтууд
- 296** Эх сурвалж, цаашид унших материалууд

Бүлэг 8: Малын тоог бууруулахад баримтлах техникийн стандарт

- 299** Танилцуулга
- 302** Малын тоог бууруулах үйл ажиллагааны хувилбарууд
- 306** Үйл ажиллагааг хэрэгжүүлэх цаг хугацаа
- 308** LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн Стандартуудын Түншлэл (ХСТ)-ийн стандартуудтай холбогдох байдал
- 308** LEGS-н зарчмууд ба бусад анхаарах асуудлууд
- 311** Малын тоог бууруулах үйл ажиллагааны хувилбаруудын шийдвэрийн мод
- 313** Стандартууд
- 324** Хавсралт 8.1: Малыг тоог бууруулах үйл ажиллагааны үнэлгээний шалгах хуудас
- 326** Хавсралт 8.2: Малыг тоог бууруулах үйл ажиллагааг хянах, үнэлэх шалгуур үзүүлэлтийн жишээнүүд
- 328** Эх сурвалж, цаашид унших материалууд

Бүлэг 9: Малжуулах үйл ажиллагаанд баримтлах техникийн стандартууд

- 332** Танилцуулга
- 335** Малжуулах үйл ажиллагааны хувилбарууд
- 340** Үйл ажиллагааг хэрэгжүүлэх цаг хугацаа
- 341** LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн Стандартуудын Түншлэл (ХСТ)-ийн стандартуудтай холбогдох байдал
- 342** LEGS-н зарчмууд ба бусад анхаарах асуудлууд
- 348** Малжуулах үйл ажиллагааны хувилбаруудын шийдвэрийн мод
- 351** Стандартууд
- 362** Хавсралт 9.1: Малжуулах үйл ажиллагааг үнэлэх шалгах хуудас
- 364** Хавсралт 9.2: Малжуулах үйл ажиллагааг хянах, үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн жишээнүүд
- 367** Хавсралт 9.3: Малжуулах сүргийн доод хэмжээг тогтоох хэлэлцүүлэг
- 369** Эх сурвалж, цаашид унших материалууд

Үргэлжлэл

Хавсралтууд

373 Хавсралт А: Нэр томъёоны тайлбар

383 Хавсралт Б: Товчилсон үгс

384 Хавсралт В: Тохиромжтой хугацааны нэгдсэн хүснэгт

385 Хавсралт Г: Талархал болон хувь нэмэр оруулсан
хүмүүсийн нэрс

388 Индекс

Энэхүү номын тухай

Мал аж ахуйн онцгой байдалд баримтлах заавар, стандартууд (LEGS) гарын авлагын шинэчилсэн хувилбар нь агуулга болон хэлбэрийн хувьд нэлээд их өөрчлөлтийг багтаажээ. Шинэ бүтэц, сайжирсан дизайн, суурь бүлгүүдэд хийгдсэн өөрчлөлтүүд, энгийн Англи хэлээр бичигдсэн зэрэг нь мал аж ахуйн мэргэжилтнүүд, хүмүүнлэгийн ажилтнуудын аль аль төдийгүй анх удаа хэрэглэж буй хүн ч хялбархан ойлгож, ашиглахуйц болжээ. Бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн стандартуудын түншлэл (ХСТ)-ийн бусад стандартуудтай холбосон нь талархуштай байна.

Мэти Ба Диао, Сахелийн бүс нутгийн гангийн хяналтын улс хоорондын байнгын хорооны (CILSS) Сахелийн бүс нутгийн бэлчээрийн мал аж ахуйг дэмжих хөтөлбөрийн Бүсийн зохицуулагч асан

Уншигчдад ээлтэй, хэрэглэхэд хялбар, хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдалд нийцсэн, илүү олон кейс судалгаагаар баяжуулсан LEGS-н гурав дахь хэвлэлтийг миний бие талархан хүлээн авч байна. Энэ хувилбарт онцгой байдлын үед хариу арга хэмжээ хэрхэн авах талаар шинэлэг арга замуудыг тусгаж, ирээдүйн төлөвлөлт рүү чиглүүлэхуйц байдлаар өмнөх үйл ажиллагаа, туршлагуудыг үнэлж дүгнэсэн байна. Зөвлөлдөх үйл явц, олон нийтэд хүрсэн байдал нь өмнөх хэвлэлтүүдээс хавь илүү байсан. Гарын авлагад тусгасан хэрэглэгдэхүүнүүд нь мал аж ахуйд суурилсан амьжиргаанд төвлөрөн хүнсний баталгаат байдлын чиглэлээр ажиллаж буй хүмүүнлэгийн болон хөгжлийн байгууллагууд аль алинд нь маш их хэрэг болно гэдэгт би итгэлтэй байна.

Викрант Махжан, Sphere Энэтхэг байгууллагын Гүйцэтгэх захирал

Энэ гурав дахь хэвлэлт баялаг агуулгатай, илүү энгийн хэллэг ашигласны зэрэгцээ LEGS-н хандлагыг нутгийн иргэдэд эзэмшүүлж, дадуулах нь зүйтэй гэсэн саналын дагуу сайжруулалт хийгджээ. Гарын авлага нь хүний амь нас, амьжиргаа хоорондын жам ёсны холбоог тодорхой дүрсэлж, онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөлтийн шинэ бүлэгт гамшигт нэрвэгдсэн нутгийн иргэдийн амь насыг аврах, амьжиргааг хамгаалах гол хэрэглэгдэхүүнүүдийг нэгтгэж өгсөн байна.

Др Киса Жума Нгейва, Кени улсын Мал эмнэлгийн газрын дарга асан

“Миний хувьд LEGS-н 3 дахь хэвлэлтийг гаргахад хувь нэмэр оруулсан маань их чухал байлаа. Энэ гарын авлага нь онцгой байдлын эрсдэлд орсон хүмүүсийн амьжиргааг хадгалан үлдээхэд зориулсан заавар, журмуудын чухал эх сурвалж төдийгүй малтай холбоотой асуудалд зүй ёсны хандлагатай, дэлхийн хэмжээний мэргэжилтнүүдийн суралцах онцгой боломжийг олгосон юм”.

Норман Эрнесто Мора Серда, Никарагуа улсын Гамшигаас хамгаалах үндэсний системийн Сургалт, хариу арга хэмжээ хариуцсан захирал

‘LEGS нь онцгой байдал үүссэн үед малд чиглэсэн хариу арга хэмжээг чанартай хэрэгжүүлж гамшигт нэрвэгдсэн хүн амын сэргэн босох чадавхыг болон эрсдэл сөрөн тэсвэрлэх чадварыг ерөнхийд нь бэхжүүлэх үйл ажиллагааг чиглүүлэх лавлах бичиг юм. Энэ гурав дахь хэвлэл нь хэрэглэхэд хялбар, орон нутгийн иргэдийн оролцоог хангах, жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр зэрэг шинэ үзэл баримтлалуудыг тусгаж, стандарт, үндсэн үйл ажиллагаа болон зааварчилгааг дахин сайжруулсан байна. LEGS-н гарын авлага анх гарсан цагаас хувь нэмрээ оруулагчдын нэгний хувьд Хил хязгааргүй малын эмч нар (VSF) олон улсын байгууллага нь өөрийн ажилтнуудад LEGS-н зарчмууд, стандартууд, тэдний хэрэглээний талаар дэлгэрэнгүй ойлголт өгөх сургалтуудыг тасралтгүй зохион байгуулж ирсэн билээ. Тиймээс гарын авлага нь сургалтын чухал сурах бичиг болсон бөгөөд, энэхүү сайжруулсан гурав дахь хэвлэлт нь хямралын аль ч шатанд ажиллаж буй хүмүүст ашиглахад хялбар, хариу арга хэмжээний гарын авлага болно.’

Маргерита Гомараска, VSF Олон улсын байгууллагын зохицуулагч

LEGS гарын авлага нь мал аж ахуйн мэргэжлийн хүмүүст хамтдаа төлөвлөх, хэрэгцээ, хийдлийг тодорхой зураглах боломжоор хангах нийтлэг ойлголт, хүрээг олгож байна. Шинэ хэвлэлт нь малын хорогдол, үйлдвэрлэлийн алдагдлыг бууруулахад бэлтгэл бэлэн байдал, эрт арга хэмжээний гол шинжийг харгалзан багууд урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах гол хэрэгсэл болно. Түүнчлэн бэлэн мөнгө, эрхийн бичгийн тусламжийн талаар нэмэлт дэлгэрэнгүй мэдээлэл оруулсан нь малд чиглэсэн үйл ажиллагаанд энэ системийг ашигласан нь хариу арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг улам сайжруулсан байна. Зааварчилгаанууд нь түншлэгч талууд, бодлого боловсруулагчдыг оролцуулан чанартай хариу арга хэмжээний талаар харилцан суралцах, мэдлэг солилцох хэрэгсэл байсан, цаашид чухал хэрэгсэл нь байсаар байх болно.

Рейн Поулсен, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Онцгой байдал, эрсдэл сөрөн тэсвэрлэх чадварын албаны захирал





Гарын авлагыг хэрхэн ашиглах тухайд

- 15 **LEGS гарын авлагын зориулалт юу вэ?**
- 15 **LEGS-г хэн хэрэглэх шаардлагатай вэ?**
- 16 **LEGS гарын авлага юуг агуулсан бэ?**
- 17 **LEGS гарын авлагыг ашигласнаар ямар өөрчлөлт гарах вэ?**
- 17 **LEGS бусад ямар эх сурвалжуудаар хангадаг вэ?**



Гарын авлагыг хэрхэн ашиглах тухайд

LEGS гарын авлагын зориулалт юу вэ?

Мал аж ахуйн онцгой байдалд баримтлах заавар, стандартууд (LEGS) гарын авлага нь хүмүүнлэгийн онцгой байдалд дагаж мөрдөх наад захын стандарт, зааварчилгаагаар хангадаг. Энэ гарын авлага нь гамшигт нэрвэгдсэн малтай иргэдийн амьжиргааг дэмжихэд тусална. Бага, дунд орлоготой орнуудад амьдардаг мал аж ахуй эрхлэгчдийг онцгойлон чухалчилж, хүмүүнлэгийн хариу арга хэмжээний чанарыг сайжруулах зорилготой юм.

LEGS гарын авлага нь мал аж ахуйн онцгой байдлын хариу арга хэмжээг төлөвлөх, шийдвэр гаргахад туслах практик хэрэгслүүдийг агуулдаг. Мөн онцгой байдал үүсэхэд малыг тэжээлээр хангах, усаар хангах, мал эмнэлгийн тусламж үзүүлэх, малын байраар хангах, малын тоог бууруулах, малжуулах гэсэн зургаан чиглэлд хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд баримтлах стандарт, үндсэн үйл ажиллагаа, зааварчилгаагаар хангадаг.

LEGS гарын авлага нь онцгой байдлын үед мал аж ахуйд суурилсан амьжиргааг хамгаалах, гамшгийн дараагаар сэргээн босгох нь чухал гэдгийг онцолдог юм. Амьжиргаанд суурилсан хөтөлбөр нь гарын авлагыг хэрэглэгчийн дагаж мөрдөх LEGS-н найман зарчмын эхнийх нь юм.

LEGS-н бүх зааварчилгаа нь мэргэжлийн дүн шинжилгээ, нотолгоонд суурилсан сайн дадалд тулгуурласан юм.

LEGS-г хэн хэрэглэх шаардлагатай вэ?

LEGS нь амьжиргааны гол хэрэгсэл нь мал аж ахуйгаас хамаардаг газар, нутагт хүмүүнлэгийн тусламж үзүүлдэг хүмүүст голчлон зориулагдсан. Тэдгээрт гамшигт нэрвэгдсэн бүс нутагт хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд оролцдог тухайн нутгийн иргэд, үндэсний болон олон улсын төрийн бус байгууллагуудын ажилтнууд; засгийн газар, орон нутгийн засаг



захиргааны байгууллагын ажилтнууд; хоёр болон олон талт засгийн газар хоорондын байгууллагад ажилладаг хүмүүс; хувийн хэвшлийнхэн багтана. Түүнчлэн гамшигт нэрвэгдсэн нутгийн иргэд ч мөн гарын авлагын хэрэглэгч байж болно. Энэхүү гарын авлагад мал аж ахуйд сөрөг нөлөөтэй онцгой байдлын хариу арга хэмжээ авч буй бүх талуудыг “агентлагууд” гэсэн нэр томъёог төлөөлүүлэн ашигласан байгаа.

LEGS-н заавар нь онцгой байдал, мал аж ахуй, амьжиргаа хэрхэн, яагаад давхцаж байгааг тодорхой тайлбарладаг. Иймээс энэхүү гарын авлага нь онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээ, сэргээн босгох үйл ажиллагаанд оролцдог мал аж ахуйн мэргэжилтнүүд болон хүмүүнлэгийн ажилтнуудын аль алинд нь хэрэгтэй. Мөн энэхүү гарын авлага нь онцгой байдлын хариу арга хэмжээнд хамаарал бүхий хандивлагчид, бодлого боловсруулагчид болон хариу арга хэмжээний санхүүжилт, үйл ажиллагаа, бодлогуудад тодорхой нөлөө үзүүлдэг бусад талуудад мөн хамаатай. Үүнээс гадна боловсролын байгууллагуудад ч мөн хэрэгтэй.

LEGS гарын авлагад юу багтсан бэ?

LEGS гарын авлага нь гурван үндсэн бүлэгтэй. Эдгээрийг эхлээд уншиж ойлгох нь чухал юм. *Бүлэг 1* нь LEGS түүний Sphere (Сфер) дэх тулгуурууд болон Хүмүүнлэгийн Стандартуудын Түншлэл (HSP) дэх холбоосыг танилцуулдаг. *Бүлэг 2* нь LEGS-н тулгуур 8 зарчмыг тайлбарладаг бол *Бүлэг 3* нь мал аж ахуйд суурилсан онцгой байдлын хариу арга хэмжээг төлөвлөхөд шаардлагатай практик хэрэгслүүдийг зааж өгдөг. Иймээс эдгээр бүлгүүд нь дараагийн техникийн стандартын бүлгүүдийн суурь нь болдог.

Техникийн үйл ажиллагааны зургаан бүлгүүд (*4, 5, 6, 7, 8, 9-р бүлэг*) бүгд нийтлэг бүтэцтэй. Тэдгээрийг яаралтай тусламжийн хариу арга хэмжээний төлөвлөлтөд болон байнгын лавлах эх сурвалж болгон ашиглах ёстой. Тэдгээр бүлгүүдийн эхэнд мал аж ахуй болон амьжиргааг дэмжихэд тухайн техникийн үйл ажиллагаа яагаад чухал болохыг тодорхойлсон байдаг. Түүнчлэн хариу арга хэмжээний боломжит хувилбаруудын үр өгөөж, сорилт бэрхшээлүүдийг тоочиж, хүмүүнлэгийн онцгой байдлын аль үе шатанд хэрэглэхэд тохиромжтойг заасан байдаг. Стандартын хэсгүүд нь:

- **Стандартууд**–аливаа нөхцөл байдалд онцгой байдлын үед хүрэх хамгийн бага чанарын тодорхойлолт;
- **Үндсэн үйл ажиллагаа**–LEGS стандартуудад хүрэх бодит алхмууд буюу үйл ажиллагаанууд, бүх нөхцөл байдалд бүгд хамаарахгүй байж болно;
- **Зааварчилгаанууд**–эдгээрийг үндсэн үйл ажиллагаатай холбож унших бөгөөд LEGS стандартуудыг хэрэглэх үед тулгарч болох тодорхой



асуудал, бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх талаар тайлбарладаг.

Гарын авлагын төгсгөлд чухал нэр томьёоны тайлбарыг оруулсан ба эдгээрийг гарын авлагад анх дурдах тохиолдолд өөр өнгөөр бичсэн болно.

0

Гарын авлагыг ашигласнаар ямар өөрчлөлтийг бий болгох вэ?

LEGS гарын авлага нь эрсдэлд өртсөн нутгийн иргэдийн хувьд "мал" нь амьжиргааны хамгийн чухал хөрөнгө гэдгийг тайлбарладаг. Энэ гарын авлага нь хүмүүнлэгийн онцгой байдлын үед мал аж ахуйд суурилсан амьжиргааг сайн санааны үүднээс дэмжих боловч тохиромжгүй хариу арга хэмжээнүүдийн улмаас сүйрүүлэхгүй байх зорилготой. LEGS гарын авлага дахь арга хэрэгслүүдийг ашигласнаар онцгой байдлын үед малд чиглэсэн хариу арга хэмжээг сонгох, үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлэхэд тусална. Мал амьтанд чиглэсэн хамгийн тохиромжтой, боломжтой, цаг алдалгүй хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг LEGS-н техникийн зургаан үйл ажиллагааны хэсгүүдэд тодорхойлсон. LEGS-н найман зарчим нь гарын авлагыг хэрэглэгчдэд зохих шийдвэр гаргах, стандартыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь туслах бүхий л нөхцөл байдалд хэрэглэгдэхүйц удирдамж, заавраар хангадаг.

LEGS өөр ямар нөөц, боломжоор хангадаг вэ?

LEGS гарын авлагын энэхүү гурав дахь хэвлэлийг хэвлэмэл хэлбэрээр авах боломжтой. Хүмүүнлэгийн стандартын түншлэлийн интерактив гарын авлагын сайт дээр болон LEGS вэб сайтаас pdf хэлбэрээр татаж авах боломжтой (www.livestock-emergency.net) ба тэндээс мөн LEGS-н талаар нэмэлт мэдээлэл: товч танилцуулга, нэмэлт аргачлал, хэрэгслүүд, кейс судалгаанууд авч үзэж болно. Зарим кейс судалгаанууд үйл явцыг буюу тухайн хариу арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлсэн тухай бичигдсэн байдаг бол заримд нь малтай хүмүүсийн амьжиргаанд гарсан үр нөлөөний талаар бичигдсэн байдаг. Түүнчлэн LEGS сургалтын хөтөлбөр болон LEGS цахим мэдээллийн товхимолд хэрхэн бүртгүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл тэнд бас бий.



LEGS хүрээ

Гарын авлагыг хэрхэн ашиглах



LEGS хүрээ
LEGS-н Танилцуулга





Бүлэг 1:

LEGS-н танилцуулга

- 21 LEGS-н үндэс юу вэ?
- 24 LEGS-т ямар мал амьтан, мал аж ахуй эрхлэгчид, хөрөнгө хамаарах вэ?
- 27 LEGS-н амьжиргааны зорилтууд юу вэ?
- 29 LEGS онцгой байдал, тэдгээрийн үр нөлөөг хэрхэн тодорхойлдог вэ?
- 34 LEGS-т хамааралтай бусад чухал үзэл санаа, асуудлууд юу вэ?
- 38 LEGS нь Sphere болон Хүмүүнлэгийн Стандартуудын Түншлэлтэй хэрхэн холбогддог вэ?
- 40 LEGS-н талаар илүү ойлголт, мэдээлэл авах ямар эх сурвалжууд байдаг вэ?
- 44 LEGS -т хамаарахгүй сэдвүүдийн талаар нэмэлт ямар мэдээлэл байдаг вэ?



Бүлэг 1: LEGS-н танилцуулга

Бүлгийн тойм

Энэ бүлэгт дараах асуултуудын дагуу LEGS-г танилцуулдаг:

- LEGS-н үндэс юу вэ?
- LEGS-т ямар мал амьтан, мал аж ахуй эрхлэгчид, хөрөнгө хамаарах вэ?
- LEGS-н амьжиргааны зорилтууд юу вэ?
- LEGS онцгой байдал, тэдгээрийн үр нөлөөг хэрхэн тодорхойлдог вэ?
- LEGS-т хамаарах бусад чухал үзэл санаа, асуудлууд юу вэ?
- LEGS нь Sphere ба Хүмүүнлэгийн Стандартуудын Түншлэлтэй хэрхэн холбогддог вэ?
- LEGS-н талаар илүү ойлголт, мэдээлэл авах ямар эх сурвалжууд байдаг вэ?
- LEGS-т хамаарахгүй сэдвүүдийн талаар нэмэлт ямар мэдээлэл байдаг вэ?

LEGS-н үндэс юу вэ?

Амьжиргааг дэмжих

Онцгой байдлын хариу арга хэмжээ нь хүний амь насыг зөвхөн авран хамгаалах төдий бус хүмүүнлэгийн үйл ажиллагаанд гамшигт өртсөн хүмүүсийн амьжиргааг хамгаалах асуудлыг зайлшгүй харгалзах ёстой гэдгийг өдгөө хүлээн зөвшөөрөх болсон. Амьжиргаа нь хүмүүс өөрсдийгөө болон гэр бүлээ хэрхэн тэжээх, амьдарлаа залгуулах арга хэрэгслүүд юм. Амьжиргааг амьдралынхаа хэрэгцээг хангахад шаардагдах хүмүүсийн чадвар, хөрөнгө, орлого, үйл ажиллагаанууд гэж ихэвчлэн тодорхойлсон байдаг.

Амьжиргааг дэмжих нь LEGS-н үндэс бөгөөд үүнийг энэхүү гарын авлагад хоёр замаар тусгасан болно. Амьжиргаанд-суурилсан хөтөлбөр нь LEGS-н Зарчмуудын анхдагч зарчим нь юм. (Бүлэг 2, болон бусад техникийн үйл ажиллагаа тус бүрт хамааралтай хэсгийг Бүлэг 4, 5, 6, 7, 8, 9-с харна уу). LEGS мөн амьжиргаанд суурилсан хандлагыг онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөөнүүдийг боловсруулахад баримталдаг (Бүлэг 3 харна уу).

LEGS нь хямралд өртсөн мал бүхий хүмүүсийн амьжиргаанд дэмжлэг үзүүлдэг. Ингэхдээ LEGS нь малын тэжээл, ус, мал эмнэлгийн тусламж,



байр, малын тоог бууруулах, малжуулах гэсэн зургаан техникийн үйл ажиллагаанаас хариу арга хэмжээний хувилбаруудыг төлөвлөж, хэрэгжүүлж дэмжлэг үзүүлдэг. Эдгээр техникийн үйл ажиллагаанууд мал хөрөнгөд чиглэн LEGS-н амьжиргааны гурван зорилтуудтай нийцдэг (доорх хэсгээс харна уу).

Нотолгоо

LEGS дэлхий нийтийн нотолгоонд суурилсан сайн туршлагад тулгуурласан юм. Эдгээр нотолгооны хүрээнд мал аж ахуй болон малд чиглэсэн үйл ажиллагаануудын үнэлгээнүүд, тойм судалгаанууд болон нөлөөллийн үнэлгээнүүдийг мөшгиж, ашигласан болно. Энэхүү LEGS Гарын авлагын гурав дах хэвлэл нь дараах санал зөвлөмжүүдэд үндэслэсэн. Үүнд:

- Гол сэдвүүдийн хүрээнд боловсруулсан таван хэлэлцүүлгийн баримт бичгээс гарсан редакцын зөвлөмжүүд болон баримт бичиг тус бүрийн цахим хэлэлцүүлэгт ирүүлсэн санал хүсэлтүүд;
- “LEGS-г хэрэглэгчдэд хэрхэн илүү ээлтэй болгох вэ” хэлэлцүүлгийн баримт бичиг;
- Мали, Кени, Филиппин, Энэтхэг, Никарагуа улсад зохион байгуулсан зөвлөлдөх семинарууд;
- LEGS-н гарын авлагын хоёр дахь хэвлэлийн цахим зөвлөгөөн;
- LEGS-н Нөлөөллийн Мэдээллийн сан (LEGS цахим хуудас: www.livestock-emergency.net/legs-impact-database-г ашиглах боломжтой)-г хянан магадлагаа ба шинэчлэл;
- Гурав дахь хэвлэлийн ноорогт олон нийтийн хэлэлцүүлэг;

Эдгээр нотолгоо нь LEGS Гарын авлагад дараах байдлаар тусгагдсан болно:

1. Бүлэг тус бүрийн төгсгөлд оруулсан ашигласан хэвлэлүүд болон цаашид унших материалын жагсаалт;
2. Бодит кейс судалгаанууд, дэлхийн хэмжээний жишээнүүдийг бүлэг тус бүрд тодруулан оруулсан ба LEGS цахим хуудас (www.livestock-emergency.net/case-studies)-с мэдээллийг бас авах боломжтой.

Хүний эрх

LEGS нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхүүдийг хүндлэх, хамгаалах, биелүүлэх зорилгуудтай нийцсэн **Хүний эрхэд суурилсан хандлагыг** дагаж мөрддөг. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 1-р Зүйл-д тусгагдсан ‘Хүн болж төрсөн бүх хүн эрх чөлөөтэй амьдрах ба нэр төр, эрхийн хувьд эрх тэгш байна...’ гэсэн заалт нь олон улсын хууль эрхзүйн орчин дахь хүний эрхийн зарчим юм.

Ялангуяа хоол хүнсний эрхийг тусгасан 25-р Зүйл нь LEGS-т бүр



ихээр хамаардаг. Энэ нь *‘Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй.’* гэж тусгагдсан байдаг. (Жич: хүч чадалтай эр хүнээр ихэвчлэн төлөөлүүлж бичдэг байсан 1948 оны төлөөний үгийн сонголт хэвээр хадгалагдан орсон)

Мал, амьтны тавлаг байдал

LEGS-н хариу арга хэмжээний хувилбарууд нь мал **амьтны тавлаг байдлыг** сайтар хангадаг. LEGS гарын авлагын өмнөх хоёр хэвлэлт гарснаас хойш олон улсын байгууллагууд мал амьтны тавлаг байдлыг чухалчлах тухай ойлголтоо улам хөгжүүлсэн юм. Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ) мал, амьтны тавлаг байдлыг одоо идэвхтэй сурталчилж байна.

LEGS техникийн тусгай үйл ажиллагаанууд нь амьтны тавлаг байдлын үнэлгээний протоколуудын *Хайрцаг 1.1*-д жагсаалтаар харуулж буй Малын тавлаг байдлын таван хүрээний аль нэг үзүүлэлттэй холбогддог. LEGS-н техникийн бүлгүүдэд тухайн үйл ажиллагаа нь мал, амьтны тавлаг байдлын эдгээр хүрээтэй хэрхэн холбогддог болохыг тайлбарладаг юм.

Хайрцаг 1.1

Мал, амьтны тавлаг байдал: Таван хүрээ

- 1. Тэжээллэг**–мал, амьтан хангалттай хэмжээний, шимт бодисын зохистой харьцаатай, олон нэр төрлийн, чанартай сайн тэжээл, цэвэр усаар хангагдах нөхцөлийг багтаасан хүчин зүйлс.
- 2. Хүрээлэн буй орчин**–халуун, хүйтний хэм, хэвтэр, орон зай, агаар, үнэр, дуу чимээ болон урьдчилан таамаглах чадвараар дамжуулан орчны ая тухыг бүрдүүлэх хүчин зүйлс
- 3. Эрүүл мэнд**–өвчин, бэртэл, гэмтэл, тамир тэнхээ алдагдахаас ангид эрүүл байлгах хүчин зүйлс
- 4. Зан авир**–шиншлэх, тэжээл хайх, сүрэглэх, зугатах, зайлсхийх зэргээр шинэлэг, анхаарал татахуйц орчны өөрчлөлтүүдийг мэдрэхүйгээр дамжуулан бий болгох хүчин зүйлс
- 5. Тав тухгүй байдал**–мал, амьтныг айх, түгших, уурлах, өлсөх, өвдөж зовуурилах тухгүй мэдрэмжүүдээс ангид тайван, тогтуун, тухтай байлгах хүчин зүйлс

Эх сурвалж: <https://www.worldanimalprotection.us/blogs/five-domains-vs-five-freedoms-animal-welfare>



LEGS-н Зарчмууд

LEGS нь дараах найман зарчимд тулгуурладаг. Тэдгээр нь:

1. Амьжиргаанд суурилсан хөтөлбөрийг дэмжих;
2. Олон нийтийн оролцоог хангах;
3. Уур амьсгалын өөрчлөлтөд хариу үзүүлэх ба байгаль орчныг хамгаалах;
4. Бэлэн байдал, эрт арга хэмжээг дэмжих;
5. Зохицуулалт бүхий хариу арга хэмжээг хангах;
6. Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрийг дэмжих;
7. Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих;
8. Хяналт, үнэлгээ, хариуцлагатай байдал, суралцах (ХҮХС)-д үүрэг хүлээх.

Бүлэг 2 LEGS-н Зарчмуудыг болон тэдгээрийн хэрэглээг тайлбарладаг ба техникийн үйл ажиллагааны бүлэг тус бүр (*Бүлгүүд 4,5,6,7,8,9*) тэдгээр үйл ажиллагаанууд LEGS-н найман Зарчимтай хэрхэн холбогдож, нийцсэнийг тайлбарладаг.

LEGS-т ямар мал амьтан, мал аж ахуй эрхлэгчид, хөрөнгө хамаарах вэ?

LEGS мал амьтныг хэрхэн тодорхойлдог вэ?

LEGS-н хүрээнд, 'мал' гэсэн нэр томъёонд бага болон дундаж орлоготой орнуудын хүн амын амьжиргааг тэтгэдэг мал, амьтны төрлүүдийг хамруулдаг. Энэ нь LEGS том хэмжээний мал аж ахуйн бизнесийн хэлбэрийг бус харин бэлчээрийн болон мал аж ахуйн жижиг үйлдвэрлэл эрхлэгчид рүү голчлон анхаардаг. Шувуу, гахай, хонь, ямаа, үхэр, тэмээ, усны одос үхэр, лам гөрөөс, сарлаг, илжиг гэх мэт хүмүүсийн амьжиргааг залгуулах чухал мал, амьтад багтдаг. Амьжиргааг дэмжихэд ач холбогдол бага муур, нохой мэтийн гэрийн тэжээвэр амьтдыг LEGS-т хамааруулдаггүй. Гэхдээ 'гэрийн тэжээвэр амьтад' гэх тодорхойлолт янз бүрийн сэдвийн хүрээнд ялгамжтай ойлголт өгдөг гэдгийг хүлээн зөвшөөрдөг юм. Түүнчлэн LEGS-т зөгийн аж ахуй, загасны аж ахуйг хамаардаггүй. Эдгээрийг хаана харгалзаж үздэг болохыг LEGS-т хамааралгүй сэдвүүдийн нэмэлт мэдээллүүдээс үзэх боломжтой.

Ажлын мал

Хүмүүнлэгийн хямралд нэрвэгдсэн орнуудад адуун төрөлтнүүд (адуу, луус, илжиг) амьжиргааны үндсэн суурь болох нь бий. Эдгээр ажлын мал



нь заримдаа зах руу ачаа тээвэрлэх, ус зөөх гэх мэтээр эмэгтэйчүүдийн амьжиргаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Зарим тохиолдолд нохой ч мөн ажлын мал болж болно. LEGS-г ашиглан онцгой байдлын хариу арга хэмжээг төлөвлөхдөө гамшигт нэрвэгдсэн хүн амын амьжиргаанд ямар төрлийн мал, амьтан ямар үүрэг, ач холбогдолтойг анхаарч үзэх шаардлагатай.

Онцгой байдлын үед ажлын мал, амьтад тодорхой хэмжээнд өртдөг. Тухайлбал, ган гачгийн үед илжиг, тэмээ ба лам гөрөөс алс холоос их хэмжээний ус зөөж илүү их ажиллах хэрэгтэй болдог. Ийм нөхцөлд тэдгээр нь биеийн жингээ түргэн алдах үр дагавартай учир үүнээс хамгаалахын тулд тэдгээрийг илүү сайн тэжээх шаардлага үүсдэг. Түүгээр ч барахгүй, хэрвээ ажлын мал амьтан үхвэл тухайн өрхийн амьжиргаа илүү эрсдэлд орно.

LEGS хүмүүнлэгийн хямралын хариу арга хэмжээнд ажлын мал амьтны ач холбогдлыг онцгойлон авч үздэг. Ган гачгийн үед хүнсний тусламжийг татан авах, тээвэрлэхэд ажлын малыг ашиглаж болно. Үр дүнд нь тэд бэртэх, гэмтэх, турах, эцэх зэргээр тухайн хямралын нөлөөнд өртдөг.

Мал аж ахуй эрхлэгчдийн төрөл

Хайрцаг 1.2.т харуулсанчлан дэлхий даяар хүмүүсийн амьжиргаанд мал, амьтад өөр өөр түвшинд янз бүрийн замаар чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хайрцаг 1.2

Амьжиргаанд нь мал чухал хувь нэмэр оруулдаг мал бүхий хүмүүсийн жишээнүүд

- Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид: малаас амьжиргаа нь бүрэн хамааралтай хүмүүс
- Газар тариалан–бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид: өрхийн жижиг тариалан, мал аж ахуйг хослуулан эрхэлдэг хэдий ч мал нь тэдгээрийн амьжиргааны гол хөрөнгөд тооцогддог хүмүүс
- Жижиг тариалан эрхлэгчид: шар үхэр, одос үхрийг газар хагалах, бордох зэрэг ажлын гол хүч болгон ашигладаг
- Цөөн тооны үхэр, ямаа, гахай, тахиа өсгөн үржүүлж хоол хүнс, орлогоо залгуулдаг малчид, фермерүүд, мөн ажлын малаа хөсөг, тээвэрт ашиглан амьжиргаагаа залгуулдаг хүмүүс;
- Лам гөрөөс, луус, илжиг, морин тэргээр ачаа, тээврийн үйлчилгээ үзүүлж амьжиргаагаа залгуулдаг үйлчилгээ үзүүлэгчид
- Хотын болон хот орчмын мал аж ахуй эрхлэгчид, хотын мал, амьтныг хотын иргэдийг амьжиргааны болон хоол, хүнсний нэмэлт



орлого, эх үүсвэртэй байхад хувь нэмэр оруулдаг гэж үздэг. Ялангуяа энд хотын хүн амын хэрэгцээнд шинэ сүү нийлүүлж амьжиргаагаа залгуулдаг саалийн аж ахуй эрхлэгчид, өсвөр хонь, ямаа худалдан авч бордон зах зээлд борлуулж амьжиргаагаа залгуулдаг хотын эмэгтэйчүүд хамаатай.

Ард иргэд мал аж ахуй ба газар тариалан эрхлэн амьжиргаагаа залгуулдаг. *Онцгой байдлын үед ашиглах Газар тариалангаас хамааралтай амьжиргааг дэмжих Стандарт (SEADS)* нь LEGS-тэй ижил загвартай гарсан бөгөөд хүмүүнлэгийн хямралд нэрвэгдсэн жижиг тариалан эрхлэгчдийг дэмжихэд LEGS-тэй хамтатган ашиглах шаардлагатай.

Мал амьтны худалдаачид, дэлгүүрийн эзэд, тэжээл нийлүүлэгчид, мал амьтны эрүүл мэндийн ажилчдын амьжиргаа нь малаас болон мал аж ахуй эрхлэгчдээс хамааралтай.

Мал амьжиргааны хөрөнгө болох нь

Малын ашиг шимийг хүртэж амьжиргаагаа залгуулдаг хэн бүхний амьжиргааны гол хөрөнгө нь мал мөн. LEGS-д амьжиргааны хөрөнгө гэж хувь хүн, айл өрхийн амьжиргаагаа залгуулахын тулд ашиглаж буй нөөцүүд, тоног төхөөрөмж, ур чадвар, давуу тал, харилцаа холбоог хэлнэ гэж тодорхойлдог.

Амьжиргааны чиглэлийн мэргэжилтнүүд амьжиргааны хөрөнгийг нийгмийн, хүний, байгалийн, санхүүгийн болон биет хөрөнгө гэж ангилан үздэг. Мал аж ахуйд суурилсан амьжиргаанд мал нь банкны 'амьд' данстай адил байх бөгөөд энэхүү санхүүгийн хөрөнгийг эзэд нь хэрэгцээтэй үедээ зарж борлуулж орлого олох эсвэл санхүүгийн баялаг байдлаар хадгалж болдог. Мөн түүнчлэн, олон газарт мал, амьтан эзнийхээ нийгэмд эзлэх хөрөнгө чинээг илтгэх нийгмийн чухал хөрөнгөд тооцогддог. Уг хөрөнгийг эзэн нь нийгмийн харилцааны хүрээнд хэн нэгэнтэй солилцох, хэн нэгэнд бэлэглэж болдог талтай. "Хүн"-амьжиргааны хөрөнгө гэх ойлголтын хүрээнд хүний эрүүл мэнд, шим тэжээл, ажиллах чадвар (*Бүлэг 2: LEGS-н Зарчмууд-н Хайрцаг 2.1-г хар*)-ыг хамааруулдаг. Хөдөөгийн олон өрхийн хувьд тэдний өмчилж буй мал нь өрхийн хоол хүнсний хэрэгцээ болон нийгэм-эдийн засгийн байр суурийг илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Малтай хүмүүс онцгой байдлын эрсдэлд хэр зэрэг өртөх нь тэдний мал хөрөнгөтэй нягт холбоотой. Учир нь мал хөрөнгийн үнэ цэнэ өндөр байх тусам тэдгээрийн цочролыг даван туулах чадвар илүү байдаг. Иймд мал аж ахуйд суурилсан хариу арга хэмжээг хэр оновчтой болохыг тодорхойлохын тулд амьжиргаанд мал сүрэг ямар үүрэг гүйцэтгэж байгааг болон тэрхүү амьжиргааны хөрөнгөд онцгой байдлын улмаас учрах үр нөлөөг сайтар



ойлгох нь чухал юм.

Бүлэг 3: Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөлт нь мал нь амьжиргааны гол хөрөнгийн үүргийг гүйцэтгэдэг эсэхийг болон мал аж ахуйд суурилсан амьжиргааг ойлгох анхдагч үнэлгээ хийх үед LEGS-н хэрэглэгдэхүүнүүдийг хэрхэн ашиглахыг тайлбарласан байгаа. Мал аж ахуйд суурилсан хариу арга хэмжээг газар тариаланд чиглэсэн дэмжлэг, хүнсний тусламж, **бэлэн мөнгө ба эрхийн бичиг** (CVA) зэрэг мал аж ахуйн бүс бусад үйл ажиллагаануудын хамт хэрэгжүүлж болно. Ингэснээр мал хөрөнгөд учрах зарим дарамт богино хугацаанд арилж, амьжиргааг сэргээн босгох үйл явц илүү боломжтой болдог.

Нөгөөтэйгүүр, гамшгийн нөлөөгөөр, эрэгтэй ба эмэгтэй хүмүүс ялгаагүй хэдэн үеэрээ мал маллаж амьжиргаагаа залгуулж байсан хүмүүсийн мал хөрөнгө үгүй болж, хоосрох тохиолдол байдаг. Онцгой байдлын нөлөөнд олон давтамжтай өртсөнөөр өрхийн гишүүд нь тарж бутрах, гэмтэж бэртэх, зарим нь бүр амь насаа алдах зэргээр өрхийн чадавх алдагдах, мал маллаж амьжиргаагаа залгуулах урам зориг нь бөхөх тохиолдлууд гардаг. Тэд амьжиргааны өөр эх үүсвэрийг өөрсдөө бий болгох дэмжлэгийг авахыг илүүд үздэг.

LEGS-н амьжиргааны зорилтууд юу вэ?

LEGS-н онцгой байдлын хариу арга хэмжээ нь амьжиргааны гурван зорилтод үндэслэдэг.

LEGS-н техникийн үйл ажиллагаанууд нь хямралд өртсөн хүмүүст дэмжлэг үзүүлэхдээ:

1. **Тухайн нөхцөлд үлдсэн** буюу байгаа мал хөрөнгөөс шууд ашиг хүртэх;
2. **Үндсэн мал хөрөнгийг хамгаалах;**
3. **Үндсэн мал хөрөнгийг нөхөн сэргээх**

Онцгой байдлын нөлөөнд өртсөн мал аж ахуйд суурилсан амьжиргаатай хүн амд үзүүлэх боломжтой хариу арга хэмжээг LEGS-н амьжиргааны эдгээр гурван зорилтын хүрээнд үнэлж, тодорхойлно. Сонгосон техникийн үйл ажиллагаа (усаар хангах, байраар хангах гэх мэт техникийн бүлгүүдэд тайлбарласан бусад үйл ажиллагаанууд) нь LEGS-н амьжиргааны эдгээр 3 зорилтуудын аль нэг нэгэнд хүрэхэд туслах ёстой. Техникийн бүлэг тус бүрийн танилцуулгад эдгээр зорилтуудтай холбож тайлбарласан байдаг. *Хүснэгт 1.1*-т техникийн үйл ажиллагаануудад зорилтуудтай хэрхэн холбогдож буйг илүү тодруулж тайлбарласан болно.



Хүснэгт 1.1: LEGS-н амьжиргааны гурван зорилтууд, үйл ажиллагааны жишээнүүд

LEGS-н амьжиргааг дэмжих зорилт	LEGS-н үйл ажиллагааны жишээ
1. Байгаа мал хөрөнгөөс шууд ашиг хүртэх. Байгаа мал хөрөнгөд нь түшиглэн орлого олох эсвэл хүнсээр хангагдах яаралтай тусламжийг үзүүлэх	Малыг цөөлөх: Эрсдэлд орсон эсвэл зах зээлд нийлүүлэх боломжгүй малыг худалдан борлуулах эсвэл нядлах нь малын эздийг бэлэн мөнгөтэй болгож эсвэл хүнсээр хангагдах дэмжлэг болдог. Энэ нь үлдсэн мал хөрөнгийг урт хугацаанд хамгаалах боломжийг олгодог. Тэжээл ба Усаар хангах: Нэрвэгдсэн өрхийн ашиг шим сайтай үндсэн сүргийг тэжээл, усаар хангаж ашиг шимийг нь нэмэгдүүлснээр тухайн өрхийн хүнсний баталгаат байдал нэн даруй сайжрахад чухал хувь нэмэр оруулах болно.
2. Үндсэн мал хөрөнгийг хамгаалах. Малыг амьд мэнд байлгаж чадвал онцгой байдал намжсаны дараа малын бүтээгдэхүүн үйлдвэрлэл эргэж сэргэх боломж бий	Мал эмнэлгийн дэмжлэг: Энэ нь онцгой байдлын аль ч үе шатанд мал хөрөнгийг хамгаалах ба нөхөн сэргээхэд зэрэг нөлөөтэй. Хөрөнгийн хамгаалалтыг сайжруулахад бусад үйл ажиллагаа (тухайлбал, малын тэжээл, усаар хангах)-тай уялдуулах нь оновчтой. Тэжээлээр хангах: Энэ нь онцгой байдлын үед болон дараа нь үлдсэн мал хөрөнгийг хамгаалахад нэн чухал ач холбогдолтой. Ган гачгийн үед усаар хангах үйл ажиллагаатай хамт үзүүлэх нь зохистой. Малын байраар хангах: Уг хариу арга хэмжээ нь хүйтэн, халуун цаг агаарын нөхцөл байдлаас хамгаалах; аюулгүй байдлыг хангах; хүн, малд тохирсон эрүүл орчныг бүрдүүлэх зэрэг онцгой байдлын тухайн нөхцөл, хэрэгцээнээс хамаарч янз бүрээр авч хэрэгжүүлдэг. Мөн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд (тухайлбал, газар хөдлөлтөд тэсвэртэй - малын байр, эсвэл өндөрлөг газрыг ашиглаж үерийн аюулаас хамгаалах), онцгой байдал өнгөрсний дараа мал хөрөнгийг хамгаалах (тухайлбал, галт уулын дэлбэрэлт)-д ашиглаж болно. Усаар хангах: Энэ нь үлдсэн мал хөрөнгийг хамгаалахад чухал ач холбогдолтой.
3. Үндсэн мал хөрөнгийг нөхөн сэргээх. Мал хорогдол гарсан болон мал хөрөнгийг хамгаалах боломжгүй байсны дараа хөрөнгийг нөхөн сэргээх	Малжуулах: Энэ нь онцгой байдлын дараа мал аж ахуй эрхлэгчдийн мал сүргийг нөхөн сэргээхэд туслах үйл ажиллагаа юм. Үүний хүрээнд амьжиргааг залгуулахад хувь нэмэр болох цөөн тооны тахиа, бог мал, ажлын малыг өгч болох юм. Уг арга хэмжээг гамшгийн дараах нөхөн сэргээх үе шатанд гамшгийн гарз хохирлын үнэлгээ хийх нөхцөл бүрдсэн үед хэрэгжүүлэхэд тохиромжтой байдаг. Тэжээл/ус/малын байр/мал эмнэлгийн дэмжлэг: Зорилт 2-г харна уу. Нөхөн сэргээх шатанд амьжиргааны үндсэн хөрөнгийг нөхөн сэргээхэд эдгээр хариу арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь зайлшгүй бөгөөд үр дүнд нь амьжиргааны хөрөнгө бэхжиж, цаашид тохиолдож болзошгүй гамшигт нэрвэгдэх эмзэг байдлыг бууруулах ач холбогдолтой.



LEGS онцгой байдал, тэдгээрийн үр нөлөөг хэрхэн тодорхойлдог вэ?

LEGS ба гамшгийн эрсдэлийн удирдлагын мөчлөг

Хүмүүнлэгийн хямрал, гамшгууд нь хэвийн нөхцөл байдалтай харьцуулахад хүний амь нас эрсдэх, эсвэл дэд бүтэц, эд хөрөнгөд их хэмжээний хохирол учруулахтай холбоотой байдаг. Заавал гамшиг учруулахгүй ч олон аюул, заналхийллүүд бий.

Гамшиг ба хүмүүнлэгийн хямралыг тодорхойлсон олон ойлголтууд байдаг бөгөөд LEGS-н хувьд аюулд өртсөн нутгийн иргэдийн даван туулах чадвараас давсан нөхцөл байдлыг 'онцгой байдал' гэсэн нэр томъёогоор ашигладаг. Нутгийн ядуу иргэд бэлтгэл муутай, сөрөн тэсвэрлэх чадвар сул, даван туулах чадвар багатай байдаг. Нутгийн иргэдэд учрах үр нөлөөнд тэдний тухайн аюулын өртөнгийн түвшин, эрсдэлд хэр байгаа зэрэг бусад хувьсагчид нөлөөлдөг.

Онцгой байдал дахин давтагдах хандлагатай байдаг учраас тэдгээрийн нэг удаагийн үзэгдэл гэхээсээ илүүтэй мөчлөгийн нэг хэсэг гэж үзэх нь зохистой. LEGS нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, онцгой байдлын хор уршгийг бууруулахыг харгалзсан **гамшгийн эрсдэлийн удирдлагын** (ГЭУ)-н мөчлөгтэй нийцдэг. LEGS-н үйл ажиллагаанууд хариу арга хэмжээ, нөхөн сэргээх рүү илүүтэй төвлөрдөг ба ГЭУ-н мөчлөг (*Бүдүүвч 1.1-г харна уу*)-н онцгой байдал бодитоор нүүрлэхээс өмнө эрсдэлийг тодорхойлох, бэлэн байдлыг хангах нь чухал болохыг мөн онцолдог. LEGS энэхүү мөчлөгт бэлэн байдал хамгийн гол үүрэгтэйг хүлээн зөвшөөрдөг тул LEGS-н гарын авлагын энэхүү гурав дахь хэвлэлд бэлэн байдлын стандартуудыг техникийн олон бүлгүүдэд LEGS-н бэлэн байдлын зарчимд тулгуурлан оруулсан болно (*Бүлэг 2-н Зарчим 4: Бэлэн байдал-г харна уу*).

LEGS дэх гамшгийн төрлүүд ба үе шатууд

LEGS онцгой байдлыг дараах хоёр үндсэн төрөлд авч үздэг:


1. Удаан явцтай гамшиг;
2. Гэнэтийн гамшиг;

Мөргөлдөөн, улс төрийн тогтворгүй байдал гэх мэт нь ган гачиг мэтийн удаан явцтай гамшиг, эсвэл газар хөдлөлт зэрэг гэнэтийн гамшиг өөр бусад хүчин зүйлстэй хавсарч болох юм. Энэ төрлийн хавсарсан гамшгийн үед олон хүн нэрвэгдэж тэдний хэрэгцээг хангах их хэмжээний тусламж шаардлагатай болдог. Гамшиг урт хугацаанд үргэлжилж сунжирсан гамшиг болох магадлалтай байдаг ба зарим бүс нутагт байгалийн гамшиг тодорхой



давтамжтай тохиолдож ужгирсан/давтагдсан онцгой байдалд хүргэдэг.

Бүдүүвч 1.1: Гамшгийн эрсдэлийн удирдлагын мөчлөг



Эх сурвалж: Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын стратегид үндэслэв (ISDR)

Онцгой байдлын хариу арга хэмжээг төлөвлөхдөө ямар төрлийн гамшиг гэдгийг тодорхой болгох нь чухал. Гэнэтийн гамшиг, удаан-явцтай гамшиг ба хавсарсан гамшгийн жишээнүүдийг *Хайрцаг 1.2*-т харуулав.



Хүснэгт 1.2: Гамшгийн төрлүүд ба жишээнүүд

Гамшгийн төрөл	Гамшгийн жишээ
Удаан явцтай гамшиг	Ган гачиг Хахир өвөл (Монголын зуд)
Гэнэтийн гамшиг	Үер Газар хөдлөлт Галт уулын дэлбэрэлт Шуурга (далайн хар шуурга-хуррикан, тайпуун, циклон) Хээрийн түймэр (аяндаа эсвэл хүний буруутай үйлдлээс) Амьтан, ургамлын зарим өвчин, хортон шавьж
Хавсарсан гамшиг	Богино эсвэл урт удаан хугацааны мөргөлдөөний улмаас хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх Мөргөлдөөнтэй онцгой байдлын үед өөр төрлийн гамшиг, ган гачиг хавсрах Улс төр, эдийн засаг ба нийгмийн хямрал Хил дамжин халдварладаг өвчин эсвэл цар тахлын дэгдэлт нь өөр төрлийн гамшигтай хавсрах

1



Өөр, өөр төрлийн гамшиг, онцгой байдлын үед тодорхой цаг хугацаанд ялгаатай үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх шаардлагатай байдаг тул LEGS удаан явцтай болон гэнэтийн гамшгийн үе шатыг дараах байдлаар ялгаатай тодорхойлдог. Үүнд:

- Удаан явцтай гамшгуудын LEGS-н үе шатууд **сэрэмжлүүлэг /түгшүүр/ онцгой байдал/нөхөн сэргээлт (ган гачгийн менежментийн мөчлөгт-т суурилсан загвар).**
- Гэнэтийн гамшгуудын үе шат нь **шууд үр дагавар/эрт нөхөн сэргээлт/ нөхөн сэргээлт.**

Эдгээр үе шатууд гамшгийн үр нөлөөтэй хэрхэн харгалздагийг *Бүдүүвч 1.2-т* харуулж байна.

Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөлтөд LEGS-н аргачлал эдгээр ялгаатай үе шатуудыг (*Бүлэг 3: Онцгой байдлын хариу арга хэмжээ төлөвлөгөө*-г хар) сонгосон үйл ажиллагааг хэрэгжүүлэх хамгийн тохиромжтой цаг хугацааг тодорхойлоход ашигладаг.

Бүдүүвч 1.2: Удаан явцтай болон гэнэтийн гамшиг дахь LEGS-н үе шатууд



Хавсарсан эсвэл удаан үргэлжилсэн гамшгийн үед онцгой байдал удаан явцтай эсвэл гэнэт тохиолдсон эсэхэд хамааруулж үе шатыг тодорхойлж болдог. Тухайлбал, иргэний дайны үед ган гачиг хавсарч тохиолдоход үйл ажиллагааг цаг хугацаагаар нь удаан явцтай гамшгийн үе шатанд тохируулж сонгоно. Дайн самуунтай оронд газар хөдлөлт хавсарсан онцгой байдлын хариу арга хэмжээг гэнэтийн гамшгийн үе шатаар төлөвлөвөл илүү оновчтой болох магадлалтай.



Мал аж ахуй эрхлэгчдэд гамшиг хэрхэн нөлөөлдөг вэ?

Гамшиг мал аж ахуй эрхэлдэг хүн амд *Хүснэгт 1.3*-т үзүүлсэнчлэн хэд хэдэн байдлаар нөлөөлдөг.

1

Хүснэгт 1.3: Мал амьтан болон мал аж ахуйтай холбоотой хүн амд гамшиг хэрхэн нөлөөлдөг вэ

Гамшгийн төрөл	Мал амьтан ба хүн амд яаж нөлөөлж болох вэ
Удаан явцтай гамшиг	Мал тарга хүчээ аажмаар алдах Малын зах зээлийн үнэ унаж, хүн амын хүнсний үнэ өсөх Малын тэжээл гэх мэт мал аж ахуйн орцуудын үнэ өсөх Хүн амын хүнсний аюулгүй байдал ба тэжээллэг чанар аажмаар муудах Гамшгийн нөхцөл хүндэрч олон мал хорогдох Хэрвээ үржлийн үндсэн сүрэг үхэж хорогдвол онцгой байдлын дараах нөхөн сэргээх үйл явцыг хүндрүүлдэг
Гэнэтийн гамшиг	Эхэн үед мал, (хүн) үхэж үрэгддэг Дэд бүтэц (зам болон хашаа хороо зэрэг), үйлчилгээ (мал эмнэлгийн үйлчилгээ зэрэг) болон мал амьтны тэжээл болон усан хангамж тасалддаг Хүмүүс нүүлгэн шилжиж малаасаа тусгаарлагддаг Хариу арга хэмжээ дутагдалтай байдгийн улмаас илүү олон мал үхэх, өвчин дэгдэх цаашид хор нөлөө ихэсдэг
Хавсарсан гамшиг	Бэлчээрийн хүрэлцээ багасдаг Зэвсэгт бүлэглэлүүд малыг хулгайлдаг Мөргөлдөөний улмаас зах зээл, үйлчилгээнд хүрэх боломжгүй болдог Харилцаа, холбоо, дэд бүтэц алдагдаж, нэрвэгддэг Хүмүүс ба мал амьтад нүүн шилждэг Хүний хоол, хүнсний аюулгүй байдал ихээр алдагдах ба өлсгөлөнгийн байдал сунжирдаг



LEGS-т хамааралтай бусад гол үзэл санаа ба ойлголтууд юу вэ?

LEGS нь доор дурдсан хэд хэдэн сайтар боловсруулсан яаралтай тусламж, хариу арга хэмжээг хүргэх үзэл санаанууд болон ойлголтуудаас бүрддэг.

Сөрөн тэсвэрлэх чадварын дүн шинжилгээ

20-р зууны сүүлийн арван жилийн тогтвортой амьжиргаа болон тогтолцоонд нөлөөлөх хөгжлийн бодлого нь LEGS-н чиг хандлагын үндсэн санааны үргэлжлэл болон бэхжиж байна. Сөрөн тэсвэрлэх чадвар гэх үзэл санаа нь тогтвортой амьжиргааны чиг хандлагыг бий болгодог. Энэ нь онцгой байдлын нөлөөлөл ба нөхөн сэргээх боломжийг бэхжүүлж, уялдуулах зорилготой. Сөрөн тэсвэрлэх чадавх нь хувь хүн, өрх айл, албан байгууллага, орон нутгийн засаг захиргаа, засгийн газар, бүр экосистемийн хувьд ч ижил ойлголт юм. Өөр өөр байгууллагууд өөрсдийн эрх мэдлээс шалтгаалж даван туулах чадавхыг өөр өөрөөр тодорхойлдог. Хувь хүний сөрөн тэсвэрлэх чадавх нь түүний эдийн засгийн байдал, мэдлэг, боловсрол, хүйс, эрүүл мэнд, нас зэрэг даван туулах ба дасан зохицох чадварт нөлөөлдөг олон хүчин зүйлээс хамаардаг.

Нутгийн иргэдийн сөрөн тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх нь тэднийг өөрсдийг нь болон амьжиргаа залгуулах үндсэн үүрэгтэй мал амьтныг нь ирээдүйд болзошгүй онцгой байдлын нөлөөллөөс хамгаалахад тусалдаг. Тухайлбал, газар тариалан ба мал аж ахуйн холимог аж ахуй эрхэлдэг өрхүүд өөрсдийн тэжээлээ бэлтгэн, үр тариа/тэжээлийн үнийг хямдруулах, мөн ургац буурах үед зарим малаа зах зээлд борлуулж бэлэн мөнгө болгодог. Мөн бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид тайван жилүүдэд малаа нөөцөлж, цаг хүндэрсэн жилд нь цочролоос хамгаалж чаддаг. Сөрөн тэсвэрлэх чадавхтай мал аж ахуйн систем нь хоол хүнс, түүний шимт чанарыг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг.

Сөрөн тэсвэрлэх чадавхын талаарх ойлголт нь LEGS-н Зарчмууд болон амьжиргааны зорилтуудтай нийцдэг. Гэвч, одоогоор онцгой байдлын үеийн хариу арга хэмжээ нь урт хугацаанд сөрөн тэсвэрлэх чадварыг сайжруулсан эерэг нөлөөллийн талаарх тодорхой нотолгоо хараахан байхгүй байна.

Шинэ цар тахал ба түүний нөлөөлөл

Зооноз өвчин (**зооноз**) гэдэг нь мал амьтнаас хүнд дамжин халдварладаг өвчин юм. Зооноз өвчинд боом, галзуу гэх мэт бидний сайн мэддэг мал амьтнаас хүний эрүүл мэндэд аюул занал учруулдаг өвчнүүд багтдаг. Зэрлэг амьтад болон мал гээд хүн-мал амьтдын хоорондын харилцаа улам ойртох нь халдварт өвчнүүдийн эрсдэлийг улам нэмэгдүүлж байна. LEGS зооноз



өвчнүүдийг *Бүлэг 6: Мал эмнэлгийн тусламж*-н хүрээнд мал эмнэлгийн нийтийн эрүүл мэндийн хэсэгт тусгайлан оруулсан. Хүмүүс ба мал амьтныг хаана нүүлгэн шилжүүлнэ тэнд халдвар дамжих шинэ эрсдэл үүсч болно (*Бүлэг 7: Малын байр байршуулалт хэсэг*-г харна уу).

Мал амьтнаас хүмүүсийг өвчлүүлэх "шувууны томуу" цар тахал үүсгэсэн шиг вирус халдварлах эрсдэл байгааг эрдэмтэд урт хугацааны турш сануулсаар байсан. Цар тахал үүсгэсэн CAPC-КоВ-2-н вирус, Ковид-19-н вирус нь зэрлэг амьтдаас дамжин халдварласан байх магадлалтай ч мал аж ахуй эрхлэгчдэд нилээд сөрөг үр дагавар учруулсан байдаг. Ковид-19-н эдийн засгийн нөлөөлөл ба LEGS-н үйл ажиллагааны тасалдлыг *Хүснэгт 1.4*-т харуулав.

Хүснэгт 1.4: Ковид-19 цар тахал мал амьтанд суурилсан амьжиргаанд хэрхэн нөлөөлсөн ба LEGS-н арга хэмжээнүүд

Мал амьтан ба мал аж ахуй эрхлэгчдэд цар тахлын нөлөө	
Тэжээл	Зарим хаалттай нөхцөлд хоол, тэжээлийн дутагдалд орж байсан, тухайлбал, саалийн үнээнүүд.
Мал амьтны нүүлгэн шилжүүлэлт	Үндэстэн дотор болон олон улсын шилжилт хөдөлгөөнийг хорьсон (хил хаасан) бэлчээрийн МАА эрхлэгчид малаа бэлчээрлүүлэх, худалдан борлуулж чадахгүй болсон.
Зах зээл хаагдсан	Зах зээл хумигдаж мал аж ахуй эрхлэгчдийн орлого буурсан Мал аж ахуйн бүтээгдэхүүнүүд (өндөг, сүү)-г тээвэрлэх, борлуулахад хүндрэлтэй болсон. Мал аж ахуйн хэрэгслийн дутагдалд орсон.
Мал эмнэлгийн үйлчилгээ	Цар тахлын улмаас Засгийн газрын зарим вакцин түгээлт саатсан
LEGS-н үйл ажиллагаануудад цар тахлын нөлөө	
LEGS-н сургалт	Биет сургалт цахим руу шилжсэн.
LEGS-н оролцооны дүн шинжилгээ (анхан шатны үнэлгээ, хариу арга хэмжээг тодорхойлох, ХҮХС)	Олон нийтийн үйл ажиллагаа багасаж, цуцлагдаж байсан. Хүмүүсийн хоорондын алслалтыг багасгах чадвартай техник, технологи ашиглахдаа болгоомжтой байх шаардлага үүссэн.



Мал амьтан ба уур амьсгалын өөрчлөлт: Дэлхийн мэтгэлцээнүүд

Уур амьсгалын өөрчлөлтэй холбоотой судалгаа, шинжилгээний үр дүнд мал аж ахуй нь хүлэмжийн хий үйлдвэрлэлийн гол эх үүсвэр болохыг нотлон харуулах болсон. Энэ үр дүн нь ирээдүйн мал аж ахуй үйлдвэрлэл хүний хоол хүнсний тогтолцоо, өндөр түвшний улс төрийн мэтгэлцээний үндэс болж байна.

Давамгайлж байгаа улс төрийн байр суурь нь дэлхий нийтээрээ хүний хоол хүнсний хэрэгцээний дийлэнхийг ургамлын гаралтай болгох, мал аж ахуйн гаралтай хүнсний хэрэгцээг бууруулж бүр тэг хэрэглээ рүү зорих шаардлагатай гэсэн байна. Эдгээр мэтгэлцээнүүд мал аж ахуйн тогтолцоог дэмжих ёстой гэсэн бодлогыг оролцуулаад олон улсын тусламжийн бодлогод нөлөөлж байна. Зарим мэтгэлцээн бүр цаашлаад хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд нэвтрэх болжээ.

LEGS-д дэлхийн уур амьсгалын өөрчлөлт нь анхаарлын төвд байх чухал асуудал ба хүлэмжийн хийн ялгарлыг нэн даруй бууруулах шаардлагатай гэж үздэг. Үүний зэрэгцээ хүмүүнлэгийн хямралд өртөж байгаа ядуу буурай, эрсдэлтэй бүлгийн мал аж ахуй эрхлэгчдэд тусламж үзүүлэх хамгийн тохиромжтой арга зам нь мал аж ахуйгаас хамааралтай дэмжлэг гэж үзсээр байна. Бодлогын мэтгэлцээнүүд LEGS-н хүрээнд хамаардаггүй, том хэмжээний үйлдвэржсэн мал аж ахуйн тогтолцооноос гарсан тоон мэдээлэлд ихэвчлэн тулгуурласан байдаг. (Бүлэг 2-т *Зарчим 3: Уур амьсгал ба хүрээлэн буй орчин*-г харна уу).

Бичил биетний тэсвэржилт

Бичил биетний тэсвэржилт (ББТ) бол онцгой анхаарах, шинээр гарч буй асуудал юм. Энэ нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрчимжсэнтэй холбоотой антибиотикийн хэтрүүлсэн болон буруу хэрэглээ, хяналтгүй худалдаанаас шалтгаалж байна. Яаралтай хариу арга хэмжээний тусламжийн багцад антибиотик оруулсан тохиолдолд LEGS удирдамждаа алхам тутамд ББТ бууруулах зохистой хэрэглээг зөвлөдөг.

Нэг эрүүл мэнд

Нэг эрүүл мэнд үзэл баримтлал нь: Хүний эрүүл мэнд, мал, амьтны эрүүл мэнд ба хүрээлэн буй орчны эрүүл мэндийг хамтруулан авч үздэг. Эдгээрийг заримдаа салгаж авч үздэг ч хоорондоо салшгүй холбоотой сэдвүүд юм. Эдгээр харилцан холбоотой системд аюул занал учруулж байгаа хүчин зүйлд хүн амын өсөлт, байгалийн нөөцийн ашиглалт, хэт нүсэр дэд бүтцийн хөгжил, мөн мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрчимжүүлэлт ба тэлэлт орно. Мөн дэлхийн хүн ба мал амьтан (зэрлэг амьтдыг оролцуулаад), бүтээгдэхүүний



шилжилт хөдөлгөөнөөр эрсдэл нэмэгдэж байна.

Мал эмнэлгийн нийтийн эрүүл мэндийн үйлчилгээ нь хүн, мал амьтан ба хүрээлэн буй орчны эрүүл мэндийг холбон үздэг урт хугацааны түүхтэй. Эртний болон өнөөгийн олон зоонoz өвчнүүдээс сэргийлэх чиг хандлага нь өвчний тархан халдварлалт ба эрсдэлийг тооцсон олон талт цогц арга барилтай. Одоо ч мөн Нэг Эрүүл мэнд үзэл баримтлалын шаардлага улам нэмэгдэж байна. Онцгой байдлын хариу арга хэмжээнд амьжиргаанд нөлөөлөх эерэг нөлөөллийн баталгаа хязгаарлагдмал байна. Гэхдээ, LEGS удирдамжид онцгой байдлын үед агентлагууд мал амьтнаар үүсдэг өвчнүүдээс нийтийн эрүүл мэндийг хэрхэн хамгаалахад анхаарах ёстойг тусгасан байдаг.

Хүмүүнлэг-Хөгжил-Энх тайван уялдаа холбоо

Улс төрийн ноцтой болон өргөн хүрээг хамарсан тогтворгүй байдал болон түүнд хамааралтай мөргөлдөөн нэмэгдэж, хавсарсан онцгой байдлууд улам нэмэгдэх хандлагатай байна. Одоо хүмүүнлэгийн санхүүжилтийн ихэнх хувь нь тэрхүү хавсарсан онцгой байдалд зарцуулагдаж байна. Ган гачиг, хүчтэй хар салхи мэтийн байгалийн гаралтай гамшигт үзэгдлийн давтамж болон хор нөлөө нэмэгдэж эрсдэлд байгаа хүмүүс өмнөхөөсөө илүү олноор нэрвэгдэхийн зэрэгцээ дээрх хавсарсан гамшгийн нөлөөнд ч давхар орох магадлал үүссээр байна.

Хүмүүнлэг-Хөгжил-Энх тайвны холбоо нь хавсарсан онцгой байдлын хариу арга хэмжээнд хүмүүнлэг, хөгжил ба энх тайвны салбарууд уялдан ажиллах чиг хандлагыг илүүд үзэж байна. LEGS-н хувьд хавсарсан хүмүүнлэгийн хямралын хариу арга хэмжээнүүдийг зохицуулахад яаралтай болон урт-хугацааны хэрэгцээ хоорондын уялдааг хангах шаардлагатайг чухалчилдаг (Бүлэг 2-н Зарчим 5: Хариу арга хэмжээний зохицуулалт-г харна уу).

Малын даатгал

Малын индексжүүлсэн даатгал нь тэжээл, ус, байр, хашаагаар хангах гэх мэтээр мал хөрөнгийг хамгаалах зардлыг шийдэх дагалдах үйл ажиллагаа болж LEGS-т тусгагддаг. Ийм тогтолцоог хөгжүүлэх сонирхол нэмэгдэж байгаа ч даатгалын бодлого баригчид мал аж ахуй эрхлэгчдийг бүгдийг бус өчүүхэн хэсгийг даатгалд хамруулдаг. LEGS нь даатгалын компаниудын чухалчилдаг бүлгээс гадна орхигддог хямралд нэрвэгдсэн нутгийн иргэд рүү чиглэдэг. Одоогоор, LEGS-н хүрээнд малын даатгалын талаар заавар гаргах даатгалын үр нөлөөний талаарх хангалттай үнэлгээ, судалгаа байхгүй байна.



LEGS нь Sphere болон Хүмүүнлэгийн Стандартуудын Түншлэл (ХСТ)-тэй хэрхэн уялдах вэ?

Sphere 1997 онд байгуулагдаж, хүмүүнлэгийн үйл ажиллагааны чанар ба хариуцлагыг сайжруулах зорилгоор хүмүүнлэгийн хариу арга хэмжээний минимум (наад захын) стандартуудыг боловсруулсан. Sphere Гарын авлагад тэдгээр наад захын стандартуудыг тусгасан байдаг ба 2018 онд дөрөв дэх хэвлэлийг боловсруулан гаргасан байдаг. Sphere нь хүмүүнлэгийн хариу арга хэмжээний амин чухал элементүүдэд анхаарал хандуулдаг. Энэ нь хүний эрхэд суурилсан хүчирхэг тогтолцоо ба түүний хууль эрхзүйн үндэс болно. Sphere-н үндсүүд бол чанар ба хариуцлагыг тусгасан **Хүмүүнлэгийн Тунхаг, Хамгааллын Зарчмууд** болон **Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт** юм.

LEGS-н анхны хэвлэл 2009 онд хэвлэгдсэн. Хэвлэгдсэн цагаасаа Sphere Гарын авлагын хүний хамгааллыг оролцуулсан хүмүүнлэгийн үндсүүдтэй маш нягт уялдаж ирсэн. LEGS-г хэрэглэнэ гэдэг нь хариу арга хэмжээний төлөвлөгөө ба хэрэгжилтэд чухал нөлөө үзүүлдэг Sphere-н үндсүүдийг дагаж мөрдөнө гэсэн үг юм. Энэ нь бүх төрлийн онцгой байдлын үед мал аж ахуйд хамааралтай хариу арга хэмжээний хяналт, нөлөөллийн үнэлгээ болон хариуцлага зэрэгт бас хамаардаг (*Бүлэг 3: Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөлт* харна уу).

LEGS нь 2016 оноос эхлүүлсэн стандарт санаачлагуудын хамт, Хүмүүнлэгийн Стандартууд Түншлэл (ХСТ)-г үүсгэн байгуулагчдын нэг юм. Sphere-н баримт бичгүүд нь ХСТ-н үндэс болох доор дурьдсан бүх стандарт санаачлагуудыг багтаадаг:

- Sphere Гарын авлага;
- Хуарангийн менежментийн наад захын стандартууд;
- Хүмүүнлэгийн Үйл ажиллагаан дахь Хүүхэд Хамгааллын наад захын стандартууд;
- Ахмад настнууд ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан Хүмүүнлэгийн Оролцооны стандартууд;
- Боловсролын Наад захын Стандартууд;
- Мал аж ахуйн онцгой байдалд баримтлах заавар ба стандартууд;
- Эдийн засгийг сэргээх наад захын стандартууд;
- Зах зээлийн дүн шинжилгээний наад захын стандарт;
- Онцгой байдлын үеийн газар тариалан-хамааралт амьжиргааг дэмжих Стандартууд;
- Хүмүүнлэгийн үндсэн стандарт (ХҮС) нэгдэл (ХСТ дэд гишүүн ба Хүмүүнлэгийн үндсэн Стандартын хамтран зохицуулагч).



Хайрцаг 1.3

LEGS-н Хүмүүнлэгийн стандартуудын түншлэл (ХСТ) дэх үүрэг амлалт

Хүмүүнлэгийн тунхаг

Хүмүүнлэгийн тунхаг нь байгууллагуудаас хүмүүнлэгийн зарчмыг баримтлах ба хийж буй ажилдаа хариуцлагатай хандах үүрэг амлалтыг шаарддаг. Тунхаг бичигт олон улсын хуулиудын гурван төлөөлөл болох хүний эрхийн хууль, дүрвэгсдийн хууль ба олон улсын хүмүүнлэгийн хууль багтдаг. Үүнд мөн ёс зүйн хоёр суурь зарчмууд болох хүмүүнлэгийн зарчим, хүмүүнлэгийн зайлшгүй шаардлагын зарчим орно. Хүмүүнлэгийн Тунхаг бичигт хүмүүнлэгийн байгууллагууд дараах гурван эрхийг хүлээн зөвшөөрөхийг санал болгодог: нэр төртэй амьдрах; хүмүүнлэгийн тусламж авах; хамгаалуулах болон аюулгүй байдлаа хангуулах.

Хүмүүнлэгийн Тунхаг бичигтэй холбогдох LEGS-н үүрэг амлалт нь LEGS-н хүний эрхийн үндэс, түүн дэх хүмүүнлэгийн тусламж хамгаалалтыг сурталчлан таниулах замаар хүртээмжтэй байдлыг хангадаг. LEGS нь гамшигт нэрвэгдсэн бүс нутгуудын нийгмийн эмзэг бүлгүүд рүү чиглэж хариу арга хэмжээ үзүүлдэг. Тэдгээрт хүүхдүүд (ялангуяа тусгаарлагдсан, асран хамгаалагчгүй эсвэл өнчин хүүхдүүд), эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эсвэл шашин шүтлэг, гарал үүсэл, нийгмийн бүлэг ба хүйсийн байдлаар гадуурхагдсан хүмүүс багтдаг (Бүлэг 2-н Зарчим 2: Нийгмийн оролцоо-г мөн харна уу).

Хамгааллын Зарчмууд

Онцгой байдлын хариу арга хэмжээг хэрэгжүүлж буй байгууллагууд нь нэрвэгдсэн хүн амд тусламж үзүүлэхдээ тэдний үйл ажиллагаа нь эрсдлийг нэмэгдүүлэхгүй байх хариуцлагыг хүлээдэг. Үүнийг хангахдаа Sphere Гарын авлага дахь дөрвөн Хамгааллын Зарчмуудыг нэг бүрчлэн дагаж мөрдөх ёстой. Үүнд:

- Хүмүүсийн аюулгүй байдал, нэр хүнд болон эрхийг хангах байдлыг сайжруулах ба тэдэнд цаашид учирч болзошгүй хор хөнөөлийг зайлуулах;
- Хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн тусламжийг ялгаварлан гадуурхалтгүй, ижил тэгш хүргэх нөхцөлийг хангах;
- Заналхийлэл, биет хүчирхийлэл, албадлага, гачигдлын улмаас бие мах бод, сэтгэлзүйн хямралд өртсөн хүмүүст нөлөөллөөс ангижрахад туслах;
- Хүмүүсийг эрхээ эдлэхэд нь туслах.



Бүлэг 2-н Хавсралт 2.1 дэх LEGS-н дэмжлэгүүд Хамгааллын Зарчмуудыг хэрхэн нэг бүрчлэн ашиглахыг харна уу

Чанар ба Хариуцлагатай байдлын Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт

Бүх Хүмүүнлэгийн стандартуудын түншлэл (ХСТ)-н санаачлагуудад онцгой байдлын хариу арга хэмжээнд чанар ба хариуцлагыг сайжруулахыг чухалчилдаг. Тэд Чанар ба Хариуцлагыг тусгасан Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт (ХҮС) ба түүний есөн үүрэг амлалтыг даган мөрдөж, хэрэгжүүлдэг. Үүрэг амлалт бүр чанарын шалгуурууд, гол үйл ажиллагаанууд болон зааварчилгаатай.

Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт (ХҮС) дахь үүрэг амлалт нь зохион байгуулалтын түвшин юм. Тийм учраас мал аж ахуйд хамааралтай хариу арга хэмжээг оролцуулаад бүх төрлийн хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь үүрэг амлалтаар дамжсан зохион байгуулалттай дэмжлэг болж хэрэгждэг. Тиймээс мал аж ахуйтай хамааралтай хариу арга хэмжээний хариуцлагыг Хүмүүнлэгийн стандартуудын түншлэл (ХСТ)-н ерөнхий үүрэг амлалтууд болон чанарын шалгуурт багтаан үнэлдэг. LEGS нь Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт (ХҮС)-тай хэрхэн нийцэж байгааг LEGS Зарчмууд бүлэгт үзүүлэв (*Бүлэг 2-г харна уу*).

LEGS-н Зарчмууд хэрхэн Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт (ХҮС)-н үүрэг амлалтуудыг дэмжиж байгааг *Хавсралт 2.2-т* тоймлон оруулсан тодорхой бүрдлүүдээс харж болно.

LEGS-н тухай илүү ойлголт авах мэдээллийн ямар эх үүсвэрүүд байна вэ?

LEGS-н техникийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх зөвлөмж

LEGS нь мал аж ахуйн онцгой байдлын хариу арга хэмжээний чанар болон хариуцлагын тогтолцоог илүү сайжруулахыг зорьдог. Сайн дэмжлэг, нотолгоонд суурилсан хэрэглээ ба шийдвэр гаргалт бүхий стандарт болон заавраар хангаж энэхүү зорилгодоо хүрдэг. Гэхдээ LEGS мал аж ахуйд хэрхэн яаж дэмжлэг үзүүлсэн, улс үндэстний онцгой байдлын хариу арга хэмжээний арга барил, тусламжийн санхүүжилтыг хэрхэн босгох талаар тодорхой мэдээлэл өгдөггүй.

НҮБ-ын ХХААБ-аас 2016 онд онцгой байдлын үед "мал аж ахуйн тусламжийн



үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх заавар хэвлэн гаргасан. (НҮБ-ын ХХААБ 2016)" Энэхүү заавар нь LEGS-н дагалдах баримт бичиг болохоор загварчлагдсан болно:

НҮБ-ын ХХААБ (2016) Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаа "Хэрхэн хийх" гарын авлага. Edited by Philippe Ankers, Suzan Bishop, Simon Mack and Klaas Dietze. FAO Animal Production and Health Manual No. 18. Rome, <https://www.fao.org/3/i5904e/i5904e.pdf>

LEGS зааврын техникийн бүлэг бүрт (Бүлэг 4, 5, 6, 7, 8, 9) хамааралтай хэрэглээний хэсгийг ХХААБ-ын заавраас авч тусгасан. Мөн LEGS-н техникийн бүлэг бүрийн төгсгөлд байгаа цаашид унших хэвлэлийн жагсаалтад хэрэглээний гарын авлагуудын эх үүсвэрүүдийг багтаан оруулсан байгаа.

Мал амьтны тавлаг байдал

Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ). Бид юу хийх вэ: Мал амьтны тавлаг байдал. See <https://www.woah.org/en/what-we-do/animal-health-and-welfare/animal-welfare/>

ДМАЭМБ-ын хуурай газрын амьтдын эрүүл мэндийн кодекс-т мал амьтны тавлаг байдлын талаарх зөвлөмж багтсан. (дээрх линк харна уу). Мөн үндэсний олон байгууллагууд малын тавлаг байдлын стандарт удирдамжийг боловсруулж түгээдэг. Жишээ нь: <https://science.rspca.org.uk/sciencegroup/farmanimals/standards>

Тогтвортой амьжиргаа

Тогтвортой амьжиргааг тусгасан маш олон хэвлэлийн материал байдаг нь: Chambers R. and Conway, G. (1991) Sustainable rural livelihoods: practical concepts for the 21st century, IDS Discussion Paper no. 296, <https://www.ids.ac.uk/publications/sustainable-rural-livelihoods-practical-concepts-for-the-21st-century/>

DFID (1999) Sustainable livelihoods guidance sheets, DFID 1999–2001, <https://www.livelihoodscentre.org/documents/114097690/114438878/Sustainable+livelihoods+guidance+sheets.pdf/594e5ea6-99a9-2a4e-f288-cbb4ae4bea8b?t=1569512091877>

Serrat O (2008) The sustainable livelihoods approach, ADB Knowledge Solutions paper, <https://www.adb.org/sites/default/files/publication/27638/sustainable-livelihoods-approach.pdf>

Levine S (2014) How to study livelihoods: bringing a sustainable livelihoods framework to life, Working Paper 22, Secure Livelihoods Consortium, <https://securelivelihoods.org/wp-content/uploads/How-to-study-livelihoods-Bringing-a-sustainable-livelihoods-framework-to-life.pdf>



Цар тахлууд

Дараах хэвлэл, материалууд нь цар тахлын нөхцөл дэх мал аж ахуйн хөтөлбөрийн заавар, зөвлөмжийг тусгасан:

FAO (2020) Guidelines to mitigate the impact of the COVID-19 pandemic on livestock production and animal health, <https://www.fao.org/in-action/kore/publications/publications-details/en/c/1277631/>

FAO (2020) Guidance note: risk communication and community engagement. Coronavirus disease 2019 (COVID-19) pandemic, <https://www.fao.org/policy-support/tools-and-publications/resources-details/en/c/1306987/>

Global Food Security Cluster (2020) Guidance for emergency livestock actions in the context of COVID-19: addressing emerging needs related to the pandemic and reprogramming on-going critical activities, <https://fscluster.org/coronavirus/document/guidance-emergency-livestock-actions>

Catley, A (2020) COVID-19, livestock and livelihoods: a discussion paper for the Livestock Emergency Guidelines and Standards (LEGS), <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2021/01/LEGS-COVID-19-Discussion-Paper-single-pages.pdf>

LEGS (2020) COVID-19 response: LEGS guidance note, (LEGS), <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/04/LEGS-COVID-19-Guidance-Note-28-April-2020.pdf>

Малын эм, бичил биетний тэсвэржилт

Дэлхий нийтэд хүндрэл болж буй бичил биетний тэсвэржилт (ББТ) ба хэрэглэгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг харуулдаг дараах хэлэлцүүлгийн өгүүлэл нь LEGS-н хэрэглээ, судалгааны төслийн туршлагауд болон дүгнэлтүүдийг багтаасан болно:

Hufnagel, H (2020) The quality of veterinary pharmaceuticals: a discussion paper for the Livestock Emergency Guidelines and Standards (LEGS), <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/11/LEGS-Discussion-Paper-The-Quality-of-Veterinary-Pharmaceuticals.pdf>

Hufnagel, H (2022) The quality of veterinary pharmaceuticals: LEGS technical brief, LEGS, https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2022/06/Quality-Veterinary-Pharma-Brief_June-2022.pdf



Хүмүүнлэгийн Стандартуудын Түншлэл (ХСТ)

Одоогоор, Хүмүүнлэгийн Стандартууд Түншлэл нь Sphere болон есөн санаачлагыг багтаадаг.

The Sphere Handbook, Sphere Association, <https://spherestandards.org/handbook-2018/>

Minimum Standards for Child Protection in Humanitarian Action (CPMS), The Alliance for Child Protection in Humanitarian Action, https://alliancecpa.org/en/CPMS_home

Livestock Emergency Guidelines and Standards (LEGS), <https://www.livestock-emergency.net/download-legs/>

Minimum Economic Recovery Standards (MERS), SEEP Network, <https://seepnetwork.org/MERS>

Minimum Standards for Education, Inter-Agency Network for Education in Emergencies (INEE), <https://inee.org/resources/inee-minimum-standards>

Minimum Standard for Market Analysis (MISMA), CALP Network, <https://www.calpnetwork.org/publication/minimum-standard-for-market-analysis-misma/>

Humanitarian inclusion standards for older people and people with disabilities, Age and Disability Capacity Programme (ADCAP), <https://www.helpage.org/what-we-do/emergencies/adcap-age-and-disability-capacity-building-programme/>

Minimum Standards for Camp Management Global Camp Coordination and Camp Management (CCCM) Cluster, <https://ccmcluster.org/resources/minimum-standards-camp-management>

Standards for Supporting Crop-related Livelihoods in Emergencies (SEADS), <https://seads-standards.org/>

Core Humanitarian Standard (CHS), CHS Alliance (HSP Associate member and co-curator of the CHS), <https://corehumanitarianstandard.org/>



LEGS-д хамаарахгүй сэдвүүдийн талаарх мэдээллийг цаашид ямар эх сурвалжаас авах боломжтой вэ

Мал амьтны өвчний онцгой байдлын зааврууд

Мал амьтны өвчний тархалт заримдаа мал аж ахуйд суурилсан амьжиргааг маш ихээр сүйтгэдэг ч, LEGS үүнд хариу арга хэмжээг хариуцахгүй. Тийм нөхцөлийг даван туулах дэлгэрэнгүй зөвлөмжийг өөр эх үүсвэрүүдээс авах боломжтой. LEGS мөн хил дамжин халдварладаг мал амьтны өвчний тархалтыг хянахгүй. Үүний тухайд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тусгай зааврууд бий.

The World Organisation for Animal Health (founded as OIE) (2021) Terrestrial Animal Health Code, <https://www.woah.org/en/what-we-do/standards/codes-and-manuals/terrestrial-code-online-access/>

Guides from the FAO Emergency Prevention System for Animal Health (EMPRES-i), <https://empres-i.apps.fao.org/>

The Food and Agriculture Organization of the United Nations (FAO) produces disease-specific guides, such as:

Tuppurainen, E., Alexandrov, T. and Beltrán-Alcrudo, D. (2017) 'Lumpy Skin Disease: A Field Manual for Veterinarians', FAO Animal Production and Health Manual No. 20, FAO, Rome, <https://www.fao.org/3/i7330e/i7330e.pdf>

FAO and OIE/WOAH (2020) Global control of African swine fever: a GF-TADS initiative, 2020–2025. Paris, <https://www.woah.org/app/uploads/2021/06/global-control-of-african-swine-fever-a-gf-tads-initiative-2020-2025.pdf>

Загас, усны аж ахуй ба зөгийн аж ахуй

LEGS загас, усны аж ахуй, зөгий үржүүлэг (зөгийн аж ахуй)-г хамаарахгүй, гэхдээ НҮБ-н ХХААБ дараах заавраар хангасан байдаг:

Cattermoul, B., Brown, D. and Poulain, F. (eds) (2014) Fisheries and aquaculture emergency response guidance, FAO, Rome, <https://www.fao.org/3/i3432e/i3432e.pdf>

FAO, IZSLT, Apimondia and CAAS (2021) Good beekeeping practices for sustainable apiculture, FAO Animal Production and Health Guidelines No. 25, Rome, <https://www.fao.org/documents/card/en/c/cb5353en>



Хань бараа болдог тэжээвэр амьтад

Хүмүүнлэг ба амьжиргааны хэтийн төлөвт ордог хань бараа болдог тэжээвэр амьтад (муур, нохой гэх мэт)-ыг LEGS шууд хамааралдаа авдаггүй. Гэхдээ, LEGS-н олон стандарт ба зааварт хань бараа болдог тэжээвэр амьтдыг тэмдэглэн оруулсан байгаа. Онцгой байдлын үед хань бараа болдог тэжээвэр амьтдын талаарх цаашид ашиглах боломжтой эх үүсвэрийн холбоос: <https://www.nal.usda.gov/legacy/awic/disaster-planning>

Мал амьтны даатгал

Aklilu, Y (2020) Livestock insurance: a discussion paper for the Livestock Emergency Guidelines and Standards, LEGS, <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2021/01/LEGS-Insurance-Discussion-Paper-single-page.pdf>

Онцгой байдлын оролцоонуудын амьжиргаанд суурилсан тохиолдлын судалгаануудыг харах холбоос: <https://www.livestock-emergency.net/resources/case-studies/>







Бүлэг 2:

Зарчмууд

- 49 Танилцуулга
- 49 Зарчим 1: Амьжиргаанд суурилсан хөтөлбөрийг дэмжих
- 53 Зарчим 2: Олон нийтийн оролцоог хангах
- 56 Зарчим 3: Уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээ ба байгаль орчныг хамгаалах
- 59 Зарчим 4: Бэлэн байдал ба эрт арга хэмжээг дэмжих
- 61 Зарчим 5: Хариу арга хэмжээнүүдийн зохицуулалтыг хангах
- 64 Зарчим 6: Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрийг дэмжих
- 66 Зарчим 7: Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих
- 69 Зарчим 8: Хяналт, үнэлгээ, хариуцлагатай байдал ба суралцах амлалт (ХҮХС)
- 72 Хавсралт 2.1: LEGS ба Sphere-н Хамгааллын Зарчмуудын уялдаа холбоо
- 73 Хавсралт 2.2: LEGS-н Зарчмууд нь Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт (ХҮС)-ыг дэмжих нь
- 75 Эх сурвалж ба цаашид унших материал



Бүлэг 2: LEGS-н Зарчмууд

Танилцуулга

Энэхүү бүлэгт LEGS-н найман зарчмыг тодорхойлж харуулав. LEGS-н Зарчмууд гэдэг нь нотолгоонд суурилсан эсвэл олон жилийн үйл ажиллагааны туршлага, түүний үнэлгээ юм. Үүнд хяналт үнэлгээний ба хэрэгжүүлэгчдийн туршлагыг мөн хамруулж үздэг. LEGS-н Зарчмууд нь Sphere-н суурь ойлголтуудаас дагалдан гардаг. Тэдгээр суурь асуудлууд мөн хүмүүнлэгийн хямралууд (*Бүдүүвч 2.1*)-ын үед мал аж ахуйд хамааралтай хариу арга хэмжээний үр дүнд тулгуурлан хэрэгжүүлэх арга замыг багтаадаг. LEGS-н Зарчмууд хэрхэн Sphere-н Хамгааллын Зарчмууд болон Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт (ХҮС)-тай нийцэж байгааг *Хавсралт 2.1* ба *2.2*-т харуулав.

LEGS-н Зарчмуудыг хүмүүнлэгийн бүх нөхцөл болон LEGS-н бүх техникийн үйл ажиллагаанд баримталдаг. Гэхдээ, зарчим бүр практик хэрэглээ болох нь тухайн нөхцөл байдлаас хамаарч өөр өөр байж болно. Хүмүүнлэгийн тусламж нь мухардмал байдлыг засахад чиглэгдэж, байгууллагууд зарчмыг ойлгох ба хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг ч улс төр, аюулгүй байдал юм уу бусад асуудлуудын тусгай нөхцөл байдал нь зарчмыг практик хэрэглээ болоход нөлөөлж болно. Хэрэгжүүлэгч байгууллагууд онцгой байдлын үйл ажиллагааныхаа турш LEGS-н бүх Зарчмуудыг баримталдаг. Тэд бас өөрсдийн дотоод зохион байгуулалт болон ажлын арга барилдаа зарчмуудыг баримтлах ёстой.

Зарчим 1: Амьжиргаанд суурилсан хөтөлбөрийг дэмжих

Амьжиргаанд суурилсан мал аж ахуйн хөтөлбөрийн ашиг тус

LEGS-н амьжиргаанд суурилсан хөтөлбөрийг дэмжих Зарчим нь 'амь нас ба амьжиргааг хамгаалах' хүмүүнлэгийн ерөнхий зорилготой нийцдэг. Энэ зарчимд хүмүүнлэгийн хариу арга хэмжээнд хүмүүсийн амьжиргааг хамгаалах ба онцгой байдлын дараа нөхөн сэргээх дэмжлэгийн үйл ажиллагаанууд багтах ёстой. LEGS-н амьжиргаанд суурилсан хөтөлбөрийн зөвлөмж нь Sphere-н суурь ойлголт дахь хүний эрхэд суурилсан чиг хандлагатай нягт уялддаг. Малын ашиг шимийг хүртэж, хүнс орлогоо залгуулдаг хүмүүс онцгой байдлын тусламжид хамрагдаж, мал сүргээ хамгаалуулах, нөхөн сэргээлгэх эрхтэй.



Зураг 2.1: Sphere-н суурь ойлголтууд, LEGS-н Зарчмууд ба LEGS-н техникийн үйл ажиллагаанууд



Мал аж ахуй эрхлэгчдийн амьжиргааг нь хангадаг ямар мал амьтанд ямар замаар гамшиг нөлөөлж болохыг *Хайрцаг 2.1*-т тоймлон харуулав. Хүмүүсийн гамшиг, онцгой байдлыг тэсвэрлэх чадварыг тодорхойлох нэн



тэргүүний хоёр хүчин зүйл нь тэдний санхүүгийн хөрөнгө ба олон нийтийн сүлжээ болдог. Энэ нь мал амьтан, санхүүгийн гол хөрөнгө болохоос гадна хөдөө орон нутагт нийгэмд эзлэх байр суурийг илэрхийлдэг гэсэн үг.

Хайрцаг 2.1

Онцгой байдал дахь мал амьтан ба амьжиргааны хөрөнгө

Мал амьтан, санхүүгийн үнэт хөрөнгө/нөөц

Бага болон дунд орлоготой олон улс орнуудад мал амьтан нь санхүүгийн хоёр эх үүсвэр буюу бэлэн мөнгөний орлого мөн санхүүгийн хуримтлалын хэлбэр болдог. Өрхийн орлогынх нь нилээд хувь нь мал амьтан ба малын гаралтай бүтээгдэхүүнээ худалдан борлуулснаар бүрддэг. Үүнтэй ижлээр, мал амьтан нь хуримтлалын хамгийн чухал төрөл нь болдог. Тэд хуримтлалын өсөлт (мал, амьтан нөхөн үржих мэт) болон шаардлагатай хэрэгцээгээ мал амьтан хөрөнгөө уян хатан зохицуулж хангадаг. Үүнд өрхийн хэрэгцээ ч мөн багтана. Газар хагалах, эд зүйлсээ зах зээлд тээвэрлэх зэргээр ажлын мал амьтнаас эдийн засгийн хамгийн чухал ашиг тусыг хүртдэг.

Мал амьтан, нийгмийн үнэт хөрөнгө/нөөц

Онцгой байдлын үед хүмүүсийн эсэн мэнд тэсч үлдэх чадвар нь тэдний хамаатнууд болон найз нөхдийн тусламж, дэмжлэгээс хамаарч болно. Хөдөө орон нутгийн нөхцөлд зээл авах эсвэл бэлэг өгөхдөө мал амьтан ба түүний бүтээгдэхүүнээр орлуулан шийдэх зэргээр мал амьтанд суурилсан солилцоо нь орон нутгийн нийгмийн харилцаа холбоог дэмжих тогтолцоог ихэвчлэн маш найдвартайгаар дэмждэг. Ийм тогтолцоог хэвийн үед байдаг шиг онцгой байдлын үеийн, мөн онцгой байдлын дараах нөхөн сэргээх үе шатанд ч хэрэглэж болдог. Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид ба газар тариалан-мал аж ахуй эрхлэгчдийн нийгэмлэгүүд нь ган гачиг, өвчний тархалт юм уу бусад шалтгаанаар малаа алдсан өрхүүдийг малжуулах нарийн тогтолцоотой байна.

Мал амьтан, хүн үнэт хөрөнгө/нөөц

Амьжиргааны ойлголтод өрхийн эрүүл мэндийн байдал, боловсролын түвшин болон ажиллах чадвар зэргийг хүний үнэт хөрөнгө гэж авч үздэг. Сүү болон өндөг зэрэг мал, амьтны гаралтай хоол хүнс нь өндөр тэжээллэг чанартай ба энэ нь ялангуяа бага насны хүүхдүүд, мөн жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдэд нэн шаардлагатай байдаг. Ийм хоол хүнсээр хүүхдийн бие махбодь, оюун санааны өсөлтийн хэрэгцээг хоёуланг нь хангадаг. Ядуу өрхүүд мал амьтны гаралтай хоол тэжээлийг өөрийн мал амьтнаас шууд хэрэглэх нь ийм хоол хүнсийг авах, хэрэглэх ганц боломж нь байх магадлалтай.



Онцгой байдлын үед мал аж ахуйн дэмжлэгийг сонгож, тодорхойлохдоо оролцоог хангах аргуудыг ашиглах шаардлагатай (*Бүлэг 3: Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөө*-г харна уу). Ингэснээр мал аж ахуй эрхлэгчид *Хайрцаг 2.1*-т үзүүлсэн LEGS-н үйл ажиллагааны нэг, эсвэл хэд хэдэн амьжиргааны дэмжлэгээс сонгох боломжтой болно. Тэд мал аж ахуй гол хөрөнгийг хамгаалахыг чухалчилдаг ба LEGS-н амьжиргааны зорилтуудтай эдгээр амьжиргааны дэмжлэгүүд нийцдэг.

LEGS-н техникийн үйл ажиллагаануудаар гамшигт нэрвэгдсэн хүн амыг дэмжих зорилтууд нь:

- 1. Байгаа малаас шууд ашиг хүртэх;** ба/эсвэл
- 2. Үндсэн мал хөрөнгийг хамгаалах;** ба/эсвэл
- 3. Үндсэн малыг нөхөн сэргээх.**

Амьжиргаанд суурилсан хөтөлбөр ба орон нутгийн үйлчилгээ, зах зээл

LEGS-н амьжиргаанд суурилсан аргачлалууд нь амьжиргааны чухал хөрөнгө болох мал амьтныг хамгаалахыг зөвлөж мал аж ахуй эрхлэгчдийн онцгой байдлаас эргэн сэргэхэд нь шаардлагатай үйлчилгээнүүд, зах зээл болон тогтолцоог дэмжихийг мөн зорьдог. Энэхүү чиг хандлагад онцгой байдлын үед ТББ-ууд, засгийн газраас малын эм, тэжээл болон бусад зүйлсийг үнэгүй тараасан муу туршлагатай сургамжийг ч харгалзан үздэг. Үнэгүй зүйлс нь орон нутгийн хувийн хэвшлийн тоглогчдын хүчийг сулруулж, орон нутгийн зах зээлийн тогтолцоог нураах, эсвэл тохиромжгүй бүтээгдэхүүн шахаж оруулах боломжийг бий болгох магадлалтай. LEGS хувийн мал эмнэлгийн ажилчид, мал эмнэлгийн туслах мэргэжилтнүүд, тэжээл ханган нийлүүлэгчид болон худалдаачдаас тусгаар ажиллахын оронд эдгээр үйлчилгээнийхнийг татан оруулж ажиллахыг зөвлөж байна. Энэ нь LEGS-н техникийн үйл ажиллагааны төлөвлөлт болон хэрэгжилтэд тэднийг татан оруулах арга юм. Илүү дэлгэрэнгүй зааврыг LEGS-н техникийн бүлгүүдэд тусгасан болно.

Амьжиргаанд суурилсан хөтөлбөр, хөгжлийн болон хүмүүнлэгийн дэмжлэгийн ялгаа

LEGS-н техникийн үйл ажиллагааг хувийн хэвшилтэй эсвэл засгийн газартай хамтран хэрэгжүүлэхдээ дэмжлэгийн төрлүүдийг хооронд нь ялгах нь чухал. Дэмжлэгийн төрлүүдэд онцгой байдлын үед болон онцгой байдлын дараах яаралтай тусламжийн шатанд мал хөрөнгийг хамгаалах эсвэл нөхөн сэргээх тусламжууд хамаарна. Бусад төрлийн дэмжлэгүүд нь урт хугацаатай хөгжлийн үйл ажиллагаанд хамаарна. Дэмжлэгийн төрлүүдийг ялгах нь хүмүүнлэгийн тусламжийн нөөцүүдийг хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулахаас зайлсхийхэд тусалдаг. Энэ нь нөөцийг үр дүнтэй, үр ашигтай



ба ёс зүйтэй ашиглах Хүмүүнлэгийн үндсэн стандарт (ХҮС)-н Амлалт 9-тэй нягт уялдана (LEGS-н Зарчмууд ХҮС-тай хэрхэн холбогдохыг харуулсан *Бүлэг 1: LEGS-н Танилцуулга-н Хавсралт 2.2-г* харна уу).

Хүмүүнлэгийн үйл ажиллагааны хэтийн төлөвт энэхүү ялгааны хүрээнд тэжээл, ус, мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээ зэрэг мал аж ахуйн үндсэн хэрэгцээг илүүд үздэг. Үүнд ханган нийлүүлэгчид ба үйлчилгээ үзүүлэгчдэд хамааралтай хэрэглэгдэхүүнүүд ч багтана. Харин өвчний тандалт, мал аж ахуйн хөгжлийг урт хугацаанд дэмжих, цогц бодлогыг боловсруулах, мөн байгууллагын түвшний зохион байгуулалтын асуудлууд зэрэг тогтолцооны дэмжлэгүүд нь нэн тэргүүнд эрэмбэлэгддэггүй ба үүнийг, онцгой байдлын биш 'хэвийн' үед анхаарах шаардлагатай. Хэрэгцээ шаардлагыг иргэд болон орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй хамтран үнэлж, хариу арга хэмжээг хамтдаа төлөвлөх ба мал аж ахуйгаас хамааралтай шаардлагатай дэмжлэгийг эрэмбэлэн сонгодгоороо хүмүүнлэгийн үйл ажиллагаа нь хөгжлийн хэрэгцээ шаардлагаас ялгаатай юм.

Хүмүүнлэгийн ба хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг хооронд нь тодорхой ялгах нь хэзээ ч хялбар байдаггүй. Хавсарсан гамшгийн хүмүүнлэгийн хөтөлбөрүүд удаан-хугацааны үйл явц болдог. Цаг хугацаа сунжрахад, мал аж ахуйн мэргэжилтнүүд өвчний тандалт, мал эмнэлгийн нийтийн эрүүл мэнд, бусад нийгмийн салбарын үйл ажиллагаа зэрэгт бодлого болон зохицуулалтын шинэчлэлт хийх дэмжлэгийг зайлшгүй шаарддаг. Дээрх арга хэмжээнүүдэд хүмүүнлэгийн нөөцөөс ашиглах нь хэр зэрэг үндэслэлтэй болох нь тухайн нөхцөл байдал (мал аж ахуйн үндсэн хэрэгцээ болох тэжээл, усан хангамж болон мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээ зэргийг хангасан эсэх)-с хамаарна.

Зарчим 2: Олон нийтийн оролцоог хангах

Онцгой байдлын үеийн мал аж ахуйн төслүүд дэх олон нийтийн оролцоо

Үр нөлөөтэй ба ёс зүйтэй хүмүүнлэгийн тусламжийн үндсэн үзэл санаа бол олон нийтийн оролцоо юм. Энэ нь Хүмүүнлэгийн Тунхаг бичгийн анхны зарчим ба Хүмүүнлэгийн үндсэн стандарт (ХҮС)-н үүрэг амлалт ба чанарын шалгуур (*Хавсралт 2.2-г* харна уу)-т шууд холбогддог.

Sphere-н Хамгааллын Зарчмуудтай тохирох шаардлага нь олон нийтийн оролцоо юм. Тухайлбал, үйл ажиллагаанууд нь хүмүүст хор нөлөөгүй, заналхийлэл, хүчирхийллийн эрсдэлээс ангид хэрэгжих нөхцөлөөр хангахад анхаарна (*Бүлэг 1 LEGS-н Танилцуулга, Хайрцаг 1.3-г* харна уу).



Онцгой байдлын мал аж ахуйн үйл ажиллагаанд хариу арга хэмжээг төлөвлөх ба хэрэгжүүлэхдээ олон нийттэй нягт хамтран ажилладаг олон жилийн туршлагатай тодорхой байгууллагууд байдаг. Тэдэнд мөн олон нийтийн оролцооны чанар ба амьжиргаа дахь нөлөөллийн хоорондын уялдааг харуулсан баримтууд бий. Оролцоонд орон нутгийн байгаль орчин, бэлчээрийн менежмент, мал аж ахуйн үйлдвэрлэл, өвчин эмгэг, мал, амьтны хөдөлгөөнтэй холбоотой, нийгмийн уламжлалт тогтолцоо мэтийн талаарх уугуул иргэдийн мэдлэгийг хүндлэх нь чухал. Энэхүү мэдлэг нь тохиромжтой яаралтай арга хэмжээг ялган таних үед практик ач холбогдол өгдөг. Энэ нь өрхийн эдийн засагт мал аж ахуй голлодог нийгэм, орон нутгийн хувьд бүр илүү хамааралтай байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэл болон өвчин эмгэгийн тухай статистик мэдээлэл авах боломжгүй, хуучирсан байх үед энэ талаарх орон нутгийн мэдлэгийг нэгтгэх нь чухал. Мал аж ахуйгаасаа нэн хамааралтай илүү алслагдсан ба хязгаар хөдөө нутагт мал аж ахуйн мэдээлэл хязгаарлагдмал байх нь нийтлэг. Орон нутгийн уламжлалт байгууллагууд, удирдагчид хэрэгцээ шаардлагыг эрэмбэлэх, тохиромжтой арга хэмжээг төлөвлөх хурал цуглаан, ярилцлагад мал аж ахуй эрхлэгчдийг дайчлах, удирдан зохион байгуулах чухал үүрэг гүйцэтгэж болно.

Олон нийтийн идэвхтэй оролцоог хангах

Онцгой байдлын мал аж ахуйтай холбоотой хариу арга хэмжээнд оролцдог байгууллагууд оролцооны аргыг өргөн ашиглаж байна. Гэсэн хэдий ч, 'олон нийтийн оролцоо' гэж юу болох, болон хүмүүнлэгийн нөхцлүүдэд үр дүнтэй оролцооны төрлүүд юу болох талаар ойлголт өөр өөр байх тохиолдол байдаг. Онцгой байдлын мал аж ахуйтай холбоотой нөхцлүүдэд энэ нь боломжтой гэдэг нь харагдсан учраас байгууллагуудад идэвхтэй оролцоо (*Хүснэгт 2.1*-г харна уу)-г дэмжихийг LEGS зөвлөдөг. Энэ нь мөн мал аж ахуйгаас амьжиргаанд үзүүлэх үр ашигтай нягт холбогддог. Мал аж ахуй эрхлэгчид төслийн бүх үе шат болох: үнэлгээ, загварчлал, төлөвлөгөө, хэрэгжүүлэлт болон хяналт, үнэлгээ, хариуцлагатай байдал, суралцах амлалт (ХҮХС)-д оролцох ёстой.

Идэвхтэй олон нийтийн оролцооны нэг хэсэг болгож нийгмийн угсаа болон эд баялгийн ялгаатай бүлгүүдийг анхаарч үзэх нь чухал юм. Хүмүүсийн эд баялаг, хүйс, нас юм уу бусад хүчин зүйлээс хамаарч малыг ашиглах ба эзэмших нь өөр байдаг. Тийм учраас мал аж ахуйн оролцоог үр дүнтэй тодорхойлох, загварчлах болон хэрэгжүүлэхэд эрсдэлд өртөж болзошгүй, эмзэг бүлгийн мал аж ахуй эрхлэгчдийн тусгайлсан оролцоог шаарддаг. Үүнд бас мал амьтан, малын бүтээгдэхүүнийг хэрэглэж ашиг хүртдэг эрсдэлд байгаа эмзэг бүлгийг багтаах ёстой. Тийм бүлгүүдэд магадгүй өрх толгойлсон эмэгтэй,



дотоодод нүүлгэн шилжүүлсэн хүмүүс, дүрвэгчид, эсвэл харьяалалгүй хүн ам багтаж болно.

Анхдагч үнэлгээгээр үйл ажиллагаанууд нь ялгаатай бүлгүүдэд хэрхэн өөр нөлөө үзүүлэхийг анхаарах шаардлагатай. Байгууллагууд нь эдгээр ялгаанд мэдрэмжтэй байх шаардлагатай ба эрэгтэйчүүд, баян чинээлэг хүмүүс, орон нутгийн удирдлага, уламжлалын бүлгүүд давамгайлан оролцохоос сэргийлэх хэрэгтэй. Мал аж ахуй эрхлэгчдийн насны ялгаатай бүлгүүдийн оролцоог хэрхэн хангахаа анхдагч үнэлгээгээр тооцох хэрэгтэй. Учир нь удирдан зохион байгуулах, орлого олох чадвар нь наснаас хамаарч ялгаатай байдагтай адил тэдний үүрэг хариуцлага ч харилцан адилгүй байж болно.

Үнэлгээ болон хэрэгжилтийн үе шатанд эмэгтэйчүүд, өндөр настан, эрсдэлт бүлгийн хүмүүс (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эмэгтэйчүүдийг оролцуулаад)-н оролцоонд хориг болох зүйлийг арилгах нь чухал. Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан Хүмүүнлэгийн оролцооны стандартыг харна уу. Мөн байгууллагууд нь хүүхэд ба өсвөр насныхны хөдөлмөр эрхлэлт, хамгааллын аюулгүй байдал гэсэн хоёр хүчин зүйлийг анхаарч болзошгүй эрсдэлүүдээс хамгаалах нь чухал. *Зарчим 3-н Хүүхдийн оролцоо*, болон *Стандарт 22*, Амьжиргаа ба хүүхэд хамгаалал: *Хүүхдийг Хамгаалах Наад захын Стандартууд* (CPMS)-г үзнэ үү.

Идэвхтэй оролцоо нь олон нийттэй ойр байх, байгууллагын ажилчид болон орон нутгийн хүмүүс хоорондын сайн харилцааг шаарддаг. Ковид-19-ын хязгаарлалтуудын нэг үр нөлөө нь олон улс оронд шууд харилцдаг нийгмийн бүлгүүдэд илүү сорилтуудыг бий болгосон. Ковид-19-ын хязгаарлалтын үйл явцуудаас одоо ч туршлагауд бий болсоор байна. Гэхдээ ерөнхий сургамж нь Ковид-19-ын нөхцөлд орон нутгийн байгууллагууд болон сүлжээ холбоонууд олон улсын байгууллагуудаас илүү өөрчлөлтөд дасан зохицож байлаа (LEGS-н *Зарчим 7: Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих*-г мөн харна уу).

Хүснэгт 2.1: Онцгой байдлын үеийн мал аж ахуйд хамааралтай үйл ажиллагааны олон нийтийн оролцооны төрлүүд

Олон нийтийн оролцооны төрөл	LEGS-т холбогдох нь
Идэвхгүй оролцоо: Олон нийт нь шийдэгдсэн эсвэл аль хэдийн тохиолдсон зүйлд оролцох. Хүмүүсийн үзэл бодлыг сонсоогүй гадны байгууллагын мэдэгдэл эсвэл зохион байгуулалттайгаар хийвэл нэг талын л үзэл баримтлал болдог. Мэдээлэл дан гадны мэргэжилтнүүдийнх байна.	Sphere-н үндсүүдтэй нийцэхгүй ба LEGS үүнийг зөвлөхгүй.



Зөвлөлдөх оролцоо: Олон нийт нь зөвлөх юм уу асуулт асуух замаар оролцох. Гадны байгууллагууд асуудлууд тодорхойлох ба мэдээлэл цуглуулах үйл явц мөн хяналтын дүн шинжилгээг ч хийнэ. Зөвлөлдөх үйл явцад ямар ч шийдвэр гаргалтыг хэлэлцэхгүй бөгөөд мэргэжилтнүүд хүмүүсийн үзэл бодлыг хүлээн авах үүрэг хүлээхгүй.	дээрхтэй ижил.
Материаллаг урамшуулалд суурилсан оролцоо: Олон нийт материаллаг урамшуулал (бэлэн мөнгө, хоол мэт)-д дульдуйдан ажиллах хүч зэргийг ханган оролцох.	дээрхтэй ижил.
Үйл ажиллагааны оролцоо: Гадны байгууллагуудын үзэмжээр үйл ажиллагааны зорилгын хүрээнд олон нийтийг татан оролцуулах. Хүмүүс урьдчилан тодорхойлсон төслийн зорилтуудыг хэрэгжүүлэх бүлгүүдийг бүрдүүлж оролцдог. Тэд шийдвэр-гаргахад оролцож болох ч тэр нь зөвхөн гадны байгууллагуудын аль хэдийн гаргасан том шийдвэрүүдийн хүрээнийх байх болно.	дээрхтэй ижил.
Идэвхтэй оролцоо: Хүмүүс үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, дүн шинжилгээ хийх болон орон нутгийн бүлгүүд байгуулахад мөн чадавхжуулахад оролцох. Оролцоо нь төслийн зорилгуудад хүрэх гэхээсээ илүүтэй эрхийн хүрээнд гэж харагддаг. Бүлгүүд орон нутаг дахь шийдвэрүүдэд хяналт тавихаас эхлээд хэрхэн нөөц боломжийг орон нутгийн бүтэц ба үйл ажиллагааг эвдэхгүйгээр ашиглах зэрэгт хувь нэмэр оруулдаг.	Энэ нь Sphere-н үндсүүдтэй нийцдэг; Энэ онцгой байдлын мал аж ахуй төслүүдэд сайн хэрэглээ болж тусгагддаг; LEGS үүнийг зөвлөдөг.
Өөрийгөө дайчлах: Гадны оролцогчдоос хамаарахгүй бие даан санаачлага гарган оролцох. Тэд нөөц боломж болон тэдэнд шаардлагатай техникийн зөвлөмжийг авахын тулд гадны тоглогчидтой холбоо тогтоодог ч нөөц хэрхэн ашиглагдаж байгаа хяналтаас гадуур байдаг. Хэрвээ засгийн газар болон ТББ-аас таатай нөхцөл бүрдэж, дэмжлэгтэй байвал өөрийн дайчлалт нь түгэн дэлгэрэх боломжтой.	Онцгой байдлын үеийн мал аж ахуйтай хамааралтай санаачлагуудад өөрийгөө-дайчлах оролцооны талаар маш бага баримт байна.

Зарчим 3: Уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээ ба байгаль орчныг хамгаалах

Мал аж ахуй ба уур амьсгалын өөрчлөлтийн талаарх дэлхий нийтийн мэтгэлцээн

LEGS мал аж ахуйн бүтээгдэхүүний уур амьсгалын өөрчлөлт дэх нөлөөллүүдийн дэлхийн мэтгэлцээний ач холбогдлыг талархан хүлээн авдаг. Гэсэн ч, одоо дэлхийн олон зуун сая хүн мал аж ахуйгаас амьжиргааны ашиг хүртэн, гамшгийн эрсдэлтэй бүс нутгуудад амьдарч байна. Дунд болон урт хугацаандаа хөдөө орон нутагт мал аж ахуйгаас маш их хамааралтай хүн



амын амьжиргааны бусад олон талт ба бололцоотой сонголтууд ерөнхийдөө хомс байна. Энэхүү хамааралд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний шууд хэрэглээ ордог. Уураг болон бусад хэрэгцээт тэжээлээр баялаг, хоол хүнс дутмаг улс, орнуудын хувьд мал аж ахуй нь өлсгөлөнд нэрвэгдсэн асар олон хүн амыг хоол тэжээлээр хангадаг.

LEGS нь мал аж ахуйн тогтолцоо ба хүний хоол хүнсний талаарх том хэлбэрийн мэтгэлцээнүүдэд үйлдвэржсэн мал аж ахуйн тоон мэдээллийн судалгаанд ихэвчлэн тулгуурладаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Бага орлоготой улс орнуудын ядуу хүн амын эрхэлдэг жижиг аж ахуй болон бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэл нь эдгээрээс үндсээрээ ялгаатай. Шийдвэр гаргагчид мал аж ахуйн ялгаатай үйлдвэрлэлийн тогтолцоо, амьжиргааны хэлбэр, тухайн нөхцөлийг анхаарч үзэх шаардлагатай. Тэд аж үйлдвэржсэн орнуудын арилжааны мал аж ахуйн тогтолцоонд зонхилж хамаарах өргөн хүрээний болон хялбаршуулсан шийдвэрүүдээс зайлсхийх ёстой.

Амьжиргаанд үзүүлэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө

Уур амьсгалын өөрчлөлт голчлон мал аж ахуй эрхлэгчид, тэдний мал амьтан ба амьжиргаанд шууд болон шууд бусаар харилцан хамааралтай замуудаар нөлөөлдөг. Уур амьсгал дахь аажим өөрчлөлтүүд агаарын хэм, хур тунадасны өөрчлөлтөөр илэрч тэдгээр нь мал амьтны ашиг шимд нөлөөлдөг байна. Үүнд мөн усны хүртээмж, мал амьтны өвчний гаралт болон бэлчээрийн ургамлын зүйлийн бүрдэл, тухайлбал, Энэтхэг болон Зүүн Африкт давамгайлан тархаж байгаа *Prosopis juniflora* мэт зүйлийн нөлөөлөл, өөрчлөлтүүд орно. Шууд бус нөлөөлөлд хүний хүнс хоол болон мал амьтны тэжээлийн аль алиных нь зах зээл дэх үнийн өөрчлөлтүүд орно. Хүмүүсийн уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх хариу арга хэмжээ гэж тухайлбал, газар ашиглах аргаа өөрчлөх, био түлш хэрэглэх зэргийг хэлж болно. Ихэнх жижиг хэмжээтэй мал аж ахуй эрхлэгчид газраа багасган мал аж ахуй ба газар тариаланг хослуулан холимог фермийн систем ашиглаж байна. Тариалан, түүний тогтолцоо ч мөн адил уур амьсгалын өөрчлөлтөд өртөн, тэдгээр үйлдвэрлэгчид мал аж ахуй ба газар тариалангийн хосолсон аж ахуй руу шилжиж байна (SEADS стандарт харна уу).

Ерөнхийдөө ядуу буурай мал аж ахуй эрхлэгчдэд уур амьсгалын өөрчлөлттэй хамааралтай дарамтыг тэсч гарах чадавх сул байдаг. Ийм чадавхыг бэхжүүлэхэд илүү их зардал, санхүүгийн хөрөнгө оруулалт эсвэл зээл шаардлагатай нь ойлгомжтой. Олон жижиг үйлдвэрлэгчид байгалийн аюул учрахад нөлөөлөл нь илүү хүчтэй тусч, улам их эрсдэлд ордог. Байгалийн гаралтай аюул, гамшгийн тохиолдол, давтамж нэмэгдэж байгаа нь ядуу үйлдвэрлэгчдэд хүндээр нөлөөлөх төдийгүй мөн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой удаан явцтай юм уу гэнэтийн гамшгуудад өртөх эмзэг байдал нь



улам их нэмэгддэг. Эдгээр асуудлууд нь ужгирсан улс төрийн тогтворгүй байдал ба мөргөлдөөний үед улам нэрмээс болж хавсарсан гамшгийн нөхцөл байдалд хүргэдэг.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл нэмэгдэхийн хэрээр бага орлоготой ба дунд орлоготой орнуудын жижиг хэмжээтэй юм уу эрсдэлд орсон мал аж ахуй эрхлэгчдэд чиглэсэн үр дүнтэй гамшгийн эрт сэрэмжлүүлгийн тогтолцоо болон эрт үеийн хариу арга хэмжээг авахад бэлэн байх шаардлага улам илүү нэмэгдэж байна – LEGS *Зарчим 4: Бэлэн байдал*-г харна уу.

Малын хариулга ба орон нутгийн байгаль орчны менежмент

Ихэнх жижиг аж ахуй үйлдвэрлэгчид, мал бүхий иргэд бага орцтой, бага бүтээмжтэй үйлдвэрлэлийн тогтолцоог ашигладаг. Тэдгээр нь байгалийн бэлчээр, өвс, ус, үр тарианы багахан хаягдал зэргээс бүрэн хамааралтай байдаг.

Тиймээс байгаль орчны менежмент нь тийм хэмжээний мал аж ахуйн бүтээгдэхүүн ба түүнтэй холбоотой санхүү, нийгэм, хоол хүнс бүтээхэд туслах үндсэн хүчин зүйл нь болдог. Байгаль орчны менежментийн эргэн тойронд урт хугацааны бодлого ба хөгжлийн асуудлууд хамаарч цогц асуудал болдог бол үүний зарим асуудал нь LEGS-н хүрээнээс гадуур байдаг. Ядуу буурай мал аж ахуй эрхлэгчдийн хувьд гол хүндрэл нь ихэнхдээ газар өмчлөлийнх нь тодорхой бус байдалтай холбогддог. Ийм нөхцөл худалдааны юм уу улс төрийн сонирхлоор хялбар тохиролцож шийддэг газарт ядуу мал аж ахуй эрхлэгчид эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийж чадахгүй байдагтай холбоотой уг асуудал зонхилон үүсдэг.

LEGS нь орон нутгийн байгаль орчны менежментийг дэмжихийн тулд хэрэгжихүйц, мөн энгийн аргуудыг илүү ашигладаг. Энэ дэмжлэг онцгой байдлын үед ба онцгой байдлын дараах яаралтай нөхөн сэргээх шатанд хийгддэг.

Онцгой байдлын нөхцөлд мал аж ахуйгаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүд хэрхэн нэмэгдэх эрсдэлтэйг ойлгох нь чухал. Жишээ нь:

- Ган гачгийн улмаас бэлчээр, тэжээл, усны нөөц багасч, усны эх үүсвэр тойрсон мал амьтны нягтрал үүсч, тэнд бэлчээр талхлагдаж эхэлдэг.
- Хүмүүс малтайгаа хамт хуаран руу дүрвэн нүүж, улмаар хязгаарлагдсан бүс нутгуудад мал амьтны бөөгнөрөл бий болно. Хэдийгээр тэнд мал амьтныг ус, тэжээлээр хангах ч эрүүл ахуйн асуудал хүндэрч анхаарлын төвд орно. Хөрш залгаа нутгуудын орон нутгийн иргэдийн ашигладаг бэлчээр, худгийг ашиглаж, нөөцийг шавхан, байгаль орчин доройтон сүйрч болзошгүй нөхцөл үүснэ.
- Мөргөлдөөн, бусад хүчин зүйлийн улмаас нүүдэл ба хөдөлгөөн хоригдож,



мал, амьтны хэвийн нүүдэл, шилжилт хөдөлгөөн хязгаарлагдсанаар мал амьтны төвлөрөл бий болдог. Үүнээс үүдэн орон нутгийнх нь бэлчээр талхлагдаж, улмаар мал амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.

Зарим онцгой байдлын үед байгаль орчны асуудалд малын гаралтай хог хаягдлын менежмент (ялангуяа хуарангийн зохион байгуулалтын нөхцөл) багтдаг. Үүнд мал амьтны нядалгааны дараах дайвар хаягдал болон мал амьтны сэг зэм устгал зэрэг орно. Зарим онцгой байдлын нөхцөл, ялангуяа үерийн гамшгаар мал амьтан хэдэн арван мянгаараа үхдэг. Энэ нь байгаль орчин болон хүний эрүүл мэндэд маш их сөрөг нөлөөллийг авчирдаг.

Онцгой байдлын үеийн мал эмнэлгийн үйлчилгээний техникийн үйл ажиллагаанд байгаль орчны үнэлгээг тусгайлан авч үздэг. Энэ нь эм бэлдмэлүүдийг болгоомжтой хэрэглэх шаардлагад хамаарах ба ялангуяа, гадна шимэгчийн эсрэг угаалга, цацлагын зориулалттай эм бэлдмэл, мөн цагаан хорхойн эсрэг болон үрэвслийн эсрэг зэрэг тусгай эм бэлдмэлүүдийн хэрэглээ хамаарна.

2

Зарчим 4: Бэлэн байдал ба эрт үеийн арга хэмжээний дэмжлэг

LEGS-н тойм судалгаануудын нотолгоо ба хэрэглэгчдийн туршлага нь мал аж ахуйгаас хамааралтай эрт үеийн хариу арга хэмжээ, амьжиргааны үр нөлөө ба үр ашигтай байх хоорондын холбоог тодорхой харуулдаг. Эрт үеийн хариу арга хэмжээний үнэ цэнийн талаарх нотолгоонууд ихэнхдээ ган гачиг (удаан явцтай гамшиг)-н хариу арга хэмжээнээс үүдэлтэй. Гэсэн хэдий ч бэлэн байдал болон эрт үеийн хариу арга хэмжээний зарчим нь удаан явцтай гамшиг ба гэнэтийн гамшигт хоёуланд нь өргөнөөр ашиглагддаг. LEGS-н хэд хэдэн техникийн бүлгүүдэд бэлэн байдлын стандартыг энэхүү зарчмыг хэрэгжүүлэхэд туслах үйл ажиллагааны дэлгэрэнгүй заавартай нь оруулсан.

Гамшгийн эрсдлийг бууруулах (ГЭБ) гол элементүүдийг гамшигт өртөмтгий бүс нутгуудад дэмжлэг үзүүлэхэд ашиглах боломжтой байдаг. Эдгээр элементүүдэд бэлэн байдал, төлөвлөлт, эрт үеийн хариу арга хэмжээ багтана. Хавсарсан гамшгийн үед хэрэгжүүлэх ГЭБ-н үйл ажиллагааг удаан явцтай ган гачиг ба гэнэтийн гамшгийн үед гамшгаас үүдэлтэй тохиолдож болзошгүй бусад үр дагаваруудтай давхацсан үед хэрэгжүүлж болно. LEGS-н *Зарчим 3: Уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээ ба байгаль орчны хамгаалалт*-д дурьдсанаар уур амьсгалын хэлбэлзэл ихэсч байгаа нь LEGS-н үйл ажиллагаануудад бэлэн байдал ба хариу арга хэмжээг цаг



алдалгүй хэрэгжүүлэх чадавхыг сайжруулахыг шаардаж байна.

Зарим бүс нутгуудад, хөгжлийн төслүүдэд хөрөнгийг уян хатан арга замаар ашиглах нь нэмэгдэж байна. Энэ нь онцгой байдлын дараах хөрөнгийг хөгжлийн зориулалтаар түргэн ашиглах боломжийг нэмэгдүүлж байна гэсэн үг юм. Ган гачгийн үеийн мал аж ахуйн эрт үеийн хариу арга хэмжээ, түүний менежментийн мөчлөгийн үе шат зэрэгт дэмжлэг үзүүлэхэд ихэвчлэн ашигладаг хөрөнгийн уян хатан бодлогыг заримдаа хямралыг өөрчлөгч гэж нэрлэдэг. Эдгээр арга хэмжээнүүд нь LEGS-н зорилтуудын дагуу төлөвлөгдсөн мөн энэхүү төлөвлөлтдөө орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчид ба зах зээлийн тоглогчдыг оролцуулсан тохиолдолд энэ нь LEGS-н *Зарчим 1: Амьжиргаанд суурилсан хөтөлбөр*-тэй нийцнэ.

ГЭБ болон уян хатан санхүүжилтыг урт хугацааны хөгжлийн хөтөлбөрүүдэд зарцуулах боломжтой байдгаараа давуу талтай юм. Онцгой байдлын мал аж ахуйн арга хэмжээ хэрэгжсэн гол бүсүүд дэх урт хугацааны хөгжлийн туршлагатай байгууллагуудын үр дүнтэй хөтөлбөрүүдээр хөгжлийн хөтөлбөрүүдийн хэсэг болох гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулдаг. Энэхүү төлөвлөгөөг өмнөх хүмүүнлэгийн хариу арга хэмжээнүүдийн мэдлэг, туршлага болон хариу арга хэмжээний төрлүүдэд үндэслэн боловсруулдаг тул энэ нь тухайн тодорхой онцгой байдлын мөн санхүүжилтын нөхцөл байдлуудад хэрэгжих боломж олгодог. Гэсэн хэдий ч энэ тохиолдолд хөтөлбөрийн менежер нь хүмүүнлэгийн болон хөгжлийн, мөн эрт үеийн арга хэмжээний чиглэлээр маш их туршлагатай хүн байх шаардлагатай бөгөөд тэд бэлэн байдлыг хангах, эрт үеийн арга хэмжээ, мөн түүнчлэн хөрөнгө санхүүг уян хатан төлөвлөх чиглэлд доноруудтай хамтран ажилласан туршлагатай байх нь чухал.

Гамшиг, онцгой байдлын бүхий л төрлүүдэд эрт үеийн сэрэмжлүүлгийн системийг хөгжүүлэх, гамшгийн бэлэн байдлын төлөвлөлт хийх мөн уян хатан санхүүжилтын тогтолцоог бий болгоход олон нийтийн оролцоо маш чухал. Энэ талаарх мэдээллийг LEGS-н *Зарчим 2: Олон нийтийн оролцоог хангах*-д тусгасан болно. Бэлэн байдлын төлөвлөгөөг орон нутгийн байгууллагуудын болон олон нийтийн бүлэглэлүүдийн чадавхыг бэхжүүлэхийг зорьж боловсруулах ба орон нутгийн боломжтой мэдлэгүүдийг тусгах, эрт үеийн сэрэмжлүүлгийн үйл ажиллагааг багтаасан байх шаардлагатай. Ган гачигт өртдөг бүс нутгуудад тусгай чадавхыг бэхжүүлэх гангийн менежментийн мөчлөг нь үйл ажиллагаануудын гинжин хэлхээг хангаж өгдөг. Уур амьсгалтай холбоотой онцгой байдлын нөлөөнд өртдөг бүх бүс нутгуудад цаг уурын мэдээг дамжуулах ба мэдээг ашиглах чадавх маш чухал байдаг. Орон нутгийн оролцогч талуудад уур амьсгалтай холбоогүй газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт зэрэгт ч дээрхтэй ижил



мэдээлэл дэмжлэг хэрэг болдог.

Эрт сэрэмжлүүлэг, бэлэн байдал ба эрт үеийн хариу арга хэмжээ нь ихэвчлэн хэрэгжүүлэгч байгууллагуудын үндсэн техникийн үйл ажиллагаанууд болж харагддаг. Ер нь үр дүнтэй эрт үеийн арга хэмжээнд гол удирдан зохион байгуулагчийн оролцоо маш их хамааралтай. Энэхүү удирдагч зөвшөөрөл, худалдан авалт, баг бүрдүүлэлт болон бусад дараалсан үйл ажиллагааг шууд дэмжин хэрэгжүүлж чадна. Тэд мөн арга хэмжээг хэрхэн хурдтай, үечлэлтэй, ба гүйцэтгэх дэс дараалал зэрэг үйл ажиллагааг хэрхэн яаралтай арга хэмжээ болгохоо шууд зохицуулалтаар хангадаг. Тухайлбал, тээврийн компаниуд, тэжээл нийлүүлэгчид юм уу мал эмнэлгийн ажилчид зэрэг хувийн хэвшлийн хэрэгжүүлэгчдийг төлөвлөлтийн шатанд бэлтгэсэн гэрээний нооргийг ашиглан урьдчилан байршуулж болно.

Цаашлаад, бэлэн байдлын өөр нэг тал нь хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан хариу арга хэмжээг чанартай хүргэж чадахуйц хангалттай мэдлэг, туршлага, харилцааны үр чадвартай байх шаардлагатай. Үүнд мал аж ахуйн менежмент эсвэл мал эмнэлгийн сургалт зэргээр оролцогчийн болон олон нийтийн арга барил, туршлага сайжирсан зэрэг техникийн үр чадваруудтай байх зэрэг орно. (*Зарчим 2: Олон нийтийн оролцоо, ба Зарчим 7: Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих-г харна уу*).

Зарчим 5: Хариу арга хэмжээний зохицуулалтыг хангах нь

Ихэнх хүмүүнлэгийн хямралуудын үед олон янзын үйл ажиллагаанууд нэгэн зэрэг хэрэгждэг. Тиймээс нөлөөллийг нэмэгдүүлэх, хөрөнгийн ашиглалтыг хангах болон давхардлаас сэргийлэх зэрэг зохицуулалт хийх шаардлагатай болдог. Энэхүү зохицуулалт нь ихэвчлэн засгийн газраас эсвэл НҮБ-ын агентлагуудаар дамжин хийгддэг. Энэ нь нийтлэг зорилтуудад санаа нэгдэн LEGS зэрэг хүмүүнлэгийн стандартуудыг ашиглах олон байгууллагыг үйл ажиллагаанд татан оролцуулах нөхцөлийг бүрдүүлж өгнө. Бүх хамтрагч талуудаас гамшгийн хариу арга хэмжээний үед цаг хугацаа болон ажилтнуудын талаарх үүрэг амлалтаа биелүүлэхэд зохицуулалт нэн шаардлагатайг өмнөх сургамж, туршлагууд харуулж байна. Үүний тулд үндсэн арга хэмжээний хүрээнд тодорхой бүс нутагт, эсвэл онцгой байдлын тодорхой төрлүүдийн үед зохицуулалтыг хийх ажлын хэсгийг байгуулах нь үйл ажиллагаануудыг хооронд нь уялдуулахад тусална. Мөн хамтрагч талуудын үүрэг хариуцлагыг зөвшилцөж тодорхой болгосноор тэд амьжиргаа болон хэрэгжиж буй хөгжлийн санаачилгуудад нэгдэх боломжтой болдог.



Түүнчлэн хандивлагч доноруудын зүгээс ч хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаануудыг уялдуулахыг дэмжих, шаардах байр суурьтай байдаг. Зохицуулалтын хоёр үндсэн төрөл ихэвчлэн LEGS-т хамаардаг. Үүнд:

- Мал аж ахуйн үйл ажиллагаанууд хоорондын зохицуулалт
- Мал аж ахуйн үйл ажиллагаанууд ба бусад салбар хоорондын зохицуулалт.

Мал аж ахуйн үйл ажиллагаанууд хоорондын зохицуулалт

Мал аж ахуйн үйл ажиллагаануудын цар хүрээг тооцох, тэдгээрийг хүн амын тусгай дэд бүлгүүдэд эсвэл эрсдэлд буй бүлэгт тохируулан хэрэгжүүлэхэд хариу арга хэмжээнүүдийн хооронд зохицуулалт хийх нь нэн чухал. Хэрвээ олон хэрэгжүүлэгч байгууллагуудаар өөр төрлүүдээр тусламж хүргэж байгаа бол зохицуулалт нь давхардал болон хэрэгцээт төрлийн дэмжлэг хүрэхгүй байхаас сэргийлдэг. Тухайлбал, хэрвээ тэжээл, ус, малын эрүүл мэндийн хариу арга хэмжээнүүдийг хослуулах шаардлагатай нөхцөлд нэг төрлийн дэмжлэгийг нь орхигдуулбал бусад хариу арга хэмжээнүүдийг үр дүнгүй болгох эрсдэл үүсдэг.

Өөр өөр хэрэгжүүлэгч байгууллагууд ижил дэмжлэг үзүүлж буй тохиолдолд үйл ажиллагаагаа уялдуулж, хөтөлбөрийн үр дүнг тогтвортой байх зохицуулалтаар хангах ёстой. Жишээ нь, хэрвээ байгууллагууд зэргэлдээ орон нутгуудад малын тоо толгойг бууруулах үйл ажиллагаанд ялгаатай үнээр худалдан авалт хийх, эсвэл малжуулах үйл ажиллагаандаа өөр өөр хуваарилалтын бодлого (үнэгүй тараах, зээлээр өгөх, татаас гэх мэт бусад) ашиглавал эдгээр санаачлагууд нь бие биенийгээ үгүйсгэх нөхцөл болно. Мал эмнэлгийн тусламжид эмчилгээний өртөгт ялгаатай бодлого хэрэглэвэл үйл ажиллагааг сулруулах ба нөлөөлөлд өртсөн хүн амын дунд төөрөгдөл үүсгэж болно. Ган гачиг зэрэг удаан явцтай гамшгийн үед ган гачгийн үе шатанд тохирсон үйл ажиллагаануудын гинжин хэлхээг хангах зохицуулалт зайлшгүй шаардлагатай. Мал аж ахуйн туршлага багатай байгууллагуудыг илүү мэргэшсэн байгууллагуудаас техникийн заавар ба тусламж авахад хүчтэй зохицуулалт бас хэрэг болно.

Мал аж ахуйн үйл ажиллагаанууд ба бусад салбар хоорондын зохицуулалт

Мал аж ахуйн үйл ажиллагаануудыг бусад салбаруудын үйл ажиллагаатай уялдуулан хооронд нь зохицуулахад хоёр үндсэн асуудалд анхаарал хандуулах шаардлагатай.

Хүний амьдралыг аврах хүмүүнлэгийн чухал үйл ажиллагаанд мал аж ахуйг дэмжих үйл ажиллагааг цаг хугацаа болон чухлын зэргээр нь эрэмбэлэх



Онцгой байдлын үед, хамгийн шаардлагатай яаралтай арга хэмжээ нь нэрвэгдсэн хүн амын амь насыг аврах тусламжаар хангах байж болно. Ийм тохиолдолд мал аж ахуйн тусламж нь энэ чиглэлийн тусламжийн хүчийг сулруулах ба муугаар нөлөөлж болохгүй. Бодит байдалд яаралтай тээвэр, харилцаа холбоо юм уу бусад нөөц боломжууд хязгаарлагдсан нөхцөлд мал аж ахуйн салбар тусламж шаардлагатай хүн амд хоол хүнс, орон байр, ус болон эрүүл мэндийн тусламжийг хүргэхэд дайчлагдах ёстой гэсэн үг. Тухайлбал, усан хангамжийн хөтөлбөрүүдэд хүн амын усны хэрэгцээг түрүүлж хангах ёстой ба тухайн нөхцөлд мал амьтныг хангах шаардлага зэрэгцэн үүссэн бол хоёр бүлэгт зориулсан өөр чанартай усны нөөцийг шийдсэн байх шаардлага тавигдана.

Техникийн болон тээвэр холбооны бусад салбаруудтай хийх зохицуулалт

Мал аж ахуйн үйл ажиллагаануудын үр дүнг нэмэгдүүлэх мөн нөөцийг үр ашигтай ашиглахад хүмүүнлэгийн бусад төрлийн тусламжуудтай аль болох уялдах ёстой гэж LEGS-т зөвлөдөг. Хүмүүнлэгийн хямралд өртөж байгаа улс орнуудын ихэнх аж ахуйн тогтолцоо нь газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүний холимог тогтолцоо байдаг. Онцгой байдлын үед Газар тариалангаас хамааралтай амьжиргааг дэмжих стандартууд нь **SEADS**-д тусгагдсан байдаг. Хамтарсан үнэлгээнүүд хийх, хамтарсан хяналт ба үнэлгээний үйл ажиллагаанууд ба цаг хугацааны уялдааг хангах зэргийг багтаасан мал аж ахуй, газар тариалангийн үйл ажиллагааны зохицуулалтын олон боломжууд бий.

Зарим мал аж ахуй эрхлэгч орон нутагт хүүхдийг мал аж ахуйн ажилд туслуулдаг. Энэ нь тэдний сургуульд хамрагдалтад нөлөөлж болзошгүй ба онцгой байдлын үеийн боловсролд Боловсролын наад захын стандартууд (INEE) хамааралтай ба Хүүхэд хамгаалах наад захын стандартууд сургуулийн уян хатан хуанли ба албан бус боловсролын сонголтуудыг заавраар хангах ач холбогдолтой юм. Бусад салбаруудтай техникийн зохицуулалт хийх нь тухайн нөхцөл байдалд хамааралгүй байж болох ч хэрэгжүүлэгч байгууллагуудад нөөц боломжоо хуваалцах, тээвэр холбооны хэтийн төлөвлөгөөнд зохицуулалт хийх боломжуудыг бий болгодог. Тухайлбал, онцгой байдлын хариу арга хэмжээний тусламжийн барааг хүргэж ирсэн ачааны машиныг буцахад нь мал, амьтны тоо толгойг цөөлөх үйл ажиллагаанд хамааралтай малыг тээвэрлэх; хөргөгчүүдэд хүн ба мал амьтанд хоёуланд нь зориулсан эмийг хадгалах; хоргодох байранд хэрэглэгдэхгүй болсон зүйлсийг мал амьтны хашаа хороог сэлбэх, засахад хэрэглэх зэргээр ашиглаж болно.



Зарчим 6: Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрийн дэмжлэг

Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр нь ямар ч онцгой байдлын үед ач холбогдолтой. Энэ нь эмэгтэйчүүд ба охид, эрэгтэйчүүд ба хөвгүүд мэт жендерт хамааралтай хүмүүст тусгай өөр өөр хэрэгцээ байдаг учраас нөөцийн ашиглалт болон дасан зохицох стратеги нь ялгаатай байна. Жендерт хамаатай эдгээр ялгаатай нөөц ба дасан зохицох стратегийг ойлгож, хооронд нь ялгаж тодорхойлох хэрэгтэй.

Онцгой байдлын үед үр дүнтэй жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрийг ялган тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагууд дараах нөхцлүүдээс үүсдэг. Үүнд:

- Хямрал, онцгой байдал нь ихэвчлэн эмэгтэйчүүд, охид болон хөвгүүдийн ажлын ачааллыг нэмэгдүүлж, тэдний хоол хүнс, өмч хөрөнгийн хэрэглээ, чухал хэрэгцээт үйлчилгээгээр хангагдах нөхцөлийг нь бууруулдаг.
- Жендерт суурилсан хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэл нэмэгддэг. Энэ нь эмэгтэйчүүд, охид ба хөвгүүдийн зөрчил мөргөлдөөн, хүмүүнлэгийн хямралуудыг даван туулах ба нөхөн сэргэх чадварт сөргөөр нөлөөлдөг.

Өнөөгийн онцгой байдлын мал аж ахуйн хариу арга хэмжээнүүдэд илүү хүртээмжтэй жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрүүд, болон түүнд холбоотой амьжиргаа ба хоол тэжээллэгийн хэрэгцээний жишээнүүд бий болж байна. Хамгийн наад зах нь эмэгтэйчүүдийн амьжиргаанд мал амьтны үүрэг оролцоог ямар ч төрлийн онцгой байдлын үйл ажиллагааны нэг хэсэг болгон шийдэж байх ёстой. Эмэгтэйчүүдийн мэдэлд байгаа мал хөрөнгийн зохицуулалт нь хүүхдийн эрүүл мэнд болон хүнс тэжээлтэй холбоотой, ажлын ачаалал болон цагийн зохицуулалт зэрэг нэмэгддэг учраас энэ нь бага асуудал биш юм.

Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр ба LEGS-н техникийн үйл ажиллагаанууд

Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр нь зөвхөн эмэгтэйчүүд рүү чиглэх шаардлагатай бүс эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүд рүү ижил тэгш хандах ёстой. Гэхдээ, LEGS-н үйл ажиллагаануудын хүрээнд зарим гол асуудлууд эмэгтэйчүүдийг тусгайлан авч үзсэн байдаг. Үүнд онцгой байдлын үед эмэгтэйчүүдийн амьжиргааны хөрөнгийг хамгаалах, тэдний мал аж ахуй дахь үүрэг оролцоог тодруулах, амьжиргаанд нь зонхилон нөлөөлж болох соёл, эдийн засгийн хориг саадыг тодорхойлох зэрэг орно.



Онцгой байдлын хариу арга хэмжээнүүдийн туршлага, сургамжууд нь мал аж ахуйд жендерийн мэдрэмжтэй үүрэг, эрх болон хариуцлагын ойлголтыг эргэж харах шаардлагатайг харуулдаг. Үүнд үндсэн хөрөнгө мал аж ахуйн зохицуулалт ба түүнийг эзэмших бүрэн эрхийн асуудал орно. Ихэнх орон нутгуудад мал аж ахуй эрхлэгчдийг, мал амьтныг хянах 'эзэн' гэх жирийн ойлголт илүү байдаг. Тухайлбал, эмэгтэйчүүд ба хүүхдүүд нас гүйцсэн сүрэгт бус залуу, өсвөр насны мал сүргийг илүү хариуцсан байдаг. Эсвэл эмэгтэйчүүд сүү, цөцгийн тос, арьс шир зэрэг мал аж ахуйн бүтээгдэхүүнийг хариуцаж тэд илүүтэй хүнсний хангамжийг хянаж болно. Эрэгтэйчүүд ерөнхийдөө, мал амьтныг худалдах, солилцох юм уу бэлэглэх эрхтэй байх магадлалтай. LEGS-н техникийн үйл ажиллагаануудыг дагаж мөрдөхдөө эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхдүүдийн өдрийн болон улирлын ажлын үүрэг, хариуцлагыг ялган тодорхойлох шаардлагатай. Үүнд мал амьтны төрөл болон насны ангиллаас хамаарч тэдний үүрэг оролцоог тодорхойлно. Тухайлбал тахианы аж ахуй зэрэг жижиг амьтан эмэгтэйчүүдийн амьжиргаанд чухал үүрэгтэйг үл харгалзан том мал амьтны төрөл рүү анхаарсан байх жишээтэй.

Мал аж ахуй эрхлэгч орон нутгуудад эмэгтэйчүүд ба охид илүүтэй гадуурхал, хязгаарлалтуудтай тулгарах эрсдэл заналхийлж байдгийг анхаарах нь чухал. Үүнд тэдний амьжиргааны эх үүсвэр, мал аж ахуйн нөөц болон суурь үйлчилгээ авах нөхцөлүүд нь хязгаарлагдах зэрэг орно. Мөн бусад хориг гэсэн ойлголтод тэдний гэр бүл болон нийгмийн хариуцлага жигд бус, хамгаалах үйлчилгээ болон хууль эрх зүйн хувьд тэгш бус, орон нутгийн болон үндэстний түвшинд улс төрийн эрх тэгш бус байдал зэрэг багтана.

Эсрэгээрээ, онцгой байдлын зарим нөхцөлд мал аж ахуйн менежментэд эмэгтэйчүүд илүү эрх мэдэлтэй байр суурьтай байх тохиолдол байдаг ба энэ нь тухайлбал, эрэгтэйчүүд ажил хайхаар шилжин суурьшсан үед байж болно. LEGS-н техникийн үйл ажиллагаануудаар дамжуулж үүрэг, хариуцлагыг шинээр буй болгоход бус харин нөхцөл байдалд нь тохируулж байр суурийг нь бэхжүүлэхийг зорих нь чухал.

Онцгой байдлын нөхцөл байдал нь хэвшил болсон хүйсийн үүрэг оролцоог өөрчилж өвөрмөц боломжуудыг бий болгох боломжтой байдаг. Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүдэд хамааралтай үүрэг оролцоо (заримдаа албан бус) руу чиглэсэн хамгийн сайн арга бол олон нийтэд суурилсан бүлгүүдэд оролцуулах, бүлгийг удирдуулах арга байж болно.

Мал аж ахуйгаас хамааралтай дэмжлэгийн анхдагч үнэлгээ (*Бүлэг 3: Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөө*)-нд эрэгтэйчүүд ба хөвгүүд, эмэгтэйчүүд ба охидын оролцооны алийг нь урьтал болгохоо сайтар нягтлан тодруулах нь чухал. Үүнд мөн онцгой байдлын нөлөөлөл нь



хүйсийн ялгаатай байдалтай холбоотой өөр өөр байх талаарх мэдээллүүд, мөн хүйсээр ангилсан бүх мэдээллийг багтаана. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд болон хүүхдүүдийн ажлын ачаалал, тэдний хяналтад байгаа мал амьтных нь нөөцөд аливаа үйл ажиллагааны үзүүлэх нөлөөллийг тодорхой тооцсон байх шаардлагатай. Ингэснээр үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах мөн үр дүнг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.

Хүйсийн үүрэг, оролцоо, хариуцлага болон байр суурь өөрчлөгдөж байгааг мөн харгалзан үзэх шаардлагатай. Хэрэгжүүлэгч байгууллагууд эмэгтэйчүүдтэй хийх ярилцлагадаа байгууллагынхаа эмэгтэй ажилтнуудыг оролцуулах нь илүү хялбар байхыг мөн анхаарч үзэх хэрэгтэй. Онцгой байдлын үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжүүлэлт болон хяналтад цаг хугацаа ба нөөц боломж хязгаарлагдмал байдаг. Гэсэн хэдий ч жендерийн дүн шинжилгээ нь хэрэглэхэд хялбар бөгөөд үйл ажиллагаа, үр дүнг мэдэгдэхүйц сайжруулахад нөлөөлж чаддаг.

Зарчим 7: Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих

Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих: Мал амьтанд чиглэсэн онцгой байдлын үеийн үйл ажиллагааны туршлагууд

Өнгөрсөн арван жилд мал аж ахуй чиглэлээр хэрэгжүүлсэн онцгой байдлын үйл ажиллагааны туршлагад үндэслэн орон нутгийн туршлага, арга аргачлал, үр дүнг өөрийн болгож эзэмшин авч үлдэхийг дэмжих LEGS-н Зарчим бий болсон. Уг үйл ажиллагаанууд нь гадны байгууллагууд болон орон нутгийн тоглогчдын хамтран гаргасан техникийн шийдвэр гаргалт, техникийн үйл ажиллагаа орон нутгийн удирдлага, нутгийн бусад бүлгийн тэгш оролцоотой түншлэлийн хөгжүүлэлт зэрэг юм. Үүгээр хязгаарлахгүйгээр орон нутгийн өөрийн болгож, эзэмших (өөриймшүүлэх) чадавхыг дэмжсэн хэд хэдэн туршлагууд үүнд хамаарна. Жишээлбэл, орон нутгийн эрх баригчдыг үйл ажиллагаануудад зохицуулалт, хяналт, үнэлгээ хийхэд дэмждэг, үйл ажиллагааны загварчлал, хэрэгжүүлэлт, үнэлгээ олон нийттэй хамтран хийдэг, мөн орон нутгийн засаг захиргааг наад захын стандартууд боловсруулах, сургалтын хөтөлбөр боловсруулах ба хэрэгжүүлэх, бодлогоо шинэчлэхэд нь дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанууд хамаарна. Уг үйл ажиллагаанууд нь ирээдүйд учирч болзошгүй онцгой байдлын бэлэн байдал, болон хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх зорилготой орон нутгийн удирдлага болон ТББ-уудын үүрэг оролцоог тодорхой болгож өгсөн.



Ийм үйл ажиллагаанууд олон улсын хүмүүнлэгийн байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа "нутагшуулалт" үзэл баримтлалтай сайн нийцдэг байна. Тухайлбал, Эдийн засгийн Харилцан Туслалцах ба Хөгжлийн Байгууллага (OECD)-н хүмүүнлэгийн тусламжийг "нутагшуулах" зорилтод онцгой байдлын нөлөөлөлд өртсөн хүн амын хэрэгцээ шаардлагыг илүү мэдэх үндэсний түвшний оролцогч талуудыг ирээдүйн хүмүүнлэгийн хариу арга хэмжээнд бэлтгэхийн тулд орон нутгийн эрх баригчдын манлайлал болон иргэний нийгмийн байгууллагууд, бүлгүүдийн чадавхыг хүмүүнлэгийн үйл ажиллагаанд хүлээн зөвшөөрөх, хүндлэх мөн бэхжүүлэх шаардлагатай хэмээн үзсэн байна. LEGS нь хямрал тохиолдоход хамгийн түрүүнд орон нутгийн байгууллага, ард иргэд, эрх баригчид хариу арга хэмжээг хэрэгжүүлдэг гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Тэдэнд мөн орон нутгийн тусгай хэрэгцээ шаардлага ба нөхцөл байдлын талаар маш их мэдлэг, туршлага байдаг.

Мал аж ахуйн зарим санаачлагуудын хүрээнд орон нутгийн хамтрагч талуудтай түншлэх замаар техникийн үйл ажиллагааны аливаа шийдвэр гаргалтыг тэдэнд шилжүүлж байдаг. Орон нутгийн өөрийн болгож, эзэмших дэмжлэгийн үзэл баримтлалд тулгарч буй чухал сорилт нь нутгийн байгууллагууд төсөвт хяналт тавих үйл явцад оролцох нь хязгаарлагдмал байгаа явдал юм. Энэ нь тэдэнд үйл ажиллагааг дангаар төлөвлөх ба хэрэгжүүлэх, мөн нөөцийн хяналтыг "эзэмших" бүрэн эрх байхгүйтэй холбоотой. Уг асуудал нь донор хандивлагчид болон олон улсын ТББ-уудын бодлоготой холбоотой ба хүмүүнлэгийн салбарыг бүхэлд нь хамардаг. Хүмүүнлэгийн үйл ажиллагааны бүх салбарын хэмжээнд байгаа энэхүү асуудлыг зөвхөн мал аж ахуйн үйл ажиллагаанд дангаар нь өөрчлөх боломжгүй байна.

Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих LEGS-н чиг хандлага

LEGS-н Орон нутгийн өөриймшүүлж, эзэмших чадавхыг дэмжих Зарчимд дээрх дурдсан туршлагууд, асуудлуудад анхаарлаа хандуулж, орон нутгийн чадавхыг дэмжих дараах үндсэн элементүүдийг тодорхойлсон байна. Үүнд:

- Онцгой байдлын үеийн мал аж ахуйн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхдээ орон нутгийн талуудын ижил түвшний оролцоог хангаж хуучин туршлагуудад үндэслэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа сайжруулан, үргэлжлүүлэх ёстой. Тэд олон нийтийн ба орон нутгийн эрх баригчдын болон иргэний нийгмийн байгууллагууд, бүлгүүдийн үзэл санааг дүн шинжилгээ хийх болон шийдвэр гаргахдаа тусгах ёстой.
- Орон нутгийн өөрийн болгож, эзэмших чадавхыг дэмжих зарчим нь *Зарчим 2* буюу *Олон нийтийн оролцоог хангах*-тай нийцдэг ба орон нутаг өөрөө загварчилсан хариу арга хэмжээ (энэ нь бүхэлдээ орон



нутгийн хяналтад байх)-г LEGS дэмждэг ба энэ нь орон нутгийн нөхцөл байдалд илүү тохиромжтой болдог байна. Зарим нөхцөл байдлын үед мал амьтанд чиглэсэн дэмжлэгийг үзүүлэхэд уламжлалт аргууд нь илүү тохиромжтой байх тохиолдол байдаг.

- Техникийн бүх үйл ажиллагаанд үндэсний болон орон нутгийн эрх баригчдын зохицуулалтыг ашиглахыг LEGS дэмждэг. Мөн олон нийтэд суурилсан байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт уг арга хэмжээг хэрэгжүүлэхийг хөхүүлэн дэмждэг (*Ашигласан хэвлэл ба цаашид унших материал*-с харна уу). Мөн түүнчлэн, LEGS орон нутгийн эрх баригчдыг хэрэгжүүлэгч байгууллагатай мал аж ахуйн үйл ажиллагаанд наад захын стандартууд болон орон нутгийн нөхцөл байдалд тохирсон заавар зэргийг боловсруулж хамтран ажиллахыг дэмждэг.

Онцгой байдлын мал аж ахуйн үйл ажиллагаанууд нь орон нутгийн ТББ-ууд болон удирдлага орон нутагтаа хэрхэн илүү эзэн байх, хяналт тавих (тухайлбал, орон нутгийн санхүүгийн хэрэгцээг тодорхойлох, гадны хөрөнгийг хүлээн авах болон хариуцах гэх мэт) боломжийг хангаж өгдөг. Эдгээр тохиолдлуудыг баримтжуулж үлдээх нь цаашид орон нутгийн өөрийн болгож эзэмших (өөриймшүүлэх) чадавхыг дэмжихэд туршлага, сургамж болох ба мөн үүний үр дүнг улам нэмэгдүүлэхэд тусална. Мөн цаашид мал аж ахуйн яаралтай тусламжийн үед практик туршлага олж авч, байр сууриа бэхжүүлсэн орон нутгийн хэрэгжүүлэгчид, байгууллагуудын эерэг жишээнүүдэд үндэслэн хүмүүнлэгийн тогтолцоог өргөн хүрээнд өөрчилж чадах лобби ч хийх боломж бүрдэх магадлалтай.



Зарчим 8: Хяналт, үнэлгээ, хариуцлагатай байдал, суралцах амлалт (ХҮХС)

Онцгой байдлын үеийн мал аж ахуйн хариу арга хэмжээний хэсэг болох ХҮХС-н хэрэгжилтийн ашиг тус

LEGS-н сүүлийн Зарчим нь Хяналт, үнэлгээ, хариуцлагатай байдал, суралцах амлалт (ХҮХС) тогтолцоог зохион байгуулж, түүний хэрэгжилтийг хангах шаардлага юм. Сайн төлөвлөсөн, хэрэгжүүлсэн ХҮХС-н тогтолцоо нь онцгой байдлын мал аж ахуйн хариу арга хэмжээний үр дүнг нэмэгдүүлнэ. Энэ нь мөн LEGS-н амьжиргааны зорилтуудыг биелүүлэх, сургамж авах, хэрэгжилтийг үргэлжлүүлэхэд тустай. Үр нөлөөтэй ХҮХС нь нэрвэгдсэн хүн ам ба Хүмүүнлэгийн Стандартуудын Түншлэлийн үүрэг амлалтын хариуцлагыг дээшлүүлэхэд дэмжлэг болдог.

Онцгой байдлын мал аж ахуйн хариу арга хэмжээний хэрэгжилтийн ахиц дэвшлийн гол мэдээллийг хяналт мониторинг хангаж өгнө. Энэ нь анхдагч үнэлгээгээр тодорхойлсон мэдээллүүд, түүний үнэ цэнэ, хэвээр байгаа эсэх, эсвэл үйл ажиллагааны явцад шаардлагатай өөрчлөлтүүд хэрэгтэй болсон уу гэдгийг шалгах маш чухал үйл ажиллагаа бөгөөд үр дүнтэй хяналт нь хэрэгжилтийн үйл ажиллагаанд бодит цагийн зохицуулалт хийх боломжийг олгодог. Харин үнэлгээ нь ихэвчлэн төслийн зорилтууд биелэгдсэн үү, биелэгдээгүй юу, хэрэв биелээгүй бол яагаад гэдгийг илрүүлэх үйл ажиллагаа юм. Нөлөөллийн үнэлэмж юм уу үр дүнгийн үнэлгээгээр хариу арга хэмжээний үр дүнг тусгайлан тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, энэ нь мал аж ахуйд чиглэсэн хариу арга хэмжээний амьжиргаанд үзүүлсэн үр дүн, нөлөөллийг тооцох бөгөөд үүнд малын хорогдол, мал амьтнаас гаралтай орлого, хоол хүнс зэрэг орно. Хариу арга хэмжээний зорилго нь хүлээгдэж буй үр дүн тодорхой агуулсан байх шаардлагатай ба ийм тохиолдолд үнэлгээ нь үүний дагуу үр дүнг хэмжих болно.

Үр дүнгийн үнэлгээнүүдэд амьжиргаанд эерэг ба сөрөг нөлөөлсөн сургамжуудыг багтаах нь маш чухал. Энэ нь цаашдын хариу арга хэмжээний төлөвлөлт ба үр нөлөөг сайжруулахад чухал ач холбогдолтой.

Хариуцлагатай байх ба суралцах тогтолцоог бий болгоход цаг хугацаа, хүчин чармайлт ихээхэн шаардагддаг. Шаардлагатай мэдээлэл, санал хүсэлт, дүн шинжилгээг цуглуулж, олж авсан мэдээлэл, сургамжаа гамшигт нэрвэгдсэн хүмүүстэй хуваалцах нь хариуцлагыг сайжруулах үйл явц бөгөөд энэ нь мал аж ахуй болон хүмүүнлэгийн салбарт аль алинд нь цаашид хэрэгжүүлэх хөтөлбөрийг сайжруулахад хэрэгтэй юм. Хүмүүнлэгийн үндсэн



стандарт ХҮС-н Үүрэг амлалт 7 хэсэгт зааснаар хүмүүнлэгийн тоглогчдоос үргэлжлүүлэн суралцах, сайжирч байхыг шаарддагтай LEGS-н үзэл санаа нийцдэг. Хэрэгжүүлэгч байгууллага нь мал аж ахуйн төрөлжсөн байгууллага, олон салбарынх бол, ХҮС-т үйл ажиллагааг даатгах ёстой ба ХҮС-н үүрэг амлалтын дагуу хариуцлагыг хангах тогтолцоотой байх нь чухал.

Техникийн үйл ажиллагаа дахь ХҮХС-н хэрэгжилтэд анхаарах зүйлс

Хүмүүнлэгийн олон байгууллагууд аль хэдийн газар дээр нь ХҮХС-г хэрэгжүүлэх тогтолцоотой болсон байдаг. Онцгой байдлын мал аж ахуйн хариу арга хэмжээнд ХҮХС тогтолцоог зохион байгуулахад анхаарах чухал асуудлууд нь:

- **Хөрөнгө оруулалт:** ХҮХС-г үр дүнтэй болгоход, ажилтнуудын чадавхыг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалт хийхэд цаг хугацаа шаарддаг. Чанартай мэдээлэл цуглуулахад ажилтан оролцооны арга барилыг эзэмшсэн, хангалттай үр чадвартай байх шаардлагатай ба мөн мал аж ахуйд суурилсан амьжиргааны талаар зохих мэдлэгтэй байх нь чухал. Ихэнх онцгой байдлын хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах төлөвлөлтийн үе шат зэрэгт ажилтны үр чадварыг сайжруулах эсвэл солилцох шаардлагыг ханган ажиллах нь хамгийн сайн гүйцэтгэл болдог.
- **Хяналт:** Онцгой байдлын нөхцөл дэх үйл ажиллагаануудад сорилт, бэрхшээлүүдийг тодорхойлохтой зэрэгцэн аль болох хурдан хугацаанд LEGS-н үйл ажиллагаануудын хяналтын үйл ажиллагааг эхлүүлэх хэрэгтэй. Хяналт нь хангалттай давталттай хийгдэх боломжтой ба хэрэгжүүлэлтийн явцад гарч болох шаардлагатай өөрчлөлтүүд, шинэчлэлтүүдийг аль болох түргэн хугацаанд тодорхойлох үйл ажиллагаа байна.
- **Үр дүнгийн үнэлгээг эрэмбэлэх:** Хэрэгжүүлэгч байгууллагууд хариу арга хэмжээ дуусмагц эсвэл дууссаны дараа хийх үр дүнгийн үнэлгээнд цаг хугацаа, болон хөрөнгийг хуваарилах шаардлагатай. Онцгой байдлын үеийн мал аж ахуйн хариу арга хэмжээний амьжиргаанд үзүүлсэн нөлөөлөл, үр дүнг оролцооны аргаар тодорхойлсон үнэлгээ нь илүү тодорхой нотолгоотой байдаг нь судалгаагаар тодорхойлогдсон байдаг. Ийм үнэлгээ нь олон нийтийг суралцах, сургамж авах, хариуцлагатай байдалд оролцуулсан байдаг.
- **Сургамж авах, суралцах арга барилууд:** Сургамж авч, суралцахдаа зөвхөн мэдээллүүдийг цуглуулах нь мэдээж хангалтгүй бөгөөд мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хяналт ба үнэлгээний мэдээллийг хуваалцахад туслах, зохион байгуулах арга барил шаардлагатай.



LEGS-н Бусад Зарчмуудтай нийцэх байдал

LEGS-н үйл ажиллагаа үр дүнтэй ХҮХС-тэй байх нь LEGS-н бусад Зарчмуудтай нийцэж тэдгээрийг дэмждэг. Үүнд:

- **Амьжиргаанд суурилсан хөтөлбөрийн дэмжлэг:** Үр дүнтэй ХҮХС тогтолцоо нь хариу арга хэмжээний LEGS-н амьжиргааны зорилтуудтай нийцсэнийг болон мал аж ахуйд суурилсан амьжиргаанд төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг тодорхойлоход чухал.
- **Олон нийтийн оролцоог хангах:** ХҮХС тогтолцоонд олон нийтийн оролцоог хангасан байх нь чухал. Энэ нь хэрэгжилтийн явцад хариуцлагыг сайжруулахуйц нэрвэгдсэн хүн амын санаа бодлыг сонсож, туслах нөхцөл болдог. Оролцоог хангах нь мөн хяналтын үзүүлэлтүүдийг бодитой болгоход тусалдаг. Мал аж ахуй эрхлэгчид нь л өөрсдөө үйл ажиллагааны үр дүнг цаг хугацаанд нь хамгийн сайн ажиглаж мэддэг.
- **Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрийн дэмжлэг:** ХҮХС-н дэлгэрэнгүй мэдээллүүд нь эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг тодорхойлоход тусална. Мөн төлөвлөсөн хариу арга хэмжээнүүд тэдэнд ялгаатайгаар хүрэх эсвэл нөлөөлөхөөр тусгагдсан эсэхийг харуулна.
- **Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих:** Нэрвэгдсэн хүн амыг онцгой байдлын хариу арга хэмжээний хяналт ба үнэлгээнд татан оролцуулах нь хэрэгжилтэд тэдний оролцоог нэмэгдүүлэх боломж юм. Олон нийтийг анхдагч шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлохоос эхлээд, мэдээлэл цуглуулах хүртэлх бүх үйл ажиллагаанд оролцуулах нь чухал юм.



Хавсралтууд

Хавсралт 2.1: LEGS ба Sphere-н Хамгаалалтын Зарчмуудын нийцэмж

Дэлхийн олон газарт мал сүрэг нь санхүүгийн үнэт хөрөнгө бөгөөд чанар сайтай хоол хүнсний бэлэн эх үүсвэр болдог. Мөн хөдлөх эд хөрөнгөд тооцогдоно. Тийм учраас найдвартай бус нөхцөлд дээрэмчид болон буутай бүлэглэл малыг онилж болдог. Онцгой байдлын мал аж ахуй хамааралтай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх ба эрсдлийг бууруулахад оролцож байгаа хүмүүсийн хамгааллын асуудалд нэн түрүүн зөв дүн шинжилгээ хийж, хамгаалалтаар хангах шаардлагатай.

Тухайлбал:

- Малыг хамгаалах эсвэл тараах үед дайны зориудын тактик болохуйц хувь хүн, айл өрх хулгай ба дээрэмд өртөх эрсдэл нэмэгдэж болно. Мал хөрөнгө болох эсэх нь аюулгүй байдлыг хэрхэн хангаснаас хамаарна.
- Мал аж ахуйн үйл ажиллагаа нь эмэгтэйчүүд ба хүүхдүүдийг малын тэжээл, ус олохын тулд алслагдсан бүс нутаг руу зорчих шаардлага үүсгэж болно. Энэ нь тэднийг хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хулгайлагдах эрсдэлд оруулдаг.
- Нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүс хамгийн их эрсдэлд орох магадлалтай. Мал амьтны бөөгнөрөл нь хулгай дээрмийг өдөөх, ус, эсвэл бэлчээрийн төлөө таньж мэдэхгүй нутаг орон руу нүүх нь халдлагад өртөмтгий байдлыг нэмэгдүүлдэг.
- Байгалийн нөөцийн хомсдолын үед мал амьтныг шинэ нутаг руу нүүлгэхэд, тэнд эзэн ба нүүдэллэж ирсэн бүлгүүдийн хооронд зөрчилдөөн үүсэх боломжийг нэмэгдүүлдэг.
- Гамшгийн улмаас хүүхдүүд мал амьтны үндсэн эзэн нь болж болно. Энэ нь тэднийг хулгай ба дээрэмд өртөх эрсдэлтэй байдалд оруулдаг. Иймээс мал аж ахуйн үйл ажиллагаанууд нь эмзэг бүлгийн хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангасан, тэдний насны онцлогт тохирсон, нэр хүндийг дэмжсэн байх нь чухал..

Энэ төрлийн дүн шинжилгээ нь анхдагч үнэлгээний бүрэлдэхүүн хэсэг болох ёстой. Ялангуяа мөргөлдөөнтэй холбоотой онцгой байдлын үед... (Бүлэг 3: *Яаралтай хариу арга хэмжээний төлөвлөгөө*-г харна уу).



Хавсралт 2.2: LEGS-н Зарчмууд нь Хүмүүнлэгийн Үндсэн Стандартын Үүрэг амлалтыг хэрхэн дэмждэг вэ

Хүмүүнлэгийн үндсэн стандарт Үүрэг амлалтууд ба чанарын шалгуур	LEGS-н Зарчмууд ХҮС-н Үүрэг амлалтуудыг хэрхэн дэмжиж болох
1. Гамшигт нэрвэгдсэн орон нутаг ба хүмүүс тэдний хэрэгцээнд хамааралтай ба тохиромжтой дэмжлэгийг авна Чанарын шалгуур: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь тохиромжтой ба хамаатай байх	Оролцооны арга барилыг зөв ашигласан бол анхдагч үнэлгээ болон хариу арга хэмжээний явцад дэмжлэг илүү тохиромжтой ба хамааралтай байх болно. LEGS-н <i>Зарчим 2: Олон нийтийн оролцоог хангах</i>; LEGS-н <i>Бүлэг 3: Яаралтай хариу арга хэмжээний төлөвлөгөө</i> харна уу
2. Гамшигт нэрвэгдсэн орон нутаг ба хүмүүст хүмүүнлэгийн тусламжийг тэдэнд шаардлагатай цаг хугацаанд нь хүргэх Чанарын шалгуур: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ үр дүнтэй ба цагаа олсон байх	LEGS-н <i>Зарчим 4: Бэлэн байдал ба эрт үйл ажиллагаа</i>, эрт үеийн ба цагт хугацаанд нь тохирсон хариу арга хэмжээг дэмждэг LEGS-н <i>Оролцооны Хариу арга хэмжээг тодорхойлох матрикс</i> нь онцгой байдлын ялгаатай үе шатуудын дагуу тохиромжтой хариу арга хэмжээг дэмждэг LEGS-н үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдэд шаардлагатай, тохирсон цаг хугацаанд нь үзүүлсэн хариу арга хэмжээ багтдаг
3. Гамшигт нэрвэгдсэн хүмүүс хүмүүнлэгийн үйл ажиллагааны дүнд сөрөг нөлөө авахгүй, илүү бэлэн байдлаа хангах, сөрөн тэсвэрлэх, чадавх нь нэмэгдэж, эрсдэл нь буурсан байх Чанарын шалгуур: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ орон нутгийн чадавхыг бэхжүүлж, сөрөг нөлөөллөөс холдуулдаг байх	LEGS-н <i>Зарчим 1: Амьжиргаанд суурилсан хөтөлбөр</i> ба <i>Зарчим 7: Орон нутгийн эзнийг дэмжих</i>: орон нутагт боломжтой байгаа тоглогчид, тогтолцоо ба үйлчилгээтэй хамтран ажиллахыг зөвлөдөг
4. Гамшигт нэрвэгдсэн хүмүүс тэдэнд нөлөөлж байгаа нөхцөл байдлын талаар мэдээллийг авах, шийдвэр гаргахад оролцох эрхтэйгээ мэдэх Чанарын шалгуур: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээнүүд хүмүүсийн харилцаа, оролцоо болон эргэх холбоо дээр үндэслэсэн байх	LEGS-н <i>Зарчим 2: Олон нийтийн оролцоог хангах</i>: загварчлах, төлөвлөх, хэрэгжүүлэх ба үйл ажиллагааны хяналт, үнэлгээнд олон нийтийн оролцоог чухалчилдаг LEGS-н <i>Зарчим 3</i>: хариу арга хэмжээний төлөвлөлт ба хэрэгжилтэд олон нийтийн оролцоог онцгой анхаардаг



Хүмүүнлэгийн үндсэн стандарт Үүрэг амлалтууд ба чанарын шалгуур	LEGS-н Зарчмууд ХҮС-н Үүрэг амлалтуудыг хэрхэн дэмжиж болох
5. Гамшигт нэрвэгдсэн хүмүүс нь гомдол саналаа илэрхийлэх, хариу хүлээн авах боломжтой механизмаар хангагдсан байна Чанарын шалгуур: Гомдлуудыг хүлээн авдаг, шийдвэрлэдэг байх	Гомдлын арга зам нь байгууллагын хэмжээний ерөнхий шинж чанартай байх ба зөвхөн мал аж ахуйтай хамааралтай биш байна LEGS-н <i>Зарчим 8: ХҮХС</i>, хариуцлагыг сайжруулах зэрэг оролцооны хяналтыг чухалчилдаг
6. Гамшигт нэрвэгдсэн хүмүүс зохицуулсан, биесээ нөхсөн тусламжийг авна Чанарын шалгуур: Хүмүүнлэгийн хариу арга хэмжээнүүд зохицуулагдсан ба дагалдсан байх	LEGS-н <i>Зарчим 5: Хариу арга хэмжээний зохицуулалт, сайн зохицуулалт</i> ба нөлөөллүүдийн хоорондын уялдаа нь хүчтэй нотолгоог бий болгоно
7. Гамшигт нэрвэгдсэн хүмүүс туршлага, алдаанаасаа сургамж авч, суралцсан сайжирсан байгууллагын тусламжийг авна Чанарын шалгуур: Хүмүүнлэгийн тоглогчид нь байнга суралцах ба сайжрах	LEGS <i>Зарчим 8: ХҮХС</i>, хяналт ба үнэлгээнээс бий болсон сургамжууд нь ирээдүйн төлөвлөгөөнүүдэд ач холбогдолтой LEGS-н шинэ хэвлэлд оролцооны нөлөөллийн үнэлгээнүүдийн эх үүсвэр бүхий системтэй нотолгооны тойм судалгаануудыг оруулсан
8. Гамшигт нэрвэгдсэн хүмүүс нь шаардлагатай чадвар, туршлага сайн боловсрол эзэмшсэн ажилтан ба сайн дурын ажилтнаас тусламж авна Чанарын шалгуур: Ажилтнууд нь ажлаа үр дүнтэй хийхэд нь туслах шударга, тэгш дэмжлэгээр хангагдсан байх	LEGS-н <i>Зарчим 4: Бэлэн байдал ба эрт арга хэмжээ</i>, амьжиргаанд суурилсан ба оролцооны чиг хандлагуудад шаардлагатай техникийн туршлага, чадвар хуримтлуулсан ажилтан нэн чухал байх нь зайлшгүй LEGS-н <i>Зарчим 6: Жендерийн-мэдрэмжтэй хөтөлбөр</i>, тусгай нөхцөл байдалд тусламжийн ажилтны хүйс ач холбогдолтой байж болно
9. Гамшигт нэрвэгдсэн хүмүүс тэдэнд тусалж буй байгууллагууд нөөц боломжоо хариу хэмжээнд үр дүнтэй, өгөөжтэй, ба ёс зүйтэй зарцуулж байна гэж найддаг Чанарын шалгуур: Нөөцийг зориулалтын дагуу хариуцлагатай зохион байгуулах ба ашиглах	LEGS мал аж ахуйн хариу арга хэмжээний тохиромжтой төрлийг зөв цаг хугацаанд нь хүргэх тохиромжтой эх үүсвэрийн менежмент ба эх үүсвэрүүдийн сувгийг дэмждэг Нөөцийг үр дүнтэй ашиглах зохицуулалтаар хангагдсан хариу арга хэмжээг удирдах; LEGS-н <i>Зарчим 5: Зохицуулагдсан хариу арга хэмжээг хангах</i>-г харна уу



Ашигласан хэвлэл ба цаашид унших материал

LEGS-н амьжиргааны зарчим

Aklilu, Y., Admassu, B., Abebe, D. and Catley, A. (2006) Pastoralist livelihood initiative: guidelines for livelihoods-based livestock relief interventions in pastoralist areas, Feinstein International Famine Center, Tufts University, Addis Ababa, <https://www.livestock-emergency.net/userfiles/file/general/Feinstein-International-Center-2006.pdf>

Braam D.H., Chandio R., Jephcott F.L., Tasker A., Wood J.L.N. (2021) Disaster displacement and zoonotic disease dynamics: The impact of structural and chronic drivers in Sindh, Pakistan. PLOS Glob Public Health 1(12): e0000068, <https://doi.org/10.1371/journal.pgph.0000068>

Schreuder, B. (2015) Afghanistan, a 25-years' Struggle for a Better Life for its People and Livestock, DCA-VET/Erasmus Publishing, Lelystad/Rotterdam, <https://dca-livestock.org/books/>

Scoones, I. (1998) Sustainable rural livelihoods: a framework for analysis, IDS working paper 72, Institute for Development Studies, University of Sussex, Brighton, <https://opendocs.ids.ac.uk/opendocs/bitstream/handle/20.500.12413/3390/Wp72.pdf?sequence=1>

LEGS-н олон нийтийн оролцооны зарчим

Catley, A. and Leyland, T. (2001) 'Community participation and the delivery of veterinary services in Africa', Preventive Veterinary Medicine 49: 95–113, [https://doi.org/10.1016/S0167-5877\(01\)00171-4](https://doi.org/10.1016/S0167-5877(01)00171-4)

Catley, A. (2020) Participatory epidemiology: reviewing experiences with contexts and actions, Preventive Veterinary Medicine 180, 105026, <https://doi.org/10.1016/j.prevetmed.2020.105026>

Catley, A., Leyland, T. and Bishop, S. (2008) 'Policies, Practice and Participation in Protracted Crises: The Case of Livestock Interventions in South Sudan', in L. Alinovi, G. Hemrich and L. Russo (eds), Beyond Relief: Food Security in Protracted Crises, Practical Action Publishing, Rugby, https://www.researchgate.net/publication/257825324_Alinovi_L_Hemrich_G_Russo_L_editors_Beyond_Relief_Food_Security_in_Protracted_Crises_Evidence_from_Sudan_Somalia_and_the_Democratic_Republic_of_Congo_Practical_Action_London_2008

CBM Global Disability Inclusion (no date) Step-by-step practical guidance on inclusive disaster risk reduction, Inclusive DRR Hands-on Tool, CBM Global, <https://idrr.cbm.org/en/card/livestock>

Cornwall, A. (1996) 'Towards participatory practice: participatory rural appraisal (PRA) and the participatory process', in K. de Koning, M. Martin (eds), Participatory Research and Health: Issues and Experiences, Zed Books Ltd., London, pp.94–107, <https://www.eldis.org/document/A15874>

Sadler, K., Mitchard, E., Abdullahi A., Shiferaw Y. and Catley, A. (2012) Milk Matters: The Impact of Dry Season Livestock Support on Milk Supply and Child Nutrition in Somali Region, Ethiopia, Feinstein International Center, Tufts University, Addis Ababa, <https://fic.tufts.edu/wp-content/uploads/Milk-Matters-2.pdf>

LEGS-н уур амьсгал ба байгаль орчны зарчим

Houzer, E. and Scoones, I. (2021) Are livestock always bad for the planet? Rethinking the protein transition and climate change debate, Brighton: PASTRES, Brighton, https://opendocs.ids.ac.uk/opendocs/bitstream/handle/20.500.12413/16839/Climate-livestock_full_report_%28EN%29_web.pdf?sequence=5&isAllowed=y



VSF International (2014) Livestock and climate change – going beyond preconceived ideas and recognizing the contribution of small-scale livestock farming facing climate change, Position Paper n.2. Executive Summary, October 2014, http://vsf-international.org/wp-content/uploads/2015/02/2_LivestockClimChange_english-new-logo.pdf

LEGS-н бэлэн байдал ба эрт арга хэмжээний зарчим

Benson, C. and Twigg, J. with Rossetto, T. (2007) Tools for Mainstreaming Disaster Risk Reduction: Guidance Notes for Development Organisations, ProVention Consortium, Geneva, https://www.preventionweb.net/files/1066_toolsformainstreamingDRR.pdf

Cabot Venton, C., Fitzgibbon, C., Shiterek, T., Coulter, L. and Dooley, O. (2012) The economics of early response and disaster resilience: lessons from Kenya and Ethiopia, DFID, London, https://www.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/67330/Econ-Ear-Rec-Res-Full-Report_20.pdf

Catley, A. and Charters, R. (2015) Early response to drought in pastoralist areas: lessons from the USAID crisis modifier in East Africa, USAID/East Resilience Learning Project, USAID/East Africa, Nairobi, https://pdf.usaid.gov/pdf_docs/PA00M1PX.pdf

Catley, A. and Cullis, A. (2012) 'Money to Burn? Comparing the costs and benefits of drought responses in pastoralist areas of Ethiopia', Journal of Humanitarian Assistance, 24 April, 2012, <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/05/Catley-and-Cullis-2012.pdf>

LEGS (2018) Revisiting the economic impacts of early drought response: How does early response affect households in pastoralist areas? LEGS Briefing Paper, Livestock Emergency Guidelines and Standards, <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2017/10/LEGS-Briefing-Paper-Economic-Impacts-of-Early-Drought-Response.pdf>

Rohwerder, B. (2017) Flexibility in funding mechanisms to respond to shocks, GSDRC Helpdesk Research Report 1412, Birmingham, UK: GSDRC, University of Birmingham, <https://assets.publishing.service.gov.uk/media/59b7ec37ed915d19636fef39/1412-Flexibility-in-funding-mechanisms-to-respond-to-shocks.pdf>

USAID/Ethiopia (2014) Resilience in Africa's drylands: revisiting the drought cycle management model, USAID/Ethiopia Agriculture Knowledge, Learning, Documentation and Policy Project, Technical Brief, May 2014, <http://www.agri-learning-ethiopia.org/wp-content/uploads/2014/07/AKLDP-Technical-Brief-DCM-May-2014-HQ.pdf>

LEGS-н зохицуулах зарчим

Watson, D.J. and van Binsbergen, J. (2008) Review of VSF-Belgium's Turkana emergency livestock off-take intervention 2005, Research Report 4, International Livestock Research Institute (ILRI), Nairobi, https://cgspace.cgiar.org/bitstream/handle/10568/234/RR4_LivestockOfftakeIntervention.pdf

LEGS-н жендерийн-мэдрэмжтэй хөтөлбөрийн зарчим

de Jonge, K. and Maarse, L. (2020) Gender and livestock in emergencies: a discussion paper for the Livestock Emergency Guidelines and Standards (LEGS), LEGS, <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/11/LEGS-Discussion-Paper-Gender-and-Livestock.pdf> (See for example Box 1: 'Five Steps in a Rapid Gender Analysis'.)

IFAD (2020) How to do gender and pastoralism, International Fund for Agricultural Development, Rome, <https://www.ifad.org/en/web/knowledge/-/publication/how-to-do-note-gender-and-pastoralism>



LEGS (2018) LEGS gender module, On-line training module on LEGS and gender, <https://www.livestock-emergency.net/new-line-training-module-legs-gender/>

Mazurana, D. and Maxwell, D. (2016) Sweden's feminist foreign policy: implications for humanitarian response, FIC/Tufts, HPG, Kings College London, World Peace Foundation, <https://fic.tufts.edu/assets/Feminist-Foreign-Policy-Humanitarian-Response.pdf>

Mercy Corps (2014) Rethinking resilience: prioritizing gender integration to enhance household and community resilience to food insecurity in the Sahel, https://www.mercycorps.org/sites/default/files/2019-12/Rethinking_Resilience_Gender_Integration.pdf

Pasteur, K. (2002) Gender analysis for sustainable livelihoods frameworks: tools and links to other sources, draft, <https://www.livestock-emergency.net/userfiles/file/assessment-review/Pasteur-2002.pdf>

UNFPA (2015) Minimum Standards for Prevention and Response to Gender-based Violence in Emergencies, United Nations Population Fund (UNFPA), <https://www.unfpa.org/publications/minimum-standards-prevention-and-response-gender-based-violence-emergencies-0>

LEGS-н орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих зарчим

Featherstone A. (2020) Putting the best foot forward: localisation, contextualisation and institutionalisation, a discussion paper for the Livestock Emergency Guidelines and Standards (LEGS), LEGS, <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/11/LEGS-Institutionalisation-and-Localisation-Summary-Discussion-Paper.pdf>

Humanitarian Leadership Academy (2019) Unpacking localization, <https://www.humanitarianlibrary.org/resource/unpacking-localisation>

Humanitarian Practice Network (2021) Survivor- and community-led crisis response: practical experience and learning, Briefing Paper no. 84, https://odihpn.org/wp-content/uploads/2021/05/HPN_SCLR-Network-Paper_WEB.pdf

OECD (2017) Localising the response: World Humanitarian Summit – putting policy into practice, The Commitments into Action Series, OECD, Paris, <https://www.oecd.org/development/humanitarian-donors/docs/Localisingtheresponse.pdf>

See also: Local to Global Protection, <https://www.local2global.info/>

LEGS-н ХҮХС зарчим

FAO (2016) Livestock-related interventions during emergencies – The how-to-do-it manual. Edited by Philippe Ankers, Suzan Bishop, Simon Mack and Klaas Dietze. FAO Animal Production and Health Manual No. 18. Rome, <https://www.fao.org/3/i5904e/i5904e.pdf> (See Chapter 10, Monitoring, Evaluation and Impact Assessment)

Sphere Association (2018) The Sphere Handbook: Humanitarian Charter and Minimum Standards in Humanitarian Response, The Sphere Project, Geneva, <https://spherestandards.org/handbook-2018/>

LEGS-н Зарчмууд тохиолдлын судалгаануудыг мөн: <https://www.livestock-emergency.net/resources/case-studies/> цахим хуудас-с үзэж болно



LEGS хүрээ
LEGS-н Зарчмууд





Бүлэг 3:

Онцгой байдлын үеийн хариу арга ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

- 81 Танилцуулга
- 82 1 дүгээр үе шат: Анхдагч үнэлгээ
- 90 2 дугаар үе шат: Хариу арга хэмжээг тодорхойлох
- 93 3 дугаар үе шат: Техникийн үйл ажиллагаанууд, тэдгээрийн хувилбаруудад дүн шинжилгээ хийх
- 99 4 дүгээр үе шат: Хариу арга хэмжээний төлөвлөгөө
- 102 LEGS-н үйл ажиллагаанууд дахь ХҮХС зааварчилгаа
- 108 Хавсралт 3.1: Анхдагч үнэлгээ – санал болгох оролцооны аргачлалууд
- 112 Хавсралт 3.2: Анхдагч үнэлгээ – шалгах асуултуудын загвар
- 114 Хавсралт 3.3: Анхдагч үнэлгээ – мэдээлэл цуглуулах загвар
- 115 Хавсралт 3.4: PRIM – загварууд
- 117 Хавсралт 3.5: PRIM – жишээнүүд
- 122 Хавсралт 3.6: Бэлэн мөнгө болон эрхийн бичиг олгох тусламж – хариу арга хэмжээний арга замууд, хүргэх механизмууд болон шийдвэрийн мод
- 127 Хавсралт 3.7: Хариу арга хэмжээний төлөвлөгөө – загвар
- 128 Хавсралт 3.8: Хариу арга хэмжээний төлөвлөгөө – малын тоог бууруулах үйл ажиллагааны жишээ
- 129 Эх сурвалж ба цаашид унших материалууд

Зураг © David Hadrill



Бүлэг 3: Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөлт

Үе шатууд



3

Танилцуулга

Энэ бүлэг нь онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөлт хийх зааварчилгааг харуулсан бөгөөд уг үйл ажиллагаа нь 4 үе шаттай явагддаг. Үе шат тус бүрт ашиглагдах тухайлсан арга хэрэгслүүдтэй юм.

1 дүгээр үе шат: Анхдагч үнэлгээ—үүсээд буй онцгой байдлын үед мал амьтанд дэмжлэг үзүүлэх нь тохиромжтой эсэхийг шийдэх; мал амьтны үүрэг, онцгой байдлын үр нөлөө, одоогийн нөхцөл байдлын дүн шинжилгээ гэсэн мэдээллийг гаргаж ирэх бөгөөд түүнийгээ 2 болон 3 дугаар шатанд ашигладаг.



- 1 дүгээр шатанд ашиглах хэрэгслүүд: Үнэлгээний шалгах асуултууд (*Хавсралт 3.2* болон *Хавсралт 3.3* харна уу).

2 дугаар үе шат: Хариу арга хэмжээг тодорхойлох – нөхцөл байдалтайгаа уялдсан, мөн цаг үеэ олсон мал амьтанд чиглэсэн хариу арга хэмжээний техникийн үйл ажиллагаануудыг тодорхойлж, шаардлагаар нь эрэмбэлэх:

- 2 дугаар шатанд ашиглах хэрэгслүүд: Оролцооны аргаар хариу арга хэмжээг тодорхойлох матриц буюу PRIM (*Хавсралт 3.4* болон *3.5* харна уу).

3 дугаар үе шат: Техникийн тусламжууд болон тэдгээрийн хувилбаруудад дүн шинжилгээ хийх – шаардлагаар нь эрэмбэлэн гаргасан үйл ажиллагаанууд дотроос тохиромжтой, хэрэгжүүлэх боломжтой, мөн цагаа олсон хувилбаруудыг сонгох:


- 3 дугаар шатанд ашиглах хэрэгслүүд: Хувилбарууд, ашиг тус болон сорилт бэрхшээлүүдийн хүснэгт, цагийн хуваариуд, шийдвэрийн моднууд, стандартууд болон зааварчилгаанууд (техникийн стандартууд *4, 5, 6, 7, 8, 9 дүгээр бүлэг* болон *Хавсралт 3.6* харна уу).

4 дүгээр үе шат: Хариу арга хэмжээний төлөвлөгөө – Эхний 3 шатнаас гарсан мэдээлэл болон шийдвэрүүдийг ашиглан хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна:

- 4 дүгээр үе шатанд ашиглах хэрэгслүүд: Хариу арга хэмжээний төлөвлөгөөний загвар (*Хавсралт 3.7* болон *3.8* харна уу).

Эдгээр 4 үе шат нь бүгд LEGS-н 8 дахь зарчимд тодорхойлсноор Хяналт, Үнэлгээ, Хариуцлага болон Суралцах (ХҮХС) тогтолцоогоор хангагдсан. (*Бүлэг 2 харна уу*). ХҮХС тогтолцоог төлөвлөлтийн үеэр аль болох хурдан бий болгосноор хариу арга хэмжээний хэрэгжилтийн явцад ХҮХС тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

1 дүгээр үе шат: Анхдагч үнэлгээ



Тойм

Ямар ч онцгой байдлын хариу арга хэмжээ хэрэгжүүлэхийн өмнө анхдагч үнэлгээ хийх хэрэгтэй. Ингэснээр тухайн үүссэн байдалд мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь тохиромжтой эсэхийг тодорхойлох бөгөөд үүнд онцгой байдлын төрөл, үе шат болон ноцтой байдлын зэргийг



авч үзнэ. Энэхүү анхдагч үнэлгээ нь хийгээд л орхих зүйл биш, харин ямар техникийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг судлах, эсвэл мал амьтанд чиглэсэн хариу арга хэмжээ ер нь шаардлагатай эсэхийг шийдэх эхний алхам юм.

Үнэлгээнд бэлтгэх

Байгаа мэдээллүүдийг нягтлах

Үнэлгээний зарим мэдээлэл онцгой байдал үүсэхээс ч өмнө бэлэн байдлын төлөвлөлтийн үед аль хэдийн цуглуулагдсан байх боломжтой (*2 дугаар бүлгийн Зарчим 4-с харна уу*). Номын 4-8 бүлэгт уг ажиллагааг дэмжих бэлтгэл ажлын стандартыг багтаасан. Тухайн чиглэлээр ажиллаж байгаа агентлагууд нутгийн иргэдтэй хамтран бэлэн байдлын чадамжаа хөгжүүлэх бүрэн боломжтой. Бэлтгэл ажлаар цуглуулсан мэдээллүүд нь амьжиргаа залгуулдаг арга хэлбэрүүд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тогтолцоо, нийгэм, соёл болон жендерийн нормууд, гол оролцогчид болон байгууллагуудын талаар ойлголт өгдөг. Ингэснээр анхдагч үнэлгээг илүү нарийн тодорхой гаргах боломж нэмэгдэх юм.

Засгийн газрын мэдээ тайлан, эрүүл мэнд болон мал эмнэлгийн статистик мэдээ, ТББ-уудын тайлан, болон бусад эх сурвалжуудаас мөн тоон мэдээллийг цуглуулж болно. Сансраас авсан зураг болон газарзүйн мэдээллийн системээс цуглуулсан орон зайн тоон мэдээлэл ч хэрэг болдог. Эдгээр нь үерийн усны хүрсэн түвшин эсвэл усалгааны цэг болон мал амьтанд амин чухал байгалийн бусад нөөцийн байршлыг харуулдаг.

Байгаа мэдээллийг нягтлах нь гамшигт нэрвэгдсэн газарт хэрэгцээгүй зүйлс шаардахаас сэргийлж мөн анхдагч үнэлгээ хийхэд бэрхшээл тулгарсан үед ашиглаж болох чухал ач холбогдолтой байдаг.

Үнэлгээний баг болон аргачлалууд

LEGS-н анхдагч үнэлгээг гол оролцогчид болох гамшигт нэрвэгдсэн нутгийн гол бүлгүүд болон орон нутгийн удирдлагыг хамруулан оролцоот төлөвлөлтийн нэг хэсэг болгон хийх хэрэгтэй. Ингэснээр гамшигт нэрвэгдсэн нутгийнхны онцгой байдалд хариу арга хэмжээ үзүүлэх мэдлэг болон чадамжийг үнэлэх боломж гарна. Мөн нутгийн иргэд нь эрх тэгш оролцогчид болохыг бататгаж буй хэрэг бөгөөд тэднийг хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах болон хэрэгжүүлэх бүрэн эрхээр хангаж байгаа юм. (*Бүлэг 2, Зарчим 2: Оролцоо болон Зарчим 7: Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих хэсгийг харна уу.*)

Иймээс үнэлгээний багтаа орон нутгийн төлөөллүүдийг багтааж нутгийн удирдлага болон ТББ-уудыг татан оролцуулах нь зүйтэй. Мөн багтаа хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах, эмзэг бүлгийн төлөөллийг оролцуулах, нутаг орноо сайн мэддэг иргэд болон мал аж ахуйн мэргэжилтнүүдийг багтаах нь чухал.



Үнэлгээний багийн оролцооны аргачлал болон арга хэлбэрүүдийг хэрхэн эзэмшсэн, мөн үр чадвар болон техникийн мэдлэг зэргээс үнэлгээний мэдээллийн чанар хамаарна. LEGS анхдагч үнэлгээний мэдээллийг аль болох оролцооны аргачлалаар, чанарт суурилан цуглуулахыг зөвлөдөг. Энэ бүлгийн төгсгөлд байгаа ХҮХС-н тухай хэсгээс оролцооны арга замуудын талаар илүү олж мэдээрэй. *Хавсралт 3.1*-д анхдагч үнэлгээнд хамгийн тохиромжтой аргачлалуудыг санал болгосон. Иймд үнэлгээний багууд эдгээр аргачлалуудад суралцах хэрэгтэй.

Үнэлгээ нь өөр хоорондоо ялгаатай бүлгүүд, ялангуяа эрсдэлд өртсөн бүлгүүдийг зохих түвшинд хамруулах хэрэгтэй. Мөн цуглуулсан мэдээллээ хамрах түвшнээр (нас, эд хөрөнгийн байдал, болон хүйсээр г.м) ангилснаар эдгээр бүлгүүдэд тохирох хэрэгцээ, шаардлагыг хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах боломжтой болно.

1 дүгээр үе шатанд ашиглах хэрэгслүүд

LEGS-н анхдагч үнэлгээ гурван төрлийн шалгах асуултаас бүрддэг (*Бүдүүвч 3.1 болон Хайрцаг 3.1–3.3* харна уу). Байгаа мэдээллийг ашиглан оролцооны аргачлалаар эдгээр асуултуудад хурдан хариулах боломжтой. Гурван төрлийн асуултыг зэрэг ч асуух боломжтой бөгөөд асуултуудыг үүссэн нөхцөл байдалд тохируулан өөрчилж болно.

Шалгах асуултууд бүр “Шийдэх цэг”-ээр төгсөж байгаа бөгөөд энэ нь үүссэн нөхцөлд тохирох мал аж ахуйд чиглэсэн арга хэмжээг тодорхойлоход туслах юм. Хавсралт 3.2-т хагас бөглөсөн шалгах асуултуудын жишээг оруулав.

Бүдүүвч 3.1: LEGS-н анхдагч үнэлгээний шалгах асуултуудын тойм

1. Мал амьтны амьжиргаанд гүйцэтгэх үүрэг

Ердийн үед мал амьтан амьжиргаанд яаж хувь нэмэр оруулдаг вэ?

2. Онцгой байдлын мөн чанар болон үр нөлөө

Үүссэн онцгой байдал нь орон нутаг, мал амьтан болон мал маллагаанд яаж нөлөөлсөн бэ?

3. Нөхцөл байдлын дүн шинжилгээ

Байдал ямар байна вэ? (холбоо харилцаа, дэд бүтэц, аюулгүй байдал хэр байна, мөн бусад оролцогчид хэн байна вэ?)



Хайрцаг 3.1

Шалгах асуултууд 1: Мал амьтны амьжиргаанд гүйцэтгэх үүрэг

Хэрэв гамшигт нэрвэгдсэн хүн амын амьжиргаанд нь мал аж ахуй чухал үүрэгтэй бол мал амьтанд дэмжлэг үзүүлэх хэрэгцээ ихэснэ. Дараах асуултууд нь үнэлгээний багт мал амьтны амьжиргаанд үзүүлдэг ач холбогдол болон гүйцэтгэдэг үүргийг тодорхойлоход тусална. Ингэснээр мал амьтанд чиглэсэн хариу арга хэмжээ тохиромжтой эсэхийг шийдэх юм. Эдгээр мэдээллүүдийн дийлэнх нь бэлэн эх сурвалжуудад хэдийн дурдагдсан байдаг. Отроор яваа эсвэл онцгой байдлын үед хүрч очих боломжгүй байгаа бүлгүүдэд үнэлгээ хийхэд өмнө нь байсан мэдээлэл дээр үндэслэх хэрэгтэй болдог. Мэдээллийн эх сурвалж нь ямар ч байлаа гэсэн, малаа хэрхэн хариулдгийг ойлгож мэдэх нь чухал. Тэр дундаа малын үр ашиг, өмчлөл, болон маллагаа нь хүйсээр, эд хөрөнгийн байдлаар эсвэл эрсдэлд байгаа байдлаар ялгаатай бүлгүүдэд яаж нөлөөлж байгааг олж мэдэх нь чухал.

- 1.1** Гамшигт нэрвэгдсэн газар нутагт 'энгийн' буюу онцгой байдал үүсээгүй үед амьжиргаагаа залгуулдаг үндсэн арга хэлбэрүүд нь юу байдаг вэ?
- 1.2** Мал амьтныг голлон юунд ашигладаг вэ? (жишээ нь, хоол хүнсэнд, орлого олоход, нийгмийн харилцаанд, хүчний ажилд, уналга тээвэрт)?
- 1.3** 'Энгийн' үед болон улирлаас хамааран хоол хүнсний хэдэн хувийг мал амьтнаас гаргаж авдаг вэ?
- 1.4** 'Энгийн' үед орлогынхоо хэдэн хувийг мал аж ахуйгаас олдог (малын гаралтай бүтээгдэхүүнүүд, уналга тээвэрт, болон хүчний ажилд), түүнийгээ хэрхэн зарцуулдаг вэ?
- 1.5** Өрхийн гишүүд мал маллагаанд ямар үүрэгтэй оролцдог (ашиглах болон зарцуулах эрхийг оролцуулаад) вэ? Үүнд өрхийн гишүүдийн хүйс болон насанд онцгойлон анхаарал хандуулаарай. Мөн малын төрөл болон нас, улирлын онцлогийг тэмдэглэж авна.
- 1.6** Мал амьтны бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон байгалийн нөөцийн менежментэд уламжлалт болон бусад байгууллагууд, удирдлагууд хэрхэн оролцдог, ямар үүрэгтэй байдаг вэ?
- 1.7** Хүнд хэцүү цаг үе тулгарсныг илтгэдэг үзүүлэлтүүд болон түүнийг даван туулах үндсэн стратеги нь юу вэ? Жишээ нь хоол хүнсний хомсдол; мал амьтныг олноор нь нядлах эсвэл борлуулах; хэвийн бус шилжилт хөдөлгөөн; өрхийн гишүүд тархан суурьших; бусад эд хөрөнгөө зарж борлуулах гэх мэт. Эдгээр стратегиуд нь ирээдүйн амьжиргааны баталгаат байдалд сөрөг нөлөө үзүүлэх үү?



- ▶ **Шийдэх цэг:** Гамшигт нэрвэгдсэн иргэдийн амьжиргаанд мал аж ахуй чухал үүрэг гүйцэтгэдэг үү? Мал амьтанд чиглэсэн хариу арга хэмжээ авах шаардлагатай юу?

Хайрцаг 3.2

Шалгах асуултууд 2: Онцгой байдлын мөн чанар болон үр нөлөө

Энэ шалгах асуултууд нь нэрвэгдсэн хүн амд онцгой байдлын үзүүлсэн нөлөөллийг ойлгож мэдэхэд чиглэсэн. Үүгээр онцгой байдлын хариу арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тодорхойлно. Мэдээллүүдийн зарим нь бусад агентлагийн хийсэн үнэлгээнд эсвэл удаан үргэлжилж буй онцгой байдлын үед бол эрт үеийн үнэлгээнд хэдийн багтсан байж болох юм.

- 2.1** Энэ нь ямар төрлийн онцгой байдал вэ: түргэн явцтай, удаан явцтай эсвэл хавсарсан шинжтэй юу?
- 2.2** Онцгой байдал үүсэхэд ямар хүчин зүйл (ган, үер, газар хөдлөлт, зөрчил мөргөлдөөн г.м) нөлөөлсөн, мөн ямар газар нутгийг хамарч байна вэ?
- 2.3** Тухайн газар нутагт энэ төрлийн онцгой байдал тохиолдож байсан түүх бий юу?
- 2.4** Онцгой байдал аль үе шатандаа хүрээд байна вэ? (удаан явцтай гамшгийн **сэрэмжлүүлэг/түгшүүр/онцгой байдлын/нөхөн сэргээх үе;** эсвэл гэнэтийн гамшгийн **гэнэтийн хор хохирол/эрт үеийн нөхөн сэргээх/нөхөн сэргээх** г.м)
- 2.5** Хүн амын ямар хэсэг болон мал амьтны аль төрөл зүйл гамшигт нэрвэгдсэн бэ?
- 2.6** Үүссэн онцгой байдал нь нэрвэгдсэн хүн амд ямар нөлөө үзүүлсэн байна вэ? Тухайлбал:
 - 2.6.1** Нэрвэгдсэн хүн амын хоол хүнсний шим тэжээлийн төлөв байдал ямар байна вэ?
 - 2.6.2** Өвчин дэгдэлт ямар байна вэ?
 - 2.6.3** Нас баралтын үзүүлэлт ямар байна вэ?
 - 2.6.4** Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настнууд, тусгай хэрэгцээт иргэд, үндэс угсаа эсвэл нийгмийн гарлаараа өөр хоорондоо ялгаатай бүлгүүдэд онцгой байдал яаж нөлөөлж байна вэ?



- 2.6.5** Нэрвэгдсэн хүн амын онцгой байдалд хариу арга хэмжээ үзүүлэх чадамж нь ямар байна вэ?
- 2.6.6** Асуулт 1.7-д дурдсан хүнд хэцүү цагийг илтгэх үзүүлэлтүүд болон түүнийг даван туулах стратеги байна уу?
- 2.6.7** Нэрвэгдсэн хүн амын дунд олноор шилжилт хөдөлгөөнд оролцож эсвэл байршлаа өөрчлөх тохиолдол гарч байна уу? Хэрэв тийм бол хэн үүнд өртсөн, мөн тэд мал амьтнаа авч явсан байна уу?
- 2.6.8** Хэрэв нэрвэгдсэн хүн ам байршлаа өөрчилсөн бол, очсон газарт нь ямар нөлөө гарч байна вэ?
- 2.7** Онцгой байдал мал амьтанд ямар нөлөө үзүүлж байна вэ? Боломжтой бол малын төрлөөр нь ангилах. Тухайлбал:
- 2.7.1** Мал амьтны байдал хэр доройтсон бэ?
- 2.7.2** Малын эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлсэн бэ? (жишээлбэл, үс тэжээлийн хомсдол; гэмтэл бэртэл; өвчин; хэт хүйтрэлт эсвэл халалтаас үүдсэн цочрол)
- 2.7.3** Малын ашиг шимд нөлөөлсөн үү? (жишээ нь сүүний гарц, цус, өндөг, ажиллах хүч буурсан г.м)
- 2.7.4** Малын хорогдол нэмэгдсэн үү?
- 2.7.5** Малыг өрхийн хэрэглээнд зориулан нядлах нь ихэссэн үү?
- 2.7.6** Малын хорогдлын хэмжээ 'энгийн' үетэй харьцуулахад нэмэгдсэн үү?
- 2.7.7** Малын байр, хашаа саравчинд нөлөөлсөн үү?
- 2.8** Малын хариулга, маллагаанд үүссэн онцгой байдал ямар нөлөө үзүүлж байна вэ? Тэр дундаа:
- 2.8.1** Бэлчээрлэх болон өвс тэжээлд ямар нэг нөлөө үзүүлсэн үү?
- 2.8.2** Малаа услахад ямар нөлөө үзүүлсэн үү?
- 2.8.3** Өдөр тутмын болон улирлын нүүдэлд ямар нөлөө үзүүлсэн үү?
- 2.8.4** Малын худалдаачид, болон зах зээлд нийлүүлдэг малын гол бүтээгдэхүүнүүд ямар нөлөө үзүүлсэн бэ? (борлуулалт; үнэ; мал болон тэжээл хоорондын худалдааны нөхцөл; өвс тэжээлийн болон эмийн хангамж)
- 2.8.5** Мал эмнэлгийн үйлчилгээ, малын эмийн сан зэрэг мал амьтанд чиглэсэн үйлчилгээнд ямар нөлөө үзүүлсэн?
- 2.8.6** Ажиллах хүч дэх хүйсийн хуваарилалтад ямар нөлөө үзүүлсэн бэ?



- 2.9** Үүссэн онцгой байдал нь байгаль орчинд хэрхэн нөлөө үзүүлсэн, мал маллагаанд ямар үр нөлөө дагуулсан бэ?
- 2.10** Цаг агаарын урьдчилсан мэдээ болон улирлын урьдчилсан төлөв байдал ямар байна вэ? (цас, бороо, халалт, хуурайшилт, аюулгүй байдлын асуудлууд нэмэгдэх, болон хоол хүнсний хүртээмж г.м.)

► **Шийдэх цэг:** Онцгой байдлын хариу арга хэмжээ шаардлагатай юу?

Хайрцаг 3.3

Шалгах асуултууд 3: Нөхцөл байдлын дүн шинжилгээ

Эдгээр шалгах асуултууд нь үйл ажиллагаа явуулах орчноо ойлгож мэдэх, тээвэрлэлтэд тулгарч болох асуудлууд, бусад оролцогчидтой давхцаж байгаа эсвэл хамтарч хийх боломжтой ажлууд юу байгааг тогтоох юм.

- 3.1** Нэрвэгдсэн газар нутагт онцгой байдлын хариу арга хэмжээ хэрэгжүүлж байсан ямар түүх (эерэг болон сөрөг) байгаа, түүнээс авсан сургамж нь юу болох?
- 3.2** Нэрвэгдсэн газар нутагт гол оролцогчид (нутгийн хариу арга хэмжээ хэрэгжүүлэгчдийг оролцуулаад) нь хэн болох, мөн тэд юу хийж байгаа вэ?
- 3.3** Зохицуулах үүргийг гүйцэтгэж байгаа оролцогч байна уу? зохицуулалт хэр үр дүнтэй байна вэ?
- 3.4** Ямар нөөц боломжууд байна вэ, тэр дундаа уламжлалт даван дуулах стратегиуд болон нутгийнхны санаачлан хийж буй хариу арга хэмжээнүүд юу байна?
- 3.5** Одоогийн нөхцөл байдал ямар байна вэ?
- 3.5.1** Харилцаа холбоо хэр явагдаж байна?
- 3.5.2** Аюулгүй байдал хэр байна, хөтөлбөр болон ажилтны аюулгүй байдалд ямар нэг нөлөө байна уу?
- 3.5.3** Мал амьтныг нүүлгэх, шилжин суурьшуулах ямар боломж байна вэ (хил нэвтрэх эрх, үүсэж болох зөрчилдөөн)?
- 3.5.4** Малчдад тулгарч буй хамгааллын гол асуудлууд юу вэ?
- 3.5.5** Зам тээвэр зэрэг дэд бүтцийн одоогийн нөхцөл байдал ямар байна?



3.5.6 Бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцаа үзүүлэх ямар боломж байна? Жишээлбэл, зах зээл хүртээмжтэй, хэвийн ажиллаж байна уу? Бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцааг хүлээн авагчид болон төр зөвшөөрөх үү? Гар утсаар, мөнгөн гуйвуулгын компаниудаар гэх мэтчилэн найдвартай хүргэх зохицуулалт бий юу?

3.5.7 Хилээр нэвтрэхтэй холбоотой асуудлууд байна уу?

3.5.8 Мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд тулгарч болох бодлогын эсвэл хууль эрх зүйн асуудал байна уу? Жишээлбэл, малын хөдөлгөөн эсвэл экспортыг хорих; нядалгааны тухай хуулиуд; зөвшөөрлийн журмууд (орон нутгийн мал эмнэлгийн ажилчдын үйл ажиллагааны зөвшөөрөл г.м); тусламжийн байгууллагууд хоорондын зохицуулалт; болон гол оролцогч байгууллагуудын бодлого журам.

3.5.9 Үйл ажиллагаанд ямар нэг ашиг сонирхол (соёлын, улс төрийн, г.м.) нөлөөлөх магадлалтай юу?

Эдгээр асуултууд нь зөрчил мөргөлдөөнтэй байгаа газар нутагт үнэлгээ хийхэд илүү ач холбогдолтой.

- **Шийдэх цэг:** Дээрх асуултуудын хариулт нь нэрвэгдсэн газар нутагт үйл ажиллагаа хэрэгжүүлэхээс сэргийлэх, ноцтой асуудалтай тулгарахаар байна уу? Жишээ нь аюулгүй байдлын асуудлаас үүдэн нүүлгэх боломжгүй байна уу? Нэрвэгдсэн хүн амд бусад оролцогчид хэдийн хангалттай тусламж үзүүлсэн байна уу?

Мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийх

Үнэлгээний баг нь анхдагч үнэлгээний мэдээллийг цуглуулахдаа үр дүн, аргачлал, эх сурвалж, огноог багтаасан энгийн загварыг ашиглана (Мэдээлэл цуглуулах загварыг Хавсралт 3.3-с харна уу). Үүний дараагаар эдгээр мэдээллийг шалгах асуултуудын бүтцийн дагуу нэгтгэж тайлан хэлбэрт оруулна. Үнэлгээний баг уулзаж шалгах асуулт бүрийн дагуу гол цуглуулсан мэдээллээ тулгаж, үр дүнгүүдээ нягталж, дүн шинжилгээ хийгээд мал амьтанд чиглэсэн хариу арга хэмжээ тохиромжтой эсэхийг шийднэ.



2 дугаар үе шат: Хариу арга хэмжээг тодорхойлох



Тойм

Хэрэв анхдагч үнэлгээгээр мал амьтанд тусламж үзүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн бол, дараагийн үе шат нь **ач холбогдол болон цаг хугацааны хувьд мал аж ахуйд чиглэсэн онцгой байдлын ямар хариу арга хэмжээнүүдийг** хэрэгжүүлэх хэрэгтэйг тодорхойлно. Үнэлгээний баг мал амьтанд чиглэсэн онцгой байдлын хариу арга хэмжээг боловсруулахдаа дор хаяж LEGS-н амьжиргааг дэмжих нэг зорилтод нийцүүлнэ. **Гамшигт нэрвэгдсэн нутгийн иргэдийг дэмжихийн** тулд:

1. Одоо байгаа мал амьтнаасаа **нэн даруй ашиг тус хүртэх**;
2. **Эд хөрөнгийг хамгаалах**; болон/эсвэл
3. **Эд хөрөнгийг сэргээн босгох**.

LEGS нь онцгой байдлын үед нэрвэгдсэн хүн амын мал сүрэгт чиглэсэн амьжиргааг дэмжих зургаан техникийн тусламжийг үзүүлдэг. Эдгээрийг нэгнээ дэмжих хэлбэрээр цугт нь хэрэгжүүлж ч болдог. Жишээлбэл ганд нэрвэгдсэн мал сүрэгт тэжээл болон усны хангамжийг хамтад нь хүргэх; эсвэл газар хөдлөлтөөр хорогдсон малыг нөхөн олгохын хамтаар мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлнэ. Эдгээр зургаан техникийн тусламж нь:

- **Тэжээл:** гамшигт нэрвэгдсэн мал амьтныг өвс тэжээлээр хангах;
- **Ус:** байгаа усны үүсвэрийг сэлбэх эсвэл шинэ эх үүсвэр бий болгох замаар мал амьтныг усаар хангах;
- **Мал эмнэлгийн үйлчилгээ:** малын эрүүл мэндийн үйлчилгээ;
- **Малын байр, байршуулалт:** цаг уурын аюулт үзэгдэл, аюултай нөхцөл байдал эсвэл нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн мал амьтныг хамгаалах;
- **Малын тоог бууруулах:** гамшигт нэрвэгдсэн мал амьтныг зах зээлийн эсвэл хүнс тэжээлийн үнэлэмжээ алдахаас нь өмнө зохицуулах (зарж борлуулах эсвэл нядалгааны хөтөлбөрүүдээр)– мал худалдаалах нь гантай үед ихэвчлэн хэрэгжих боломжтой бөгөөд харин малын өвчин гарсан үед шууд устгалд оруулах хэрэгтэй;
- **Малжуулах:** онцгой байдлын үеэр хорогдсон малыг нөхөн олгох, эсвэл



онцгой байдлын дараагаар амьжиргааг дэмжих шинэ үйл ажиллагаа хэлбэрээр олгодог.

2 дахь үе шатны арга хэрэгсэл

2 дахь үе шатанд LEGS-н хэрэглэдэг аргачлал бол **Оролцооны аргаар хариу арга хэмжээг тодорхойлох матриц (PRIM)** юм. PRIM-н зорилго нь оролцоог хангах бөгөөд:

- Хурдан хугацаанд шууд харагдахуйц үр дүнгүүдийг гаргадаг;
- Аль үйл ажиллагаа нь хамгийн сайн үр нөлөө үзүүлэхээр байгааг харуулдаг;
- Хариу арга хэмжээний зорилгод (амьжиргааг дэмжих зорилт) төвлөрч; хэрэгжилтийн тохиромжтой цагийг тогтоодог.

PRIM-г ажлын хэсэг болж хийхэд хамгийн тохиромжтой. Хэрэв танхимаар уулзаж хийх боломжгүй бол багаараа цахим уулзалт хийж болно. PRIM боловсруулахад бүх гол оролцогчдыг хамруулах хэрэгтэй. Үүнд нутгийн удирдлагууд, хямралд өртсөн хүн амын төлөөлөл, (эрэгтэй, эмэгтэй бүгд) болон эрсдэлд байгаа гол бүлгүүдийн төлөөллийг багтаана. Ийнхүү өргөн хүрээтэй оролцоог хариу арга хэмжээний төлөвлөлтийн үйл явцад хангаснаар орон нутгийн мэдлэг, үр чадварыг тодорхойлох, мөн онцгой байдалд хариу үзүүлэх чадамжийг таньж мэдэх юм.

PRIM-н зүүн хэсэгт техникийн 6 тусламжийг (тэжээл; ус; мал эмнэлгийн үйлчилгээ; малын байр; малын тоог бууруулах; болон малжуулах) нь LEGS-н амьжиргааг дэмжих 3 зорилтод нийцүүлэхээр байрлуулсан. Энэ нь оролцогчдод зорилт бүрд үйл ажиллагаа тус бүр хэр үр нөлөө үзүүлэхийг нягтлах боломж олгодог (*Бүдүүвч 3.2* харна уу).

Матрицын баруун хэсэгт тохиолдож буй онцгой байдлын үе шатуудыг харуулах бөгөөд техникийн тусламж үзүүлэх хамгийн тохиромжтой цагийг тодорхойлоход тусална.

LEGS нь удаан явцтай гамшиг болон гэнэтийн гамшиг тус бүрд зориулсан PRIM загвартай. Эдгээр нь *бүлэг 1*-д тодорхойлсон онцгой байдлын үе шатуудын хоёр тусдаа тодорхойлолт дээр үндэслэсэн (*Хавсралт 3.4* дээрээс PRIM-н хоосон загварыг харна уу). Хавсарсан онцгой байдлын үед оролцогчид одоо үүссэн нөхцөлд хамгийн ойр дөхөж байгаа гамшгийн төрлөөр нь PRIM боловсруулна. Өөрчилж хийх бол ярилцаж байгаад тодорхойлолтуудаа гаргаад түүнийгээ матрицынхаа баруун хэсэгт оруулж өгнө.



Бүдүүвч 3.2: Оролцооны аргаар хариу арга хэмжээ тодорхойлох матриц (PRIM) дээр хэрхэн ажиллах

2 LEGS-н зорилтыг
техникийн тусламжуудтай
тохируулна

↓

1 Гэнэтийн эсвэл удаан
явцтай гамшгаас хамааран
PRIM загварыг сонгоно

↓

LEGS-н амьжиргааг
дэмжих зорилтуудыг
тохирох байдлаар оноо өгнө

↓

Үйл ажиллагааны тохирох
цагийг сонгоно

↓

Техникийн тусламжууд	Нэн даруй ашиг тус хүртэх	Эд хөрөнгийг хамгаалах	Эд хөрөнгийг нөхөн сэргээх	Гэнэтийн хор хохирол	Эрт үеийн нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлт
Тэжээл	2			✓	✓	
Ус	0					
Мал эмнэлгийн үйлчилгээ	3	3	3	✓	✓	✓
Малын байр		2		✓	✓	
Малын тоог бууруулах	0	0	0			
Малжуулах			3			✓

3 Техникийн тусламж нь
амьжиргааг дэмжих
зорилтыг хэр хангаж
байгааг оноогоор
үнэлнэ

4 Техникийн тусламжийг
хэрэгжүүлэх хамгийн
тохиромжтой үеийг зөвөөр
тэмдэглэнэ

5 Үр дүнгээ нягтлаад хамгийн
тохиромжтой техникийн
тусламжууд аль болохыг
тогтооно

1. Үүссэн онцгой байдлын төрөлдөө (гэнэтийн эсвэл удаан явцтай) тохирсон PRIM загварыг сонгоод одоогийн нөхцөл нь онцгой байдлын үе шатуудтай тохирч байгаа эсэхийг баталгаажуулна (*Бүлэг 1: LEGS-н танилцуулга. LEGS онцгой байдал болон түүний үр нөлөөг хэрхэн тодорхойлдог вэ? хэсгийг харна уу*). PRIM-н баруун дээд хэсэг нь онцгой байдлын төрлөөс (гэнэтийн эсвэл удаан явцтай) хамаарч өөр байгааг анзаараарай. *Бүдүүвч 3.2-т гэнэтийн гамшгийн жишээ өгөгдсөн байгаа.*
2. Боломжит техникийн тусламжуудыг LEGS-н амьжиргааг дэмжих 3 зорилтуудтай уялдуулж, холбож харна. (*Бүлэг 1-н Хүснэгт 1.1 болон техникийн тусламжуудыг танилцуулсан Бүлэг 4-9 харна уу*). Тэнд



техникийн тусламж бүр LEGS-н амьжиргааг дэмжих зорилтуудад хэрхэн хувь нэмэр оруулж болохыг танилцуулсан.

3. Тухайн тусламж зорилт тус бүрд хүрэхэд хэр үр нөлөөтэй байж болохыг 0-3 гэсэн оноогоор үнэлнэ. 3 маш сайн, эерэг нөлөөтэй; 2 тодорхой үр нөлөөтэй; 1 маш бага нөлөөтэй; 0 тохиромжгүй.
4. Зөв тэмдэглэгээгээр тусламжийн хэрэгжих тохиромжтой цаг үеийг тэмдэглэнэ.
5. Матрицаа нягтлаад, аль тусламжууд нь одоо өрнөж буй онцгой байдлын үе шатанд хамгийн сайн үр дүнг авчрахаар байгааг тогтооно. LEGS-н техникийн тусламжууд нь нэг болон хэд хэдийг сонгон хэрэгжүүлэх боломжтойг санаарай. Тусламжууд нь онцгой байдлын үе шатны дагуу дараалж эсвэл нэгэн зэрэг хэрэгждэг.

Бүгд дуурайж хэрэглэх 'зөв' PRIM загвар гэж байдаггүй; PRIM бүр тухайн байршил, үүссэн хэрэгцээнээс хамаараад оролцооны аргаар боловсруулагдана.

Оролцогчид матрицыг боловсруулахдаа хувийн ашиг сонирхол эсвэл мэдлэгтээ дулдуйдан нэг талыг барьж болохгүй.

Хавсралт 3.4-т PRIM-н гэнэтийн болон удаан явцтай гамшгийн хоосон загварууд, Хавсралт 3.5-д гүйцэт боловсруулсан PRIM-н загварууд байгаа.

PRIM нь тухайн нөхцөлд өрнөж буй онцгой байдлын үе шатанд мал аж ахуйд суурилсан амьжиргааг дэмжин хамгаалах хамгийн тохиромжтой, цагаа олсон үйл ажиллагааг тодорхойлон гаргаж ирж байгаа юм. Ингэснээр 3 дугаар үе шатанд шилжих суурь тавигдана.

3 дугаар үе шат: Техникийн тусламжууд болон тэдгээрийн хувилбаруудад дүн шинжилгээ хийх



Тойм

2 дахь үе шатанд оролцогчид PRIM-г ашиглан хамгийн тохиромжтой нэг эсвэл хэд хэдэн техникийн тусламжийг сонгосон бол 3 дахь үе шатанд



эдгээр сонгосон тусламжийн хувилбаруудаас **тохиромжтой байдал, хэрэгжих боломж, болон цаг хугацааны** хувьд аль нь илүү оновчтой болохыг нарийвчлан шинжилнэ. Үүнд зориулан техникийн бүлгүүдэд (4–9) олон төрлийн арга хэрэгслүүдийг багтааж өгсөн. Өмнөх шатанд дурдсан LEGS-н 6 техникийн тусламж бүрд хэрэгжүүлж болох хувилбарууд байгаа. Жишээлбэл: усны машинаар ус зөөвөрлөх эсвэл худгийг засаж янзлах, мөн малыг зарж эсвэл нядалж тоог бууруулах гэх мэт хувилбарууд *хүснэгт 3.1*-д багтсан.

Хүснэгт 3.1: Техникийн тусламжууд болон хувилбаруудын тойм

Техникийн тусламж	Техникийн хувилбарууд
Тэжээл	Онцгой байдлын үед байран тэжээх Онцгой байдлын үед тэжээлийн баазад тэжээх
Ус	Уст цэгүүд Ус зөөвөрлөх
Мал эмнэлгийн үйлчилгээ	Мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээ Улсын мал эмнэлгийн үйлчилгээ
Малын байр, байршуулалт	Малын байр Мал ба байршуулалт
Малын тоог цөөлөх	Малыг арилжаалан борлуулах Малыг хэрэглээнд нядлан борлуулах
Малжуулах	Мал аж ахуйд суурилсан хөрөнгийг нөхөн сэргээх Мал аж ахуйд суурилсан хөрөнгийг бий болгох



3 дахь үе шатны арга хэрэгслүүд

LEGs-н техникийн тусламжууд болон тэдгээрийн хувилбаруудын тохиромжтой байдал болон хэрэгжих үндэслэлд дүн шинжилгээ хийх **5 гол арга хэрэгслүүдийг** багтаасан. Эдгээр арга хэрэгслүүдийг хэрэгтэй гэсэн тохиолдолдоо ашиглаж болох бөгөөд ямар нэг дэс дараалал мөрдөх эсвэл бүгдийг нь ашиглах шаардлагагүй. Дараах байдлаар хэрэглэж болно:

1. Хамгийн тохиромжтой хувилбаруудыг сонгохын тулд холбогдох техникийн тусламжийн бүлгийн эхэнд байгаа **хувилбарууд** хэсгийг нягталж харна.
2. Сонгосон хувилбарынхаа **ашиг тус болон сорилт бэрхшээлүүдийн хүснэгтийг** нягталж харна.
3. Техникийн тусламж нь үүссэн онцгой байдлын үе шаттай **цаг хугацааны** хувьд тохирч байгаа эсэхийг тусламжийн цагийн хүснэгтээс нягталж баталгаажуулна.
4. **Шийдвэрийн** модоор дамжуулан сонгосон тусламж/хувилбаруудын төлөв болон шалгууруудыг нягтална.
5. Илүү нарийн төлөвлөхдөө **стандартууд, үндсэн үйл ажиллагаанууд болон зааварчилгааг** нягтлаарай.

Арга хэрэгсэл 1: Хувилбаруудын тойм

Техникийн тусламжийн 6 бүлэг тус бүр тухайн тусламжийн хүрээнд хэрэгжүүлж болох хувилбарууд тус бүрийн тайлбарыг багтаасан. Жишээ нь тэжээлээр хангах бүлэгт онцгой байдлын үед тэжээх хоёр хувилбар: (а) байран; болон (б) тэжээлийн цэгийг санал болгож байгаа. Тэжээлийн хувилбар (б) дотроо мөн хоёр дэд хувилбартай: очиж тэжээх (өдрийн) цэг, болон суурин тэжээх цэг.

Үүссэн нөхцөлд аль хувилбарууд нь хамгийн тохиромжтойг сонгохдоо тайлбарыг нь уншиж нягтлаарай.

Арга хэрэгсэл 2: Хувилбаруудын ашиг тус ба сорилт бэрхшээлүүд

Техникийн тусламжийн бүлэг тус бүрд хувилбаруудын ашиг тус болон сорилт бэрхшээлүүдийг нэгтгэсэн хүснэгт байгаа (Жишээ нь *Бүлэг 4: Малыг тэжээлээр хангах Хүснэгт 4.2* харна уу). Энэ хүснэгтийг нягталснаар сонгосон хувилбарынхаа тохиромжтой эсэхийг баталгаажуулна.

Арга хэрэгсэл 3: Цаг хугацааны хүснэгт

Техникийн тусламжийн бүлэг тус бүрд гэнэтийн болон удаан явцтай гамшуудын үе шатуудад үйл ажиллагааны олон хувилбаруудаас хэрэгжүүлэхэд хамгийн тохиромжтой үе нь аль болохыг харуулсан цаг хугацааны хүснэгт байгаа (Жишээг нь *Бүлэг 4-н Хүснэгт 4.3* харна уу). Эдгээр цаг хугацааны хүснэгт нь зөвлөмж төдий бөгөөд орон нутгийн нөхцөл



байдлаас хамаарч өөрчлөгдөж болно. Зааварчилгааны хүснэгтийг нягталж сонгогдсон хувилбарыг үүссэн нөхцөлд хэрэгжүүлэх хамгийн тохиромжтой хугацаа нь хэдийд байгааг шалгаарай. Хавсралт С (Гарын авлагын төгсгөлд байгаа) бүх техникийн тусламжийн бүлгүүдийн цаг хугацааны хүснэгтийг нэгтгэсэн байгаа.

Арга хэрэгсэл 4: Шийдвэрийн мод

Техникийн тусламжийн бүлэг бүрд байгаа шийдвэрийн мод нь тухайн техникийн хувилбарыг сонгохоос өмнө анхаарч үзэх шаардлагатай гол асуултууд болон асуудлуудыг хамтад нь гаргаж тавьдаг (жишээ болгон *Бүлэг 4, Бүдүүвч 4.1* харна уу).

Шийдвэрийн модны асуултуудын 'Тийм' эсвэл 'Үгүй' гэсэн хариултыг дагаж явсаар ямар нэг хувилбаруудад эсвэл 'үйл ажиллагаа байхгүй' гэсэн хайрцагт тулж ирнэ. Анхдагч үнэлгээний болон PRIM-р боловсруулсан мэдээлэл нь эдгээр асуултуудад хариулахад тусална. 'Үйл ажиллагаа байхгүй' гэсэн дүгнэлтэд хүрсэн бол энэ ямар ч тусламж хэрэггүй гэсэн үг биш харин нь гол асуултуудад 'Тийм' гэж хариулахад шаардлагатай нэмэлт бэлтгэл ажлуудыг хийх хэрэгтэй гэсэн утгатай байх магадлалтай.

Арга хэрэгсэл 5: Стандартууд болон зааварчилгаанууд

Техникийн тусламжийн бүлэг бүрд стандартууд, үндсэн үйл ажиллагаанууд болон зааварчилгаанууд багтсан. Эдгээр нь хариу арга хэмжээ төлөвлөхөд анхаарах асуудлууд болон нэмэлт мэдээллээр хангадаг бөгөөд дараах байдлаар тодорхойлж болно:

- **Стандартууд нь** ерөнхийдөө чанарыг баримталсан байх бөгөөд ямар ч онцгой байдлын үед хангах ёстой доод шалгуурыг илтгэдэг.
- **Үндсэн үйл ажиллагаанууд нь** стандартуудыг дагаж явдаг бөгөөд тэдгээрийг мөрдөхөд туслах үндсэн алхам, үйл ажиллагаануудыг багтаадаг.
- **Зааварчилгаа нь** үндсэн үйл ажиллагаатай хамт хэрэглэгддэг бөгөөд стандартыг мөрдөхөд анхаарах тусгай асуудлуудыг хөнддөг.

Техникийн тусламжийн бүх бүлэг нь LEGS-н 8 зарчимтай хэрхэн холбогддог, мөн тэдгээрийг хэрэгжүүлэхэд анхаарах нарийн асуудлуудыг багтаасан.

Техникийн тусламжийн бүх бүлэг нь **үнэлгээ болон төлөвлөлтийн** стандартыг багтаасан (үнэлгээний шалгах асуултууд нь бүлгийн хавсралтуудад байгаа). Энэ стандарт нь хэрэгжүүлэгч агентлагуудад хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахад хэрэгтэй гол мэдээлэл болон асуултуудыг гаргаж өгдөг. Ихэнх техникийн бүлгүүд нь хэрэгжүүлэгч агентлагуудын онцгой байдал үүсэхээс өмнө авч хэрэгжүүлэх шаардлагатай



үндсэн үйл ажиллагаа болон бэлтгэл ажлыг заасан **бэлэн байдлын стандартуудыг** багтаасан. Эдгээр үйл ажиллагаанууд нь төлөвлөлтийн үйл явцыг мэдээлж, шаардлагатай тохиолдолд хариу арга хэмжээний төлөвлөгөөнд ордог.

Техникийн тусламжийн бүлгүүдэд байгаа бусад стандартууд, үндсэн үйл ажиллагаанууд болон зааварчилгаанууд нь тухайн тусламж эсвэл түүний хувилбаруудтай холбогдох мэдээллийг агуулсан байдаг. Мөн хариу арга хэмжээний төлөвлөгөөний загвар боловсруулах, хэрэгжилтийг хангах нарийвчилсан техникийн зааварчилгаагаар хангадаг.

Хүргэх арга замууд болон механизмууд

Хариу арга хэмжээний төлөвлөгөөний бэлтгэл ажлын хүрээнд хэрэгжүүлэгч агентлаг нь хариу арга хэмжээг хүргэх механизм болон тохиромжтой арга замуудыг нягтлах шаардлагатай.

Арга замууд нь тусламж хүргэгдэж буй хэлбэрүүд юм. Үүнд тусламж хүлээн авагчид бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ байдлаар шууд олгогддог бодит тусламж, эсвэл хүлээн авагчид өөрсдөө хэрэгцээт зүйлсээ авах боломжийг олгодог бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцаа багтдаг. Бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцааг хүмүүнлэгийн тусламжид ашиглах нь нэмэгдсэн. Учир нь энэ хэлбэр нь туслалцаа хүлээн авагч өөртөө хамгийн шаардлагатай зүйлсээ эрэмбэлэн тодорхойлж, сонголтоо хийхийг дэмждэг бөгөөд энэ төрлийн туслалцаа амьжиргаагаа хамгаалах, дахин эхлэхэд эерэг үр нөлөө үзүүлж байгаа тохиолдлууд олон харагдаж байгаа.

Хэрэгжүүлэгч агентлаг нь шаардлагатай бараа, үйлчилгээгээр хангаж чадах зах зээлийн хүртээмж (эсвэл боломжит хүртээмж), тусламж хүлээн авагчид бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцаа эсвэл материаллаг тусламж алийг нь илүүд үзэж байгаа болон тэдний тусламжаа өөрсдөө авч чадах байдал зэрэг хэд хэдэн хүчин зүйлийг харгалзан үзээд ямар хэлбэрээр туслахаа шийддэг. Мөн аюулгүй байдал, донор болон агентлагуудын шаардлага, хүчин чадлыг бодолцож үзэх хэрэгтэй. Анхдагч үнэлгээ нь бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцаа үзүүлэх боломжтой эсэхийг тодорхойлоход тусална. (*Үнэлгээний шалгах асуултууд 3, асуулт 3.5.6*).

Хүргэх механизм нь хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авагчдад бэлэн мөнгө эсвэл эрхийн бичиг хэлбэрээр (жишээ нь ухаалаг карт, утсаар шилжүүлэх, кассаар авах, чек, АТМ-р авах г.м) хүргэх эсвэл шилжүүлэх арга зам бий. Зарим хүргэлтийн механизмууд нь мөн хүлээж авах, хадгалах болон төлбөр төлөлтийн (жишээ нь утсан дээрх түрийвч, банкны данс, ухаалаг карт г.м.) үйлчилгээг ч үзүүлдэг.



Хавсралт 3.6-д LEGS-н техникийн тусламжуудад Бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцаа (CVA) үзүүлэх боломжит арга замууд болон хүргэлтийн механизмуудыг харуулсан (Бүдүүвч 3.8 болон Хүснэгт 3.5 харна уу). Эдгээрийн дараа шийдвэрийн модоор дамжуулан CVA нь хэрэгжих үндэслэлтэй бас тохиромжтой юу гэдгийг тодорхойлно (Бүдүүвч 3.9-г харна уу).

Бэлэн мөнгө (бэлнээр эсвэл цахимаар) эсвэл эрхийн бичгийн (бэлнээр эсвэл цахимаар) туслалцаа нь мөн үйл ажиллагааны зорилтоос хамаардаг:

- Бэлэн мөнгөний хувьд яаралтай хэрэгцээ байгаа үед (жишээ нь тэжээл эсвэл мал эмнэлгийн үйлчилгээ авах) илүү тохиромжтой. Мөн гол бараа үйлчилгээ нь орон нутгийн зах зээлээс хангагдах боломжтой үед тохиромжтой.
- Эрхийн бичгийн туслалцаа нь тусгай бараа, үйлчилгээний (жишээ нь, хэрэв тусгай тэжээл эсвэл мал эмнэлгийн үйлчилгээ хэрэгтэй болох, эсвэл тусгай хашаа хороо барих шаардлага гарах) чанарыг алдагдуулахгүй байх шаардлагатай үед тохиромжтой.


Үүнээс гадна шууд бус бэлэн мөнгөний тусламжийн хувилбарууд байдаг бөгөөд хэрэгжүүлэгч агентлагууд нь үйлчилгээ үзүүлэгч эсвэл төрийн байгууллагад үйл ажиллагааг хэрэгжүүлэх урамшуулал олгох байдлаар хэрэгждэг. Жишээлбэл нядалгааны байрны төлбөрийг чөлөөлөх, нүүх зөвшөөрлийн хураамж, худалдааны төвийн хураамж, эсвэл мал эмнэлгийн үйлчилгээний төлбөр; тээврийн зардлын урамшуулал; ус ашиглагчдын холбоог түлшээр хангах; нэмэлт тэжээлийн үнийг бууруулах эсвэл төрөөс урамшуулал олгох.

Бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцаа (CVA)-д гол анхаарах асуудал нь түүнийг малчдад хүргэх механизм (хүлээн авагчдад хэрхэн очих арга зам) бөгөөд жишээлбэл, гарт нь эсвэл кассаар дамжуулан бэлнээр олгох нь оторлож яваа малчдын хувьд тийм ч тохиромжтой бус. Ийм үед хэрэв боломжтой бол гар утсаар шилжүүлэх хувилбар илүү оновчтой. Үүнтэй адилаар хэрэв бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцаа хүртэхэд бичиг баримтаа үзүүлэх хэрэгтэй болбол бичиг баримтгүй малчид эсвэл нүүдэл суудлаар бичиг баримтаа алдсан эсвэл таниулах боломжгүй болсон хүмүүст хүндрэл үүснэ.

Бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцаа (CVA)-тай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг (зах зээлийн үнэлгээ хийх дэлгэрэнгүй заавар болон бэлэн мөнгөөр хариу арга хэмжээ үзүүлэх механизмуудыг) *Эх сурвалж ба цаашид унших материал хэсгээс харна уу.*



4 дүгээр үе шат: Хариу арга хэмжээний төлөвлөгөө



Тойм

LEGS-н онцгой байдлын хариу арга хэмжээ төлөвлөлтийн 4 дүгээр үе шатанд хэрэгжүүлэгч агентлаг нь өмнөх гурван үе шатанд цуглуулсан мэдээлэл болон шийдвэрүүд дээр үндэслэн хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна.

LEGS-т хариу арга хэмжээний төлөвлөгөөний загварыг багтаасан (*Хавсралт 3.7* харна уу). Гэхдээ зарим байгууллагууд өөрсдийн загвар болон бага зэргийн ялгаатай нэр томъёог ашигладаг. Ямар ч загвар (эсвэл нэр томъёо) ашигласан бай, хариу арга хэмжээний төлөвлөгөө нь Үйл ажиллагаа → Үр дагавар → Үр дүн → Зорилт (*Хүснэгт 3.2-г* харна уу) гэсэн тодорхой үндэслэлтэй өөрчлөлтийн онолд суурилсан байна.

Хүснэгт 3.2: Мал амьтанд чиглэсэн хариу арга хэмжээний төлөвлөгөөний өөрчлөлтийн онол

Түвшин	Тодорхойлолт	Жишээ–Мал борлуулах
Үр нөлөө	Амьжиргаанд гарсан үр нөлөөнүүд нарийн тодорхойлогдсон	Малаа борлуулсан орлогын хамгийн багадаа 20% нь хариу арга хэмжээ хэрэгжиж дуусахаас өмнө үлдсэн мал сүргээ хамгаалахад зарцуулагдсан
Үр дүн (Зорилго)	Хариу арга хэмжээний богино болон дунд хугацааны эерэг үр дүнгүүд– үр дагавартай учир шалтгаанаар холбоотой	Нэг өрхийн малаа борлуулж олсон дундаж орлого нь \$100 ам.доллар
Үр дагавар (Зорилт)	Үр дүнд хүрэхээр авсан хариу арга хэмжээ	Нэг өрх 3 хүртэл бод малыг хэрэгжүүлэгч агентлагаар дамжуулан худалдаалсан.



Үйл ажиллагаанууд	Үр дагавруудад хүрэхээр хийсэн үйл ажиллагаанууд	Өрх бүрийн борлуулах малын тооны дээд хязгаарыг тогтоох Зорилтот өрхүүдийг тодорхойлох Малын үнийг тогтоох Тээвэрлэлтээ шийдэх г.м.
-------------------	--	--

Өөрчлөлтийн онолын доороос дээш үргэлжлэх явц нь логик дараалалтай байгааг нягтална:

- **Хэрэв** бид эдгээр **үйл ажиллагааг** хэрэгжүүлбэл, энэ **үр дагавар** гарна.
- **Хэрэв** бид энэ **үр дагаврыг** авчирвал, дараа нь энэ **үр дүнд** хүрнэ.
- **Хэрэв үр дүнд** хүрвэл, энэ нь **зорилт** болон **үр нөлөөнд** хувь нэмрээ оруулна.

Үйл ажиллагаанаас үр нөлөөнд хүрэх техникийн үндэслэлтэй явцыг хангахын тулд, өөрчлөлтийн онолын бүх үе шатыг тоон хэмжигдэхүүнээр тооцно. Хоорондын холбоосыг нь тогтоохын зэрэгцээ, өөрчлөлтийн онол болон болзошгүй эрсдлүүдийг тодорхойлох таамаглал гаргана. Эдгээрийг ХҮХС тогтолцоогоор хянана (ХҮХС тухай дараагийн хэсгийг харна уу).

LEGS-н амьжиргааг дэмжих зорилтууд нь ерөнхий байдаг ч хариу арга хэмжээний төлөвлөгөөний зорилтууд нь тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, холбоо хамааралтай мөн цагаар хэмжигдсэн (SMART зорилтууд) байх ёстой. Ингэснээр зорьсон амьжиргааны үр нөлөөг тогтсон хугацаанд гаргах боломж бүрдэнэ. SMART зорилтуудгүйгээр зорилт (үр нөлөө) биелсэн эсэхийг тодорхойлох хэцүү. Сайн, чанартай хийж гүйцэтгэсэн анхдагч үнэлгээ болон 1-3 дугаар үе шатанд тодорхойлсон хариу арга хэмжээнүүд нь тохиромжтой зорилтуудыг тодорхойлох үйл явц юм.

Хүснэгт 3.3: LEGS-н амьжиргааны зорилтуудыг SMART зорилтуудтай холбох нь

LEGS амьжиргааны зорилтууд	Хариу арга хэмжээний төлөвлөгөө дэх SMART зорилтуудын жишээ
Үлдсэн мал хөрөнгийг ашиглан гамшигт нэрвэгдсэн хүн амыг нэн даруй ашиг тус хүртэхэд нь дэмжих	Нядлан борлуулах: 2.2 кг борц нь 4 ам бүлтэй дундаж өрхийн авах шаардлагатай нийт уургийн хэмжээг дор хаяж бүтэн долоо хоног хангана
Гамшигт нэрвэгдсэн хүн амыг гол мал хөрөнгөө хамгаалахад нь дэмжих	Нэмэлт тэжээл: Төслийн хэрэгжих хугацаанд зорилтот өрхүүдэд чиглэсэн хариу арга хэмжээгээр малын хорогдол хамгийн багадаа 15% буурна



Гамшигт нэрвэгдсэн хүн амыг гол мал хөрөнгөө сэргээн босгоход нь дэмжих	Малжуулах болон мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх: Төслийн хэрэгжилтийн 20 дахь сар гэхэд малжуулсан айлуудын дор хаяж 75% багадаа 40 тооны хонь, ямаатай байна.
---	---

4 дүгээр үе шатны арга хэрэгсэл

4 дүгээр үе шатны арга хэрэгсэл нь хариу арга хэмжээний төлөвлөгөө (*Хавсралт 3.7*-с хариу арга хэмжээний загварыг харна уу) юм. Энэ төлөвлөгөө нь өмнөх 3 үе шатуудад цуглуулсан мэдээлэл болон дүн шинжилгээнд үндэслэгдэнэ.

Хариу арга хэмжээний төлөвлөгөө нь сонгосон техникийн тусламжууд, тэдгээрийн хувилбарууд, холбогдох LEGS-н амьжиргааг дэмжих зорилтууд, хариу арга хэмжээний SMART зорилтууд болон хариу арга хэмжээгээр хүрэх өөрчлөлтийн явцыг багтаах ёстой. *Хавсралт 3.8*-д мал борлуулах үйл ажиллагаагаар хэсэгчлэн боловсруулсан хариу арга хэмжээний төлөвлөгөөг харууллаа.

Хэрэгжүүлэгч агентлагуудын хувьд үйл явц болон үр нөлөөний үзүүлэлтүүдийг (дараагийн хэсгээс тодорхойлолтыг нь хараарай) тодорхойлох нь хариу арга хэмжээний төлөвлөгөөний нэг чухал хэсэг юм. Ингэснээр үйл ажиллагаа хэрэгжиж эхэлмэгц хяналт тавих боломжтой болно. Хяналтын тоон мэдээлэл нь хэрэгжилтийн явцад үйл ажиллагаануудыг засаж сайжруулах боломж олгодог чухал ач холбогдолтой. Мөн бүрэн хэмжээний ХҮХС тогтолцооны хүрээнд үр нөлөөг үнэлэх болон үнэлгээ хийхэд хэрэгтэй гол мэдээллээр хангадаг (*доорх хэсгээс харна уу*).

Хариу арга хэмжээний төлөвлөгөө нь үйл ажиллагаанууд нь нээлттэй, Зорилтот бүлгийг оролцоотойгоор тогтоох, анхдагч үнэлгээ (Үе шат 1) болон олон нийтийн хэлэлцүүлгээр мэдээллээ цуглуулсны үндсэн дээр шударгаар хэрэгжиж байгаа гэдгийг бататгах хэрэгтэй. Хэрэгжүүлэгч агентлаг нь зорилтот бүлгээ сонгох аргачлал болон тусламж хүлээн авагчдаа сонгохдоо гамшигт нэрвэгдсэн хүн ам болон эрсдэлд байгаа бүлгүүдтэй зөвшилцөн тохирох хэрэгтэй.

Мөн сонгох шалгуураа нарийн гаргаж, нийтэд түгээж мэдээлнэ. Боломжтой бол олон нийтийн уулзалт хийж, нээлттэй, хариуцлагатай байдлыг хангах шаардлагатай. Зорилтот бүлгийг сонгох явц нь тусламж хүлээн авагчдын хяналт дор (эрсдэлд байгаа бүлгүүдийг марталгүй) явагдах ёстой. Ингэснээр ашиг тусыг тэгш бус хуваарилсан гэх эргэлзээг тайлж, хариуцлага, нээлттэй байдлыг нэмэгдүүлэхэд тусална.

Бүх 4 үе шат дууссанаар орон нутгийн нөхцөл байдал болон хэрэгцээнд



тулгуурласан, амьжиргааг дэмжих зорилтуудтай холбогдсон, оновчтой, хэрэгжих боломжтой, цаг хугацаатай үйл ажиллагаатай хариу арга хэмжээний төлөвлөгөө бэлэн болно.

LEGS гарын авлагын 4-9 бүлэгт энэхүү ажиллагааг дэмжих техникийн дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан болно.

LEGS-н үйл ажиллагаанууд дахь Хяналт, үнэлгээ, хариуцлагатай байдал, суралцах (ХҮХС) зааварчилгаа

Хяналт, үнэлгээ, хариуцлага, суралцах (ХҮХС) нь хариу арга хэмжээний төлөвлөлтийн LEGS-н бүх 4 үе шатыг дэмжиж оролцдог.

8 дугаар зарчимд (*Бүлэг 2-г харна уу*) онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн хариу арга хэмжээн дэх ХҮХС тогтолцооны ач холбогдлыг тайлбарласан. Энэ хэсэгт ХҮХС гол төлвүүдийг 10 дугаар бүлгийн 'Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаануудын хяналт, үнэлгээ болон үр нөлөөг үнэлэх' *НҮБ-ын Хүнс, Хөдөө аж ахуйн Байгууллага FAO (2016)*-тэй уялдуулах зааварчилгааг багтаасан. ХҮХС тогтолцооны талаар өөр олон эх сурвалжууд бий (*Эх сурвалж ба цаашид унших материалыг харна уу*).

Ихэнх байгууллагууд өөрсдийн ХҮХС тогтолцоотой, тусгай мэргэжилтэнтэй байдаг. Ийм тохиолдолд хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодорхойлогдсон үйл явцын болон хяналтын үзүүлэлтүүд шууд тогтолцоонд орж хяналтыг нэн даруй эхлүүлэх боломжтой.

Хэрэв бэлэн байхгүй бол, ХҮХС тогтолцоог төлөвлөлт эхэлмэгц бий болгох хэрэгтэй. Ингэснээр хяналт нь үйл ажиллагааны эхнээс тавигдах боломжтой бөгөөд хариу арга хэмжээний хэрэгжилтийн үеэр ХҮХС тогтолцоог үр дүнтэйгээр удирдан явуулна. ХҮХС тогтолцоо нь амьжиргааны үр нөлөөний тухай хамтын мэдлэгийг дэмжихэд чиглэсэн. Энэ тогтолцоо нь ерөнхийдөө:

1. Өөрчлөлтийн онолууд болон SMART зорилтуудыг хэрэглэх;
2. Үйл явц болон үр нөлөөний үзүүлэлтүүдийг тодорхойлох;
3. Оролцооны аргачлалуудыг бусад тоон мэдээлэлтэй хослуулах;
4. Хяналтаар дамжуулан шаардлагатай бол хэрэгжилтийг засаж сайжруулах;
5. Үр нөлөөний үнэлгээг хамруулах;
6. Хариуцлагатай байх;
7. Мэдлэгийг ашиглаж, түгээх үүргийг гүйцэтгэнэ.



1. SMART зорилтуудыг хэрэглэх

4 дүгээр үе шатанд дурдсанаар хариу арга хэмжээний зорилтууд нь тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, холбоо хамааралтай, мөн цаг хугацаатай (SMART) байх ёстой. Ингэснээр хариу арга хэмжээ сайн төлөвлөгдөж, амьжиргаанд үзүүлсэн үр нөлөөг хэмжих боломж олгоно.

Тэжээлээр хангах үйл ажиллагааг SMART зорилттой хэрэгжүүлбэл: 2 дүүрэгт, төсөл дуусахад хамгийн орлого багатай өрхүүдийн 50% нь голлох бог малынхаа хорогдлыг доод тал нь 25% багасгасан байна; *FAO (2016)* Хайрцаг 11, хуудас. 164. харна уу.

2. Үйл явц болон үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох

Шалгуур үзүүлэлтүүд нь хяналт болон үнэлгээг хэмждэг нэгж юм. LEGS-д үйл явцын болон үр нөлөөний гэсэн 2 төрлийн шалгуур үзүүлэлтүүд байдаг.

Үйл явцын шалгуур үзүүлэлтүүд нь үйл ажиллагааны явцыг хэмждэг: жишээлбэл, вакцинд хамрагдсан малын тоо, явуулсан сургалтын тоо гэх мэт. Ихэнхдээ тоогоор хэмжигддэг, жишээ нь мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хувьд явцын шалгуур үзүүлэлт нь олгосон эмийн тоо эсвэл хийгдсэн үзлэгийн тоо байж болно. Явцын шалгуур үзүүлэлтэд нь ихэвчлэн төслийн зарцуулалттай холбогддог учраас санхүүгийн хариуцлага тооцоход, мөн хэрэгжилтэд засвар өөрчлөлт оруулах, хэрэгцээг олж илрүүлэхэд ашиглагдана. Үйл ажиллагаа хэрэгжиж байх үед явцын хяналтыг тогтмол (жишээ нь сар бүр) явуулж байдаг.

Үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүд нь тусламж хүлээн авагчдын амьдрал болон амьжиргаанд үзүүлж буй үр нөлөөнд анхаардаг. Жишээ нь сүүгээ боловсруулснаар шим тэжээлийн түвшин сайжрах, эсвэл малаа борлуулснаар орлого нэмэгдэх. Дээр дурдсан мал эмнэлгийн үйлчилгээний жишээг авч үзвэл үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүд нь малд үзүүлсэн эмчилгээний хувьд малын хорогдлын тоог малын төрөл болон өвчлөлөөр нь гаргаснаар мэдэж болно. Үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүдийг хэмжихдээ ихэвчлэн үр нөлөөний үнэлгээний нэг хэсэг болгон хийдэг (доор харууллаа).

Үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүд нь ихэвчлэн өмнөх нөхцөл байдлын талаар ойлголт, мэдээлэлтэй байх эсвэл үр нөлөөг харуулах харьцуулах эхний суурь үзүүлэлттэй байхыг шаарддаг. Жишээ нь:

- Хэрэв малын тэжээл эсвэл мал эмнэлгийн үйлчилгээгээр хангах хариу арга хэмжээ нь малын хорогдлыг 50% бууруулахаар зорьсон бол үйл ажиллагаа эхлэх үеийн хорогдлын хэмжээг мэдэх хэрэгтэй. Энэ хорогдлын суурь түвшнийг 3 дугаар үе шатны үеэр олон нийттэй хэлэлцэн тогтоож болно.



- Хэрэв малыг нядлан борлуулж зорилтот өрхүүдэд бэлэн мөнгө олгох хариу арга хэмжээ төлөвлөсөн бол үйл ажиллагаа хэрэгжихээс өмнө өрхийн орлого эсвэл зарлага ямар байсан мэдээлэл хэрэгтэй. Ингэснээр үйл ажиллагаанаас олсон бэлэн мөнгөний ач холбогдлыг олж мэдэх боломжтой болно.
- Хэрэв гантай үед хүүхдүүдийн сүүний хэрэглээг нэмэгдүүлэхээр малыг тэжээл болон мал эмнэлгийн үйлчилгээгээр хангах хавсарсан үйл ажиллагаа хэрэгжүүлэх гэж байгаа бол, эхлэхээс өмнө сүүний хэрэглээ ямар байсан тухай мэдээллийг мэдэж байх хэрэгтэй.

Ийм суурь мэдээлэл 'бэлэн' байхгүй бол анхдагч үнэлгээний үеэр цуглуулах эсвэл дараа нь 'өнгөрсөн үеийн' суурь мэдээлэл хэлбэрээр цуглуулж болно; *FAO (2016)*-н хуудас. 165–166 харна уу (*Хүснэгт 21*).

LEGS-н техникийн бүлэг бүрд хавсралтаар үйл явц болон үр нөлөөний үзүүлэлтүүдийг санал болгосон байгаа. Мөн *FAO (2016)*-н хуудас. 161 (*Хүснэгт 19*) болон хуудас 165-г хэзээ үйл явцыг, мөн хэзээ үр нөлөөг хэмжих зааварчилгаа болгон харна уу.

3. Оролцооны аргуудыг бусад тоон мэдээлэлтэй хавсаргах

LEGS-н зарчмуудын хамтаар LEGS нь хяналт болон үнэлгээ хийх оролцооны аргачлалуудыг санал болгодог. LEGS-н анхдагч үнэлгээ болон хяналт, үнэлгээнд тохирох хэд хэдэн түгээмэл хэрэглэгддэг оролцооны аргачлалууд бий. Тэдгээрийг Оролцоотой суралцах болон ажиллах (Participatory Learning and Action - PLA), Оролцоотой орон нутгийн үнэлгээ (Participatory Rural Appraisal - PRA) болон оролцоот эпидемиологийн аргачлалуудаас авсан.

Оролцооны аргачлалууд нь ашигласан аргачлал болон бусад хүчин зүйлүүдээс хамааран өөр өөр төрлийн мэдээллүүдийг гаргаж ирж болно. Жишээ нь:

- Оролцоот зураглал нь тэмдэглэгээ хийсэн дүрсэн мэдээллийг гаргадаг.
- Албан бус ярилцлага нь хүмүүсийн илүү сонирхож буй малын төрөл, эсвэл хариу арга хэмжээний хэрэгжилтийн талаар үзэл бодол зэрэг хувийн чанартай мэдээллүүдийг гаргаж ирдэг. Мөн өдөрт саадаг сүүний хэмжээ эсвэл малын хорогдол, малын үнэ ханш зэрэг тоон мэдээллийг ч цуглуулж болдог.
- Эрэмбэлэх болон оноо өгөх аргачлалууд нь сонгогдсон зүйлийн ач холбогдлыг харуулдаг. *Хавсралт 3.1*-с оролцооны аргачлалуудын тухай илүү олж мэдээрэй.

Оролцооны аргаар цуглуулсан мэдээллийг бусад мэдээлэлтэй зэрэгцүүлэн шалгаж болно. Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн хариу арга хэмжээний үед хоёр чухал зэрэгцүүлэн шалгах зүйл байдаг:



- 1 болон 3 дугаар үе шатны үед төрөөс гаргасан малын болон зах зээлийн үйл ажиллагаа, үнийн мэдээлэл, малын бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон бусад асуудлаар хийсэн судалгааны тайлан нь оролцооны үнэлгээнд дэмжлэг болдог. Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн хариу арга хэмжээнүүдийн үнэлгээний өмнөх тайлангууд ч мөн чухал мэдээллээр хангадаг.
- Үр нөлөөний үнэлгээгээр хариу арга хэмжээний хэрэгжилтийн явцын хяналтын тоон мэдээллийг нэгтгэж амьжиргааны үр нөлөөний үнэлгээтэй харьцуулах хэрэгтэй. Өөрчлөлтийн онолоор үр нөлөөнд хөтөлж буй гүйцэтгэлүүдэд дүн шинжилгээ хийж, түүнийг хяналтын тоон мэдээллээр баяжуулна.

Бусад анхаарах асуудлууд:

- **Түүвэрлэх:** Онцгой байдлын үед хариу арга хэмжээний төлөвлөлтийн цаг давчуу байдаг тул чухал гэж үзсэн мэдээлэгч, оролцогчдын төлөөллийг тодорхойлж 'зорилтот түүвэр' авна. Ингэснээр эрсдэлд байгаа бүх бүлгүүдийг хамруулна (жишээ нь ганд нэрвэгдсэн ядуу малчид, эмэгтэй малчид, үерт автсан тосгоны оршин суугчид, эсвэл хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд – Хүүхэд хамгааллын минимум стандарт CPMS Pillar 4, *Стандартууд 21, 22*).
- **Ангилах:** Цуглуулсан мэдээллийг хүйс, нас, эрсдэлтэй бүлэгт холбоотой байдлаар нь ангилах хэрэгтэй (Зарчим 2: Олон нийтийн оролцоо, Зарчим 6: Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр болон *Бүлэг 1, Хайрцаг 1.3* харна уу).
- **Тоон мэдээлэл:** Оноо өгөх болон эрэмбэлэх аргачлалууд нь тоон мэдээлэл гаргадаг. Эдгээрийг давтамжтай хийснээр тоон мэдээллийн сантай болох боломжтой бөгөөд статистик аргачлалаар нэгтгэн дүгнэж дүн шинжилгээ ч хийж болно.
- **Хүртээмж:** Цар тахал, зөрчил мөргөлдөөн зэрэг нүүр нүүрээ харан уулзах боломжгүй тохиолдолд оролцооны стандарт аргачлалууд ашиглах боломжгүй юм. Иймд тохиолдолд дижитал арга хэрэгслүүд болох гар утас (ярилцлага хийх) мөн боломжтой бол цахим уулзалтуудыг (фокус бүлгийн ярилцлагад) ашиглаж болно. Хүүхдүүд болон залуу хүмүүстэй ярилцаж байгаа бол, хүүхдийг хамгаалах стандартад тохирсон аргачлалыг сонгоно. (CPMS *Зарчим 3: Хүүхдийн Оролцоо, Стандарт 22, Амьжиргаа болон Хүүхэд Хамгаалал*)
- **Тоон судалгаа:** Асуумж хэлбэрээр статистикийн түүвэр аргачлалаар ихэвчлэн авдаг. Тоон судалгаа нь уян хатан бус, оролцооны хэлбэрээр бус, мөн нэлээдгүй хөрөнгө, техникийн мэдлэг шаарддаг. Утасны апплейкшн зэрэг арга хэрэгслүүд тоон судалгаа авах явцыг хурдасгасан ч оролцооны хэлбэрээр бус байдаг нь LEGS-н *Зарчим 2:*



(Олон нийтийн оролцоо)-тай харшилж байна. Зарим тоон мэдээлэл нь SMART зорилтуудыг хянахад хэрэг болдог, жишээ нь малын зах зээлийн тоо мэдээ болон бараа, үйлчилгээний үнэ г.м. Гэхдээ энэ тоон мэдээллийг гол мэдээлэгчтэй ярилцлага хийхдээ цуглуулж ч болно. (LEGS-н Оролцооны Техникийн Арга хэрэгслүүд; болон *FAO (2016)* хуудас. 173, 175 болон 176.)

4. Хяналтын үр дүнг ашиглан шаардлагатай бол хэрэгжилтийг засаж сайжруулах

Хяналтыг гамшигт нэрвэгдсэн хүн амтай тогтмол яриа хийж, хариу арга хэмжээний хэрэгжилтийн гүйцэтгэл болон үйл явцыг үнэлж байх хэлбэрээр явуулах хэрэгтэй. Энэ үйл явцын үзүүлэлтүүдийг ажиглагчаар хянуулна. Хариу арга хэмжээний төлөвлөгөөний бэлтгэл 4 дүгээр шатанд боловсруулсан өөрчлөлтийн онол нь үр нөлөөнд үзүүлэх гүйцэтгэлийн урсгалд нөлөөлж болзошгүй эрсдэлүүд болон таамаглалуудад дүн шинжилгээ хийсэн. Олон нийттэй ярилцах нь эдгээр таамаглал болон эрсдэлүүдийг ажиглахад тусалдаг. Хяналт нь эдгээр асуудлуудыг нэн даруй тодорхойлж, тухай бүрд нь хэрэгжилтэд засвар оруулж сайжруулах боломжийг олгодог.

5. Үр нөлөөний үнэлгээг хамруулах

LEGS-н ХҮХС зарчим нь онцгой байдлын хариу арга хэмжээг үнэлж түүнээс юу сурснаа ирээдүйд үйл ажиллагаандаа тусгахын ач холбогдлыг онцолдог.

Ердийн үнэлгээ нь төслийн зорилтын биелэлтийг үнэлдэг бол үр нөлөөний үнэлгээ нь хариу арга хэмжээний амьжиргаа, хүнсний аюулгүй байдал, эсвэл шим тэжээлд үзүүлсэн өөрчлөлтөд төвлөрдөг. LEGS нь үр нөлөөг тодорхой гаргах SMART зорилтуудыг хэрэглэхийг зөвлөдөг, ингэснээр 'үнэлгээ' болон 'үр нөлөөний үнэлгээ' нь хоорондоо тун төстэй болж ирнэ.

SMART зорилтуудад нийцүүлснийг үнэлэхээс гадна ашиг тус - зардлын дүн шинжилгээг багтааж болно. Энэ нь хариу арга хэмжээний санхүүгийн зардлыг нэрвэгдсэн хүн амд хүрсэн үр ашигтай (ихэвчлэн санхүүгийн) харьцуулж, мөнгөн дүнг нягтална. Жишээ нь, мал борлуулах үйл ажиллагааны зардалд дүн шинжилгээ хийхдээ малаа зарсан өрхүүдийн авсан бэлэн мөнгө болон хүлээн авсан махны мөнгөн дүнг харьцуулан гаргана.

LEGS үнэлгээ хийхдээ оролцооны аргуудыг ашиглахыг санал болгодог бөгөөд хариу арга хэмжээний үр нөлөөний дүн шинжилгээнд дурдсанаар гамшигт нэрвэгдсэн хүн амын оролцоог хангахад чиглэсэн юм. *Хавсралт 3.1-д* жагсаасан оролцооны аргачлалуудыг үр нөлөөний үнэлгээ, анхдагч үнэлгээ, болон явцын хяналтад ч ашиглаж болно. Мөн *FAO (2016)*: үнэлгээ, хуудас. 170–174; үр нөлөөний үнэлгээ, хуудас. 174–192; ашиг тус - зардлын дүн шинжилгээ, хуудас. 192–196.



6. Хариуцлагатай байдал

ХҮХС тогтолцоонд гамшигт нэрвэгдсэн хүн амаас хариу арга хэмжээний талаар санал сэтгэгдэл сонсох механизмыг суулгаж өгөх хэрэгтэй. Мөн тэдгээр санал сэтгэгдэл нь хэрэгжүүлэгчийн чихэнд хүрч, ямар нэг шийдэл гарсан гэдгийг эргээд хүмүүстээ мэдэгдэх хэрэгтэй. Хүмүүнлэгийн үндсэн стандарт (ХҮС) нь хариуцлагыг бий болгох, хянах бүтцийг 9 үзэл баримтлал (амлалт) болон холбогдох чанарын шалгуурт тулгуурлан гаргаж ирсэн (*Бүлэг 2: LEGS зарчмууд, Хүснэгт 2.1* харна уу). 9 үзэл баримтлалаар гүйцэтгэлийг хянах үзүүлэлтүүдийг ч мөн багтаасан (*ХҮС болон Эх сурвалж ба цаашид унших материалыг харна уу*).

7. Мэдлэгийг ашиглах болон түгээх

ХҮХС тогтолцооны суралцах хэсэг нь хяналт болон үнэлгээгээр цуглуулсан мэдээллээр одоо явагдаж буй болон ирээдүйн хэрэгжилтэд дүн шинжилгээ, эргэцүүлэл болон өөрчлөлтийг авчирч буйг илэрхийлдэг. Суралцах нь алдаагаа давтахгүй байхад, үйл ажиллагааг хэрэгцээ нөхцөлдөө тааруулан өөрчлөхөд, мөн ирээдүйн ажилдаа тусгах ч нөлөөтэй.

Үр өгөөжтэй суралцах нь албан хяналтын болон албан бус туршлагаар хуримтлагдсан мэдээллийг тогтмол нягталж байх тогтолцоог шаарддаг. Донор болон төрийн тайлан мэдээнээс гадна тогтмол олон нийтийн уулзалт хийдэг байх хэрэгтэй. Нэрвэгдсэн хүн амтай харилцаа холбоо, оролцоо болон хариуцлагыг хангаж байх тохиромжтой бусад арга замыг агентлагууд эрэлхийлэх хэрэгтэй. Гол хүрч ажиллах хэлбэрүүд нь:

- Байгууллага дотор болон ажилчдын дунд суралцах соёлыг бий болгох – суралцах үйл ажиллагаанд зориулж цаг, нөөц гаргах;
- Сайн харилцаа холбоог хангах тохиромжтой хэллэгтэй хэрэглэхэд хялбар загвар гаргаж хэрэглэх;
- Өмнөх онцгой байдлын хариу арга хэмжээнээс суралцахыг уриалах (жишээлбэл анхдагч үнэлгээний үеэр);
- Санал сэтгэгдэл эсвэл үйл ажиллагааны нөхцөл байдлаас үүдэн хариу арга хэмжээний хэрэгжилтэд гарсан өөрчлөлтийг тэмдэглэн авах;
- Мэдээллээ бусад хэрэгжүүлэгчид болон зохицуулалтын сүлжээнд хуваалцсанаар мэдлэгийг нэмэгдүүлэх.

(ХҮС Үзэл баримтлал (амлалт) 7-г харна уу.)



Хавсралтууд

Хавсралт 3.1: Анхдагч үнэлгээ-санал болгож буй оролцооны аргачлалууд

Ярилцлага хийх аргачлалууд

Ихэнх оролцооны аргаар мэдээлэл цуглуулах техникүүд нь нээлттэй асуулттай ярилцлагад суурилдаг бөгөөд үүгээр хэлэлцүүлэг өрнүүлж мөн ярилцагчтай эргэн холбогддог. Эдгээр ярилцлагууд нь ерөнхийдөө гурван хэлбэртэй байдаг:

- **Гол мэдээлэгчтэй хийх ярилцлага:** Эдгээр нь тодорхой мэдээлэл агуулсан бүлгийн төлөөллүүдтэй зорьж уулздаг бөгөөд үүнд бүлгийн ахлагчид, орон нутгийн төрийн болон ТББ-ын албан хаагчид, шашны удирдагчид, эмэгтэйчүүдийн бүлэг, болон бусад иргэний нийгмийн байгууллагууд ордог.
- **Фокус бүлгийн ярилцлага:** Хүмүүсийг ижил төстэй байдлаар нь бүлэг болгон (хүйс, нас, эд хөрөнгийн байдал, сонирхол, амьжиргаа залгуулдаг хэлбэрээр г.м.) ярилцлага хийдэг бөгөөд, тэдэнд тавьсан асуултаудыг өөр бүлэгт тавьж, хооронд нь харьцуулалт хийдэг.
- **Бусад оролцооны аргачлалд дэмжлэг болох:** Зураглал гаргах зэрэг оролцооны дасгал ажлуудаар гарсан мэдээллийг ярилцлага авах хэлбэрээр цааш нь илүү дэлгэрүүлж болдог.

Дүрслэх аргачлалууд

Фокус бүлгийн үеэр орон нутгийн нөхцөл байдал, гол асуудлуудыг дүрслэхдээ (шууд газар дээр эсвэл цаас ашиглан) энэ аргыг ашиглаж болно:

- **Зураглал** газар нутгийн гол шинж тэмдгүүдийг тодорхойлж өгдөг (орон нутгийн нөөц боломжууд, үйлчилгээнүүд, худалдааны төвүүд, бэлчээрийн газар, усалгааны цэг, мал эмнэлэг г.м), мөн аюулгүй байдал болон малын нүүдэлтэй холбоотой мэдээллийг ч гаргадаг.
- **Улирлын хуанли** отроор бэлчээрлэх хугацаа, үр тариа, хадлан хадах цагийг ч тэмдэглэнэ.
- **Түүхэн цаг хугацаа** амьжиргаанд нөлөөлж байсан томоохон үйл явдлууд, гамшгуудыг тодорхойлно (ган, хүчтэй шуурга г.м).
- **Венн диаграмм** байгууллагууд эсвэл үйлчилгээ хоорондын холбоо хамаарлыг харуулдаг.

Эрэмбэлэх болон оноо өгөх аргачлалууд

Эрэмбэлэх болон оноо өгөх аргачлалууд нь тоон үр дүн гаргадаг тул нэгтгэж, дүн шинжилгээ хийхэд дөхөм байдаг:



- **Хувь тэнцүүлэн харьцуулах арга нь** хамааралтай чухал зүйлсийг харуулдаг. Жишээ нь: өөр өөр төрлийн малын өвчлөлийн үр нөлөө гэх мэт.
- **Эрэмбэлэх арга нь:** Тэргүүлэх байдал, хэрэгцээ шаардлагаар нь дэс дараалалд оруулдаг. Жишээ нь: мал амьтанд тулгараад байгаа асуудал гэх мэт.
- **Матрицаар оноо өгөх арга нь** нь төрөл бүрийн шалгууруудыг тохируулан үнэлэх арга юм. Жишээ нь: мал амьтанд чиглэсэн боломжит үйл ажиллагааг хариу арга хэмжээний хурд болон малын хорогдолд авчрах үр нөлөө, зардал зэрэгт тохируулан оноогоор дүгнэнэ.

Хүснэгт 3.4 дээр дурдсан зарим оролцооны аргачлалуудыг анхдагч үнэлгээний 3 төрлийн сонгогдсон шалгах асуултуудтай холбов.

Хүснэгт 3.4: Анхдагч үнэлгээнд санал болгож буй оролцооны аргачлалууд

3

Үнэлгээний шалгах асуултууд*	Сэдэв	Аргачлал
1.5	Хүйс/насны үүрэг болон улирлын онцлог	Өдрийн/ улирлын хуанли
2.5 2.6 2.8 2.9 2.10	Нэрвэгдсэн газрын хамрах хүрээ Эрсдэлд байгаа нэрвэгдсэн бүлгүүд 'энгийн' болон онцгой байдлын үеийн үйлчилгээ болон байр сууц Байгалийн нөөцийн зураглал (өмнө ба дараа): бэлчээр, ус, нүүлгэлт шилжилт хөдөлгөөн Байгаль орчинд үзүүлсэн нөлөө Улирлын өөрчлөлт	Зураглал
2.3 2.4 2.7 2.8	Онцгой байдлын үе шатууд Малын өвчлөлийн төлөв Малын борлуулалтын төлөв Малын үнэ ханшийн төлөв Малын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөв	Цаг хугацааны шугам



Үнэлгээний шалгах асуултууд*	Сэдэв	Аргачлал
1.3 1.4 2.6 2.7 2.8	Орлого/хоол хүнсний эх сурвалж Шим тэжээлд гарсан өөрчлөлт Хүмүүсийн өвчлөлд гарсан өөрчлөлт Малын худалдаа, үнэ, болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлд гарсан өөрчлөлт	Хувь тэнцүүлэн харьцуулах
1.3 1.4 2.7 3.1	Орлого/хоол хүнсний эх сурвалж Малын төлөв байдал, хорогдол, өвчлөл Өмнөх хариу арга хэмжээний түүх болон үр дүн	Эрэмбэлэх/ оноогоор дүгнэх
2.6	Нэрвэгдсэн хүн ам (зорилтот бүлгийг тогтооход)	Эд хөрөнгөөр жагсаах
1.6 3.2 3.3	Уламжлалт байгууллагуудын үүрэг болон харилцаа холбоо Гол оролцогчид болон зохицуулалт	Венн диаграм

* Дугаарууд нь шалгах асуултуудын дагуу байгаа

Анхдагч үнэлгээг дэмжих нэмэлт аргачлалууд:

- **Хүйсийн үүрэг болон эрх мэдлийн харьцаатай холбоотой 1.5 асуултад:** 'Women's empowerment in livestock index' (Galiè et al., 2018); мөн *Хайрцаг 1: Five Steps in a Rapid Gender Analysis* in the LEGS Gender Discussion Paper (de Jonge, K. and Maarse, L., 2020)
- **Шим тэжээлийн талаарх 2.6 асуултад:** *Standardized Monitoring and Assessment of Relief and Transitions Protocol* – хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн статус, малын хорогдлын тоон мэдээллээр тогтмол хангадаг агентлаг хоорондын санаачилга. Судалгаа явуулах гарын авлага, болон дүн шинжилгээ хийх программ хангамжтайгаа ирдэг, – CE-DAT (SMART 2017)
- **Малын хорогдлын тухай 2.7 асуултад:** Catley et al. (2014)–н гангийн үеэр малын хорогдлын шалтгааны үнэлсэн оролцоот эпидимологийн аргачлалыг үзээрэй



- **Төлөвлөсөн үйл ажиллагаа болон онцгой байдлын байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх 2.9 асуултад:** Rapid Environmental Assessment Tool (Hauer, M. and Kelly, C 2018) болон FRAME assessment tool (UNHCR, 2009)
- **Даван туулах стратегиудтай холбоотой хэд хэдэн эх сурвалжууд бий (асуулт 1.7, 2.6.5 болон 2.6.6):** жишээ нь Coping Strategies Index (Maxwell and Caldwell 2008).

Оролцооны аргачлалуудтай холбоотой дэлгэрэнгүй зааварчилгааг *Эх сурвалж ба цаашид унших материал хэсгээс* харна уу.



Хавсралт 3.2: Анхдагч Үнэлгээ – шалгах асуултуудын жишээ (хэсэгчлэн боловсруулсан)

Зүүн өмнөд Азид тохиолдсон галт уулын дэлбэрэлтийн гэнэтийн гамшгийн үед хийгдсэн анхдагч үнэлгээний сонгосон асуудлуудаар цуглуулсан мэдээг жишээ болгон оруулав.

1.1 Гамшигт нэрвэгдсэн газар нутагт 'энгийн' үед амьжиргаагаа залгуулдаг үндсэн арга хэлбэрүүд нь юу байдаг вэ?

Айл өрхүүдийн ихэнх нь амьжиргааны хувьд мал амьтнаас хамаардаг бөгөөд үр тариа ургуулж нэмэлтээр хэрэглэдэг. Мал сүргийн дийлэнх нь махны чиглэлийн үхэр (А дүүргийн өрхүүдийн 60%, Б дүүргийн өрхүүдийн 90%), зарим айлууд сүүний чиглэлийн үнээ болон гахай малладаг.

Дүүрэг	Дүүрэг А	Дүүрэг Б
Хүн амын тоо	1,100,000	1,250,000
Нийт малын тоо	18,300	275,000

Аргачлалууд: аймгийн төрийн байгууллагуудын тайлан (хүн болон мал амьтны тоо); амьжиргааны арга замуудын талаарх фокус бүлгийн ярилцлага

1.2 Мал амьтныг голлон юунд ашигладаг вэ? (жишээ нь хоол хүнсэнд, орлого олоход, нийгмийн харилцаанд, хүчний ажилд, уналга тээвэрт)

- Малын бүтээгдэхүүнээс махыг хамгийн өргөн хэрэглэдэг бөгөөд Б дүүргийнхэн сүү мөн хэрэглэдэг гэжээ.
- Хоёр дүүрэгт үр тариа тариалах ажилд малаа хэрэглэдэг, мөн аргал, бууцыг нь түлш, бордоо болгон ашигладаг байна.

Аргачлалууд: фокус бүлгийн ярилцлага

1.5 Өрхийн гишүүд мал маллагаанд ямар үүрэгтэй оролцдог (ашиглах болон зарцуулах) вэ? Үүнд өрхийн гишүүдийн хүйс болон насанд онцгойлон анхаарал хандуулж, мөн малын төрөл болон нас, улирлын онцлогийг тэмдэглэж авна.

Эрэгтэйчүүд: Малыг газар тариалангийн ажилд ашиглах, үхрээ хариулах.

Эмэгтэйчүүд: Будааны талбайг цэвэрлэж, дахин тариалалт хийх, гахай шувуу зэрэг жижиг амьтдаа малладаг.

Зарцуулах эрх нь ч мөн энэ хариуцсан малынхаа хүрээнд байдаг. Эмэгтэйчүүд жижиг амьтад, түүнээс гарсан бүтээгдэхүүнийг зарж борлуулдаг бол эрэгтэйчүүд бод малаа болон үр тариагаа зарцуулах асуудлыг хариуцдаг.



Нэмж тэмдэглэхэд, өмнөх галт уулсын дэлбэрэлтээс үүссэн шавхруу нь тэр хавийнхны хэрэгцээг хангадаг ойролцоох голд нийлсэн байна. Үүнээс болж голын хажуу хавийн тосгоны эрчүүд элс олборлох ажил хийж байгаа бол эмэгтэйчүүд болон өрхийн бусад гишүүд малаа хариулж, үр тариагаа боловсруулж байна.

Аргачлалууд: өдөр тутмын болон улирлын хуанли; фокус бүлгийн ярилцлага

2.7 Онцгой байдал мал амьтанд ямар нөлөө үзүүлсэн бэ? Малын төрөл бүрд. Тухайлбал:

2.7.1 Мал амьтны нөхцөл хэр доройтсон бэ?

Хоёр дүүрэгт галт уулын дэлбэрэлтийн дараа үүссэн үнс, нурам нь олон мал амьтны эрүүл мэндэд нөлөөлжээ. Бүх оролцогчид тодорхой тооны мал амьтнаа алдсан гэж мэдээлсэн.

2.7.2 Малд ямар үр нөлөө үзүүлэв (жишээ нь өвс тэжээл болон усны хомсдол; гэмтэл бэртэл; өвчлөл; хэт хүйтрэлт эсвэл халалтаас үүдсэн цочрол)?

А дүүрэг галт уулын үнс нь амьд үлдсэн мал амьтны эрүүл мэндэд нэлээд сөрөг нөлөө үзүүлсний дотор суулгалт, (оролцогчдын 50%), болон амьсгалын замын асуудлууд (45%) давамгайлсан байна. Бэлэн (эсвэл цэвэрхэн) өвс тэжээлийн хомсдол үүссэн нь олон мал амьтныг нь эцэж сульдахад (30%) хүргэжээ.

2.7.4 Малын хорогдол нэмэгдсэн үү?

Малын хорогдлын гол шалтгаанууд нь:
 -Өвс тэжээлийн хомсдолоос үүдэн сульдсан (53%);
 -Нүүлгэн шилжүүлэлтийн үеэр гэмтэж бэртсэн (20%);
 -Үнс, нурмаас үүдэлтэй өвчлөл (15%);
 -Цангаж үхэх (12%).

Аргачлалууд: фокус бүлгийн ярилцлага; хувь тэнцүүлэн харьцуулах



Хавсралт 3.3: Анхдагч үнэлгээ – тэмдэглэл хийх загвар

Энэ анхдагч үнэлгээний дүгнэлтүүд нь энэ жишээгээр үзүүлсэн шиг энгийн загвар дээр тэмдэглэгдэж болно:

Огноо

Байршил:

Оролцогчид – эрэгтэй:

Оролцогчид – эмэгтэй:

Ярилцлага авагчийн нэр:

Үнэлгээний аргачлал	Үнэлгээний асуулт(ууд)	Гол үр дүнгүүд
Фокус бүлгийн ярилцлага	1.1, 1.2	
Хувь тэнцүүлсэн харьцуулалт	1.3	
.....		
.....		
.....		



Хавсралт 3.4: PRIM – загварууд

Бүдүүвч 3.3: Гэнэтийн гамшгийн PRIM загвар

LEGS-н амьжиргааг
дэмжих зорилтуудад
тохируулан оноо өгөх

Үйл ажиллагаа явуулах
тохиромжтой цаг үе

Техникийн тусламжууд	Нэн даруй ашиг тус хүртэх	Эд хөрөнгийг хамгаалах	Эд хөрөнгийг нөхөн сэргээх	Гэнэтийн хор хохирол	Эрт үеийн нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлт
Тэжээл						
Ус						
Мал эмнэлгийн үйлчилгээ						
Малын байр						
Малын тоог цөөлөх						
Малжуулах						

3 – Зорилтод маш эерэг үр нөлөөтэй

2 – Зорилтод тодорхой үр нөлөөтэй

1 – Зорилтод маш бага үр нөлөөтэй

0 – Тохиромжгүй

**Бүдүүвч 3.4: Удаан явцтай гамшгийн PRIM загвар**

LEGS-н амьжиргааг
дэмжих зорилтуудад
тохируулан оноо өгөх

Үйл ажиллагаа явуулах
тохиромжтой цаг үе

Техникийн тусламжууд	Нэн даруй ашиг тус хүртэх	Эд хөрөнгийг хамгаалах	Эд хөрөнгийг нөхөн сэргээх	Сэрэмж лүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
Тэжээл							
Ус							
Мал эмнэлгийн үйлчилгээ							
Малын байр							
Малын тоог цөөлөх							
Малжуулах							

3 – Зорилтод маш эерэг үр нөлөөтэй

2 – Зорилтод тодорхой үр нөлөөтэй

1 – Зорилтод маш бага үр нөлөөтэй

0 – Тохиромжгүй

Хавсарсан гамшгийн үед удаан явцтай болон гэнэтийн гамшгийн аль алиныг нь багтаасан, холбогдох PRIM-г ашиглана. (Хавсралт 3.5-д байгаа PRIM загвар С харна уу). Дээрх төрлийн гамшгууд биш, удаан үргэлжилж байгаа эсвэл хавсарсан онцгой байдлын үед, тохиромжтой гэж үзвэл PRIM-н зөвхөн зүүн хэсгийг ашиглана (амьжиргааг дэмжих зорилтуудтай).



Хавсралт 3.5: PRIM – жишээнүүд

Доорх жишээнүүд нь гэнэтийн, удаан явцтай болон хавсарсан шинжтэй зэрэг өөр төрлийн онцгой байдлын үед боловсруулсан PRIM-г харууллаа. Жишээ бүрд PRIM –н үр дүнг тайлбарласан болно.

Бүдүүвч 3.5: PRIM жишээ А. Гэнэтийн гамшиг – Азид болсон газар хөдлөлт

Техникийн тусламжууд	LEGS-н амьжиргааг дэмжих зорилтуудад тохируулан оноо өгөх			Үйл ажиллагаа явуулах тохиромжтой цаг үе		
	Нэн даруй ашиг тус хүртэх	Эд хөрөнгийг хамгаалах	Эд хөрөнгийг нөхөн сэргээх	Гэнэтийн хор хохирол	Эрт үеийн нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлт
Тэжээл	1	3	3	✓	✓	—
Ус	1	1	1	✓	—	—
Мал эмнэлгийн үйлчилгээ	1	3	3	✓	✓	✓
Малын байр	2	2	2	✓	✓	—
Малын тоо цөөлөх	0	0	0	—	—	—
Малжуулах	0	0	3	—	—	✓

3 – Зорилтод маш эерэг үр нөлөөтэй

2 – Зорилтод тодорхой үр нөлөөтэй

1 – Зорилтод маш бага үр нөлөөтэй

0 – Тохиромжгүй

PRIM Жишээ А тэмдэглэгээ:

- Газар хөдлөлтөөс амьд үлдсэн малыг нэн даруй тэжээлээр хангах нь айл өрхийг сүү болон малын гаралтай бусад бүтээгдэхүүнээр дамжуулан хоол хүнсний эрсдэлд оруулахгүй байхад тустай. Дараагаар нь мал эд хөрөнгөө хамгаалах болон эргэн босгоход ч тусалж болно. Хэрэв газар хөдлөлт болохыг урьдчилан мэдэх боломж байсан бол тэжээл болон ус нөөцлөх арга хэмжээг авч болох юм.
- Газар хөдлөлт нь бэлэн байгаа нөөц хангамжид ямар нэг нөлөө үзүүлсэн эсэхээс хамаарч усаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлбэл бага зэргийн ач тустай байх талтай.
- Амьд үлдсэн мал амьтанд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нь тэдний амьд үлдэх магадлалыг нэмэгдүүлэх ач тустай. Мөн эрт үеийн нөхөн сэргээлт болон нөхөн сэргээлтийн үед ч үнэтэй хувь нэмэр оруулдаг.



Мөн малын гаралтай хоол хүнс хэрэглэдэг өрхүүдийн хувьд жирэмсэн эмэгтэйчүүд/хүүхдийн хоол хүнсний чанарыг алдагдуулахгүй байх ач холбогдолтой.

- Малын байртай холбоотой тусламжууд нь мал амьтны төрөл болон үүссэн хэрэгцээнээс хамааран гамшгийн гэнэтийн хор хохирлыг бууруулах хэлбэрээр мөн мал хөрөнгийг хамгаалах, эргэн босгоход хэрэглэгдэж болно. Хэрэв түгшүүр, сэрэмжлүүлэг хангалттай авсан бол малаа хашаа хорооноос нь гаргаж, олон амьтдыг дарагдаж үхэх аюулаас аврах боломжтой байв. Гамшгийн дараах болон эрт үеийн нөхөн сэргээлтийн үед нэрвэгдсэн мал амьтныг дулаан, хуурай хашаа, байраар хангах нь тэднийг хамгаалж, тэнхрүүлэхэд чухал ач холбогдолтой.
- Зах зээлийн тогтолцоо хэвийн явагдахгүй байгаа бол малаа борлуулах нь гамшигт нэрвэгдсэн хүн амд нэн яаралтай тусламж болж чадахгүй. Мал нь ус эсвэл өвсгүйгээс болж үхэхээр байгаа бол нядалж борлуулах нь хамгийн тохиромжтой хувилбар болно. Хэрэв мал амьтан нядалж борлуулаад ч мах болохооргүй болтлоо эцэж турсан бол малынхаа зовлонг нь хөнгөлөөд, заралгүйгээр төхөөрөх нь зүйтэй. (*Бүлэг 8: Мал тоог бууруулах* хэсгээс харна уу).
- Эд хөрөнгөө эргэн босгохын тулд малаа алдсан иргэдийг малжуулах нь томоохон дэмжлэг болж чадна. Гэхдээ энэ үйл ажиллагааг зөвхөн нөхөн сэргээлтийн үед л хийж эхэлнэ.



Бүдүүвч 3.6: PRIM жишээ В. Удаан явцтай гамшиг – Африкт тохиож буй ган

LEGS-н амьжиргааг
дэмжих зорилтуудад
тохируулан оноо өгөх

Үйл ажиллагаа явуулах
тохиромжтой цаг үе

Техникийн тусламжууд	Нэн даруй ашиг тус хүртэх	Эд хөрөнгийг хамгаалах	Эд хөрөнгийг нөхөн сэргээх	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
Тэжээл	1	2	3	—	✓	✓	—
Ус	1	2	1	—	✓	✓	—
Мал эмнэлгийн үйлчилгээ	1	3	3	✓	✓	✓	✓
Малын байр	0	0	0	—	—	—	—
Малын тоо цөөлөх	3	2	1	✓	✓	(✓)	—
Малжуулах	0	0	3	—	—	✓	✓

3 – Зорилтод маш эерэг үр нөлөөтэй

2 – Зорилтод тодорхой үр нөлөөтэй

1 – Зорилтод маш бага үр нөлөөтэй

0 – Тохиромжгүй

PRIM Жишээ В-н тэмдэглэл:

Африкт тохиож буй удаан явцтай ган нь Жишээ А-д харуулсан газар хөдлөлтөөс хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл болон цаг хугацааны хувьд маш ялгаатай харагдаж байна.

- Гангийн түгшүүр болон онцгой байдлын үед тэжээл, усаар хангах нь мал сүргээ хамгаалах, цаашид сэргээн босгоход тусална.
- Гангийн бүх үе шатанд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нь мал хөрөнгийг хамгаалах, сэргээн босгоход чухал ач холбогдолтой бөгөөд хорогдол, өвчлөлөөс сэргийлж, мал амьтны ганг тэсэж гарах чадамжийг бэхжүүлдэг.
- Энэ жишээ дээр хашаа хороогоор хангах шаардлагагүй.
- Сэрэмжлүүлэг болон түгшүүрийн үед, малаа арилжаалан борлуулах нь нэрвэгдсэн айл өрхүүдэд бэлэн мөнгөний урсгалыг нээж, нэн даруй ашиг хүртэх боломжийг олгодог. Үлдэж буй малд ч хязгаарлагдмал нөөцөө хуваалцах малын тоо цөөрснөөр амьд үлдэх магадлал нь нэмэгдэнэ.



Малаа арилжсан мөнгөөрөө үлдсэн малдаа хэрэгтэй тусламж ч үзүүлнэ. Хэрэв энэ үйл ажиллагааг онцгой байдлын үе хүртэл хойшлуулбал мал хэт эцэж сульдсан байх тул арилжин борлуулах боломжгүй болно. Ийм үед нядалж борлуулах нь нэрвэгдсэн айл өрхөд тодорхой хэмжээний шууд дэмжлэг болж очно (хаалт дотор зөв тэмдэглэгээгээр дүрслэв).

- Жишээ дээр ган нь эхэн шатандаа (сэрэмжлүүлэг/түгшүүр) яваа учир нядлахаас илүүтэй зарж борлуулахыг илүүд үзэх хэрэгтэй. Энэ нь малчдад бэлэн мөнгөтэй болж цаашид амьжиргаагаа хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд нь тусална.
- Нөхөн сэргээлтийн үед малжуулах нь мал хөрөнгийг эргэн босгоход чухал хувь нэмэртэй.

PRIM-н сүүлийн жишээ нь зөрчил мөргөлдөөнтэй үед тохиож буй удаан явцтай гамшиг бөгөөд энэ нь хэрэгжүүлж болох үйл ажиллагааны тохиромжтой байдал, хэрэгжих үндэслэлд хэрхэн нөлөөлж байгааг харж болно.

Бүдүүвч 3.7: PRIM жишээ С. Хавсарсан гамшиг – Африкт удаан үргэлжилж буй зөрчил мөргөлдөөний үеэр тохиож буй ган

LEGS-н амьжиргааг
дэмжих зорилтуудад
тохируулан оноо өгөх

Үйл ажиллагаа явуулах
тохиромжтой цаг үе

Техникийн тусламжууд	Нэн даруй ашиг тус хүртэх	Эд хөрөнгийг хамгаалах	Эд хөрөнгийг нөхөн сэргээх	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
Тэжээл	1	3	3	—	✓	✓	—
Ус	1	1	1	—	✓	✓	—
Мал эмнэлгийн үйлчилгээ	1	3	3	✓	✓	✓	✓
Малын байр	2	2	2	✓	✓	✓	✓
Малын тоо цөөлөх	2	1	1	—	—	(✓)	—
Малжуулах	0	0	3	—	—	✓	✓

3 – Зорилтод маш эерэг үр нөлөөтэй

2 – Зорилтод тодорхой үр нөлөөтэй

1 – Зорилтод маш бага үр нөлөөтэй

0 – Тохиромжгүй



PRIM Жишээ С-н тэмдэглэгээ:

- Жишээ В-н PRIM-тэй харьцуулахад ихэнх боломжит үйл ажиллагаанууд нь (тэжээл, ус, мал эмнэлгийн үйлчилгээ, болон малжуулах г.м) хэрэгжиж болохоор байна. Ингэснээр гамшигт нэрвэгдсэн хүн амд ихээхэн ач тус хүргэнэ.
- Тэжээлээр хангах нь мал, хөрөнгийг хамгаалах болон сэргээн босгоход ач холбогдолтой. Ялангуяа малаа бэлчээх боломжгүй, хязгаарлагдмал орчинд байгаа үед бүр ч чухал. Үүнтэй адилаар үүссэн зөрчил мөргөлдөөнөөс үүдэн малаа услах цэгт аваачиж чадахгүй байгаа тохиолдолд усаар хангах ч мөн чухал. Ингэснээр хүн, малын ундны ус холилдохгүй байх ч давуу талтай.
- Жишээ В-н PRIM дээр хашаа, байр шаардлагагүй гэж байсан бол энэ тохиолдолд аюулгүй байдлын үүднээс (хулгай дээрэмд өртөх г.м) болон нүүлгэн суурьшуулсан тохиолдолд зайлшгүй шаардлагатай болж ирсэн.
- Зөрчил мөргөлдөөнтэй үед зах зээл болон дэд бүтэц хэдийн саатсан байдаг тул малаа арилжаалан борлуулах нь тохиромжгүй. Нядалж борлуулах (хаалт дотор зөв тэмдэглэгээгээр дүрслэв) арга хэмжээ арай тохиромжтой байж болох ч хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагаа хэр хязгаарлагдмал байгаагаас хамаарна.
- Энэ бүх үйл ажиллагаанууд нь хариу арга хэмжээ үзүүлэгчийн зөрчил мөргөлдөөнтэй нөхцөл байдалд хэрхэн ажиллах чадамжаас хамаарна.



Хавсралт 3.6: Бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцаа– хариу арга хэмжээний арга замууд, хүргэлтийн механизмүүд болон шийдвэрийн мод

Бүдүүвч 3.8: LEGS-н техникийн тусламжууд болон тэдгээрийн хувилбаруудад зориулсан хариу арга хэмжээний загварууд

Техникийн тусламжууд болон тэдгээрийн хувилбарууд	Бэлэн мөнгө шилжүүлэх төрлүүд		
	Мөнгөн тэтгэлэг*	Эрхийн бичгүүд*	Материаллаг тусламж**
Тэжээл			
Суурин тэжээх	✓	✓	✓
Тэжээлийн баазад тэжээх	✓	✓	✓
Ус			
Уст цэгүүд	✓	✓	✓
Ус зөөвөрлөх	✓	✓	✓
Мал эмнэлгийн үйлчилгээ			
Мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээ	✓	✓	✓
Улсын мал эмнэлгийн үйлчилгээ	—	—	✓
Малын байр			
Малын байр	✓	✓	✓
Мал байршуулах	—	—	✓
Малын тоог цөөлөх			
Малыг арилжаалан тоог бууруулах	✓	—	✓
Малыг хэрэгцээлэн тоог бууруулах	✓	—	✓
Малжуулах			
Хорогдсон малыг нөхөн сэлбэх	✓	✓	✓
Малтай болгох	✓	✓	✓

*Хэрэв хэрэгжүүлэгч байгууллага нь бэлэн мөнгөний тусламж эсвэл эрхийн бичгийн туслалцаа үзүүлэх бол хөтөлбөрийн зорилтоос хамаарч түүндээ ямар нэг нөхцөл (жишээ нь малаа вакцинжуулсан байх, сургалтад хамрагдсан байх г.м) эсвэл хориг шаардлагууд (тодорхой малын тэжээл эсвэл эмийн төрөл заалтад) тавих эсэхээ шийдэх хэрэгтэй. Хэрэв малжуулахад зориулж



их хэмжээний мөнгө шилжүүлэх бол тодорхой нөхцөл тавих нь зүйтэй. Жишээ нь нийт мөнгийг хэсэгчлэн олгох ба эхний хэсгээ зориулалтын дагуу зарцуулснаа баталгаажуулснаар дараагийн хэсгийг хүлээн авна.

Нөгөө талаар, хэрэв зорилт нь тодорхой элементтэй бол (мал амьтны биед шаардлагатай шим тэжээл г.м), агентлагууд нь малчдыг чанарын шаардлага хангах яг тохирсон тэжээлийг товлосон борлуулагчаас авах шаардлагыг тавих нь зүйтэй.

Бэлэн мөнгөний тусламж нь шууд болон шууд бус хэлбэртэй байж болдог. Шууд шилжүүлгийг малчдад өгч болох бол шууд бус шилжүүлгийг малын худалдаачдад өгч болно. Мал арилжаалан борлуулахыг шууд бус шилжүүлэгт тооцох бөгөөд зах зээлийн ажиллагааг дэмжихийн тулд агентлагуудаас малын худалдаачдад зээл олгож буй хэрэг юм. Шууд шилжүүлэгт агентлагууд малчдад мал худалдан авах эрхийн бичиг олгох хэлбэр багтаж болно.

****Материаллаг тусламжид (жишээ нь малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах г.м), нөлөөлөх (бодлогын болон зөвшөөрөлтэй холбоотой саад бэрхшээлүүдэд), сургалт хийх, г.м.**

Хүснэгт 3.5: LEGS-н үйл ажиллагаанд ашиглах Бэлэн мөнгө, эрхийн бичгийн тусламж (CVA)-г хүргэх боломжит механизмуд

Ангилал	Тодорхойлолт	Боломжит нийлүүлэгчид
Бэлэн мөнгөний тэтгэлэг		
Шууд бэлэн мөнгөөр төлөх	Тусламж хүлээн авагчид хэрэгжүүлэгч байгууллага бэлэн мөнгийг шууд олгоно	Хэрэгжүүлэгч байгууллага/ хамтрагч
Агент/кассаар дамжуулж хүргэх	Бэлэн мөнгийг зуучлагчаар ажиллах албан болон албан бус байгууллагаар дамжуулан хүргэнэ; үүнд тусламж хүлээн авагчийн банкны данстай байхыг шаарддаггүй	Мөнгө шилжүүлдэг агентууд, шуудан, худалдаачид, бичил санхүүгийн байгууллагууд, банкнууд
Урьдчилсан төлбөрт карт	АТМ машинд уншуулж болох картыг CVA-д хэрэглэж болно; карт уншигч машинд уншуулах бол сүлжээтэй байх мөн гүйлгээг баталгаажуулах шаардлагатай	Банк, ББСБ, бичил санхүүгийн байгууллагууд, шуудан




Ангилал	Тодорхойлолт	Боломжит нийлүүлэгчид
Ухаалаг карт	Чиптэй карт, АТМ болон карт уншигч машинд алинд нь ч уншуулж болно, бэлэн мөнгөний тэтгэлэг болон дэлгүүрээс худалдан авалт хийхэд хэрэглэнэ; сүлжээ байхгүй үед ч гүйлгээг баталгаажуулах боломжтой	Банк, ББСБ-ууд, шуудан
Гар утсаар мөнгө шилжүүлэх	Нууцлалтай кодыг дэлгүүр эсвэл худалдааны төвд уншуулаад мөнгө авч болох бөгөөд CVA-н үед хэрэглэдэг; гүйлгээ хийхийн тулд утас нь интернэт холболттой байх шаардлагатай	Үүрэн телефоны оператор, банкууд
Банкны данс	Бэлэн мөнгөний тэтгэлгийг байршуулах хувийн эсвэл эзэмшлийн данснууд; тусламж хүлээн авагчийг албан бичиг баримттай мөн заримдаа оршин суугаа хаягаа шалгуулахыг шаарддаг.	Банкнууд
Эрхийн бичгүүд		
Эрхийн бичиг	Цаасаар, цахимаар эсвэл бусад хэлбэрээр урьдчилан тохирсон үнээр сонгосон борлуулагчаас бараа эсвэл үйлчилгээ солилцон авахыг хэлдэг	Хэрэгжүүлэгч агентлаг/ хамтрагч/ борлуулагч


UNHCR-н Бэлэн мөнгө түгээх механизм Үнэлгээний арга хэрэгслүүд дээр суурилан боловсруулав – <https://www.unhcr.org/5899ebec4.pdf>

CALP Network Ашигласан хэвлэлийн жагсаалт болон цаашид уншиж судлах материалыг харна уу.



Бүдүүвч 3.9 Мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд Бэлэн мөнгө, эрхийн бичгийн тусалцаа (CVA)-ны шийдвэрийн мод







Хавсралт 3.7: Хариу арга хэмжээний төлөвлөгөө – загвар

Үйл ажиллагаа:	
Хувилбар	
LEGS Амьжиргааг дэмжих зорилтууд	
SMART Зорилт	Үр нөлөөний үзүүлэлтүүд . .
Үр дүнгүүд	Үйл явцын үзүүлэлтүүд . .
Үр дагаврууд	Үйл явцын үзүүлэлтүүд . .
Үйл ажиллагаанууд	Үйл явцын үзүүлэлтүүд . .



Хавсралт 3.8: Хариу арга хэмжээний төлөвлөгөө – Малын тоо бууруулах үйл ажиллагааны жишээ

Үйл ажиллагаа: Малын тоо бууруулах		
Хувилбар	Малыг арилжаалан тоог бууруулах	
LEGS	Амьжиргааны эд хөрөнгийг хамгаалах	
Амьжиргааг дэмжих зорилтууд		
SMART		
Зорилт	Үйл ажиллагаа дуусахаас өмнө малаа борлуулаад олсон орлогынхоо хамгийн багадаа 20%-г үлдсэн малаа хамгаалахад зарцуулна.	Үр нөлөөний үзүүлэлтүүд • Малаа зарсан орлогын тодорхой хэсэг нь ус, тэжээл, мал эмнэлгийн үйлчилгээ эсвэл мал тээвэрт зарцуулагдана
Үр дүнгүүд	Зорилтот өрхүүд малаа зараад бэлэн мөнгөний орлоготой болно	Үйл явцын үзүүлэлтүүд • Мал борлуулаад олсон өрхийн дундаж орлого
Үр дагаврууд	Мал худалдаалах	Үйл явцын үзүүлэлтүүд • Борлуулсан малын дундаж тоо болон төрөл • Борлуулалтын хугацаа
Үйл ажиллагаанууд	Зорилтот газар нутгийг тодорхойлох Малын худалдаачдыг тодорхойлох Орон нутаг болон худалдаачдын дунд харилцан яриа өрнүүлэх Орон нутгийн удирдлагатай малын худалдааны татварыг хөнгөлөх талаар тохирох	Зорилт тодорхойлох. Цаг төлөвлөх Байршлууд... Худалдан авалт... Үйл явцын үзүүлэлтүүд • Олон нийтийн төлөөлөл болон бусад оролцогчидтой хийсэн уулзалтын тоо • Олон нийт болон худалдаачдын уулзалтын тоо • Татварын хөнгөлөлт

Хариу арга хэмжээний төлөвлөгөөний үйл ажиллагааны хэсэг нь зорилтот бүлгүүд, цагийн хуваарь, байршил, худалдан авалтын үйл явц, хүргэх загвар зэрэг нарийвчилсан мэдээллийг сайтар оруулж өгөх хэрэгтэй.



Эх сурвалж ба цаашид унших материал

Энд дурдсан эх сурвалж болон санал болгож буй цаашид унших материалуудыг дараах сэдвээр жагсаалаа:

1. Үнэлгээ
2. Зах зээлийн дүн шинжилгээ
3. Бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцаа (CVA)
4. Хяналт, үнэлгээ, хариуцлагатай байдал, суралцах амлалт (ХҮХС)
5. Оролцооны аргачлалууд

1. Үнэлгээ

ACAPS (2014) Humanitarian Needs Assessment: The Good Enough Guide, The Assessment Capacities Project (ACAPS), Emergency Capacity Building Project (ECB) and Practical Action Publishing. Rugby, <https://www.acaps.org/humanitarian-needs-assessment-good-enough-guide>

de Jonge, K. and Maarse, L. (2020) Gender and livestock in emergencies: a discussion paper for the Livestock Emergency Guidelines and Standards LEGS, <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/11/LEGS-Discussion-Paper-Gender-and-Livestock.pdf>

Food and Agriculture Organization of the United Nations (FAO) and International Labour Organization (ILO) (2009) The Livelihood Assessment Toolkit: Analysing and Responding to the Impact of Disasters on the Livelihoods of People, 1st edn, FAO and ILO, Rome and Geneva, https://www.fao.org/fileadmin/templates/tc/tce/pdf/LAT_Brochure_LoRes.pdf

Galiè, A., Teufel, N., Korir, L. et al. (2018) 'The women's empowerment in livestock index', Social Indicators Research 142: 799–825, <https://doi.org/10.1007/s11205-018-1934-z>

Hauer, M. and Kelly, C. (2018) Guidelines for Rapid Environmental Impact Assessment in Disasters – Version 5, 2018 [Rapid Environmental Assessment Tool], Coordination of Assessments for Environment in Humanitarian Action Initiative, https://reliefweb.int/sites/reliefweb.int/files/resources/REA_2018_final.pdf

Maxwell, D. and Caldwell, R. (2008) The Coping Strategies Index: Field Methods Manual, 2nd edn, Cooperative for Assistance and Relief Everywhere, Inc. (CARE), https://www.researchgate.net/publication/259999318_The_Coping_Strategies_Index_Field_Methods_Manual_-_Second_Edition

SMART (2017) SMART – Standardised Monitoring and Assessment for Relief and Transitions Manual 2.0, SMART, Action Against Hunger Canada, and the Technical Advisory Group, <https://smartmethodology.org/survey-planning-tools/smart-methodology/>

Sphere (2014) Sphere for assessments, The Sphere Project and ACAPS, Geneva, <https://spherestandards.org/resources/sphere-for-assessments/>

2. Зах зээлийн дүн шинжилгээ

Albu, M. (2010) Emergency Market Mapping and Analysis Toolkit (EMMA), Practical Action Publishing, Rugby, <https://www.emma-toolkit.org/toolkit>



CALP (2018) Minimum Standard for Market Analysis (MISMA), CALP Network, <https://www.calpnetwork.org/publication/minimum-standard-for-market-analysis-misma/>

International Red Cross and Red Crescent Movement (2014) Rapid Assessment for Markets: Guidelines, <https://preparecenter.org/resource/rapid-assessment-for-markets-ifrc-guidelines/>

SEEP (2017) Minimum Economic Recovery Standards, 3rd edn, the SEEP Network, Washington D.C., and Practical Action Publishing, Rugby, <https://seepnetwork.org/Resource-Post/Minimum-Economic-Recovery-Standards-Third-Edition-exist-190>

3. Бэлэн мөнгө, эрхийн бичгийн тусалцаа

The CALP Network website contains many tools and resources on cash and voucher assistance, including the Glossary of Terms and the Programme Quality Toolbox. See <https://www.calpnetwork.org/resources/>

Elluard, C. (2015) Guidance notes: cash transfer in livelihood programming, The CaLP Network and the Livelihoods Centre, <https://www.calpnetwork.org/wp-content/uploads/2020/03/calp-waf-guidance-notes-en-web-1.pdf>

FAO (2011) The use of cash transfers in livestock emergencies and their incorporation into Livestock Emergency Guidelines and Standards (LEGS), Animal Production and Health Working Paper No. 1, FAO, Rome, <https://www.fao.org/3/i2256e/i2256e00.pdf>

Hermon-Duc, S. (2012) MPESA project analysis: exploring the use of cash transfers using cell phones in pastoral areas, Télécoms Sans Frontières and Vétérinaires Sans Frontières, Germany and Nairobi, <https://www.calpnetwork.org/publication/mpesa-project-analysis-exploring-the-use-of-cash-transfers-using-cell-phones-in-pastoral-areas/>

Norwegian Refugee Council (NRC) (2019) Remote Cash Project Guidelines and Toolkit, <https://www.nrc.no/what-we-do/themes-in-the-field/cash-and-vouchers/remote-cash-project-guidelines-and-toolkit/>

4. XYXC

Catley, A., Burns, J., Abebe, D. and Suji, O. (2014) Participatory Impact Assessment: A Design Guide, Feinstein International Center, Tufts University, Somerville, <https://fic.tufts.edu/publication-item/participatory-impact-assessment-a-design-guide/>

Cosgrave J., Buchanan-Smith M. and Warner, A. (2016) Evaluation of Humanitarian Action (EHA) Guide, ALNAP, <https://www.alnap.org/help-library/evaluation-of-humanitarian-action-eha-guide>

CHS Alliance, Group URD and the Sphere Project (2014) Core Humanitarian Standard on Quality and Accountability, 1st edn, <https://corehumanitarianstandard.org/files/files/Core%20Humanitarian%20Standard%20-%20English.pdf>

CHS Alliance, Group URD and the Sphere Project (2015) CHS Guidance Notes and Indicators, <https://corehumanitarianstandard.org/files/files/CHS-Guidance-Notes-and-Indicators.pdf>

Emergency Capacity Building Project (2007) Impact Measurement and Accountability in Emergencies: The Good Enough Guide, Oxfam, <https://policy-practice.oxfam.org/resources/impact-measurement-and-accountability-in-emergencies-the-good-enough-guide-115510/>

FAO (2016) Livestock-related interventions during emergencies – The how-to-do-it manual. Edited by Philippe Ankers, Suzan Bishop, Simon Mack and Klaas Dietze. FAO Animal Production



and Health Manual No. 18. Rome, <https://www.fao.org/3/i5904e/i5904e.pdf> (See Chapter 10: Monitoring, evaluation and impact assessment)

LEGS (2016) LEGS Evaluation Tool, Livestock Emergency Guidelines and Standards, UK, <https://www.livestock-emergency.net/legs-evaluation-tool/>

5. Оролцооны аргачлалууд

Alders, R.G., Ali, S.N., Ameri, A.A., Bagnol, B., Cooper, T.L., Gozali, A., Hidayat, M.M., Rukambile, E., Wong, J.T. and Catley A. (2020) 'Participatory epidemiology: principles, practice, utility, and lessons learnt', *Frontiers in Veterinary Science* 7:532763, <https://doi.org/10.3389/fvets.2020.532763>

Holland, J. (ed.) (2013) *Who Counts? The Power of Participatory Statistics*, Practical Action Publishing, Rugby, <https://practicalactionpublishing.com/book/2385/who-counts>

LEGS (2021) LEGS Participatory Techniques Toolkit, Livestock Emergency Guidelines and Standards (LEGS), https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2022/02/LEGS-Participatory-Techniques-Toolkit_May-2021.pdf

Pretty, J.N., Guijt, I., Thompson, J. and Scoones, I. (1995) *Participatory Learning and Action: A Trainer's Guide*, International Institute for Environment and Development (IIED), London, <https://www.iied.org/6021iied>

UNHCR and CARE (2009) *Framework for Assessing, Monitoring and Evaluating the Environment in Refugee-Related Operations (FRAME Toolkit)*, joint UNHCR and CARE project, <https://www.unhcr.org/uk/protection/environment/4a97d1039/frame-toolkit-framework-assessing-monitoring-evaluating-environment-refugee.html>

See also case studies for planning livestock-based interventions in emergencies at: <https://www.livestock-emergency.net/resources/case-studies/>



LEGS хүрээ

Гамшгийн хариу арга хэмжээний төлөвлөлт

Техникийн стандартууд



Малын тэжээлийн стандарт

1. Бэлэн байдал
2. Үнэлгээ ба төлөвлөлт
3. Тэжээх түвшин
4. Тэжээлийн аюулгүй байдал



Усаар хангах стандарт

1. Бэлэн байдал
2. Үнэлгээ ба төлөвлөлт
3. Уст цэгийн байршил
4. Уст цэг сэргээн засварлах, байгуулах
5. Зөөврийн усны чанар ба эх үүсвэр
6. Зөөврийн усны тээвэрлэлт ба түгээлт



Мал эмнэлгийн тусламжийн стандарт

1. Бэлэн байдал
2. Үнэлгээ ба төлөвлөлт
3. Мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээний загвар
4. Үзлэг болон эмчилгээ
5. Зооноз өвчнүүд
6. Ариун цэвэр, хүнсний эрүүл ахуй
7. Малын сэг зэм устгал
8. Малын өвчний тандалт



Малын байр, байршуулалтын стандарт

1. Бэлэн байдал
2. Үнэлгээ ба төлөвлөлт
3. Малын байр
4. Мал байршуулалт
5. Удаан эдэлгээтэй малын байрны шийдэлд шилжих



Малын тоо толгойг бууруулах стандарт

1. Бэлэн байдал
2. Үнэлгээ ба төлөвлөлт
3. Мал худалдаалж малын тоо толгойг бууруулах
4. Малыг хэрэгцээлж тоо толгойг бууруулах



Малжуулах стандарт

1. Үнэлгээ ба төлөвлөлт
2. Үйл ажиллагааны багцыг тодорхойлох
3. Хүргэлтийн тогтолцоо
4. Хүлээн авагчдад зориулсан нэмэлт дэмжлэг






Бүлэг 4: Малын тэжээлд баримтлах техникийн стандарт

- 136 Танилцуулга
- 139 Тэжээлээр хангах хувилбарууд
- 144 Үйл ажиллагаанууд (тусламж)-ыг хэрэгжүүлэх цаг хугацаа
- 145 LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн түншлэлийн стандартууд (ХТС)-тай холбогдох нь
- 146 LEGS-н зарчмууд болон бусад анхаарах асуудлууд
- 151 Малын тэжээлийн тусламжийн хувилбаруудын шийдвэрийн мод
- 154 Стандартууд
- 164 Хавсралт 4.1: Тэжээлээр хангах үйл ажиллагааны үнэлгээний шалгах асуултууд
- 166 Хавсралт 4.2: Малыг тэжээх үйл ажиллагааны хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн жишээнүүд
- 168 Эх сурвалж ба цаашид унших материал



Бүлэг 4: Малын тэжээлд баримтлах техникийн стандарт





Танилцуулга

Онцгой байдлын төрөл нь тэдгээрийн ноцтой байдлын түвшнээс шалтгаан малын тэжээлийн нөөцөд янз бүрээр нөлөөлдөг. Жишээлбэл, гангийн онцгой байдал хөрсний чийгийн хэмжээг багасгаж, ногооны ургалтыг зогсоож малын бэлчээр, таримал тэжээлийн нөөцийг бууруулдаг. Харин галт уулын үнс, нурам эсвэл үерийн ус малын бэлчээр, тэжээлийн талбайг дарж, бүрхэн малын тэжээлийн нөөцийг сүйрүүлдэг. Хангалттай сайн бэлчээр, тэжээлийн нөөцтэй байлаа ч гэсэн зөрчил мөргөлдөөний улмаас тэдгээрийг ашиглах боломжгүй байдалд хүрэх тохиолдлууд ч гардаг. Малын тэжээлийн хангамжид нөлөөлдөг зарим онцгой байдал нь хэдэн долоо хоног үргэлжилдэг бол зарим нь хэдэн жилээр ч сунжирдаг.

Онцгой байдлын улмаас тэжээлийн хангамж алдагдахад, тухайн нөхцөлд нэрвэгдсэн малыг цаг алдалгүй зохистой хэмжээний, чанартай нэмэлт тэжээлээр хангах шаардлагатай. Ингэснээр малын тарга хүч алдагдахаас сэргийлж, өрхийн хүнсний үйлдвэрлэл хэвийн үргэлжлэхэд хувь нэмэр оруулах боломж бүрдэнэ. Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн тухайд малын сүүний тогтвортой хангамжтай байх нь хүүхдийн хоол тэжээл, эрүүл мэндэд онцгой сайн эерэг үр нөлөөг үзүүлдэг.

Энэ бүлэгт онцгой байдлын үед малын тэжээл ач холбогдолтойг онцолж, тэжээлийн хариу арга хэмжээний хувилбарууд, тэдгээрийн ашиг тус болон тулгарч болох бэрхшээлүүдийг танилцуулах болно. LEGS нь тэжээл үйлдвэрлэлийн асуудлыг шууд авч үздэггүй боловч онцгой байдлын бус үеийн малын тэжээлийн үйлдвэрлэл, тэжээлийн тогтолцооны ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг. Дэлгэрэнгүй мэдээллийг НҮБ-ын ХХААБ-ын гарын авлагын (2016) 'Тэжээлээр хангах' Бүлэг 6-с авах боломжтой. Техникийн хувилбар бүрд LEGS нь стандарт, үндсэн үйл ажиллагаа, зааварчилгаагаар дамжуулан мэдээллийг өгсөн байгаа. Үнэлгээний шалгах хуудас, хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг энэхүү бүлгийн төгсгөлд хавсралтаар оруулсан болно. *Цаашид нэмж унших эх сурвалжийн* жагсаалтыг мөн оруулсан. Кейс судалгаануудыг LEGS-н цахим хуудаснаас (<https://www.livestock-emergency.net/resources/case-studies/>) авах боломжтой.

LEGS-н амьжиргааг дэмжих зорилтуудтай холбогдох байдал

Онцгой байдлын үед малыг хангалттай тэжээлээр хангах нь LEGS-н амьжиргааг дэмжих гурван зорилтыг биелүүлэхэд дараах байдлаар хувь нэмэр оруулдаг:

- Ашиг шим сайтай малыг тэжээх нь өрхийн хүнсний хангамжийг шууд сайжруулахад тусалж, **гамшигт нэрвэгдсэн нутгийн иргэд байгаа мал хөрөнгөө ашиглан шууд ашиг хүртэх** боломжийг олгодог.
- Мал, түүн дотор уналга ачлагын болон бусад ажлын малыг хамруулан тэжээх



нь амьжиргааны үндсэн мал хөрөнгийг хамгаалахад тусалдаг.

- Үржлийн үндсэн малыг тэжээх нь сүргийг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлж амьжиргааны үндсэн мал хөрөнгийг нөхөн сэргээхэд хувь нэмэр болдог.

Онцгой байдлын хариу арга хэмжээнд малын тэжээлийн хангамжийг хангахын ач холбогдол

Хүмүүсийн адил мал нь тэжээл, усгүй бол амьд явахгүй. Ялангуяа ашиг шим сайтай мал тэжээл, усан хангамж нь тасалдахад онцгой эмзэг байдаг (*Бүлэг 5: Усаар хангах*-г харна уу). Тиймээс онцгой байдалд нэрвэгдсэн мал, амьтныг хамгаалахад чиглэгдсэн аливаа арга хэмжээ нь малын хорогдлыг хязгаарлахын тулд наад зах нь тэжээлийн гол нөөцийг хүртээмжтэй байлгахад анхаарах ёстой. Онцгой байдлын улмаас малын тэжээлийн нөөцийн хүртээмж багасахад тэжээлээр хангах зайлшгүй шаардлага бий болдог. Онцгой байдлын үеийн их хэмжээний малын хорогдол нь малын өвчлөлөөр бүс өлсгөлөнд нэрвэгдсэний үр дагавар юм. Иймээс тэжээлийн хангамжийг ган гачигт нэрвэгдсэн бүс нутагт болон галт уулын дэлбэрэлт, томоохон үер, мөргөлдөөний тохиолдлуудад онцгой анхаарах шаардлагатай. Хар салхи, газар хөдлөлт, үер, зөрчил мөргөлдөөнөөс үүдэн тэжээлийн хангамж тасалдах, нөөцийн агуулахууд эвдэрч сүйдэх гэх мэт шалтгаанаар малын нэмэлт тэжээлийн хүртээмж алдагдаж болдог. Иймэрхүү онцгой байдлын дараа малын ашиг шимийг урт хугацаанд хадгалахын тулд ханган нийлүүлэлтийн сүлжээг дахин бий болгох, тэжээлийн агуулах, захуудыг дахин барих шаардлага гарч болзошгүй. (Нигерт гангийн бэлэн байдлыг хангах малын тэжээлийн банк бий болгосон тухай жишээ кейсийг харна уу. Энэ жишээнд онцгой байдлын дараа үргэлжлүүлэх боломжтой мал тэжээх үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийсэн тухай дурдсан).

Зарим хүмүүнлэгийн байгууллагууд онцгой байдлын үеэр малд тэжээл хүргэх нь хүний амь нас авран хамгаалахад сөрөг нөлөө үзүүлнэ гэж үздэг. Энэ нь ялангуяа тээврийн нөөц хомс үед хүн амд зориулсан хүнсний тусламж болон бусад чухал бүтээгдэхүүний хүргэлт тасалдах магадлалтай учраас гэдэг. Гэсэн хэдий ч малтай иргэд малын тэжээл тэдэнд чухал гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Дэлхий даяар малтай иргэд хүнсний тусламжийг малтайгаа хуваалцах нь түгээмэл тохиолддог бөгөөд зарим нь үндсэн мал хөрөнгөө хамгаалах зорилгоор хүнсний тусламжаасаа орон нутгийн зах зээлд зарж малын тэжээл худалдан авдаг.

Онцгой байдлын үед ялангуяа олон жил үргэлжилсэн гангийн нөхцөлтэй тулгарсан тохиолдолд малын тэжээлийг хангахтай холбоотой зардал их гардаг. Иймд тэжээлийн хангамжийг эхлүүлэхээс өмнө зардлыг сайтар үнэлэх хэрэгтэй. Гэсэн хэдий ч зардлын асуудлыг альтернатив шийдлүүдийн хүрээнд авч үзэх ёстой, магадгүй зардал-үр ашгийн шинжилгээний энгийн хэрэгсэл ашиглаж болно. Энэ нь урт хугацааны хүнсний тусламж эсвэл



малжуулах гэх мэт хувилбаруудтай харьцуулахад малын тэжээлийн арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтойг батлахад тусална.

Сүү болон бусад төрлийн хүмүүнлэгийн тусламж авах боломжгүй болсон бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн хүүхдүүдийн хоол тэжээлийн тусламжийн өртгийг малжуулах үйл ажиллагааны өртөг зардалтай харьцуулж болно. Жишээ нь, бэлчээр мал аж ахуйн үйлдвэрлэлтэй Зүүн-өмнөд Этиоп болон Зүүн-хойд Кенид хоёр улирал дараалан бороо ороогүйн улмаас үүссэн ган гачгийн үр өгөөжийн судалгаагаар бог малтай айлуудын үндсэн сүргийг дахин бүрдүүлэхэд ижил тооны малд тэжээлийн тусламж үзүүлж хамгаалахаас 3-6 дахин илүү зардалтай байсныг тогтоосон байдаг.

Онцгой байдлын үед малыг цаг алдалгүй тэжээлээр хангах нь мал, амьтан хангалттай хэмжээний, шимт бодисын зохистой харьцаатай, олон нэр төрлийн, чанартай сайн тэжээл, цэвэр усаар хангагдах нөхцөлийг багтаасан хүчин зүйлсийг хамрах "тэжээллэг" гэж нэрлэх мал, амьтны тавлаг байдлын таван хүрээний хамгийн эхнийхэд хувь нэмэр оруулна. Энэ талаар *Бүлэг 1: LEGS-н танилцуулга*-д дурдсан. (Этиоп улсад үхрийг нэмэгдэл тэжээлийн үр нөлөөг судалсан мөн үзнэ үү. Энэхүү кейс судалгаагаар нэмэгдэл тэжээлээр хангагдсан үхэр сүрэгт хорогдлын түвшин эрс буурдгийг тогтоожээ)

Өвс тэжээл болон бусад тэжээлийн нөөц хангалтгүй эсвэл байхгүй болсон үед цөм сүргийг цаг алдалгүй тэжээлээр хангаснаар малчдын өөрсдийнх нь авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээн дээр жинтэй, чухал дэмжлэг болно. Жишээ нь, ган гачиг нүүрлэсэн үед малыг замын хажуугийн нарийн жалга хэсгээр бэлчээх нь бий (замын хажуу жалга нь замаас урссан борооны усыг тосож авснаар илүү их чийг хуримтлуулж, ногооны гарцыг сайжруулахад нөлөөлж байдаг). Үүний нэгэн адил үер болсон үед малыг замын хажуугийн уснаас хамгаалах далан дагуу (энэ нь газраас өргөгдсөн байдаг учраас үерийн ус тогтдоггүй) бэлчээдэг байна. Онцгой байдлын үеэр мал сүргийг уул эсвэл голын ай сав бүхий газар луу нүүлгэж болдог. Түүнчлэн малчид тухайн орон нутгийн хүнсний үйлдвэрүүдээс хөдөө аж ахуйн дайвар бүтээгдэхүүн худалдан авч малдаа тэжээл болгон өгч болно.

Энэ бүх арга хэмжээг авсан ч гэсэн малчид онцгой байдлын үед алдсан өвс тэжээлээ бүрэн нөхөж авах боломжгүй байх нь бий. Энэ тохиолдолд малын нэмэлт тэжээл шаардлагатай болдог. Үүнд нөөшилсөн малын тэжээл тухайлбал бухал өвс, үр тарианы шавхраг, баяжуулсан тэжээл, олон төрлийн амин дэмтэй шахмал (multi-nutrient blocks-MNB) эсвэл гар аргаар хийсэн зуун настын ургамлын холимог гэх мэт орж болно. (Үйл ажиллагааны жишээ: Зэрлэг ургамлаар малаа тэжээсэн Суданы туршлагаас харна уу) Үүнээс гадна эвдэрч сүйдсэн малын тэжээлийн агуулахыг дахин барих ажилд туслалцаа шаардагддаг. Ялангуяа галт уулын дэлбэрэлтийн улмаас малын тэжээл нь үнсэнд дарагдаж үгүй болсон газруудад энэ маш чухал. Мөн малын тэжээлээр хангахад үндсэн үүрэг гүйцэтгэдэг зах худалдааны газрууд үүнийг онцгой анхаарах хэрэгтэй байдаг.



Тэжээлээр хангах хувилбарууд

Онцгой байдлын үед мал амьтныг тэжээлээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ тээврийн зардлыг тооцох нь чухал. Жирийн сорго, шар будаа, чихрийн нишингэ эсвэл боодолтой өвс зэрэг сул савлагаатай тэжээлийг тээвэрлэх зардал өндөр байдаг. Ялангуяа хол замд үхэр, тэмээ, адуу тэжээхээр (бод малын өдрийн идэх тэжээлийн хэмжээ нь харьцангуй их) их хэмжээгээр тээвэрлэхэд зардал өндөр гардаг. Мөн шим тэжээл бага, чанар муутай тэжээлээр хангавал үйл ажиллагааны үр нөлөө тааруу гарна.

Тэжээлийг онцгой байдлын үед хариу арга хэмжээний үйл ажиллагаа болгон хэрэглэх гэж байгааг мэдвэл нийлүүлэгчид үнээ өсгөх магадлалтай байдаг. Мөнгөө оновчтой зарцуулахын тулд шим тэжээлийн агууламж өндөртэй, гэрээр бэлдсэн холимог тэжээл эсвэл олон төрлийн амин дэмтэй шахмал тэжээлүүдийг хэрэглэвэл зохимжтой. Олон төрлийн амин дэмтэй шахмал (MNBs) болон хорголжин тэжээл нь нунтаг тэжээлийг бодвол хийсээд явчихгүй эсвэл малд хаяж өгөхөд шороотой холилдоод алга болдоггүй зэрэг давуу талтай байдаг.

Аль түвшний, ямар төрлийн тусламжаар хангах нь гамшигт нэрвэгдсэн хүн амын амьжиргаанд мал амьтан ямар үүрэг гүйцэтгэдгээс хамаарна. Жишээ нь цөөн тооны жижиг фермерүүд, эсвэл хотын захаар амьдардаг өрхүүдэд бол хэрэгжүүлэгч агентлагаас бүх мал амьтдыг нь тэжээчих хангалттай нөөцөөр хангаж чадна. Учир нь энэ бүлэгт ганц хоёр саалийн үнээ, газар хагалахад хэрэглэдэг ажлын үхэр, арваад хонь ямаатай өрхүүд голчлон багтдаг. Энэ тусламж нь тэднийг үргэлжлүүлэн цөөн малаараа ойр зуурын амьжиргаандаа дэм хийж явах боломжоор нь хангадаг.

Харин олон жилийн ганд нэрвэгдсэн бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг иргэдэд тэжээлийн хангамж хүргэнэ гэдэг нэг биш хэд хэдэн агентлагууд нийлээд хийхэд ч санхүү болоод тээвэр зохицуулалтын чадавхын хувьд амаргүй ажил. Энэ тохиолдолд малчдын хувьд цөөн тооны цөм үржлийн сүргээ сонгох нь оновчтой бөгөөд ингэснээр цаашид мал сүргээ сэргээн босгох боломж бүрдэнэ.

Хэрэв цөөн тооны үржлийн цөм малаа сонгож тэжээхээр шийдсэн бол тэжээлээр хангах хариу арга хэмжээг мал борлуулах үйл ажиллагаатай холбон үлдсэн малаа (угаасаа онцгой байдлын тэжээлийн нөөц хүрэхгүй учраас) зарж борлуулах нь зүйтэй. Ийнхүү малаа арилжаалан борлуулснаар бэлэн мөнгөтэй болж тэжээлээр хангах үйл ажиллагааны зардлыг бууруулна. Харин малаа хэрэгцээндээ нядалбал хүнсний тусламжаас хамааралтай өрхүүдийг махны чухал эх үүсвэрээр хангаж, шим тэжээлтэй хүнсэнд зарцуулах зардал буурч, хэрэгцээнд мал нядалж борлуулах зардал



ч тэнцвэржинэ (*Бүлэг 8: Малын тоо толгойг бууруулах* хэсгийг харна уу). Малын тоог багасгаснаар тэжээлийн нөөц нь төлөвлөснөөс олон малд хуваагдан хаанаа ч хүрэхгүй байх эрсдэлээс сэргийлнэ.

Хэдий сайн төлөвлөж, тэвэрээ зохицуулаад, малаа цөөлсөн ч онцгой байдлын үед тэжээлээр хангах нь зардал бас ажиллагаа ихтэй байдаг. Тиймээс энэ үйл ажиллагааны зорилтыг гамшигт нэрвэгдсэн малчидтай зөвшилцөн, хамтран төлөвлөх нь чухал. Үйл ажиллагааны зорилт нь малын тарга тэвээргийн алдагдлыг бууруулах, тарга тэвээргийг нь хадгалах, тарга тэвээргийн алдагдлыг нөхөх эсвэл малын ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх байж болно.

Мөн үйл ажиллагааг эхлэхдээ л хэзээ дуусгаа тодорхой төлөвлөсөн байх нь чухал. Ингэснээр сунжирч зардал өсөх болон буруу үед ажиллагааг зогсоох зэрэг эрсдэлүүдээс сэргийлэх боломжтой.

Ихэнх тэжээлээр хангах үйл ажиллагааг хивэгч мал амьтанд хэрэгжүүлдэг; үйл ажиллагаатай холбоотой ашиг тус болон тулгардаг бэрхшээлүүдийг *хүснэгт 4.1-т* нэгтгэв.

Хүснэгт 4.1: Тэжээлээр хангах үйл ажиллагааны ерөнхий ашиг тус болон сорилт бэрхшээлүүд

Ашиг тус	Сорилт бэрхшээлүүд
Голлох мал хөрөнгө хамгаалагддаг	Онцгой байдлын үед тэжээлийн нөөц татах нь амаргүй
Хол оторт явж маргаан зөрчилдөөн үүсэх нь багасдаг	Онцгой байдлын үед тэжээлийн үнэ болон тээврийн зардлын үнэ хөөрөгдөх магадлалтай байдаг
Хамгаалагдсан мал амьтнаас сүү/өндөг авах эсвэл газар хагалах/уналгад ашиглах зэргээр онцгой байдлын үед орлогын үүсвэр болдог.	Онцгой байдлын үед мал амьтныг тэжээлээр хангах нь үнэтэй бас тогтвортой бус байдаг.
Мал амьтныг хамгаалснаар мал сүргээ сэргээн босгож, амьжиргаагаа ч хамгаалдаг	Онцгой байдлын үед тэжээлээр давтамжтай хангах нь орон нутгийн малын тоог хиймлээр өсгөдөг
Онцгой байдлын үед хот айлаараа мал маллах нь айл гэрүүдийг ойртуулж, нэгнээ дэмжиж, хэцүү үеийг давахад тусалдаг.	Малын тоо өссөнөөр хомс байгаа усны нөөцийг улам барагдуулдаг.



Ашиг тус	Сорилт бэрхшээлүүд
	Онцгой байдлын улмаас тэжээл хадгалах байр болон тээвэрлэх тогтолцоонд хязгаарлагдмал байдал үүсдэг Өөр өөр тэжээл нөөцөөс тээвэрлэлт хийх нь олон төрлийн ургамлын хорхой шавьж болон өвчин тархаах магадлалтай. Гаднаас тэжээл тээвэрлэн авчрах нь орон нутгийн дотоод зах зээлийг хямраадаг; жишээлбэл худалдан авч байгаа газарт үнийг өсгөж, хомсдол үүсгэдэг.

Онцгой байдлын үед мал амьтныг өвс тэжээлээр хангах үндсэн хоёр техникийн хувилбарууд байдаг нь: 'суурин' болон 'тэжээлийн бааз'. Хоёр хувилбарын алийг нь ч хэрэгжүүлж болох ч эхлээд ямар төрлийн мал амьтан, хэдэн тоо толгойг хамруулах гэдгээ урьдчилан тохирох хэрэгтэй. Малчид (эмэгтэй эрэгтэй хоёулаа) өөрсдөө аль малаа үндсэн үржлийн мал болгон хамгаалах вэ гэдгээ шийдэх хэрэгтэй. *(Үйл ажиллагааны жишээ судалгаа: Этиопт эмэгтэйчүүд цөм сүргийг тэжээлээр хангах хөтөлбөрийг зохицуулан ажилласан жишээг харна уу.* Энэ жишээ судалгаанд суурин тэжээлийн баазад эмэгтэйчүүдийг багахан цалинжуулан ажиллуулснаар тэднийг онцгой байдлын хариу арга хэмжээнд оролцох оролцоог дэмжсэн тухай гардаг)

Хувилбар 1: Онцгой байдлын үед суурин (малын хотонд) тэжээх

Энэ хувилбарын хүрээнд тэжээлийн нөөцийг худалдаж аваад, тээвэрлээд, хадгалаад, үр шим хүртэгч өрхүүдэд түгээдэг. Тэжээл нь орон нутгийн төрийн байгууллага, хөдөө аж ахуй хоршоо, эсвэл зах худалдааны төв зэрэг төвийн түгээлтийн цэгээс ирдэг. Өөрөөр мөн өрх бүрд хөлсийг нь төлсөн хоёр дахь дамжлага болох жижиг ачааны машин, трактор, эсвэл хөсөг тэргээр ч тээвэрлэгдэн хүрч болдог.

Үүнээс гадна агентлагууд суурин тэжээх үйл ажиллагааг бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцаа (CVA)-аар дамжуулан үзүүлдэг. Малчдыг малдаа тэжээл худалдан авахад нь зориулж бэлэн мөнгө эсвэл эрхийн бичгээр хангадаг. Энэ тогтолцоо нь зах зээл нь хэвийн бөгөөд энэ аргыг дэмжих тохиолдолд ашиглагдах боломжтой. Хүн амын хөдөлгөөнд хэвийн оролцох болон худалдаж авсан тэжээлийг тээвэрлэх нөхцөл хангагдсан байх ёстой. Бэлэн мөнгийг ямар нэг нөхцөлгүйгээр олгож болох ч түүнийг юунд зориулан олгож байгааг малчдад мэдэгдэх нь зүйтэй, ингэснээр малчид



малынхаа төрөлд тохируулан тэжээлээ худалдаж авах боломжтой болно. Харин бараа худалдан авах эрхийн бичиг нь тэжээл худалдан авах газар болон тэжээлийн төрлийг заасан хязгаарлалттай байдаг.

Хүснэгт 4.2-т онцгой байдлын үед мал амьтныг суурин тэжээх үйл ажиллагааны ашиг тус болон сорилт бэрхшээлүүдийг харуулсан.

Хувилбар 2: Онцгой байдлын үед тэжээлийн баазад тэжээх

Энэ техникийн хувилбарт онцгой байдлын хоёр төрлийн тэжээх баазын сонголттой:

Дэд хувилбар 2.1: Тэжээлийн баазад оруулж-гаргаж тэжээх тогтолцоо нь малчдыг тохиролцсон тооны малаа (жишээ нь 2 саалийн үнээ, 5 хонь/ямаа эсвэл нэг тэмээ) өдөрт нэг эсвэл өнжөөд нэг авчирч, төлөвлөсөн хуваарийн түвшинд тэжээх үйл ажиллагаа юм (*Стандарт 3: тэжээх түвшин* харна уу).

Ихэвчлэн сонгосон малд тэмдэг тавьж (будаж түрхэх, чихэнд нь дугаар зүүх гэх мэт) нэг малаа хуваарьтай тэжээж байгаа гэдгээ хянадаг. Малчдыг сонгогдоогүй, өөр мал авчрахыг зөвшөөрдөггүй, учир нь ингэж малын тэжээлийн хуваарийг тасалдуулах нь тэжээлийн үр дүнг бууруулж, тэжээж буй малын амьд үлдэх боломжийг ч багасгадаг.

Дэд хувилбар 2.2: Тэжээлийн баазад байршуулан тэжээх тогтолцоо нь тохиролцсон тооны малыг тэжээх бааз дээр авчирч байршуулан тэжээдэг үйл ажиллагаа юм. Онцгой байдлын үе дуусахад малыг буцааж эздэд нь хариуцуулан өгдөг.

Тэжээх баазад ирж байгаа малд тэмдэглэгээ хийж оруулдаг бөгөөд услахаар гаргах үед (хэрэв тэжээлийн баазад ус байхгүй бол) бусад малтай холилдож андуурагдахгүй.

Хүснэгт 4.2-т тэжээлийн баазын ашиг тус болон тулгардаг саад бэрхшээлүүд, хоёр дэд хувилбар үйл ажиллагааны ялгарах ашиг тус болон бэрхшээл сорилтыг ч мөн оруулсан.



Хүснэгт 4.2: Тэжээлээр хангах хувилбарын ашиг тус болон сорилт бэрхшээлүүд

Ашиг тус	Сорилт бэрхшээл
Онцгой байдлын үед суурин тэжээх	
Малчид өөрсдөө малаа хариуцан зохицуулна Малаа өдрийн цагаар бэлчээрт идээшлүүлээд оройн цагаар ноогдол тэжээлийг нь өгч болно Малаас гарах бүтээгдэхүүн, хийлгэх ажил нь айл өрхөд тустай Баазад байршуулан маллах болон тээвэрлэлттэй холбоотой асуудлуудаас зайлсхийнэ.	Тээвэрлэлт болон хүргэлтийн явцад тэжээлийн хорогдол гарах Гэрт хүргэх явцад нэмэлт зардал, тээвэрлэлтийн асуудлууд үүсдэг (хэдийгээр гамшигт нэрвэгдсэн хүн амаас зардал нь гарч байгаа ч) Нэрвэгдсэн хүн ам тэжээлийг өөр нэмэлт малд болон айл хөршдөө өгөх зэргээр нөөцийг хуваах Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд бэрхшээлтэй байдаг Тэжээлийн хэрэглээ болон түүнээс үүдэн малын биед гарч байгаа өөрчлөлтийг хянахад нэлээд төвөгтэй
Онцгой байдлын үед тэжээлийн баазад тэжээх	
Малчид хамгаалах үндсэн малаа сонгох шаардлагатай Байгаа тэжээлийг ноогдлын дагуу зохистой хэрэглэдэг Мал болон хүн амын аюулгүй байдал хангагдсан Мал эмнэлгийн сайжруулсан үйлчилгээгээр хангадаг Харуул болон асаргааны ажил хийж орлого олох боломжтой Тэжээлийн хэрэглээ болон малын биед гарч буй сайжралтыг хянахад хялбар	Шаардлага ихтэй (суурин тэжээх хувилбартай харьцуулахад) – малын эрүүл мэндийн үйлчилгээ болон мэргэжилтэн, тэвш/тэжээгч, хангалттай ус, хашаа, хамгаалалттай тэжээлийн байр сав Хамгаалалтаар хангах шаардлагатай Гол хариуцагч ажилчдын зардал нэмэгдэнэ– тэжээлийн баазын менежер, бусад техникийн болон зохицуулах ажилчид, харуул хамгаалалтын ажилчид Удирдлагатай холбоотой асуудлууд– орон нутгийн удирдлагын хүлээлтэд нийцүүлэх байх г.м Тэжээлийн баазад байхдаа хорогдсон малд нөхөн төлбөр олгоно

Дараагийн хуудсанд үргэлжилнэ



Ашиг тус	Сорилт бэрхшээл
Дэд хувилбар 2.1: Тэжээлийн баазад оруулж-гаргаж тэжээх тогтолцоо	
Шөнийн цагийн харуул хамгаалалтад төлөх зардал буурна Малчид өөрсдөө малаа услах ажлаа хариуцна Түгжрэл үүсэхээс сэргийлэх мөн малын өвчин тархахаас сэргийлэхийн тулд хуваарилан тэжээж болно	Мал нь тэжээх бааз руу туугдаад очиж чадах хэмжээний эрүүл байх хэрэгтэй Тэжээх бааз руу аваачих болон буцаж авчрахад маллагаа их шаарддаг
Дэд хувилбар 2.2: Тэжээлийн баазад байршуулан тэжээх тогтолцоо	
Малчид өөрсдөө тэжээлийн нөөцөө хуваарилах, тарааж хэрэглэх боломж байхгүй Малыг тусгаарласан учраас өвчин тархах эрсдэл бага	Малыг хамгаалах, услах, тэжээх, хашаалахад зохион байгуулалттай ажиллах хүч шаардлагатай Онцгой байдлын хугацаанд өдөр бүр зохион байгуулалттай ажиллах хүчин хэрэгтэй

Үйл ажиллагаанууд (тусламж)-ыг хэрэгжүүлэх цаг хугацаа

Хэрэгжүүлэх зардлыг нь тооцохдоо хэрэв тэжээлээр хангах үйл ажиллагааг богино хугацаанд хэрэгжүүлбэл үр ашиг ба зардлын харьцаа өндөр гарах нь бий. Жишээлбэл үерийн аюулын дараа богино хугацааны дотор нөхцөл байдал намжих хүртэл 'холбох гүүр' байдлаар тэжээх үйл ажиллагаа явуулж болдог, мөн ган гачигт нэрвэгдсэн мал амьтдыг бороо орж газар чийглэн ногоо ургатал тэжээлээр хангадаг.

Заримдаа хур тунадасны хэмжээ бага, маш ноцтой гангийн үед, эсвэл удаан үргэлжилсэн хавсарсан онцгой байдлын үед тэжээлээр хангах үйл ажиллагааг жил, түүнээс ч урт хугацаагаар сунгаж явуулах хэрэг гардаг. Энэ үйл ажиллагаанд зарцуулах зардал нь цөөн тооны цөм үржлийн малаар хязгаарлагддаг бөгөөд нутгийн малын үүлдрийг хамгаалах ч малчдын амьжиргааг хамгаалахад тийм ч их дэмжлэг болж чаддаггүй.

Хүснэгт 4.3-т өөр явцтай онцгой байдлуудын үед тэжээлээр хангах үйл ажиллагааг явуулах боломжит цаг хугацааны хуваарилалтыг харуулсан. Онцгой байдлын бус, энгийн үед агентлагууд болон малчид хадлан тэжээл бэлтгэх ажилд хөрөнгө хаяж, тэжээлийн хэрэглээнд анхаарал хандуулах



хэрэгтэй бөгөөд үүнд бэлчээрийн менежмент зэрэг орон нутагт шалгарсан аргуудаас ашиглах нь үр дүнтэй. Үйл ажиллагааны жишээ судалгаа: Этиоп-д бэлэн байдлыг хангахын тулд бэлчээрийг дахин сэргээж үржлийн цөм сүргийг хамгаалсан жишээ: Доройтсон бэлчээрийн газраа хашиж усалгааг нь шийдэн орон нутагт тохиромжтой ургамлын үр тариалж, хадлангаа айл хотлоороо хуваан хэрэглэсэн түүхийг харуулсан.

Хүснэгт 4.3: Тэжээлээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжит цаг хугацаа

Хувилбарууд	Гэнэтийн гамшиг		
	Гэнэтийн хор хохирол	Эрт үеийн нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлт
1. Суурин	✓	✓	—
2. Тэжээлийн бааз	✓	✓	—

Хувилбарууд	Удаан явцтай гамшиг			
	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
1. Суурин	—	✓	✓	—
2. Тэжээлийн бааз	—	✓	✓	—

4

LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн түншлэлийн стандартууд (ХТС)-тай холбогдох нь

Тэжээлээр хангах болон малын тоо толгойг бууруулах үйл ажиллагааг холбохын ач холбогдлыг (*Бүлэг 8: Малын тоо толгойг бууруулах; болон Үйл ажиллагааны жишээ судалгаа*: Нигерт тэжээлээр хангах болон малын тоо толгойг бууруулах үйл ажиллагааг хослуулан хэрэгжүүлсэн жишээ) энэ хэсэгт харуулсан. Малын тоо толгойг бууруулах үйл ажиллагааны дэмжлэгээр илүүдэл малын тоог бууруулж, цөөн тооны цөм үржлийн малынхаа амьд үлдэх боломжийг хангадаг.

Хүмүүсийн мал хөрөнгийг хадгалж үлдэх нь амьжиргааг сэргээх суурь үндэс болох бөгөөд урт хугацаанд хүнсний баталгаат байдлыг хангаж, шим тэжээлийн хангамжийг сайжруулахад хувь нэмэр оруулдаг. Энэ нь



эргээд тэдний шим тэжээлийн дутагдалд ороход хүргэдэг шалтгаануудыг хянаж зохицуулах чадамжийг нэмэгдүүлдэг. Мөн хамгаалагдсан үржлийн цөм сүрэгт мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх (*Бүлэг 6: Мал эмнэлгийн тусламж-г харна уу*) болон усаар хангах (*Бүлэг 5: Усаар хангах-г харна уу*) шаардлагатай. Эдгээр үйл ажиллагаанууд нэг нэгнээ дэмжин хэрэгжиж байдаг тул хоорондын уялдаа холбоог хангах нь нэн чухал юм.

LEGS-н зарчмууд болон бусад анхаарах асуудлууд

Хүснэгт 4.4: LEGS-н зарчмуудын малыг тэжээлээр хангах үйл ажиллагаатай холбогдох байдал

LEGS-н Зарчмууд	LEGS –н зарчмууд малыг тэжээлээр хангах үйл ажиллагаануудтай хэрхэн холбогдож буй жишээнүүд
1. Амьжиргаанд суурилсан хөтөлбөрүүдийг дэмжих	Мал амьтныг тэжээлээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэн наанадаж малын жинг барьж байх хэмжээний тэжээлээр хангаснаар мал амьтнаас амьжиргаа нь хамааралтай өрхүүдийн амьжиргааг хамгаалдаг. Тэжээл нь үржлийн цөм сүрэг зэрэг гол мал хөрөнгийг сонгон амьжиргааг урт хугацаанд баталгаажуулахыг зорьж ажилладаг. Тэжээлээр дамжуулан мал амьтны бүтээгдэхүүний гарцыг дэмжвэл, айл өрх болон хүн амын шим тэжээлийн хэрэгцээ тасалдахгүй байх боломж бүрддэг. Тэжээлээр хангах үйл ажиллагаа нь мөн тээвэрлэгчид, нэмэлт тэжээл нийлүүлэгчид, болон тэжээлийн баазад ажиллагсад (асрагч, харуулууд, г.м.) зэрэг хэрэгжилтэд оролцогчдын амьжиргаанд ч мөн нэмэлт дэмжлэг болдог.
2. Олон нийтийн оролцоог хангах	Олон нийтийн оролцоо нь хамрагдах өрхүүд болон мал амьтныг тохирсон тэжээлээр хангах үйл ажиллагааг сонгоход амин чухал. Олон нийтийн тасралтгүй оролцоо нь олгогдсон тэжээлийн нөөц нь зохистой, тэгш хэрэглэгдэж байгааг бататгахад тустай байдаг. Тэжээлийн баазыг амжилттай ажиллуулахад мөн олон нийтийн оролцоо зайлшгүй хэрэгтэй байдаг.

Дараагийн хуудсанд үргэлжилнэ



LEGS-н Зарчмууд	LEGS –н зарчмууд малыг тэжээлээр хангах үйл ажиллагаануудтай хэрхэн холбогдож буй жишээнүүд
3. Уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчноо хамгаалахтай холбогдуулах нь	Тэжээлээр хангах үйл ажиллагаа нь орон нутгийн малын үүлдрийг дэмжихийг нэн тэргүүнд тавих ёстой. Тэжээх явц нь усаар хангах үйл ажиллагаатай уялдаж хэрэгжсэнээр мал амьтны хэт төвлөрлөөс сэргийлж чадна. Мөн боломжтой бол суурин тэжээх хувилбарын хэрэгжилттэй хавсран явах нь зүйтэй. Тэжээлийн баазыг байгуулахдаа байгаль орчны нөлөөг бодолцож үзэх хэрэгтэй. Тэжээлийн хангамжийг тээвэрлэж байхдаа бусад газарт ургамлын хорхой шавж, өвчин тараахаас сэргийлж, анхаарах нь чухал. Жижиг тариаланчид малын бэлчээрт үлдэсэн эсвэл тэжээлийн баазад үлдсэн бууцыг ашиглах боломжтой.
4. Бэлэн байдал болон эрт үеийн арга хэмжээг дэмжих	Үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг хангахад тэжээлийн нөөцийг цаг тухайд нь худалдан авах, тээвэрлэх болон тогтсон цэгт байршуулах нь чухал нөлөөтэй. Онцгой байдлын бус үед хадлан тэжээл бэлдэх болон усалгаатай тэжээлийн тариалалтыг дэмжсэнээр даван туулах чадамжийг бэхжүүлж, бэлэн байдлыг сайжруулдаг. Олон нийтийн хувьд эрт сэрэмжлүүлэх тогтолцоо болон шаардлагатай үед бүрэн ашиглаж болох гэнэтийн үйл ажиллагааны сангаас мөн үр шим хүртэж болно. Эрт үеийн арга хэмжээ нь онцгой байдлын үед мал амьтанд ирэх ачааллыг бууруулж, эрүүл мэндийг нь дэмждэг.
5. Хариу арга хэмжээнүүдийн зохицуулалтыг хангах	Бүх үйл ажиллагаа нь боломжтой бүх нөөцийг үр дүнтэй ашигласан байхаар тохируулан зохицуулагдах хэрэгтэй бөгөөд хүмүүнлэгийн тусламжтай мөн уялдаж явах учиртай. Малын тоо толгойг бууруулах, мал эмнэлгийн үйлчилгээ болон усаар хангах үйл ажиллагаануудыг нэгнээ дэмжих байдлаар зохицуулснаар бүх техникийн үйл ажиллагаануудын үр дүн нэмэгдэнэ.

Дараагийн хуудсанд үргэлжилнэ



LEGS -н Зарчмууд	LEGS –н зарчмууд малыг тэжээлээр хангах үйл ажиллагаануудтай хэрхэн холбогдож буй жишээнүүд
6. Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрүүдийг дэмжих	Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд болон залуус үйл ажиллагааны үе шат бүрд (боловсруулах, хэрэгжүүлэх, болон хяналт үнэлгээ хариуцлага, суралцах (ХҮХС)) бүрэн оролцох хэрэгтэй. Энэ нь тохирох малын төрлийг болон хамрагдах өрхийн тоог гаргахад хүйсийн ялгаварлал үүсэхээс сэргийлнэ. Ялангуяа өрх толгойлсон эмэгтэйчүүд/хүүхэд-ийг орхигдуулахгүй байхад онцгой анхаарах нь чухал.
7. Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих	Тэжээлээр хангах үйл ажиллагааг аль болох орон нутгаас хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох хэрэгтэй. Үүнд орон нутгийн тэжээл үйлдвэрлэл, тээвэрлэгчид, агуулах эзэмшигчид болон тэжээлийн цэгт ажиллах нутгийн хүмүүс зэрэг орно.
8. Хяналт, үнэлгээ, хариуцлагатай байдал, суралцах (ХҮХС)-г баримтлах	Малын тэжээлийн хангамжийг давтамжтайгаар хянах нь зардлын үр дүн болон хангамжийн чанар, түгээлтийн тогтолцооны үр дүнтэй байдал болон сонгогдсон мал амьтанд хэмжээ/шим тэжээлийн хувьд зохих түвшний тэжээл очиж байгааг мэдэхэд тусалдаг. Мал амьтныг тэжээлээр хангах үйл ажиллагааг бусад үйл ажиллагаатай харьцуулан үр ашиг-зардлын дүн шинжилгээ хийх нь чухал. Хариуцлагыг сурталчлан таниулах болон үйл ажиллагаанаас гарсан эерэг, сөрөг үр дүнгүүдийг хуваалцах, үүнээс суралцах зайлшгүй шаардлагатай.

Эрсдэлд байгаа бүлгүүдийг товлох

Өмнөд Африкт хийсэн судалгаагаар гангийн онцгой байдал үүссэн үед ядуу малчид нь чинээлэг малчдаас илүү их мал алддаг (нийт малынхаа тоонд харьцуулахад) мөн малаа хамгаалахын тулд мал бүрд зарцуулдаг дундаж зардал нь өндөр байдаг болохыг баталсан. Тиймээс амьжиргааны түвшин доогуур малчдын (өрхөд оногдох малын тоо цөөтэй) малд хангалттай нөөц тэжээл өгөхөд анхааран ажиллах хэрэгтэй бөгөөд энэ нь онцгой байдлын үед тэжээлээр хангах үйл ажиллагааны зохистой төлөвлөлт болон зохицуулалтаар бүрэн хийгдэх боломжтой юм.

Харин ийм хяналт тавьж чадаагүй тохиолдолд тэжээлийн нөөц нь чинээлэг, нөлөө бүхий бүлэгт хэрэгцээнээс нь ч илүү хэмжээгээр хуваарилагдах магадлалтай байдаг. Хэдийгээр эдгээр өрхүүд ч мөн эрсдэлд байгаа боловч тэдний хувьд малаа хамгаалах, тэжээлийн нөөцийг өөрсдөө татаад авах чадавхтай. Мөн хяналт сул байснаас малчин биш хүмүүс тээвэрлэгдэн ирж буй тэжээлийг замаас нь урвуулан зорилтот бус малчдад зарж борлуулах үйлдэл ч гарч болзошгүй.



Орон нутгийн чадавх болон даван туулах стратегийг дэмжих

Онцгой байдалтай тулсан малчдын хувьд өөрсдийн мэдлэг, ур чадвар болон чадавхад тулгуурлан хариу үйлдэл үзүүлдэг. Улирлаас үүдэлтэй үер болох магадлалтай үед жижиг фермерүүд малаа нам дор газраас өндөрлөг рүү нүүлгэдэг. Мөн цагаа олсон, тодорхой албан ёсны түгшүүрийн дохиог илгээвэл илүү олон ч мал амьтныг аварч хамгаалах боломжтой. Ийм түгшүүрийн дохио өгөөгүй үед ус үерийн далангаас даван орж ирвэл зөвхөн үр тариаг сүйтгээд ч зогсохгүй мал амьтан болон холбогдох дэд бүтцэд ч бас хохирол учруулдаг.

Гангийн үед ч мөн адил малчид малаа туун хамгаалагдсан нөөц бэлчээрийг зорьдог. Хэрэв энэ нь бүтэлгүйтвэл малаа цааш нь туун ганд арай бага нэрвэгдсэн газрыг зорьдог. Энэ холын отрыг хийхдээ малчид танил хүмүүсээс сураг чимээ авч, нийгмийн сүлжээ ашигладаг. Цаашлаад орон нутгийн болон улсын байгууллагатай хэлэлцэж тохирох ч шаардлага гардаг. Африкийн холбоо болон Африкийн захын бүсийн эдийн засгийн бүлгүүдийн хувьд малын нүүдэл отроос олж болох эдийн засгийн асар том үр ашгийг олж харж эхэлсэн бөгөөд баруун Африкт л гэхэд малын отрын замыг тогтоон гаргасан бөгөөд энэ зорилгоор хил дамнан явах эрхийг хуулиар олгосон. Ийнхүү хил дамнан отроор явахыг дэмжих нь орон нутгийн даван туулах стратегиудыг бэхжүүлдэг. Гэхдээ үүнтэй холбоотой малчдын аюулгүй байдал, оторлон очиж байгаа нутгийн иргэдтэй харилцах (байгаа малын тэжээлийг булаалдах асуудал) болон малын өвчин тараах аюул нэмэгдэх зэрэг асуудлуудыг орхигдуулж болохгүй. Тиймээс отроор явах ажилд гаднын дэмжлэг зайлшгүй хэрэгтэй болдог тул энэ ажлыг хэрэгжүүлж эхлүүлэхээс өмнө үнэлгээ, дүн шинжилгээг сайтар хийх хэрэгтэй.

Онцгой байдлын дараагаас малчдын дунд нэн даруй хөгшин болон нялх малаа зарах ажил түгээмэл өрнөдөг (*Бүлэг 8: Малын тоо толгойг бууруулах-г харна уу*). Мөн малаа хээлтүүлж, үржлийн малыг эцээхээс сэргийлдэг.

Орон нутгийн чадавх, даван туулах стратегийн чухлыг таньж мэдэх, тэдний зааварчилгааг даган, мэдлэг ур чадвар болон чадавхыг нэгтгэх нь гаднын агентлагуудын хувьд чухал ач холбогдолтой. (*LEGS-н зарчим 7: Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих-г харна уу*).

Малчдын мэдлэг болон ур чадварын тодорхой жишээнүүдийг үндсэн үйл ажиллагаа болон зааварчилгааны хүрээнд онцолсон байгаа.



Хортон шавж болон өвчин тархалтыг багасгах

Онцгой байдлын үед тэжээлээр хангах үйл ажиллагааг өөр газраас (болж өгвөл өөр улсаас биш) тэжээл авчрах шаардлага үүсэж болно. Энэ үйл ажиллагааны үеэр зэрлэг ургамлын үр, хортон шавж болон өвчин дамжин ирэх магадлалтай. Энэ эрсдэлийг багасгахын тулд чанарын баталгааг шалгах, ургамлын эрүүл ахуйн өндөр түвшний шалгалтыг худалдан авах болон түгээх цэгүүд дээр хийнэ.

Орон нутгийн зах зээлийг хямрааж, сөргөөр нөлөөлөхгүй байх

Онцгой байдлын үед тэжээлээр хангах нь чухал ч энэ ажил нь орон нутгийн малын тэжээлийн тогтолцоо болон зах зээлийг хямраахгүй байх нь чухал. Үүний тулд орон нутгийн тэжээлээс авах мөн орон нутгийн нийлүүлэгчийг (жишээ нь дүүрэг/бүсийн) нэн тэргүүнд тавих хэрэгтэй. Ингэснээр онцгой байдлын үед тэжээлээр хангах үйл ажиллагаа дууссан ч орон нутгийн тэжээлийн тогтолцоо болон зах зээл нь малын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжсээр байх юм (*Үйл ажиллагааны жишээ судалгаа: Нигер-т гангийн бэлэн байдлыг хангахад малын тэжээлийн банк бий болгосон тухай. Дээр дурдсан жишээ*).

Зах зээлийн үнэлгээ нь хамгийн тохиромжтой хувилбар болон арга замыг тодорхойлдог. Үүгээр хэчнээн хэмжээний тэжээлийг ямар хугацаатайгаар тэжээлийн үнэ болон хангамжид сөргөөр нөлөөлөлгүйгээр худалдан авч болохыг гаргадаг. Зарим онцгой байдлын үед тэжээлээр тасралтгүй хангахын тулд зарим хэсгийг орон нутгаас, заримыг нь гаднаас худалдан авах холимог загварыг хөгжүүлэх хэрэгтэй болдог.

Агентлаг нь бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцаагаар дамжуулан орон нутгийн тэжээлийн зах зээлийг дэмжин бэхжүүлэхэд тусалж чадна. Өмнө нь дурдсанчлан энэ нь онцгой байдал дууссаны дараа ч малын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг үргэлжлүүлэн сайжруулахад туслах юм.

Кемпүүд (Хуаран, бааз)

Шилжүүлэгдэн байршсан малчид нь Дотооддоо Шилжүүлэгдэн Байршигч хүмүүс эсвэл дүрвэгсдийн кемпүүдэд зарим мал амьтантайгаа ирдэг. Суурьшсаныхаа дараагаар мөн шинээр мал амьтан авч ч болдог. Эдгээр хүмүүст мал амьтнаа тэжээх болон услах нэмэлт дэмжлэг хэрэгтэй байдаг (*Бүлэг 5: Ус-г харна уу*). Мөн мал эмнэлгийн үйлчилгээ ч хэрэг болдог (*Бүлэг 6: Мал эмнэлгийн тусламж-г харна уу*).

Очиж байгаа газарт нь мөн малчид байж болох бөгөөд энэ тохиолдолд олон тооны мал ирвэл одоо байгаа тэжээл болон усны нөөц улам л багасах нөхцөл үүснэ. Үүнээс үүдэн хоорондоо өрсөлдөх, зөрчил мөргөлдөөн ч үүсэх



магадлалтай. Иймд талуудын хооронд сайн харилцааг хадгалахын тулд хүлээн авч байгаа талыг малын тэжээл эсвэл мал эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнээр мөн хангаж болно.

Кемп дотор ч мөн малтай хүмүүст байгаа газраа бууц болгохгүйн тулд нэмэлт газар шаардлагатай болдог (*Бүлэг 7: Малын байр, байршуулалт-г харна уу*). Зарим тохиолдолд малтай өрхийг бэлчээр усандаа ойр газар руу нүүлгэх нь илүү тохиромжтой байдаг. Ингэснээр хүлээн авсан нутгийн иргэдтэй үүсэх зөрчлөөс ч сэргийлж болох талтай.


Тухайн газар мал нэмж ирэх нь дандаа сөрөг үр дагавартай байдаггүй. Зарим газарт жижиг тариаланчид эдгээр малын өтөг бууцыг хөрсөндөө тэжээл болгон хэрэглэх боломж гарлаа ч гэж хардаг.


Малын тэжээлийн тусламжийн хувилбаруудын шийдвэрийн мод

Шийдвэрийн мод нь (*Бүдүүвч 4.1*) онцгой байдлын үед мал амьтныг тэжээлээр хангах үйл ажиллагааны хамгийн хэрэгжих боломжтой, тохирох хувилбаруудыг тодорхойлох гол асуултуудыг нэгтгэсэн. Үүний дараах стандартууд, үндсэн үйл ажиллагаанууд болон зааварчилгаа нь нарийвчилсан төлөвлөгөө гаргахад хэрэгтэй илүү мэдээллүүдийг агуулсан. Боломжтой газар нь онцгой байдлын үеэс өмнөх буюу 'ердийн' үед бэлэн байдлыг хангах үйл ажиллагаа явуулахыг мөн дурдсан.



Бүдүүвч 4.1: Малыг тэжээх хувилбаруудын шийдвэрийн мод





*Үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагагүй гэдэг нь ямар ч үйл ажиллагаа хэрэгжүүлэх хэрэггүй гэсэн үг биш. Харин гол асуултуудад 'тийм' гэж хариулахад шаардагдах чадавхыг бэхжүүлэх хэрэгтэйг сануулж байгаа хэрэг юм.



Стандартууд

Стандарт 1: Бэлэн байдал

Бэлэн байдлыг хангах нь онцгой байдал үүсэхээс өмнө тэжээлийн нөөцийг цаг тухайд нь худалдан авч, тээвэрлэж, урьдчилан байршуулах үйл ажиллагаанууд юм.

Үндсэн үйл ажиллагаа

- Нутгийн малчдын мэдлэг, чадвар болон даван туулах стратегиудыг оролцооны үнэлгээнүүддээ оруулна (*Зааварчилгаа 1-г харна уу*).
- Орон нутгийн тэжээлийн боломжит бэлэн нөөцийг тогтоох үйл ажиллагааны өмнөх үнэлгээ болон зах зээлд үүсгэж болзошгүй хямралын эрсдлийн түвшинд хийх дүн шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэнэ (*Зааварчилгаа 2-г харна уу*).
- Тэжээлийн нөөцийг гаднаас татаж авахаар болсон тохиолдолд чанар болон үнийг нь үндэслэн найдвартай, тогтвортой нөөцтэй, өмнө нь зөвшөөрөгдөж байсан нийлүүлэгчдийг тодорхойлж гаргана. (*Зааварчилгаа 3-г харна уу*).
- Түгээлтийн газрууд болон тэжээл тээвэрлэж явах замын аюулгүй байдалд үнэлгээ хийнэ (*Зааварчилгаа 4-г харна уу*).
- Тэжээлийн худалдан авалтыг үр дүнтэй хийж чадах захиргааны болон худалдан авалтын тогтолцоотой хэрэгжүүлэгч агентлагуудыг тодорхойлно (*Зааварчилгаа 5-г харна уу*).
- Түгээлтийн арга замыг ил тод, шударга явуулах чадамжтай орон нутгийн итгэмжлэгдсэн газрыг тодорхойлно (*Зааварчилгаа 6-г харна уу*).
- Онцгой байдлын үед тэжээлээр хангахад нөлөөлж болохуйц бодлогын хүрээний хориг, саад бэрхшээл байгаа эсэхийг мэдэх, уламжлалт стратегиудыг дэмжинэ (*Зааварчилгаа 7-г харна уу*).

Зааварчилгаа

1. Орон нутгийн даван туулах стратегиуд

Нүүдэлчдийн хувьд тархан байршсан бэлчээр, усанд хүрэх уламжлалт амьжиргааны стратеги нь оторлох юм. Гантай үед алслагдсан нутаг руу явж отор хийдэг. Заримдаа хөрш зэргэлдээ улсууд руугаа ч оторлох тохиолдол гардаг. Хол замд малаа том машинд ачаад явах нь ч бий. Агентлаг отрыг дэмжсэнээр малын амьд үлдэх магадлал сайжирсан гэдгийг нотлох жишээ цөөн, харин отрын замыг хамгаалах нь нүүдлийн тогтолцооны дасан зохицох чадамжийг сайжруулж байгаа тусламж болдог. Онцгой байдлын



үед мал амьтныг тэжээлээр хангах хариу арга хэмжээний төлөвлөгөө нь орон нутгийн малчдыг оторлох зэрэг өөрсдийн сайн хэрэгжүүлдэг дасан зохицох болон даван туулах стратегиудыг дэмждэг.

Ихэнх жижиг фермерүүдийн хувьд ургац хураалтын үеэр үр тарианыхаа хаягдал үлдэгдлийг цуглуулж хадгалаад хүйтний улиралд, тэжээл хомс үед түүгээр малаа тэжээдэг. Онцгой байдлын үед тариа буудайн үлдэгдлийг цуглуулж хадгалах боломж бага эсвэл цуглуулсан хэмжээ нь хангалтгүй байх талтай. Мал борлуулах болон тэжээлээр хангах үйл ажиллагаанууд нь жижиг фермерүүдийг малын тоо болон байгаа тэжээлээ тэнцвэртэй хэрэглэхэд тусална.

2. Орон нутгийн тэжээлийн бэлэн байдал

Орон нутагт байгаа малын тэжээлийн бэлэн байдлыг урьдчилан тодорхойлсон байх нь тэжээл гаднаас авчрахаас хавьгүй илүү давуу талтай:

- Өртөг: Орон нутагт байгаа тэжээл нь ерөнхийдөө арай хямд байдаг (гэхдээ онцгой байдал үүссэн үед үнэ өсөх магадлалтай).
- Тээврийн зардал: Богино зайнд тээврийн зардал бага байна.
- Тээвэрлэлтийн хорогдол: Богино зайнд тээвэрлэснээр хулгайд алдах болон ачсан тэжээлд хорогдол, гэмтэл гарах нь бага.
- Гаднаас тэжээл авчирч дотоодын зах зээлээ хямраахаас сэргийлнэ.
- Тэжээл худалдан авсан мөнгө нь орон нутгийн эдийн засагт үлдэж байна.
- Орон нутгийн ажиллах хүч: Орон нутагт малын тэжээл бэлтгэхэд хадлан хадах, тээвэрлэх, хадгалах болон түгээхэд мөн орон нутгаас ажиллах хүч дайчлах боломжууд бүрддэг.
- Орон нутгийн чадавх: Орон нутгийн тэжээл үйлдвэрлэгчид болон зах зээлийг дэмжсэнээр шинэлэг санаа, бүтээлийг бий болгох хөшүүрэг болно.

Нөгөө талаар орон нутгаас худалдан авалт хийх нь агентлагууд, орон нутгийн тэжээл нийлүүлэгчид, болон нутгийн малчдыг байгаа тэжээл дээрээ өрсөлдөх байдалд хүргэж болзошгүй. Энэ тохиолдолд чанар муудах, үнэ хөөрөгдөх зэрэг асуудал үүсэж цаашлаад гаднаас авчрахаас өөр аргагүй байдалд хүргэдэг.



3. Гаднаас тэжээл авч нөөцлөх

Зарим онцгой байдлын үед тэжээлээр хангах хөтөлбөрүүд нь тусгай шим тэжээлийн заалттай шахмал тэжээлүүдийг хэрэглэх шаардлагатай болдог бөгөөд эдгээрийг орон нутгаас авах боломжгүй байдаг. Зарим ховор тохиолдолд эдгээрийг хот суурин газраас эсвэл бүр хөрш зэргэлдээ улсуудаас ч авчрах хэрэг гардаг. Эдгээр өртөг өндөртэй тэжээлийг аюулгүй тээвэрлэх зам, дэд бүтцийг сайтар шийдэж өгөх шаардлагатай. Цаашид үүсэж болох эрсдэлийг бууруулахын тулд үйл ажиллагаанд дараах зүйлсийг анхаарна:

- Тэжээл хадгалах тохиромжтой байр сав болон нөөц тэжээлийг хадгалах, урьдчилан байршуулах газрыг бэлдсэнээр хүргэлтэд үүсэх саад бэрхшээлээс сэргийлэх (нөөцлөх нь тэжээл бохирдох эсвэл муудах зэргэ эрсдэл дагуулдаг тул тэжээл хадгалах менежментийг үр дүнтэй хийх нь маш чухал);
- Хангалт хийх боломжтой нэгээс олон нийлүүлэгчийг тодорхойлж ажилласнаар нэг нийлүүлэгчээ алдлаа гэхэд үйл ажиллагаанд доголдох үүсэхгүй;
- Орон нутагт хэсэг хугацаанд түр орлуулан хэрэглэж болох импортын үнэтэй шахмал тэжээлийг орлох орон нутагтаа хийсэн илчлэг өндөртэй тэжээлийн олдоц юу байгаад үнэлгээ хийх;
- Онцгой байдлын үед тэжээлээр хангах хөтөлбөрт хэрэглэж болох нутагтаа өөрсдийн нөөцөөр хийсэн, боломжийн шим тэжээлтэй холимог тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжих.

4. Аюулгүй байдал

Онцгой байдлын үед мал амьтныг тэжээлээр хангах үйл ажиллагааны тэжээлийн худалдан авалт, хадгалалт, тээвэрлэлт болон түгээлтийг хийхэд олон нийт болон ажилчдад тулгарч болох аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах (*Бүлэг 2: LEGS-н Зарчмууд* харна уу) шаардлагатай бөгөөд үүнийг бэлэн байдлыг хангах төлөвлөлтийн нэг хэсэг болгох хэрэгтэй. Дийлэнх олон улсын агентлагууд нь өөрсдийн аюулгүй байдлын дүрэмтэй байдаг бөгөөд ажилчдынхаа аюулгүй байдлыг хангахын тулд хамгаалалтын компаниудтай хамтран ажилладаг. Харин орон нутгийн байгууллагуудын хувьд ийм түвшний хамгаалалтаар хангах боломжгүй. Хавсарсан гамшгийн үед олон улсын байгууллагууд нь эдгээр жижиг, нөөц боломж багатай байгууллагуудтай хүч хавсран ажилладаг. Мөн орон нутгаа мэддэг, харилцаа холбоо сайтай тээвэрлэгчдийг гэрээлэн тэжээлийг эцсийн цэгт эрсдэл багатай хүргэдэг.



5. Удирдлагын тогтолцоо

Жижиг нийлүүлэгчдээс худалдан авалт хийхийг зөвшөөрдөггүй хатуу худалдан авалтын тогтолцоотой бол агентлагууд энэ удирдлагын тогтолцоогоо шинэчлэх хэрэгтэй. Боломжтой бол байгууллагын онцгой байдлын бэлэн байдлыг хангах төлөвлөлтийн явцад давуу эрхтэй нийлүүлэгчдийн жагсаалт гаргаж, зохих шалгалтыг хийнэ.

6. Түгээлтийн бүтэц

Боломжтой бол хүн амын хүйсийн харьцааг төлөөлсөн бүтэцтэй байгууллагаас тэжээлийн өдрийн болон долоо хоногийн түгээлтийн хэмжээг зохицуулах. Ахмадууд (эрэгтэй, эмэгтэй оролцоно) үйл ажиллагаанд хамруулах өрхийг сонгох, ажиллах найдвартай хүмүүсийг олоход туслах хэрэгтэй.

7. Бодлого/нөлөөллийн орчин

Бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанууд нь онцгой байдлын үед малын тэжээлийг худалдан авах, тээвэрлэх болон хүргэхэд тулгарч болох саад бэрхшээлүүдэд бодлогын нарийн үнэлгээ хийнэ (жишээ нь улсын болон аймгийн хил дамнан малын тэжээл зөөхөд ямар нэг хориг байгаа эсэх). Орон нутгийн даван туулах стратеги байгаа ч хэрэгжихгүй байгаа бол түүнд саад болж буй зүйлд дүн шинжилгээ хийнэ. Мөн эдгээр стратегийг дахин хэрэглэж хэвшихэд нөлөөлөл үзүүлж болно. Жишээ нь ган болон үерийн онцгой байдлын бус үед өргөн хүрээтэй бэлэн байдлыг хангах төлөвлөгөөний хүрээнд онцгой байдлын үед хэрэглэх ган/үерийн нөөцийг бүрдүүлэх. Ингэснээр тэжээлээр хангах нь удаан хугацаанд тэжээлийн хомсдолтой байгаа асуудалд нааштай үр дүн авчрах, үүнд орон нутгийг татан оролцуулж, хариуцлагыг нэмэгдүүлж өгнө. *(Үйл ажиллагааны жишээ судалгаа: Нигерт гангийн бэлэн байдлыг хангахад малын тэжээлийн банк бий болгосон жишээ судалгааг харна уу).*

Стандарт 2: Үнэлгээ болон төлөвлөлт

Онцгой байдлын үед мал амьтныг тэжээлээр хангах хувилбаруудын үнэлгээ нь мал амьтны орон нутгийн амьжиргаанд гүйцэтгэх үүрэг; малын тэжээлийн хэрэгцээ; болон тохиромжтой үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг тогтоодог.

Үндсэн үйл ажиллагаа

- Нэрвэгдсэн хүн ам онцгой байдлын үе дууссаны дараа ч мал амьтнаас ашиг шим хүртсээр байх магадлал өндөр үед л онцгой байдлын үед мал амьтныг тэжээлээр хангах үйл ажиллагааг эхлүүлнэ. *(Зааварчилгаа 1-г харна уу).*



- Цаашид мал хөрөнгөө сэргээн босгоход урт хугацаанд ашиглагдах, онцгой байдлын үеийг даваад гарах магадлал өндөртэй, эрүүл, амьжиргаанд ач холбогдолтой байдалд нь дүн шинжилгээ хийж тэжээлээр хангах үндсэн малаа сонгоно (*Зааварчилгаа 2-г харна уу*).
- Тэжээлийн бааз байгуулах хэрэгтэй болсон бол хамгаалалтаар хангах, орж гарахад хялбараар зохицуулах (мал амьтад болон малчдад), мөн малын тэжээл, эм тариаг хадгалах агуулахтай байна. Баазын техник хангамж болон нөөц нь ч мөн онцгой байдлын үеийн турш хангалттай хүрэхээр байх хэрэгтэй. Мал амьтан болон тэжээлийн удирдлага нь малаа хариулах хэвийн байдалдаа аль болох түргэн шилжихэд нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй (*Зааварчилгаа 3-г харна уу*).
- Анхдагч үнэлгээний үеэр бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцааг үзүүлэх арга замыг судлаарай (*Зааварчилгаа 4-г харна уу*).
- Хүүхдийг шим тэжээлээр хангах, малын тоо толгойг бууруулах, малыг усаар хангах, болон мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх зэрэг бусад онцгой байдлын үйл ажиллагаануудтай холбон хэрэгжүүлэх боломжийг судлаарай (*Зааварчилгаа 5-г харна уу*).

Зааварчилгаа

1. Гамшигт өртсөн хүмүүс малаа үргэлжлүүлэн маллах

Онцгой байдлын үед зарим хүмүүс бүх малаа алдах эрсдэлд ч ордог. Энэ хохирол нь шууд тохиолддог, эсвэл гэмтэж бэртэх, өвдөх, нүүж суух эсвэл нас барах зэргээр өрхийн чадавх буурснаас малаа хариулах боломжгүйгээс (хариулах сонирхолгүй) ч үүсэж болно. Тиймээс онцгой байдлын үед малын тэжээлээр хангах үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө хамрагдах өрхүүд нь малаа үргэлжлэн хариулах хүсэлтэй байгаа эсэхийг мэдэх нь чухал. Онцгой байдлын үед мал амьтныг тэжээлээр хангах үйл ажиллагаагаар дунд болон урт хугацаандаа хамгийн их үр шим хүртэж чадах өрхүүдийг олон нийтийн санаачилгаар (оролцоотойгоор) тодорхойлж чадна. Үр шим хүртээгүй бусад өрхүүдийн хувьд өөр төрлийн тусламж хүртэж болно.

2. Зорилтот малыг сонгох

Мал амьтад нь ус тэжээлийн хомсдлыг даван туулах, түүнээс эргэн сэргэхдээ илүү сайн байдаг. Тэмээ, ямаа нь үхэр хоньтой харьцуулахад гангийн нөхцөлд илүү тэсвэртэй. Тиймээс илүү ганд тэсвэртэй малаар төрөлжинө гэвэл тэмээ, ямаандаа чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлбэл илүү тохиромжтой. Мөн онцгой байдлын үеэр ажилд дайчлах, ус, тэжээл зөөх амьтаддаа бас анхаарах хэрэгтэй. Ямар төрлийн хэдэн тооны малыг хамруулахаа тогтсоны дараагаар малчид өөрсдөө үйл ажиллагаанд хамруулах малыг сүргээсээ сонгох нь зүйтэй.



3. Тэжээлийн бааз

Тэжээлийн бааз байгуулах нь ихээхэн хөрөнгө шаардана (санхүүгийн болон эд материалын). Тиймээс үүнийг барьж босгох ажилд орон нутгийн байгууллагууд болон боломжит оролцогчдыг бүрэн хамруулах нь чухал. Анхааралдаа авах асуудлууд нь онцгой байдлын үед урьдчилан тодорхойлсон хугацаанд хангалттай хүрэх тэжээлийн нөөц, харуул хамгаалалт, хүртээмжтэй байдал болон хашаа байртай байх.

Баазыг удирдах асуудлыг нийтийн оролцоотой хэлэлцэх нь зүйтэй. Үүнд баазын бүтцийн асуудлууд (тэжээл болон усны тэвш); өвчтэй малын асаргаа; тэжээлийн агуулах, өдөр тутмын тэжээл усалгаа; мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх; болон ажилчдын үүрэг хариуцлагын тогтолцооны асуудлууд орно. Тэжээлийн баазын ерөнхий удирдлагыг орон нутгийн иргэд хянах нь зүйтэй бөгөөд гаднын мэргэжилтнүүдийн тусламжийг хэрэгтэй үедээ авч болно (*Үйл ажиллагааны жишээ судалгаа: Өмнө нь дурдагдсан Эмэгтэйчүүд үндсэн сүргийг тэжээх хөтөлбөрийг удирдахад тусалсан, Этиоп улсын жишээ*).

4. Бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцаа

Бэлэн мөнгө, эрхийн бичгийн тусламж нь хадгалах байр савны боломж муутай өрхүүдэд сайн тохирдог. Гол нь эдгээр өрхүүд нь тэжээлийн нөөц сайтай, зах худалдааны төв нь хэвийн ажиллагаатай газарт амьдардаг байх хэрэгтэй. Эрхийн бичиг нь тогтмол шинэ тэжээл авч хэрэглэхэд маш тохиромжтой байдаг. Гэхдээ бас анхаарах асуудлууд ч бий. Жишээ нь: үйлдвэрлэгчид үнээ өсгөснөөр худалдаачид үнийн хөөрөгдөлтэй тулгарах асуудал бий болдог. Тиймээс тэжээлийн олдоцтой байдал, чанар болон үнийг анхааралтай хянаж байх шаардлагатай бөгөөд эрхийн бичиг үнэ цэнээ алдахгүй байх ёстой. Эрхийн бичгээр олгож буй орон нутгийн худалдаачид, үйлдвэрлэгчдэд мөн зарцуулсан цаг, хөдөлмөрт нь багахан урамшуулал олговол зохимжтой.

5. Дэмжих хөтөлбөрүүд

Тохиромжтой үед нь хүүхдэд өгөх шим тэжээл, малын тоо толгойг бууруулах, ус болон мал эмнэлгийн үйлчилгээгээр хангах үйл ажиллагаануудыг багтаасан өргөн хүрээтэй хүмүүнлэгийн арга хэмжээнд тэжээлээр хангах ажиллагааг уялдуулах нь зүйтэй.

Хавсралт 4.1 тэжээлээр хангах үйл ажиллагааны үнэлгээний шалгах хуудас нь үнэлгээ болон төлөвлөлтийн үйл явцыг удирдах шалгах асуултуудыг багтаасан.



Стандарт 3: Тэжээх түвшин

Онцгой байдлын үед тэжээх түвшин нь малын амьд үлдэх баталгааг хангасан, бүтээгдэхүүний гарцын хэмжээг тохиролцсон, үйл ажиллагаа хэрэгжиж дуустал тогтвортой байх хэрэгтэй.

Үндсэн үйл ажиллагаа

- Өөр өөр төрлийн малд тохирсон шим тэжээлийг үндэслэн хуваарийн дагуу тэжээх түвшнийг тогтооно. (*Зааварчилгаа 1 ба 2-г харна уу*).
- Тэжээх түвшин нь өгч болох хэмжээ мөн үргэлжилж болох байдлыг хангана (*Зааварчилгаа 2-г харна уу*).
- Тэжээлийн зах болон дэлгүүрүүд байхгүй болж малын ирээдүйн гарц үйлдвэрлэлд гэнэтийн эсвэл богино хугацааны аюул учирвал, онцгой байдлын үед мал амьтан тэжээх үйл ажиллагааны нэг хэсэг болгон нөөцийг дахин дүүргэх хэрэгтэй (*Зааварчилгаа 3-г харна уу*).

Зааварчилгаа

1. Шим тэжээлийн хүрэлцээ

Малыг амьд байлгахаар тэжээх болон бүтээгдэхүүн гаргахаар тэжээх нь өөр өөр ойлголтууд бөгөөд хоёр дахь хувилбар нь өсөлтийг дэмжих, хээлтэй мал, ажлын мал эсвэл малаас бүтээгдэхүүн авах зорилготой тэжээхийг хэлдэг. Жижиг малыг амьд байлгахаар тэжээх нь үхэр тэмээ зэрэг амьтдынхаас асар том ялгаатай. Ялгаатай тодорхойлолтууд, тэжээлийн агууламж, болон зөвлөсөн тэжээлийн дэлгэрэнгүй (адууны бүлгийн амьтад, шувуу, гахай хамаарна)-г *FAO (2016), Бүлэг 6-с харна уу*.

Малын бүтээгдэхүүний гарц өндөр байх тусам тэжээлийн үйл ажиллагааны зардал их байна. Тиймээс өндөр гарцтай малыг цөөн тоогоор, богино хугацаанд л тэжээх боломжтой байдаг. Ихэнх малчид илүү олон малаа хамгаалж үлдэхийг хүсдэг болохоор бага өртөгтэй тэжээлийг сонгодог. Хэрэв малын сүүний гарцаар дамжин хүүхэд шим тэжээлээр хангагдаж байгаа бол малын бүтээгдэхүүний гарцыг дэмжих тэжээлд нэмж зардал гаргах хэрэгтэй.

2. Тэжээлийг төсөвлөх

Тэжээлийн тоо хэмжээг төлөвлөхдөө хамрагдах мал амьтдад өдөрт шаардлагатай тэжээлийн хэмжээ, худалдан авалт болон тээврийн зардал, үйл ажиллагааны үргэлжлэхээр төлөвлөсөн хугацаа, төсөв зэргийг дараах байдлаар авч үзнэ:

- Өдөрт шаардлагатай тэжээл—мал амьтны төрлөөс хамааран өөр өөр байх бөгөөд ямар зорилготой тэжээж байгаа шим тэжээлийн төлөвлөгөөнөөс хамаарна *Зааварчилгаа 1*;



- Бэлэн байгаа тэжээлийн нөөц: орон нутагт байгаа эсвэл өөр газраас авчирсан өөр төрлийн тэжээлүүдийн хэмжээ;
- Худалдах үнэ: нэгжийн өртөг;
- Тээврийн зардал: тэжээлийн эх сурвалжаас хүргэлтийн эцсийн цэг хүртэлх зай (төв дэлгүүр эсвэл түгээлтийн цэгээс гэсэн үг), болон нэгжийн өртөг;
- Тэжээлийн сав болон хэмжилтийн савыг нөөцөө зөв зохистой зарцуулахад ашиглана;
- Хугацаа: төлөвлөгдсөн хөтөлбөрийн хугацаа;
- Төсөв: үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бэлэн байгаа санхүүгийн эх үүсвэр;
- Үйл ажиллагааг хүргэхэд шаардлагатай хүмүүс/ажилчид.

Дээр өгөгдсөн мэдээлэлд үндэслэн үйл ажиллагаанд хэчнээн мал хамруулахыг тооцож болно. Нөөц боломж хязгаарлагдмал бол хамруулах малынхаа тоог цөөлөх, тэжээх хугацааг богиносгох эсвэл өгөх шим тэжээлийн зорилгоо өөрчлөх хэрэгтэй.

4

3. Тэжээлийн агуулахыг дахин сэлбэх

Гэнэтийн болон хавсарсан гамшгийн үед малын тэжээлийн агуулах сүйтгэгдэх, тэжээлийн зах зээл, нийлүүлэлтийн шугам тасалдах асуудлууд үүсэж болдог. Хэрэв эдгээр гарз хохирол нь мал амьтны амьд үлдэх эсвэл бүтээгдэхүүний гарц тасалдах аюулд нэн даруй хүргэвэл агуулахыг засаж янзлах, нийлүүлэлтийн шугамыг дахин сэргээх ажлыг хэрэгжүүлнэ. Ингэснээр мал сүргийг хамгаалж, бүтээгдэхүүний гарцыг тасалдуулахгүй үргэлжлүүлнэ.

Стандарт 4: Тэжээлийн аюулгүй байдал

Тэжээлийг гамшигт нэрвэгдсэн газраас биш гаднаас авсан бол ариун цэвэр, ургамлын эрүүл ахуй болон тэжээлийн эх үүсвэрийн чанарыг шалгах бусад ажлыг хийж баталгаажуулна

Үндсэн үйл ажиллагаа

- Нутгийн мал сүргийн тоо, ургаж байгаа бэлчээрийн ургамал, ургамлын гарц, гаднаас дамжин орж ирэх хортон шавж, өвчин болон халдвар тараагчдын эрсдлийн түвшнийг үнэлнэ (*Зааварчилгаа 1-г харна уу*).
- Худалдан авах цэг дээрээс тэжээлд хортон шавж, өвчин болон бусад халдварын эх үүсвэр агуулсан байгаа эсэхийг шалгана (*Зааварчилгаа 2-г харна уу*).



- Тээвэрлэх машин болон хадгалах байранд ариун цэвэр, халдваргүйтгэлийн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ (Зааварчилгаа 3-г харна уу).

Зааварчилгаа

1. Эрсдэлийн үнэлгээнүүд

Онцгой байдлын үед эрсдэлийн үнэлгээ хийх нь амаргүй хэдий ч тэжээлээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай, баримтлах ёстой зүйл юм. Тэжээлийн эх үүсвэр нь нэлээд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бол үйл ажиллагаагаа эргэн хянаад тэжээлийн эх үүсвэрээ өөр газраас сонгосон нь дээр.

Тэжээлийн үйл ажиллагаанаас сурч мэдсэн зүйлсээ сайн баримтжуулж авах хэрэгтэй (*Бүлэг 3: Онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний төлөвлөлт* болон ХҮХС хэсэг).

2. Чанарын хяналт

Хаанаас ч татан авалт хийсэн бай бүх онцгой байдлын үеийн тэжээлд чанарын хяналт хийлгэх ёстой. Үүнд хогийн ургамлын үр, хортон шавж, элс шороо, тоос, төмрийн хэлтэрхий ил харагдаж байгаа эсэхийг шалгах мөн лабораторийн шинжилгээгээр мөөгөнцөр, хорт бодисын ялгарлыг шалгана. Лабораторид өгсөн тэжээлийн дээж дэх хатаалтын чанар, эслэг, эрдэс, уураг, өөх тос, болон кальцийн агууламжийг (хөхүүл амьтанд маш чухал) шалгана.

3. Ариун цэврийг хангах үйл явц

Чанарын хяналтын арга хэмжээнүүдийг хүргэлтийн цэг дээр биш худалдан авч ачилт хийгдэх цэг дээрээ хийсэн нь дээр байдаг. Чанарын хяналтын арга хэмжээнд хамгийн багадаа дараах зүйлс багтана:

- Чанарын баталгаа: Нийлүүлэгчээс чанарын баталгааны хуудас гаргуулж авна. Тээвэрлэхээс өмнө тэжээл нь зохих ёсоор савлагдаж, хаяглагдсан байх хэрэгтэй.
- Угааж, хатаана: Тээвэрлэлт хооронд бүх ачааны машин болон тэжээл хадгалах байрыг цэвэрлэж хатаана.
- Бүртгэл хөтөлнө: Халдвар тараахаас сэргийлэхийн тулд бүх ачааны машины ачсан зүйлсийг бүртгэж тэмдэглэнэ. Жишээ нь: малын тэжээлийн өмнө нь химийн бодис, шил, тосолгооны материал эсвэл төмрийн хаягдал зэрэг аюултай материал тээвэрлэж байсан машинд хэзээ ч ачиж болохгүй.
- Бага хүрэлцэх: Онцгой байдлын үеийн малын тэжээлд хүний гар бага хүргэх хэрэгтэй. Малын тэжээл тээвэрлэж яваа машинд хүн тээвэрлэж



авч явж болохгүй.

- Хамгаалалт: Тээвэрлэлтийн үед бүх малын тэжээлийг бороо шорооноос хамгаалахын тулд усны хамгаалалттай брезент эсвэл хучлагаар хучих хэрэгтэй.
- Цаг хугацаа: Тээвэрлэлтийн болон хадгалалтын хугацааг аль болох л богино байлгах хэрэгтэй



Хавсралтууд

Хавсралт 4.1: Тэжээлээр хангах үйл ажиллагааны үнэлгээний шалгах асуултууд

Энэ шалгах асуултуудыг арга хэмжээ тохиромжтой эсэхийг тодорхойлох яаралтай анхдагч үнэлгээ болон онцгой байдлын үед мал амьтныг тэжээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх үед ашиглаж болно.

Онцгой байдлын үед тэжээлээр хангах бүх үйл ажиллагаанууд

Хувь хэмжээ болон шимт чанар

- Тэжээх үйл ажиллагааны зорилтод нийцсэн өдрийн тэжээх хэмжээг тооцсон уу? FAO (2016), хуудас 95 харна уу.
- Төлөвлөсөн тэжээх ажиллагаа нь зорилтот хүн амд хүргэхэд учирч болох тээврийн хүндрэл бэрхшээл, асуудлуудыг тооцсон уу?
- Ноогдол тэжээлийг тооцохдоо төсвийнхөө боломжийг тооцсон уу?

Тэжээлийн аюулгүй байдал

- Тэжээлийн баталгаат байдал, стандарт ажиллагааны заавар баримталсан уу?
- Тэжээлийн чанарын үнэлгээ хийгдсэн үү, боломжит хогийн ургамлын үр, хортон шавж, өвчин болон бусад халдвар дамжуулагч байх эрсдэлийг шалгасан уу?
- Тэжээлийн чанарын хяналт (жишээ нь тэжээлийн дээжийг лабораторид тогтмол шинжилгээнд оруулах), тэжээлийн харагдах байдалд үзлэг хийсэн үү?
- Тэжээлийн хадгалалтын хугацаа нь аюулгүй байдал, чанар, болон хадгалалтын горимын дагуу явж байгаа юу?
- Тэжээл тээвэрлэж буй машин болон хадгалж буй агуулахын байранд ариун цэврийг сайтар сахиж байгаа юу?

Тэжээлийг татаж авах болон түгээх

- Агентлаг нь тэжээлээр хангах үйл ажиллагааны үргэлжилж буй хэрэгцээг хангах уян хатан удирдлагын тогтолцоотой юу?
- Үйлдвэрлэл болон тээврийн зардлыг багасгаж, орон нутгийн үйлдвэрлэгчид, худалдаачид болон бусад бизнесийг дэмжих зорилгоор боломжтой бол тэжээлийг орон нутгаас авч байгаа юу?
- Орон нутгаас тэжээл авахад бусад оролцогч бүлгүүдийг эрсдэлд оруулаагүй биз?
- Нөхөн сэргээлтийн үеэр хоосон тэжээлийн агуулахуудаа эргэн дүүргэсэн үү?



- Хоёр талдаа ачаа тээвэрлэх (жишээ нь, малын тоо толгойг бууруулах), тэжээлээ хүргээд буцахдаа борлуулах мал ачаад явах зэргээр түгээлтийн тогтолцоог илүү үр өгөөжтэй ашиглах боломж байгаа юу?
- Тээвэрлэлтийн зам, хадгалалтын агуулах болон түгээлтийн сүлжээний аюулгүй байдал хангагдсан уу?

Онцгой байдлын үед тэжээх баазууд

Тэжээлийн баазад хүрэх болон нэрвэгдсэн хүн амыг тодорхойлох

- Үйл ажиллагаанд орон нутгийн хүн амын төлөөлөл, нутгийн удирдлагууд идэвхтэй оролцон, тогтмол зөвлөлдөж байна уу?
- Хамрагдаж буй өрхүүд (эрэгтэй болон эмэгтэй өрхийн тэргүүнтэй) төлөвлөсөн тэжээлийн бааз нь яаж ажиллах талаар бүрэн ойлголцотой байгаа юу?
- Оролцогчид нь энэ үйл ажиллагаанд оролцсоноор үүсэж болох эрсдэлийг ойлгож байгаа юу?
- Оролцох сонирхолтой айл өрхүүд нь тавьж буй шаардлагыг (жишээлбэл малаа тууж ирэх г.м) биелүүлж чадах уу?
- Тэжээлийн баазад тэжээхэд хамгийн тохиромжтой малын төрөл болон оролцох айл өрхүүдийг тодорхойлох процедур байгаа юу?

Материал хангамж болон удирдлага

- Тэжээлийн бааз барихад хэрэгтэй барилгын болон бусад материалуудыг орон нутгаас авч болох уу, эсвэл ойрхноос бага зардлаар тээвэрлэж ирэх боломжтой юу?
- Баазад урьдчилан тооцоолсноор байрлуулж болох тэжээл болон усны бэлэн хангамж байгаа юу?
- Мал эмнэлгийн үйлчилгээ зэрэг хэрэгцээт дэмжлэг үйлчилгээ байгаа юу?
- Баазын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх чадвартай менежерүүд байгаа юу?
- Орон нутгийн бүх оролцогчдын асуудал хэрэгцээг сонсож, зохицуулж чадах удирдлагын бүтэц байгаа юу?
- Бааз дээр ажиллах хангалттай ажиллах хүч байгаа юу? (Боломжтой бол орон нутгийн хүмүүсээс авч ажиллуулах хэрэгтэй)



Хавсралт 4.2: Малыг тэжээх үйл ажиллагааны хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн жишээнүүд

	Явцын шалгуур үзүүлэлт (хэрэгжиж байгаа зүйлсийг хэмжинэ)	Үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүд (хэрэгжиж байгаа зүйлсийн үр дүнг хэмжинэ)
Үйл ажиллагааг загварчлах	Малчид, олон нийтийн төлөөлөл, бусад оролцогчид (хамаарах хувийн салбарын нийлүүлэгчид)-той хийсэн уулзалтын тоо	Өөр өөр оролцогчдын үүрэг хариуцлагууд Тэжээлээр хангах арга замууд, худалдан авах, тээвэрлэх болон түгээх Тэжээлээр хангахад хамруулах өрхүүд болон малын тоо, төрлийг сонгоход олон нийтийн оролцоо Малын тэжээл хүлээн авах явцад олон нийтийн оролцоо (тосгонд суурилсан тэжээлийн төвүүд г.м)
Үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Тэжээлийн газар худалдаалагдан хүргэгдсэн тэжээлийн хэмжээ болон өртөг Тэжээх малын тоо болон төрөл Нэг өдөрт идэх хэмжээ, малын төрлөөр Тэжээх хугацаа Тендерийн үйл явц – худалдан авалт болон тээвэр Орон нутгийн худалдан авалтыг дэмждэг захиргааны тогтолцоо Байгаа боломжийн үнэлгээнүүд Баталгаат байдлын үнэлгээнүүд	Тэжээлээр хангагдаж байгаа болон хангагдаагүй малын биеийн байдлыг харьцуулсан оноо Тэжээлээр хангагдаж байгаа болон хангагдаагүй малын хорогдлын түвшин Хүүхдийн авах шим тэжээлд гарсан өөрчлөлт Тэжээл цуглуулахад эмэгтэйчүүд/ охидод шаардагдаж буй цаг Хүмүүнлэгийн үйл ажиллагааны бодлогод нөлөөлсөн нотолгоо Тэжээлийн чанар, чанарын батламж болон ургамлын эрүүл ахуйн чанарын стандартуудыг мөрдсөн гэрчилгээ Худалдаалсан цэгээс тээвэрлэсэн, хадгалсан, болон үйлчлүүлэгчид хүргэх цэг хүртэл Лабораторийн шинжилгээг давтамжтай хийх



	Явцын үзүүлэлтүүд хэрэгжиж байгаа зүйлсийг хэмжинэ)	Үр нөлөөний үзүүлэлтүүд (хэрэгжиж байгаа зүйлсийн үр дүнг хэмжинэ)
Үйл ажиллагааг хэрэгжүүлэх (үргэлжлэл)	Бэлэн мөнгө, эрхийн бичгийн туслалцаа	Чанарын үнэлгээнүүд Орон нутгийн худалдан авалт Баталгаат байдлын тохиолдлууд Орон нутгийн удирдлагын тогтолцоо/ байгууллага Орон нутгийн бүтцийн хүртээмжтэй байдал Бэлэн мөнгө/эрхийн бичгүүд



Эх сурвалж ба цаашид унших материал

Ayantunde, A.A., Fernández-Rivera, S., and McCrabb, G. (eds) (2005) *Coping with Feed Scarcity in Smallholder Livestock Systems in Developing Countries*, International Livestock Research Institute (ILRI), Nairobi, <http://mahider.ilri.org/handle/10568/855>

Bekele, G. and Abera, T. (2008) *Livelihoods-based Drought Response in Ethiopia: Impact Assessment of Livestock Feed Supplementation*, Feinstein International Center, Tufts University, Digital Collections and Archives, Medford, MA, <http://hdl.handle.net/10427/71144>

Bekele, G., Ali, T. E., Regassa, G. and Buono, N. (2014) 'Impact of goat feeding and animal healthcare on child milk access in Ethiopia', *Field Exchange* 47, p72, <https://www.ennonline.net/fex/47/goat>

Catley, A. (ed.) (2007) *Impact Assessment of Livelihoods-based Drought Interventions in Moyale and Dire Woredas, Ethiopia, Pastoralists Livelihoods Initiative*, Feinstein International Center, Tufts University, Medford, MA, together with CARE, Save the Children USA, and USAID-Ethiopia, <https://fic.tufts.edu/assets/IMPACT1-2.pdf>

Catley, A., Admassu, B., Bekele, G. and Abebe, D. (2014) 'Livestock mortality in pastoralist herds in Ethiopia and implications for drought response', *Disasters* 38(3): 500–516 <https://doi.org/10.1111/disa.12060>

Cullis, A. (2021) *Understanding the Livestock Economy in South Sudan: field study findings*, TANA Copenhagen, <https://tanacopenhagen.com/wp-content/uploads/2021/04/Field-Report.pdf>

FAO (2021) *Pastoralist Knowledge Hub* <https://www.fao.org/pastoralist-knowledge-hub/en/>

FAO (2016) *Livestock-related interventions during emergencies – The how-to-do-it manual*. Edited by Philippe Ankers, Suzan Bishop, Simon Mack and Klaas Dietze. FAO Animal Production and Health Manual No. 18. Rome, <https://www.fao.org/3/i5904e/i5904e.pdf> (See Chapter 6)

Gebru, G., Yousif, H., Adam, A., Negesse, B. and Young, H. (2013) *Livestock, Livelihoods, and Disaster Response, Part Two: Three Case Studies of Livestock Emergency Programmes in Sudan, and Lessons Learned*, Feinstein International Center, Tufts University, Medford, MA, <https://fic.tufts.edu/publication-item/livestock-livelihoods-and-disaster-response-part-two-2/>

Goe, M.R. (2001a) *Assessment of the scope of earthquake damage to the livestock sector in Gujarat State, India*, Consultancy Mission Report, FAO, Bangkok/Rome.

Goe, M.R. (2001b) *Relief and rehabilitation activities for the livestock sector in earthquake affected areas of Kachchh District, Gujarat State, India*, Technical Cooperation Project Proposal, FAO, Rome/Bangkok.

International Institute for Environment and Development (IIED) and SOS Sahel UK (2009) *Modern and Mobile: The Future of Livestock Production in Africa's Drylands*, de Jode, H (ed), IIED and SOS Sahel UK, London, <https://pubs.iied.org/12565iied>

Krätli, S. (2015) *Valuing Variability: New Perspectives on Climate Resilient Drylands Development*, de Jode, H (ed), IIED, <https://pubs.iied.org/sites/default/files/pdfs/migrate/10128IIED.pdf>

LEGS (2018) *Revisiting the economic impacts of early drought response: How does early response affect households in pastoralist area?* LEGS Briefing Paper, prepared by A. Catley, LEGS <https://www.livestock-emergency.net/general-resources-legs-specific/>



Ngaka, M.J., 2012, 'Drought preparedness, impact and response: a case of the Eastern Cape and Free State provinces of South Africa', *Jamba: Journal of Disaster Risk Studies* 4(1), Art. 47, <https://jamba.org.za/index.php/jamba/article/view/47>








Бүлэг 5: Усаар хангахад баримтлах техникийн стандартууд

- 173 Танилцуулга
- 176 Усаар хангах хувилбарууд
- 180 Үйл ажиллагаанууд (тусламж)-ыг хэрэгжүүлэх цаг хугацаа
- 181 LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн түншлэлийн стандартууд (ХТС)-тай холбогдох нь
- 182 LEGS-н зарчмууд болон бусад анхаарах асуудлууд
- 186 Усаар хангах хувилбаруудын шийдвэрийн мод
- 189 Стандартууд
- 202 Хавсралт 5.1: Уст цэгүүдийн үнэлгээний шалгах хуудас
- 204 Хавсралт 5.2: Усаар хангах үйл ажиллагааны хяналт, үнэлгээний жишээнүүд
- 205 Хавсралт 5.3: Уст цэгүүдийн менежментэд анхаарах асуудлууд
- 206 Эх сурвалж ба цаашид унших материал



Бүлэг 5: Усаар хангахад баримтлах техникийн стандарт



5

Танилцуулга

Ус нь тэжээл, мал эмнэлгийн үйлчилгээний дэргэд бүх төрлийн мал аж ахуйн системд амьтдыг амьд байлгадаг чухал элемент юм. Өндөр ашиг шимтэй амьтад усан хангамжийн тасалдалд маш эмзэг байдаг. Усгүй үед ихэнх амьтад (зарим тэмээнээс бусад) хэдхэн хоногоос илүү амьдрах боломжгүй.



Онцгой байдлын улмаас байгалийн усны эх үүсвэр алдагдах, эсвэл хиймэл усны эх үүсвэрт биет гэмтэл учирсан тохиолдолд мал аж ахуй эрхэлдэг иргэдийн хувьд усны хүртээмж чухал асуудал болж хувирдаг.

Онцгой байдлын үед усаар хангах хариу арга хэмжээ нь мал амьтныг амьд авч үлдэхээс гадна гамшигт нэрвэгдсэн айл өрхүүдийг мал амьтнаасаа үр шим хүртсээр байх (жишээ нь сүү болон өндөгөөр хангах) боломжийг олгодог. Үүссэн онцгой байдал нь гэнэтийн эсвэл удаан явцтайгаас хамааран усаар хангах техникийн хувилбарууд нь өөр өөр байна. Онцгой байдлын өмнөх үеийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд одоо байгаа усны нөөц хангамжууд эсвэл гаднаас ус зөөвөрлөхийн аль үр дүнтэй үйл ажиллагааг нь дэмжиж тусладаг. Мөн бэлэн байдлыг хангаснаар тусламж нь нэрвэгдсэн иргэдэд нэмж бэрхшээл сорилт үүсгэхгүй байхад тустай.

Энэ бүлэгт онцгой байдлын үед мал амьтныг усаар хангах хариу арга хэмжээг хэрэгжүүлэхийн ач холбогдлыг танилцуулна. Мөн усаар хангах үйл ажиллагааны техникийн хувилбарууд болон тэдгээрийн ашиг тус, сорилт бэрхшээлүүдийг тайлбарлах юм. Энэ талаар мэдээллийг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага FAO (2016)-н Бүлэг 7 “Усаар хангах” хэсгээс харж болно. Техникийн хувилбар бүрт LEGS гарын авлага нь стандартууд, үндсэн үйл ажиллагаанууд болон зааварчилгааг багтаасан. Үнэлгээний шалгах асуултууд, мөн хяналт үнэлгээний үзүүлэлтүүдийг бүлгийн төгсгөлд хавсралтаар оруулсан болно. Цаашид уншиж судлах материалын жагсаалтыг мөн гаргасан. Кейс судалгаануудыг LEGS-н вэбсайтаас (<https://www.livestock-emergency.net/case-studies>) олж харах боломжтой

LEGS-н амьжиргааг дэмжих зорилтуудтай холбогдох нь

Онцгой байдлын үед мал амьтныг усаар хангах нь мал хөрөнгийг онцгой байдлын үед болон түүнээс хойш ч аварч хамгаалахад тусладаг бөгөөд LEGS-н амьжиргааг дэмжих 3 зорилттой бүгдтэй нь уялдана:

- Эрүүл мал амьтан нь айл өрхийн хоол хүнсний аюулгүй байдлыг хангадаг. Тиймээс усаар хангах нь гамшигт нэрвэгдсэн хүн амд “байгаа мал сүргээсээ нэн даруй ашиг хүртэх”-д дэмжлэг үзүүлснээр LEGS-н амьжиргааг дэмжих эхний зорилтыг биелүүлж байна.
- Тэжээлээр хангахын зэрэгцээ онцгой байдлын үед амьжиргааны гол эх сурвалж болсон мал амьтныг усаар хангаснаар амьд авч үлдэх боломжтой. Ингэснээр LEGS-н хоёр дахь зорилт болох үндсэн мал хөрөнгийг хамгаалж байна.
- Үүн дээр нэмээд урьдчилан сэргийлэх, эрсдэлийг даван туулах чадавхыг бэхжүүлэх арга хэмжээнүүдээр дамжуулан одоо байгаа болон шинэ мал хөрөнгийг дэмжих үйл ажиллагаа явуулж болно. Үүнд хадгалалтын багтаамж болон хүртээмжийг бүрэн ашиглахын тулд тохиромжтой



цаг хугацаанд өөрөөр хэлбэл “цагаа олж хийсэн уст цэг болон усны эх ундаргыг сэргээн босгох” ажлууд орно. Энэ нь LEGS–н амьжиргааг дэмжих 3 дахь зорилт буюу мал хөрөнгийг сэргээн босгохтой уялдаж байна.

Онцгой байдлын үед мал сүргийг усаар хангах хариу арга хэмжээний ач холбогдол

Онцгой байдлын үед усны эх ундаргад хүрэх боломжгүй болсон үед усаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь маш чухал. Мөн энэ үйл ажиллагааг зөв зохистой хэрэгжүүлэх нь чухал бөгөөд сайн бодож тунгаагүй хариу арга хэмжээ нь байгаль орчны доройтол, зөрчил мөргөлдөөнд ч хүргэх эрсдэлтэй.

Орон нутаг, газар бүрт мал сүргийн усны хүртээмж маш ялгаатай байдаг бөгөөд уур амьсгалын нөхцөл байдал болон олон нийтэд хангамж нь хүртээмжгүй байх зэргээс үүддэг. Хагас хуурай болон хуурай орчинтой, нүүдлийн аж ахуй эсвэл холимог фермийн аж ахуй эрхэлдэг Африк болон Ази тивийн газар нутгаар усны хангамж нь улирлын чанартай байдаг. Ган бол удаан явцтай гамшгийн гол хүчин зүйл бөгөөд зөрчил мөргөлдөөнтэй хосолсоноор хавсарсан гамшиг үүсгэдэг. Халуун дулаан цаг ууртай бүсийн хувьд хур тунадас харьцангуй элбэг тул жилийн түрш усны хангамж хүрэлцээтэй байдаг. Энэ бүс нутагт гэнэтийн гамшгуудаас (газар хөдлөлт, үер гэх мэт) үүдэн ус түгээх байгууламжийн үйл ажиллагаа доголдох, усны ундарга бохирдох зэргээр усанд хүрэх боломжгүй болох магадлалтай. Эдгээр алдагдал нь усан хангамжийн байгууламжид гэмтэл учруулахаас гадна бохир ус, хог хаягдал, шавар шавхай, сэг зэмээр дамжин усыг бохирдуулдаг. (Пакистан, Иран, Афганистан зэрэг хуурай бүсэд газар хөдлөлт болвол зөрчил мөргөлдөөнтэй хавсраад хавсарсан гамшиг үүсгэх магадлалтай.

Хуурай бүсийн ихэнх газар нутагт мал услах цэгүүд нь (цооног, худаг, болон далангууд) үүсээд байгаа эрэлт хэрэгцээг хангах боломжгүй болсоор байна. Уст цэгийн доройтол нь гадаргын усны багасалт, уст цэгийн арчилгаа засварыг дутуу хийх, зориуд эвдэж сүйтгэх, буруу менежмент, харж хамгаалахгүй орхигдуулах болон ашиглах малын тоо нэмэгдсэн зэргээс үүдэж болно. Усны хүртээмж тасалдах, хэврэг байдлыг бууруулах урт хугацааны хөгжлийн ажил нь бүс нутаг болон үндэсний эдийн засаг, эрчим хүч, болон хөдөө аж ахуйн бодлогуудтай холбогддог бөгөөд нилээд маргаантай асуудлын нэг юм. Хөдөө аж ахуйд урт хугацааны усны бодлого хэрэгжүүлэх нь арилжааны хэлбэрт шилжүүлэх, хувьчлах, том хэмжээний усжуулалтын систем зэрэгт чиглэдэг нь хүн амд илүү бэрхшээл үүсгэдэг.



Малын усны хангамжийн хомсдолд хариу үзүүлэхээр онцгой байдлын үйл ажиллагаа явуулж байгаа бол хэрэгжүүлэгч агентлаг нь усны хүртээмжийн асуудлыг өргөн хүрээтэйгээр, уг үндсээр нь авч үзэж, ойлгох хэрэгтэй. Мөн мал амьтныг аварч үлдэх арга хэмжээ хэрэгжүүлэхэд цаг давчуу байгааг мэдэж байх учиртай. Иймд бэлэн байдлыг хангах нь маш чухал байдаг.

Малд олгох усны чанарын стандарт нь хүний хэрэгцээний устай адил өндөр биш ч суурь чанарын шаардлагуудыг хангасан байх ёстой. Хүнд өгөхөөргүй усыг малд өгч болно. Тодорхой төрлийн мал амьтанд өдөрт өгөх усны хэмжээ болон чанарын шаардлагуудыг FAO (2016)-с харна уу.

Усаар хангах нь малын сайн сайхан байдлыг хангах таван үндэс суурийн эхнийх болох 'шим тэжээл'-ийг өгдөг бөгөөд мал амьтныг хангалттай, тэнцвэртэй, цэвэр хүнс болон усны хүртээмжтэй байлгах нөхцөл болдог. Энэ тухай *Бүлэг 1: LEGS-н танилцуулга*-д дурьдсан.

Усаар хангах хувилбарууд

Дүрмээр бол усаар хангах үйл ажиллагаанууд нь усан хангамжийн хамгийн хэмнэлттэй, тогтвортой хувилбар дээр үндэслэсэн байх ёстой. Уст цэгүүдийг сэргээн засварлах эсвэл шинээр байгуулах нь усны хомсдолыг арилгах хамгийн боломжит, урт хугацааны шийдлийг санал болгодог бөгөөд үүнийг ашиглах нь *LEGS 3-р зарчим: Байгаль орчныг хамгаалах*-д нийцнэ. Гэсэн хэдий ч усаар нэн даруй заралтай хангах шаардлага үүссэн үед өртөг өндөртэй, тогтвортой биш тухайлбал ус зөөвөрлөх гэх мэт аргуудыг богино хугацаанд ч гэсэн хэрэгжүүлэх шаардлага үүсдэг. Анхны зардал өндөр байсан ч машинаар зөөж усаар хангах нь алдагдсан мал хөрөнгийг нөхөхөөс илүү эдийн засгийн хувьд ашигтай бөгөөд илүү боломжтой хувилбар байж болох юм.

Нөхцөлтэй эсвэл нөхцөлгүй, хязгаарлалттай эсвэл чөлөөтэй хэлбэрээр эрхийн бичиг, гар утсаар мөнгө шилжүүлэх эсвэл бэлнээр төлөх зэрэг хүргэлтийн механизмууд нь усаар хангахад тохиромжтой, зардал хэмнэсэн арга замууд байж болох юм. Усны хүртээмжээс хамааран малчид нь тэдгээрийг хувийн хэвшил, нийтийн өмчлөлийн эсвэл бусад малыг усаар хангах боломжтой газруудад ашиглаж болох юм. (*Бүлэг 3: Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөлт*-н Бэлэн мөнгө болон эрхийн бичгийн тусламж (CVA) хэсгийг харна уу) Гэхдээ үүнд нэрвэгдсэн хүн амын нөхөн сэргээх шууд зардлыг бодолцож үзэх хэрэгтэй. Хүмүүнлэгийн байгууллагууд нь гамшигт нэрвэгдсэн хүн амыг шууд төлбөрөө хийхийг илүү дэмжиж байгаа бөгөөд ингэснээр үйлчилж буй усны төлбөрийн системийг доголдуулахгүй байх боломжтой. Энэ шууд төлөлтийг уст цэг болон ус зөөвөрлөх аль аль хувилбарт ашиглахаар судалж үзэх хэрэгтэй. Ингэж чадвал гаднаас өгсөн санхүүжилтээс илүү тогтвортой хүргэлтийн сүлжээг бий болгох боломжтой.



Хувилбар 1: Уст цэгүүд

Уст цэгүүд нь худаг, цооног, гадаргын ус цуглуулах систем (жишээлбэл: далан, хадгалах сав) зэрэг янз бүрийн хэлбэртэй байж болно. Хотын цахилгаан хангамжийг мөн ашиглаж болно. Онцгой байдлын үед мал аж ахуй эрхлэгчдэд усан хангамжийг дараах гурван аргын аль нэгээр сонгож болно:

1. Хямралд нэрвэгдсэн ард иргэдэд илүү өргөн хүрээг хамруулах зорилгоор одоо байгаа уст цэгүүдийн менежментийг өөрчлөх;
2. Одоо байгаа боловч эвдэрсэн уст цэгүүдийг сэргээн засварлах;
3. Шинээр уст цэгүүдийг бий болгох;

Эдгээр арга бүр нь хүндрэл учруулж болзошгүй. Эхний арга нь хамгийн бага зардлаар хэрэгжиж болох ч усан хангамж хангалтгүйн улмаас хэрэгжих боломжгүй байж магадгүй юм. Энэ нь одоо байгаа хэрэглэгчид болон хямралд өртсөн шинэ хэрэглэгчдийн хэрэгцээг хангах нарийн төвөгтэй байдлаас шалтгаалан боломжгүй байж магадгүй юм. Удаан явцтай гамшгийн үед эвдэрсэн уст цэгүүдийг сэргээн засварлах нь бэлэн байдлын арга хэмжээний хувьд тохиромжтой. Гэнэтийн гамшгийн үед усны хүртээмж, эсвэл чанарыг сайжруулахад шаардагдах ажил харьцангуй бага, сэлбэг хэрэгслийг бэлэн байлгахад бусад тохиолдолд нөхөн сэргээлт хийхэд хангалттай хугацаа байхгүй байж болно. Шинээр уст цэгүүд байгуулах нь нилээд төвөгтэй мөн цаг хугацаа их зарцуулах ажил юм. Үүнд газраа сонгох, хэлэлцээр хийх, газар ухах, зохицуулалтын ажил болон урт хугацааны үйл ажиллагааг хангахын тулд орон нутгийн хүн амд хариуцуулах ажлууд багтана.

Хүн ам болон мал амьтны усны хэрэгцээг хангахтай холбоотой асуудлууд нь амьжиргааг дэмжих гурван зорилтуудад нөлөөлдөг. Мөн газар тариалан болон мал амьтнаас амьжиргаа нь хамааралтай хүн амын хувьд ч маргааны сэдэв болж байна. (*SEADS* харна уу) Гэхдээ зохистой төлөвлөлт, зохицуулалтыг хийж чадвал хүн, мал аль алиныг нь усаар хангах түгээлтийн цэгүүдийн сүлжээг үүсгэх боломжтой.

Хувилбар 2: Ус зөөвөрлөх

Ус зөөвөрлөх нь хамгийн сүүлийн сонголт болж хэрэгждэг бөгөөд зөвхөн онцгой байдлын эхэн үед л хэрэгжүүлдэг. Энэ үйл ажиллагаа нь зардал ихтэй, нөөцийн үр ашиггүй зарцуулалттай, хүн хүч их шаарддаг. Гэхдээ энэ нь мал амьтан харангадсан үед аварч үлдэхийн тулд хурдан хугацаанд хэрэгжүүлэх боломжтой ганц хувилбар юм. Тиймээс ус зөөвөрлөх хувилбарыг бусад усаар хангах хувилбаруудыг хэрэгжүүлэх боломж бүрдэх хүртэл түр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа гэж үзэх хэрэгтэй. Зардал хуваалцах/нөхөх боломжуудыг мөн эрэлхийлэх хэрэгтэй.



Сайтар дүн шинжилгээ болон үнэлгээ хийсний дараагаар малчид ус зөөвөрлөх зардлыг бэлнээр хийх үү эсвэл төстэй хэлбэрээр зохицуулах үү гэдгээ шийднэ. Иргэд өөрсдөө зөөвөрлөх машинаа зохицуулбал хэсэгчилсэн хөнгөлөлттэй ус зөөвөрлөх хувилбарыг хэрэгжүүлж болно. Харин иргэд өөрсдөө хувь нэмэр оруулах боломжгүй бол хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс ус зөөвөрлөх үйлчилгээг бүрэн хөнгөлөлттэй хүргэнэ. Бүх оролцогчид ил тод, тэгш хүртээмжтэйгээр мэдээллийг авч хоорондоо харилцах нь энэ үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх гол үндэс юм.

Ус зөөвөрлөх нь материал техник хангамж их шаарддаг бөгөөд төлөвлөлт, машинуудын зохион байгуулалтад анхаарал их хандуулах хэрэгтэй байдаг. Үүнд үүсч буй нөхцөл байдал, зөөвөрлөх зам нээлттэй, жолооч болон багийн бусад гишүүдийн аюулгүй байдал хангагдсан мөн усны сав хэвийн ажиллагаатай байгаа зэргийг хянах ажлууд ордог.

Усаар хангах янз бүрийн хувилбаруудын ашиг тус, сорилт бэрхшээлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг *Хүснэгт 5.1*-д үзүүлэв.

Хүснэгт 5.1: Усаар хангах хувилбаруудын ашиг тус ба сорилт бэрхшээл

Хувилбар	Ашиг тус	Сорилт бэрхшээл
1. Уст цэгүүд		
1.1 Одоо байгаа усны эх үүсвэрүүдийн менежментийг өөрчлөх	Энэ нь одоо байгаа боломж, нөөцийг дээд зэргээр ашиглах харьцангуй хямд сонголт юм Энэ нь ихэвчлэн онцгой байдлын үед хурдан хэрэгжиж болно	Үүнд хүрэх боломж ихэвчлэн хязгаарлагдмал байдаг Энэ нь шинэ хэрэглэгчдийн бүлгүүдийн хооронд зөрчилдөөн үүсгэх боломжтой
1.2 Одоо байгаа усны эх үүсвэрүүдийг нөхөн сэргээх	Энэ нь усаар хангах бусад хувилбаруудаас хамгийн хямд байх магадлалтай Усны эх үүсвэрийн удирдлагын бүтэц аль хэдийнэ нэгэнт бий болсон байна Энэ бол онцгой байдлыг даван туулах урт хугацааны шийдэл юм	Анх бий болсон доройтлын шалтгаан (жишээ нь: усны түвшин бага байх) хэвээр байх бөгөөд эсвэл давтагдах боломжтой



Хувилбар	Ашиг тус	Сорилт бэрхшээл
1.2 Одоо байгаа усны эх үүсвэрүүдийг нөхөн сэргээх (Үргэлжлэл)	Хүн, мал амьтны усны хэрэгцээг нэгэн зэрэг хангах боломжтой Энэ нь эрсдэлтэй өрхүүдэд “ажиллаад бэлэн мөнгө авах (ажил-бэлэн мөнгө CFW)” санаачлагаар дамжуулан дэмжлэг үзүүлдэг (жишээ нь далангийн шороо арилгах, байгалийн ус цуглуулах талбайг цэвэрлэх, одоо ашиглаж байгаа савыг засварлах)	Нөхөн сэргээлтийн ажилд цаг хугацаа, материал бүрдүүлэх шаардлагатай ихэвчлэн хэтэрхий удаан үргэлжлэх болно
1.3 Шинээр усны эх үүсвэрийг бий болгох	Гамшгийн үед болон түүний дараа яаралтай хэрэгцээ шаардлага гарсан үед хүн амыг ундны усны тогтвортой шинэ эх үүсвэрээр хангах бүрэн боломжтой Мал, хүн амыг шаардлагатай усны эх үүсвэрээр нэгэн зэрэг хангана	Энэ нь нөхөн сэргээлтээс илүү өртөг өндөртэй, маш өндөр хөрөнгө оруулалт, урт хугацааны санхүүжилт шаарддаг Онцгой байдлын үед үр дүнтэй хариу арга хэмжээ авахад шаардагдах хугацаа хэтэрхий урт байх магадлалтай Тохиромжтой байршил байж болох ч богино хугацаанд (онцгой байдлын үед) хэцүү Мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, тэгш хүртээмжийг хангах, усны нөөц, хүрээлэн буй орчны тогтвортой ашиглалтыг хангахын тулд орон нутагт суурилсан, хүлээн зөвшөөрөгдсөн удирдлагын тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Хүн, мал ундаалж болох шинэ газар нутгийг ашиглах нь зарим сөрөг үр дагаврыг (зөрчил, байгаль орчны доройтол) бий болгоно Бэлчээрийн ердийн хэв маягийн өөрчлөлтөөс үүдэлтэй зарим эрсдэл (хуурай улирлын бэлчээрт хялбар нэвтрэх, нүүдлийн замыг өөрчлөх, газар эзэмших эрхийн маргаан үүсэх гэх мэт) үүсч болзошгүй



Хувилбар	Ашиг тус	Сорилт бэрхшээл
2. Ус зөөвөрлөх		
	Нэн шаардлагатай усны хэрэгцээг хурдан хугацаанд хангах боломжтой Хүний хэрэгцээнд хангалтгүй чанарын усыг малд ашиглаж болно	Өртөг өндөртэй-нөөц хангалтгүй тул отрын малыг тууварлан малын тэжээл хангалттай байгаа газарт, усны эх үүсвэрт хүргэх нь илүү тохиромжтой Хөдөлмөр их шаарддаг зөөвөрлөлтийн хувьд төвөгтэй Энэ нь тогтвортой биш, зөвхөн түр зуурын шийдэл юм Ус шаардлагатай байгаа хүн, мал амьтны хооронд хамгийн их зөрчилдөөн үүсгэх магадлалтай Усыг эрх тэгш, хүртээмжтэй хүргэхийн тулд орон нутагт түшиглэсэн удирдлагын бүтэц бий болгох шаардлагатай Усны эх үүсвэрийн одоо байгаа хэрэглэгчидтэй зөрчилдөх магадлалтай

Үйл ажиллагаанууд (тусламж)-ыг хэрэгжүүлэх цаг хугацаа

Дээр дурдсанчлан ус зөөвөрлөх нь яаралтай тусламжийн дараах (гэнэтийн гамшиг) эсвэл яаралтай тусламжийн (удаан явцтай гамшиг) үе шатанд тохиромжтой богино хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ боловч зардал ихтэй, үйл ажиллагаа нь тогтворгүй учраас цаашид удаан үргэлжлүүлэх боломжгүй байдаг. Уст цэгийн менежментийг өөрчлөх эсвэл одоо байгаа цэгүүдийг сэргээн засварлах ажлыг онцгой байдлын хоёр хэлбэрийн бүх үе шатанд хийж болно. Одоо байгаа доройтсон усны эх үүсвэрүүд хангалтгүй эсвэл нөхөн сэргээлт хийхэд тохиромжгүй тохиолдолд усны шинэ эх үүсвэр байгуулах нь боломжтой шийдэл юм. Энэхүү үйл ажиллагаа нь онцгой байдлын бэлэн байдал болон онцгой байдлын дараах хариу арга хэмжээний аль алиных нь нэг хэсэг болох усны чиглэлээрх хөгжлийн урт хугацааны хөтөлбөрүүд болон сайжруулсан менежменттэй уялдаатай байх ёстой. Хүснэгт 5.2-т эдгээр усны сонголт бүрийн тохиромжтой цаг хугацааг санал болгож байна



Дасан зохицох чадварыг бэхжүүлэх арга хэмжээ нь хүмүүнлэгийн хариу арга хэмжээнд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд онцгой байдлын бус тогтвортой байдлын үед авч үзэх ёстой. “Хэвийн” үед өгсөн бэлэн байдлын хандив (жишээ нь, багаж хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл) нь онцгой байдлын үед усны хомсдолын хурц үе шатыг бууруулахад тусална. Бусад бэлэн байдлын үйл ажиллагааг Стандарт 1-д санал болгож байна: Бэлэн байдлыг доор харуулав.

Table 5.2: Усаар хангах үйл ажиллагааны зохистой цаг хугацаа

Хувилбар	Гэнэтийн гамшиг		
	Гэнэтийн хор хохирол	Эрт үеийн нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлт
1.1 Уст цэгүүд: менежментийг өөрчлөх	✓	✓	✓
1.2 Уст цэгүүд: сэргээх	✓	✓	✓
1.3 Уст цэгүүд: шинээр барих	—	—	✓
2. Ус зөөвөрлөх	✓	—	—

Хувилбар	Удаан явцтай гамшиг			
	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
1.1 Уст цэгүүд: менежментийг өөрчлөх	✓	✓	✓	✓
1.2 Уст цэгүүд: сэргээх	✓	✓	✓	✓
1.3 Уст цэгүүд: шинээр барих	✓	✓	—	✓
2. Ус зөөвөрлөх	—	—	✓	—

LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн түншлэлийн стандартууд (ХТС)-тай холбогдох нь

Усаар хангах нь мал аж ахуйд суурилсан онцгой байдлын үед авах бусад арга хэмжээний нэмэлт юм. Энэ нь ялангуяа малыг тэжээлээр хангах болон, малын тоо толгойг бууруулах үйл ажиллагаатай ихээхэн хамаатай. Гамшгаас үлдсэн нөөц буюу малыг аврахын тулд ус, тэжээл өгдөг. Нэг үйл ажиллагаагаар нөгөөг нь алдагдуулахгүйн тулд санаачлага болон



агентлаг хоорондын уялдаа холбоо нь чухал юм. Газар тариалангийн усны хэрэгцээг зохицуулах шаардлагатай байж болно (SEADS-ийг үзнэ үү). Мөн малыг усаар хангах нь хүний усны хангамжид нэмэлт болж болно. Энэ нь ялангуяа усны эх үүсвэрийг сэргээн засварлах болон шинээр байгуулах үйл ажиллагааны хүрээнд мал амьтан, хүний аль алинд нь тохирсон чанартай усаар хангагдсан тохиолдолд хамаарна. Харин үүний эсрэгээр малыг зөөврийн усаар хангах нь хүн амыг усаар хангах асуудалд зөрчилдөөн үүсгэж болох тул зохицуулалтад анхаарах хэрэгтэй. Хүн амын усан хангамжийн талаарх нэмэлт мэдээллийг Sphere гарын авлагын «Усан хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйг дэмжих» сэдэвт бүлгээс үзнэ үү. Хүн амын усны нөөцийг мал амьтан бохирдуулахгүй байхаар зохицуулалт хийх шаардлагатай. Хүн ба малын усан хангамжийн уялдаа холбоог хангах хэрэгцээ нь орон зай, усны эх үүсвэр хоёулаа хязгаарлагдмал байж болох бааз (кемп)-ын нөхцөлд онцгой чухал болж магадгүй юм (*Бүлэг 7: Малын байр, байршуулалт* хэсгийг үзнэ үү).

LEGS-н зарчмууд болон бусад анхаарах асуудлууд

Хүснэгт 5.3: LEGS зарчмууд болон усан хангамжийн хамаарал

LEGS-н зарчмууд	Эдгээр зарчмууд болон усан хангамжийн хамаарлын жишээ
1. Амьжиргаанд суурилсан хөтөлбөрийг дэмжих	Усан хангамж нь малын хорогдлоос хамгаалахад чухал үүрэгтэй. Малын ашиг шимийг зөвхөн усаар тогтмол хангаж байж хүртэх боломжтой. Онцгой байдлын улмаас үүссэн ус хангамжийн доголдол, тасалдал нь эрсдэлтэй гэр бүлийн орлого, амьжиргаанд нөлөөлдөг бөгөөд хот, хөдөө, бэлчээрийн мал аж ахуйн болон жижиг аж ахуйн үйлдвэрлэлд мөн адил ялгаагүй нөлөөлдөг.
2. Олон нийтийн оролцоог хангах	Олон нийтийн идэвхтэй оролцоо нь давхаргын ялгавартай байдлаас үүсэх эрсдэлээс сэргийлэхэд тусалдаг (жишээлбэл, илүү баян хэсэг нь өөрийн малыг усаар хангах). Ингэснээр бүх нийгмийн бүлгүүдэд ус тэгш хүртээмжтэй байх боломжийг олгодог.

Үргэлжлэл дараагийн хуудсанд



LEGS-н зарчмууд	Эдгээр зарчмууд болон усан хангамжийн хамаарлын жишээ
2. Олон нийтийн оролцоог хангах (Үргэлжлэл)	Усны менежментийн хороод нь усан хангамжийн зохистой шийдлүүдийг тодорхойлоход тусална. Тухайн хороодод бүх нийгэм, жэндэр, баялгийн бүх бүлгүүд болон хувийн усны бизнесийг удирддаг хүмүүс багтах ёстой. Ингэснээр хямралд өртсөн бүх дэд бүлэг болон эрсдэлтэй бүлгүүдэд шударга хандах боломжийг хангаж чадна. Мөн хороод нь үйл ажиллагааны зардлыг хуваах боломжийг олгодог (Хавсралт 5.3-ыг үзнэ үү).
3. Уур амьсгалын өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх, байгаль орчныг хамгаалах	Хэт их ус ашиглалтаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Байгаль орчныг сүйтгэхээс сэргийлэхийн тулд байнгын усны шинэ цэгүүдийг сайтар төлөвлөх шаардлагатай. Бэлэн байдлын үйл ажиллагаа нь уур амьсгалын чиг хандлагыг харгалзан үзсэн ус хангамжийн хувилбаруудын техник, эдийн засаг, нийгмийн зөв үнэлгээг багтаасан байх ёстой.
4. Бэлэн байдал, эрт үеийн арга хэмжээг дэмжих	Бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны нэг хэсэг болох уст цэгийг сэргээн засварлах нь онцгой байдлын үед өртөж болзошгүй нийгмийн бүлэгт дэмжлэг болдог. Онцгой байдлын үеийн усны бодлогыг орон нутгийн засаг захиргаатай хамтран боловсруулсан усны хөгжлийн урт хугацааны төлөвлөгөөнд нэгтгэх нь гамшгийн эрсдэлийг бууруулахтай (DRR) уялддаг. Усны эх үүсвэрийн менежментийн удирдамж/сургалт нь олон нийтийг онцгой байдлын үед илүү сайн бэлтгэхэд тусалж чадна.
5. Зохицуулалттай хариу үйлдлээр хангах	Тэжээл өгөх, мал эмнэлгийн тусламж үзүүлэх, малын тоо толгойг бууруулах зэрэг бусад арга хэмжээнүүдтэй нэгэн зэрэг усаар хангах боломжтой. Эдгээр үйл ажиллагаа нь бие биенээ нөхөж, үр дүнг бууруулахгүй байлгахын тулд зөв зохицуулалт чухал юм. Хүн, малын хэрэгцээний аль алийг нь хангахын тулд зөв зохицуулалт хийх нь онцгой чухал юм. Өвчний тархалтыг хязгаарлах, түүний дотор зоонозын аюул, зэрлэг амьтанд эсвэл амьтнаас халдварлахыг хязгаарлахын тулд хүний ашигладаг усны нөөцийг мал бохирдуулах ёсгүй.

Үргэлжлэл дараагийн хуудсанд



LEGS-н зарчмууд	Эдгээр зарчмууд болон усан хангамжийн хамаарлын жишээ
6. Жендэрийн мэдрэмжтэй хөтөлбөрийг дэмжих	Мал бол эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн амьжиргаанд чухал ач холбогдолтой. Тиймээс орон нутгийн түвшинд устай холбоотой бүх менежмент дэх тэдний оролцоо нь зохих хариу арга хэмжээ авч, усны шударга хуваарилалтаар хангахад эерэгээр нөлөөлнө. Усны цэг хол зайтай байх нь ялангуяа хүчирхийллийн халдлагад өртөх зэргээр эмэгтэйчүүд, хүүхдүүдэд болзошгүй эрсдэл, заналхийллийг бий болгодог. Хамгаалалтын механизмын (жишээлбэл, хамтран ус авах, гэрэлтүүлэг, хамгаалалт гэх мэт) тусламжтайгаар эдгээрээс сэргийлэх хэрэгтэй. Онцгой байдал эсвэл хямралын үед жендэрийн үүрэг, ялангуяа нийгмийн ядуу гишүүдийн хувьд өөрчлөгдөж магадгүй (жишээ нь, усны хүртээмж илүү хязгаарлагдмал байх). Боломжит тэгш бус байдлыг арилгахын тулд эдгээр өөрчлөлт, үр дагаврыг ойлгох шаардлагатай.
7. Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих	Хүмүүнлэгийн хариу арга хэмжээний орон нутгийн өөриймшүүлэх (удирдах, эзэмших) чадварыг бэхжүүлэх нь усаар хангах, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах, элэн байдлыг хангахтай холбоотой усны менежментийн хороод болон бусад орон нутгийн санаачлага зэрэг одоо байгаа бүтцийг тодорхойлох явдал юм. Газар өмчлөл, үндэс угсаа, орон нутгийн бодлого нь усны хүртээмжид нөлөөлж болзошгүй. Уст цэгийн менежмент, мөргөлдөөнөөс зайлсхийх талаар тухайн орон нутгийн мэдлэгийг ашиглах нь нарийн төвөгтэй эсвэл олон давтагдах хямралд өртсөн орон нутгийн иргэдэд онцгой чухал юм. Усны эх үүсвэр ба байгалийн нөөцийн менежментийн хоорондын хамаарал болон бусад холбогдох соёлын зан үйлийн талаарх уламжлалт мэдлэгийг орон нутгийн удирдлагаар дамжуулан хамгийн сайн ойлгох боломжтой. Орон нутгийн усны хороод болон иргэдийн мөнгөн хандив нь аливаа усны нөөцийг бий болгох, засварлах, удирдах зардлыг урт хугацаанд шийдвэрлэхэд тусална.

Үргэлжлэл дараагийн хуудсанд



LEGS-н зарчмууд	Эдгээр зарчмууд болон усан хангамжийн хамаарлын жишээ
8. Хяналт, үнэлгээ, хариуцлагатай байдал, суралцах (ХҮХС)-г баримтлах	Усны схемд хяналт тавих нь эрсдэлт бүлгийн хүмүүст тэгш хүртээмжтэй байх, зардлыг боломжит түвшинд барихад чухал ач холбогдолтой юм. Үүний нэгэн адил усны менежментийн тогтолцоонд хяналт тавих нь хэрэгжүүлэгч агентлагуудад тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг шийдвэрлэх боломжийг олгоно. Усны хомсдолыг нөхөн сэргээх схем хэрхэн ажиллаж байгааг үнэлэх нь урт хугацааны шийдлийг бэхжүүлэхэд хүргэдэг. Усны салбар дахь хүмүүнлэгийн болон хөгжлийн оролцогчидтой төлөвлөгөөт болон төлөвлөөгүй үр дагаврын талаар олж мэдсэн зүйлээ хуваалцах нь хариуцлагатай байдлыг сайжруулах, урт хугацааны стратеги боловсруулахад тусалдаг

Аюулгүй байдал ба зөрчилдөөн

Ус хэрэглэгчдийн хувийн аюулгүй байдал, хамгааллын асуудал нь онцгой байдлын үед “усаар хангах” үйл ажиллагааны бүх хувилбарт чухал анхаарах зүйл юм (*Бүлэг 1: Хайрцаг 1.3, Хамгааллын зарчмуудыг* үзнэ үү). Жишээлбэл, онцгой байдлын үед ус түгээх цэг дээр мал усалдаг хүмүүс, ялангуяа эмэгтэйчүүд малын хулгай, дээрэм, халдлагад өртөх эрсдэлтэй байдаг. Уст цэгүүд нь халдлагад өртөмтгий, маш мэдрэмтгий байж болох тул зарим тохиолдолд тусгайлан хамгаалах ёстой. Мөргөлдөөний үед худаг, усалгааны цэгүүд нь хорт бодис, амьтны сэг зэмээр зориудаар бохирдох; цооног болон гүний худаг нь зориудаар чулуугаар дүүргэгдэх магадлалтай.

Байгалийн усны олон цэгүүд нь тэдний менежментийг хариуцдаг урьд өмнө нь байсан уламжлалт хэрэглэгчид, байгууллагуудтай байдаг. Хэрэв яаралтай тусламжийн арга хэмжээнд одоо байгаа усны менежментийн бүтцийг оролцуулж чадахгүй бол энэ нь одоо байгаа болон шинэ ус хэрэглэгчдийн хооронд маргаан үүсгэж болзошгүй. Өмчлөлийн зөрчилдөөнөөс зайлсхийхийн тулд уст цэгүүдийг сэргээн засварлах, байгуулахаас өмнө болзошгүй асуудлуудыг тодорхойлох шаардлагатай. Энэ нь ирээдүйд тэгш хүртээмжтэй, тогтвортой тогтолцоог хангах болно

Усны зөрчилдөөн нь суурин болон хуаранд онцгой эмзэг байдаг (*Бүлэг 7: Малын байр, байршуулалт*-ыг үзнэ үү). Суурингийн гаднах уст цэгээс малаа услах шаардлагатай бааз (хуаран)-ын оршин суугчид нь зочин буюу гаднаас ирсэн хүн амтай зөрчилдөж болзошгүй. Бүх оролцогч талуудтай эрт хэлэлцээ хийх нь болзошгүй зөрчилдөөнийг багасгахад тусална.





Усаар хангах хувилбаруудын шийдвэрийн мод

Шийдвэрийн мод (Зураг 5.1) нь яаралтай усаар хангах арга хэмжээний хамгийн боломжит, тохиромжтой хувилбарыг тодорхойлоход анхаарах зарим гол асуултуудыг нэгтгэн харуулсан. Дараах стандартууд, үндсэн үйл ажиллагаанууд болон зааварчилгаанууд нь нарийвчилсан төлөвлөлтөд илүү их мэдээлэл өгдөг. Боломжтой бол эдгээр нь онцгой байдал эхлэхээс өмнө «хэвийн» үед хийгдсэн бэлэн байдлын үйл ажиллагаанд тулгуурлах



Бүдүүвч 5.1: Усаар хангах хувилбаруудын шийдвэрийн мод







Стандартууд

Усаар хангах ажлыг эхлүүлэхийн өмнө *Зураг 5.1-д* үзүүлсэн шиг техникийн янз бүрийн хувилбаруудын хэрэгжих боломжтой эсэхийг сайтар судлах хэрэгтэй.

Стандарт 1: Бэлэн байдал

Бэлэн байдлыг хангах арга хэмжээ нь онцгой байдлын үед мал сүргийг тогтвортой, тохиромжтой байдлаар усаар хангах төлөвлөгөө боловсруулахад тусалдаг.

Үндсэн үйл ажиллагаа

- Ашигладаг болон ашигладаггүй усны эх үүсвэрүүдийн байршлын зураглал гаргаж, хүчин чадлыг нь хэмжин тэмдэглэх (*Зааварчилгаа 1-ийг үзнэ үү*).
- Одоо ашиглаж буй усны менежментийн системийг тодорхойлох (*Зааварчилгаа 2-ыг үзнэ үү*).
- Одоо байгаа усны эх үүсвэрээс үргэлжлүүлэн ус авч ашиглах эсвэл усны ашиглалтыг нэмэх нь одоо болон ирээдүйд байгаль орчинд хэрхэн нөлөөлөхийг үнэлэх. (*Зааварчилгаа 3-ыг үзнэ үү*).
- Усны салбарт хэрэгжиж буй төслүүдийн талаар мэдээлэл цуглуулах, онцгой байдлын үеийн усны менежментийн стратегийг урт хугацааны үйл ажиллагаатай хэрхэн уялдуулж болох талаар судлах (*Зааварчилгаа 4-ыг үзнэ үү*).

5

Зааварчилгаа

1. Усны эх үүсвэр, хүчин чадлын зураглал гаргах

Одоо байгаа (болон ашигладаггүй) усны эх үүсвэрийн байршил, “ердийн” үеийн хүчин чадал зэрэг шаардлагатай мэдээлэл цуглуулна. Боломжтой бол усны чанарын талаар мэдээлэл цуглуулах хэрэгтэй. Холбогдох байгууллагууд, ялангуяа урт хугацааны усны төсөл хэрэгжүүлдэг байгууллагууд ийм мэдээлэлтэй байж магадгүй юм. Энэхүү мэдээлэл нь онцгой байдлыг үнэлэх болон хариу арга хэмжээг төлөвлөхөд тусалдаг (*Стандарт 2-ыг үзнэ үү*).

2. Одоогийн байгаа усны менежментийн системийг үнэлэх

Ус бол өргөн тархсан байгалийн нөөц. Усыг хүн ам, мал амьтан, газар тариаланд ашиглахад тодорхой менежмент шаардлагатай. Үүнд ус ашиглах хугацаа, усыг тэгш хуваарилах, усны дэд бүтцийн засвар үйлчилгээ, эрүүл ахуйг хангах зэрэг арга хэмжээ орно.



Цооног, цөөрөм, далан, усан сан, гадаргын болон гүний худаг нь ихэвчлэн орон нутгийн (уламжлалт) харьяанд байдаг. Аливаа тохиромжтой, боломжтой үед энэхүү уламжлалт менежментийн тогтолцоонд үндэслэн онцгой байдалд ус түгээх нь илүү үр дүнтэй. Тиймээс энэхүү уламжлалт тогтолцоог урьдчилан тодорхойлох нь онцгой байдлын хариу арга хэмжээ төлөвлөхөд маш чухал юм.

Нийгмийн тогтворгүй байдал үүсэх өндөр магадлалтай бүс нутагт нийгэмд сөрөг нөлөө үзүүлдэг усны асуудал байгаа эсэхийг бэлэн байдлын хариу арга хэмжээний хүрээнд судалж, нийгмийн хурцадмал байдлыг бууруулах шийдлүүдийг тодорхойлох боломж олгоно. Тухайлбал, олон нийтэд тулгуурласан зөрчилдөөнийг шийдвэрлэх механизм гэх мэт.

3. Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Хэрэв усны эх үүсвэрийг их хэмжээгээр ашиглах нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа бол онцгой байдлын үед усны хэрэглээ нэмэгдэж, байдал улам хүндэрнэ. Эмзэг байршлын талаар зохих мэдээлэлтэй байх нь цаашид усны хэрэглээний улмаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад тусална.

Үнэлгээ хийхдээ усны шинэ эх үүсвэрийн байршил, хүчин чадал нь байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгааг судлах хэрэгтэй, учир нь усны шинэ эх үүсвэрийн байршил нь байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Нөгөө талаас, байгалийн нөөцийн менежментийн стратегийн дагуу уст цэгүүдийн байршлыг төлөвлөвөл байгаль орчин, мал амьтны хэрэглэж буй байгалийн нөөцөд эерэг нөлөө үзүүлэх боломж бий.

4. Усан хангамж хөгжүүлэх

Усны эх үүсвэрийг хөгжүүлэх, тухайлбал, усны дэд бүтцийг барьж байгуулах, сэргээн засварлах нь ерөнхийдөө урт хугацааны бүтээн байгуулалт юм. Боломжтой бол хөгжлийн агентлагууд онцгой үед усаар хангах төлөвлөгөөг эдгээр урт хугацааны хөтөлбөрүүдэд тусгаж болно. Онцгой үед усан хангамжийг хурдан төлөвлөж хэрэгжүүлэхийн тулд төсвөө зөв хуваарилах, санхүүжилтийн уян хатан бодлого хэрэгжүүлэх гэсэн аргуудыг хэрэглэж болно. Уст цэгүүдийг хөгжүүлэх нь олон янзын бүлгүүдийн (жишээлбэл, малчид, тариаланчид гэх мэт) хамтын ажиллагааг бэхжүүлэх боломж олгодог. Учир нь тэд өөрсдийн усны хэрэгцээг хангахын тулд хамтран ажилладаг.



Стандарт 2: Үнэлгээ ба төлөвлөлт

Усны хэрэгцээ, боломжийг судалж, орон нутгийн усны менежментийн систем дээр тулгуурлан мал амьтны усан хангамжийг тодорхойлно.

Үндсэн үйл ажиллагаа

- Бэлэн байдлын үйл ажиллагаан дээр тулгуурлан (*Стандарт 1-ийг үзнэ үү*), усаар хангах үндсэн бүтцийг бий болгох хувилбаруудад дүн шинжилгээ хийх (*Зааварчилгаа 1-ийг үзнэ үү*)
- Одоо ашиглаж байгаа болон доройтсон усны эх үүсвэрүүдийн усны чанарыг үнэлэх (*Зааварчилгаа 2, 3-ыг үзнэ үү*).
- Одоо үйлчилж байгаа менежментийн систем эсвэл илүү үр ашигтай менежментийн шинэ тогтолцоог тодорхойлох. Ингэснээр аливаа зөрчилдөөн гаргахгүйгээр, боломжийн чанартай усыг тасралтгүй нийлүүлж, эрсдэлтэй бүлгүүдийг оролцуулан бүх хэрэглэгчдийн хэрэгцээг хангах болно (*Зааварчилгаа 4-ийг үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Одоо байгаа усны эх үүсвэрүүдийг ашиглах хувилбаруудыг судлах

Усаар хангах үйл ажиллагааг төлөвлөхдөө эхлээд одоо байгаа усны эх үүсвэрүүдийн үнэлгээг холбогдох талуудын идэвхтэй оролцоотой хийж, усны хүртээмж, үйлчилгээний үнэ ханш, чанарыг судална.

Энэхүү олон нийтийн оролцоотой хийгдсэн үнэлгээнд доройтсон, ашиглах боломжгүй болсон усны эх үүсвэрүүдийг хамруулах хэрэгтэй. Үнэлгээнд ядуу, эрсдэлтэй өрхүүдийн усны хүртээмжид анхаарлаа хандуулна. Бэлэн байдлын төлөвлөлт хийгдсэн бол энэ мэдээлэл аль хэдийн бэлэн болсон байж магадгүй юм (*Стандарт 1-ийг үзнэ үү*).

Хүн амын ундны усны хэрэгцээг энэхүү анхан шатны судалгаанд мөн хамруулах хэрэгтэй.

Мал сүргээ усны өөр эх үүсвэр рүү нүүлгэх шийдвэр гаргахаас өмнө нүүлгэх зардал, тэнд байгаа ус хангамж (бэлчээр, өвс тэжээл)-ийг тооцоолох, мөн тухайн усны эх үүсвэрийн бусад хэрэглэгчид нэмж мал амьтан хүлээн авах хүсэлтэй байгаа эсэхийг судлах хэрэгтэй.

Бусад уст цэгээс ус зөөвөрлөх нь маш өндөр зардалтай. Тиймээс эхлээд бусад хувилбаруудыг судалж үзсэний дараа хамгийн сүүлд нь ус зөөвөрлөх хувилбар руу анхаарлаа хандуулаарай. (*Хавсралт 5.1: Уст цэгүүдийн үнэлгээний шалгах хуудас*).



2. Мал амьтанд зориулсан усны чанар

Мал амьтны усны чанарын асуудал ерөнхийдөө хүн амын усны чанарын асуудлыг бодвол чухлаар тавигддаггүй хэдий ч эрдэс бодис ихтэй ус хэрэглэх нь малын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй, мөн усаар дамжин сальмонелла, боом, колибациллус зэрэг өвчин халдварлана.

Хээрийн нөхцөлд усны бичил биетний бохирдлыг тодорхойлох боломж байхгүй бол үндсэн шинжилгээ хийхийг зөвлөдөг. Үндсэн шинжилгээний хүрээнд химийн бохирдол (ойролцоох үйлдвэрүүд) болон бактериологийн/органик бохирдлыг (суурин газрууд) шинжилж, орон нутгийн иргэдтэй зөвлөлддөг. (*Хавсралт 5.1: “Уст цэгүүдийн үнэлгээний шалгах хуудас”, НҮБ-ын ХХААБ-ын гарын авлагын усны чанар хэсгийг үзнэ үү (2016, х. 112).*

3. Хүн амын үндны усны эх үүсвэрийн бохирдол

Хүн, мал, амьтан нь усны нэг эх үүсвэрээс ундаалдаг бол ус нь мал амьтны ялгадсаар амархан бохирдож, хүний эрүүл мэндэд нөлөөлнө. Ус бохирдохоос сэргийлж мал амьтныг усны тэвшээр эсвэл саваар услах гэх мэт энгийн аргыг юуны өмнө хэрэглэнэ. Мөн мал амьтанд хэрэглэдэг акарицид (**acaricides**) болон бусад химийн бодисоор усыг бохирдуулахаас сэргийлэхийн тулд усны эх үүсвэрийг хамгаалах шаардлага гарч болно.

4. Усны менежментийн систем

“Ердийн үед” ус ашиглах, усны эх үүсвэрийг арчлах ажлыг зохион байгуулах олон уламжлалт аргууд байдаг. (*Стандарт 1, Зааварчилгаа 2-ыг үзнэ үү*). Одоо байгаа усны эх үүсвэрийг сэргээн засварлах, шинэ эх үүсвэр байгуулахад энэхүү уламжлалт менежментийн тогтолцоог харгалзан үзэх ёстой. Харин онцгой байдлын үед уламжлалт аргаар гэнэтийн болон удаан явцтай гамшгаас хамгаалах боломжгүй байж болно. Тиймээс байгууллагууд гаднаас тусламж, дэмжлэг үзүүлэх шаардлага гарч магадгүй.

Зарим нийгэмд байдаг уламжлал, хязгаарлалтын улмаас өөр угсаатны болон нийгмийн бүлгүүд хамтран нэг уст цэгийг ашиглахад хүндрэл учирдаг. Эдгээр асуудлуудад мэдрэмжтэй хандах хэрэгтэй бөгөөд хариу арга хэмжээ нь бүх хүмүүсийг уст цэгийг ижил тэгш ашиглах боломжоор хангахад чиглэгдсэн байх ёстой. Усны хэрэглээг тогтвортой, ижил тэгш хэвшүүлж, бэхжүүлэхийн тулд LEGS-н *6-р зарчим*: *«Жендэрийн мэдрэмжтэй хөтөлбөрүүд»*-ийг хэрэгжүүлэхийг санал болгож байна. Шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийг оролцуулах нь олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, эмзэг бүлгийн эрх ашгийг хамгаалахад хувь нэмэр оруулдаг.



Стандарт 3: Уст цэгүүдийн байршил

Сэргээн засварласан болон шинээр байгуулагдсан усны эх үүсвэрүүд нь онцгой байдал, гамшигт нэрвэгдсэн бүсэд оршин сууж буй, хамгийн эрсдэл бүхий ихэнх өрхүүдийн малыг ижил тэгш усаар хангах боломжтой газар байрласан байна.

Үндсэн үйл ажиллагаа

- Одоогийн болон ирээдүйн эрэлт хэрэгцээн дээр тулгуурлан сэргээн засварлах болон шинээр байгуулах уст цэгүүдийн байршлыг сонгоно. Сонголт хийхдээ орон нутгийн иргэд болон мал амьтны эрэлт хэрэгцээг харгалзан үзэх ёстой (*Зааварчилгаа 1-ийг үзнэ үү*).
- Ашиглах усны эх үүсвэр нь онцгой байдлын үед болон түүнээс хойшхи хугацаанд хэрэгцээг хангах хүчин чадалтай байх ёстой (*Зааварчилгаа 2-ыг үзнэ үү*).
- Уст цэгүүдийн байршлыг төлөвлөхдөө аюулгүй байдлыг харгалзан үзэх (*Зааварчилгаа 3-ыг үзнэ үү*).
- Одоо байгаа уламжлалт усны менежментийн систем дээр тулгуурлан нутгийн иргэд, удирдагчидтай (эрэгтэй, эмэгтэй) хамтран уст цэгүүдийн байршлыг сонгох ажлыг зохион байгуулах (*Зааварчилгаа 4-ийг үзнэ үү*).

Зааварчилгаа

5

1. Усны хэрэгцээний үнэлгээ

Онцгой байдлын үеийн усны хэрэгцээний үнэлгээг малын тооллого, орон нутгийн захиргааны бүртгэл, гамшигт өртсөн нутгийн иргэдтэй зөвлөлдсөний үндсэн дээр хийнэ. Үнэлгээ хийхдээ мал амьтан, хүн амын уст цэгт хүрэх, ашиглах байдлыг харгалзан үзнэ.

Жишээлбэл, хэрэв мал амьтан уст цэг дээр ундаалдаг бол уст цэг хүртэл малын туулах зайг үнэлгээний явцад тооцоолно. Мөн усны онгоцны тоо, услах хуваарь, мал амьтанг хүлээлгэх газар, хүлээх хугацааг анхааралдаа авна. Хэрэв тухайн мал амьтан байрлаж байгаа газарт усыг зөөвөрлөж, малаа услах гэж байгаа бол мөн адилхан үнэлгээ хийнэ.

2. Усны хүрэлцээг хангах

Уст цэг нь төлөвлөсөн хэрэгцээг хангаж чадахгүй бол нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай. (Тухайлбал, нэмэлт уст цэгүүдийг байгуулах эсвэл машинаар ус зөөвөрлөх зэрэг). Усаар хангах аргуудыг үнэлэхдээ уст цэгүүдийн ирээдүйн үр ашгийг давхар үнэлнэ. Энэ нь ердийн болон онцгой байдлын үед аль алинд нь хамаарна.



3. Аюулгүй байдал

Малаа уст цэгт туун ирж услах гэж буй хүмүүс малын хулгай, дээрэм болон хувийн халдлагад өртөх эрсдэлд ордог. Учир нь тэдний хөдөлгөөнийг урьдчилан таамаглахад хялбар байдаг. Ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийн аюулгүй байдал онцгой анхаарал шаарддаг. Уст цэгийн байршлыг тодорхойлохдоо гамшигт өртсөн бүс нутгийн аюулгүй байдлыг хариуцдаг байгууллагуудтай холбоо тогтоох шаардлагатай. Эдгээр байгууллагууд зөрчилдөөнөөс сэргийлэх болон бусад аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх чадвартай байдаг.

4. Орон нутгийн манлайлал

Стандарт 1: "Бэлэн байдал" ба Стандарт 2: "Үнэлгээ ба төлөвлөлт"-д онцлон тэмдэглэснээр уст цэгийн байршлыг сонгохдоо орон нутгийн усны менежментийн системийг ашиглах нь зүйтэй. Энэ нь одоо байгаа уст цэгүүдийг сэргээн засварлах, мөн шинээр уст цэг байгуулах зэрэгт аль алинд нь хамаарна. Онцгой байдал болон ердийн үед усны эх үүсвэрийг тогтмол арчлахад орон нутгийн удирдагчид чухал үүрэг гүйцэтгэнэ. Ингэснээр орон нутгийн иргэд усыг тогтвортой, тэгш эрхтэй хэрэглэх нөхцөл бүрдэнэ. Ялангуяа хуарангийн оршин суугчид болон орон нутгийн иргэдийн хооронд усны төлөөх өрсөлдөөн гарч болзошгүй тул энэ асуудалд онцгой анхаардаг. Ийм нөхцөлд орон нутгийн удирдагчидтай зөвшилцөж, тохиролцох нь асуудлыг шийдэхэд чухал ач холбогдолтой юм.

Стандарт 4: Уст цэгүүдийг сэргээн засварлах, шинээр байгуулах

Сэргээгдсэн эсвэл шинээр байгуулагдсан уст цэгүүд нь малыг зохих хэмжээгээр цэвэр усаар хангах, зардал багатай, тогтвортой арга хэрэгсэл юм.

Үндсэн үйл ажиллагаа

- Хэрвээ гамшигт өртсөн бүс нутгийн хэрэгцээг одоо байгаа уст цэгүүдийн ашиглалтыг нэмэгдүүлэх замаар хангах боломжгүй бол эдгээр уст цэгүүдийг сэргээн засварлах боломжийг судалж болно (*Заварчилгаа 1-ийг үзнэ үү*).
- Усны хэрэгцээ нэмэгдэж байгаа болон нэмэгдэх төлөвтэй, гамшигт өртсөн бүс нутаг дахь доройтсон бүх уст цэгүүдийг судлах, доройтсон шалтгааныг олох (*Заварчилгаа 2-ыг үзнэ үү*).
- Одоо байгаа уст цэгүүдийг ашиглах, эсвэл сэргээн засварлах боломжгүй бол үр дагаврыг нь сайтар тооцоолсны үндсэн дээр шинээр уст цэг байгуулах талаар судалж болно (*Заварчилгаа 3-ыг үзнэ үү*).



- Сонгосон газруудад уст цэг сэргээн засварлах/шинээр байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах техникийн орц, материалыг хүргэнэ (*Зааварчилгаа 4-ийг үзнэ үү*).
- Гадны байгууллагууд болон гамшигт өртсөн иргэдийн хооронд зардал хуваалцахыг дэмжсэн санаачлагуудыг хэрэгжүүлэх талаар судална (*Зааварчилгаа 5-ыг үзнэ үү*).
- Уст цэгүүдийн ажиллагаа, засвар үйлчилгээг хариуцах хүмүүсийг сургаж, бэлтгэх (*Зааварчилгаа 6-г үзнэ үү*).
- Орон нутгийн удирдагчдын дэмжлэгтэйгээр тогтвортой менежментийн бүтцийг бий болгох (*Зааварчилгаа 7-г үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Уст цэгүүдийг сэргээн засварлах хэрэгцээг батлах

Гамшигт өртсөн иргэдэд зориулж уст цэгүүдийн ашиглалтыг уртасгах нь уст цэгийг сэргээн засварлахаас хамаагүй хямд юм. Гэсэн хэдий ч төлөвлөлтийн үе шатанд одоогийн болон шинэ хэрэглэгчдийн хооронд зөрчилдөөн үүсэх боломжийг сайтар судлах нь чухал юм. Бодит амьдрал дээр одоо байгаа усны эх үүсвэрийг ашиглан гамшигт өртсөн иргэдэд усаар хэсэгчлэн үйлчлэх боломж байгаа. Гэхдээ үүнээс гадна эдгээр уст цэгүүдийг сэргээн засварлах шаардлага гарч магадгүй.

2. Сэргээн засварлахад тохиромжтой уст цэгүүдийг тодорхойлох

Цогц судалгаа хийх нь бага зардлаар уст цэг байгуулах хөтөлбөрийн эхний алхам юм. Уст цэг бүрийн хувьд дараах мэдээлэл цуглуулсан байх ёстой:

- Усны чанар
- Уст цэгүүдийг сэргээн засварлах хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц бололцоо
- Уст цэгийн хүчин чадал (тоо хэмжээ, тогтвортой ажиллах бололцоо).
- Эвдрэлийн хувь хэмжээ, засварлах боломж/ засварын зардал
- Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ
- Уст цэг доройтсоны шалтгаан, уст цэгийг сэргээн засварласан тохиолдолд гарах үр нөлөө (үймээн самуун, усны чанар, өмчлөл зэрэг асуудлууд уст цэг ашиглагдахгүй байх, техникийн болон засвар үйлчилгээний асуудал гарахад нөлөөлдөг).

3. Уст цэгүүдийг шинээр байгуулах хэрэгцээг батлах

Хэрвээ сэргээн засварласан уст цэгүүд гамшигт нэрвэгдсэн иргэдийг хангалттай усаар хангах боломжгүй бол шинээр уст цэг байгуулах шаардлага гарна. Уст цэг шинээр байгуулахад дараах сөрөг үр дагавар гарах боломжтой: жишээлбэл, газрын маргаан, бэлчээх замыг өөрчлөх,



байгаль орчны доройтол, байгалийн нөөцийн төлөөх өрсөлдөөн гэх мэт. Эдгээр үр дагаврыг сайтар судлах хэрэгтэй.

4. Хувилбаруудын техникийн боломж

Уст цэгүүдийг ашиглахаа больсон шалтгааныг ойлгох нь сэргээн засварлах ажлын техникийн үнэлгээ хийхэд тусална. Сэргээн засварлах ажлын бусад шаардлагууд:

- Сэргээн засварлах ажлыг гүйцэтгэж чадах мэргэжлийн усны инженер, ажилчидтай байх
- Шаардлагатай материалыг уст цэг дээр хүргэх техникийн боломж, зам
- Худаг, усан сангийн сэлбэг хэрэгсэл

Уст цэг шинээр байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж нь нөхөн сэргээж засварлах тоног төхөөрөмжөөс илүү хүнд байх магадлалтай (жишээлбэл, өрөмдлөгийн машин, малталтын төхөөрөмж). Тиймээс илүү өндөр даацтай тээврийн хэрэгсэл, илүү сайн чанартай зам шаардлагатай.

5. Зардлаа нөхөх

Гамшигт нэрвэгдсэн бүс нутагт ус түгээх үйл ажиллагаанд оролцох орон нутгийн иргэдийн чадвар, хүсэл сонирхлыг үнэлэх нь чухал юм. Шийдвэр гаргагчид, орон нутгийн ахмадууд, улс төрийн удирдагчид, ялангуяа нөлөө бүхий эмэгтэй удирдагчдаас иргэдийг онцгой байдлын хариу арга хэмжээнд идэвхтэй оролцохыг уриалахад дэмжлэг хүсэж болно.

6. Үүрэг хариуцлага

- Уст цэгүүдэд байнгын анхаарал, засвар үйлчилгээ шаардлагатай. Түүнчлэн уст цэгүүдэд дараах ажлуудыг гүйцэтгэх хүмүүс (орон нутгийн иргэд эсвэл байгууллагын ажилтнууд) шаардлагатай
- усны чанар, хангамж материалыг тогтмол шалгах
- бүх хэрэглэгчид усыг ижил тэгш ашиглах боломжтой байгаа эсэхийг шалгах
- хэрэглэгчдийн хоорондын маргааныг шийдвэрлэх
- урсгал засвар үйлчилгээ хийх, эвдэрсэн эд ангиудыг шуурхай захиалах, солих ажлыг хариуцах (гар худгууд цооногийг бодвол ерөнхийдөө бага эвдэрдэг)
- орон нутгийн хэрэглэгчдэд зориулж усны бүлэг, хороодыг хамруулсан сургалт зохион байгуулах (Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн хөгжих, нийгэмд илүү идэвхтэй байр суурь эзлэх боломжуудыг хязгаарласан уламжлалт зан үйлийг баримталдаг гэдгийг санаж байгаарай).

7. Удирдлагын бүтэц



Уст цэгүүдийг орон нутгийн иргэд хариуцдаг эсвэл хувийн хэвшлийнхэн эзэмшдэг эсэхээс үл хамааран уст цэг удирдах бүтэц нь орон нутгийн дэмжлэгтэйгээр байгуулагдаж, тогтвортой ажиллах нь илүү чухал юм. Энэ нь онцгой байдлын дараах үед уст цэгийг цаашид ажиллуулах, цаг тухайд нь засвар үйлчилгээ хийхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Мөн орон нутгийн бүх иргэд усыг тогтвортой, ижил тэгш ашиглах боломжоор хангагдана (*Хавсралт 5.3-ыг үзнэ үү*).

Стандарт 5: Зөөвөрлөх усны чанар, эх үүсвэр

Зөөвөрлөх усыг төлөвлөсөн хариу арга хэмжээний хугацаанд чанарын баталгаатай, хангалттай хэмжээнд нийлүүлэх боломжтой эх үүсвэрээс авдаг.

Үндсэн үйл ажиллагаа

- Үнэхээр өөр сонголт байхгүй бол ус зөөвөрлөж болно, гэхдээ энэ бол зөвхөн богино хугацааны шийдэл гэдэгт анхаарна уу (*Зааварчилгаа 1-ийг үзнэ үү*).
- Ус зөөвөрлөх хугацаанд ус хангамжийг тогтвортой байлгана (*Заавар 2-ыг үзнэ үү*).
- Усны эх үүсвэрээс ус зөөвөрлөх тохиолдолд тухайн эх үүсвэрийн хэрэглэгчдэд сөргөөр нөлөөлөхгүй байхыг сайтар шалгана, мөн холбогдох хууль ёсны эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авна (*Зааварчилгаа 2, 3-ыг үзнэ үү*).
- Усны эх үүсвэрийг ашиглах нь орон нутгийн иргэдийн ундны усны хангамжийг бууруулахгүй байхад анхаарлаа хандуулна (*Зааварчилгаа 3, 4-ийг үзнэ үү*).
- Усны чанар мал амьтанд тохирч байгаа эсэхийг шалгана (*Зааварчилгаа 5-ыг үзнэ үү*).
- Ашиглахаас өмнө ус зөөвөрлөх савыг сайтар цэвэрлэсэн эсэхийг шалгана (*Зааварчилгаа 6-г үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Богино хугацааны арга хэмжээ

Ус зөөвөрлөх нь зардал ихтэй, ложистик (тээвэрлэлт)-ийн хувьд хүндрэлтэй учраас зөвхөн мал амьтан үсгүйгээс болж үхэж хорогдох аюул нүүрлэсэн үед л хэрэглэдэг эцсийн арга хэмжээ юм. Хүний ундны усыг ачааны машинаар зөөвөрлөхийг ерөнхийд нь зөвлөдөггүй. Усны эх үүсвэр рүү малыг тууж, ойртуулах зэрэг бусад аргуудыг сайтар судалсны дараа машинаар ус тээвэрлэх шийдвэр гаргана.



2. Тасралтгүй нийлүүлэлт

Хэдийгээр зөвхөн богино хугацаанд ус зөөвөрлөхийг зорьж байгаа боловч, энэ нь үргэлж хийх боломжгүй байдаг. Үйл ажиллагааны нөхцөл байдлаас үл хамааран төлөвлөлтийн үе шатанд усан хангамжийг бодитоор үнэлэх нь чухал юм. Энэхүү үнэлгээний хүрээнд:

- Санал болгож буй усны эх үүсвэрүүдийг онцгой байдлын үед усыг тогтвортой нийлүүлэх хүчин чадалтай эсэхийг үнэлнэ. Түүнчлэн, онцгой нөхцөл байдал гүнзгийрэх бол эдгээр усны эх үүсвэрт хэрхэн нөлөөлөхийг судлах хэрэгтэй.
- Хэрэглэгчдээс эсвэл холбогдох эрх бүхий байгууллагуудаас усны эх үүсвэрийг ашиглах зөвшөөрөл авах.
- Усны эх үүсвэрт найдвартай хүрч чадах эсэхийг тодорхойлох; жишээлбэл, ачааны машинууд уст цэгт хүрэх замыг эвдлэх эрсдэл өндөр байдаг.
- Ус тээвэрлэх зардал ихэвчлэн өндөр байдаг, тиймээс төсвөө зөв төлөвлөөрэй. Хэрэв бусад хариу арга хэмжээг хэрэгжүүлэх нь хойшлогдвол, зөөврийн үйлчилгээг үргэлжлүүлэх санхүүжилт хангалттай байх ёстой. Усны эх үүсвэр нь ус түгээх цэгүүдтэй ойролцоо байрладаг бол зардал мэдэгдэхүйц буурна. Харин энэ тохиолдолд одооны хэрэглэгчидтэй зөрчилдөх эсвэл нийлүүлэлт тасрах зэрэг эрсдлүүд гарч болно.

3. Одооны хэрэглэгчдийн хэрэгцээг судлах

Усны эх үүсвэрүүд ихэвчлэн хэрэглэгчидтэй байдаг. Эдгээр хэрэглэгчидтэй зөрчилдөх нь үйл ажиллагаанд ноцтой хохирол учруулж, сөрөг нөлөөнд өртсөн иргэдийн тоо нэмэгдэх магадлалтай. Усны эх үүсвэр нь ус түгээх цэгүүдтэй ойрхон байрлах нь санхүүгийн хувьд ашигтай байж болох юм. Гэхдээ энэ нь одоогийн хэрэглэгчдэд ус авах хүндрэл учруулж болохгүй. Ус зөөвөрлөх ажлыг төлөвлөх үе шатанд төслийн менежерүүд орон нутгийн манлайлагч нар болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллаж, одоогийн хэрэглэгчдийн асуудалд зохих анхаарлаа хандуулж, боломжтой бол зөрчилдөөнийг шийдвэрлэх орон нутгийн уламжлалт аргуудыг хэрэглэнэ.

4. Хүн амын эрэлт хэрэгцээтэй уялдуулан ажиллах

Усны хомсдол нүүрлэсэн эсвэл ус зөөвөрлөх боломж хязгаарлагдмал нөхцөлд хүн амын үндсэн хэрэгцээг ямагт нэн тэргүүнд тавих ёстой. Гэсэн хэдий ч хүн, мал амьтны аль алиных нь хэрэгцээг хангах боломжтой. Өргөн хүрээнд тархсан онцгой нөхцөл байдалд тээврийн хэрэгслээр хүн, мал амьтанд аль алинд нь зэрэг үйлчлэх боломжгүй байж болно. Харин орон нутагт жижиг хэмжээнд хүн ам, мал амьтныг усаар хангах нэгдсэн



үйлчилгээ үзүүлэх боломжтой. Ачааны машин, ажиллах хүчин хангалттай байгаа тохиолдолд малын усыг хүний ундны усны чанарын шаардлага хангахгүй эх үүсвэрээс авч болно.

5. Усны чанар

Хүн, мал амьтан аль алинд нь зориулж ус машинаар тээвэрлэж байгаа бол усны чанар Sphere стандартыг хангасан байх ёстой. Хэрэв сайн чанартай усны эх үүсвэр хязгаарлагдмал байгаа бол хүний хэрэгцээнд зориулж техникийн болон эдийн засгийн хувьд цэвэршүүлэх боломжгүй чанар муутай усыг гол мөрөн, нуур, цөөрмөөс авч зөвхөн мал амьтны хэрэгцээнд ашиглаж болно.

6. Ус зөөвөрлөх савны ариун байдал

Усан сан, савыг хортой пестицид, гербицид, уусгагч бодис, түлш, бохир ус зэрэг төрөл бүрийн шингэн тээвэрлэхэд ашиглаж байсан байж болно. Тухайн савыг өмнө нь юуны зориулалтаар ашиглаж байсан нь тодорхой байгаагүй л юм бол бүх сав суулга, төхөөрөмжийг ус зөөвөрлөх ажиллагаанд ашиглахаас өмнө сайтар цэвэрлэж, халдваргүйжүүлсэн байх ёстой.

Стандарт 6: Зөөврийн усны тээвэрлэлт болон түгээлт

Гамшигт өртсөн бүс нутагт усыг найдвартай тээвэрлэж, тэгш хуваарилна.

5

Үндсэн үйл ажиллагаа

- Үр ашигтай хөрөнгө оруулалт, менежментийн үр дүнд хариу арга хэмжээний туршид ажиллах хүчин хангалттай байх ёстой (*Зааварчилгаа 1-ийг үзнэ үү*).
- Усны сав бүхий тээврийн хэрэгсэл, шаардлагатай тоног төхөөрөмжийг түлшээр хангах, засвар үйлчилгээ хийх хангалттай хөрөнгө бэлэн байлгах (*Зааварчилгаа 2-ыг үзнэ үү*).
- Боломжтой бол хүнд ачаатай усны машинуудын хөдөлгөөнд эвдэрдэггүй замыг сонгох (*Заавар 3-ыг үзнэ үү*).
- Ус түгээх цэгүүдийг тохиромжтой байршилд байгуулж, ус түгээх үед гарч болох малын хөдөлгөөнийг зохицуулах (*Зааварчилгаа 4, 5-ыг үзнэ үү*).
- Ус түгээх ажиллагааны аюулгүй байдалд үнэлгээ хийх (*Зааварчилгаа 6-г үзнэ үү*).
- Орон нутгийн иргэдийн онцгой байдлын үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх чадвар болон санхүүгийн татаас авах хэрэгцээг үнэлэх (*Заавар 7-г үзнэ үү*).



Зааварчилгаа

1. Хүний нөөц

Ус зөөвөрлөх үйл ажиллагаа нь ажилтнуудын, ялангуяа чадварлаг, туршлагатай менежер, удирдагч нарын тууштай хөдөлмөр зүтгэл шаарддаг. Жолооч, туслахуудад зохих цалин хөлс, үндсэн хэрэгцээг хангах зардал олгох, хувийн аюулгүй байдал зэрэг бусад хэрэгцээг хангах замаар тогтвортой ажиллах сонирхлыг нь дэмжих нь бас чухал юм.

2. Засвар үйлчилгээ, түлшний хангамж

Мэргэжлийн засварчид, түлш, шаардлагатай тоног төхөөрөмж, материалууд ус зөөвөрлөх бүх хугацаанд найдвартай, тогтмол нийлүүлэгдэж байх шаардлагатай. Үүнд шахуурга, усны сав, ус түгээх төхөөрөмжийг ажиллуулах, засварлахад шаардагдах материалууд багтана. Дараах асуудлуудад гол анхаарлаа хандуулна:

- **Шатахууны үнэ, хангамж:** ер нь жолооч нар гол замаас хазайлгүй шатахуунаа авах боломжтой байвал хамгийн их үр дүнтэй. Гэхдээ энэ тохиолдолд түлшийг тусад нь тээвэрлэх шаардлага гарч, ус зөөвөрлөх ажиллагааны ложистик (Тээвэрлэлт)-ийг хүндрүүлнэ. Усны эх үүсвэрийг сонгоходоо үүнийг анхаарч үзэх хэрэгтэй.
- **Сэлбэг хэрэгсэл:** олдоц сайтай, орон нутагт үйлдвэрлэсэн, засварлахад хялбар байвал илүү тохиромжтой

Эдгээр асуудлууд (ялангуяа засвар үйлчилгээтэй холбоотой) нь ямар төрлийн тээврийн хэрэгслийг (жишээ нь: усны савтай ачааны машин эсвэл тракторын чиргүүл) сонгон ус зөөвөрлөх талаар шийдвэр гаргахад нөлөөлнө.

3. Ус зөөвөрлөх маршрутын бүрэн бүтэн байдлыг хангах

Ус зөөвөрлөх зам нь устай цистернуудийг явахад тохиромжтой байх ёстой. Эсвэл онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөөнд засвар үйлчилгээ хийх зохицуулалтыг тусгасан байх ёстой. Жишээ нь бэлэн мөнгө төлж засвар хийлгэх гэх мэт.

Түүнчлэн ус зөөвөрлөх маршрутын дагуу амьдардаг иргэд ч усны асуудлаа шийдвэрлүүлсэн, төлөвлөгөөтэй танилцсан, баталсан байх ёстой. Үгүй бол тэд зам хаах эсвэл өөрсдийн хэрэгцээг хангахын тулд устай тээврийг өөр тийшээ чиглүүлэх зэрэг саад учруулж болзошгүй юм. Хэрэгжүүлэгч агентлагууд "хор хөнөөл учруулахгүй байх" зарчмуудыг дагаж мөрдөхийн хүрээнд зөрчилдөөн гарах эрсдлийг үнэлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байх ёстой (*Бүлэг 1: "Sphere" хамгаалах зарчмуудын LEGS-н танилцуулгыг үзнэ үү*).



4. Ус түгээх цэгүүдийг зохион байгуулах

Малчид усыг түгээх цэгээс авч зөөвөрлөн малаа услах, эсвэл малаа туун авчирч усны сав эсвэл усан сангаас шууд услах боломжтой. Ямар ч тохиолдолд боломжтой бол орон нутгийн усны менежментийн системд тулгуурлан бүх ус хэрэглэгчдийн хэрэгцээг тэгш, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

Боломжтой газар ус нөөцлөх байгууламж байгуулбал ус зөөвөрлөх ажиллагаанд илүү үр ашигтай байдаг. Учир нь ачааны тэргүүд усаа нөөцлөх цэг дээр хурдан юүлж, олон удаа зөөвөрлөж, ус хүлээх цагийг багасгадаг.

5. Нүүлгэн шилжүүлсэн мал сүрэгт ус зөөвөрлөх

Ган гачигийн үед мал амьтныг нүүлгэн шилжүүлэх нь уламжлалт арга хэмжээ юм. Ийм тохиолдолд ус зөөвөрлөх үйл ажиллагааг нүүлгэн шилжүүлэлттэй уялдуулах шаардлагатай. Энэ нь ачааны машинаар ус зөөвөрлөх ложистикийн ачааллыг ихээхэн нэмнэ.

6. Аюулгүй түгээлтийн сүлжээ байгуулах

Онцгой байдлын хөтөлбөрийн хүрээнд ус зөөвөрлөх үйл ажиллагааг хариуцаж буй ажилтнуудын хувийн аюулгүй байдал нэн тэргүүнд тавигдах ёстой.

7. Бүрэн буюу хэсэгчилсэн татаас олгох

Үнэлгээний хүрээнд орон нутгийн иргэдэд ус зөөвөрлөх зардалд хувь нэмрээ оруулах хүсэл, боломж байгаа эсэхийг судлах хэрэгтэй. Байгууллагууд ус зөөвөрлөх ажлын зардлыг бүрэн хариуцах эсвэл хэсэгчлэн санхүүгийн дэмжлэг олгох шаардлага гарч магадгүй юм.



Хавсралтууд

Хавсралт 5.1: Уст цэгүүдийн үнэлгээний шалгах хуудас

Энэхүү шалгах хуудас нь онцгой байдлын үед мал аж ахуй эрхлэгчдэд ашиглах боломжтой уст цэгийг үнэлэхэд анхаарах асуудлуудыг нэгтгэн харуулав. Энэхүү шалгах хуудасны асуултуудад хариулах мэдээллийн эх сурвалж нь орон нутгийн шуурхай үнэлгээнээс эхлээд зарчмын хувьд усны чанарын лабораторийн шинжилгээ хүртэл өөр өөр байж болно. Гэсэн хэдий ч тэд орон нутгийн янз бүрийн оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалтыг үргэлж оруулах ёстой. Үнэлгээг цаг хязгаартай буюу тулгаж хийх үед хэрэглэгчид аль асуултыг хамрах ёстойг эрэмбэлэх шаардлагатай болдог.

Усан хангамж

- Уст цэгээс одоо ус гарч байна уу?

Хэрвээ “*тийм*” бол:

- Онцгой нөхцөл байдлын хариу арга хэмжээний үед уст цэгийн ус хатаж ширгэх эрсдэл байна уу?
- Тухайн уст цэг нь хэдий тооны малыг усаар хангах боломжтой вэ?

Хэрвээ “*үгүй*” бол:

- Орон нутгийн мал сүргийн хэрэгцээг хангахуйц уст цэгийг сэргээн засварлах нь техникийн хувьд (зардлын хувьд ч, цаг хугацааны хувьд ч) боломжтой юу?
- Уст цэгийг сэргээн засварлах ажлыг удирдаж, хэрэгжүүлэх боловсон хүчин бэлэн үү?

Хүртээмжтэй байдал

- Уст цэгт өвчинд нэрвэгдсэн мал сүргийн ихэнх хэсэг хялбар хүрэх боломжтой юу?
- Уст цэгийг мал ашиглахад нийгэм, соёл, улс төрийн ямар нэгэн хязгаарлалт байгаа юу?
- Хямралд өртсөн мал аж ахуй эрхлэгчид усны эх үүсвэрийг тэгш эрхтэйгээр (нас, хүйс, үндэс угсаа, хөрөнгө чинээ харгалзахгүйгээр) ашиглаж чадах уу?
- Нэрвэгдсэн мал амьтан дараах асуудлуудгүйгээр уст цэгийг ашиглаж боломж байгаа эсэхийг шалгах:
 - a. одоо байгаа хэрэглэгчдийн (хүн ба мал амьтан) хэрэгцээнд сөргөөр нөлөөлөхгүй байх
 - b. малчдын хувийн аюулгүй байдалд эрсдэл учруулахгүй байх (эмэгтэйчүүд болон хүүхдүүд оролцуулаад)?



с. тусламжийн бусад асуудалд саад болохгүй байх ?

Усны чанар

- Усны чанарын эх үүсвэрийн хүрэлцээг үнэлэх туршилтын төхөөрөмж (талбай эсвэл лаборатори) байгаа эсэх?

Хэрэв “тийм” бол:

- Химийн гол нэрийн бохирдуулагч бодист шинжилгээ хийх лабораторийн хүртээмж ямар байна вэ?
- Уст цэгүүд/эх үүсвэрүүдэд хэрэглэж болох усны шинжилгээнд ашиглах цомог байгаа юу?
- Усны эх үүсвэрийн микробиологийн бохирдлын үнэлгээг хийх зохих мэргэшсэн техникч орон нутагт байгаа юу?

Хэрэв “үгүй” бол дараах асуултууд нь газар дээр нь шуурхай үнэлгээ хийхэд тусална:

- Эх үүсвэрээс гарч байгаа ус нь тунгалаг уу, эсвэл булингартай юу?
- Тухайн газар ямар нэгэн давсжилт (жишээ нь давс үүссэн)-ын талаарх баримт нотолгоо байгаа эсэх?
- Химийн бохирдлын талаарх орон нутгийн шалгуур үзүүлэлтүүд (жишээлбэл, бордоо, пестицидийн хэрэглээний загвар, арьс ширний үйлдвэр, хөнгөн үйлдвэр зэрэг орон нутгийн жижиг үйлдвэрүүд байгаа эсэх) байна уу?
- Усаар дамждаг өвчин гарч байсан эсэх талаар ямар нэгэн мэдээлэл байна уу?

Тайлбар: Усны үнэлгээнд онцгой ач холбогдолтой оролцооны арга, арга техникт байгалийн нөөц, үйлчилгээний газрын зураг, янз бүрийн усны байгууламжийн матриц үнэлгээ орно. Оролцооны аргын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг *3-р бүлгийн Хавсралт 3.1: Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөлт* болон LEGS оролцооны техник хэрэгслийн багцад тайлбарласан болно. .



Хавсралт 5.2: Усан хангамжийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн жишээ

Үйл явцын шалгуур үзүүлэлтүүд (болж буй зүйлийг хэмжих)	Нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүд (болж буй үйл явдлын үр дүнг хэмжих)
Үйл ажиллагааг загварчлах нь	
Олон нийт/олон нийтийн төлөөлөл болон бусад оролцогч талуудтай хийсэн уулзалтын тоо (тухайн тохиолдолд хувийн хэвшлийн холбогдох ханган нийлүүлэгчдийг татан оролцуулах)	Усаар хангах хувилбаруудад дүн шинжилгээ хийсэн уулзалтын тайлан Хэрэгжүүлэх төлөвлөгөөнд дараах зүйлийг оруулна: - янз бүрийн оролцогчдын үүрэг, хариуцлага; - усан хангамжийн арга барил, жишээлбэл. одоо байгаа эх үүсвэрийг нөхөн сэргээх; эх үүсвэрийг шинээр бий болгох; - сэргээн засварласан эсвэл шинээр байгуулсан усны цэгийг удирдахад олон нийтийн оролцоог хангах
Усаар хангах	
Нөхөн сэргээсэн буюу шинээр байгуулсан уст цэгийн тоо төрөл, байршлаар нь гаргах Уст цэгүүдээс нийлүүлэх усны хэмжээ, хүчин чадал Машинаар хангасан усны хэмжээ	Хэрэглэгчид болон тэдний мал сүрэг, тэр дундаа эмзэг бүлгийнхэнд усны хүртээмжтэй байдал (уст цэг хүртэлх биет зай) Усны олдоц – малын хэрэгцээнд хангалттай эсэх Усны чанар – малд тохиромжтой байдал Уст цэг ашиглаж буй мал бүхий өрхийн тоо, ус шаардлагатай мал бүхий өрхийн тоо; тоон үзүүлэлтүүдийг эмзэг бүлгээр нь ангилан харуулах Усны цэг ашиглаж буй малын тоо толгойг малын төрлөөр; услах давтамж Малын ус бэлтгэх эмэгтэйчүүд, охидын хөдөлмөрийн ачааллыг нэмэгдүүлэх, бууруулах



Хавсралт 5.3: Уст цэгийн менежментэд анхаарах асуудлууд

Усны эх үүсвэрийн тодорхой удирдлагын тогтолцоог бий болгох нь усны тэгш, шударга, алдаа гажуудалгүй хуваарилалтыг хангахад чухал ач холбогдолтой. Энэ нь мөн засвар үйлчилгээний хуваарийг хадгалахад тусална. Туршлагаас харахад менежментийн асуудлыг үйл ажиллагааны эхэнд авч үзэхгүй бол хүртээмж нь тэгш бус байх төдийгүй зөрчилдөөн үүсгэж болзошгүй юм.

Урт хугацааны менежмент бас чухал. Энэ нь онцгой байдлын үе шат дууссаны дараа уст цэгүүд эвдрэлд орохгүй, харин сэргээн босгох үе шат болон түүнээс цааш үргэлжлүүлэн ажиллах явдал юм. Олон нийтийн менежментийн зарим болзошгүй асуудлуудыг доор авч үзсэн болно. Усны цэгүүд хувийн өмчид байгаа тохиолдолд менежментийн зохицуулалт өөр байна.

Гишүүнчлэлийн олон талт байдал: Уст цэгийн менежментийн хороо нь орон нутгийн нийгэм, соёлын янз бүрийн түвшний олон янзын гишүүдийг шаарддаг. Шаардлагатай тохиолдолд агентлагууд усны хорооны удирдлагын тогтолцоог бэхжүүлэхийн тулд орон нутгийн иргэдэд гадны дэмжлэг үзүүлэх ёстой.

Эмэгтэй төлөөлөгчдийг оролцуулах: Усны менежментийг тогтвортой, шударга, тэгш бэхжүүлэхийн тулд эмэгтэйчүүдийн оролцоог онцгойлон зөвлөж байна. Усны менежментийн хороонд эмэгтэйчүүдийг оруулахыг зөвлөж байна, учир нь тэд ерөнхийдөө ахуйн хэрэглээний ус ашиглах талаар зөвшилцөх шаардлагатай болдог.

Уст цэг ба ус зөөвөрлөх: Усыг зөөвөрлөж түгээх менежментийг орон нутгийн уст цэгийн менежментийн системд үндэслэн байгуулж болно. Энэ нь нийгэмд тэгш хуваарилалт, хүртээмжийг хангахад тусална.

Ил тод байдал: Усны асуудал үүссэн үед хариу арга хэмжээ авахад зардлаа хуваалцах тохиолдолд ил тод журмыг хэрэгжүүлэх ёстой. Мөн чанараараа мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр байгаа хөрөнгийн удирдлага, зардлын хуваарилалт нь маш эмзэг асуудал байдаг. Санхүүгийн хариуцлагатай оролцогчид данс, үнэт зүйлсээ хэдийд ч ил тод байлгахын тулд сонгогдсон нийгэмлэгийн гишүүдтэй (мөн үйл ажиллагааны ард байгаа байгууллагатай) нягт хамтран ажиллах шаардлагатай.

Олон нийтийн хуримтлал: Хэрэв хөрөнгө мөнгө, хамрах хүрээ нь зөвшөөрөгдөж байвал ирээдүйн онцгой байдалд бэлтгэхийн тулд иргэд олон нийт хуримтлалын схем болон/эсвэл банкны дансыг анхаарч үзэж болно. Энэ нь яаралтай тусламжийн төрөл, яаралтай хэрэгцээ шаардлагаас хамааран зохих мэргэжилтнүүдийн удирдлага дор хөрөнгө зарцуулах хувилбаруудыг тодорхойлж болно.



Эх сурвалж болон цаашид унших материал

Бэлэн мөнгө ба зардлыг нөхөх

Усны тээврийн хэрэгсэл, усны системийн зардлыг нөхөх тухай үнэгүй онлайн сургалтын модулиудыг DisasterReady/Mercy Corps англи, араб хэл дээр боловсруулсан болно: <https://get.disasterready.org/water-trucking-and-cost-recovery-online-training/>

ISW/SDC (2016) How to establish a Full Cost Recovery Water Supply System? What are the Key Factors for Success and Replication?, SDC Briefing Note, Federal Department of Foreign Affairs (FDFA), Bern, <https://www.rural-water-supply.net/en/resources/details/770>

Усны онцгой асуудал үүссэн үед баримтлах техникийн заавар

House, S. and Reed, R. (2004) Emergency Water Sources – Guidelines for Selection and Treatment, 3rd edn, Water, Engineering and Development Centre (WEDC), Loughborough, <https://wedc-knowledge.lboro.ac.uk/details.html?id=18064>

Ус болон мал амьтны онцгой байдал

FAO (2016) Livestock-related interventions during emergencies – The how-to-do-it manual. Edited by Philippe Ankers, Suzan Bishop, Simon Mack and Klaas Dietze. FAO Animal Production and Health Manual No. 18. Rome, <https://www.fao.org/3/i5904e/i5904e.pdf> (See Chapter 7)

Gebru, G., Yousif, H., Adam, A.E.M., Negesse, B. and Young, H. (2013) Livestock, Livelihoods, and Disaster Response, Part Two: Three Case Studies of Livestock Emergency Programmes in Sudan, and Lessons Learned, Feinstein International Center, Tufts University, Medford, MA, <http://fic.tufts.edu/publication-item/livestock-livelihoods-and-disaster-response-part-two-2/>

Ус зөөвөрлөх

Coerver, A., Ewers, L., Fewster, E., Galbraith, D., Gensch, R., Matta, J., Peter, M. (2021) Compendium of Water Supply Technologies in Emergencies, 1st edn, German WASH Network (GWN), University of Applied Sciences and Arts Northwestern Switzerland (FHNW), Global WASH Cluster (GWC) and Sustainable Sanitation Alliance (SuSanA), Berlin, ISBN: 978-3-033-08369-1, https://www.washnet.de/wp-content/uploads/2021/09/GWN_Emergency-Water-Compendium_2021_new.pdf

WEDC, Loughborough University (2011) Delivering safe water by tanker, WHO Technical Notes on Drinking-Water, Sanitation and Hygiene in Emergencies, Number 12, WHO, Geneva, <https://wedc-knowledge.lboro.ac.uk/resources/e/mn/042-Delivering-safe-water-by-tanker.pdf>

Wildman, T., Brady, C., and Henderson, E. (2014) 'Rethinking emergency water provision: Can we stop direct water trucking in the same places every year?', Humanitarian Exchange Magazine, issue 61, article 13, Humanitarian Practice Network, <https://odihpn.org/publication/rethinking-emergency-water-provision-can-we-stop-direct-water-trucking-in-the-same-places-every-year/>

Wildman, T. (2013). Technical Guidelines on Water Trucking in Drought Emergencies, Oxfam GB, London, <https://policy-practice.oxfam.org/resources/technical-guidelines-on-water-trucking-in-drought-emergencies-301794/>

See also case studies for water interventions in emergencies at: <https://www.livestock-emergency.net/resources/case-studies/>






Бүлэг 6: Мал эмнэлгийн тусламжийн техникийн стандарт

- 210 Танилцуулга
- 212 Мал эмнэлгийн тусламжийн хувилбарууд
- 221 Үйл ажиллагаанууд (тусламж)-ыг хэрэгжүүлэх цаг хугацаа
- 222 LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн түншлэлийн стандартууд (ХТС)-тай холбогдох нь
- 223 LEGS-н зарчмууд болон бусад анхаарах асуудлууд
- 230 Мал эмнэлгийн тусламжийн хувилбаруудын шийдвэрийн мод
- 232 Стандартууд
- 249 Хавсралт 6.1: Мал эмнэлгийн тусламжийн үнэлгээний аргачлал, шалгах хуудас
- 251 Хавсралт 6.2: Мал эмнэлгийн тусламжийн хяналт үнэлгээний шалгуур үзүүлэлтийн жишээнүүд
- 253 Эх сурвалж ба цаашид унших материал



Бүлэг 6: Мал эмнэлгийн тусламжийн техникийн стандарт





Танилцуулга

Мал аж ахуй эрхлэгчид нь онцгой байдлын үед малыг тэжээл, усаар хангахтай адил мал эмнэлгийн тусламжийг чухал ач холбогдолтой гэж тайлбарладаг. Эрт оношлох, эмчлэх зэрэг мал эмнэлгийн тусламж үйлчилгээ нь малыг өвчнөөр хорогдохоос урьдчилан сэргийлэхэд тусалдаг. Малын хорогдол ихсэхэд хүргэдэг, малчдын амьжиргаанд голлон нөлөөлдөг онцгой байдлын дараа мал аж ахуй эрхэлдэг иргэдийн амьжиргааг эргэн сэргээхэд олон жил шаарддаг. Ихэнх тохиолдолд малчид үндсэн үржлийн амьтдаа хамгаалахыг зорьдог. Ер нь мал эмнэлгийн вакцин, эм нь “хорогдох магадлалтай, үнэ цэнэ бүхий мал”-тай харьцуулахад харьцангуй хямд.

Хувийн мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч, төрийн бус байгууллага, засгийн газар, агентлагууд нь мал эмнэлгийн эмнэлзүйн (клиник) үйлчилгээнд дэмжлэг үзүүлж болно. Онцгой байдлын үед орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй хамтран ажилладаг мал эмнэлгийн арга хэмжээ нь гамшигт өртсөн ард иргэдийн малын гаралтай бүтээгдэхүүний хангамж (хэрэгцээг хангах)-ийг хадгалахад тусална. Мөн гамшгийн дараах үе шатанд мал эмнэлгийн үйлчилгээг авах боломжтой байхад тусална. Мал эмнэлгийн эмнэлзүйн (клиник) тусламж үйлчилгээ нь онцгой байдлын үед нэн тэргүүнд авах арга хэмжээ юм. Гэсэн хэдий ч зарим нөхцөл байдалд үүнийг мал эмнэлгийн нийтийн эрүүл мэнд, малын өвчний тандалт зэрэг төрийн салбарын мал эмнэлгийн чиг үүргийг дэмжих замаар нөхөж болно.

Энэ бүлэгт онцгой байдлын үед мал эмнэлгийн тусламж үзүүлэх ач холбогдлын талаарх мэдээллийг танилцуулж, мал эмнэлгийн тусламжийн хувилбарууд тус бүрийн дэмжлэг, түүнтэй холбоотой ашиг тус, сорилтуудын хамт харуулав. Эдгээр мэдээлэл нь *НҮБ-ын ХХААБ-ын гарын авлагын бүлэг 5 “Мал эмнэлгийн тусламж” (2016)*-т байгаа болно. LEGS нь тусламжийн хувилбар бүрийн хувьд стандарт, үндсэн үйл ажиллагаа, зааварчилгаагаар дамжуулан мэдээлэл өгсөн байгаа. Үнэлгээний хяналтын хуудас, түүнчлэн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг энэ бүлгийн төгсгөлд хавсралтаар үзүүлэв. Жишээ судалгаануудын талаар LEGS вэбсайтыг харна уу (see <https://www.livestock-emergency.net/case-studies/>).

LEGS-н амьжиргааны зорилтуудтай холбогдох нь

Онцгой байдлын үед мал эмнэлгийн тусламж үзүүлэх нь LEGS-н амьжиргааны зорилтуудын хоёр зорилтын хүрээнд, хямралд өртсөн ард иргэдийг дэмжихэд тусална:

- Амьжиргааны гол хөрөнгө болох мал амьтныг хамгаалах
- Гол хөрөнгө болох мал амьтныг нөхөн сэргээх



Мал эмнэлгийн тусламж нь малын хорогдлоос урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ мал аж ахуйн үйлдвэрлэл болон малын тавлаг байдалд эерэг нөлөө үзүүлдэг. Энэхүү мал эмнэлгийн тусламж үйлчилгээ нь малын сүүний үйлдвэрлэл, үржил шим, малыг ажиллах хүч болгон ашиглах зэргээс үл хамааран малаас авах үр ашгийг нэмэгдүүлж байдаг. Мал эмнэлгийн тусламж үйлчилгээ нь бэлчээрийн мал сүрэг, ганц илжиг, хоёр үхэр эсвэл хэдхэн тахиа гэх мэт үнэ цэнэтэй мал амьтныг нөхөн сэргээхэд тусалдаг.

Онцгой байдлын үед мал эмнэлгийн тусламж үзүүлэхийн ач холбогдол

Бага, дунд орлоготой орнуудад малын өвчлөл нь малын хорогдол, мал аж ахуйн үйлдвэрлэл буурах гол шалтгаануудын нэг болдог. Гамшиг нь өвчний эрсдлийг нэмэгдүүлдэг бөгөөд үр нөлөө нь амьтны эрүүл мэндэд янз бүрээр илэрнэ. Тухайлбал:

- Ган, үер, хатуу ширүүн өвөл нь бэлчээр тэжээлийн нөөц хомсдож, малын тарга тэвээрэг алдагдаж, сульдсан малын биеийн эсэргүүцэл сулран өвчнийг тэсвэрлэх чадвар буурна.
- Үерийн улмаас хөрсний гулсалт үүсэж, хөрсний халдварт өвчин болох боом зэрэг өвчин, харин үерийн ус нь Рифт хөндийн халуурал зэрэг дамжуулагчаар дамждаг халдварт өвчин гарах нөхцлийг тус тус бүрдүүлдэг байна.
- Газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт зэрэг байгалийн аюул нь амьтдыг ихээр гэмтээж бэртээдэг.
- Онцгой нөхцөл байдлын улмаас өөр өөр газар нутагт байсан мал нэг дор цугларч нийлж холилдох үед халдварт өвчин дамжих эрсдэл нэмэгддэг.
- Шинэ газар нутагт нүүдэллэж очсон мал амьтан нь тухайн газар нутагт гардаг өвчний эсрэг дархлаагүй байдгаас шалтгаалан өвчлөх эрсдэлтэй.
- Хөл хөдөлгөөн ихтэй нөхцөлд суурьшиж байгаа мал амьтан болон хүмүүсийн хооронд зоонозын халдвар дамжих эрсдэл нэмэгддэг.

LEGS нь олон улсын чухал ач холбогдолтой малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах асуудлыг хамаардаггүй болно. Энэ талаарх тусгай удирдамж Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ) болон НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (НҮБ ХХААБ)-д байдаг талаар *Бүлэг 1: LEGS-н танилцуулга* хэсгээс харна уу.

Онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний нэг хэсэг болох мал эмнэлгийн тусламж нь 1-р бүлэгт тодорхойлсон “Мал амьтдын тавлаг байдал”-ын 5 үндсэн ухагдахууны “эрүүл мэнд” ба “тав тухгүй байдал” гэж нэрлэсэн 2 зүйлд шууд нөлөөлдөг.



Мал эмнэлгийн тусламжийн хувилбарууд

LEGS нь гамшгийн үед үзүүлэх мал эмнэлгийн үндсэн хоёр төрлийн тусламжийг санал болгодог: Мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээ болон улсын мал эмнэлгийн үйлчилгээ. Мал эмнэлгийн тусламж нь дээрх хувилбаруудаар хязгаарлагдахгүй нэгээс дээш олон сонголт эсвэл дэд сонголтыг олгож, тэдгээрээс сонгон хэрэгжүүлж болно.

LEGS-н 2-р зарчим болох Олон нийтийн оролцоог хангахдаа ядуу, гамшигт өртөх эрсдэлтэй мал аж ахуй эрхлэгчдийг илүү хамруулахын тулд мал эмнэлгийн арга хэмжээг иргэдтэй хамтран тодорхойлж, эрэмбэлвэл зохино. Энэ нь мал аж ахуй эрхлэгчдэд бодитоор тулгарч буй хэрэгцээг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэх боломжийг олгодог байна.

Чанар ба хариуцлагын талаарх Хүмүүнлэгийн үндсэн стандарт (ХҮС) нь нөөцийг үр дүнтэй, үр ашигтай, ёс зүйтэй ашиглахыг шаарддаг. Мал эмнэлгийн тусламж гэдгийг янз бүрийн үйл ажиллагааны хүрээнд нөөцийг зохистой хуваарилах гэж ойлгох боловч, энэ нь мал болон өмч хөрөнгийг шууд хамгаалахад чиглэсэн дэмжлэгийг чухалчилна гэсэн үг юм. Нэмэлт удирдамжийн талаарх мэдээллийг *Стандарт 2: Үнэлгээ ба төлөвлөлт* хэсгээс авна уу.

Хувилбар 1: Мал эмнэлгийн эмнэлзүйн (клиникийн) үйлчилгээ

Онцгой байдлын үед мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээ нь оношилгоо, эмчилгээ, вакцинжуулалтаас бүрдэх ба онцгой байдал үүссэн үед мал аж ахуй эрхлэгчид хамгийн түрүүнд хэрэгжүүлдэг арга хэмжээ юм. Эдгээр үйлчилгээг төр, төрийн бус байгууллага эсвэл хувийн мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан тус тус хүргэж болно. Орлого багатай ихэнх улс орнуудад мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээ нь төрөөс хувийн хэвшилрүү шилжиж байна. Тиймээс өсөн нэмэгдэж буй хувийн мал эмнэлгийн салбар нь мал эмнэлгийн эмнэл зүйн тусламж үйлчилгээний гол эх үүсвэр болж магадгүй юм.

Гэсэн хэдий ч малын эмч нар ихэвчлэн томоохон хотын төвүүд эсвэл өндөр хөгжсөн арилжааны чиглэлийн томоохон фермийг түшиглэн хөгжих сонирхолтой байдаг. Алслагдсан бүс нутагт уламжлалт эмч нар болон мал эмнэлгийн янз бүрийн албан бус ханган нийлүүлэгчдийн хамт мал эмнэлгийн туслах мэргэжилтнүүд гол үйлчилгээ үзүүлэгч байж болно.

Мал эмнэлгийн туслах ажилтан зэрэг олон нийтэд түшиглэсэн малын эрүүл мэндийн ажилтнууд (ОНТМЭА) нь олон нийтийн (аж ахуй эрхэлж буй



бүлэг хүмүүс) дунд байж тэдэнтэй хамгийн ойр ажилладаг. Тэд (ОНТМЭА) онцгой байдлын үед мал эмнэлгийн эмнэлзүйн болон улсын мал эмнэлгийн үйлчилгээг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хавсарсан гамшиг болон ган гачигтай үед ОНТМЭА нь малын хорогдлыг бууруулж, үйлчилгээний хүртээмжийг харьцангуй бага зардлаар хүргэж нөхцөл байдлыг сайжруулж байдаг.

Сайн туршлагыг дагаж мөрдвөл ОНТМЭА-ны тогтолцоо нь малын эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлүүдэд эерэгээр нөлөөлж, орон нутгийн зүгээс хүлээн зөвшөөрөгдөж, мал аж ахуй эрхлэгчдийн дэмжлэг авдаг байна.

Сайн туршлага гэдэгт сонгох, хянах, зохих зөвөлгөө өгөхөд оролцооны арга ашиглах, удирдамжаар хангах, мөн боломжтой бол эмэгтэй, эрэгтэй ОНТМЭА-ыг хамтад нь сургаж, тэдний оролцоог хангах зэрэг үйл ажиллагаа багтана. ОНТМЭА, бусад малын эрүүл мэндийн ажилтнууд болон эм/тоног төхөөрөмж нийлүүлэгчдийн хоорондын харилцаа холбоо нь мөн чухал юм. Гэсэн хэдий ч зарим улс орнуудад ОНТМЭА-ууд ажиллах хууль эрх зүйн зохицуулалт байдаггүй тул малын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх бусад механизмыг (боломжийг) анхаарч үзэх шаардлагатай. Хүмүүнлэгийн хямралын үед урьдчилан сэргийлэх болон мал эмнэлгийн эмнэл зүйн үйл ажиллагаанд доголдол үүсэх учраас дараах хоёр ангиллын арга хэмжээг нэгэн зэрэг хэрэгжүүлэх шаардлагатай болно:

- Малд нэг бүрчлэн үзлэг болон эмчилгээ хийх;
- Мал бүрийг толгой дараалан (масс) вакцинжуулах эсвэл масс эмчилгээний хөтөлбөр

1.1 Мал амьтанд (нэг бүрчлэн болон сүрэгт) үзлэг болон эмчилгээ хийх

6

Энэ сонголт нь мал амьтдад онцгой байдлын үед үүсээд байгаа өвчнийг оношлон, илрүүлэх үзлэг хийж, түүнд тохирсон эмчилгээг авах боломжийг олгодог. Энэ үед янз бүрийн өрхийн мал сүрэгт нь өөр өөр өвчтэй байгаа мал нэг бүрт тохирсон эмчилгээ үйлчилгээ үзүүлэх хэрэгтэй болдог. Энэ арга хэмжээг зарим оронд онцгой байдлын үед мал эмнэлгийн эрхийн бичиг (ваучер)-ийн системээр дамжуулан хэрэгжүүлдэг. Эдгээр системийг олон нийт, хувийн хэвшил, засгийн газрын түншүүд хамтран хөгжүүлдэг байна. (Үйл ажиллагааны жишээ судалгаа: Кени дэх мал эмнэлгийн эрхийн бичгийн схем, Этиоп дахь мал эмнэлгийн эрхийн бичгийн схемийг үзнэ үү).

Үүний нэгэн адил онцгой байдлын бус үеийн мал эмнэлгийн тусламжийн хариу арга хэмжээ нь өрхүүдэд шууд болон шууд бус хэлбэрээр бэлэн мөнгө олгох нь хүмүүст мал эмнэлгийн тусламж үйлчилгээний төлбөрийг хувийн хэвшилд ажиллагсадруу төлөх боломжийг олгодог байна.



Ингэснээр өвчний тохиолдол бүрт мал эмнэлгийн эмнэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлж чадахаас гадна эмийг үнэ төлбөргүй тараах мэт нь одоо байгаа хувийн мал эмнэлгийн үйлчилгээнд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлаас зайлсхийхэд чиглэгддэг. Малд нэг бүрчлэн эмнэл зүйн туслалцаа үзүүлэх нь мал амьтныг бөөнөөр нь эмчлэхтэй харьцуулахад эмэнд тэсвэртэй болох эрсдлийг бууруулж чадна.

1.2 Мал бүрийг толгой дараалан (масс) вакцинжуулах буюу эмчлэх хөтөлбөрүүд

Эдгээр хөтөлбөрийг онцгой байдлын үед мал сүргийг өвчлөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор түгээмэл ашигладаг. Ихэнх тохиолдолд яаралтай өргөн хүрээг хамарсан вакцинжуулалт болон эмийн эмчилгээний хөтөлбөр нь нэг удаагийн арга хэмжээ байх бөгөөд мал аж ахуй эрхлэгчдэд ямар ч үнэ төлбөргүй хийгддэг. Тиймээс одоо ажиллаж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний санхүүгийн чадавхыг алдагдуулахгүйн тулд санхүүгийн туслалцаанд анхаарах хэрэгтэй.

- Өргөн хүрээг хамарсан эмийн эмчилгээний хөтөлбөрт ихэвчлэн шимэгч хорхой, ялангуяа хачиг, ширх зэрэг гадна паразитууд болон өтний эсрэг эмийн эмчилгээ тус тус хамаардаг байна. Эдгээр өргөн хэрэглэгддэг хөтөлбөрүүдийн хэрэгжүүлэгчид болон уг үйлчилгээг хүлээн авагч ашиг хүртэгчдийн зүгээс нь энэхүү хөтөлбөрийг эерэг нөлөө үзүүлдэг гэж тэмдэглэсэн байдаг. Гэсэн хэдий ч LEGS нь судалгаагаар үр нөлөө эсвэл зардлын үр ашигтай байдал хязгаарлагдмал (Үр нөлөөний жишээ судалгаа: Кени улсад ган гачгийн үед малыг бөөнөөр туулгах эмчилгээний хязгаарлалт хэсгийг харна уу) мал бүрийг толгой дараалан эмчлэх стандартын талаар энд хараахан оруулаагүй байна. Хэрэв тусламжийн байгууллагууд нь мал бүрийг толгой дараалан (масс) эмчлэхээр сонголт хийсэн бол эмийн нөлөөг сайтар баримтжуулах, хэзээ, хэрхэн хэрэглэхийг ойлгохын тулд зохих үнэлгээ хийхийг LEGS-с зөвлөж байна. Өргөн хүрээнд туулгалт боловсруулалт хийх хөтөлбөрийн зарим үр дагавар нь гамшгийн дараа ч ажиглагдаж болно. Тиймээс үнэлгээний загвар, цаг хугацаа зэрэг хүчин зүйлийг харгалзан үзэх хэрэгтэй.
- Мал нэг бүрийг толгой дараалан (масс) вакцинжуулах хөтөлбөрийг ихэнхдээ боом, цусан халдварт, иж балнад, ньюкасль, рифт хөндийн халуурал, хонь, ямааны цэцэг өвчний үед хэрэгжүүлдэг байна. Мал бүрийг толгой дараалан вакцинжуулахыг хэдийгээр гэнэтийн болон удаан явцтай гамшгийн үед түгээмэл хэрэглэдэг ч амьжиргаанд нөлөөлж байгаа нөлөө нь маш хязгаарлагдмал байдаг. (Нөлөөллийн жишээ судалгаа: Этиоп улсад онцгой байдлын үеийн малын вакцинжуулалтыг хязгаарлах талаар үзнэ үү). Тиймээс LEGS-д мал бүрийг толгой дараалан



вакцинжуулах тухай стандартыг оруулаагүй болно. Хэрэв өргөн хүрээнд вакцинжуулалт хийхээр шийдсэн бол вакциндсан болон вакциндаагүй сүрэг дэх малын хорогдлыг харьцуулах үнэлгээг хийхийг LEGS-с зөвлөж байна. Мал бүрийг толгой дараалан (масс) вакцинжуулахтай холбоотой техникийн чанартай 3 асуудал байна:

- a. Цаг хугацаа: Зарим төрлийн вакциныг өвчин гарах хугацаа эсвэл өвчин гараад тархах улирлаас өмнө хийлгэсэн тохиолдолд л үр дүнтэй байдаг. Энэ хугацаа нь хүмүүнлэгийн хямрал эсвэл хариу арга хэмжээ авах хугацаатай давхцахгүй байж магадгүй юм.
- b. Зарим идэвхгүйжүүлсэн (үхүүлсэн) вакцин нь хамгаалалтын дархлааг бий болгохын тулд эхний удаа хоёр тунг тарих шаардлагатай. Эдгээр тохиолдолд уг вакцины нэг тунг хэрэглэх нь үр дүнгүй байдаг. Үүний нэгэн адил давтан тун нь зөвхөн вакцинжуулалтын эхний бүрэн тун таригдсаны дараа л үр дүнтэй байх ба малын вакцинжуулалтын түүх тодорхойгүй байж болно.
- c. Сүргийн дархлааг бий болгохын тулд вакцинд хамрагдах малын эзлэх хувь нь өвчлөлөөс хамаарч өөр өөр байдаг. Малын өвчинтэй тэмцэх үндэсний стратегид эдгээр хувь хэмжээг ихэвчлэн тодорхой заагаагүй байдаг.

LEGS нь зарим нөхцөл байдалд тухайлбал хавсарсан гамшгийн үед өвчнийг устгах компани ажлын нэг хэсэг болгон вакцинжуулалтыг дэмждэг байна. Эдгээр тохиолдолд вакцинжуулалтын стратегийг НҮБ-ын ХХААБ зэрэг техникийн тэргүүлэх байгууллагаас тогтоох бөгөөд үүнийг дагаж мөрдөнө.

Хувилбар 2: Улсын мал эмнэлгийн үйлчилгээ

6

Хүмүүнлэгийн хямралын үед улсын мал эмнэлгийн чиг үүргийг дэмжих нь засгийн газрын суларсан чадавхыг нөхөж болно. Эсвэл албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн эрх мэдэл байхгүй тохиолдолд хөндлөнгөөс оролцож болно. Үүнд хоёр төрлийн үйл ажиллагаа багтана:

- Мал эмнэлгийн нийтийн эрүүл мэнд;
- Малын өвчний тандалт судалгаа;

Хавсарсан гамшгийн үед мал эмнэлгийн үйл ажиллагааг дэмжих бодлого, байгууллагыг бэхжүүлэхэд чиглэсэн оролцооны зарим жишээ байдаг. Энэ нь ялангуяа онцгой байдлын үед мал эмнэлгийн туслах мэргэжилтнүүдийг ашиглахтай холбоотой байж болох юм.

Төрийн мал эмнэлгийн чиг үүрэгт үзүүлэх дэмжлэгийг авч үзэх ба онцгой байдлын нөхцөл байдалд өөр хоорондоо нягт холбоотой гурван чухал сорилт үүсдэг:



Мал эмнэлгийн тусламжийг нэн тэргүүнд тавих: LEGS-н 1-р зарчим: Амьжиргаанд суурилсан хөтөлбөр, LEGS-н 2-р зарчим: Олон нийтийн оролцооны хүрээнд мал эмнэлгийн арга хэмжээг ард иргэдтэй хамтран тодорхойлж, эрэмбэлэх хэрэгтэй. Ийм үйл ажиллагаанууд нь LEGS-н амьжиргааг хангах нэг буюу хэд хэдэн зорилтод хүргэх болно. Мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээ нь онцгой байдлын үед амьжиргааг дэмжихэд хэрхэн хувь нэмэр оруулдгийг харуулсан тодорхой үндэслэлтэй нотлох баримтууд бий. Гэсэн хэдий ч төрийн салбартай холбоотой үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэг, нөлөөний талаарх баримт нотолгоо хамаагүй бага байна. Ер нь мал аж ахуй эрхлэгчид нь малын эмнэл зүйн арчилгаа маллагааг нэн тэргүүнд авч үздэг.

Зардал-үр ашиг: Хүмүүнлэгийн үндсэн стандарт (ХҮС)-д үндэслэн нөөцийг үр ашигтай, үр нөлөөтэй, ёс зүйтэй ашиглах ёстой. Зарим үйл ажиллагаа нь мал эмнэлгийн эмнэл зүйн тусламж үйлчилгээ болон улсын мал эмнэлгийн чиг үүргийг дэмжих зорилготой байдаг. Ийм нөхцөлд эдгээр хоёр төрлийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд хүний болон санхүүгийн нөөцийг зохистой хуваарилах талаарх зааварчилгаа нь тун хязгаарлагдмал байдаг.

Бэлэн байдал: (Мал эмнэлгийн тусламж) *LEGS 4-р зарчим:*

Бэлэн байдлын зарчмаар эмнэлзүйн үйлчилгээ тусламжийг цаг тухайд нь хүргэх төлөвлөлтөд анхаарлаа хандуулах ёстой. Энэ үйл явцад орон нутагт мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлэгч нар, сайн чанарын эм нийлүүлэгчдийг урьдчилан байршуулах, хувийн хэвшил, төрийн байгууллага, түншүүдтэй хамтран орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгчдийн бүртгэл тооллого, олон нийтэд бэлэн мөнгө, эрхийн бичгийн тусламж (CVA)-ийн түр зуурын загвар боловсруулах зэрэг багтаж болно. Төлөвлөлтөд онцгой байдлын үед хариу арга хэмжээ хэрэгжүүлэхэд оролцох мал эмнэлгийн ажиллах хүчний бэлэн байдлыг хангасан эсэхийг баталгаажуулна.

Бэлэн байдал гэдэгт үндэсний малын эрүүл мэндийн асуудлаарх бодлогын шинэчлэл зэрэг "хэвийн" үед улсын мал эмнэлгийн салбарын үндсэн үйл ажиллагаа; эсвэл вакцинжуулалтын хөтөлбөрүүд зэрэг ердийн үед байнга хэрэгжүүлдэг үйл ажиллагаануудыг хамааруулахгүй болно.

2.1 Мал эмнэлгийн нийтийн эрүүл мэнд: Мал эмнэлгийн нийтийн эрүүл мэндэд зоонозын өвчлөлийн тухай ойлголт хамаарах бөгөөд өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчний хяналт, хүн амын хүнсний аюулгүй байдал зэрэг орно. Зоонозын өвчин нь мах, сүү зэрэг амьтны гаралтай хоол хүнс эсвэл мал амьтадтай харьцах хавьтал болох үед мал амьтнаас хүнд халдварлан дамждаг. "Хэвийн", гамшгийн бус үед эдгээр өвчний хяналт нь нийтийн эрүүл мэндийн салбарын гол үүрэг байдаг. Зооноз өвчинд боом, иж балнад, сүрьеэ, бруцеллёз, галзуу, хамуу, Рифтийн хөндийн халуурал



болон өндөр хоруу чанартай шувууны томуу (шувууны ханиад) зэрэг өвчнүүд багтана.

Тэдгээр өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах тусгай удирдамжийг *LEGS 1-р бүлэг удиртгал* хэсэгт буюу мал амьтны тавлаг байдал хэсэгт дурьдсанаас гадна НҮБ-ын ХХААБ (FAO) болон Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (WOAH)-аас авах боломжтой.

Мал эмнэлгийн нийтийн эрүүл мэнд нь олон салбарыг хамардаг. Үүнд зөвхөн төрийн болон хувийн хэвшлийн малын эмч, мал эмнэлгийн туслах мэргэжилтнүүд төдийгүй эрүүл мэндийн салбарын ажилтнууд, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд, нийгэм судлаачид, харилцаа холбооны мэргэжилтнүүд болон бусад мэргэжлийн хүмүүс хамаардаг.

Мал эмнэлгийн нийтийн эрүүл мэнд нь “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалтай нягт холбоотой байдаг. “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлал болон мал эмнэлгийн нийтийн эрүүл мэндийн хүрээнд явагдах үйл ажиллагаа нь LEGS-т хамаардаг.

Мал эмнэлгийн нийтийн эрүүл мэндэд мах, сүү, өндөг гэх мэт амьтны гаралтай бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдлыг багтаана.

Мал эмнэлгийн зориулалттай зарим эм нь дээрх хүнсэнд үлдэгдэл байдлаар хадгалагдаж, улмаар хүн тэдгээрийг нь хүнсэндээ хэрэглэж болзошгүй. Хүмүүнлэгийн хямрал болсон үед хүнсний аюулгүй байдал, хүнсний баталгаат байдлын тухай ойлголт алдагддаг. Түүнчлэн хүн амын хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн хомсдол их байсан бүс нутагт урьд өмнө байснаас илүүтэй хоол тэжээлийн аюулгүй, баталгаат байдал алдагдаж, дутагдал (хямрал) үүсч болно.

6

Зарим тохиолдолд хоол тэжээлийн чанарын түвшин «хэвийн» үед ч гэсэн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас тогтоосон хязгаараас доогуур байдаг. Ийм нөхцөлд байгаа хүмүүсийн хувьд эмийн үлдэгдэл агуулсан мах, сүүг хэрэглэснээс болж хүнсний аюулгүй байдал алдагдаж, хүн өвчлөх, хэт таргалалт зэрэг эрүүл мэндийн эрсдэл улам нэмэгддэг.

2.2 Мал амьтны өвчний тандалт нь тухайн газар нутгийн өвчний нөхцөл байдлыг мэдэхийн тулд мал амьтны өвчлөлийн талаарх мэдээлэл цуглуулах зорилготой.

Тандалт нь шинэ болон шинээр гарч буй өвчнийг илрүүлэхэд дэмжлэг болдог. Тандалтын систем нь өвчний тархалт, эдийн засгийн талаар мэдээлэл өгч, гол нэрийн халдварт болон зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах хөтөлбөрүүдийг дэмжих боломжийг олгодог байна. Өвчний тандалтын мэдээлэл нь мал, малын гаралтай бүтээгдэхүүний олон улсын худалдааг



дэмжих боломжийг олгоно.

Хүмүүнлэгийн хямралын үед хийгдэх өвчний тандалт, мөрдөн шалгах судалгааны үйл ажиллагааны талаарх жишээнүүд:

- өвчний талаарх мэдээллийг сайжруулахын тулд нийгэмд чиглэсэн сурталчилгаа хийх;
- өвчнийг мэдээлдэг малын эмч, мал эмнэлгийн туслах ажилтан нарыг сургалтад хамруулах;
- мал эмнэлгийн мэргэжлийн эмч нарыг өвчнийг мэдээлэх албан ёсны систем бүтэцтэй холбох замаар засгийн газрын тандалтын тогтолцоог дэмжих;
- өвчний дэгдэлтийг цаг тухайд нь бүс нутгийн онцлогт тохируулан тандан судлах, хариу арга хэмжээг авах;
- өвчний тандалт судалгааны үр дүнгийн талаар тогтмол эргэн мэдээлэх.

Мал эмнэлгийн тусламжийн үндсэн болон дэд хувилбаруудын ашиг тус, сорилт бэрхшээлийн талаар *Хүснэгт 6.1*-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 6.1: Мал эмнэлгийн тусламжийн хувилбаруудын ашиг тус, сорилт бэрхшээл

Дэд-хувилбар	Ашиг тус	Сорилт бэрхшээл
Хувилбар 1: Мал эмнэлгийн мал эмнэл зүйн (клиник) үйлчилгээ		
1.1 Мал амьтан (тухайн мал болон сүрэг)-д үзлэг, эмчилгээ хийх	Мал эмнэлгийн тусламж үйлчилгээ уян хатан байна. Одоо байгаа хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчдийг жишээ нь: эрхийн бичгийн схемээр дамжуулан дэмжих боломжтой. Төрийн салбарыг тухайлбал зөвөлгөө, чанарын хяналт гэх мэтэд татан оролцуулж болно	Хэрвээ үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэхээр бол үйлчилгээний хамрах хүрээ болон үргэлжлэх хугацаа нь санхүүжилтээс хамааран хязгаарлагдах магадлалтай. Хэрвээ үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлбэл одоо байгаа хувийн хэвшлийн үйлчилгээг үзүүлэгчдэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Орон нутагт байгаа эмийн чанар муу байж магадгүй тул сайн чанарын эм ханган нийлүүлэгчдийг урьдчилан байршуулах эсвэл урьдчилан сонгох шаардлагатай

Үргэлжлэл дараагийн хуудсанд



Дэд-хувилбар	Ашиг тус	Сорилт бэрхшээл
1.1 Мал амьтан (тухайн мал болон сүрэг)-д үзлэг, эмчилгээ хийх (Үргэлжлэл)	Ялангуяа мал эмнэлгийн сайн дурын ажилтан (ОНТМЭА) гэх мэт сайтар бэлтгэгдсэн, мал эмнэлгийн туслах ажилтнуудыг ашиглавал хамрах хүрээ өргөжих боломжтой. Эрсдэлд байгаа хувь мал буюу сүрэгт зорилтот, стратегийн зорилготой урьдчилан сэргийлэх эмчилгээ, вакцинжуулалтыг зөвшөөрдөг. Малын хорогдол байсаар байх үр нөлөөний зарим тоон нотолгоо байдаг. Мал бүрийг толгой дараалан (масс) эмийн эмчилгээ хийх арга нь хүрээлэн буй орчныг бохирдуулах эрсдэл харьцангуй бага байдаг Мал бүрийг толгой дараалан (масс) эмийн эмчилгээ хийх нь эмэнд тэсвэртэй болох эрсдэл харьцангуй бага байдаг.	
1.2 Мал бүрийг толгой дараалан (масс) хамруулсан эмийн эмчилгээ эсвэл вакцинжуулалтын хөтөлбөрүүд	Үүнийг хэрэгжүүлэхэд харьцангуй хялбар байдаг. Мал бүрийг толгой дараалан (масс) туулгалт хийхэд хүйтэн хэлхээ шаарддаггүй. Нэг мал амьтанд зарцуулах зардал бага байж болно.	Олонх газарт ялангуяа онцгой байдлын үед тодорхой өвчнийг илрүүлэхэд чиглэсэн өвчний оношийг баталгаажуулах лабораторийн байгууламж сул байдаг. Томоохон хэмжээний вакцинжуулалтын хөтөлбөрийг эпидемиологийн үндсэн мэдээлэлгүйгээр зөв төлөвлөхөд хэцүү байх болно.

Үргэлжлэл дараагийн хуудсанд



Дэд-хувилбар	Ашиг тус	Сорилт бэрхшээл
1.2 Мал бүрийг толгой дараалан (масс) хамруулсан эмийн эмчилгээ эсвэл вакцинжуулалтын хөтөлбөрүүд (Үргэлжлэл)	Мал бүрийг толгой дараалан (масс) хамруулах ажилд ашиглах эм нь мал эмнэлгийн салбарт жишээлбэл ваучерын схемээр дамжуулан орлого оруулах боломжтой.	Нэг удаагийн компанит ажлын хүрээнд идэвхгүйжүүлсэн вакцины нэг удаагийн тун нь тухайн өвчнөөс хамаарч үр дүн хязгаарагдмал байж болзошгүй. Вакцинжуулалтын хамгийн оновчтой хугацаа нь өртөлтийн өндөр эрсдэлтэй хугацаанаас өмнө таригдсан байх, энэ нь хүмүүнлэгийн яаралтай тусламжтай хугацаатай давхцахгүй байж магадгүй. Хамрах хүрээ нь ихэвчлэн техникийн шалгуур үзүүлэлтээс илүүтэй санхүүжилтээс хамаардаг. Үнэ төлбөргүй эмчилгээ, вакцинжуулалт хийлгэснээр хувийн хэвшлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулж болзошгүй. Дийлэнх вакцины хувьд хүйтэн хэлхээг бий болгох эсвэл хүйтэн хэлхээний дэмжлэг хэрэгтэй болдог. Ядарсан туранхай мал амьтдын хувьд вакцин тарьсаны дараа үзүүлэх дархлааны хариу урвал тун сул байж магадгүй (жишээлбэл: тэжээл дутагдсанаас). Орон нутагт байгаа эмийн чанар муу байж магадгүй тул сайн чанарын эм ханган нийлүүлэгчдийг урьдчилан байршуулах шаардлагатай.

Үргэлжлэл дараагийн хуудсанд



Дэд-хувилбар	Ашиг тус	Сорилт бэрхшээл
Хувилбар 2: Улсын мал эмнэлгийн үйл ажиллагаа		
2.1 Мал эмнэлгийн нийтийн эрүүл мэнд	Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх нь ихэвчлэн хямд өртөгтэй байдаг ч сургалтын материалыг нутгийн хэлээр боловсруулах, турших ажилд харилцааны тусгай мэдлэг шаардагдана. Энэ хамтын ажиллагааг хөгжүүлэхэд боломжтой мал эмнэлэг, эрүүл мэнд, WASH (Ус, Орчины Эрүүл Ахуй) болон бусад салбартай нягт хамтран ажиллах хэрэгтэй.	Үр дүнтэй арга барил нь олон нийтийн оролцоог шаарддаг. Мал аж ахуй эрхлэгчид онцгой байдлын туршид ч хамгийн чухал оролцогчид байх болно. Хэрвээ хянуур удирдаж цаг хугацаанд нь багтаахгүй бол энэ нь амжиргаанд тулгуурласан шууд тусламжаас нөөцийг үр ашиггүй байдал руу чиглүүлж болзошгүй.
2.2 Мал амьтны өвчний тандалт	Энэ (тандалт) нь бусад мал эмнэлгийн арга хэмжээг нөхөж бусад арга хэмжээний үр нөлөөг үнэлэхэд тусална. Энэ нь мал эмнэлгийн төв байгууллага болон хямралд өртсөн газар нутгийн хоорондын уялдаа холбоог бий болгодог Энэ нь зарим улс орон, бүс нутагт малын олон улсын худалдааг хөгжүүлэхэд тус дөхөм болно	Энэ (тандалт) нь тандалтын тодорхой зорилгод үндэслэсэн байх шаардлагатай. Энэ (тандалт) нь үйл ажиллагаанд чиглэсэн үйл явц биш харин өгөгдөлд тулгуурласан процесс болж чадна. Хэрвээ цаг хугацаанд нь зөв менежмент хийхгүй бол хүмүүсийн амьжиргааг шууд дэмжихэд зориулагдсан нөөцийг өөр тийш үр ашиггүй зарцуулж болзошгүй.

Үйл ажиллагаанууд (тусламж)-ыг хэрэгжүүлэх цаг хугацаа

Гэнэтийн болон удаан явцтай аль ч гамшгийн үе шат бүрд мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээ үзүүлэх нь тохиромжтой байдаг. Түүнчлэн нөхөн сэргээлтийн үе шатанд улсын мал эмнэлгийн чиг үүргийг дэмжих нь хамгийн тохиромжтой байж болох юм. Яг энэ үед мал амьтны өвчнийг яаралтай эмчлэхэд мал эмнэлгийн эмнэл зүйн тусламж үйлчилгээ нь чиглэгдэнэ. (Хүснэгт 6.2-г харна уу) Мал эмнэлгийн эмнэл зүйн тусламж үйлчилгээ нь



ихэвчлэн хавсарсан онцгой байдлын үед тохиромжтой байдаг. Улсын мал эмнэлгийн чиг үүргийг дэмжих цаг хугацаа нь нөхцөл байдлаас хамаарч өөр өөр байж болно. Тухайлбал, хямралд өртсөн улс орны бүс нутаг нь удаан хугацаа өнгөрөхөд зөрчилдөөн харьцангуй бага түвшинд хүрч болно. Энэ нь мал эмнэлгийн нийтийн эрүүл мэнд, өвчний тандалтад дэмжлэг үзүүлэх зэрэг урт хугацаанд хийгдэх ажлыг тодорхойлох боломж олгодог.

Хүснэгт 6.2. Мал эмнэлгийн тусламжийн боломжит цаг хугацаа

Хувилбарууд	Гэнэтийн гамшиг		
	Гэнэтийн хор хохирол	Эрт үеийн нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлт
1. Мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээ	✓	✓	✓
2. Улсын мал эмнэлгийн үйлчилгээ	—	—	✓

Хувилбарууд	Удаан явцтай гамшиг			
	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
1. Мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээ	✓	✓	✓	✓
2. Улсын мал эмнэлгийн үйлчилгээ	—	—	—	✓

Хэрэв вакцинжуулалт хийх гэж байгаа бол вакцинжуулалтын цаг хугацаа нь маш чухал. Учир нь малын олон нэрийн өвчний дэгдэлт нь улирлын шинж чанартай байдаг. Вакцины дархлааны үргэлжлэх хугацаа нь тухайн өвчин эсвэл вакцинаас хамаарч хязгаарлагдаж болно. Эдгээр тохиолдолд вакцинжуулалтыг халдвар дэгдэхээс өмнө хийх ёстой. Гэхдээ жилийн энэ цаг үе нь хүмүүнлэгийн хямралын цагтай давхцахгүй байх магадлалтай бөгөөд хэрвээ цаг хугацаа давхцвал вакцинжуулалт үр дүнгүй байж магадгүй. Сүүлийн олон жилийн хугацаанд үргэлжилсэн онцгой байдлын үеийн вакцинжуулалтын хуанлийг вакцинжуулалтын цагийг зөв төлөвлөхөд ашиглаж болно.

LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн түншлэлийн стандартууд (ХТС)-тай холбогдох нь

Мал эмнэлгийн тусламж үйлчилгээ нь онцгой байдлын үед дангаараа малыг



амьд үлдээх, ашиг шимийг нь нэмэгдүүлэх баталгаа болохгүй. Тиймээс мал эмнэлгийн тусламжийг амьжиргаанд суурилсан мал аж ахуйн бусад арга хэмжээнүүдтэй уялдуулах ёстой. Малд тэжээл, ус хэрэгтэй (*Бүлэг 4: Малын тэжээл* болон *Бүлэг 5: Ус*. Зарим газарт малын байр шаардагдана (*Бүлэг 7: Малын байр харна үү*).

Мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээ нь амьд үлдсэн мал, нөөцийг хадгалахад тусалсанаар малын тоо толгойг бууруулахад нэмэлт дэмжлэг болдог (*8-р бүлэг: Малын тоо толгойг бууруулах* хэсгийг үзнэ үү). Мал эмнэлгийн нийтийн эрүүл мэндийн үйл явцад мал нядалгааны өмнөх болон дараах үзлэг багтах ба тэдгээр нь нядалгааны дараа чухал ач холбогдолтой. Мөн мал эмнэлгийн үйлчилгээ нь малжуулах үеийн тухайлбал: мал, амьтныг тараасны дараа эсвэл мал, амьтныг худалдан авахаас өмнө шинжилгээнд хамруулахад нэмэлт дэмжлэг шаардлагатай (*Бүлэг 9: Малжуулах*).

Мал эмнэлгийн тусламж нь мал эмнэлгийн болон мал эмнэлгийн туслах ажилтнууд, хувийн хэвшлийн эм ханган нийлүүлэгчид зэрэг орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчдийг дэмжих шаардлагатай бөгөөд тэдний үйл ажиллагааг сулруулж болохгүй. Эдийн засгийг сэргээх минимум стандарт (MERS) нь зах зээлд дүн шинжилгээ хийх, эдийн засаг, хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд амьжиргааг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зааварчилгаа болдог.

LEGS зарчмууд болон бусад анхаарах асуудлууд

Хүснэгт 6.3: LEGS-н зарчмууд мал эмнэлгийн тусламжид хамааралтай байдал

6

LEGS-н зарчим	Мал эмнэлгийн тусламжид LEGS-н зарчмууд хэрхэн хамааралтай болохыг харуулсан жишээ
1. Амьжиргаанд суурилсан хөтөлбөрийг дэмжих нь	Мал эмнэлгийн үйлчилгээ нь малын хорогдлыг бууруулж малыг санхүүгийн болон амьжиргааны эх үүсвэр болгон хамгаалах боломжийг олгодог. Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч нартай хамтран ажиллаж, эмийг үнэ төлбөргүй тараахгүй байх нь гамшгийн нөхцөл байдлын дараа шаардлагатай үйлчилгээг алдагдуулахгүй байхад тусламжийн байгууллагуудад нэмэр болно.

Үргэлжлэл дараагийн хуудсанд



LEGS-н зарчим	Мал эмнэлгийн тусламжид LEGS-н зарчмууд хэрхэн хамааралтай болохыг харуулсан жишээ
2. Олон нийтийн оролцоог хангах	Мал эмнэлгийн үр дүнтэй хариу арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх нь ард иргэдийн идэвхтэй оролцооноос хамаарна. Мал аж ахуйн хариу арга хэмжээний үр нөлөөг ойлгохын тулд оролцооны нөлөөллийн үнэлгээг хийхийг зөвлөж байна. Мал аж ахуй эрхлэгчид үйлчилгээний дизайн, үнэлгээг хийх болон хүргэхэд оюуны чухал хувь нэмэр оруулж чадна. Тэд ихэвчлэн малын эрүүл мэндийн асуудал тухайлбал өвчний шинж тэмдэг, халдвар дамжих хэлбэр, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах арга замуудын талаар нарийвчилсан мэдлэгтэй байдаг. Энэ мэдлэг нь ялангуяа бэлчээрийн болон бэлчээр, хөдөө аж ахуйг хослон эрхэлдэг бүлэг (нэг дор хамт амьдардаг, нийтлэг эрх ашигтай бүлэг хүмүүс)-т сайтар баримтжуулсан байдаг. Сургалт явуулж байгаа агентлаг орон нутгийн иргэдийг сургаж тэдний мэдлэг дээр тулгуурлан Олон нийтэд түшиглэсэн малын эрүүл мэндийн ажилтан (ОНТМЭА)-тай болгоход дэмжлэг үзүүлэх ёстой.
3. Байгаль орчныг хамгаалах болон уур амьсгалын өөрчлөлтөд хариу үзүүлэх	Мал сүрэг эсвэл тухайн мал амьтанд хэрэглэх эмийг сонгохдоо хүрээлэн буй орчны бохирдолын эрсдэлийг бууруулахад анхаарал хандуулна. (жишээлбэл зарим акрацид эсвэл гельминтийн эсрэг бэлдмэлийг их хэмжээгээр хэрэглэхээс аль болох зайлсхийх) Онцгой байдлын үед, ялангуяа байгалийн нөөцөд ноцтой нөлөөлж буй ган гачиг зэрэг онцгой байдлын үед байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг үргэлж анхаарч үзэх хэрэгтэй. Мал эмнэлгийн үйлчилгээ нь өрхийн хэмжээнд үр дүн гарах магадлал багатай, энэ орон нутагт тогтвортой байх боломжгүй харин эрүүл, илүү ашиг шимтэй малын сүргийг тогтвортой хадгалахад тусалдаг.
4. Бэлэн байдал болон эрт хариу арга хэмжээг дэмжих	Үр дүнтэй мал эмнэлгийн үйлчилгээ нь чанартай эмийг шаарддаг. Тиймээс чанартай эм нийлүүлэх эх үүсвэрийг тодорхойлох, нийлүүлэлтийн сүлжээ, хадгалах байгууламжийн зураглалыг гаргаж, тэднийг урьдчилан байршуулахад бэлэн байх нь чухал юм. Оролцоот тархвар судлалын аргыг ашиглах нь онцгой байдлын үед хамаарах гол гол өвчнийг тодорхойлж, эрэмбэлэхэд нь чухал үүрэгтэй. Хүнд суртлын эсрэг бэлэн байх ба/эсвэл эрт хариу арга хэмжээ авах, санхүүжилтийн үр дүнтэй урсгалыг бий болгох нь шуурхай хариу арга хэмжээ авахад чухал үүрэгтэй.

Үргэлжлэл дараагийн хуудсанд



LEGS-н зарчим	Мал эмнэлгийн тусламжид LEGS-н зарчмууд хэрхэн хамааралтай болохыг харуулсан жишээ
5. Хариу арга хэмжээний зохицуулалтыг хангах нь	Зохицуулалт нь мал эмнэлгийн үйлчилгээг тууштай үзүүлэхэд тусална. Мал эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээний үүрэг, хариуцлагын зохицуулалт, тохиролцоо нь будлианаас зайлсхийхэд чухал ач холбогдолтой. Үр ашгийг дээд зэргээр нэмэгдүүлэхийн тулд мал эмнэлгийн дэмжлэгийг зохицуулахад LEGS-н бусад техникийн арга хэмжээ шаардлагатай. Олон нийтэд түшиглэсэн малын эрүүл мэндийн ажилтан (ОНТМЭА)-ыг хамруулсан (тухайлбал, ОНТМЭА -ын сонголт хийх, сургах, хянах гэх мэт) үйл ажиллагаатай уялдуулсан арга барил шаардлагатай. Үнэ тогтоох эсвэл бүрэлдэхүүн хэсгийн үнэ цэнийн тууштай байдлыг хангахад чиглэсэн эрхийн бичиг бүхий мал эмнэлгийн үйл ажиллагаа бүхий хамтарсан арга барил шаардлагатай. Вакцинжуулалт гэх мэт өвөрмөц үйл ажиллагааны хувьд цаг хугацаатай уялдуулах зохицуулалтыг хийх боломжтой (жишээлбэл, хавсарсан гамшгийн үед вакцинжуулалтын хуанли ашиглах).
6. Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрийг дэмжих нь	Жендерийн мэдрэмжтэй мал эмнэлгийн тусламжийн хөтөлбөр нь эмэгтэйчүүдийн хувьд мал эмнэлгийн ажилтан эсвэл малын эрүүл мэндийн бүтээгдэхүүн борлуулагч болгоход чиглэсэн асуудлыг шийдвэрлэх боломж юм. Малын эрүүл мэндийн мэргэжилтнүүд нь эмэгтэйчүүдийн ихэвчлэн хэрэглэдэг ажлын зориулалттай малыг эмчлэх ур чадвар, мэдлэгтэй байх ёстой. Мэдлэгийг олгодог хүмүүс болон сургалтын хөтөлбөрүүдэд жендерийн талаарх тусдаа бүрэлдэхүүн хэсэгтэй байх ёстой. Боломжтой бөгөөд тохиромжтой тохиолдолд тэд тусгайлан чиглэсэн үйл ажиллагаагаар дамжуулан эмэгтэйчүүдийг сургалтад татан оролцуулах болон ОНТМЭА-наар эмэгтэйчүүдийг сонгон ажилд авах ёстой.



LEGS-н зарчим	Мал эмнэлгийн тусламжид LEGS-н зарчмууд хэрхэн хамааралтай болохыг харуулсан жишээ
6. Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрийг дэмжих нь (Үргэлжлэл)	Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр нь онцгой байдлын үед мал аж ахуй эрхлэгчид болон малын эрүүл мэндтэй холбоотой жендерийн онцлогтой асуудлуудыг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Малын эрүүл мэндийн ажилтнууд шувуу, бог мал, илжиг зэрэг эмэгтэйчүүдийн өмчлөл, мэдэлд байдаг малыг нэн тэргүүнд анхаарч үзэх хэрэгтэй. Өрх толгойлсон эмэгтэйчүүд болон бусад эрсдэлт бүлэгт хамаарах хэсэгт мал эмнэлгийн дэмжлэгийн тусгай шаардлага тавьж болно. Эмэгтэйчүүд ихэвчлэн угсаатны уламжлалт мал эмнэлгийн тодорхой мэдлэгтэй байдаг тул хариу арга хэмжээг төлөвлөхдөө үүнийг анхаарах ёстой. Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр нь хөдөлмөрийн хуваарийн өөрчлөлтийг тодорхойлох боломжийг олгоно (жишээлбэл, онцгой байдлын үед эмэгтэйчүүд янз бүрийн төрлийн малыг хариулж маллах үед).
7. Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих	Мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь олон нийтэд түшиглэсэн тэдний дэмжлэгийг хүлээж байгаа тохиолдолд илүү үр дүнтэй, тогтвортой байх болно. Ийм хандлага нь малын эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хувьд нутгийн иргэд чухал хүч гэдгийг хүлээн зөвшөөрөхөд хялбар байх болно. Олон нийтэд түшиглэсэн малын эрүүл мэндийн тогтолцоо нь хамгийн алслагдсан хөдөөгийн иргэдэд мал эмнэлгийн тусламж үзүүлэх үр дүнтэй арга бөгөөд нутагшсан тогтолцоо юм. Тэд мал эмнэлгийн нийтийн эрүүл мэнд, малын өвчний тандалтын тогтолцоонд хувь нэмэр оруулах боломжтой. Орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн төрийн бус байгууллагууд нь мал эмнэлгийн эрхийн бичгийн схем зэрэг арга хэмжээг төлөвлөх, хянах ажилд хөндлөнгөөс оролцох ёстой. Мөн орон нутгийн засаг захиргаа, ТББ-уудыг сургалтын хөтөлбөр (жишээ нь ОНТМЭА-д зориулсан) боловсруулах, зохион байгуулах, ОНТМЭА-ын систем, ваучерын схемийн стандарт, удирдамжийг хамтран боловсруулахад тэдэнд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

Үргэлжлэл дараагийн хуудсанд



LEGS-н зарчим	Мал эмнэлгийн тусламжид LEGS-н зарчмууд хэрхэн хамааралтай болохыг харуулсан жишээ
8. Хяналт, үнэлгээ, хариуцлагатай байдал, суралцах (ХҮХС)-г баримтлах	Мал эмнэлгийн хариу арга хэмжээний явцыг хянах, хэрэгжилтэд цаг тухайд нь зохицуулалт хийхэд хяналт, үнэлгээ, хариуцлагатай байдал, суралцах (ХҮХС)-д шаардлагатай. Мал эмнэлгийн яаралтай хариу арга хэмжээний тухай мэдлэгийг олгох чадавхийг сайжруулахын тулд илүү их нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагатай байна. Улсын мал эмнэлгийн чиг үүргийг дэмжих, онцгой байдлын үед авах арга хэмжээний амьжиргаанд үзүүлэх үр нөлөөний талаар баримт нотолгоо маш хязгаарлагдмал байдаг. Хяналтын тогтолцоо болон нөлөөллийн үнэлгээ нь үйл явцыг хөнгөвчлөх цаашид практикийг сайжруулахад үнэ цэнэтэй мэдээлэл болно.

Хамгаалал

Бэлэн мөнгө болон эсвэл өндөр үнэтэй эм авч явдаг мал эмнэлгийн ажилчид нь дээрэм, халдлагад өртөж болзошгүй. Мал амьтны эрүүл мэндийг хэрэгжүүлэхэд аюулгүй байдлыг хангаж ажиллах шаардлагатай. Хөрш зэргэлдээ айл эсвэл газар нутгаас хулгайлагдсан мал амьтад нь тухайн сүрэгтээ өвчин шинээр үүсгэнэ. Мөн бэлчээрт байгаа мал, түүний тоног хэрэгсэл, эд хөрөнгө хулгайд алдагдах эрсдэлтэй. (*Бүлэг 7: Малын байр, байршуулалт* хэсгийг харна уу).

Хүртээмж

Дэд бүтэц, харилцаа холбоо сул хөгжсөн алслагдсан бүс нутагт мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нь “хэвийн” үед ч хүндрэлтэй байдаг. Бааз (мал сүргээ адгуулж нэг дор амьдарч байгаа хэсэг хүмүүс амьдарч буй газар) руу хүрэхэд зарим тохиолдолд зөвхөн явган явах эсвэл завь ашиглаж болно. Байнга нүүдэллэж нэг газарт удаан амьдардаггүй малчдын мал нь мал эмнэлгийн үйлчилгээнд тогтмол хамрагдах боломжгүй байдаг.

Алслагдсан нутагт байгаа хот айл, иргэд онцгой байдал үүссэн үед эрсдэлд илүү өртөх магадлалтай байдаг. Ийм нөхцөлд ихэнх тохиолдолд мал эмнэлгийн туслах ажилтнууд (ОНТМЭА) нь малчдад хүрч очиж, тэдэнтэй ажиллах боломжтой тул хамгийн тохиромжтой үйлчилгээ үзүүлэгчид юм.

Боломж болон зардлыг нөхөх

Орон нутгийн иргэдэд мал эмнэлгийн тусламж үзүүлэхдээ зардлаа нөхөх янз бүрийн аргыг санал болгоно. *Хүснэгт 6.1*-д гурван сонголтыг тоймлон харуулав.



Гамшгийн үед хариу арга хэмжээ авах байгууллагууд заримдаа мал эмнэлгийн үнэ төлбөргүй тусламж үзүүлдэг. Энэ практик нь мал эмнэлгийн үйлчилгээний төлбөрөөс хамаарч одоо үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Мөн зарим үйлчилгээ төлбөртэй, зарим нь үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлж байдаг нь мал аж ахуй эрхлэгчдийг төөрөгдөлд оруулж болзошгүй юм. Мал эмнэлгийн эмнэл зүйн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх нь хямралд нэрвэгдсэн ард иргэдийн амьжиргаанд ихээхэн үр өгөөжтэй, үр ашигтай, тэгш байдаг ч хамрах хүрээ нь маш хязгаарлагдмал байдаг. Амьжиргааны тэтгэмжийн талаар үйлчилгээний төлбөрт суурилсан эсвэл ваучерын схем ашигладаг тухай олон нотолгоонууд ОНТМЭА-ны тогтолцоонд байдаг.

Ядуу малчид энгийн, хямд өртөгтэй, олон нийтэд түшиглэсэн арга барилд суурилсан хувийн мал эмнэлгийн үйлчилгээг ашигладаг болохыг нотлох баримт харуулж байна. Гэсэн хэдий ч онцгой байдлын үед гадны тусламжийн байгууллагууд мал эмнэлгийн эмнэлзүйн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, тэгш, үр дүнтэй үзүүлэхийн зэрэгцээ орлого шаарддаг орон нутгийн хувийн үйлчилгээ үзүүлэгчдийг дэмжих сорилттой нүүр тулгардаг. Мал эмнэлгийн эрхийн бичиг (ваучер) гэх мэт аргууд нь ядуу мал бүхий хүмүүст мал эмнэлгийн үйлчилгээг хүртээмжтэй болгохын зэрэгцээ хувийн хэвшлийг ч хамтад нь дэмждэг.



Хайрцаг 6.1

Онцгой байдлын үед мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээг хүргэх нь:

Төлбөрийн гурван хувилбар

Үнэ төлбөргүй үйлчилгээг хүргэх: Хамрах хүрээ нь ихэвчлэн гадны агентлагууд (байгууллага)-ын санхүүжилтийн хэмжээнээс хамаардаг. Ихэнх тохиолдолд үйлчилгээ нь хямралд өртсөн иргэдийн зөвхөн багахан хэсэгт л хүрдэг. Хэрэв эмнэлзүйн үйлчилгээ нь тусламжийн байгууллагын ажилтнаар дамжин хүрч байгаа бол орон нутгийн үйлчилгээ, зах зээл, урт хугацааны хөгжлийн үйл явц удаашрах магадлалтай байна. Ямар нэгэн удирдлага, хяналтгүй тохиолдолд үйлчилгээ хүргэж байгаа цэг дээр үнэ төлбөргүй үйлчилгээ хүрэхгүй байх эрсдэлтэй.

Одоо байгаа эсвэл шинээр бэлтгэгдсэн мал эмнэлгийн туслах ажилтнууд: Ихэвчлэн эдгээр ажилтнууд мэргэжлийн үйлчилгээг олон нийтэд арай бага үнэлгээгээр хүргэдэг. Энэхүү хэлбэр нь орон нутгийн чадавхийг бэхжүүлж, тогтолцоог дэмжиж цаашид цаг хугацаа өнгөрөх тусам гамшгийн үр нөлөөг бууруулах боломжийг олгодог. Энэ нь мөн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулдаг болно. Нөгөө талаас боломжийн үнэтэй үйлчилгээг хэвээр хадгалах нь бэрхшээлтэй байж магадгүй юм.

Үйлчилгээнд зориулсан төлбөрийг үе шаттайгаар нэвтрүүлэх:

Энэ хувилбарын хувьд онцгой байдлын идэвхтэй үед үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг. Дараа нь малын худалдааны захууд ажиллаж эхэлснээр үйлчилгээ үзүүлэгчдийн зүгээс үйлчилгээний төлбөрийг төлөх шаардлагыг тавина. Энэ хувилбарын эрсдэл нь эхний хувилбартай тун төстэй. Өмнө нь үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлж байсан бол дараагийн шатанд төлбөр төлөх шаардлагатай гэж үйлчилгээ авагчдыг ятгахад хэцүү байж магадгүй юм.

Бэлэн мөнгө, эрхийн бичиг (ваучер)-ийн туслалцааг ашиглах нь

Онцгой байдлын үед мал эмнэлгийн мэргэжилтнүүд болон туслах ажилтнууд нь мал эмнэлгийн тусламж үзүүлэх агентлагын хамтрагч түнш нь байх боломжтой. Эрхийн бичиг (ваучер гэх мэт) механизмуудын үйлчилгээг үзүүлэхэд ашиглаж болно. *(Бүлэг 3: Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөлт* хэсгийг үзнэ үү.) Бэлэн мөнгө болон эрхийн бичиг нь хамгийн ядуу, их эрсдэлтэй мал аж ахуй эрхлэгчдэд туслахад зориулан хэрэглэдэг. Энэ нь онцгой байдлын туршид хувийн үйлчилгээг явуулахад мөн тусалж чадна. Тусламжийн байгууллагууд эмнэл зүйн мал эмнэлгийн



үйлчилгээнд зориулж бэлэн мөнгө, ваучер тараах боломжтой. Төрийн мал эмнэлгийн зарим үйл ажиллагаа нь нөхөн олговор эсвэл шууд бус тэтгэмж олгох хэлбэрээр байж болно. Үйл явцын жишээнүүдийг үзнэ үү: Кени дэх мал эмнэлгийн эрхийн бичгийн схем, Этиоп дахь мал эмнэлгийн эрхийн бичгийн схем, түүнчлэн Нөлөөллийн жишээ судалгаа: Сомали дахь мал эмнэлгийн тусламж болон мал хуваарилалтын тусламжийн эрхийн бичиг.

Хуаран (бааз)

Хүмүүс болон тэдний мал, амьтад нь шилжин нүүдэллэх нь өвчин шинээр тархах нөхцлийг үүсгэж болно. Тухайлбал, өөр өөр бүс нутгийн мал амьтад олноор бөөгнөрч холилдох, тэжээл эсвэл усны тэвшээр дамжин ойрын хавьталд орно. Иймээс хуаран дотор малын өвчний эрсдлийг бууруулахад чиглэсэн тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнийг хийх нэг арга бол шинээр ирж байгаа мал амьтдыг бусад мал амьтдаас өвчин илрэх хүртэлх хугацаанд тусгаарлах зориулалттай хорио цээрийн бүс байгуулах явдал юм (*Бүлэг 7: Малын байр, байршуулалт* хэсгийг үзнэ үү).


Хуаран дотор мал эмнэлгийн нийтийн эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх нь чухал юм. Өвчний эрсдэлийн үнэлгээг тэр дундаа зоонозын өвчлөл, тэдгээр өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ иргэдийн оролцоог хангах аргаар тодорхойлж, хамтран хэрэгжүүлнэ.

Мал эмнэлгийн тусламжийн хувилбаруудын шийдвэрийн мод

Шийдвэрийн мод (*Зураг 6.1*)-д мал эмнэлгийн яаралтай тусламжийн арга хэмжээний хувьд аль нь хамгийн боломжтой, тохиромжтой хувилбар болохыг тодорхойлоход анхаарах зарим гол асуултуудыг нэгтгэн харуулсан болно. Стандартууд, үндсэн арга хэмжээнүүд болон зааварчилгаануудыг нарийвчилсан төлөвлөлтөд илүү тодорхой мэдээллийг тусгаж түүнийг дагаж мөрдөнө. Боломжтой бол эдгээр нь онцгой байдал эхлэхээс өмнө «хэвийн» үед хийгдсэн бэлэн байдлын үйл ажиллагаанд тулгуурлах ёстой.



Зураг 6.1: Мал эмнэлгийн тусламжийн хувилбаруудад зориулагдсан шийдвэрийн мод





Стандартууд

Стандарт 1: Бэлэн байдал

Мал эмнэлгийн хэрэгцээ, чадавхыг үнэлж, яаралтай тусламжийн төлөвлөгөөг онцгой нөхцөл үүсэхээс өмнө хийдэг.

Үндсэн үйл ажиллагаа

- Олон нийт, орон нутгийн мал эмнэлгийн эрх бүхий байгууллага, үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран мал эмнэлгийн тусламж үзүүлэх онцгой байдлын үеийн төлөвлөгөөг боловсруулах (*Зааварчилгаа 1, 2, 3, 4, 5-ыг үзнэ үү*).
- Орон нутгийн ханган нийлүүлэгчдээс нийлүүлэх малын эмийн чанар, үйлчилгээ үзүүлэгчдийн зүгээс тухайн эмийг зохих ёсоор хадгалах чадавхын үнэлгээнд тулгуурлан хийгдсэн болзошгүй байдлын төлөвлөгөөг нягтлах (*Зааварчилгаа 6-г үзнэ үү*).
- Онцгой байдлын төлөвлөгөөнд тухайн орон нутагт гардаг малын зонхилох өвчин, түүний нөхцөл байдал болон тухайн бүс нутагт тохиолдох онцгой байдлын төрлүүдийг харгалзан үзнэ (*Зааварчилгаа 7-г үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Иргэдийн оролцоотой бэлэн байдлын төлөвлөлт

Мал аж ахуй нь амьжиргааны эх үүсвэр болсон бүс нутагт гэнэтийн эсвэл удаан явцтай гамшгийн эрсдэлээс сэргийлэх мал эмнэлгийн дэмжлэг үзүүлэх бэлэн байдлын төлөвлөгөөг холбогдох байгууллагууд боловсруулах хэрэгтэй. *LEGS 2-р зарчмын дагуу: Олон нийтийн оролцоо.* Олон нийт нь эдгээр төлөвлөгөөг боловсруулахад оролцох, хүйс, нийгмийн янз бүрийн бүлгүүдийн хэрэгцээ, шаардлага тэргүүлэх чиглэлийн ялгаатай байдлыг төлөвлөгөөнд харгалзан үзнэ. Онцгой байдлын төлөвлөгөөг боловсруулахад орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгчид болон төрийн мал эмнэлгийн байгууллагуудын төлөөллийг оролцуулах ёстой.

2. Бодлого болон хууль эрх зүйн хүчин зүйлс

Шуурхай үнэлгээнд бэлэн байдлын төлөвлөлтөд хэрэгжүүлэх хувилбаруудтай холбоотой төрийн болон агентлагийн бодлого, дүрэм, журмыг шуурхай тоймлон үзэж оруулах хэрэгтэй. Жишээлбэл:

- Зарим улс оронд мал эмнэлгийн туслах ажилтан нарын мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулах эрхийг хуулиар хүлээн зөвшөөрдөггүй эсвэл тодорхой хүрээнд хязгаарлагддаг.



- Зарим улс орон малын өвчинтэй тэмцэх өөрийн бодлоготой бөгөөд үүнийг дагаж мөрдөх шаардлагатай; Хэрвээ тэдгээрийг дагаж мөрдөхгүй гэж үзвэл тусламжийн байгууллагууд нь өвчний хяналтын бусад боломжит аргуудыг тэдэнд тайлбарлах шаардлага үүснэ.
- Мөн үндэсний эм бүртгэх байгууллагуудын эмийн бүртгэлд зарим төрлийн мал эмнэлгийн бүтээгдэхүүнийг хэрэглэхийг хязгаарласан байдаг.
- Зарим хандивлагчид болон засгийн газруудын хүнд сурталтай шаардлагын улмаас малын эм худалдан авалтад саад учирдаг. Эдгээр нь онцгой байдлын нөхцөлд хурдан бөгөөд шуурхай худалдан авалтад нөлөөлнө.
- Байгууллагын болон хандивлагчийн бодлого нь зардлаа нөхөх төлөвлөгөөнд саад учруулж болзошгүй.

Бодлогын агуулга гэдэг ойлголт нь амин чухал, боломжит хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх, ирээдүйд гарах нөлөөлөл эсвэл бодлогын арга хэмжээний үндэс суурь болно.

3. Уян хатан санхүүжилт

Боломжтой бол хүмүүнлэгийн хямралд өртөх эрсдэлтэй бүс нутагт ажиллаж буй хөгжлийн хөтөлбөрүүдэд эрт хариу арга хэмжээ авах боломжийг олгох уян хатан санхүүжилт эсвэл хямралыг өөрчлөх арга хэрэгслийг багтаасан байвал зохино. Мал эмнэлгийн эмнэл зүйн тусламж нь онцгой байдлын бүх үе шатанд идэвхтэй, нягт хамааралтай байдаг. Үүнд үйл явцыг удаашруулахгүй байх, хүнд суртал саад учруулах ёсгүй бөгөөд эрт хариу арга хэмжээний нэг хэсэг болгон оруулах ёстой.

6

4. Үйлчилгээний загварчлал

Бэлэн мөнгө эсвэл эрхийн бичиг (ваучер)-ээр дамжуулан мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж байгаа тохиолдолд тусламжийн байгууллагууд нь онцгой байдал үүсэхээс өмнө оролцогч талуудыг тоймлон тодорхойлно. Тухайлбал, ваучерын мөнгөн дүн болон үйлчилгээ үзүүлэгчээс шаардагдах үйлчилгээний хураамж зэрэг байж болно. Гэрээний загварууд болон бусад захиргааны баримт бичгийг урьдчилан бэлтгэсэн байна. Бэлтгэлтэй байх үед анхаарч үзэх үйлчилгээний дизайны бусад асуудлыг *Стандарт 3: Мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээний загвар*-аас үзнэ үү.

5. Мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгчид

Онцгой байдлын үед мал эмнэлгийн эмнэлзүйн тусламж үйлчилгээний ач холбогдлыг харгалзан үзэж бэлэн байдлын төлөвлөгөөнд эрсдэлтэй



бүс нутагт одоо ажиллаж байгаа байгаа мал эмнэлгийн бүх төрлийн ажиллагсдыг татан оролцуулахаар тооцно. Энд тухайн орон нутагт гарч байгаа малын өвчнийг оношлох, эмчлэх чиглэлээр бэлтгэгдсэн мэргэшсэн ажилчдыг онцгойлон авч үзэх хэрэгтэй. Ерөнхийдөө малын эмчээс эхлээд тодорхой төрлийн үйлчилгээ үзүүлдэг мал эмнэлгийн туслах мэргэжилтнүүд эдгээрт хамаарах бөгөөд тэд нар төрийн болон хувийн хэвшлийн аль нэгэнд харьяалагдаж байдаг. Тэдгээр ажиллагсдын талаар бүртгэл хөтлөх нь хариу арга хэмжээг хурдан шуурхай авах боломжийг олгодог. Энэ нь эмнэлзүйн чадавхын дутагдалтай байдлыг тодорхойлох болон холбогдох сургалт, давтан сургалтын хэрэгцээ байгаа эсэхийг тогтооход тусалдаг. Энэ талаар *Стандарт 2: Үнэлгээ ба төлөвлөлт, Стандарт 4: Үзлэг, эмчилгээ* зэргийг үзнэ үү.

6. Эм хангамж, чанар болон хадгалалт

Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгчид болон мал эмнэлгийн эм ханган нийлүүлэгчдийн бүртгэл гаргаж, хөтлөх шаардлагатай. Учир нь мал эмнэлгийн эмийн чанар маш чухал асуудал юм. Дотоодын ханган нийлүүлэгчдийн эмийн чанарыг үнэлж, нийлүүлэлтийн сүлжээг зураглах хэрэгтэй. Эмийн чанарыг лабораторийн шинжилгээгээр шалгах замаар холбогдох үнэлгээг хийнэ. Эмийг хадгалах, түгээх агуулахыг мөн үнэлнэ (жишээлбэл, хөргөлтийн хэрэглээ). Хангалттай хэмжээний эм хадгалах агуулах бүхий сайн чанарын эм нийлүүлэгчийг урьдчилан сонгон шалгаруулж болно. Орон нутгийн ханган нийлүүлэгчид эмийн чанар, хадгалалттай холбоотой асуудлаар тэдний мэдлэгийг дээшлүүлэх эсвэл сургалтад хамруулах нь үр дүнтэй байж болно. Тохиромжтой чанартай малын эмийг дотоодоос ханган нийлүүлэх боломжгүй нөхцөлд эм импортлох төлөвлөгөөнд тусламжийн байгууллагууд анхаарч, төлөвлөлт хийх хэрэгтэй. Тиймээс ч энэ үйл ажиллагаанд нэмэлт цаг хугацаа шаардлагатай болно.

7. Мал амьтны өвчнийг үнэлэх

Онцгой байдлын үед тохиолддог малын өвчин нь “хэвийн” үеийнхээс ялгаатай байж магадгүй. Тухайн нутаг дэвсгэрт нөлөөлж буй онцгой байдлын үндсэн төрлүүдэд хамаарах малын өвчнийг тодорхойлж, эрэмбэлэхийн тулд мал аж ахуй эрхлэгчдийн оролцоотойгоор үнэлгээ хийх хэрэгтэй. Тэргүүлэх ач холбогдолтой өвчнийг эрэмбэлэн тогтооход оролцооны эпидемиологийн аргуудыг ашиглаж болно. Мөн бусад эх үүсвэрээс цуглуулсан мэдээллийг (жишээлбэл, орон нутгийн мал эмнэлгийн байгууллагын тандалтын тайлан г.м) ашиглан энэ үйл ажиллагааг дэмжих боломжтой байдаг.



Стандарт 2: Төлөвлөлт болон үнэлгээ

Хямралд өртсөн хүн ам, тухайлбал эрсдэлт бүлгийг мал эмнэлгийн хэрэгцээ шаардлагын үнэлгээ, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход тэднийг идэвхтэй оролцуулна.

Үндсэн үйл ажиллагаа

- Хямралд өртсөн хүн амын нийгмийн бүх дэд бүлгүүдийг оролцуулан, орон нутгийн мал эмнэлгийн байгууллага болон үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран тэдний оролцоотойгоор мал эмнэлгийн хэрэгцээний талаарх үнэлгээ хийж, тэргүүлэх чиглэлийг тогтоох (*Зааварчилгаа 1*-ийг үзнэ үү).
- Нөлөөлөлд хэдийнээ өртсөн бүс нутагт (эсвэл нүүлгэн шилжүүлсэн иргэдийн хувьд "хүлээн авагч тал") тусламжийн байгууллагуудын тусалцаатайгаар бүх мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгчдийн одоогийн болон боломжит чадавхыг зураглаж, дүн шинжилгээ хийх (*Зааварчилгаа 2*-ыг үзнэ үү).
- Үйлчилгээ үзүүлэгчдийн ажил үйлчилгээг гамшгийн өмнөх үеийн төлбөрийн нөхцөлтэй холбон судалж энэхүү үнэлгээг баталгаажуулах (*Заавар 2*-ыг үзнэ үү).
- Өвөрмөц стратегийг хэрэгжүүлэхийг идэвхжүүлэх эсвэл саад учруулж болохуйц эрх зүйн хүчин зүйлс буюу бодлогын шуурхай дүн шинжилгээг үнэлгээнд багтаасан эсэхийг баталгаажуулах (*Стандарт 1, Зааварчилгаа 3*-ыг үзнэ үү).

Зааварчилгаа

1. Оролцооны аргаар шуурхай үнэлгээ хийх

Оролцооны аргаар шуурхай үнэлгээг дараах байдлаар хийнэ:

- оролцооны аргад сургагдсан туршлагатай мал эмнэлгийн ажилчдыг ашиглан үнэлгээг хийнэ;
- эрсдэлт бүлгийн тэргүүлэх чиглэлүүдэд онцгой анхаарал хандуулах;
- орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшлийн мал эмнэлгийн ажилтнуудыг зөвшилцөлд татан оролцуулна;
- эрсдэлт бүлэгт хамаарч байгаа малын төрөлд анхаарал хандуулан малын эрүүл мэндийн тэргүүлэх ач холбогдол өгөх асуудлыг тодорхойлж, эрэмбэлнэ;
- боломжтой бол зохих шаардлага хангасан хоёрдогч өгөгдөлтэй харьцуулан шалгаж баталгаажуулна.



Хяналтын хуудас болон үнэлгээний аргуудын жагсаалтыг *Хавсралт 6.1: Мал эмнэлгийн тусламж үйлчилгээний үнэлгээний арга, шалгах хуудас-т* дурдагдсан болно. (*Мөн 3-р бүлэг: Яаралтай тусламжийн төлөвлөлт. оролцоонд суурилсан мэдээлэл цуглуулах аргуудыг* үзнэ үү). Онцгой нөхцөл байдлын үед асуумж бүхий малын өвчний албан ёсны судалгаа болон лабораторийн оношилгоо хийх боломж тун хомс байдаг. Өвчний талаар үнэ цэнтэй мэдээлэл олж авлаа ч гэсэн энэ нь шаардагдах нэмэлт цаг хугацаа, зардал, шуурхай арга хэмжээ авах хэрэгцээтэй холбоотойгоор баталгаажуулах нь ховор байдаг.

Удаан үргэлжилсэн хямралын үед өвчинтэй тэмцэх стратегийг боловсронгуй болгохын тулд илүү системтэй малын өвчлөлийн судалгаа эсвэл тандалт шаардлагатай болно. Эдгээр тохиолдолд оролцоот эпидемиологийн аргыг ашиглах ёстой.

2. Мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгчдийн зураглал гаргах, дүн шинжилгээ хийх

Болзошгүй бэлэн байдлын төлөвлөгөөнд (Стандарт 1, заавар 5-ыг үзнэ үү) тусламжийн байгууллагууд нь одоо үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүс (мал эмнэлгийн мэс засалчид болон мал эмнэлгийн бүх төрлийн мэргэжлийн бусад ажилтнууд), тэдгээрийн үйл ажиллагаа, хамрах хүрээний талаарх зураглалыг боловсруулах ёстой. Хэрэв тэд мал эмнэлгийн ажилчдын тооллогыг аль хэдийн хийсэн бол энэ нь бэлэн байдлын төлөвлөгөөний нэг хэсэг болно. (*Стандарт 1: Бэлэн байдал* хэсгийг үзнэ үү) Зураглал нь тусламжийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлэх стратеги, түүний дотор төлөвлөсөн газарзүйн хамрах хүрээ, эрсдэлт бүлэгт хүрэх боломжийг тодорхойлоход тусална. Үүнд өөр өөр үйлчилгээ үзүүлэгч нарын (үүнд уламжлалт эмч нар болон бусад албан бус ажилчдыг багтааж болно) үзүүлсэн ялгаатай үнэ ханшийг оруулах ба энэ нь газрын зураг, анализын нэг хэсэг болно.

Улс орнуудын хувьд ялгаатай байдаг боловч дараах ангилалд мал эмнэлгийн ажилтнууд хамаарагдана. Үүнд:

- Мал эмнэлгийн туслах ажилтнууд
- Мал амьтны эрүүл мэндийн сайн дурын ажилтан/туслах;
- Мал амьтны эрүүл мэндийн техникч;
- Мал эмнэлгийн үндэсний хууль тогтоомж, дүрэмд тодорхойлогдсон олон нийтэд тулгуурласан малын эрүүл мэндийн ажилтан (ОНТМЭА) нар.

Зарим (ихэвчлэн зэвсэгт мөргөлдөөнтэй газарт) онцгой байдлын үед төр, хувийн хэвшлийн аль аль нь мал эмнэлгийн үйлчилгээг зохих ёсоор үзүүлж чадахгүй байх магадлалтай. Ийм тохиолдолд гадны тусламжийн



байгууллагууд нь ОНТМЭА болон/эсвэл мал аж ахуй эрхлэгчдийг сургах замаар олон нийтэд түшиглэсэн үйлчилгээг дэмжих нь зүйтэй. Энэхүү үйл ажиллагаа нь засгийн газрын болон/эсвэл хувийн хэвшлийн чадавхыг нэмэгдүүлэх төлөвлөгөөнд үндэслэх ба энэ нь тодорхой стратегийн нэг хэсэг болох боломжтой болно.

Стандарт 3: Мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээний загвар

Мал эмнэлгийн үйлчилгээг хямралд нэрвэгдсэн ард иргэдийн идэвхтэй оролцоотойгоор орон нутгийн нийгэм, техник, аюулгүй байдал, бодлогын нөхцөл байдалд тохирсон байдлаар зохион байгуулдаг.

Үндсэн үйл ажиллагаа

- Үйлчилгээний загварыг баталгаажуулахын тулд бэлэн байдлын төлөвлөгөө болон/эсвэл анхдагч үнэлгээний мэдээлэлд хийсэн дүн шинжилгээг ашиглаж байгаа эсэхийг нягталж үзнэ. Мөн хямралд өртсөн хүн ам, түүний дотор эрсдэлт бүлгийн хүн амын идэвхтэй оролцоонд тулгуурласан эсэхийг мөн нягталж үзнэ. (*Зааварчилгаа 1-ийг үзнэ үү*).
- Үйлчилгээний загвар нь эрсдэлт хэсэгт хүрч үйлчлэх өвөрмөц арга замууд ялангуяа хүртээмж, чадвартай холбоотой асуудлуудыг шийдэж байгаа эсэхийг шалгана уу (*Зааварчилгаа 2-ыг үзнэ үү*).
- Үйлчилгээний загварт шаардлагатай мал эмнэлгийн вакцин, эмийн олдоц болон түүнийг шуурхай худалдан авах хэрэгцээг харгалзан үзсэн эсэхийг нягталж үзнэ. Мөн орон нутгийн түвшинд тухайн бүтээгдэхүүний чанарыг зохих ёсоор хадгалах боломжит агуулах байгаа эсэхийг анхаарч нягталж үзэх хэрэгтэй (*Зааварчилгаа 3-ыг үзнэ үү*).
- Үйлчилгээний загварт шаардлагатай бол орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчдийг түргэвчилсэн байдлаар сургах төлөвлөгөө тусгагдсан эсэхийг шалгана уу (*Зааварчилгаа 4-ийг үзнэ үү*).
- Үйлчилгээний загварт орон нутгийн нийгэм, соёлын хэм хэмжээ ялангуяа шашны болон жендерийн үүрэг хариуцлагад суурилсан эсэхийг нягталж үзэх (*Зааварчилгаа 5-ыг үзнэ үү*).
- Үйлчилгээний загварт орон нутгийн иргэд, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч болон тусламжийн байгууллагын ажилтнуудын аюулгүй байдлыг дээд зэргээр хангасан эсэхийг нягталж шалгах (*Зааварчилгаа 6-г үзнэ үү*).
- Боломжтой бол үйлчилгээний төлбөрийг үйлчилгээний загварт тусгасан эсэхийг нягталж шалгах (*Зааварчилгаа 7-г үзнэ үү*).
- Үйлчилгээний загвар нь мал эмнэлгийн туслах мэргэжилтнүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах чадавхыг буй болгоход чиглэгдсэн эсэхийг нягталж үзэх (*Зааварчилгаа 8-ыг үзнэ үү*).



Зааварчилгаа

1. Үнэлгээний үр дүнд тулгуурлан төлөвлөлт хийх

Үйлчилгээг загварчлах нь анхдагч үнэлгээний явцад гарсан малын эрүүл мэндийн тэргүүлэх асуудлуудыг эрэмбэлэн тодорхойлоход чиглэгдсэн байх ёстой. *(Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөлт 3-ыг үзнэ үү)*. Мал эмнэлгийн анхан шатны үйлчилгээ нь малын эрүүл мэндийн бүх асуудалд чиглэн ажиллах боломж муутай төдийгүй зохимжгүй. Ихэнх тохиолдолд хязгаарлагдмал хүрээ, хэмжээтэй вакцин, эм бэлдмэл нь тухайн бүс нутагт хамгийн чухал анхаарах шаардлагатай өвчнөөс урьдчилан сэргийлэх эсвэл эмчлэх боломжтой. Иймээс мал амьтны өвчлөл, мал эмнэлгийн үйлчилгээний талаар малчдыг оролцуулан бүх ашиг хүртэгч талууд харилцан ойлголцож хүлээн зөвшөөрсөн байх шаардлагатай. Хэрвээ тодорхой зүйлд чиглэсэн эрэмбэлэлт хийж чадахгүй тохиолдолд (жишээлбэл, хүйтэн хэлхээ гэх мэт шаардлагатай байгууламжууд байхгүй үед) өртсөн иргэдийг оролцуулаад бүх оролцогч талууд сайтар зөвлөлдөн зөвшилцөлд хүрсэн байх ёстой. Үүний нэгэн адил үйл ажиллагаа явуулах тохиромжтой цаг хугацааны талаар (ялангуяа вакцинжуулалт) бүх оролцогч талуудтай хэлэлцэж тохиролцсон байна. Боломжтой бол үйлчилгээний төлөвлөлтөд гамшигт нэрвэгдсэн ард иргэдийн идэвхтэй оролцоог хангах ёстой.

2. Эрсдэлт бүлэгт хүрэх нь

Үйлчилгээний загвар нь эрсдэлт бүлгийн өмчлөлд байгаа болон эдэлж хэрэглэж буй малын төрлийг харгалзан үзэж, тухайн төрлийн мал амьтны эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч үзвэл зохино. Мал эмнэлгийн үйлчилгээ авах тэгш байдлыг хангахын тулд үйлчилгээний боломж, хүртээмжийн асуудалд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Хязгаарлагдмал дэд бүтэцтэй алслагдсан хүрэх боломж багатай бүс нутгуудад нэвтрэхэд үнэтэй тээврийн хэрэгсэл (жишээлбэл, агаарын тээврээр) ашиглах шаардлагатай байж болох бөгөөд энэ нь тухайн төсвийн хүрээнд хамрах хүрээг хязгаарладаг. Энэ тохиолдолд орон нутгийн мал эмнэлгийн мэргэжлийн ажиллагсдыг ашиглах замаар явганаар эсвэл луус, унадаг дугуй, завь зэрэг орон нутгийн ердийн тээврийн хэрэгслээр зорчин үйлчилгээг хүргэх боломжтой. Зарим тохиолдолд хөтөлбөрүүд нь орон нутгийн мал эмнэлгийн ажилчдыг тээврийн хэрэгслээр хангах эсвэл шаардлагатай бусад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

Гэнэтийн гамшгийн үед үнэ төлбөргүй тээвэрлэлт хийнэ. Удаан үргэлжилсэн хямралын үед зардлыг хувааж төлөх зохицуулалт нь ихэвчлэн тохиромжтой байдаг. Үйлчилгээний төлбөрийн стратеги нь үйлчилгээг шуурхай, тэгш хүргэх хэрэгцээг харгалзан үзэхийн зэрэгцээ боломжтой бол хувийн



хэвшлийн мал эмнэлгийн ажилчдыг дэмжихэд чиглэх ёстой. Өндөр эрсдэлтэй бүлэг, хувийн мал эмнэлгийн ажилтан нарыг туслан гүйцэтгэгчээр тодорхой богино хугацаанд үйлчилгээ үзүүлэхэд ажиллуулах боломжтой. Тэд эрхийн бичиг (ваучер)-ын схемийг ашиглаж болно (Үйл явцын жишээ судалгаа: Кени дэх мал эмнэлгийн эрхийн бичгийн схем болон Этиоп дахь мал эмнэлгийн эрхийн бичгийн схемийг үзнэ үү). Хувийн хэвшлийн мал эмнэлгийн салбар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа эсвэл мал эмнэлгийн үйлчилгээнд төрөөс татаас олгодог нутагт, тухайн нутагт дагаж мөрдөж байгаа үйлчилгээний үнийн бодлогыг баримтлах ёстой. Эдгээр нөхцөл байдал нь зорилтот эрсдэлт бүлгүүдийн хувьд үнээс чөлөөлөх боломжийг олгодог. Төөрөгдлөөс зайлсхийхийн тулд эдгээр асуудалд олон нийтийн оролцоо, иргэдийн төлөөлөгчдийн зөвшилцөл, түүнчлэн бүх оролцогч талуудыг оролцуулсан тодорхой зөвшилцөл шаардлагатай болно.

3. Яаралтай худалдан авалт, хадгалалт

Малын эм худалдан авах туршлага багатай байгууллага бол мэргэжлийн хүнээс зөвлөгөө авах ёстой. Дотоодын болон олон улсын зах зээлээс нийлүүлэгчдийн хувьд малын эм болон вакцины чанарын хооронд ихээхэн ялгаатай байдаг. Тогтсон хугацаанд багтаан хугацаа хэтрүүлэхгүйгээр их хэмжээний эмийг нийлүүлэх хүчин чадал нь харилцан адилгүй ялгаатай байдаг. Өргөн хүрээтэй их хэмжээний бүтээгдэхүүний худалдан авалт нь зарим бэрхшээлийг үүсгэдэг байна. Зарим мал эмнэлгийн вакцинд өвчний эмгэг төрүүлэгчийн нутгийн үүсгэгчийг ялган авч ашиглах шаардлага үүсдэг тул тусламжийн байгууллагууд нь вакцины найрлагыг зөв эсэхийг сайтар шалгах шаардлага тулгардаг байна. Дотоодын импортлогчид нь ихэвчлэн улсын нийслэлд голлон төвлөрч байрладаг ба тэндээс бэлэн байгаа эмийг боломжийн хэмжээгээр нийлүүлэх боломжтой байдаг. Гэсэн хэдий ч эмийн чанар, хүчинтэй хугацаа, эм хадгалах нөхцөл зэргийг сайтар нягтлан үзэх хэрэгтэй. Орон нутгийн түвшинд мал эмнэлгийн олон нэрийн вакцин, зарим эмийн хувьд хүйтэн агуулах шаардлагатай болно. Тохиромжтой нөхцөлд хадгалах байгууламж, тээвэрлэх, хадгалах хүйтэн хэлхээ байхгүй тохиолдолд тэдгээрийг худалдаж авч, ашиглах ёсгүй. Хүйтэн хэлхээний засвар үйлчилгээ, хадгалалт байхгүйгээс хуарангийн (хээрийн нөхцөлд) нөхцөлд хадгалахад тодорхой бэрхшээл тулгардаг байна. Хүний эрүүл мэндийн үйлчилгээнд зориулагдсан хүйтэн агуулахыг зарим тохиолдолд хувааж ашиглаж болно. Гэсэн хэдий ч хүний эрүүл мэндийн мэргэжилтнүүд хүйтэн хэлхээнд мал эмнэлгийн бүтээгдэхүүнийг хамтад нь хадгалахыг хүсдэггүйг анхаарч үзэх нь зүйтэй. Өндөр өртөгтэй хүйтэн хэлхээний байгууламжуудыг бүрэн ашиглахын тулд урьдчилан нь шийдвэр гаргах түвшний тохиролцоонд хүрч гэрээ байгуулсан байх шаардлагатай.



4. Олон нийтэд суурилсан арга барил

Мал эмнэлгийн зарим ажилчид шаардлагатай үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байгаа тул тэдэнд зориулсан сургалтыг богино хугацааны давтан сургалтаар хязгаарлаж болно. Тэдгээр сургалт нь дараах зүйлд гол анхаарлаа төвлөрүүлэх ёстой. 1) тэргүүлэх ач холбогдол бүхий өвчний Эмнэлзүйн оношилгоо, 2) мал эмнэлгийн зориулалттай вакцин, эмийг зөв хэрэглэх. Орон нутгийн боловсон хүчний чадавхаас хамааран энэхүү давтан сургалтын хэрэгцээ байнга байдаггүй. Тусламжийн байгууллагууд мал эмнэлгийн туслах ажилчдыг тухайлбал ОНТМЭА-ыг сонгон авч сургалтад хамруулан гамшгийн хөтөлбөрөөс илүүтэй олон нийтэд түшиглэсэн малын эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай гарын авлагаар хангах хэрэгтэй. Эдгээр удирдамжууд нь ОНТМЭА-д эм хангамжийг дэмжих, ОНТМЭА-д зөвлөгөө өгөх, хяналт тавихын тулд өндөр түвшинд бэлтгэгдсэн мэргэжлийн туслах ажилтан эсвэл малын эмч нартай холбох нь чухал болохыг дурдсан байдаг (мөн Зааварчилгаа 8-ыг үзнэ үү). Онцгой байдлын үед түргэн шуурхай хариу арга хэмжээ авахын тулд тусламжийн байгууллагууд нь ОНТМЭА сонгон авах, тэднийг сургахтай холбоотой зарим сайн туршлагын зарчмуудыг оновчтой болгох шаардлага үүсэж магадгүй юм. Гэсэн хэдий ч, удаан үргэлжилж ужгирсан эсвэл дуусах үе шатандаа орсон гамшгийн үед ОНТМЭА-ийн мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх дараагийн сургалт зохион байгуулахыг зөвлөж байна. Зарим улс оронд ОНТМЭА бэлтгэх тогтолцоонд зориулсан үндэсний хэмжээний тогтолцооны стандарт, удирдамж, гарын авлага, зааврууд байдгаас гадна тухайлбал ОНТМЭА-дад зориулсан сургалтын гарын авлага, дадлага болон богино хугацааны оролцоот сургалтууд байдаг.

5. Нийгэм, соёлын хэм хэмжээ

Мал эмнэлгийн тусламж үйлчилгээг төлөвлөхөд тухайн орон нутгийн нийгэм, соёлын хэм хэмжээг ялангуяа тэдгээр үйл ажиллагаанд оролцож байгаа эсвэл үйлчилгээ үзүүлж байгаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын харилцаа, гүйцэтгэх үүрэг хариуцлагыг бодолцох шаардлагатай. Зарим газарт эмэгтэйчүүдийн хувьд, мал амьтныг маллах, тэдгээрийг арчлах явцдаа малаа даган чөлөөтэй нүүдэллэх эсвэл алслагдсан бүс нутагт ганцаараа явахад хүндрэлтэй байдаг. Гэсэн хэдий ч иймэрхүү хуучинсаг (консерватив) соёл байгаа ч эмэгтэйчүүдийг сонгож, сургаж ОНТМЭА болгон тусгайлан бэлтгэж, үйл ажиллагаандаа ашиглах боломжтой байдаг.

6. Хамгаалалт

Мал аж ахуй нь тухайн орон нутгийн эдийн засаг болон хүмүүсийн амьжиргаанд туйлын өндөр ач холбогдолтой тул малын эм нь маш өндөр



үнэтэй байдаг. Жижиг хэмжээтэй, өндөр үнэтэй зүйлсийг хулгайлах болон дахин цааш дамлан худалдахад хялбар байдаг. Иймээс үйлчилгээг загварчлахдаа мал эмнэлгийн ажилтнуудад учрах хүчирхийлэл, хулгай, дээрэм зэрэг эрсдлийг тооцож үзэх ёстой. Мал амьтдыг ихэвчлэн суурин газраас алсад бэлчээдэг. Заримдаа тэднийг бэлчээр, уст цэг рүү хүргэхийн тулд хол зайд тууварлана. Мал эмнэлгийн ажилчид тэдгээр газар нутагт очиж ажиллаж магадгүй тухайлбал мөргөлдөөнтэй нөхцөлд эрсдэлд орж болзошгүй. Энэ нөхцөлд тухайн орон нутгийн мал эмнэлгийн туслах мэргэжлийн ажилчдыг ашиглах нь тохиромжтой байж болно. Учир нь тэд тухайн орон нутгаа сайн мэддэг бөгөөд зэвсэгт бүлэглэлүүд эсвэл аюулгүй байдлын бусад хүчнийхэнтэй танил, хэл амаа ололцон тохиролцох чадвартай байж магадгүй юм.

7. Үйлчилгээний төлбөр

Нотлох баримт, үйлчилгээний загварт заагдсан боломжтой бүх хэлбэрээр үйлчилгээний төлбөрийг олгоно. Эрсдэлд хамгийн их өртөж буй мал аж ахуй эрхлэгчдэд эрхийн бичиг (ваучер)-ын схемийг ашиглаж болох юм. Бусад мал аж ахуй эрхэлдэг хүмүүсийн хувьд үйлчилгээний төлбөрийг хийсний дараа нөхөж олгож болно. Засгийн газар вакцинжуулах бүх үйл ажиллагааг “хувь хүний эрх ашигт” бус харин “нийтийн эрх ашигт” хандсан арга хэмжээ хэмээн үзэх шаардлагатай. Гэсэн хэдий ч клостридиоз төрлийн өвчин мэтийн мал амьтдын хооронд амархан дамждаггүй өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахдаа хувийн эрх ашгийг харгалзан үзнэ. Онолын хувьд хувийн хэвшил нь хамгийн сайн тоноглогдсон сайн үйлчилгээ хүргэгч юм.

8. Мал эмнэлгийн мэргэжлийн туслах ажилтан нарт мэргэжлийн зөвлөгөө хүргэх нь

6

Мал эмнэлгийн туслах мэргэжилтнүүд тухайлбал ОНТМЭА нар нь алслагдсан бүс нутагт ажиллаж байгаа тохиолдолд ч тэд мал эмнэлгийн мэргэжилтний удирдлагын дор ажиллах ёстой. Мэргэжлийн удирдлага нь мал эмнэлгийн бэлдмэлийг зөв хэрэглэж байгааг хянах, өвчний мэдээллийг орон нутгаас үе шаттай удирдах албан тушаалтанд мэдээлэх, ОНТМЭА нь одоо байгаа орон нутгийн, улсын болон хувийн хэвшлийн эмнэлгийн үйлчилгээтэй уялдуулж хамтран ажиллахад чиглэнэ. Зарим тохиолдолд гар утас ашиглах нь ОНТМЭА-нд тавих хяналт, мэргэжлийн зөвлөгөө хүргэхэд дөхөм үзүүлдэг.



Стандарт 4: Үзлэг ба эмчилгээ

Эмнэлзүйн сургалтад хамрагдсан мал эмнэлгийн ажилтнууд гамшигт нэрвэгдсэн иргэдийн идэвхтэй оролцоотойгоор үзлэг, эмчилгээ хийдэг.

Үндсэн үйл ажиллагаа

- Малын өвчнийг оношлох, эмчлэхэд малын эмч болон эмнэлзүйн чиглэлээр бэлтгэгдсэн мал эмнэлгийн туслах мэргэжилтнүүдийг илүү ихээр татан оролцуулах (*Зааварчилгаа 1-ийг үзнэ үү*)
- Бүх оролцогчдын үүрэг, хариуцлагыг тодорхой баримтжуулах тохиромжтой, шаардлагатай тохиолдолд бичгээр гэрээ байгуулах (*Заавар 2-ыг үзнэ үү*)
- Эдгэршгүй өвчтэй эсвэл гэмтсэн мал амьтдыг хүмүүнлэг, аюулгүй байдлаар устгах (*Заавар 3-ыг үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Малын эмч, эмнэл зүйн сургалтад хамрагдсан мал эмнэлгийн туслах мэргэжилтнүүдийг ашиглах нь

Хүмүүнлэгийн олон нөхцөл байдалд гардаг малын өвчнийг малчид өөрсдөө таньж мэддэг. Малын өвчлөлийн талаарх уугуул иргэдийн мэдлэг нь оношилгоо хийхэд туслах чухал эх сурвалж юм. Зарим тохиолдолд бэлтгэгдсэн малын эмч нарын хувьд мал амьтанд биечилж үзлэг хийх боломж хязгаарлагдмал эсвэл боломжгүй нөхцөл байдалд тэд малчдын өгсөн өвчний мэдээлэлд тулгуурладаг байна.

Малын эмч нар малд үзлэг хийх боломжтой үед өвчний онош нь эмнэл зүйн үзлэгээс ихээхэн шалтгаалдаг ба учир нь лабораторийн тусламж үйлчилгээг ихэнх тохиолдолд үзүүлэх боломжгүй байдагтай холбоотой. Ийм тохиолдолд малын эмч нь эмнэл зүйн хувьд сургаж бэлтгэгдсэн мал эмнэлгийн туслах мэргэжилтнүүдийн ур чадвар, мэдлэгийг оношлох, эмчлэхдээ ашиглах ёстой. Тэдэнд зориулсан эмнэл зүйн сургалт нь орон нутгийн мал эмнэлгийн сургууль, сургалтын хүрээлэнгийн хөтөлбөрт суурилсан байх магадлалтай. Эдгээрт тухайн орон нутагт хамаарах малын төрөл зүйл, өвчнийг хамруулбал зохино.

Хавсарсан гамшгийн үед тусламжийн байгууллагууд өвчнийг оношлоход нь туслах эсвэл анхан шатны лабораторийг бий болгохын тулд орон нутгийн мал эмнэлгийн лабораторид зарим дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Лабораторийн тусламжтайгаар өвчнийг зөв оношлох нь зарим халдварт өвчин болон өргөн хүрээтэй вакцинжуулалтыг хийх гэж байгаа тохиолдолд онцгой чухал ач холбогдолтой юм. Ийм нөхцөлд буруу онош тавих нь буруу (өөр) вакциныг



хэрэглэхэд хүргэж болзошгүй болно. Лабораторийн оношилгоо нь өвчний тандалтад дэмжлэг үзүүлэх боломжтой (*Стандарт 8: Малын өвчний тандалтыг үзнэ үү*).

2. Эрх үүрэг, хариуцлага

Гамшгийн үед мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээнд гарч болох нэг хүндрэлтэй асуудал бол оролцогч талуудын хоорондох зохицуулалт юм. Тухайлбал, үйл ажиллагаанд оролцогч нар үүрэг, хариуцлагыг буруу ойлгосноор асуудал үүсч болзошгүй. Үүнд үйлчилгээний зорилго, хамрах хүрээний талаарх бодит бус хүлээлт үүсэх, үнийн зохицуулалт эсвэл ашиг хүртэгчдийн сонголттой холбоотой эндүүрэл, үл ойлголцол орно. Олон нийтийн оролцоог хангаж, сонирхогч талуудтай зөвлөлдсөнөөр эдгээр бэрхшээлээс зайлсхийх бүрэн боломжтой. Боломжтой бол орон нутгийн удирдлагууд болон хувийн хэвшлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах ёстой. Гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг харилцан ойлголцлын санамж бичиг эсвэл түүнтэй ижил төстэй бусад баримт бичгээр баримтжуулсан байх ёстой. Энэ нь харилцан маргаан үүсэхээс сэргийлж чадах үндсэн лавлагаа баримт бичиг болж чадна.

3. Малыг хүмүүнлэг, энэрэнгүй аргаар нядалж устгах (эвтанази)

Малыг хүмүүнлэг, энэрэнгүй аргаар аюулгүй нядалж устгахдаа хүмүүнлэг стандарт, дадлыг дагаж мөрдөх ёстой. Өвчлөл, гэмтэл бэртлээс шалтгаалан нядлах, устгах аргыг сонгох ба зарим малын гулуузыг нь хүнсэнд хэрэглэж болно (*Стандарт 6: Ариун цэвэр болон хүнсний эрүүл ахуй* хэсгийг үзнэ үү). Эвтанази хийхдээ олон улсын болон тухайн улсад хүчин төгөлдөр зааврыг дагаж мөрдөх ёстой бөгөөд нядлах, сэг зэмийг аюулгүйгээр устгах журмыг баримталбал зохино. Мал нядалгааны хувьд шашны болон уламжлалт үзэл бодлыг харгалзан үзэх шаардлагатай.



Стандарт 5: Зооноз өвчнүүд

Хямралд өртсөн хүн ам нь зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд чиглэсэн үйлчилгээ, мэдээллийг авах боломжтой байна.

Үндсэн үйл ажиллагаа

- Мал, амьтны эрүүл мэндийн асуудлын анхан шатны үнэлгээнд зоонозын өвчний оролцоот үнэлгээ, түүний тэргүүлэх чиглэлийг тусгах (*Зааварчилгаа 1-ийг үзнэ үү*).
- Зоонозын өвчинтэй тэмцэх арга хэмжээг мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээ үзүүлэхтэй холбох, эсвэл бие даасан үйл ажиллагаа хэрэгжүүлэх (*Заавар 2-ыг үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Үнэлгээ

Болзошгүй бэлэн байдлын төлөвлөгөө (*Стандарт 1: Бэлэн байдал*) ба/эсвэл түргэвчилсэн оролцоот үнэлгээ (*Стандарт 3: Мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээний загварт заасны дагуу хийгдсэн*) нь зоонозын өвчний тохиолдол, эрсдлийн үнэлгээг багтаасан байх ёстой. Онцгой байдлын үед зоонозын өвчлөлийн эрсдэл нэмэгдэж эсвэл буурч болно. Жишээ нь: 1) шинэ газар нутагт малын хяналтгүй хийгдсэн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой үүсдэг боом өвчин; 2) мал амьтны сэг зэм, хог хаягдал бүхий газарт зэрлэг болон гэрийн махчин амьтдын цугларахтай холбоотой үүсдэг галзуу өвчин; 3) мал амьтан, хүмүүсийн шууд хавьтахтай холбоотой үүсдэг бусад зоонозын халдвар; 4) дүрвэгсдийн хуаранд хүн, амьтдын бөөгнөрөлөөс шалтгаалан тэдний эрүүл ахуйн нөхцөл байдал доройтсонтой холбоотой нэмэгддэг өвчлөл; 5) усан хангамж алдагдсанаас үүсэх өвчлөл.

2. Зооноз өвчний хяналт

Өвчний хяналт тавих аргууд нь тухайн зооноз өвчнөөс хамаарч янз бүр байдаг. Тухайлбал: зарим өвчний талаар мал эмнэлгийн туслах ажилтан нар аман ухуулга эсвэл тараах материал ашиглан мал аж ахуй эрхлэгчдэд мэдээлэл өгч болно. Эдгээр туслах ажилтнууд тухайлбал галзуу өвчний эсрэг өргөн хүрээтэй вакцинжуулалтын компанит ажил зохион байгуулах мөн золбин нохойн өсөлтийг хянах зэрэг үйл ажиллагаанд тусалж болно.

Малын эрүүл мэндийн менежментийн асуудалд эмэгтэйчүүд чухал үүрэг гүйцэтгэдэг тул тэдэнд хүрч үйлчлэх нь онцгой ач холбогдолтой. Гэсэн хэдий ч өвчинтэй тэмцэх арга хэмжээнд тэдгээрийг ихэвчлэн үл тоомсорлодог. Хувийн малын эмч нарын үйлчилгээний хөлсийг ихэвчлэн гадны байгууллагаас гаргуулан тэднийг богино хугацаатай ашиглаж болно.



Зоонозын өвчинтэй тэмцэх ажилд тусалцааны байгууллага хоорондын болон бүс нутаг хоорондын хамтын ажиллагааг уялдуулах хэрэгтэй. Хүний эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагууд, бусад хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах, тэдний нөөц боломжийг тухайлбал хүйтэн агуулах зэргийг ашиглах зэргээр нягт хамтран ажиллах уялдаа холбоогоо бэхжүүлэхэд анхаарах нь зүйтэй (*Стандарт 3, Зааварчилгаа 3-ыг үзнэ үү*).

Стандарт 6: Ариун цэвэр болон хүнсний эрүүл ахуй

Малын гаралтай бүтээгдэхүүнийг хэрэглэх, малыг нядалж устгахад баримтлах ариун цэврийн болон хүнсний эрүүл ахуйн арга хэмжээ нь зохион байгуулагдсан байна.

Үндсэн үйл ажиллагаа

- Удаан үргэлжилсэн хямралын үед нядалгааны цехийг байгуулах (*Заавар 1-ийг үзнэ үү*).
- Нэрвэгдсэн хүн амын дунд ашиглагдах нядалгааны цех, нядалгааны газруудад махыг хянан шалгах журмыг бий болгох (*Зааварчилгаа 1-ийг үзнэ үү*).
- Хүнсийг аюулгүй бэлтгэх сайн дадлыг дэлгэрүүлэх (*Заавар 2-ыг үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Мал нядалх байгууламж болон махны хяналт шалгалт

Хуаран маягийн суурьшлийн эсвэл нядалгааны байгууламж сүйдсэн тохиолдолд нядалгааны талбайг барих нь зүйтэй. Энэ нь эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд хүмүүнлэг аргаар нядалгаа хийж, махны хяналт шалгалтыг бэлтгэгдсэн ажилчид хийх боломжийг олгоно. Нядалгааны байгууламжийн нэгэн адил мал аж ахуй, малын эрүүл мэнд, тавлаг байдал болон эрүүл ахуйн стандартыг энд дагаж мөрдөх шаардлагатай. Мөн энд суурин эсвэл зөөврийн хөдөлгөөнт нядалгааны цехийг барих шаардлагатай байж болно (*Бүлэг 8: Малын тоог бууруулах-ыг үзнэ үү*). Эдгээр бүх тохиолдолд нядалгааны талбайг байрлуулах байршил, тэдгээрийн загварыг тодорхойлоход орон нутгийн ажиллах хүч эсвэл махны ченжүүдтэй харилцан илэн далангүй зөвлөлдөх нь тус болно. Махны хяналтын журмыг малын эрүүл мэндийн ажилтнууд илүүтэй сайн мэддэг. Нядалсан малын дотор болон дайвар эрхтнийг аюулгүйгээр устгана.

2. Олон нийтийн мэдлэг ойлголт

Үнэлгээний үр дүнд үндэслэн хүнсний аюулгүй байдлыг хангах, бэлтгэх сайн дадлыг сурталчлах зорилгоор олон нийт ойлголт, боловсролыг



сайжруулахад чиглэсэн нийтийг хамарсан аян зохион байгуулах ёстой. Тухайлбал, мал, махтай харьцах, хоол хүнс бэлтгэх, буцалгасан сүүний хэрэглээг дэмжих, эрүүл ахуйг сайжруулах замаар сүрьеэ, бруцеллёр өвчнөөс урьдчилан сэргийлэх сайн дадлын талаар зөвлөгөө өгч болно.

Стандарт 7: Малын сэг зэм устгах

Үхсэн мал амьтны сэг зэмийг аюулгүй, булшлах арга хэмжээг эрүүл ахуйн нөхцлийн дагуу зохион байгуулна.

Үндсэн үйл ажиллагаа

- Сэг зэмийг устгах хэрэгцээг үнэлэх (*Заавар 1-ийг үзнэ үү*).
- Сэг зэмийг устгахдаа эрүүл ахуйн дэглэмийг сайтар мөрдөх. (*Заавар 2-ыг үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Устгах хэрэгцээ шаардлагын үнэлгээ

Гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн аюулт үзэгдлийн үед мал амьтад олон тоогоор гэмтэж бэртэж улмаар эмчлэх эсвэл малыг хүмүүнлэг, энэрэнгүй аргаар аюулгүй нядалж устгал (эвтанази) хийх аль нэгийг сонгох шаардлага үүсч байж болно. Удаан үргэлжилсэн ган гачиг, хатуу ширүүн өвөл мөн үер ус, хуй салхи зэрэг онцгой байдлын улмаас олон тооны амьтад хорогдоно. Гамшгийн дараа малын сэг зэмийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн устгах, булшлах асуудал ургаж гарна. Малын сэг зэм нь өвчин тараах үндэс болох ба ойр орчныг бохирдуулах, эвгүй үнэр гаргахаас гадна нохой, махан идэштэн, хэрээ, тас шувуу зэрэг сэг зэмээр хооллодог амьтдын бөөгнөрөл бий болгодог. Ган гачиг болон өвлийн улиралд мал амьтад өвчний улмаас бус хоол тэжээлийн дутагдал, шингэн алдалт, хөлдөлт зэргээс шалтгаалж ихээр хорогддог. Гэсэн хэдий ч өвчний үүсгэгч нь сэг зэмд үлдэж, хүн, амьтны эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй юм. Өөр нэг чухал зүйл бол үхсэн мал амьтдын сэг зэмийг байнга харах нь малчдын сэтгэл зүйд сөрөг нөлөө үзүүлж байдаг. Иймээс эдгээр нь мал амьтдыг устгах булшлах ажлыг зохион байгуулах үндэслэл болдог юм.

2. Устгал

Байгаль орчин, эрүүл мэндийн асуудалтай холбоотой зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй. Мал амьтны сэг зэмийг устгах үр дүнтэй арга нь задлагч бодис хэрэглэх явдал юм. Усны эх булаг бүхий газарт сэг зэмийг булшлах нь усыг бохирдуулж болзошгүйг анхаарах нь зүйтэй. Ажлын хөлсөнд бэлэн мөнгө олгох нь үр дүнтэй болно. (Үйл явцын жишээ судалгаа: Монгол улс дахь сэг



зэмийг устгасан туршлагын тухай хэсгийг үзнэ үү). Малын хүүр, сэг зэмийг булуулах, бордоо бэлтгэх техникийн дэлгэрэнгүй мэдээллийг НҮБ-ын ХХААБ (FAO)-аас (2016) үзнэ үү.

Стандарт 8: Малын өвчний тандалт судалгаа

Удаан үргэлжилсэн гамшгийн туршид малын өвчний тандалтын тогтолцоо нь өвчний дэгдэлтийн үед цаг алдалгүй хариу арга хэмжээг дэмжинэ.

Үндсэн үйл ажиллагаа

- Өвчний дэгдэлтийн үед малын өвчний тандалт судалгаа хийж, оношийг баталгаажуулж, өвчний эх үүсвэр болон тархалтын хүрээг тогтоож болно. Энэ нь шаардлагатай бол хяналтын арга хэмжээг эрчимжүүлж эсвэл өөрчлөхөд хүргэнэ (*Зааварчилгаа 1-ийг үзнэ үү*).
- Удаан үргэлжилсэн хямралын үед болон өвчний тандалтын үндэсний бодлого эсвэл устгах стратеги хэрэгжиж байгаа бол тэдгээр стратеги болон бодлоготой зэрэгцэн мэдээлэл цуглуулах (*Заавар 2-ыг үзнэ үү*).
- Мал амьтны өвчний мэдээллийг цуглуулах болон тайланг мал эмнэлгийн байгууллагад хүргүүлэх асуудлыг зохион байгуулах зохицуулах байгууллагыг баталгаажуулна (*Зааварчилгаа 3-ыг үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Мал эмнэлгийн мөрдөн шалгалт болон хариу арга хэмжээ

Мал эмнэлгийн байгууллага, агентлагууд нь өвчний дэгдэлтийн судалгааг хэрэгжүүлэх үр чадвар бүхий нөөцтэй байх ёстой. Олон байгууллагууд санаачлагын хүрээнд өвчний дэгдэлтийн судалгааг түүний дотор эмгэг анатомын задлалт, лабораторийн оношлогоог хамтад нь хийж чадах мэргэжлийн сургалтад хамрагдаж мэргэшсэн, итгэмжлэгдсэн баг эсвэл хувь хүнд хариуцуулан өгч болно. Хэрвээ ийм баг эсвэл хувь хүн байхгүй тохиолдолд холбогдох дээжийг цуглуулж, гадаад, дотоодын оношилгооны лабораторид хүргүүлж болно. Энэ бүх үйл ажиллагаа нь улсын мал эмнэлгийн байгууллагуудын мөрдөн шалгах тогтолцоог хөгжүүлэхэд чиглэх ба өвчний албан ёсны оношийг төрийн захиргааны байгууллагуудаас олон нийтэд мэдээлдэг.

Удаан үргэлжилсэн хямралын үед тусламжийн байгууллагууд нь мал эмнэлгийн эмнэл зүйн ажилтан нарын чадавхыг бэхжүүлэх, өвчний судалгааг дэмжих зорилгоор орон нутгийн шинж чанартай бага оврын оношилгооны лаборатори байгуулах талаар бодох хэрэгтэй. Мөн хүн эмнэлгийн лабораторийн зарим тоног төхөөрөмжийг харилцан хуваалцаж



ашиглах боломжтой.

Судлаачид өвчний эх үүсвэр, тархалтыг илрүүлэхийн тулд холбогдох мэдээллийг цуглуулах зорилгоор газар дээр нь ажиллаж байгаа ажилтанд туслах үүднээс асуумж бүхий хяналтын хуудасны стандарт, бусад бүртгэлийн маягтуудыг боловсруулж өгнө. Иргэдийн байнгын дэмжлэгийг үргэлжлүүлэхийн тулд мал эмнэлгийн судалгааг өвчний дэгдэлтийг хянах талаар (жишээлбэл, малыг эмчлэх, вакцинжуулах замаар) цаг тухайд нь авч хэрэгжүүлэх бусад арга хэмжээнүүдтэй нягт уялдуулах шаардлагатай.

2. Мал амьтны өвчний тандалт судалгаа

Олон улс оронд малын өвчинтэй тэмцэх, устгах үндэсний болон олон улсын хэмжээний хөтөлбөрүүд байдаг. Тандалт судалгаа хийх аргачлалыг ДМАЭМБ, НҮБ ХХААБ зэрэг олон улсын байгууллагууд тогтоодог. Тухайн нутагт удаан үргэлжилсэн хямралын үед боломжтой бол малын өвчний тандалт, судалгааны тогтолцоонд дээрх аргачлалыг дагаж мөрдвөл зохино. Үйл ажиллагааны хязгаарлалт нь тандалтын аргачлалыг хэрэгжүүлэхэд саад бэрхшээл учрахаар бол үндэсний хэмжээний байгууллагууд (хэрэв үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа бол) зохицуулах, ДМАЭМБ эсвэл НҮБ ХХААБ-тай харилцаж тухайн нөхцөл байдалд тохируулан өөрчилсөн тандалтын аргыг хэрэглэж болно.

3. Тайлагналт

Удаан үргэлжилсэн хямралын үед бүх агентлагууд тандалтын тайланг тогтмол (ихэвчлэн сар бүр) нэгтгэн зохицуулалт хийж байгаа байгууллагад ирүүлж мөн холбогдох төрийн байгууллагад тус тус хүргүүлнэ. Энэ нь бүсийн түвшинд нэгтгэгдэж, тандалтын санд орж, бүс нутгийн нэгдсэн тандалтын мэдээллийг нэгтгэсэн товч тайлангууд орон нутгийн мал эмнэлгийн ажилтнуудад буцаан хүргэгдэх ёстой.



Хавсралтууд

Хавсралт 6.1: Мал эмнэлгийн тусламжийн үнэлгээний аргууд болон шалгах хуудас

Шалгуур үзүүлэлт	Хэрэглээний аргууд*
1. Хүрэлцээ: хамгийн ойр байгаа сургагдсан мал эмнэлгийн ажилтан нар болон малчдын хоорондох зай	Оролцооны зураглал. Өгөгдсөн газрын талаар дэлгэрэнгүй биш зураглал гаргах • мал, малчны байршил • хамгийн ойр орших мал эмнэлгийн үйлчилгээнүүд/хэлбэрүүд • зай (км, цаг, г.м.)
2. Хэрэгцээ: Тухайн газар нутаг дахь үйлчилгээний биет байдал, төвлөрөл/хүртээмжийн хэмжүүр	Оролцооны зураглал: дээр дурдсантай адил Шууд ажиглалт: мал эмнэлгийн ажилчид, байр, хэрэгсэлүүд Ярилцлага: мал эмнэлгийн бүтээгдэхүүний хадгалах газрын нөхцөл байдлыг үнэлэх Эм, багаж хэрэгсэлийн чанар Үндэс угсаа, хүйс, нийгмийн давхарга г.м зүйлд тулгуурласан хүртээмжтэй байдал, хориг саад
3. Боломж: Үйлчилгээний төлбөрийг төлөх хүмүүсийн чадвар	Хагас зохион байгуулалттай ярилцлага Ажиглалт: Мал эмнэлгийн байгууламж, Малын зах, Үнийн жагсаалт (Эдгээр нь ердийн үйлчилгээний зардал, малын үнэ цэнийг тодорхойлж, үйлчилгээний зардлыг малын үнэ цэнэтэй харьцуулан үзэх боломжийг олгоно. Хэрэв малын захууд үйл ажиллагаа явуулж байгаа эсвэл мал амьтдыг худалдан авч байгаа бол мал эмнэлгийн тусламж үйлчилгээний төлбөрийг төлөх боломжтой болох магадлал өндөр байна. Мөн зах зээлийн дүн шинжилгээний минимум стандарт (MISMA)-г үзнэ үү.)
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал: Нийгэм соёл, улс төрийн хэм хэмжээтэй холбоотой жендерийн асуудал, хэл ярианы чадвар болон бусад асуудлууд нөлөөлдөг мал эмнэлгийн ажилтны хүлээн зөвшөөрөгдөх байдал	Ярилцлага: эрэгтэй, эмэгтэй малчид (залуу болон өндөр настан)

Үргэлжлэл дараагийн хуудсанд



Шалгуур үзүүлэлт	Хэрэглээний аргууд*
5. Чанар: энэ хэсэгт мал эмнэлгийн ажилтнуудыг хамааруулна. Сургалтын түвшин мэргэжлийн мэдлэг, ур чадвар, харилцааны ур чадвар мал эмнэлгийн эм, вакцины чанар, нэр төрөл, тоног төхөөрөмжийн хүрэлцээ	Ярилцлага: мал эмнэлгийн ажилчид Шууд ажиглалт: мал эмнэлгийн барилга боловсролын гэрчилгээ үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг
Бүх шалгуур үзүүлэлт	Матрицын үнэлгээ: Тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй өөр өөр төрлийн мал эмнэлгийн ажилчдыг таван шалгуур үзүүлэлтээр дүгнэх ба төрөл тус бүрийн харьцангуй давуу болон сул талуудыг харуулдаг.

* Анхан шатны үнэлгээг хийх санал болгож буй оролцооны аргуудыг 3-р бүлэг: Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөлт-өөс харна уу.



Хавсралт 6.2: Мал эмнэлгийн тусламжийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн жишээ

	Үйл явцын шалгуур үзүүлэлт (болж байгаа үйл ажиллагааг хэмжих нь)	Үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүд (болж байгаа үйл ажиллагааны үр дүнг хэмжих нь)
Үйл ажиллагааны загварчлал	Оролцооны аргаар судалгаа болон дүн шинжилгээ хийж дуусгах	Мал амьтны эрүүл мэндийн тулгамдсан чухал асуудлын талаар нийгмийн янз бүрийн давхарга, хүйсийн төлөөллийн санал бодлыг тогтоох
	Орон нутаг олон нийтийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын тоо	Мал амьтны эрүүл мэндийг сайжруулах боломжит хувилбаруудын дүн шинжилгээ хийх
	Мал эмнэлгийн ажилтан болон хэрэгжүүлэгч агентлаг, хувийн мал эмнэлгийн ажиллагсдын хооронд зохион байгуулагдсан уулзалтын тоо	Мал эмнэлгийн эрхийн бичиг: орон нутгийн хувийн мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч болон олон нийт эрхийн бичгийн үнийг харилцан хүлээн зөвшөөрсөн байх
		Нөлөөлөлд өртсөн байдлын шалгуурыг олон нийтийн зүгээс хүлээн зөвшөөрсөн байх
		Мал эмнэлгийн эмийн ханган нийлүүлэгч хувийн болон улсын байгууллагад холбоотой мал эмнэлгийн туслах мэргэжилтэн нарын тоо
		Нөхөн төлбөрийн тогтолцоог хувийн хэвшлийн ажилчид болон ханган нийлүүлэгчдийн зүгээс хүлээн зөвшөөрсөн байдал Орон нутгийн түвшинд хяналт тогтолцоог хүлээн зөвшөөрсөн байдал
		Эм ханган нийлүүлэгч тусламжийн байгууллага: Тусламжийн байгууллагаас нийлүүлсэн мал эмнэлгийн ажилтны тоо, газар зүйн хамрах хүрээ



	Үйл явцын шалгуур үзүүлэлт (болж байгаа үйл ажиллагааг хэмжих нь)	Үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүд (болж байгаа үйл ажиллагааны үр дүнг хэмжих нь)
Мал эмнэлгийн түргэвчилсэн сургалт давтан сургалт	Сургагдсан мал эмнэлгийн ажилтны тоо, хүйс Сургалтын үеэр хөндөгдсөн малын эрүүл мэндийн асуудлын тоо, хэлбэр Сургалтын зардал	Сургалтад хамрагсдын мал эмнэлгийн мэдлэг, ур чадвар сайжирсан байна.
Мал эмнэлгийн үйл ажиллагаа	Мал эмнэлгийн эрхийн бичиг • Газар нутаг, хамрагдсан өрх, хэлбэр, эрхийн бичгийн тоо • Нэг өрх, нэг малчинд ноогдох эмчилгээний тоо • Нөхөн олгосон эрхийн бичгийн тоо, үнэ Агентлаг эсвэл хувийн мал эмнэлгийн эмийн сангаас олгосон эм: • Мал эмнэлгийн ажилтанд олгосон эмийн тоо, хэлбэр • Мал эмнэлгийн ажилтанд олгох эмийн үнэ • Нэг сард нэг ажилтанд ноогдох мал болон эмчилгээний тоо • Мал эмнэлгийн ажилтны ирүүлсэн хяналтын маягтын тоо • Мал эмнэлгийн ажилтны мэдээлсэн өвчний тоо	Суурь үзүүлэлттэй харьцуулсан малын өвчлөл, хорогдол төрөл зүйл тус бүрээр Мал эмнэлгийн ажилтны газар зүйн байршил Үйлчилгээ авсан мал аж ахуй эрхэлдэг өрхийн эзлэх хувь Сургалт хийсний дараа үйл ажиллагаа явуулж байгаа ажиллагсдын тоо, харьцаа Өвчний мэдээллийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан Хүний хоол, тэжээл - мал амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн сайжирч тэдгээрийн хэрэглээтэй холбоотойгоор мал амьтны гаралтай хоолны тэжээллэг чанар (хүйсийн болон хөрөнгийн ялгаатай бүлгийн хувьд) Мал амьтны эрүүл мэнд сайжирсантай холбоотой хүн амын болон хүйсийн бүлгээс хамаарсан орлого Бодлогын нөлөөлөл



Эх сурвалж ба цаашид унших материал

Admassu, B., Nega, S., Haile, T., Abera, B., Hussein A., Catley, A. (2005) 'Impact assessment of a community-based animal health project in Dollo Ado and Dollo Bay districts, southern Ethiopia', *Tropical Animal Health and Production* 37: 33–48, <http://dx.doi.org/10.1023/B:TROP.0000047932.70025.44>

Aklilu, Y. (2003) 'The impact of relief aid on community-based animal health programmes: the Kenyan experience', in K. Sones and A. Catley (eds), *Primary Animal Health Care in the 21st Century: Shaping the Rules, Policies and Institutions*, proceedings of an international conference, 15–18 October 2002, Mombasa, Kenya, African Union/Interafrican Bureau for Animal Resources, Nairobi, http://www.eldis.org/go/home&id=13563&type=Document#.U38tmbkU_Vh

Baker, J. (2011) 5-year evaluation of the Central Emergency Response Fund, country study: Mongolia, Channel Research, Belgium on behalf of the United Nations Office for the Coordination of Humanitarian Affairs (OCHA), <http://www.alnap.org/resource/11664>

Bekele, G., Akumu, J., (2009) Impact assessment of the community animal health system in Mandera West, Kenya, Tufts University, CARE, Save the Children, VSF Suisse, Nairobi, <https://fic.tufts.edu/pacaps-project/Coordination%20Support/VSF%20ELMT%20CAH%20PIA%20report.pdf>

Braam D.H., Chandio R., Jephcott F.L., Tasker A., Wood J.L.N. (2021) 'Disaster displacement and zoonotic disease dynamics: The impact of structural and chronic drivers in Sindh, Pakistan', *PLOS Glob Public Health* 1(12): e0000068, <https://doi.org/10.1371/journal.pgph.0000068>

Burton, R. (2018) *Humane destruction of stock*, PrimeFact 310, Fourth edition, New South Wales Department of Primary Industries, Orange, New South Wales, https://www.dpi.nsw.gov.au/data/assets/pdf_file/0007/1309489/Humane-destruction-of-stock.pdf

Catley, A., Admassu, B., Bekele, G. and Abebe, D. (2014) 'Livestock mortality in pastoralist herds in Ethiopia during drought and implications for drought response' *Disasters* 38(3), 500–516, <https://doi.org/10.1111/disa.12060>

Catley, A., Leyland, T. and Blakeway, S. (eds) (2002) *Community-based Animal Healthcare: A Practical Guide to Improving Primary Veterinary Services*, ITDG Publishing, London.

Catley, A., Leyland, T., Mariner, J.C., Akabwai, D.M.O., Admassu, B., Asfaw, W., Bekele, G., and Hassan, H.Sh., (2004) 'Para-veterinary professionals and the development of quality, self-sustaining community-based services', *Revue scientifique et technique de l'office international des épizooties* 23(1): 225–252, <http://www.livestock-emergency.net/userfiles/file/veterinary-services/Catley-et-al-2004.pdf>

Catley, A. (2020) 'Participatory epidemiology: reviewing experiences with contexts and actions', *Preventive Veterinary Medicine* 180, 105026, <https://doi.org/10.1016/j.prevetmed.2020.105026>

Catley, A. (2005) *Participatory Epidemiology: A Guide for Trainers*, African Union/Interafrican Bureau for Animal Resources, Nairobi.

Catley, A., Abebe, D., Admassu, B., Bekele, G., Abera, B., Eshete, G., Rufael, T. and Haile, T. (2009) 'Impact of drought-related livestock vaccination in pastoralist areas of Ethiopia', *Disasters* 33(4): 665–685, <http://dx.doi.org/10.1111/j.1467-7717.2009.01103.x>



FAO (2011) The use of cash transfers in livestock emergencies and their incorporation into Livestock Emergency Guidelines and Standards (LEGS). Animal Production and Health Working Paper. No. 1. Rome, <https://www.fao.org/3/i2256e/i2256e00.pdf>

FAO (2012) An assessment of the impact of emergency de-worming activities, FAO report OSRO/KEN/104/EC – FAOR/LOA NO. 008/2012, FAO, Nairobi. <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/05/RVC-WSPA-FAO-ILRI-2012.pdf>

FAO (2016) Livestock-related interventions during emergencies – The how-to-do-it manual. Edited by Philippe Ankers, Suzan Bishop, Simon Mack and Klaas Dietze. FAO Animal Production and Health Manual No. 18. Rome, <https://www.fao.org/3/i5904e/i5904e.pdf> (See Chapter 5)

Farm Africa (2006) Immediate support to agro-pastoral communities as a drought mitigation response: Marsabit and Moyale Districts, Final Report to FAO, OSRO/RAF/608/NET (CERF2), Farm Africa, Nairobi.

Gary, F., Clauss, M., Bonbon, E., Myers, L (2021) Good emergency management practice: The essentials – A guide to preparing for animal health emergencies, 3rd edn, FAO Animal Production and Health Manual No. 25. Rome, FAO, <https://doi.org/10.4060/cb3833en>

Heath, S.E., Kenyon, S.J., and Zepeda Sein, C.A. (1999) 'Emergency management of disasters involving livestock in developing countries', *Revue scientifique et technique de l'office international des épizooties* 18(1): 256–271, <https://doi.org/10.20506/rst.18.1.1158>

Hufnagel, H. (2020) The quality of veterinary pharmaceuticals: a discussion paper for the Livestock Emergency Guidelines and Standards, LEGS, <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/11/LEGS-Discussion-Paper-The-Quality-of-Veterinary-Pharmaceuticals-1.pdf>

Iles, K. (2002) 'Participative training approaches and methods' and 'How to design and implement training courses', in A. Catley, T. Leyland, and S. Blakeway (eds), *Community-based Animal Healthcare: A Practical Guide to Improving Primary Veterinary Services*, ITDG Publishing, Rugby.

LEGS (2020) The challenges of emergency veterinary voucher schemes: research into operational barriers to applying LEGS, LEGS Briefing Paper. <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/02/The-Challenges-of-Emergency-Veterinary-Voucher-Schemes-LEGS-Briefing-Paper-January-2020.pdf>

LEGS (2020) LEGS core standards and community-based animal health services, LEGS Briefing Paper, <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/02/LEGS-Core-Standards-and-Community-Based-Animal-Health-Services-LEGS-Briefing-Paper-January-2020.pdf>

Leyland, T. (1996) 'The case for a community-based approach, with reference to Southern Sudan', in *The World Without Rinderpest*, pp. 109–120, FAO Animal Health and Production Paper 129, FAO, Rome.

Leyland, T., Lotira, R., Abebe, D., Bekele, G. and Catley, A. (2014) *Community-based animal health care in the Horn of Africa: an evaluation for the US Office for Foreign Disaster Assistance*, Feinstein International Center, Tufts University, Addis Ababa and Vetwork UK, Great Holland.

Linnabary, R.D., New, J.C. and Casper, J. (1993) 'Environmental disasters and veterinarians' response', *Journal of the American Veterinary Medical Association* 202(7): 1091–1093.

Mutungi, P.M. (2005) External evaluation of the ICRC veterinary vouchers system for emergency intervention in Turkana and West Pokot districts, International Committee of the Red Cross



(ICRC), Nairobi.

Okell, C.N., Mariner, J., Allport, R., Buono, N., Mutembei, H.M., Rushton, J., Verheyen, K. (2016) 'Anthelmintic administration to small ruminants in emergency drought responses: assessing the impact in two locations of northern Kenya', *Tropical Animal Health and Production* 48:493–500, <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/05/Okell-at-al-2016.pdf>

Regassa, G. and Tola, T. (2010) *Livestock emergency responses: the case of treatment voucher schemes in Ethiopia*, FAO, Addis Ababa.

Schreuder, B. (2015) *Afghanistan, a 25-years' Struggle for a Better Life for its People and Livestock*, DCA-VET/Erasmus Publishing, Lelystad/Rotterdam, <https://dca-livestock.org/books/>

Schreuder, B.E.C., Moll, H.A.J., Noorman, N., Halimi, M., Kroese, A.H., and Wassink, G. (1995) 'A benefit-cost analysis of veterinary interventions in Afghanistan based on a livestock mortality study', *Preventive Veterinary Medicine* 26: 303–314, [http://dx.doi.org/10.1016/0167-5877\(95\)00542-0](http://dx.doi.org/10.1016/0167-5877(95)00542-0)

Simachew, K. (2009) *Veterinary voucher schemes: an emergency livestock health intervention – case studies from Somali Regional State, Ethiopia*, Save the Children USA, Addis Ababa.

UNDP (United Nations Development Programme) (2010) *2010 Dzud Early Recovery Programme*, UNDP Project Document, United Nations Development Programme, Ulaanbaatar.

Network UK (2019) *Operational barriers to applying LEGS: research report*, <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/02/LEGS-Research-Report-Operational-Barriers-to-Applying-LEGS-December-2019.pdf>

World Health Organization (2021) 'Tripartite and UNEP support OHHLEP's definition of "One Health"', <https://www.who.int/news/item/01-12-2021-tripartite-and-unep-support-ohhlep-s-definition-of-one-health>

See also case studies for veterinary support interventions in emergencies at: <https://www.livestock-emergency.net/resources/case-studies/>



Техникийн стандарт
Мал эмнэлгийн туслалцаа






Бүлэг 7: Малын байр ба байршуулалтын техникийн стандартууд

- 260 Танилцуулга
- 263 Малын байр, байршуулалтын хувилбарууд
- 268 Үйл ажиллагаанууд (тусламж)-ыг хэрэгжүүлэх цаг хугацаа
- 269 LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн түншлэлийн стандартууд (ХТС)-тай холбогдох нь
- 271 LEGS-н зарчмууд болон бусад анхаарах асуудлууд
- 274 Малын байр, байршуулалтын хувилбаруудын шийдвэрийн мод
- 277 Стандартууд
- 292 Хавсралт 7.1: Малын байр ба байршуулалтын үйл ажиллагааны үнэлгээний шалгах хуудас
- 294 Хавсралт 7.2: Малын байр, байршуулалтын үйл ажиллагааны хяналт шинжилгээ ба үнэлгээний шалгуур үзүүлэлтийн жишээ
- 295 Хавсралт 7.3: Малын байр ба уур амьсгалын өөрчлөлт
- 296 Эх сурвалж ба цаашид унших материал



Бүлэг 7: Малын байр ба байршуулалтын техникийн стандартууд





Танилцуулга

Малын байр нь мал, амьтны гадаад орчинд амьд үлдэхэд хэрэгцээтэй бодит байгууламж юм. Малын байр бүх мал, амьтанд шаардлагатай биш, улирлын чанартай хэрэгцээтэй байж болох юм. Хэрэгцээний хувьд байр нь түр зуурын, удаан хугацаанд ашиглахын аль аль нь ч байж болно. Хэрэгцээ гэдэгт халуун, хүйтэн цаг агаарын нөхцөл, араатан амьтан мөн хулгайлагдахаас хамгаалах, тарж бутрахаас хамгаалах, мал ба хүнд эрүүл таатай орчин бүрдүүлэх зэрэг багтана. Малын байрыг мал, амьтны аж ахуй эрхлэхэд ихэвчлэн ашигладаг.

Мал сүргийн байршуулалт нь малын байрнаас илүү өргөн хүрээтэй ойлголт юм. Үүнд газрын эрх, тэжээл ба ус ашиглах, байраар хангах, мөн байгаль орчны нөлөө зэрэг хамаарна. Онцгой байдал үүссэн үед олон тохиолдолд малын байр, хоргодох байр, байршуулалт нь хүн ба малд давхар хэрэгцээтэй болдог. Хүмүүсийн хоргодох байр, суурьшуулалтын талаар Sphere гарын авлагад дэлгэрэнгүй өгүүлнэ.

Гамшгийн улмаас нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлсэн эсвэл нүүлгээгүй аль ч тохиолдолд тэдний орон байр, амьжиргаагаа хэрхэн сэргээх нь анхаарал хандуулах гол асуудал болдог. Нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлсэн үед тэдний ирсэн газар нь уур амьсгалын хувьд өмнөх байсан нутгаас нь илүү халуун, хүйтэн, чийглэг эсвэл хуурай байж болох ба тэдэнд малын байр их хэрэгцээтэй байж магадгүй. Хавсарсан гамшгийн үед аюулгүй байдал чухал тул малын байр, хоргодох байр, байршуулалт хангалттай байх шаардлагатай болдог.

Энэхүү бүлэгт онцгой байдлын хариу арга хэмжээний үед малыг байр, байршуулах боломжоор хангахад чиглэсэн тусламж, тэдгээр тусламж тус бүрийн техникийн хувилбарууд, ашиг тус ба сорилт зэргийн талаар танилцуулах болно. Мөн НҮБ-ын ХХААБ-ын гарын авлага (2016) "Малын байр ба байршуулалт" 8-р бүлгээс мэдээлэл авах боломжтой. LEGS нь техникийн үйл ажиллагааны хувилбар тус бүрийг стандарт, үндсэн үйл ажиллагаа, зааварчилгаагаар хангах бөгөөд тэдгээрийг хувилбар тус бүрт дагаж мөрдөнө. Энэ бүлгийн төгсгөлд буй хавсралтуудад анхдагч үнэлгээний шалгах хуудас, мөн хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлт, гүнзгийрүүлэн судлах хэвлэлийн жагсаалтыг оруулсан ба жишээ судлалыг LEGS-н вэб хуудаснаас <https://www.livestock-emergency.net/resources/case-studies/> үзнэ үү.

LEGS амьжиргааны зорилтуудтай холбогдох нь

Малын байр ба байршуулалт нь гамшигт нэрвэгдсэн нутгийн иргэдийн үндсэн хөрөнгө болох мал, амьтныг хамгаалах буюу LEGS-н амьжиргааг дэмжих хоёрдугаар зорилттой нийцэж байгаа юм.



Малын байр нь гамшгаас мал сүргээ амьд авч үлдэх, амьжиргаагаа цаашид үргэлжлүүлэн баталгаажуулахад амин чухал байдаг. Онцгой байдлын дараа мал хөрөнгийг хамгаалах байр, байршуулалтыг төлөвлөхийн зэрэгцээ гамшгийн эрсдлийг бууруулах (жишээлбэл газар хөдлөлтөд тэсвэртэй малын байр) гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд оруулах нь чухал юм. "Аюулгүй барьж байгуулах-буцааж сэргээх" гэсэн элементүүд нь урт хугацаанд ашиглах малын байрыг төлөвлөхөд чухал ач холбогдолтой.

Онцгой байдлын хариу арга хэмжээнд малын байр, байршуулалт чухал болох нь

Малыг байраар хангах үйл ажиллагаа нь онцгой байдлын өмнө, онцгой байдлын үед, онцгой байдлын дараа аль ч үед тохиромжтой байж болох юм. Энэхүү арга хэмжээ нь өмнө нь ашиглаж байсан малын байрны бүтцийг сэргээх, эсвэл шинээр барих аль аль нь ч байж болно. Арга хэмжээний зарим жишээ:

- жишээлбэл, үер, газар хөдлөлт зэргийн нөлөөгөөр малын байр эвдэрч сүйдсэнээс мал, амьтад огт байргүй болох;
- онцгой байдал үүссэний улмаас малчид нүүн шилжсэн, дүрвэсэнээс үүдэн өмнөх малын байраа ашиглах боломжгүй болох эсвэл тухайн нөхцөл байдалд малын шинэ байртай болох шаардлага үүсэх (жишээлбэл, тэд дүрвэгсдийн хуаранд нүүн ирсэн нөхцөлд);
- цаг уурын эрс тэс нөхцөлүүд (халуун эсвэл хүйтэн) эсвэл зөрчил мөргөлдөөн ба аюулгүй байдал алдагдсанаас өмнө нь байргүй байсан мал амьтдад шинээр байр шаардлагатай болох;
- хариу арга хэмжээний хүрээнд мал өгөх, малжуулж байгаа үед малыг араатан амьтан, хулгай, цаг агаарын таагүй нөхцөлөөс хамгаалахын тулд шинэ байр шаардагдах

Гамшгийн хариу арга хэмжээний хүрээнд малыг байраар хангах үйл ажиллагаа нь гарын авлагын нэгдүгээр бүлэг дэх LEGS-н танилцуулгын "хүрээлэн байгаа орчин" "эрүүл мэнд", "тав тухгүй байдал" гэж нэрлэсэн хэсэгт тодорхойлсон мал амьтны тавлаг байдлын гурван эрх чөлөөг хангахад хувь нэмэр оруулж байгаа юм.

Бүх төрлийн гамшгийн үед мөн дараа нь малчдын хувьд үндсэн санаа зовоосон асуудал нь тэдний малын аюулгүй, баталгаатай, тавлаг байдал байдаг. Малчид ихэнх тохиолдолд малд эн тэргүүнд хэрэгцээтэй зүйлүүдийн хүрээнд малын байрыг чухалчилсан байдаг. Гэхдээ түслэмжийн байгууллагуудаас дэмжлэг үзүүлж байгаа эсэхээс үл хамааран, зарим тохиолдолд гэр бүлийн гишүүдээ хамгаалах хоргодох байрыг илүүд үздэг (Хайрцаг 7.1 үзнэ үү).



Хайрцаг 7.1

Малчид малын байрыг чухалчилсан үйл ажиллагаа

Жил бүр үерийн аюул нүүрлэдэг нутгуудад хавтгай нягтаршуулсан шороон далан дээр эсвэл модон баганатай тавцан дээр барилга барьж болно. Ингэж үерээс хамгаалах хариу арга хэмжээ авсны дараа малаа энд маллаж болно. Гэхдээ энэ газарт нь мал хүн хоёрт хүрэлцэхүйц зай талбай байхгүй байж магадгүй эсвэл хүний аюулгүй бүсээс хол зайтай газар малаа маллах хэрэгтэй болж магадгүй юм. Энэ тохиолдолд малчид малтайгаа ойр байх үүднээс оромж байраа орхих нөхцөл үүсэж болно.

Хүйтэн уур амьсгалтай улиралд дүрвэсэн гэр бүлүүд мал, амьтантайгаа хоргодох байраа хуваалцан амьдарч магадгүй юм. Энэ үед өвлийн хүйтэн шөнө гэр бүлийн гишүүд малынхаа биеийн дулаанаар дулаацах хэдий ч малтай хамт удаан байх нь зооноз өвчин дамжих эрсдэлийг ихэсгэдэг.

Хавсарсан хямралын үед малтайгаа хамт байх нь малын хулгайн эрсдэлийг бууруулж болох юм. Хэрвээ дүрвэгсдийн хуаранд малд зориулсан хангалттай аюулгүй орон зай байхгүй нөхцөлд дүрвэгч малчин хуарангийн гадна малтайгаа үлдэхийг илүүд үздэг. Энэ нь тэдний хувьд баталгаат бус байдлыг нэмэгдүүлж, хуаранд байгаа эрүүл мэнд, боловсролын суурь үйлчилгээнд хамрагдах боломжгүй байдалд хүргэх байсан ч тэд энэ сонголтыг хийх магадлалтай.

Дүрвэгч малчид өөрсдөд нь хоргодох байр барихаар өгсөн материалыг ашиглан өөрсдийн малдаа байр барьсан байдаг. Энэ нь хүний хэрэгцээт хоргодох байрны аюулгүй байдал, үр ашгийг бууруулахаар байсан ч тэд үүнийг хийх магадлалтай. 2005 оны Пакистаны газар хөдлөлтийн дараа орон байрны чиглэлийн тусламжийн байгууллагаас хоргодох байрны материалын багц, мөн модыг холбож уях нийлэг дээс зэргийг хамтад нь тараасан байна. Олон гэр бүл нийлэг материалан дээсээр оромжны уяа хийхийн оронд ямааны хашаа хийхэд ашигласан байжээ.

Харин дараа нь хоргодох байрны мэргэжилтнүүд орон нутгийн иргэдтэй хамтран эвдэрсэн байшингийн нурангиас төмрийн хаягдал олж, хоргодох байрны модон холбоосыг бэхлэхэд ашиглажээ. Энэ нь гэр бүлүүд өөрсдөө газар хөдлөлтөд тэсвэртэй байртай болохын зэрэгцээ малаа ч мөн орхихгүй гэдгийг харуулж байна.

(Эх сурвалж: J. Kennedy-н санал.)



Малыг байраар хангах ба байршуулалтын хувилбарууд

Хэдийгээр малчдад малын байр чухал болохыг нотлох баримтууд байгаа ч энэ нь онцгой байдлын хариу арга хэмжээний хувьд хангалттай хөгжихгүй байгаа ба энэ хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлсэн үйл ажиллагааны жишээ хязгаарлагдмал байна. LEGS-н *Зарчим 2*-н олон нийтийн оролцоо хэсэгт заасны дагуу хямралд өртсөн нутгийн иргэдэд хоргодох байраа сонгоход нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй ба үүний тулд тэдний хэрэгцээг тодорхойлох, нөхөн сэргээх хувилбаруудад үндэслэхийг чухалчлах хэрэгтэй.

Тусламжийн байгууллагууд эдгээр тэргүүлэх чиглэлийг судалж мэдсэний үндсэн дээр мал сүргийг болон хүмүүсийг тохиромжтой байраар хангана. Бусад харгалзан үзэх гол зүйлүүд нь нэрвэгдсэн нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлсэн эсэх, мөн цаг агаарын нөхцөл зэрэг байх юм.

Орон байр ба суурьшуулалтын тусламжийг хүмүүст үзүүлэх нь өргөн хүрээг хамардаг. Үүнд энгийн орон байраар хангах эсвэл орон байр барих барилгын материал өгөх зэрэг сонголтууд багтана. Тусламжийн хувилбарууд нь хямралын үед хязгаарлагдмал нөөцийг илүү үр ашигтай ашиглах боломжийг олгодог. Бэлэн мөнгө ба эрхийн бичгийн тусламж (CVA), орон сууцжуулах, газар, өмчийн эрхийг (HLP) дэмжихийн зэрэгцээ зах зээлийн баримжаатай хандлагад суурилсан арга барил зэрэг нь хүний хоргодох байрны хариу арга хэмжээний гол цөм нь болдог. Энэхүү хандлага нь гамшигт нэрвэгдсэн өрхүүдэд илүү хүндлэлтэй хандах мөн шийдвэр гаргах эрх мэдлийг олгодог ба эдгээр хувилбаруудыг малчид малын байрыг чухалчлан үзэхэд ашиглахыг зөвшөөрөх хэрэгтэй.

Хүний хоргодох байрны нэр томьёонд хуаран гэдгийг хамгийн сүүлийн сонголт гэж тодорхойлсон байдаг, гэхдээ хэрвээ бусад илүү сайн сонголт байгаа бол үүнээс зайлсхийх хэрэгтэй. Бусад сонголтууд нь өрхүүдэд илүү аюулгүй байдал, нэр хүндийг бий болгохоос гадна амьжиргааны боломжууд, эрүүл мэнд, боловсрол зэрэг үндсэн үйлчилгээнд ойртох боломжийг олгоно. Дүрвэгсдийн кэмп нь мал зэрэг томоохон хөрөнгийн хувьд хангалттай орон зай, аюулгүй байдлыг хангаж чадах хамгийн тохиромжтой сонголт юм.

Нүүлгэн шилжүүлсэн ба шилжүүлээгүй хүн амын малын байр ба байршуулалт

Онцгой байдлын үед хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх нь гамшигийн дараа тэдний нөхөн сэргээх сонголтод саад болдог. Хил дамнасан нүүлгэн шилжүүлэлт нь хувь хүний тодорхой газар хоргодох, эсвэл мал аж ахуйтай холбоотой амьжиргааны аливаа үйл ажиллагаа явуулахыг нутгийн эрх



баригчид зөвшөөрөх эсэхэд нөлөөлж магадгүй. Нүүлгэн шилжүүлэлт нь амьжиргаагаа сэргээх ба орон байртай болоход хүмүүст хэрэгцээтэй нийгэм-эдийн засгийн сүлжээний хангалттай нөлөө үзүүлдэг. Онцгой байдлын үр нөлөөг үл харгалзан өөрийн газар нутагтаа үлдэх боломжтой хүмүүс илүү аюулгүй байж, дэмжлэг авах боломжтой байж болно. нүүлгэн шилжүүлэх чухал шаардлагатай юу эсвэл орон нутагтаа үлдэх боломжтой юу гэдэг шийдвэрээс хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд нь хамаарна. Хэрэв боломжтой бол хүний орон байр, малын байр, суурьшуулалтын дэмжлэгийг тухайн өрх, нутгийн иргэд өөрийн төрөлх нутагтаа үлдэх боломжтой байдлаар олгох хэрэгтэй. Малчид малтайгаа нүүн шилжиж байгаа бол малын байраар хангах, байршуулах тусламжийг хувь хүнд буюу хамтаараа байхад тохиромжтой талбай эсвэл хашаалсан талбайд олгоно. Эдгээр нь хүн амын бөөгнөрсөн суурьшил газраас, тухайлбал, түр төлөвлөлтийн болон бие даан суурьшсан баазаас боломжийн зайд байх ёстой.

Янз бүрийн цаг агаарын нөхцөл дэх мал сүрэг ба байр

Дэлхийн олон бүс нутагт агаарын температур жилийн туршид хэт их хэлбэлзэн өөрчлөгддөг ба энэхүү өөрчлөлтөөс малаа хамгаалах хэрэгтэй бөгөөд хүчтэй салхи шуурга, ширүүн бороо, их цас орох, удаан үргэлжлэх хэт хуурайшилт зэрэг бэрхшээлүүд ч тохиолдох магадлалтай. Хүний хоргодох байр, малын байр, байршуулалтын хувилбарыг сонгохдоо уламжлалт нөхцөлд мал сүрэг, хүмүүс хэр зэрэг хамгаалагдаж байсан эсвэл орон нутгийн нөхцөлд байраа хуваан хэрэглэж байсан эсэхийг тооцон үзэх хэрэгтэй. Жишээлбэл, хүйтний улиралд байрыг дулаанаа хуваалцах үүднээс хуваан хэрэглэдэг байж болох ба хэрэв тийм бол энэ нөхцөл нь малын байр, байршуулалтын сонголт, төлөвлөлтөд нөлөөлнө.

Малын байр нь үндсэндээ хэт халалт (жишээ нь агааржуулалт эсвэл сүүдэр), хүйтэн (жишээ нь салхины хаалтууд), хуурай эсвэл чийглэг уур амьсгалаас (жишээ нь чийг эсвэл үерт өртөх газраас хол эсвэл өндөрлөг бүсэд маллах) хамгаалж байдаг. Малын байрны загварын зарим нийтлэг зарчим, материал нь хүн, малыг хоёуланг бодитоор хамгаалахад сайн таарч тохирдог. Гэвч айл өрх, мал амьтан хоёуланг нь цаг агаарын таагүй нөхцөл байдлаас нэгэн зэрэг хамгаалахыг баталгаажуулах үүднээс хангалттай орон зай бүхий байр барих материалаар хангасан байх ёстой. Эхний ээлжинд нэрвэгдсэн нутгийн иргэдэд модны доорх сүүдэр гэх мэт одоо байгаа нөөцийг ашиглах нь ихэвчлэн илүү зардал багатай, амар хялбар байдаг. Эдгээр нөөцийг хэрэгцээтэй бүх хүмүүст тэгш хүртээмжтэй байлгах боломжтой юм.

Хувилбар 1: Малын байр

Малын байрны яаралтай хэрэгцээ гарах үед малчид өөрсдөө анхны хариу арга хэмжээ болгон түр зуурын байр барьдаг. Гэвч боломжтой бол байрны



материал ба барьсан барилга байгууламж нь урт хугацаанд тэсэж үлдэхээр байх хэрэгтэй. (*Хүснэгт 7.1 үзнэ үү*). Түр зуурын болон урт хугацаанд ашиглах малын байраар хангах ажиллагаа нь үүссэн онцгой байдлын нөхцөл ба хэрэгцээнээс шалтгаалан янз бүр байж болдог. Бараг бүх тохиолдолд малыг байраар хангах дэмжлэгийг хүний хоргодох байрны тусламжтай хослуулж болох юм. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь:

- гэрээлэгчид эсвэл байгууллага, шууд нэрвэгдсэн нутгийн иргэд өөрсдөө малын байраа сэлбэх, засварлах эсвэл шинээр барих;
- малчдыг байр барих материалаар хангахдаа хүний хоргодох байр барих материал өгч, хаягдлаар нь малын хашаа барьж болохыг ойлгуулах;
- малыг байраар хангах үйл ажиллагааг хүний хоргодох байрны хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлэх (өөрөөр хэлбэл хүн малын байр, суурин, байрны загварыг адил байршилд хамтад нь шийдэж болох гэх мэт);
- хүний болон малын байрыг хамтад нь болон тусад нь барих загварын талаар сургалт хийх;
- байр барих хэрэгцээнд тулгуурлан бэлэн мөнгө ба эрхийн бичгийн тусламж үзүүлэх, хүний орон байрны тусламжийн олон үйл ажиллагаанд байгууллагууд эд материал, үнэ бүхий эрхийн бичиг эсвэл нөхцөлт бэлэн мөнгөний тусламжийг ашигладаг. Үүнд жишээлбэл, хоргодох байрыг тодорхой үе шатанд барьж дуусгах, батлагдсан аюулгүй байдлын стандартаас хамааран бэлэн мөнгийг хэсэгчлэн хуваарилахыг хамруулж болох юм. Энэ нь хоргодох байрны аюулгүй байдал, өрхийн гишүүн бүрийн хэрэгцээнд нийцүүлэхийг баталгаажуулдаг. Эдгээр аргуудыг малын байраар хангах бэлэн мөнгөний аргачлалд нийцүүлэн хэрэглэх шаардлагатай (*Бүлэг 1 LEGS-н танилцуулга, ба Бүлэг 3 Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөлт CVA үзнэ үү*);
- Өрхийн хашааны газрыг ашиглах, түрээслэх эрхийг баталгаажуулах хэлцэл хийхэд дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх (малчид, малыг албадан нүүлгэхгүй байх).

“Цугларах талбай” гэх мэт зарим төрлийн хүний хоргодох байр байдаг бөгөөд эдгээрт мал байрлуулах боломжгүй юм. Гэвч хүний бусад төрлийн ихэнх хоргодох байранд мал байршуулах боломжтой байдаг. Мал байршуулах орон зай нь өрхийн хоргодох байрны доторх зориулалтын хэсэгт эсвэл гадна талд нь тусдаа зориулалтын байршилд байх боловч кэмп юмуу суурьшлын дотор байсаар байдаг. Малыг шууд кэмпэд байршуулах боломжгүй тохиолдолд уугуул нутгийн иргэдтэй тохиролцон малын байрыг малчдын ойролцоо, аюулгүй хүрч очиж байхаар зохион байгуулах шаардлагатай байдаг.



Нутгийн иргэдийн дундын малын байрыг гамшигт нэрвэгдсэний улмаас нүүлгэн шилжүүлж буй эсвэл нүүн шилжээгүй нутгийн иргэд ашиглаж болно. Барилгын ажил, цугларах талбай, байршуулалтын кэмпэд эвдэрсэн байрыг засварлах, эсвэл хэсэг бүлэг өрхүүдэд зориулан шинээр хашаа хороо барих зэрэг ажлыг зохион байгуулж болох ба хэрвээ материал гэх мэт зарим нэг тусламжийг үзүүлбэл нутгийн нэрвэгдсэн иргэд бүлгээр ашиглах малын байрыг барих чадвартай байдаг. Хэрэв өрх тус бүрт зориулсан малын байр барих боломжгүй тохиолдолд хүмүүс өөрсдийн таньдаг хүмүүстэйгээ дундаа хамтран ашиглахыг илүүд үздэг.

Хувилбар 2: Мал сүрэг ба байршуулалт

Байршуулах үйл ажиллагаа нь нүүлгэн шилжүүлсэн иргэдэд зориулсан байр барихад чиглэнэ. Эдгээрт дараах зүйлс орж болох юм. Үүнд:

- газрын эрхийг хэлэлцэн тохиролцох, бэлчээр олж авах, оромж байр барих эсвэл бусад бодлогын асуудалд тусламж үзүүлэх;
- нүүлгэн шилжүүлж буй хүмүүсийг дагалдан яваа малын байрны хэрэгцээний талаар газар зохион байгуулагч, кэмпийн менежерүүдтэй ярилцаж, зөвшилцөх;
- нүүлгэн шилжүүлсэн хүмүүсийн малыг дэд бүтцээр хангахад туслах (жишээ нь усан хангамж);
- нийтийн ба малын эрүүл мэндийг баталгаажуулах зорилгоор кэмпэд хүн малын аль алинд хэрэгцээтэй байгаль орчны менежментийг нэвтрүүлэх.

Ихэнх байршуулалтын байгууламжууд нь онцгой байдлын үр дүнд аяндаа үүссэн байдаг. Байгууламжуудыг тэнд амьдарч байгаа хүмүүс нь газар зохион байгуулагчийн анхдагч оролцоогүйгээр барьж байгуулдаг. Үүний улмаас байршуулах байгууламж нь ихэнхдээ үндсэн дэд бүтэц, малд зориулсан хүрэлцэхүйц орон зай дутагдалтай байдаг. Ийм тохиолдолд суурь үйлчилгээний байгууламжийг бага хэмжээгээр нэмж оруулах хөтөлбөр хэрэгжүүлэх нь байгууламжийн талбайг өөрчлөн зохион байгуулахаас илүү бодитой байдаг. Байгууламжийн газрыг өргөтгөх, шинэ байгууламж оруулах, нийтийн эзэмшлийн талбайг байгуулахдаа мал, малчдын хэрэгцээг бодитой харгалзан үзэх хэрэгтэй ба үүний тулд газар зохион байгуулагч нартай зөвлөлдөх хэрэгтэй.

Хот суурингийн захад болон дотор төлөвлөсөн ба төлөвлөөгүй байгууламжийн суурин кэмпүүд байрлах нь улам нэмэгдсээр байна. Эдгээр нь хангалттай хүрэлцэхүйц газар нутаг байхгүй, нутгийн уугуул иргэдтэй харилцах, байгаль орчинд үзүүлэх нөлөө, ус татуургын систем, цахилгаан эрчим хүч, нөөцийн хүртээмж зэрэгтэй хамааралтай олон бэрхшээлтэй үргэлж тулгардаг. Хот суурингийн ойр юмуу дотор байгаа байршуулалтын кэмпүүдийн хувьд



малчид зах зээл, амьжиргаа, мал эмнэлгийн тусламж үйлчилгээг илүү сайн авах боломжтой. Гэсэн ч бүх малаа наад захын стандартыг хангасан байраар хангахад зай багтаамж хүрэлцэхгүй байж магадгүй.

Хот болон хот орчмын хоргодох байр, суурьшуулалтын хэрэгцээг гурван үндсэн сэдвийн хүрээнд авч үздэг. Үүнд:

- Гамшигт нэрвэгдсэн боловч, малтайгаа үлдсэн нүүдэлчин өрхүүд өөрсдөө эрсдэлийн үнэлгээ хийж, мал аж ахуйтайгаа хамааралтай үүрэг хариуцлагаа хувиарлаж болно. Үүнд, өрхийн зарим гишүүд орон нутгаас нүүн шилжиж, хэсэг малтай (жишээ нь эмэгтэйчүүд, охид, эрүүл мэнд болон бусад үйлчилгээнд хамрагдахын тулд) хот суурин эсвэл хотын захад байрлах, харин бусад гишүүд нь малын ихэнх хэсгийг бэлчээр, ус сайтай хөдөө орон нутагт маллах боломжтой газар байрлах зэрэг байж болно.
- Гамшигт бараг бүх малаа эсвэл ихэнх малаа алдсан малчид аргагүй эрхэнд хот эсвэл хот орчмын бүс рүү нүүн шилждэг. Ийм шилжилт нь малчин гэр бүлийн хувьд байр зэрэг бусад хэрэгцээт нөөцөө орхиход хүрдэг. Малын байр нь хот суурин газарт маллах малд тохирсон байх хэрэгтэй. Жишээлбэл, Монгол хонь маллаж байсан малчид зуданд малаа алдаад нийслэл Улаанбаатар хотын орчмын бүсэд нүүн шилжиж гахайн аж ахуй эрхлэх гэх мэт.
- Байгалийн гэнэтийн гамшигт өртсөн хот ба хот орчмын бүсэд гамшигийн улмаас эвдэрч гэмтсэн мал, шувууны байрыг сольж сайжруулах шаардлагатай болсон өрхүүд байж болох ба эдгээрт жишээлбэл тахиа, гахайн байрыг солихыг хамруулж болох юм.

Эдгээр бүх нөхцөл байдалд малаас хүнд дамжин халдварлах магадлалтай өвчний эрсдэлийг бууруулахад нөлөөлөх хүчин зүйл нь мал амьтны гаралтай хог хаягдлын менежмент, малын эрүүл мэндийг баталгаажуулахад анхаарах явдал юм (Бүлэг 6: Мал эмнэлгийн тусламж үзнэ үү).

Хүснэгт 7.1: Малын байр, байршуулалтын хувилбаруудын ашиг тус ба сорилт бэрхшээл

Хувилбарууд	Ашиг тус	Сорилт Бэрхшээл
1.1 Малын түр зуурын байр	Малд шаардлагатай байгаа байрыг шууд барих Ерөнхийдөө урт хугацаа шаардсан шийдлүүдээс илүү хямд тусдаг, илүү олон хүмүүс ашиг хүртэж чадна.	Байршил, ашиглалт, газар эзэмшлийн асуудлыг сайтар тооцохгүй бол урт хугацаандаа нурааж, дахин барих хэрэгтэй болж магадгүй



Хувилбарууд	Ашиг тус	Сорилт Бэрхшээл
1.2 Малын урт хугацаанд ашиглагдах байр	Онцгой байдал дууссаны дараа мал өмчлөгч, урт хугацааны турш ашиглах хөрөнгөтэй үлдэх Нөөцийг урт хугацаанд, эдийн засгийн хувьд илүү үр дүнтэй ашиглах	Түр зуурын байрыг бодвол илүү өртөг өндөртэй Онцгой байдал дууссаны дараа эргээд оршин сууж байсан газартаа түргэн хугацаанд буцаж нүүх хүн амд тохиромжгүй
2. Мал сүргийг байршуулах үйл ажиллагаа	Энэ үйл ажиллагаа нь гамшгийн дараах янз бүрийн нөхцөлд мал сүрэг ба малчдын хэрэгцээг хангахын тулд илүү өргөн хүрээний суурьшлын асуудлыг загварчлах, төлөвлөх боломжийг олгодог Уугуул нутгийн иргэдтэй үүсэж болох маргаан, зөрчлөөс сэргийлж тэдэнд үүсэх дарамт шахалтыг бууруулахад дэмжлэг үзүүлнэ	Онцгой байдлын нөхцөл, үе шатаас шалтгаалан хэрэгцээ шаардлагыг нэн даруй хангахад уугуул иргэдтэй зөвшилцөх хугацаа хязгаарлагдмал байдаг Хүмүүнлэгийн байгууллагууд нь нэрвэгдсэн хүн амын хувьд мал амьтан нь тэдний үндсэн хөрөнгө учраас үүнийг анхаарах нь чухал ач холбогдолтой гэдэгт тэр бүр анхаарал хандуулдаггүй учраас мал амьтныг байршуулах асуудлыг эсэргүүцэх тохиолдол гардаг

Үйл ажиллагаанууд (тусламж)-ыг хэрэгжүүлэх цаг хугацаа

Малыг байраар хангах, байршуулах тусламжийг онцгой байдлын бүх үе шатанд буюу сэргээн босгох, нөхөн сэргээх болон бусад урт хугацааны шийдлүүдийн хүрээнд хэрэгжүүлнэ. Яаралтай хариу арга хэмжээнээс авхуулаад тогтвортой шийдэл хүртэл янз бүрийн хэрэгцээ байх ба эдгээрийг нөхөн сэргээх шатанд хэрэгжүүлэх боломжтой. Малыг байраар хангах шаардлага нь гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөрийн төлөвлөлт, амь нас аврах ажиллагаа, амьжиргааг нөхөн сэргээх арга барилыг «илүү сайныг барих»-тай нэгтгэсэн үйлдлүүд зэргээр хувьсан өөрчлөгдөж байна. Оромж байраар хангах ба байршуулах тусламж нь нэрвэгдсэн иргэдийн чухалчилж үзсэн шийдлийг дэмжих хэрэгтэй ба ингэснээр зураг төсөл, байршил, барилга байгууламжийн хувьд тогтвортой болно.

Мал сүрэг ба малчдад өөр өөр цаг хугацаанд янз бүрийн эрсдэл нүүрлэдгийг тооцох нь чухал ач холбогдолтой. Дээрэм хүчирхийлэлтэй тэмцэх нь хавсарсан гамшгийн туршид илүү хамааралтай бол ялангуяа гэнэтийн гамшгийн эхний эмх замбараагүй үед цагийн байдал тогтвортой болохоос



өмнө дээрэм, хүчирхийллийн аюул илүү их байдаг. Албадан нүүлгэн шилжүүлэлтээс үүсэх эрсдэл хожуу ажиглагдаж магадгүй ба улирлын хуанли бас чухал ач холбогдолтой. Олон тооны нутгийн иргэдийг онцгой байдлын улмаас нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд тэд ихэнхдээ эхний 12 сарын дотор өөрсдөдөө болон малдаа байнгын байр барих боломжгүй байдаг. Энэ тохиолдолд жилийн цаг агаарын олон мөчлөгийг тооцож төлөвлөх шаардлагатай.

Хүснэгт 7.2: Малыг байраар хангах ба байршуулах үйл ажиллагааны боломжит цаг хугацаа

Хувилбарууд	Гэнэтийн гамшиг		
	Гэнэтийн хор хохирол	Эрт үеийн нөхөн сэргээх	Нөхөн сэргээлт
1.1 Түр байраар хангах	✓	—	—
1.2 Урт хугацаанд ашиглагдах байраар хангах	✓	✓	✓
2. Мал сүргийг байршуулах үйл ажиллагаа	(✓)	✓	✓

Хувилбарууд	Удаан явцтай гамшиг			
	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
1.1 Түр байраар хангах	—	✓	✓	—
1.2 Урт хугацаанд ашиглагдах байраар хангах	✓	✓	✓	✓
2. Мал сүргийг байршуулах үйл ажиллагаа	✓	✓	✓	✓

LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн түншлэлийн стандартууд (ХТС)-тай холбогдох нь

Мал амьтныг байраар хангах нь LEGS-н бусад бүлэгт тусгасан мал амьтанд чиглэсэн арга хэмжээний нэмэлт бүрэлдэхүүн хэсэг юм. Гамшигт нэрвэгдсэн нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлсэн нөхцөлд малыг байраар хангах үйл ажиллагаа нь малын хэрэгцээг хангах хүрээнд тэжээл, ус, мал эмнэлгийн үйлчилгээ зэргийг төлөвлөсөн хариу арга хэмжээний нэг хэсэг нь байдаг



(Бүлэг 4, 5 ба 6). Хэрэв мал амьтан нь цаг агаарын хүйтэн нөхцөлд байгаа үед малжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа (Бүлэг 9) бол малын амьд үлдэх, тавлаг байдалд байр амин чухал байх ба энэ тохиолдолд байраар хангахад илүү анхаарах хэрэгтэй. Ялангуяа тухайн нутгийн иргэд төдийлөн сайн мэдэхгүй шинэ зүйлийн мал нутагшуулж байгаа тохиолдолд байрны талаар урьдчилсан зөвлөгөөг өгөх хэрэгтэй. Онцгой байдлын дараа үргэлж биш ч зарим тохиолдолд хүн мал хоёуланд нь хоргодох байр шаардлагатай болдог. Малын байрыг хүний хоргодох байр, суурьшуулалтын бүсээс ангид авч үзэж болохгүй. Хүн ба мал амьтны хэрэгцээг хамтад нь тооцсон амьжиргааг дэмжих, амь нас хамгаалахтай холбоотой уялдуулан зохицуулсан тусламж нь урт ба дунд хугацаандаа маш сайн үр нөлөө үзүүлдэг. Гэвч иргэдийн суурьшуулалтын хэрэгцээ нь малынхаас ямагт дээгүүр тавигдана. Тиймээс мал сүрэгт чиглэсэн тусламжийн үйл ажиллагаа нь хүн амын суурьшуулалтад сөргөөр нөлөөлөхөөргүй байх нь чухал.

Гэвч олон тохиолдолд хүн ба малын суурьшуулалтын хэрэгцээ харилцан хамааралтай байгаа нь уялдсан, хамтарсан төлөвлөлт хийх хэрэгцээг улам бүр харуулж байна (LEGS-н *Зарчим 5: Хариу арга хэмжээний зохицуулалт* харна уу). Жишээлбэл, хүн ба малын усны хэрэгцээг хүрэлцээтэй хангахын тулд усны хамтарсан хэрэгцээний үнэлгээг авч үздэг.

Энэ талаар Sphere гарын авлагын “Орон байр ба суурьшуулалт” бүлгийн төгсгөл хэсэгт байгаа хүний хоргодох байр ба суурьшилтай холбоотой дэлгэрүүлэн унших материалд нарийвчлан тусгасан ба үүнд мал сүрэгт нөлөөлж болзошгүй байр, байршуулалтын асуудалд байрны зураг төсөл, материал, барилгын арга зүй, газрын эрх, байгаль орчны менежмент, барилга байгууламж, барилга, бааз зэрэг дэд бүтцийн төлөвлөлт, зураг төсөл багтана.



LEGS-н зарчмууд болон бусад анхаарах асуудлууд

Хүснэгт 7.3: LEGS-н зарчмууд байраар хангах ба байршуулахад хамаарах нь

LEGS-н Зарчмууд	Байраар хангах ба байршуулах үйл ажиллагаа нь зарчмуудтай хэрхэн хамаарахыг харуулсан жишээ
1. Амьжиргаанд суурилсан хөтөлбөр	Байраар хангах ба байршуулалтын тусламж нь малын хорогдлыг бууруулж малчдын амьжиргааны гол хөрөнгийг хамгаалж байна. Малыг байраар хангахад бэлэн мөнгө ба зах зээлийн хандлагыг ашиглах нь мал аж ахуйн зэрэгцээ өргөн хүрээтэй амьжиргааг дэмждэг. Хуаран (кемп)-д байгаа малын бүтээгдэхүүнд орон нутгийн зах дээр лангуу гаргаж өгөх нь амьжиргааг хэвийн хадгалахад тусална. Байрны байршил нь нэмэлт амьжиргаанд тусалдаг. Тухайлбал, мал аж ахуйн багаж хэрэгслийг хадгалах зэрэг.
2. Олон нийтийн оролцоог хангах	Малын байр ба байршуулалтын суурингийн загвар төлөвлөлтөд нутгийн иргэдийн оролцоо чухал байдаг. Нутгийн иргэдийг оролцуулах нь хүн ба малын эрүүл мэнд, аюулгүй байдал, хариу арга хэмжээний үр ашигтай байдал, зардал хэмнэлтийг баталгаажуулж өгдөг. Хуаранд малын байр барих ба малын байршлын бүсийг иргэдтэй хэлэлцэн тохирох нь чухал.
3. Уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах	Малыг байраар хангах, байршуулах үйл ажиллагаа нь уур амьсгалд тохиромжтой байр барих, байгальд ээлтэй материалын худалдан авалт ба хэрэглээг дэмжих, кэмпийн дотор болон ойр орчимд ус, бэлчээр ашиглахтай холбоотой үүсэх хүрээлэн буй орчны үр нөлөөг тооцох, кэмп ба байршуулалтын суурингийн малын ялгадасны менежментийг хог хаягдлын асуудлын хүрээнд зохицуулах, кэмп хаагдсаны дараа ч байгаль орчныг нөхөн сэргээх зэргийг тооцсон байх шаардлагатай. (Энэ нь зардал багатай биш бөгөөд зарим тохиолдолд байгаль орчны доройтлыг бүрэн нөхөх боломжгүй эсвэл хэдэн жил үргэлжилж болно)
4. Бэлэн байдал ба эрт үеийн хариу арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	Эрсдэлийн үнэлгээ, хуучин байсан байр ба байршуулалтын сууринг сайжруулах үйл ажиллагаагаар дамжуулан гэнэтийн гамшгийн үр нөлөөг тодорхойлон урьдчилж бэлтгэх нь малын хорогдлыг бууруулна. Уяатай малыг суллах эрт үеийн ажиллагаа бас чухал.



LEGS-н Зарчмууд	Байраар хангах ба байршуулах үйл ажиллагаа зарчмуудтай хэрхэн хамаарахыг харуулсан жишээ
5. Уялдаа холбоотой хариу арга хэмжээг хэрэгжүүлэх	Хүн болон тэдний мал амьтдын хэрэгцээг харгалзан үзсэн уялдуулан зохицуулсан үйл ажиллагаа нь амьжиргааг дэмжих, амь насыг аврахад дунд болон урт хугацаанд хамгийн их үр нөлөө үзүүлнэ.
6. Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрийг дэмжих	Байраар хангах ба байршуулалтын хувилбарууд нь мал хариулах эмэгтэйчүүд ба хүүхдүүдийн эрсдэлийг бууруулах гэх мэтээр жендерт суурилсан хүчирхийллийг бууруулахад туслах хэрэгтэй. Кэмпийн сайн төлөвлөлт нь эмэгтэйчүүдэд амьжиргааны боломжуудаа ашиглахад тусалж чадна.
7. Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих	Кэмп дотор болон гадна малтай холбоотой нөөцийг зохицуулахад орон нутгийн хүлээн авагч иргэдийн хэрэгцээг хүлээн зөвшөөрч, тэдний мэдлэг чадварыг ашиглах нь амин чухал ба байраар хангах байршуулах үйл ажиллагаанд газар эзэмших, ашиглалтын эрх, ёс журам, орон нутгийн бодлого бүх талаар нөлөө үзүүлнэ. Нутгийн иргэдийн мэдлэгийг ашиглах, мөргөлдөөнөөс зайлсхийх стратегийг дагах нь нүүлгэн шилжүүлсэн иргэдийг дэмжихэд онцгой чухал.
8. Хяналт, Үнэлгээ, Хариуцлага, Суралцах (ХҮХС)	Малчдад зориулсан байр ба байршуулалтын тодорхой төрлийн дэмжлэг нь малчид болон тэдний амьжиргаанд хэрхэн эерэгээр нөлөөлж болох талаар илүү олон нотолгоотой байх шаардлагатай. Байраар хангах үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ нь суралцах үйл явцыг дэмжиж, цаашдын үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулахад үнэ цэнэтэй мэдээллээр хангана.

Аюулгүй байдал ба зөрчил, мөргөлдөөн

Байгалийн гэнэтийн гамшиг нь хүн ба малын аль алины аюулгүй байдалд аюул занал учруулж болох юм. Эдгээр нь үер, хөрсний гулгалтаас авхуулаад газар хөдлөлт, гал түймэр хүртэл өргөн хүрээтэй. Нөгөө талаар хавсарсан гамшиг нь аажмаар үүсэх ба гэнэтийн гамшиг, эмх замбараагүй байдалтай хосолсноор аюулгүй байдал алдагдах шалтгаан болдог. Малын байраар хангах үйл ажиллагаа нь төрөл бүрийн гамшгаас үүдэлтэй аюулгүй байдал алдагдах бусад нөхцөлүүдээс малыг бодитойгоор хамгаалахыг тооцох хэрэгтэй. Аюулгүй байдал алдагдах нь онцгой байдал ба ямар нэгэн дүрвэлтийн үр дагавраар үүсэж, эрчимжих эсвэл онцгой байдал үүсэхээс өмнө байсан байж ч болно. Энэ бүх тохиолдолд, тусламжийн үйл ажиллагаа нь “хүмүүст цаашид хор хохирол учруулахаас зайлсхийх” талаарх Sphere-н Хамгааллын зарчим 1-г дагах хэрэгтэй. (Бүлэг 1: *LEGS-н танилцуулгыг үзнэ үү*). Эрсдэлийг бууруулахын тулд малчид янз бүрийн



даван туулах механизмуудыг хэрэгжүүлж болох юм. Жишээлбэл, малын байрыг тойруулан барьсан хана, хаалт нь малыг илүү сайн хамгаалж чадна. Кэмпийн орчны аюулгүй байдал алдагдах байдлыг хянах гадны тусламжийг малчид малаа өөрсөдтэйгөө хамт байлгах уу, эсвэл олон өрхийн нэгэн зэрэг ашигладаг зориулалтын байранд байлгахыг илүүд үздэг эсэхээс хамаарч төлөвлөх хэрэгтэй. Энэ нь эргээд орон нутгийн соёл, боломжит орон зай, онцгой байдлын шинж чанараас хамаарна.

Газар ашиглалт ба орон сууцжуулалт, газар ба өмч хөрөнгө эзэмших эрх

Онцгой байдлын улмаас айл өрхүүдийг шинэ байршилд нүүлгэн шилжүүлэх үед орон сууцтай болох, газар түрээслэх, эд хөрөнгө олж авах эзэмших эрх тэдэнд дутмаг байдаг. Энэ нь айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлээгүй үед онцгой байдлын улмаас бичиг баримт эсвэл эд хөрөнгө, газар түрээслэх гэрээний бусад нотлох бичиг баримтаа алдсанаас мөн тохиолдож болох юм. Өөр нэг хувилбар нь түрээслэх, өмчлөлийг баталгаажуулах талаар шийдвэр гаргадаг хүмүүс (газрын эзэд эсвэл орон нутгийн засаг захиргаа) онцгой байдлын үр дүнд өөрчлөгдөж, солигдож болно. Эдгээр нөхцөл нь кэмп, байршуулалтын суурин дахь малын байр, хувь малчны малын байранд ч хамааралтай.

Нутгийн иргэдийн хувьд газар түрээслэх ба ашиглах эрхийг баталгаажуулах нь үндэсний хууль дүрэмд бүрэн нийцсэн бичиг баримтаас илүүтэй уламжлалт гэрээ тохиролцооноос хамааралтай байдаг. Зарим тохиолдолд уламжлалт гэрээ хэлцэл нь албан ёсны цаасан гэрээ байгуулах механизмаас илүү хүчтэй ба өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Нүүлгэн шилжүүлсэн иргэдийн хувьд уугуул иргэдийн ашигладаг газрын эрхийн уламжлалт ба албан ёсны алийг нь ч авч ашиглах боломжгүй байж магадгүй. Тиймээс тэд малын байр барих ямар нэгэн газар ашиглах эрхээ баталгаажуулж чадахгүй байх магадлалтай.

Малчдад Орон сууцжуулалт, Газар, Өмч хөрөнгийн (HLP) эрхээ эдлэхэд туслах нь 'Due Diligence Standard' буюу Шалгах стандарт' хандлагад дасан зохицоход чухал байж магадгүй. Үүнийг HLP ба хүний хоргодох байранд түгээмэл хэрэглэдэг болсон бөгөөд Global Shelter Cluster буюу Олон улсын орон байрны кластер хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү 'due diligence' арга барилын дагуу эрхийг баталгаажуулах зохион байгуулалтыг (албан ба албан бус) тодорхойлоход орон нутгийн оролцогчидтой хамтран ажиллах үедээ "хангалттай сайн" жишиг үзүүлэлтийг ашигладаг. Эдгээр хандлага нь орон байрны тусламжийг урагш ахиулахад хангалттай уян хатан бөгөөд цаашид сайжруулах боломжийг олгодог.



Орон нутгийн зах зээл ба бэлэн мөнгө

Мал сүргийг байраар хангахын тулд орон нутгийн зах зээлтэй хамтран ажиллах нь зарим талаар ашиг тустай. Материал худалдан авах үйл ажиллагааг зах зээлд суурилсан хандлагаар хэрэгжүүлэхдээ зах зээлийн яаралтай үнэлгээг хийж буй хүмүүнлэгийн бусад салбаруудтай хамтран ажиллах нь чухал. Энэ нь орон нутгийн зах зээл малын байр эсвэл түүнийг барих хангалттай материал нийлүүлж чадах, мөн хүний хоргодох байр, ус, ариун цэврийн байгууламж, бусад дэд бүтцийн материал хүрэлцээтэй эсэхийг баталгаажуулдаг. Орон нутгийн зах зээлд түшиглэх нь зах зээлийн нийлүүлэлтийг идэвхжүүлэх ба үүнийг үнэлгээ хийх явцад анхаарах хэрэгтэй. Зах зээлд хэт их ачаалал үүсгэж болохгүй ба энэ нь тэд гамшигт нэрвэгдсэн мөн бусад хүн амд өдөр тутмын хэрэгцээт барааг нийлүүлж чадахгүйд хүрэх шалтгаан болдог. Үүнээс гадна, шаардлагатай материал нь орон нутагт байгаа хэдий ч тэдгээр нь хангалттай бат бөх, удаан эдэлгээтэй, дулааны хамгаалалтыг хангадаг хоргодох байраар хангахад хангалттай чанартай байж чадахгүй байж болно. Зарим тохиолдолд хязгаарлагдмал нөхцөлтэй барааны эрхийн бичиг ашигладаг бөгөөд үүнд барилгын материалын чанарыг зааж өгдөг.

Малын байр, байршуулалтын хувилбаруудын шийдвэрийн мод


Шийдвэрийн мод нь онцгой байдлын үед малын байраар хангах байршуулах үйл ажиллагааны хамгийн боломжтой ба тохиромжтой хувилбарыг тодорхойлоход анхаарах зарим гол асуултуудыг нэгтгэн дүгнэж өгдөг. Стандартууд, үндсэн үйл ажиллагаа, зааварчилгаа зэрэг нь нарийвчилсан төлөвлөлт хийхэд илүү мэдээллээр хангаж өгнө. Боломжтой бол бэлэн байдлын үйл ажиллагааг онцгой байдал үүсэхээс өмнө урьдчилан зохион байгуулах хэрэгтэй.





Бүдүүвч 7.1: Малын байр, байршуулалтын хувилбарын шийдвэрийн мод

Түлхүүр: ✓ Тийм ✗ Үгүй

Арга хэмжээ







Стандартууд

Стандарт 1: Бэлэн байдал

Малын байр, байршуулалтын бэлэн байдлыг хангах үйл ажиллагаа нь онцгой байдлын үр нөлөө ба эрсдэлийг бууруулна.

Үндсэн үйл ажиллагаа

- Одоо байгаа малын байранд гэнэтийн гамшгийн улмаас учирч болох эрсдэлийг үнэлэх (*Зааварчилгаа 1-г харна уу*).
- Малын байр барих, байршуулалтын үйл ажиллагаа нь мал амьтан, тэдний эздэд учирч болох эрсдэлийг багасгах, цаашид гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхыг нэмэгдүүлэхийг дэмжих (*Зааварчилгаа 2 харна уу*).
- Онцгой байдлын үед эрсдэлд өртөх магадлалтай мал сүргийг нүүлгэн шилжүүлэхэд шаардлагатай болж болзошгүй арга хэмжээг тодорхойлох (*Зааварчилгаа 3 ба 4-г харна уу*).

Зааварчилгаа

1. Эрсдэлийн үнэлгээ

Гэнэтийн гамшгийн үр нөлөөнөөс үүсэх боломжит эрсдэлийн үнэлгээ ба бэлэн байдлын хүрээнд гамшигт өртөх эрсдэлтэй одоо байгаа байр, байршлын суурингуудыг анхааралдаа авах нь чухал. Малын тоо ба нягтаршил нь эдгээр үнэлгээний гол элемент байх хэрэгтэй.

2. Малын хорогдлыг хамгийн дээд хэмжээнд багасгах боломжтой барилга байгууламж

Малын байрны тохиромжтой байгууламж, мал сүргийн байршуулалтад тусалж үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь онцгой байдлын малд үзүүлэх үр нөлөөг багасгана. Малын байрыг барьж байгуулахдаа онцгой байдлын үед мал хорогдох эрсдэлийг бууруулах арга хэмжээг хамруулах хэрэгтэй байж магадгүй. Жишээлбэл:

Газар хөдлөлтөд тэсвэртэй: Малын байр ба байршуулалтын загвар, бүтэц нь нягт хатуу хөрстэй газар барих, хөрсний гулсалтын эрсдэл, гамшгийн дараах нуралт, цохилтын гэмтэл сүйрлээс зайдуу байх нь тохиромжтой. Малын байрны бүтэц нь газар хөдлөлтөд аюулгүй байхаар төлөвлөгдсөн, чичиргээнд тэсвэртэй хөнгөн материалаар хийгдсэн байх хэрэгтэй. Орон нутгийн материал ба технологи ашиглаж байгаа үед барилгын тэсвэрт байдлыг нэмэгдүүлдэг тухайн нутгийн барилгын практик зөвлөмжийг ашиглах нь чухал ач холбогдолтой юм.



Үерийн үр нөлөөг бууруулах: Боломжтой бол малын байрыг үерийн эрсдэлийн бүсээс хол, зайтай байгуулах, ялангуяа халиа, үерийн аюулаас зайдуу байлгах хэрэгтэй ба хэрэв боломжгүй бол байр орчмын үерийн усны суваг шуудууг сайжруулах, өмнө тохиолдож байсан үерийн түвшингээс дээш малын байрыг байрлуулах хэрэгтэй. Хүчитгэсэн барилга байгууламж ялангуяа суурийг хүчитгэвэл барилгын эвдрэлийн эрсдэлийг бууруулдаг.

Хүчтэй салхи шуурганд тэсвэртэй: Малын байрны барилгын дээврийг зөв бэхэлж үндсэн бүтцэд холбож, бэхэлсэн байх хэрэгтэй. Малын байрны байгууламжуудад хэрвээ усны түрлэг үүсэх эрсдэл байгаа үед далай тэнгисийн шууд эргээс зайдуу байрласан байх нь тохиромжтой.

Цунамигийн үр нөлөөг бууруулах: Мал, амьтны байрыг далай тэнгисийн эргээс аль болох зайтай байрлалд байгуулах хэрэгтэй.

Галт уул, хээрийн түймрийн нөлөөг багасгах нь: Галт уулын халуун лав урсах, үнс нурам цацагдах, хээрийн түймэр дэгдэх нь мал амьтан шатаж хорогдохоос гадна тэдний тэжээл, усан хангамж, байранд хохирол учирна. Түймэр, дэлбэрэлт эхлэх үед малын байр, хашаа хороонд байгаа мал амьтныг аль болох эрт суллаж тавих нь аюулгүй байдлыг хангах арга хэмжээ болох юм. Малыг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг эрсдэлд буй нутгийн иргэдтэй хамтран боловсруулах, урьдчилан бэлтгэсэн байх хэрэгтэй. Эдгээр бүх тохиолдолд барилгын ажлыг хийхдээ гамшгийн эрсдэлийг бууруулах шилдэг туршлагыг дагаж мөрдөх ба үүний тулд барилга байгууламж, талбайн төлөвлөлт, хот төлөвлөлтийн мэргэжилтнүүдээс техникийн заавар, зөвлөмж авах шаардлагатай.

3. Малыг нүүлгэн шилжүүлэх болзошгүй байдлын арга хэмжээ

Газар хөдлөлт гэх мэт зарим төрлийн гэнэтийн гамшиг нь урьдчилсан анхааруулга өгдөггүй ба мал сүргийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх цаг хугацаа байдаггүй. Гэвч хүчтэй салхи шуурга, түймэр, үер, галт уулын дэлбэрэлт зэрэг гэнэтийн гамшгийн үед малыг нүүлгэн шилжүүлэх бага ч гэсэн хугацаа гардаг. Эдгээр онцгой байдлын үед эрсдэлт байрлалд байгаа нутгийн иргэдэд малаа нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулах, малын нүүлгэн шилжүүлэх байрыг барихад тусалж болох юм. Хүн амын нүүлгэн шилжүүлэлтийн замд саад учрахааргүй гэхдээ хүний нүүлгэн шилжүүлэлтийн бүсэд аль болох ойр байршилд чиглүүлэн нүүлгэн шилжүүлэлт хийх хэрэгтэй ба энэ нь онцгой байдал, гамшгийн үед малчид малаа манаж, тэжээхийн тулд амь насаа эрсдэлд оруулахааргүй байлгах зорилготой зохион байгуулалтын арга хэмжээ юм. Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө ба нүүлгэн шилжүүлэх байранд шаардагдах малын тэжээл, усны хэрэгцээг тооцсон байх хэрэгтэй.



4. Мал сүргийг суллах

Өөр нэг чухал арга нь онцгой байдлын үед бусад тусламж ирэхээс өмнө хашсан, уяа, аргамжаатай байгаа малыг олж тогтоон түр суллаж тэдгээрийг өлсөж хатаж үхэх аюулаас аврах явдал юм. Туршлагаас үзэхэд гэр бүлийн гишүүд сураггүй болсон, мөн шархадсан үед тэдний саалийн (бөхтэй үхэр), үнээ зэрэг мал сүрэг уяатайгаа өлсөж үхсэн тохиолдол байдаг.

Энэхүү энгийн хариу арга хэмжээ нь эдгээр мал амьтдын уяаг тайлж суллах нь ус тэжээл олж идэн аврагдах боломжийг олгодог. Эдгээр мал амьтдыг будаж тэмдэглэх хэрэгтэй ба энэ нь тэдгээрийг эзэн нь буцааж олж авахад туслах юм. Бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд хангалттай анхааруулга өгсөн тохиолдолд онцгой байдлын үед малчдад үүнийг хийхийг уриалах хэрэгтэй.

Стандарт 2: Үнэлгээ ба төлөвлөлт

Малын байр, байршуулалтын хэрэгцээний үнэлгээ ба төлөвлөлтийг нутгийн иргэдтэй зөвлөлдөх, мөн орон нутгийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн тооцоолол, тогтвортой амьжиргааны хөтөлбөр боловсруулалт зэрэгт үндэслэн хийнэ.

Үндсэн үйл ажиллагаа

- Орон нутгийн малын байр, байршуулалтын дадал, туршлагын талаар хямралд өртсөн нутгийн иргэдтэй зөвлөлдөх хэрэгтэй. Зөвлөлдөх уулзалтад гамшигт шууд бусаар өртсөн уугуул нутгийн иргэд гэх мэт хүмүүсийг хамруулах (*Зааварчилгаа 1-г үзнэ үү*).
- Эн тэргүүнд орон нутгийн хамгийн эрсдэлтэй бүлгийн хүмүүсийн малын байрны хэрэгцээг хангахад чиглэх (*Зааварчилгаа 2-г үзнэ үү*).
- Үзүүлэх сөрөг үр нөлөөг бууруулахын тулд малыг байраар хангах үйл ажиллагааны орон нутгийн байгаль орчны үр нөлөөг үнэлэх (*Зааварчилгаа 3-г үзнэ үү*).
- Нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааны хэрэгцээ шаардлагыг онцгой байдлын хариу арга хэмжээний үнэлгээний нэг хэсэг болгож, гамшгийн хариу арга хэмжээний талаар мэдээлэх (*Зааварчилгаа 4-г үзнэ үү*).
- Тохиромжтой тохиолдолд байр ба байршуулах үйл ажиллагааг дэмжиж бэлэн мөнгө ба эрхийн бичгийн шилжүүлэг хийх боломжийг илрүүлэх зах зээлийн үнэлгээ зохион байгуулах (*Зааварчилгаа 5-г үзнэ үү*).
- Малын байр ба байршуулах үйл ажиллагааны талаар бүх хамааралтай оролцогч талуудтай өргөн хүрээнд хэлэлцэх (*Зааварчилгаа 6-г үзнэ үү*).

Хавсралт 7.1-г үзнэ үү: Малыг байраар хангах, байршуулалтын үнэлгээний шалгах хуудас.



Зааварчилгаа

1. Нутгийн иргэдийн оролцоо

Ямар төрлийн малын байр нь тухайн төрөл зүйлийнхээ малын онцлог шинж чанарт нийцэж болох, мөн үүний зэрэгцээ материал, барих талбайн сонголт, талбайд нэвтрэхэд анхаарах зүйлс, эрүүл ахуй, мал сүргийн менежментийн талаар малчидтай зөвлөлдөх хэрэгтэй ба дараах зүйлд анхаарал хандуулах нь чухал. Үүнд:

- мал, амьтан маллаж буй хүмүүсийн үүрэг, хариуцлагыг ойлгох (нас хүйсэд тулгуурласан хөдөлмөрийн хуваарилалт гэх мэт);
- нүүлгэн шилжүүлсэн малчдад зориулж кэмп байгуулах тусламжийн үйл ажиллагаа хийж байгаа тохиолдолд үүнд уугуул нутгийн иргэдийг оролцуулах нь чухал ач холбогдолтой. Тухайлбал, малын байр, байршуулалтын дэд бүтэц нь нутгийн иргэдтэй зөрчилдөөн үүсгэх шалтгаан, хүрээлэн байгаа орчны дарамт, ажил олголтын өрсөлдөөн, байгалийн нөөц ашиглалтын төлөөх тэмцэл үүсгэхгүй байхыг баталгаажуулах хэрэгтэй.
- Байрны хувилбарын талаар нийтийн эсвэл хувь хүн ашиглах зориулалттай байх эсэхийг ёс заншлын хэм хэмжээ, одоогийн нөхцөл байдалд тохируулах (аюулгүй байдал, цаг агаар гэх мэт), нэрвэгдсэн иргэдтэй зөвлөлдөж шийдэх хэрэгтэй. Ихэнх тохиолдолд, онцгой байдал үүсэхээс өмнө хувь айл өрх ашиглах зориулалттай байраар хангах нь илүү тохиромжтой байдаг хэдий ч зарим тохиолдолд энэ нь боломжгүй, тохиромжгүй эсвэл таарамжгүй байдаг.

2. Эрсдэлт бүлгүүд

Үнэлгээ ба төлөвлөлтийн шатанд эрсдэлт бүлгийн тусгай хэрэгцээ байгаа эсэхийг шалгах хэрэгтэй. Өөрсдөө малын байр барьж чадахгүй байгаа харгалзах хүнгүй хүүхэд, өндөр настан, өвчтэй болон хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүст нэн тэргүүнд тусламж үзүүлэх хэрэгцээг анхаарч үзэх хэрэгтэй. Эдгээр хүмүүс барилгын материал авч чадахааргүй байвал нэмэлт тусламж шаардлагатай болно. Аливаа тусламжийн үйл ажиллагааны нэгэн адил эрсдэлтэй бүлэгт үзүүлэх тусламж нь эрсдэлт бүлэгт нутгийн иргэдийн зүгээс өөрийн даван туулах стратегия ашиглан тусламж үзүүлэх чадавхыг сулруулж болохгүйг анхаарах хэрэгтэй.

3. Орон нутгийн байгаль орчны үр нөлөө

Байгууллагууд малын байр ба байршуулалтын үйл ажиллагааны орон нутгийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг заавал үнэлсэн байх хэрэгтэй. Тухайн бүс нутагт орон нутгийн барилгын материалыг тогтвортой бусаар ашиглаж буй эсвэл малын хэт бөөгнөрөл байгаа эсэхийг үнэлгээнд оруулах нь чухал.



Энэ нь кэмп байгуулахад онцгой ач холбогдолтой (Стандарт 4-г үзнэ үү). Малын байрны байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг ерөнхийд нь дараах дөрвөн хэсэгт хувааж болох бөгөөд тэдгээрийг малын байрны анхдагч үнэлгээ ба төлөвлөлтөд хангалттай тооцон үзэхээс гадна үр дүнгийн хяналт шинжилгээ, үнэлгээнд мөн хамруулах хэрэгтэй. Үүнд:

- материалын сонголт, сонгосон материалыг малын байр барихад хэрхэн ашигладаг, хэрэгцээгүй эсвэл дууссан материалын хаягдлыг устгах арга замууд;
- кэмп, суурьшлын орчим ба доторх бүс нутагт малын хөдөлгөөн, бэлчээрлэх, хашаалахаас үүсэх үр нөлөө;
- хуаран, суурьшлын орчим ба доторх бүс нутагт малтай холбоотой хаягдал (мал нядалгааны хаягдал бүтээгдэхүүн гэх мэт)-ын үзүүлэх үр нөлөө;
- зэрлэг амьтад, уугуул нутгийн иргэдийн мал сүрэг холилдож, нийлж, хавьтал үүссэнээс зооноз өвчин дамжин халдварлах (жишээ нь малын байрнаас халдварлах) үр дагавар. Жишээлбэл, тусламжийн байгууллагууд нь хэрвээ уугуул нутгийн иргэдийн тэжээвэр шувуунд эсвэл зэрлэг шувуунд томуу өвчин илэрвэл орон нутгийн хүн ам, мөн нүүн шилжсэн хүн амд үзүүлэх үр нөлөөг тооцон үзэх хэрэгтэй.

4. Тогтвортой амьжиргаа

Онцгой байдлын үед мал сүрэгт түр зуурын тусламж шаардагдаж магадгүй. Гэвч байраар хангах, байршуулалтын үйл ажиллагаа нь нэрвэгдсэн нутгийн иргэдийн амьжиргааны хэрэгцээг удаан хугацаанд хангахад бүх хүчин чармайлтаа хандуулах хэрэгтэй. Эдгээрт газар ашиглалтын хүлээгдэж буй өөрчлөлт, нутгийн иргэдийн амьжиргааны байнгын өөрчлөлт, гамшгийн хохирлыг нөхөн сэргээх үед мал аж ахуйн менежментийн арга барилд гарсан өөрчлөлтийн нөлөөллийг харгалзан үзэх зэрэг орно.

5. Зах зээлийн үнэлгээ

Барилгын материал орон нутагт байгаа тохиолдолд байгууллагууд бэлэн мөнгө эсвэл худалдан авалтын эрхийн бичиг олгох боломжийг судлах ёстой. Энэ нь орон нутгийн зах зээлийг дэмжих, мөн гамшигт өртсөн ард иргэдэд үйл явцыг хянах боломжийг олгоно. Мэргэжилтнүүд малын байрны материалд шаардагдах техникийн шаардлагуудыг зах зээлийн үнэлгээнд тусгаж, малын хашаа барихдаа дагаж мөрдөхөд туслах хэрэгтэй.

6. Олон талуудын оролцоо

Малыг байраар хангах үйл ажиллагааны талаар нүүн шилжээд байгаа малчид, нэрвэгдсэн нутгийн иргэдтэй цаашид хэлэлцэн тохиролцох хэрэгтэй.



Оролцогч талууд нүүн шилжсэн хүмүүст зориулан малын байр, байршуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ төлөвлөлтийн уялдаа холбоог хангаж, үйл ажиллагааг нөхөх зорилгоор хүмүүсийг хорогдох байраар хангах, суурьшуулах ажилтай хамт хэрэгжүүлнэ (*LEGS-н Зарчмууд 5-г үзнэ үү: Хариу арга хэмжээнүүдийн зохицуулалтыг хангах*). Оролцогч талуудад хөдөө аж ахуй, усан хангамж, ариун цэвэр, газар ашиглалт, барилгын асуудал хариуцсан орон нутгийн удирдлагуудыг хамруулж болно.

Стандарт 3: Малын байр

Мал сүрэг нь өөрийн онцлог, ашиглах зориулалтад тохирсон эрүүл, аюулгүй орчноор хангагдсан байна.

Үндсэн үйл ажиллагаа

- Малыг байраар хангах үйл ажиллагааны төлөвлөлт нь орон нутгийн малын байрны зураг төсөлд үндэслэх (*Зааварчилгаа 1-г үзнэ үү*).
- Малын байр нь аливаа аюул, зонхилох цаг агаарын нөхцөл, өдөр тутмын болон улирлын цаг агаарын эрс тэс нөхцөлүүдээс зохих байдлаар хамгаалагдсан байхыг баталгаажуулах (*Зааварчилгаа 1 ба 2-г үзнэ үү*).
- Малын байрыг байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг багасгах загвар, материал ашиглан барихыг анхаарах (*Зааварчилгаа 3 ба 4-г үзнэ үү*).
- Малын байр нь тухайн төрөл зүйл, ашиглах зорилгод тохирсон байхын зэрэгцээ түр хугацаанд ашиглах бол материал, бүтэц нь урт хугацаанд ашиглах эсвэл үүнд тохируулан өөрчлөхөд хялбар байх (*Зааварчилгаа 2, 3 ба 5-г үзнэ үү*).
- Малын байр нь бүх малчинд аюулгүй хүрч болохуйц байхыг баталгаажуулах (*Зааварчилгаа 6-г үзнэ үү*).
- Орон нутгийн иргэдийн малын байранд хорио цээрийн систем буй болгосон байх (*Зааварчилгаа 7-г үзнэ үү*).
- Малын байр нь мал амьтныг хулгай, араатан амьтдын халдлагаас хамгаалахаар байх (*Зааварчилгаа 8-г үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Тавлаг, аюулгүй амьдрах орчин

Малын байрыг газар хөдлөлт, гал түймэр, үерийн эрсдэлээс хамгаалж аюулгүй барихын тулд хүний хоргодох байрыг аюулгүй барихад ашигладагтай ижил материал, инженерийн техник, технологийг ашиглах хүлээлт байдаг. Байгууллагууд орон нутгийн барилга барих арга техник, орон нутгийн боломжит материалыг ашиглах хувилбарыг тодорхойлох талаар хоргодох байрны мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх хэрэгтэй бөгөөд



энэ нь малын байрны тогтвортой байдлыг хангаж малчид өөрсдөө арчилж засварлах боломжийг бүрдүүлнэ. Иймээс малын байрны орон нутгийн загвар, соёлын хэм хэмжээ, орон нутгийн барилгын материал ба тэдний барилга барих арга барилын талаарх нутгийн иргэдийн мэдлэгийг нэгтгэх нь чухал. Маш цөөн тохиолдолд "хоргодох байрны систем" эсвэл импортын угсармал шийдэл тохиромжтой байж болно. Малын байр барих аюулгүй байршлыг сонгохдоо тухайн газар нутгийн талаар мэдлэгтэй болон хүмүүнлэгийн үйл ажиллагааны төлөвлөлтийн чиглэлээр туршлагажсан хүмүүсийн аль алинтай нь зөвлөлдөх нь чухал.

2. Эрүүл, аюулгүй орчин

Халуун цаг агаартай бол малын байр нь агааржуулалт сайтай, сүүдэртэй байх нь тохиромжтой. Хүйтэн цаг агаарын нөхцөлд байр нь нэвт салхлахаас сэргийлсэн битүүмжлэл сайтай байхаас гадна газар дор дулаан тусгаарлагч материалаар хийгдсэн байдаг. Эрс тэс уур амьсгалтай газар малыг тарж бутрахаас өмнө байраар хангахад анхаарал хандуулах хэрэгтэй. *(Хавсралт 7.3: Малын байр ба уур амьсгалаас үүдэлтэй сорилтууд-ыг үзнэ үү)*

3. Тохиромжтой загвар

Байрыг орон нутгийн загвар хийцэд тулгуурлан орон нутгийн материал ашиглан барина. Байгалийн гамшгийн дараа малын байрыг нурж гэмтсэн барилга, дэд бүтцийн хаягдал материал ашиглан барьж болох юм. Барилгын боломжит хаягдлыг ашиглах чармайлтыг дэмжихийн тулд хаягдлыг ашиглах багаж хэрэгслээр хангаж, хэрхэн хэрэглэх талаар сургалт хийнэ. *FAO (2016) хуудас 119-г үзнэ үү*, орон зайн шаардлага, янз бүрийн материалын хүснэгт; *хуудас 122-г үзнэ үү* Малын хашааны загвар анхаарах зүйлс.

4. Байгаль орчны доройтол

Хэрэв малын байранд тухайн орон нутгийн боломжит материалыг цуглуулан барихыг дэмжих эсвэл шаардвал энэ нь байгаль орчны байнгын доройтолд өртөх эрсдлийг үүсгэх магадлалтай. Малын байр, хашлага, хашаа хороо барих банз, дүнз бэлтгэхээр мод огтлох, тоосго шатаах зэрэг тодорхой эрсдэлүүд үүснэ. Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулахын тулд байгууллагууд шинжээч мэргэжилтэн ба орон нутгийн оролцогч талуудтай хамтран доорх асуудалд анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Материалыг үр ашигтай ашиглах, хамгийн бага засвар, өөрчлөлт шаардах материалаар баригдах байрны загварыг сонгох.
- Байрны материалыг байгальд ээлтэй, тогтвортой байдлыг тодорхойлох боломжтой эх үүсвэрээс сонгох.
- Хэрэв өргөст бут гэх мэт "амьд ургамлын" нөөцийг малын байрны хашлаганы гол материал болгон ашиглаж байгаа бол тэр ургамлын



төрөл зүйл нь тухайн нутгийн унаган ургамлын зүйл мөн эсэхийг шалгах хэрэгтэй. Мөн эдгээр зүйл ургамал бусад зүйл ургамлыг түрж ургахааргүй байх хэрэгтэй бөгөөд тухайн нутгийн байгаль экологид ямар нэгэн хохирол учруулахгүй байх ёстой.

- Байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг бууруулахын тулд зам болон малын байрыг тараан байрлуулах боломжтой кэмпиин загвар төлөвлөлтийн талаар барилгын талбай төлөвлөгчид болон байгаль орчны мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх мөн энэ тал дээр орон нутгийн зан заншилд тохирсон, аюулгүй байдлыг хангасан байх хэрэгтэй.
- Мал сүргийн нөлөөлөлд хамгийн эмзэг, өртөж болзошгүй бүс нутгийг тодорхойлохын тулд уугуул нутгийн иргэд болон оролцогч бүх талуудтай зөвлөлдөх хэрэгтэй ба учир нь энэ ажилд бодитой саад бэрхшээл учруулж болзошгүй.

5. Урт хугацаанд ашиглагдах байраар өөрчлөх

Зарим нэг онцгой байдлын үед малыг амьд үлдээх үүднээс яаралтай байраар хангах шаардлага гардаг. Гэвч эдгээр байр нь удаан хугацаанд тохиромжгүй байж магадгүй. Байгууллагууд удаан хугацаанд ашиглагдах байрыг сэргээн шинэчлэн барихад нутгийн иргэдэд тусламж үзүүлж болох юм. Онцгой байдлын үеийн түр зуурын байрыг удаан хугацаанд ашиглах эсвэл илүү байнгын бүтцэд нэгтгэн шилжүүлэх боломж чухал байдаг. Жишээлбэл, онцгой байдлын үед байрны дээврийг урт хугацаанд ашиглах материалаар хийвэл дараа нь хана, хаалга, хашаа зэргийг нэмж засан урт хугацаанд ашиглах боломжтой.

6. Ашиглаж болохуйц нийтлэг загвар

Малчид хүйс, нас, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран бүрэн ашиглах, хүрч очих, орж гарах боломжтой байвал уг малын байрыг тохиромжтой гэж үзнэ. Байр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ашиглах, орох гарах орон зай, талбайтай байх хэрэгтэй. Малын байрны орчимд жендерт суурилсан хүчирхийллийг бууруулахын тулд тусламжийн байгууллагууд эмэгтэйчүүд, охидтой зөвлөлдөн шөнийн гэрэлтүүлэг зэрэг аюулгүй байдлыг хангасан нэмэлт тоноглолоор хангах хэрэгтэй.

7. Нутгийн иргэдийн дундын байр

Зарим тохиолдолд нутгийн иргэд дундын байрыг илүүд үздэг. Малыг нийтийн эзэмшлийн байранд оруулахын өмнө дараах арга хэмжээг авсан байх хэрэгтэй:

- Малыг таних тодорхойлох/эмэгжүүлэх ажлыг малд хамгийн бага зовиуртайгаар хийх хэрэгтэй.
- Малд шимэгч хорхой ба өвчний шинж тэмдэг байгаа эсэхэд үзлэг хийх



хэрэгтэй.

- Малыг хүлээн авах үед эрүүл мэндийн байдлын талаар бүртгэл хөтлөх хэрэгтэй (жишээ нь тарга хүч, хээлтэй эсэх).
- Холоос ирж буй малыг тусгай байранд орон нутгийн зонхилох өвчний нууц үеийн хугацаагаар хорио цээрийн дэглэмд байлгана.
- Хорио цээрийн болон нийтийн байранд байгаа малд байнгын хяналт шинжилгээ хийж байх хэрэгтэй. Нийтийн байрны малын маллагаа арчилгааны ажилд өрхүүдийн жагсаалт гарган ажил үүргийн хуваарийг тодорхойлох хэрэгтэй.
- Хорио цээрийн дэглэмийг тогтоохдоо орон нутгийн туршлага, бүтэц зохион байгуулалтаас хамааран байгаль орчин, малын эрүүл мэндийн тогтолцоонд тулгуурлан эмч мэргэжилтнүүдтэй зөвшилцөж хийх хэрэгтэй. Энэ нь орон нутагт хүлээн зөвшөөрөгдөх, уугуул нутгийн иргэдтэй зөрчилдөөнийг шийдвэрлэхэд туслах ба ингэснээр нутгийн иргэд гаднаас ирж буй малыг өвчний хяналтад байлгаж байгаа гэдэгт илүү итгэлтэй байх болно. (Бүлэг 6-г үзнэ үү: Мал эмнэлгийн тусламж).

8. Хулгай ба дээрэм

Мал амьтныг байраар хангах, байршуулах үйл ажиллагаа нь тухайн орон нутагт хулгай, бусад зэрлэг амьтдын халдлагаас сэргийлсэн байх ёстой. Тухайн байр нь сайн хаагддаг хаалгатай эсвэл мал амьтны байрны эргэн тойрон сайтар хамгаалагдсан байх хэрэгтэй. Тусламжийн байгууллагууд нь аюулгүй байдлыг хангах хамгийн сайн стратегийн талаар малчид, газар зохион байгуулагчид, кэмпийн менежер ба орон нутгийн удирдлагуудтай зөвлөлдсөн байх хэрэгтэй (жишээ нь, мал аж ахуйн бүсэд эсвэл орчимд олон нийтийн эргүүл ажиллуулах гэх мэт). Мөн мал амьтны байрыг аюулгүй байдлын үүднээс хүн амын сууринтай ойрхон байршилтай байхаар төлөвлөнө. Үүнийг малыг тусдаа байрлуулж байгаа эсэхээс үл хамааран хийх ёстой.

7

Стандарт 4: Мал сүрэг ба байршуулалт

Мал амьтныг байршуулах үйл ажиллагаа нь хүн мал хоёр хамт байхад аюулгүй, тогтвортой байх нөхцөлийг дэмжих ба мал сүрэгт аюулгүй, эрүүл, тогтвортой орчныг бий болгоход тусалдаг.

Үндсэн үйл ажиллагаа

- Мал амьтныг байршуулах арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт нь хүний аюулгүй байдал, хүн, мал хамтдаа аюулгүй байхад дэмжлэг үзүүлэхийг баталгаажуулах (Зааварчилгаа 1-г үзнэ үү).



- Байршуулалтын төлөвлөлт нь бүх төрлийн малын байр, уст цэг болон кэмп доторх болон гаднах малтай холбоотой бусад дэд бүтцэд эмэгтэйчүүд, охид, эрэгтэйчүүд, хөвгүүд аюулгүй нэвтрэх боломжийг хангасан байх (*Зааварчилгаа 2-г үзнэ үү*).
- Мал сүрэгтэй холбоотой дэд бүтэц нь хөгжлийн бэрхшээлтэй малчид ашиглаж болохуйц байхыг баталгаажуулах (*Зааварчилгаа 3-г үзнэ үү*).
- Талбайн нүүлгэн шилжүүлэх маршрутын төлөвлөлт, галын аюулгүй байдлын хувьд хүн, малын аль алины аюулгүй байдлыг харгалзан үзсэн эсэхийг баталгаажуулах (*Зааварчилгаа 4 ба 5-г үзнэ үү*).
- Мал амьтныг байршуулах тусламжийн байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг дээд зэргээр бууруулах (*Зааварчилгаа 6 ба 7-г үзнэ үү*).
- Мал амьтныг байршуулах, байраар хангах үйл ажиллагаа нь хүн амын тогтвортой суурьшлыг дэмжихийг баталгаажуулах (*Зааварчилгаа 8-г үзнэ үү*).
- Суурьшлын дэд бүтэц нь нийгмийн эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулсан байхыг баталгаажуулах (*Зааварчилгаа 9-г үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Хүний аюулгүй байдал ба хүн мал хамтдаа байх

Малын байрны байршил нь малчдын аюулгүй байдал, хамгаалалтад нөлөөлнө. Жишээ нь: мөргөлдөөний бүс нутагт малын байрыг хүн амын суурин газраас хол зайтай баривал малчид, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдэд эрсдэлтэй. Мөн эсрэгээрээ малын байрыг суурьшлын дэд бүтэц хүн амын суурин газар хэт ойрхон баривал өвчин тархах эрсдэлийг нэмэгдүүлдэг. Иймээс хулгай, халдлагаас хамгаалах үүднээс малын байр, хүн амын суурьшлын хоорондох хамгийн хол зайг, мөн эрүүл ахуйг хангах, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор малын байр, хүн амын суурьшлын хоорондох хамгийн бага зайг тохиролцож болно.

Энэ талаар тусламжийн байгууллагууд нь мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх хэрэгтэй. Суурьшлын төлөвлөлтийг хүн ам, мал амьтан хамтдаа аюулгүй байхаар зохицуулах хэрэгтэй ба энэ нь малаас хүнд дамжин халдварладаг зооноз өвчний эрсдэлийг бууруулахад чухал ач холбогдолтой. Байршуулалтын бүсийн талбайн төлөвлөгөө нь хог хаягдлыг боловсруулах талбай эсвэл бохир ус зайлуулах сувгийг хүмүүсийн амьдарч байгаа талбайгаас тусгаарласан байх ёстой.

Малын өтөг шивх боловсруулах байгууламж нь хүний эрүүл мэндийн байгууламж, хүнсний агуулах, сургууль, хүүхдийн тоглоомын талбайгаас хол зайдүү байрласан байх хэрэгтэй.



2. Жендерт суурилсан хүчирхийллийг бууруулах

Мал аж ахуйн ажилд оролцож байгаа эмэгтэйчүүд, эрчүүд, охид, хөвгүүд аюулгүй, нэр төртэй, жендерт суурилсан хүчирхийлэлгүйгээр оролцох эрхтэй (*LEGS-н Зарчмууд 6*: Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр боловсруулалт). Суурин байгуулах нөхцөлд байгууллагууд нь талбайн төлөвлөлтөд оролцдог бусад хүмүүс, ялангуяа эмэгтэйчүүдийн бүлгүүдтэй хамтран ажиллах ёстой. Ингэснээр мал сүрэгтэй холбоотой жендерт суурилсан хүчирхийллийн эрсдэлийг бууруулахын тулд суурингийн зохион байгуулалт, нийтийн байгууламж, дэд бүтцийн хүрээнд мал аж ахуйн ажил эрхлэхэд эмэгтэйчүүд, охидын үүргийг тодорхойлж өгнө.

3. Хүртээмжтэй байдал

Малчин өрхийн хөгжлийн бэрхшээлтэй гишүүд кэмп эсвэл суурьшилд нүүн шилжих үед бодитой бэрхшээл нүүрлэж болох юм. Иймээс тусламжийн байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд, нутгийн зөвлөл, байр, байршуулалтын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс малтай ажиллахад үүсэх саад бэрхшээлийг багасгах зорилгоор мал сүрэгтэй холбоотой дэд бүтцийн загвар хийцийг сайжруулах төлөвлөгөө боловсруулах нь чухал.

4. Галын аюулгүй байдал ба нүүлгэн шилжүүлэлт

Кэмп суурингийн талбайн төлөвлөлтийн үндсэн шаардлага нь онцгой байдлын үед нүүлгэн шилжүүлэлт хийхэд тохиромжтой, хүрэлцээтэй замтай, онцгой байдлын машин техник орох боломжтой байх ёстой. Энэ нь кэмпэд гал гарсан эсвэл халдлагад өртсөн тохиолдолд чухал ач холбогдолтой юм. Стандартын дагуу эдгээрийг талбайн ерөнхий төлөвлөгөөнд тусгадаг бөгөөд үүнд галын хамгаалалт (гал тархахаас сэргийлж хамгаалах байрны хоорондох зай) болон гал унтраах станцууд багтдаг. Гэнэтийн гамшгийн үед кэмп дотор малчид малаа яаралтай нүүлгэн шилжүүлэхийг хүсч магадгүй. Онцгой байдлын үед мал ч бас байраа эвдэж гарахыг оролдож болно. Иймэрхүү нөхцөлд хүний амь насыг хамгаалахын тулд малыг, хүнийг нүүлгэн шилжүүлэх зам, яаралтай тусламжийн гарц, цугларах цэгт оруулахгүй байхад анхаарах хэрэгтэй. Талбай төлөвлөгч нар малд зориулсан өөр зам бий болгох, мал хүнийг нүүлгэн шилжүүлэх хэсгүүдийн хооронд хаалт хийх, хуваах хэрэгтэй.

Орон нутгийн нөхцөл байдлаас шалтгаалан малын зориулалтын байрыг кэмпийн зах эсвэл ар талд, гол нэвтрэх замаас хол байрлуулбал энэ нь илүү хялбар байх болно.



5. Зам дагуух халдлага

Байраар хангах үйл ажиллагааны үед байгалийн ургамал ашиглан хийх "амьд" байр, хашаа нь ямар ч хуурай улиралд гал түймрийн эрсдэл үүсгэхгүй байхыг анхаарах хэрэгтэй. Мөн эдгээр малын байр болон хүний хоргодох байрны хооронд гал унтраах зай байх шаардлагатай. Ерөнхийдөө торон хашаа эсвэл байрны хаалтыг кэмп буюу суурьшил дахь хүмүүст зориулагдсан замуудын аль нэгийг нь дайрах, хаах байдлаар хийж болохгүй.

6. Орон нутгийн байгаль орчны үр нөлөө

Малд үзүүлж байгаа тусламжийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгах хэрэгтэй. Бэлчээрийн талхагдлын эрсдэлийг бууруулахын тулд байрны тусламж нь малын бөөгнөрөл үүсгэхээс зайлсхийх хэрэгтэй. Байршуулалт буюу кэмпийн төлөвлөгөөнд кэмп дээр байгаа бүх малыг нэг том байранд байрлуулахын оронд хэд хэдэн жижгэвтэр байранд оруулахаар төлөвлөх нь илүү тохиромжтой байх магадлалтай. Олон салангид жижиг байртай байх төлөвлөгөөг хэрэгжүүлэх тохиолдолд талбай төлөвлөгчид нь эдгээр байр бүр мал амьтад ус, тэжээлийн нөөцийг олж идэх боломжоор хангагдсан байхыг анхаарах нь чухал ба малчид эдгээр байранд аюулгүй хүрэх боломжоор хангагдсан байх хэрэгтэй.

7. Газар олж авахаар хийх хэлцлүүд

Мал сүргийг баазад байршуулах нь орон нутгийн байгаль орчин ба нөөцөд хангалттай нэмэлт дарамтыг буй болгодог. Нөөцийн төлөө уугуул нутгийн иргэдийн малтай өрсөлдөж эхлэх нь сөргөлдөөн үүсэх эх үүсвэр болох учраас бэлчээр ашиглах талаар уугуул нутгийн иргэдтэй хэлэлцээ хийхийг оруулах хэрэгтэй. Ашиглахаар хэлэлцэн тохирсон зүйлс улирлаар өөрчлөгдөж болзошгүй бөгөөд үүнийг илүү тогтвортой байлгахын тулд байршил хооронд шилжих шаардлага гарч магадгүй юм.

8. Хүн ба малыг тогтвортой суурьшуулах

Малчид өөрсдийн уугуул нутагтаа үлдэх, нүүлгэн шилжүүлсний дараа шинэ байршилд удаан эдэлгээтэй орон сууц, байр байгуулах, эсвэл дүрвэлтийн хугацааны дараа эх нутагтаа буцаж нүүн ирж болно. Эдгээрийн аль ч тохиолдолд малын ашиглах бэлчээр, газар болон бусад нөөцийг ашиглахтай холбоотой дарамт шахалт үүсэж болзошгүй. Малчдыг нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд байршуулах нутгийн бэлчээр ашиглах эрх, менежментийн бүтэц, хүртээмж, газрын түрээсийн эрх, өмчлөл зэргийг тооцон үзэх ёстой. Тогтвортой, тохиромжтой шийдвэр гаргахын тулд оролцогч талуудтай өргөн хүрээнд зөвлөлдөх шаардлагатайн зэрэгцээ орон нутгийн эрх баригчид болон бусад салбарын мэргэжилтнүүдээс зөвлөгөө авах нь чухал юм (*Стандарт 2, Зааварчилгаа 6-г үзнэ үү*). Тусламжийн байгууллагууд



зөрчилдөөнийг багасгах хэлэлцээр хийх, мөн байр байршуулалт, газрыг бүсчлэн ашиглах төлөвлөлтийг зохистой хийх замаар газрын нөөцийг тогтвортой, аюулгүй хуваан ашиглах зэрэгт тусламж үзүүлэх хэрэгтэй.

9. Нийтийн эрүүл мэндэд үзүүлэх үр нөлөө

Ялангуяа, мал бүхий иргэд шилжин суурьшсан хуаранд эрүүл ахуйн менежментийг хэрэгжүүлэх, мал амьтны ялгадсыг устгах боломжоор хангасан байх хэрэгтэй. Менежментийн хувилбар нь дараах асуудлыг багтаасан байна. Үүнд:

- малын өтөг бууцыг зайлуулах, тараахад бэлэн мөнгө эсвэл бусад төрлийн урамшуулал олгох;
- хэвтрийн шивтэр шавхайг зузаарахаас сэргийлж тогтмол цэвэрлэх эсвэл тогтмол зөөн сэлгэж байх;
- хүн амын суурьшсан газрын эргэн тойрон мал орохоос сэргийлсэн хашлага хийх;
- хүн амын байр сууц ба малын байр хангалттай зайтай байхыг баталгаажуулах;
- малын усны эх үүсвэр, байр, хашаа, зам нь хүний хэрэгцээнд ашигладаг аливаа усны эх үүсвэрийн доод талд байрлах ба үүнд сургууль, хүүхдийн тоглоомын талбай, эрүүл мэндийн байгууллагуудад зориулагдсан аливаа усны эх үүсвэрийг багтана.
- малтай холбоотой ямар нэгэн хог хаягдал, (нядалгаа, малын захын хаягдал бүтээгдэхүүн) бохир ус зайлуулах шугам сүлжээг тухайн нутаг дэвсгэрт байрлах хүний хоргодох байрны зориулалт бүхий ус зайлуулах шугам сүлжээнээс тусад нь эсвэл доошоо уруудсан байхаар тооцох ба үүнд мөн уугуул нутгийн иргэдийн ойр орчмын суурьшлуудыг хамруулах хэрэгтэй.

Мал сүргийн нягтаршил аюулгүй түвшинд үлдэх хэрэгтэй FAO (2016)-н 119-р хуудасны Хүснэгт 14-с өөр өөр зүйлд тавигдах шаардлагын талаар дэлгэрүүлэн үзнэ үү.

7

Стандарт 5: Удаан эдэлгээтэй малын байрны шийдэлд шилжих

Малын байр, байршуулалтын төлөвлөлт нь онцгой байдлын үеийн түр байрнаас удаан эдэлгээтэй тогтвортой шийдэл рүү шилжихэд дэмжлэг үзүүлэх

Үндсэн үйл ажиллагаа

- Малын байрны хийц загвар нь малчид ашиглалтын явцад засаж,



сайжруулах, шинэчилж чадахаар байх нь чухал (*Зааварчилга 1 ба 2-г үзнэ үү*).

- Нүүлгэн шилжүүлэлтийн явцад байршуулалтын бүсэд малын тоо толгой ба төрөл зүйл нэмэгдэх боломжтойг тооцон байршуулалтын төлөвлөлтийн стратегийг боловсруулах нь тохиромжтой ба цаашдаа малчид ба мал сүргийн хэрэгцээ хувьсан өөрчлөгдөнө гэдгийг ч мөн тооцоолсон байх хэрэгтэй (*Зааварчилгаа 3-г үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Өөрчлөх боломжтой малын байрны загвар

Малын байрыг онцгой байдлын дараа эхний шатанд хүмүүнлэгийн байгууллагын хүмүүс эсвэл малчид өөрсдөө маш энгийн байдлаар богино хугацаанд барьдаг. Дараа нь эдгээр байрыг солих эсвэл шинэчлэх шаардлага гарч болзошгүй, тиймээс тэдгээр нь шилжилтийн шинж чанартай байж, нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдэд удаан эдэлгээтэй шийдлийг сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Орон нутгийн нөхцөл байдлаас шалтгаалан энэхүү "шилжилтийн" чанар нь малын байрыг "зөөврийн" (өөр байршил руу зөөх боломжтой) эсвэл "шилжүүлэх" (хэрэгцээнээс хамааран айл өрхүүд бие биедээ хандивлах, солилцох боломжтой) байхаар загвар гаргана гэсэн үг юм. Тэдгээрийг мөн "өөрчлөх" өөрөөр хэлбэл шинэчилж, илүү бат бөх болгох эсвэл байрыг өөр өөр өрхүүд ашиглах зориулалтаар өөрчлөх боломжтой байдлаар хийж болно. Орон нутгийн нөхцөл байдлаас шалтгаалан иймэрхүү ижил төстэй арга барил, дизайн нь хүний хоргодох байранд хэдийн нийтлэг байж болох талтай.

2. Мэргэжлийн сургалт

Малын байрыг цаг хугацааны явцад шилжүүлэх, сайжруулахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд тусламжийн байгууллагууд байр барих техник арга зүйн сургалтад хамруулах асуудлыг авч үзэж болно. Үүнд малчид уугуул нутагтаа буцаж нүүх эсвэл шинэ байршилд суурьших үеийн малын байрны хэрэгцээг тусгайлан оруулах ёстой.

3. Кэмп эсвэл байршуулалтын бүс дэх орон зайн зориулалтыг өөрчлөх

Малчид онцгой байдлын үеийн анхны нүүлгэн шилжүүлэлтээр эсвэл баазад ирэх үед тэдний малын тоо толгой нь цөөрсөн байж болно. Гэсэн хэдий ч цаг хугацаа өнгөрөх тусам мал төллөлт, зах зээлээс олж авах гэх мэт замаар тэдний малын тоо нэмэгдэх боломжтой тул үүнийг дагаад мөн кэмп доторх болон ойр орчмын газар, орон зайд тавигдах шаардлагууд нь нэмэгдэж болно. Кэмп дэх хүний тоо нэмэгдсэн тохиолдолд зай талбайг өргөтгөх шаардлага



үүсэх ба энэ нь газар ашиглалтад дарамт учруулж болзошгүй. Эсвэл цаг хугацаа өнгөрөх тусам амьжиргааны бусад боломжууд (ногоо тариалах, SEADS-ийг үзнэ үү, эсвэл жижиг үйлдвэрийн цехүүд гэх мэт) хөгжсөний улмаас газар эсвэл бусад нөөцийн төлөөх өрсөлдөөн үүсэж болзошгүй юм. Түүнчлэн, малын байрыг малчид өөрсдөө шинэчлэн сайжруулах ба энэ тохиолдолд илүү их зай талбай шаардагдана. Эдгээр бүх асуудлыг кэмпийн газар зохион байгуулалт, талбайг өргөжүүлэх төлөвлөгөөний аль алинд нь анхнаас нь тооцон төлөвлөх шаардлагатай. Орон нутгийн нөхцөл байдлаас шалтгаалан эхлээд жижиг кэмп барьж, дараа нь томсгох стратеги нь энэ шилжилтэд тусалж болох юм.



Хавсралтууд

Хавсралт 7.1: Малыг байр ба байршуулалтаар хангах үнэлгээний шалгах хуудас

Малын байр (түр зуурын ба удаан эдэлгээтэй)

- Түр зуурын малын байр нэн даруй шаардлагатай байна уу?
- Ямар төрлийн хэдэн тооны мал амьтанд байр шаардлагатай байна вэ?
- Өөр өөр төрлийн малын цаг агаар, байгаль орчны нөхцөлд тохирсон ямар байр байх шаардлагатай вэ?
- Нийгмийн ямар бүлгүүд голлож байна вэ?
 - а.** Мал маллахад эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд ямар үүрэгтэй вэ?
 - б.** Тухайн орон нутагт байр барих ажлыг голдуу хэн хариуцдаг вэ?
 - г.** Тусгай хэрэгцээтэй (дүрвэсэн эмэгтэйчүүд, өнчин хүүхэд гэх мэт) эсвэл өндөр эрсдэлт бүлгийнхэн байгаа эсэх?
- Хүн амын хувьд хоргодох байрны зонхилох сонголтууд юу вэ? Тэд түр болон шилжилтийн хоргодох байранд байна уу, эсвэл засварлах, сэргээн сайжруулах шаардлагатай хуучин оромжид байна уу?
- Орон нутагт ямар төрлийн малын байрны хийц загвар, барих арга, түүхий эд материал ашигладаг вэ?
- Эдгээр туршлагауд нь ирээдүйд үүсэж болох гамшгийн үед мал хоргодох эрсдэлийг бууруулж чадах уу?
- Орон нутагт барилгын материал хэр олдоцтой вэ?
 - а.** Орон нутгийн барилгын материалыг яаж бэлтгэх вэ?
 - б.** Байр барих нь байгаль орчинд ноцтой нөлөөлөх үү?
 - в.** Байр барих ажлыг дэмжих бэлэн мөнгө, эрхийн бичгийг орон нутгийн зах зээлд сөрөг нөлөө үүсгэхгүйгээр тараах боломжтой юу?
 - г.** Барилгын материалыг тухайн газар луу тээвэрлэх боломжтой юу?
- Малыг байрыг ирээдүйд аливаа аюул заналхийлэлд илүү тэсвэртэй болгохын тулд орон нутгийн барилгын ямар арга барилыг байрны загварт ашиглаж болох вэ?
- Ирээдүйд тохиолдож болзошгүй нөхцөл байдлуудад малын хорогдлын хэмжээг бууруулахын тулд малыг сүл чөлөөтэй байлгахад илүү уях нь чухал гэх мэт малын байртай холбоотой ямар дадлыг малчид өөрчлөх шаардлагатай болж болзошгүй вэ?



Байршуулалтын асуудлууд

- Малчдын өөрсдөө суурьшсан байршил эсвэл төлөвлөгдсөн кэмпэд тодорхой, өвөрмөц аюул (жишээлбэл: үер, хөрсний гулсалт, дэлбэрээгүй тэсрэх бөмбөг гэх мэт) бий юу? Кэмпийн талбайг ашиглах боломжгүй байдалд хүргэж болзошгүй өөр ямар нэг ноцтой асуудал байна уу? Жишээлбэл, хүн, малын аль алинд нь хангалттай усны хэрэгцээ байнга эсвэл улирлын чанартай дутагдалтай байх гэх мэт
- Малчид суурьшлын ямар хэв маягтай вэ?
 - a. Малчид өөрсдийн үндсэн газар нутгаас шилжин суурьшсан эсэх?
 - b. Мал аж ахуй эрхэлдэг нутгийн иргэдийн дунд болзошгүй зөрчилдөөн байгаа юу (дүрвэсэн иргэд ба уугуул нутгийн иргэдийн хооронд гэх мэт)?
 - c. Тухайн орон нутагт бэлчээрийн эх үүсвэр хангалттай юу? Онцгой байдлын дараа шилжин ирсэн иргэд, тэдний мал сүргээс шалтгаалан бэлчээрийн доройтол үүсэх эрсдэлтэй юу?
 - d. Одоогийн байгаа нийтийн буюу дундын байрны газрын эрх, менежментийн систем ба байршуулалт нь ямар дэд бүтэцтэй вэ? Тэдгээр нь шинээр байр барихад тохиромжтой юу?
 - e. Байршуулалтын хувьд эмэгтэйчүүд, охид, хөвгүүд аюулгүй хүрэх гэх мэт өөр ямар төрлийн хэрэгцээ байна вэ?



Хавсралт 7.2: Малын байраар хангах ба байршуулалтын үйл ажиллагааны хяналт ба үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн жишээ

	Үйл явцын шалгуур үзүүлэлт (болж байгаа үйл ажиллагааны хэрэгжилтийг хэмжих)	Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (болж байгаа үйл ажиллагааны үр дүнг хэмжих)
Байраар хангах ба байршуулах тусламж	Байрны тоо, төрөл байршлаар Байршуулах үйл ажиллагааны тоо, төрөл	Байр хэрэгцээтэй айл өрх /байр хэрэгцээтэй малын тоог айл өрхөд харьцуулсан дүн/ Байранд малласан малын хорогдлыг байргүйгээр малласан малын тоонд харьцуулсан дүн Байраар хангах үйл ажиллагааны үр дүнд малын гаралтай бүтээгдэхүүн өссөн эсвэл буурсан дүн, ялангуяа эрсдэлт бүлгийнхний хувьд Малын бэлчээр, дэд бүтэц, бусад байршуулалтын хэрэгцээт зүйлсийг ашиглах мал сүрэг мөн өрхийн тоо Эрсдэлт бүлгийн малчдаас (эмэгтэйчүүд, хөвгүүд ба охид, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өөр өөр ястан эсвэл бусад цөөнхийн бүлэг гэх мэт) малын байр луу аюулгүй хүрч чадна гэж мэдээлсэн малчдын тоо



Хавсралт 7.3: Малын байр ба уур амьсгалаас үүдэлтэй сорилтууд

Уур амьсгалын өөрчлөлт	Малын байрны нийтлэг тусламж
Халуун	Дээвэртэй байх, сүүдэр газар байрыг барих (өндөр дээвэртэй нэмэлт агааржуулалтай) Сүүдэрлэх ханатай байх Малыг усаар шүршиж сэрүүцүүлэх усан сантай байх Мал, хүнд ашиглагддаг бүсийн эргэн тойронд хөндлөн агааржуулалт, салхины урсгалыг тооцсон кэмгийн төлөвлөлт хийх Дулааныг бага дамжуулах шинж чанар бүхий барилгын материал ашиглах (шавар тоосго гэх мэт) Дулааны тусгал сайтай өндөр чанар бүхий материал ашиглах
Хүйтэн	Малын байранд зориулсан нэмэлт халаагуур тавих Халаах шаардлагатай талбайг бууруулахын тулд намхан дээвэртэй малын байрны загварыг ашиглах Соёлын хувьд таарамжтай бол хүн малын дундын байр оромж, хуваалцах байрны загвар ашиглах Гадна хана нь салхины хамгаалалттай байх Өвлийн улиралд хэрэглэх тэжээлийг хадгалах агуулахын зай багтаамжтай байх
Хуурай/нөөцийн усан хангамж бүхий	Байрны дотор эсвэл сүүдэртэй газар ус хадгалах сав байрлуулах нэмэлт зайтай байх Худаг, цооног эсвэл малын зориулалттай усан сан бүхий усалгааны цэгүүдийг кэмп, байршлын бүсийн эргэн тойронд болон бүх хүн нэвтрэх боломжтой газарт барих. (Бүлэг 5 -н Усаар хангах бүлгийг үзнэ үү)
Чийг	Мал зогсох хуурай талбай ба тэжээл хадгалах хуурай газраар хангах үүднээс малын байрны суурийн хэмжээг өндөрсгөх Малын байрны дотор болон орчимд борооны ус нэвтрэхээс хамгаалж дээврийн саравчийг өргөн хийх Мал ашигладаг хэсгүүдийн бохир ус зайлуулах болон хог хаягдлын менежментийн системийг кэмгийн үндсэн ус зайлуулах шугам сүлжээнд нэгтгэх.

(Тайлбар: Энэ хүснэгтэд жагсаасан арга хэмжээнүүдийг байгууллагуудын мэргэжилтнүүд болон өртсөн нутгийн иргэдтэй зөвлөлдсөний үндсэн дээр авч хэрэгжүүлэх хэрэгтэй.)



Эх сурвалж ба цаашид судлах материалууд

Camp Coordination and Camp Management (CCCM) Cluster (2021) Minimum Standards for Camp Management, CCCM Cluster, <https://cccmcluster.org/resources/minimum-standards-camp-management>

Catholic Relief Services (2012) Managing Post-Disaster (Re)-Construction Projects, How-To Guide, CRS, Baltimore, MD, <https://www.crs.org/our-work-overseas/research-publications/managing-post-disaster-reconstruction-projects>

Corsellis T. and Vitale A. (2005) Transitional Settlements: Displaced Populations, Oxfam GB and University of Cambridge shelter project, <https://www.sheltercluster.org/sites/default/files/docs/Transitional%20Settlement%20-%20Displaced%20Populations.pdf>

Dosti Development Foundation (DDF) and FAO (2007) Livestock shelter and supplementary cattle feed project report, 2006–2007, DDF and FAO, Pakistan.

FAO (2016) Livestock-related interventions during emergencies – The how-to-do-it manual. Edited by Philippe Ankers, Suzan Bishop, Simon Mack and Klaas Dietze. FAO Animal Production and Health Manual No. 18. Rome, <https://www.fao.org/3/i5904e/i5904e.pdf> (See Chapter 8)

International Federation of Red Cross and Red Crescent Societies (IFRC) and Oxfam (2007) A Guide to the Specifications and Use of Plastic Sheeting in Humanitarian Relief, IFRC and Oxfam, <https://www.sheltercluster.org/sustainable-solutions-working-group/documents/plastic-sheeting-guide>

International Organization for Migration (IOM) and The Shelter Cluster (2018) Site Planning: Guidance to Reduce the Risk of Gender-Based Violence, 3rd edn, Global Shelter Cluster, https://sheltercluster.s3.eu-central-1.amazonaws.com/public/docs/site_planning-gbv_booklet_apr-2018_web_high-res_v3_0.pdf

IOM, Norwegian Refugee Council (NRC) and United Nations High Commissioner for Refugees (UNHCR) (2015) Camp Management Toolkit, IOM, NRC, UNHCR, <https://www.refworld.org/pdfid/526f6cde4.pdf>

Jha, A.K. with Barenstein, J.D., Phelps, P.M., Pittet, D., Sena, S. (2010) Safer Homes, Stronger Communities: A Handbook for Reconstructing after Natural Disasters, World Bank, Washington, D.C. <http://hdl.handle.net/10986/2409>

The Shelter Centre (2012) Transitional Shelter Guidelines, Shelter Centre, Geneva, <https://sheltercluster.org/resources/documents/transitional-shelter-guidelines>

The Shelter Cluster (2013) Land Rights and Shelter: The Due Diligence Standard, Shelter Cluster, https://sheltercluster.s3.eu-central-1.amazonaws.com/public/docs/4.2_gsc_land_rights_and_shelter_the_due_diligence_standard.pdf

Sphere Association (2018) The Sphere Handbook: Humanitarian Charter and Minimum Standards in Humanitarian Response, 4th edn, Geneva, <https://spherestandards.org/handbook-2018/>

UNHCR (2015) UNHCR Emergency Handbook, 4th edn, UNHCR, <https://emergency.unhcr.org/topic/27459/camps>

UNHCR and International Union for Conservation of Nature (IUCN) (2005) Planning and Animal Husbandry in Refugee and Returnee Situations: A Practical Manual of Improved Management, UNHCR and IUCN, Geneva, <http://www.unhcr.org/protect/PROTECTION/4385e3432.pdf>

In addition, many practical case studies for shelter and settlement can be found in the various editions of Shelter Projects, <https://www.shelterprojects.org/>

See also case studies for livestock shelter and settlement interventions in emergencies at: <https://www.livestock-emergency.net/resources/case-studies/>





Бүлэг 8: Малын тоо толгойг бууруулах үйл ажиллагааны техникийн стандарт

- 299 **Танилцуулга**
- 302 **Малын тоо толгойг бууруулах үйл ажиллагааны хувилбарууд**
- 306 **Үйл ажиллагаанууд (тусламж)-ыг хэрэгжүүлэх цаг хугацаа**
- 308 **LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн түншлэлийн стандартууд (ХТС)-тай холбогдох нь**
- 308 **LEGS-н зарчмууд болон бусад анхаарах асуудлууд**
- 311 **Малын тоог бууруулах үйл ажиллагааны хувилбаруудын шийдвэрийн мод**
- 313 **Стандартууд**
- 324 **Хавсралт 8.1: Малын тоог бууруулах үйл ажиллагааны хяналт-үнэлгээний шалгах хуудас**
- 326 **Хавсралт 8.2: Малын тоог бууруулах үйл ажиллагааны хяналт ба үнэлгээний шалгуур үзүүлэлтийн жишээ**
- 328 **Эх сурвалж ба цаашид унших материал**



Бүлэг 8: Малын тоо толгойг бууруулах үйл ажиллагааны техникийн стандарт



Танилцуулга

Малын тоо толгойг бууруулах үйл ажиллагаа нь гангийн сөрөг нөлөөллийг бууруулах, мал сүргээс нэн хэрэгцээт ашиг шимийг бэлэн мөнгө, мах хэлбэрээр үнэ цэнийг нь авч үлдэхэд амьжиргаа нь мал аж ахуйгаас хамааралтай нутгийн иргэдэд чухал ач холбогдолтой.

Малын тоо толгойг бууруулах үйл ажиллагааг ган гэх мэт удаан явцтай гамшгийн үед мал түрж, эцэн үнэ цэнээ алдах, хорогдох, нийгмийн эрүүл мэндэд эрсдэл үүсэхээс өмнө хэрэгжүүлбэл хамгийн тохиромжтой ба гэнэтийн гамшгийн үед хэрэгжүүлэх боломж ерөнхийдөө бага юм.



Малыг тоо толгойг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхийн тулд бэлтгэл ажлыг сайн хангасан байх нь чухал. Эдгээр үйл ажиллагааны төлөвлөлтийн шатанд урьдчилсан бэлтгэл ажлын гурван чухал хувилбарыг онцолдог. Үүнд:

1. Удаан явцтай гамшгийн эрт хариу арга хэмжээний үед малыг хэт түрж эцэхээс өмнө зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагааг дэмжих нь нутгийн иргэд малаа худалдан авагчдад зах зээлийн ойролцоо үнээр борлуулах боломж олгоно.
2. Гангийн үед бэлэн байдлаа бүрэн хангаагүйн улмаас мал худалдан борлуулах үйл ажиллагааг оройтож хэрэгжүүлбэл эцэнхий туранхай малын зах зээлийн үнэ маш бага байх ба энэ тохиолдолд малын махыг зөвхөн нутгийн иргэдэд тараах нөхцөл үүсэж болзошгүй юм.
3. Үйл ажиллагааны хэрэгжилт хэт оройтвол мал сүргийг нядалж устгахад хүрэх магадлалтай (*Хайрцаг 8.1-г үзнэ үү*).

Энэ бүлэгт гамшгийн хариу арга хэмжээний хүрээн дэх малын тоо толгойг бууруулах үйл ажиллагааны талаарх мэдээлэл орсон. Мөн түүнчлэн малын тоог бууруулах үйл ажиллагааны техникийн хувилбарууд ба тэдгээрийн ашиг тус, бэрхшээлийн талаарх мэдээллээр хангана. Үүнээс гадна "FAO 2016, Бүлэг 4: Малын тоо толгойг бууруулах" -с мэдээлэл авах боломжтой. Техникийн үйл ажиллагааны хувилбар тус бүрт LEGS-н стандартууд, үндсэн үйл ажиллагаа ба зааварчилгааг тусгасан. Хяналт-үнэлгээний шалгах хуудас, түүнээс гадна хяналт-шинжилгээ ба үнэлгээний шалгуур үзүүлэлтийг энэхүү бүлгийн төгсгөл хэсэгт хавсаргалтаар оруулсан болно. Гүнзгийрүүлэн судлах материалын жагсаалтыг мөн хавсаргасан ба Жишээ судлалыг LEGS-н вэб хуудас дээр байрлуулсан. (<https://www.livestock-emergency.net/resources/case-studies-г> үзнэ үү).

LEGS-н амьжиргааны зорилтуудтой холбогдох нь

Малын тоо толгойг бууруулах үйл ажиллагаа нь нэрвэгдсэн нутгийн иргэдэд яаралтай тусламж үзүүлэх, үлдсэн мал сүргийг хамгаалах гэсэн LEGS-н амьжиргааны хоёр зорилттой нийцнэ.

Энэхүү үйл ажиллагаа нь гамшигт нэрвэгдсэн нутгийн иргэдэд дараах байдлаар тусалж чадна. Үүнд:

- байгаа мал хөрөнгөө ашиглан яаралтай ашиг тус хүртэх ба үүний хүрээнд эрсдэлд орох эсвэл зах зээлд борлуулалт багатай малаа худалдан борлуулж бэлэн мөнгө эсвэл хүнсээр хангагдах;
- үндсэн мал хөрөнгөө хамгаалах ба үүний хүрээнд үлдсэн мал сүргээ хорогдолгүй авч үлдэхийг зорьж малаа бэлэн мөнгө болгох нь ач холбогдолтой. Ингэснээр малчид малдаа тэжээл, ус, урьдчилан



сэргийлэх эм гэх мэт хэрэгцээт зүйлсийг худалдан авах эсвэл үлдсэн малаа гамшигт бага нэрвэгдсэн нутаг руу тээвэрлэх боломжтой болно.

Гамшгийн хариу арга хэмжээний хүрээнд малын тоог бууруулах үйл ажиллагааны ач холбогдол

Ган гачгийн үед мал эцэж турах, үхэж хорогдох эрсдэлтэй ба энэ үед малын тоо толгойг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлбэл маш их ач холбогдол бүхий үнэ цэнэтэй хариу арга хэмжээ болно. Өөрөөр хэлбэл энэ нь хорогдох эрсдэлтэй мал сүргээ бэлэн мөнгө эсвэл мах болгох арга хэмжээ юм. Малчид гамшгийн улмаас алдаж болзошгүй мал сүргийнхээ тоо толгойг бууруулах арга хэмжээ авах дургүй байх магадлалтай тул онцгой байдлын өмнө нөлөөллийн ажил хийх шаардлагатай болно. Малын тоог бууруулах үйл ажиллагааг малчдын болзошгүй эрсдэлийг даван туулах чадавхыг бэхжүүлэх арга гэж үздэг. Үүнд, мал сүргийн тоог цөөрүүлэх нь мал амьтны тэжээл, бэлчээр, усан хангамжийн ачааллыг бууруулж үлдсэн мал сүрэгт ашиглах нөөцийг нэмэгдүүлж өгдөг (LEGS-н Зарчмууд 3-г үзнэ үү: *Уур амьсгалын өөрчлөлт ба хүрээлэн байгаа орчин*). Түүнчлэн нядалсан малын махыг гамшгийн хүнд, хатуу нөхцөлд эрсдэлд өртсөн гэр бүлд тараах нь тэдэнд хэрэгцээ шаардлагатай уургийн агууламж бүхий нэмэгдэл хоол хүнс болж чаддаг.

Малын тоог бууруулах үйл ажиллагаа нь LEGS-н *Бүлэг 1-ын Танилцуулга* хэсэгт тодорхойлсон мал амьтны тавлаг байдлын таван эрх чөлөөний хамгийн багадаа хоёр буюу “өвчин эмгэггүй” ба “айдсаас ангид байх” нөхцлүүдийг хангахад хувь нэмэр оруулдаг. Малыг худалдан борлуулж зарах тохиолдол нь тэдэнд илүү таатай газар нутагт шилжиж, өөрийн хэвийн араншингаа гаргах боломжийг бий болгоно. Шаардлагатай тохиолдолд малыг нядалж хэрэгцээлснээр тэднийг өлсөх, цангахаас үүдсэн өвдөлт, дарамтаас чөлөөлнө. Малтай харьцах, тээвэрлэх, нядалгаа хийх зэрэг нь малын тоог бууруулах үйл ажиллагаанд хамаарах ба энэ үед өвтгөх, айдас, дарамтаас ангид байлгахыг анхаарах нь чухал юм.

Газар хөдлөлт, үер гэх мэт гэнэтийн гамшгийн үед мал сүрэг хорогдсон, амьд үлдсэн аль ч тохиолдолд малын тоог бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь ихэнхдээ тохиромжгүй байдаг. Гэвч, хүчтэй салхи шуурга эсвэл гал түймэр зэрэг байгалийн гамшгийн улмаас малын тэжээл хангамж устсан, мал амьтан нүүн шилжсэн үед тохирох хариу арга хэмжээг авна. Мал амьтан нь нийгмийн эрүүл мэндэд эрсдэл учруулах эрсдэлтэй тохиолдолд тэдгээрийг нядалж устгах хэрэгтэй. *Хайрцаг 8.1-г* үзнэ үү.



Малын тоо толгойг бууруулах үйл ажиллагааны хувилбарууд

Малын тоог бууруулах үйл ажиллагааны хамгийн түгээмэл хоёр хувилбар нь малыг зах зээлд худалдан борлуулах, махны хэрэгцээнд нядалж борлуулах юм.

Хувилбар 1: Малыг зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагаа

Зах зээл дээр малын үнэ унаж эхлэх үед малын захын үйл ажиллагаа эрхлэгчдийн (мал борлуулагч, бордооны цэгийн эзэд, махны худалдаачид гэх мэт) үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжийг дэмжих зорилгоор малыг зах зээлд худалдан борлуулахад нь гадны байгууллагууд дэмжлэг үзүүлдэг. Малыг зах зээлд ийм үнийн уналт нь эрэлт буурах, хэтэрхий олон тооны мал зах зээлд нийлүүлэгдэх, малын тарга хүч муу байх, мал борлуулагдахгүй, малчид малаа зарахыг хүсэхгүй байх зэрэг нөхцөл байдлаас шалтгаалдаг. Энэ нөхцөл байдлын үр дүнд малын зах зээлийн үнэ унах, малын зах зээлийн худалдаа эрхлэгчид бизнесээ орхиход хүрдэг.

Малыг зах зээлд худалдан борлуулахад туслах нь эдгээр хүндрэлтэй нөхцөлд малын худалдааны зах зээлийг хэвийн үргэлжлүүлэхэд тусалдаг. Мөн ингэснээр ган гачигт нэрвэгдсэн малын үнэ цэнэ нь хэт унаж, борлуулах боломжгүй болохоос өмнө зах зээлд гаргахад тусална.

Малыг зах зээлд худалдан борлуулснаар дараах ашиг тусыг олно. Үүнд:

- Гамшигт нэрвэгдсэн нутгийн иргэд бэлэн мөнгөтэй болно.
- Малчид, малын худалдаа эрхлэгчдийн дунд урт хугацааны харилцаа холбоо үүсэхийг дэмждэг.
- Энэхүү үйл ажиллагаа нь ихэнх малчид болон малд ерөнхийдөө эерэгээр нөлөөлдөг.
- Гангийн үед малын худалдан авалтанд хүмүүнлэгийн байгууллагууд шууд оролцдоггүй ба энэ тохиолдолд малыг зах зээлд худалдан борлуулах нь хамгийн зардал багатай үйл ажиллагааны нэг хэлбэр юм.

Малыг зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мал худалдаалах чиглэлийн идэвхтэй хувийн хэвшлийн тогтолцоо, дотоод болон гадаад зах зээлийн эрэлт хэрэгцээ их байх нь амжилттай хэрэгжихэд түлхэц болдог. Малыг худалдаа эрхлэгчид малыг шууд нядалгаанд оруулдаггүй хаа нэг газар тарга хүч автал маллаж байгаад нядлах эсвэл цааш дамжуулан худалдах нь элбэг байдаг.

Байгууллагуудын малын худалдаа эрхлэгчдэд үзүүлэх нийтлэг тусламжид



мал зарах малчид болон худалдаачдыг нэг дор уулзуулах, богино хугацааны зээлийг дэмжих, нөхөн олговор, татвар, хураамжийн чөлөөлөлтөд зуучлах зэргийг хамруулна. Мал амьтны худалдаа эрхлэгчидтэй малчдыг уулзуулах нь хамгийн энгийн бөгөөд үр ашигтай үйл ажиллагаа юм. Байгууллагуудын үзүүлж буй тусламж нь хэвийн явагдаж байгаа зах зээлийг тасалдуулахгүй, тогтвортой байдлыг хангахад тулгарч байгаа бэрхшээлийг даван туулах, арилгахад чиглэсэн байх хэрэгтэй.

Гамшгийн үед зарим тусламжийн байгууллагууд малын худалдаачидтай ажиллахаас илүүтэй малыг шууд худалдан авах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Гэхдээ шууд худалдан авалт нь зах зээлийн урт хугацааны тогтвортой байдлыг алдагдуулахгүй байхад анхаарах нь чухал ба үүнд болгоомжтой хандах хэрэгтэй. Хэрэв худалдаачид малын зах дээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бол тусламжийн үйл ажиллагаа хийхгүй байхыг зөвлөдөг.

Хувилбар 2: Малыг махны хэрэгцээнд зориулан нядалж борлуулах үйл ажиллагаа

Энэ нь хувийн худалдаачдаас илүүтэй байгууллагууд малыг маханд зориулан нядалж худалдан авахыг санаачилдгаараа малыг зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагаанаас ялгаатай. Энэ хувилбар нь орон нутгийн малын зах зээл уналтад орж, мал зарагдахгүй, малын худалдаа эрхлэгчид бизнесээ орхин явсан үед хэрэгжүүлэх зохимжтой арга хэмжээ юм.

Малын тарга хүч бүүрсан үед зах зээлийн үнэ ихэнхдээ унасан байдаг ба энэ тохиолдолд тусламжийн байгууллагууд малыг худалдан авч нядлах ажлыг зохион байгуулна. Үүний дараа гамшигт нэрвэгдсэн нутгийн иргэдэд шинэ махыг тараадаг. Шинэ мах хурдан мүүддэг учраас шууд тарааж чадахааргүй бол давслах, чанах, хатаах зэргээр нэн даруй хадгалах арга хэмжээ авах шаардлагатай.

Малыг махны зориулалтаар нядалж худалдан борлуулах үйл ажиллагаа нь малыг шууд зах зээлд худалдахаас илүү зардал ихтэй хувилбар бөгөөд зардлыг мах түгээлтийн нэмэгдэл ашиг, арьс, шир боловсруулах ажлын байр зэргээс хэсэгчлэн нөхдөг. Хэрэв байгууллагууд нь худалдан авсан малыг зорилтот бүлгүүдэд шууд хуваарилж, нядалгаа, мах түгээх үйл явцыг өөрсдөөр нь хариуцуулбал үйл ажиллагааны зардлыг бууруулж чадна. Мөн түүнчлэн мал нядалгаа, махны боловсруулалтыг сайжруулснаар малын тавлаг байдлыг хангаж, нийгмийн эрүүл мэндэд ч ашиг тустай байх болно. Зарим улсын хувьд үхрийг нядлахтай холбоотой шашин, соёлын асуудлууд байдаг ба үүнийг тооцох хэрэгтэй.



Малыг махны зориулалтаар нядалж борлуулах үйл ажиллагааны оролцогчид нь:

- Нөөц, боломж муутай нутгийн иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд зэрэг нядалгааны зориулалтаар малаа худалдан борлуулах үйл ажиллагаанд сонгогдсон иргэд;
- Хүнсний махыг тусламжаар тараах үйл ажиллагаанд сонгогдсон олон ам бүлтэй өрх, ганц бие эцэг эхчүүд, өнчин болон тэжээгчээ алдсан өрх, өндөр настан ба бусад эмзэг бүлгийнхэн; хэрвээ тухайн тохиолдолд хангалттай хэмжээний мах байгаа бол маргаан үүсэхээс сэргийлж тухайн нутгийн иргэдэд жигд хуваарилан тарааж болно. Мөн ихэнх тохиолдолд хүмүүнлэгийн тусламжийн байгууллагууд махыг бусад хүнсний тусламжийн нэг хэсэг болгон эмнэлэг, сургууль, хорих байгууллагуудад өгдөг;
- Мал нядалгааны газар, мах бэлтгэх, боловсруулах газрын ажиллагсад нь эдгээр үйл ажиллагаанд ашиг олох, ирээдүйд хэрэгцээтэй чадвар эзэмших зорилгоор оролцож болно.

Малын тоог бууруулах үйл ажиллагааны хувилбаруудын ашиг тус, бэрхшээл, үндсэн шаардлага зэргийг *Хүснэгт 8.1*-д нэгтгэн харуулав.

Хайрцаг 8.1

Малыг нядалж устгах

Удаан үргэлжлэх, хүнд бэрх гангийн нөхцөлд мал амьтан эцэж турах ба өвилж хүний хүнсний хэрэгцээнд тэнцэхгүй болдог. Малыг нядалж устгах шийдвэрийг мал нядлахын өмнөх ба дараах үзлэг дээр үндэслэн мал эмнэлгийн мөн нийтийн эрүүл мэндийн эрх бүхий албан тушаалтнууд гаргана. Ийм тохиолдолд нядалгааг орон нутагт хэрэгжүүлж болохуйц малын тавлаг байдлын стандартад нийцүүлэн нийтийн эрүүл мэндэд хамгийн бага эрсдэлтэй байхаар хийх ёстой. Хар салхи, үер, газар хөдлөлт зэрэг гэнэтийн гамшгийн үед эдгэрэхээргүй гэмтэл авсан мал амьтдыг (энхрий болон гэрийн тэжээвэр бусад амьтад) зовиургүйгээр үхүүлэх тохиромжтой аргыг сонгон авч хэрэгжүүлнэ.

Сэг зэм устгахад анхаарах асуудлуудыг Бүлэг 6: Мал эмнэлгийн тусламж, мөн FAO (2020) сэг зэмийн менежментийн гарын авлага, FAO (2001) гарын авлагад тусгасны зэрэгцээ малын тавлаг байдлыг хангаж малтай харьцах, зөөх тээвэрлэх, нядлах зааварчилгаагаар хангасан.



Хүснэгт 8.1: Малын тоог бууруулах үйл ажиллагааны хувилбаруудын ашиг тус, сорилт ба үндсэн шаардлагууд

Ашиг тус	Сорилт Бэрхшээл	Үндсэн шаардлага
1. Малыг зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагаа		
Нэн яаралтай хэрэгцээгээ хангах эсвэл мал сүрэгтээ дахин хөрөнгө оруулалт хийх бэлэн мөнгөтэй болно. Гамшгийн эрсдэлийг даван туулах уламжлалт стратегийг бий болгоно. Хүрэлцээгүй бэлчээр, тэжээл, усан хангамжаас үүдсэн дарамтаас ангижирна. Олон тооны мал амьтныг хамруулах боломжтой арга хэмжээ юм. Харьцангуй бага зардалтай (ихэнх зардал мал худалдан авагчаас гардаг) Худалдан авагч ба борлуулагчдын хооронд урт хугацааны харилцаа холбоо бий болохыг дэмжинэ.	Мал сүрэг тарга хүчээ алдахаас өмнө зарж борлуулах хэрэгтэй Малын худалдаачид тарган ашиг шимтэй малыг илүүд үзэх учраас эцэнхий туранхай малтай эрсдэлт бүлгийн малчдыг чухалчилж үзэхгүй байж болзошгүй Тохиромжгүй маллагаа арчилгаа, тээвэрлэлтийн улмаас малын тавлаг байдлыг алдагдуулах эрсдэл үүсэж магадгүй	Мал худалдан авах хүсэлтэй худалдан авагчид Малаа зарахыг хүссэн малчид Малыг худалдан борлуулах боломжтой дотоодын болон экспортын зах зээл Дэд бүтэц: зам, мал байр, ус, тэжээлийн эх үүсвэр, ойрын тээвэр тууврын зам, аюулгүй байдал Байгууллагууд малын худалдаа, зах зээлд зуучлах зэрэгт уян хатан хандлагатай байх Байгууллагууд нь хувийн хэвшлийг мал борлуулах үйл ажиллагаанд татан оролцуулахыг эрмэлзэх
2. Малыг махны хэрэгцээнд зориулж нядалж борлуулах үйл ажиллагаа		
Нэн яаралтай хэрэгцээгээ хангах эсвэл мал сүрэгтээ дахин хөрөнгө оруулалт хийх бэлэн мөнгөтэй болно. Хүрэлцээгүй бэлчээр, тэжээл, усан хангамжаас үүдсэн дарамтаас ангижирна.	Зорилтот бүлгийн иргэд мал нядлах, мах түгээх ажилд шууд оролцуулаагүй тохиолдолд үйл ажиллагааны хэрэгжилт илүү төвөгтэй болох магадлалтай. Тухайн орон нутгийн иргэдийг оролцуулахгүй байх нь захиргааны зардлыг нэмэгдүүлдэг.	Орон нутгийн байгууллагууд малыг худалдан борлуулахыг удирдан, зохион байгуулах замаар зорилтот бүлгийн нутгийн иргэдэд туслах Байгууллагууд үйл ажиллагаа хэрэгжүүлэх бүс нутаг, үнийн стратеги, хэрэглэх арга хэлбэр зэргээ хоорондоо уялдуулан зохицуулах



Ашиг тус	Сорилт Бэрхшээл	Үндсэн шаардлага
Нэмэлт хүнсний тусламжийг хүргэнэ. Илүүдэл нойтон махыг нөөшлөн хадгалах боломжтой болдог. Орон нутгийн иргэд ажлын байраар хангагдах боломж бүрддэг.	Мал худалдан авсныг оруулахаар зардал ихтэй болдог Урт хугацаандаа тогтвортой байдал нь бага Олон тооны малыг хамарч байгаа тохиолдолд уян хатан бус Гангийн үед ус зэрэг үндсэн хэрэгцээт зүйл ховор байх магадлалтай	Хүнсний тусламжийн үйл ажиллагаанд хамрагдаж буй иргэд мах хүлээн авах хүсэлтэй байх Хэрэгжүүлэгч байгууллага нь хөтөлбөрийг амжилттай удирдах бүтэц зохион байгуулалтын чадамжтай байх Мал нядалгааны дэд бүтэц аль хэдийн урьдчилан бүрдсэн, суурилагдсан эсвэл бусад боломжит барилга байгууламжтай байх Нийтийн эрүүл мэндийн бодлогыг дагах Мал нядалгаа ба мах түгээх үйл ажиллагааг тухайн нутгийн соёлын хэм хэмжээнд тохиромжтой байдлаар хэрэгжүүлэх. Малын тавлаг байдлыг хангах хүрээнд хүнлэг байдлаар нядлах боломж, нөхцөл байдлыг хангасан байх

Үйл ажиллагаанууд (тусламж)-ыг хэрэгжүүлэх цаг хугацаа

Гамшгийн өөр өөр үе шатаас шалтгаалан малын тоог бууруулах үйл ажиллагааны хувилбарыг тодорхойлдог ба үүнтэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх цаг хугацаа хязгаарлагдмал гэдгийг анхаарах хэрэгтэй. Удаан явцтай гамшгийн сэрэмжлүүлэг, түгшүүрийн үе шатанд малыг зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагаа хамгийн тохиромжтой, үр дүнтэй байдаг. (Бүлэг 1: LEGS-н танилцуулга гамшгийн үе шатууд сэдвийг үзнэ үү). Малыг зах зээлд борлуулах үйл ажиллагааны хүрээнд цагаа олсон тусламж



дэмжлэг үзүүлэхийн тулд бэлэн байдлыг хангах арга хэмжээнд боломжит малын худалдаачид, өртөг нэмэх бизнесүүд, мах боловсруулагчид, махны чиглэлийн малын томоохон аж ахуйн жагсаалтуудыг гаргах ажлыг оруулж болох юм (*LEGS-н Зарчим 4: Бэлэн байдал сэдвийг үзнэ үү*). Мал сүргийг махны хэрэгцээнд зориулан нядлан борлуулах үйл ажиллагааны хувьд энэ нь түгшүүрийн хожуу үе, онцгой байдал эсвэл эрт нөхөн сэргээлтийн үе шатанд байнга хэрэгжүүлдэг арга хэмжээ юм. Энэ цаг үед мал эцэж туран зарж борлуулах боломжгүй болсон байдаг. Малыг худалдан борлуулах үйл ажиллагааг гэнэтийн гамшгийн дараа жишээлбэл ой хээрийн түймрийн улмаас мал бэлчээргүй болсон үед хэрэгжүүлж болно. (*Хүснэгт 8.2-г үзнэ үү*). Малчид мал сүргээ санхүүгийн нөхцөлөөр үнэлэхийн зэрэгцээ тэд таагүй нөхцөлд мал сүргийнхээ амьд үлдэх боломж болон бусад олон хүчин зүйлийг харгалзан үздэг. Гангийн ид үед тэд мал амьтныг ямар үнээр ч хамаагүй борлуулахыг хүсэж байсан ч борооших анхны шинж илрэхэд тэдний санаа бодол өөрчлөгддөг. Иймээс байгууллагуудын хувьд энэ мэт өөрчлөгдөж болох нөхцөл байдлыг харгалзан уян хатан арга хэмжээ авахаас гадна өөр өөр хувилбарыг хэрэгжүүлэх боломжтой байх хэрэгтэй. Зах зээлийн шинжилгээний минимум стандарт (MISMA) нь инфляцийн өөрчлөлтөөс үүдсэн дарамт их байгаа гамшгийн нөхцөлд мал худалдан борлуулахад санал болгож буй үнийг баталгаажуулахад чухал байж болох юм.

Хүснэгт 8.2: Малын тоог бууруулах ажиллагааны боломжит цаг хугацаа

Хувилбарууд	Гэнэтийн гамшиг		
	Гэнэтийн хор хохёрл	Эрт үеийн нөхөн сэргээх	Нөхөн сэргээх
1. Малыг зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагаа	✓	—	—
2. Малыг махны хэрэгцээнд зориулан нядалж борлуулах үйл ажиллагаа	✓	—	—

Хувилбарууд	Удаан явцтай гамшиг			
	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээх
1. Малыг зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагаа	✓	✓	—	—
2. Малыг махны хэрэгцээнд зориулан нядалж борлуулах ажиллагаа	—	✓	✓	—



LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн түншлэлийн стандартууд (ХТС)-тай холбогдох нь

Малын тоог бууруулах үйл ажиллагааны тусламж нь үлдсэн мал ялангуяа үржлийн цөм сүргийн малаа аварч үлдэх боломжийг олгодог. Тиймээс байгууллагууд нь малын тоо толгойг бууруулах үйл ажиллагааг LEGS-н бусад үйл ажиллагаатай тухайлбал тэжээл, усаар хангах, мал эмнэлгийн тусламжтай (*Бүлэг 4, 5 ба 6-г үзнэ үү*) цогц байдлаар, уялдуулан хэрэгжүүлэх хэрэгтэй. LEGS-н *Бүлэг 3: Онцгой байдлын хариу хэмжээний төлөвлөлт* хэсэгт тодорхойлсон Оролцооны аргаар хариу арга хэмжээг тодорхойлох матриц (PRIM) нь уялдаа холбоог хангах үнэлгээг хийхэд чухал арга хэрэгсэл болно. Мал эмнэлгийн тусламжийн талаарх 5-р бүлэг нь сэг зэмийг устгахад баримтлах мэдээллийг агуулдаг.

Малыг зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагаа нь зах зээлийн зарчим, үйл явцыг сайтар ойлгохыг шаарддаг. Онцгой байдлын үеийн Зах зээлийг зураглах шинжилгээ (EMMA) арга хэрэгсэл ба Зах зээлийн үнэлгээний минимум стандарт (MISMA) зэрэг нь энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах стандарт, зааварчилгаагаар хангана. (*Бүлэг:1 LEGS-н танилцуулга хэсгийн Тусгай мэдээлэл хэсгийг харах*)

Гангийн дараа өрхийн амьжиргааг хэвийн хэмжээнд хүртэл сэргээхэд олон тооны мал сүрэг шаардлагатай ба үүнд олон жил шаардагдах тул бэлчээрийн мал аж ахуй, мөн фермерийн аж ахуй эрхлэгчдэд дан ганц малжуулах үйл ажиллагаа хангалттай биш байдаг. Иймээс хүнсний тусламж гэх мэт нэмэлт хүмүүнлэгийн тусламж шаардлагатай болох бөгөөд энэ ажилд Sphere хүмүүнлэгийн минимум стандартын гарын авлага тусална.

LEGS-н зарчмууд болон бусад анхаарах асуудлууд

Хүснэгт 8.3: Малын тоог бууруулах үйл ажиллагаанд хамаарах LEGS-н зарчмууд

LEGS-н зарчим	Зарчмууд нь малын тоог бууруулах үйл ажиллагаатай хэрхэн хамаарах жишээ
1. Амьжиргаанд суурилсан хөтөлбөрийг дэмжих	Малын тоог бууруулах үйл ажиллагаа нь үлдсэн мал сүргээ ялангуяа үржлийн цөм сүргээ хамгаалан үлдэх боломжийг сайжруулна. Малын тоог бууруулах үйл ажиллагааг LEGS-н бусад үйл ажиллагаатай (тэжээл, усаар хангах, мал эмнэлгийн тусламж) уялдуулан хэрэгжүүлсэн тохиолдолд малаас хамааралтай амьжиргааг дэмжихэд илүү тусална.



2. Олон нийтийн оролцоог хангах	Нутгийн иргэдийн оролцоог баталгаажуулах нь малын тоог бууруулах үйл ажиллагаанд оролцогчдыг шударгаар сонгоход чухал ач холбогдолтой. Хэлэлцэж тохирсон шалгуур үзүүлэлт, одоогийн эрсдэл, чадамжийн үнэлгээ зэрэгт тулгуурлан сонголтыг хийх хэрэгтэй. Хувийн худалдаачид нь ашиг орлогоо нэмэгдүүлэхийг зорьж, хангалттай тоног төхөөрөмж, малын байргүй, аюулгүй байдал нь хангагдаагүй, хүртээмж муутай нутгийн иргэдийг үйл ажиллагаанд оролцуулахгүй байж болзошгүй. Малын худалдаачдад үзүүлэх тусламж нь нутгийн иргэдийн идэвхтэй оролцоог баталгаажуулах нөхцөлтэй байвал эрсдэлд байгаа иргэд орхигдохгүй байх боломжтой. Гэвч худалдаачид дуртай малаа худалдаж авах эрхтэй байх ёстой. Мал нядлах, мах түгээх ажилд нутгийн иргэдийг шууд оролцуулах нь малын тоог бууруулах үйл ажиллагааны зардлыг бууруулахад тусална.
3. Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчныг хамгаалах хариу арга хэмжээ авах	Малын тоог бууруулах үйл ажиллагаа нь хүрээлэн байгаа орчинд эерэг мөн сөрөг нөлөө үзүүлдэг. Мал нядалгааны үед хог хаягдал (Бохирдсон гулууз мах гэх мэт) цуглардаг учраас орчны бохирдлоос сэргийлж хог хаягдлыг аюулгүй устгах хэрэгтэй. Арьс, ширийг давслах идээлэх ажил ч үүнтэй адил асуудал дагуулдаг. Ган гачгийн улмаас бэлчээрийн нөөцийн хомсдолтой үед олон тооны малыг устгах үйл ажиллагаа нь орон нутгийн байгалийн нөөцөд учрах дарамтыг бууруулдаг. Кэмп ба малын захын эргэн тойронд олон мал бөөгнөрөх нь хүрээлэн байгаа орчинд богино хугацаад шууд сөрөг нөлөө үүсгэж болзошгүй. Нутгийн уугуул үүлдэр аюулд өртөж байгаа тохиолдолд тухайн нутгийн биологийн төрөл зүйлийг алдахаас болгоомжлох хэрэгтэй.
4. Бэлэн байдал ба эрт үеийн хариу арга хэмжээнд туслах	Гамшиг, хямралын үед малын тоог бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа маш хязгаарлагдмал тул бэлэн байдал маш чухал. Энэ үед малын наймаачид, махны худалдаачид, өртөг нэмсэн үйлчилгээ үзүүлэгч нарын урьдчилсан жагсаалт гаргах нь сэрэмжлүүлэг ба түгшүүрийн үе шатанд малын тоог бууруулах ажлыг эхлүүлэхэд тусална. Гангийн үед мал хэт турахаас өмнө эрт арга хэмжээ авч мал борлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь нутгийн иргэд гадны худалдан авагчдад малаа зах зээлийн үнээр борлуулах боломжийг олгодог. Үйл ажиллагааг оройтож хэрэгжүүлэх нь мал эцэж турсны улмаас бага үнээр мах тараалтад өгөхөд хүргэдэг. Мөн хэт оройтсон үйл ажиллагаа нь малыг нядалж нөөцийн маханд хамгийн доод үнээр өгөхөд хүргэдэг.



5. Хариу арга хэмжээний уялдаа холбоог баталгаажуулах	Гол оролцогч талууд ба нэрвэгдсэн нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулсан зохицуулалтын бүлгийг байгуулах нь малын тоог бууруулах үйл ажиллагааг зохих ёсоор чиглүүлж, удирдахад тусална. Малыг маханд нядалж борлуулах ажиллагааны оролцогч талуудын хоорондын уялдаа холбоог зохицуулах нь маш чухал юм. Энэ нь худалдан авалтын үнэ, хэрэгжүүлэх арга замыг тохиролцож, өрсөлдөөн, үл ойлголцлоос зайлсхийх боломжийг олгодог.
6. Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрийг дэмжих	Малын тоог бууруулах үйл ажиллагааны хувилбаруудыг сонгох, үр шим хүртэх хүмүүсийг сонгоход жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр төлөвлөлт чухал шаардлагатай. Мал нядалгаа нь эрэгтэй ба эмэгтэй хүмүүст ажлын байр буй болгох хувилбар байж болох ба энэ нь тухайн орон нутгийн соёлын хэм хэмжээнээс хамаарна. Мах түгээх, мах хатаах үйл ажиллагаа нь мөн ажлын байр бий болгоно. Бод мал (үхэр, тэмээ, сарлаг) худалдан борлуулсан бэлэн мөнгө нь эрэгтэйчүүдийн захиран зарцуулах эрхийг нэмэгдүүлэх магадлалтай. Үүний зэрэгцээ эмэгтэйчүүд зөвхөн бог мал (хонь, ямаа) болон гэрийн тэжээвэр шувуудыг борлуулсан орлогыг илүү захиран зарцуулах эрхтэй байж болно. Эмэгтэй эрэгтэйчүүдийн аль аль нь ашиг хүртэгч байхын тулд борлуулах малыг сонгохдоо тэнцвэртэй үнэлэх хэрэгтэй. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийг энэ үйл ажиллагаанаас орхигдуулахгүй байх тал дээр онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.
7. Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих	Малчид, орон нутаг ихэвчлэн нь онцгой байдлыг даван туулах өөрийн стратегитай байдаг. Нутгийн иргэдийн эдгээр стратегид тулгуурлан малын тоог бууруулах үйл ажиллагааг иргэдийн удирдлага зохицуулалтаар хангах (жишээлбэл, зорилтот бүлгийг тодорхойлох, үнэ, хуваарилалтыг бүхэлд хянах орон нутгийн зохицуулах бүлгүүд) нь үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлнэ. Малын тоог бууруулах үйл ажиллагаа нь сонгох шалгуур, мал нядалгаа, мах түгээхтэй холбоотой соёлын хэв хэмжээ, зан заншил, цээрийг дагаж мөрддөг. Малын тоог бууруулах үйл ажиллагаа нь гамшгийн үед малаа зарж борлуулах замаар орон нутгийн эдийн засгийг дэмжиж, нутгийн иргэд хүнс болон бусад хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг худалдан авах боломжийг олгодог ба мөн нутгийн иргэдийг ажлын байраар хангадаг.




	Гадны малын худалдаачидтай холбогдох үед орон нутгийн иргэд, мөн зах зээлийн оролцогчдод тусламжийн байгууллагуудаас нэмэлт дэмжлэг хэрэгтэй болж магадгүй.
8. Хяналт, Үнэлгээ, Хариуцлага, Суралцах (ХҮХС)	Малын зах зээл, чиг хандлагыг ойлгох нь малын тоог бууруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Малыг зах зээлд худалдан борлуулах, махны хэрэгцээнд зориулан нядалж борлуулах хувилбарын аль аль нь орон нутгийн зах зээлд нөлөө үзүүлдэг. Малын үнийг хянах нь энэхүү үр нөлөөг ойлгоход туслах ба эрсдэлт бүлэгт сөрөг нөлөө үзүүлэхгүй байхыг баталгаажуулна.

Малын тоо толгойг бууруулах үйл ажиллагааны шийдвэрийн мод

Шийдвэрийн мод нь (*Бүдүүвч 8.1*) онцгой байдлын үед малын тоог бууруулах үйл ажиллагааны хамгийн боломжтой, зохистой хувилбарыг сонгоход анхаарах гол гол асуултуудыг нэгтгэн харуулдаг. Стандартууд, үндсэн үйл ажиллагаа, зааварчилгаа нь зохих мэдээллээр хангаж илүү нарийвчилсан төлөвлөлт хийхэд тусалдаг. Хэрэв боломжтой бол эдгээрийг онцгой байдал эхлэхээс өмнөх хэвийн үед боловсруулсан бэлэн байдлын үйл ажиллагаанд суурилан хийх нь илүү ач холбогдолтой.



Бүдүүвч 8.1: Малын тоог бууруулах үйл ажиллагааны хувилбаруудын шийдвэрийн мод



*Үйлдэл хийхгүй" гэсэн үр дүн нь арга хэмжээ авах шаардлагагүй гэсэн үг биш, харин гол асуултуудад "тийм" гэж хариулахын тулд нэмэлт сургалт эсвэл чадавхыг бэхжүүлэх шаардлагатай.

Үйлдэл хийхгүй* (үгүй гэж хариулсан асуултыг шийдэх боломжгүй бол)



Стандартууд

Малын тоог бууруулах үйл ажиллагаа нь мал аж ахуй эрхлэгчдэд үнэ цэнэ багатай эсвэл огт үнэд хүрэхгүй байх мал амьтдаасаа тодорхой хэмжээний үнэ цэнийг хөндлөнгийн оролцоогүйгээр олж авах боломжийг олгодог. Малыг зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагаа нь мал тарга хүчээ алдах, зах зээлийн үнэ унахаас өмнө илүү боломжтой байдаг. Харин үүнээс хойш малыг махны хэрэгцээнд зориулан нядалж борлуулах үйл ажиллагааны хувилбар тохиромжтой байж болох юм. Нэрвэгдсэн нутгийн иргэдийн оролцоотойгоор бэлэн байдал болон нөхцөл байдалд эрт үеийн дүн шинжилгээ хийх нь малын тоог бууруулах үйл ажиллагаа нь хэрэгжих боломжтой, тохиромжтой хариу арга хэмжээ мөн эсэхийг шийдэхэд нэн чухал. Малын тоог бууруулах үйл ажиллагааны үнэлгээний шалгах хуудсыг *Хавсралт 8.1-т* үзүүлэв.

Стандарт 1: Бэлэн байдал

Малын тоо толгойг бууруулах үйл ажиллагааны оновчтой цаг хугацааг тодорхойлж, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Үндсэн үйл ажиллагаа

- Эрт сэрэмжлүүлгийн мэдээлэлд хяналт дүн шинжилгээ хийх (*Зааварчилгаа 1-г үзнэ үү*).
- Зах зээлийн үйл явцыг ойлгох ба малын зах зээлийг сайтар хянах (*Зааварчилгаа 2-г үзнэ үү*).
- Малын тарга хүч ба тавлаг байдлыг байнга хянаж байх (*Зааварчилгаа 3-г үзнэ үү*).
- Гол оролцогч талуудтай хамтран малын тоог бууруулах үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хэрэгжүүлэх (*Зааварчилгаа 4-г үзнэ үү*).
- Малыг эрт борлуулахыг дэмжих (*Зааварчилгаа 5-г үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Эрт сэрэмжлүүлэг

Ганд нэрвэгдсэн ихэнх бүс нутагт гангын эрт сэрэмжлүүлгийн зарим шинж тэмдэг нь байгууллагуудад малын тоог бууруулах үйл ажиллагааг төлөвлөхийг анхааруулж байдаг.

2. Малын зах зээлд хяналт тавих

Эрэлт нэмэгдэх эсвэл малын үнэ буурахаас үл шалтгаалан борлуулах малын тоо нэмэгдэж байвал энэ нь “онцгой байдлын үеийн борлуулалт” эхэлснийг харуулна. Энэ нь малчид хэвийн, тайван үеийн зах зээлд малаа борлуулж малын үнэ цэнээ авч үлдэхийг хичээж байгаа явдал юм.



3. Малын тарга хүчинд хяналт тавих

Малын тарга хүч буурах нь хямрал нүүрлэж байгаагийн шинж тэмдэг байж болно. Нутгийн иргэдийн оролцоотой, орон нутгийн даван туулах мэдлэгт үндэслэсэн төлөвлөлт болон эрт сэрэмжлүүлгийн мэдээлэлд хийсэн хяналтын мэдээлэл нь тухайн жилийн малын тарга хүч ердийнхөөс муу байгаа эсэхийг тодорхойлоход тусална.

4. Бэлэн байдлыг хангах үйл ажиллагаа

Малыг зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагааг цаг алдалгүй эрт эхлүүлэхийн тулд бэлэн байдлын үйл ажиллагааны хүрээнд малын худалдаа эрхлэгчид, өртөг нэмэн борлуулагчид, мах боловсруулагчид, мал аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг урьдчилан гаргах нь чухал. Онцгой байдлын өмнө малыг зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагааны талаар ухуулга сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хийх шаардлагатай байж болно. Учир нь малчид гамшигт алдаж магадгүй мал сүргээ борлуулах эсэхдээ эргэлзэх магадлалтай байдаг.

5. Цаг хугацаа ба эрт үеийн үйл ажиллагаа

Малын тоог бууруулах үйл ажиллагааны хувилбарууд нь онцгой байдлын үе шатуудтай холбоотой байдаг (Хүснэгт 8.2-г үзнэ үү). Малын зах зээл боломжийн байх үед нутгийн иргэдийг малаа сайтар борлуулахыг урамшуулах нь тэдний амьжиргаанд хамгийн их тус дэм болно. Малын зах зээлийг эрт, үр дүнтэй дэмжихийн тулд санхүүжилтийн эх үүсвэрийг “хямралыг намжаагч” байдлаар урьдчилан тодорхойлох шаардлагатай болно.

Стандарт 2: Үнэлгээ ба төлөвлөлт

Тоо толгойг бууруулах үйл ажиллагаанд сонгогдсон малын төрөл нь зах зээлийн нөхцөл ба малын байдалд тохирсон байх хэрэгтэй.

Үндсэн үйл ажиллагаа

- Малыг зах зээлд худалдан бууруулах үйл ажиллагааг худалдаачид мал худалдан авах хүсэлтэй, мал боломжийн тарга хүчтэй байх үед хэрэгжүүлэх тохиромжтой байдлыг тооцоолох (*Зааварчилгаа 1-г үзнэ үү*).
- Орон нутгийн нөхцөл байдал, мэдлэг, туршлагаас хамааран худалдан борлуулах малд зохимжтой зүйл, нас, төрлийг хамруулахыг баталгаажуулсан байх (*Зааварчилгаа 2-г үзнэ үү*).
- Эрсдэлт өрхүүдийг сонгохын тулд зарим нутагт малыг тоог бууруулах уламжлалт аргыг одоо хүртэл хэрэглэж байгаа эсэхийг үнэлэх (*Зааварчилгаа 3-г үзнэ үү*).
- Онцгой байдлын үеийн хөгжлийн бодлого болон нийгмийн нөхцөл байдалд үнэлгээ хийх (*Зааварчилгаа 4-г үзнэ үү*).



- Төлөвлөлт ба үнэлгээний үйл ажиллагаанд нэрвэгдсэн нутгийн иргэд бүрэн хамрагдаж байгаа эсэхийг баталгаажуулах (*Зааварчилгаа 5-г үзнэ үү*).
- Малчид, байгууллагын ажилтнууд, мөн малын аюулгүй байдлыг хангах үүднээс аюулгүй байдлыг үнэлэх (*Зааварчилгаа 6-г үзнэ үү*).
- Тусламжийн үйл ажиллагааг дуусгах, гарах стратегийг урьдчилан төлөвлөх (*Зааварчилгаа 7-г үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Малыг зах зээлд худалдан борлуулах эсвэл малыг махны хэрэгцээнд зориулан нядалж борлуулах үйл ажиллагаа

Малын зах зээлийн үнэ 25 хувь хүртэл унах эсвэл үр тариа болон мал амьтны үнийн харьцаанд 25 хувийн өсөлт гарах нь ихэвчлэн малын тоог бууруулах үйл ажиллагааг эхлүүлэхийг сануулдаг. Хэрэгжүүлэгч байгууллагууд малыг зах зээлд худалдан борлуулах ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодорхойлохын тулд малын тарга хүч, зах зээлийн сонирхлыг үнэлэх хэрэгтэй.

2. Малыг сонгох

Үхэр, тэмээ, сарлагийг сонгож тоо толгойг бууруулах нь хүрээлэн байгаа орчинд шууд томоохон нөлөө үзүүлэхээс гадна орон нутгийн эдийн засагт бэлэн мөнгөний урсгалыг нэмэгдүүлнэ. Гэвч эдгээр бод малыг сонгох нь эмэгтэйчүүд ба эрсдэлт бүлгийн асуудлыг орхигдуулж тэгш бус, хүйсийн тэнцвэртэй бус байдлыг үүсгэж болзошгүйг анхаарах хэрэгтэй. Хонь, ямааг илүү сонгосноор эрсдэлт бүлэг, эмэгтэйчүүд илүү ашиг хүртэх боломжтой байж болох юм. Ерөнхийдөө малчид ирээдүйд мал сүргээ нөхөн сэргээхийн тулд залуу үржлийн эм малаа малын тоог бууруулах үйл ажиллагаанд хамруулахгүй авч үлдэх хэрэгтэй. FAO (2016, Бүлэг 4-г үзнэ үү), Сэдэв: “Ямар мал амьтныг сонгож хамруулах вэ?” мөн LEGS-н Зарчим 1: Амьжиргааны хөтөлбөр хэрэгжүүлэх; Зарчим 6: Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр хэрэгжүүлэх нь

3. Малын тоог бууруулах уламжлалт практик

Зүүн Африкийн орнуудын зарим нутгийн иргэд (Габра, Боран ба Гари зэрэг), гамшгийн үед тосгоны боломжтой айл өрхүүдэд үхэр, тэмээгээ нядлах даалгавар өгч махыг ядуу өрхүүдэд тараах, мөн хатааж борцлох, нөөшлөх зэргээр цаг хүндэрсэн үед хэрэглэдэг. Мөн ясыг хадгалан дахин давтан чанах замаар чөмөгний тос гарган авдаг. Хэдийгээр энэ заншил янз бүрийн шалтгаанаар хэрэглэгдэх нь багассаар байгаа ч орон нутагт байгаа зарим өрхүүд эдгээр даван туулах стратегийг одоо хүртэл хэрэгжүүлсээр байх магадлалтай юм. Нутгийн иргэд санаачлан, удирдан хэрэгжүүлдэг гамшгийг даван туулах стратегийг дэмжин урамшуулахын тулд гамшгийн үед малаа нядалж хэрэгцээлэх уламжлалт аргыг хэрэгжүүлж байгаа тосгонуудыг үнэлж, тодорхойлох хэрэгтэй ба ийм ёс заншилтай бүс нутагт гадны байгууллагын оролцоо багасна.



4. Хөгжлийн ба нийгмийн нөхцөл байдал

Малын тоог бууруулах үйл ажиллагааны хүрээнд тодорхойлсон эрсдэл болон боломжийг баталгаажуулах үүднээс онцгой байдлын улмаас үүссэн нөхцөл байдлыг өргөн хүрээнд ойлгосон байх хэрэгтэй ба үүнд дараах зүйлсийг багтааж болно.

Хилийн худалдааны хориг, дотоодын малын отор нүүдэл, тээвэр, туувар, зөвшөөрөл ба татварын бодлого, улс бүрийн хууль тогтоомжид тусгагдсан махны хяналтын одоогийн зохицуулалт, зээл авах ба мөнгө шилжүүлэх, нийтийн эрүүл мэндийн болон мал эмнэлгийн дүрэм журам, дэд бүтэц

Бусад байгууллагуудаас үзүүлж байгаа тусламжийг уялдуулан зохицуулах шаардлагатай ба өөр хоорондоо давхцахгүй байх

Хэрэгжүүлэгч байгууллагын хувийн хэвшилтэй хамтран ажиллах, зээл олголт, мал болон орон нутгийн үйлчилгээг олж авах үйл явцыг зохицуулах бодлого журам

5. Нутгийн иргэдийн оролцоо

Нутгийн иргэдийн оролцоог хангасан зохион байгуулалтыг буй болгох хэрэгтэй. Энэ нь голдуу гол түншлэгч, нэрвэгдсэн хүмүүс (эмэгтэйчүүд, залуучууд, өндөр настан ба хязгаар нутгийн иргэдийг оруулаад), орон нутгийн эрх баригчдын төлөөлөл ба бусад хүмүүнлэгийн байгууллагын төлөөллийг оруулсан зохицуулах бүлэг байдаг.

6. Аюулгүй байдал

Малын тоог бууруулах үйл ажиллагаа нь одоо байгаа аюулгүй байдалтай холбоотой асуудлыг хэр хүндрүүлж болзошгүйг тооцох хэрэгтэй. Хүмүүнлэгийн байгууллага нь ажилчдаа болон гэрээлэгч нарын аюулгүй байдлыг баталгаажуулах, хамгаалах үүрэгтэй. Бэлэн мөнгө авч явахын оронд эрхийн бичиг, мобайл мөнгө шилжүүлэг эсвэл урьдчилсан төлбөрт карт хэрэглэх гэх мэт хувилбарыг төлөвлөсөн байх хэрэгтэй.

7. Гаргах стратегиуд

Малын тоог бууруулах үйл ажиллагаа нь урт хугацаанд сөрөг үр дагавар үүсгэхгүй байхын тулд үйл ажиллагааг хэзээ яаж дуусгах төлөвлөгөөтэй байх нь чухал. Нөхцөл байдлын гэнэтийн өөрчлөлтийг (зах зээлийн үнэ, малын тарга хүч, бороошиж эхлэх гэх мэт) зохицуулахын тулд уян хатан байх шаардлагатай ба эдгээр нөхцөл байдал нь малын зах зээлд оролцож байгаа малчдын малаа зарах, малын худалдаачдын худалдан авах хүсэл эрмэлзэлд нөлөөлдөг.

Стандарт 3: Малыг зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагаа

Зах зээлд борлуулж болохуйц малыг зарж борлуулахад туслах.



Үндсэн үйл ажиллагаа

- Нэрвэгдсэн нутгийн иргэдийг хамруулах (*Зааварчилгаа 1-г үзнэ үү*).
- Мах ба малын эрэлтийг үнэлэх, нийлүүлэлтийн сүлжээний сул талыг тодорхойлох (*Зааварчилгаа 2-г үзнэ үү*).
- Гол түншлэгчдийг тодорхойлох (*Зааварчилгаа 3-г үзнэ үү*).
- Үйл ажиллагаа явуулах газар нутгийг сонгох, борлуулах боломжит мал сүрэг, дэд бүтэц, аюулгүй байдлыг тооцоолох (*Зааварчилгаа 4-г үзнэ үү*).
- Мал худалдан авагчдын тодорхой ангиллыг мөн тэдний хэрэгцээг үнэлэх (*Зааварчилгаа 5-г үзнэ үү*).
- Мал худалдан авах шалгуур, үнэ тогтоох зааварчилгааг тохиролцон нийтэд мэдээлэх, (*Зааварчилгаа 6-г үзнэ үү*).
- Мөнгө шилжүүлгийн зардлыг үнэлэх (*Зааварчилгаа 7-г үзнэ үү*).
- Мал борлуулах үйл ажиллагаа амжилттай болоход нөлөөлөх амин чухал дэмжлэгийн төрлүүдийг тодорхойлох (*Зааварчилгаа 8 ба 9-г үзнэ үү*).
- Үйл явцад чухал шаардлагатай тусламж ба хяналтаар хангах (*Зааварчилгаа 10-г үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Зөвлөгөө ба зохицуулах бүлгүүд

Зохицуулах бүлгийн зорилго нь мал борлуулах ажиллагаанд бүхэлд нь хяналт үнэлгээ хийж, эрсдэлт бүлгийн иргэдийг орхигдуулахгүй байхыг анхаарна (*Стандарт 2, Зааварчилгаа 5-г үзнэ үү*).

2. Малын зах зээл ба нийлүүлэлтийн сүлжээг үнэлэх

Малын тоог бууруулах үйл ажиллагааны санаачлагын үр дүнд зах зээлд орж ирэх нэмэлт мал амьтныг шингээх эрэлт зах зээлд заавал байх ёстой. Энэ нь дотоодын болон экспортын эцсийн зах зээл эсвэл мал амьтныг худалдаж аваад хадгалах, эцэнхий мал амьтныг бордож тэжээх завсрын зах зээл хэлбэрээр байж болдог.

Мэдээллийг Хөдөө Аж Ахуй ба Худалдааны Яам эсвэл тэдгээрийн харьяа газар хэлтэс, Статистикийн хэлтсээс авах боломжтой. Үүнд үнийн мэдээлэл, зарагдах малын тоо, эрэлт, нийлүүлэлтийн хэв шинж, арилжаа хийгдэх газар байршил, худалдааны сүлжээ зэрэг мэдээлэл оруулж болно.

3. Түншлэл

Малыг зах зээлд амжилттай худалдан борлуулах үйл ажиллагаа нь хэрэгжүүлэх байгууллага болон хувийн худалдаачдын хоорондын түншлэлээс хамаарч байдаг. Таарч тохирох түншлэгчдийн жагсаалт гаргахад Худалдаачдын Холбоо тусалж болох юм. Үүрэг хүлээсэн түншлэгчдийн голлох бүлэг нь мал худалдан авах санаачлагыг удирдах сонирхол, мөн чадамжтай байх хэрэгтэй. (Үр нөлөөний жишээ судлалыг үзнэ үү: Этиопэд малыг зах зээлд худалдан борлуулсан нь).



4. Хэрэгжүүлэх бүс нутаг

Малыг зах зээлд худалдан борлуулах тохиромжтой бүс нутгийг үнэлгээнд үндэслэн сонгон авах хэрэгтэй дараах зүйлсийг хамруулна. Үүнд:

- хүмүүнлэгийн байгууллагын ажилтнууд, малчид, мал амьтны худалдаа эрхлэгчдийн аюулгүй байдалд нөлөөлж буй нөхцөл байдал;
- худалдан борлуулахаар хангалттай тооны мал нийлүүлэх;
- мал амьтны худалдаа эрхлэгчид мал худалдан авах сонирхолтой байх
- зам, мал амьтан худалдаалах түр зуурын зах, малын байр гэх мэт боломжийн дэд бүтэцтэй байх
- мал амьтны хөдөлгөөнийг хязгаарлах мал эмнэлгийн хорио цээрийн байдал.

5. Малын худалдаачдын ангилал

Ерөнхийдөө, малыг зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагааны хувьд өөр өөр сонирхолтой худалдан авагчид байдаг. Дотоодын зах зээлийн амьд малын худалдаачид, мал нядалгааны газар, мах боловсруулагчид нь өөр ашигтай зах зээл эсвэл мах боловсруулах үйлдвэрт ашиг нэмж зарахаар боломжийн тарга хүчтэй мал худалдан авахыг чухалчилдаг. Энэ бүлгийн худалдан авагчид малын тарга хүч нэлээд буурах хүртэл боломжийн үнэ санал болгодог.

Мах экспортлогч ба бордох үйл ажиллагаа эрхлэгчид (Ранчер) гангийн нөлөөгөөр эцэж турсан ч бие томтой малыг худалдан авахыг илүүд үздэг. Энэ нь тэд малыг аваад богино хугацаанд бордож боломжийн ашиг олдогтой холбоотой. Харин энэ бүлэг нь малын төлбөрийн шилжүүлгийг гангийн гамшгийн онцгой байдлын үе шатны туршид шилжүүлэхийг чухалчилдаг. Энэ зүй тогтлыг байгууллагууд худалдаачидтай түншлэх үедээ тооцон үзэх хэрэгтэй.

6. Мал сонгох, үнэ ханш тогтоох

Мал амьтны худалдан борлуулах үйл ажиллагааны зорилго нь хүндэрсэн нөхцөлд ажиллаж байгаа малын зах зээлийг дэмжих явдал юм. Хамгийн тохиромжтой нь энэ арга хэмжээ нь малчид, малын худалдаа эрхлэгчдийн хооронд шинээр харилцаа тогтоож, харилцаа холбоог хөгжүүлж байгаа явдал юм. Худалдан авах мал амьтны төрөл, зүйл нь ердийн зах зээлд тарга хүчтэй мал амьтныг борлуулдагтай ойролцоо буюу илүүдэл эр сувай мал голлосон байх хэрэгтэй. Мал амьтныг худалдан борлуулах хөтөлбөрийн дэмжлэгтэй зарагдаж байгаа малын үнэ ил тод, шударга байхын тулд урьдчилан зохицуулах бүлэгтэй тохиролцсон байх хэрэгтэй (Зааварчилгаа 1-г үзнэ үү).

7. Гүйлгээний зардал

Захын хураамж, мал амьтныг тууварлах зөвшөөрөл, нядалгааны газрын болон махны үзлэг шинжилгээний хураамж зардлыг ихэвчлэн мал худалдан авагч нар төлдөг. Иймд эдгээр зардал нь хэт өндөр байх нь алслагдсан зах



зээл, тарга тэвээр муутай малын худалдаа арилжааг хязгаарлаж магадгүй. Эдгээр төлбөр хураамж нь бэлэн мөнгөний орлого муутай орон нутгийн байгууллагуудад орлогын чухал эх үүсвэр болдог. Эдгээр төлбөрийг орон нутгийн байгууллагуудад шууд төлөхөд гадны туслалцааг ашиглах нь худалдааг түр хугацаагаар зогсоохоос илүү зохимжтой хэлбэр байж магадгүй.

8. Зохистой тусламж

Байгууллагуудын хувьд онцгой байдлын нөхцөлд байгаа малын зах зээлийн бэрхшээл, сул талыг ойлгох нь маш чухал. Ингэснээр тэд тохиромжтой тусламжийг тодорхойлж чадна. Орон нутгийн малын ердийн зах зээлийг гажуудуулахгүйн тулд байгууллагууд нь тулгамдаж байгаа бэрхшээлийг даван туулахад туслах наад захын тусламжийг үзүүлэх хэрэгтэй. Тухайлбал:

- малаа борлуулахаар сонирхож байгаа малчид ба худалдаачдыг нэг дор уулзуулах, малын түр зуурын зах байгуулах, малын байр, багаж төхөөрөмж зэргээр хангах, аюулгүй байдлыг хангах нэмэлт арга хэмжээ авах, тэжээл усаар хангах, арбитрийн үйлчилгээ буй болгох
- малын худалдан авагч нарт мал худалдан авахад нь зориулж зээлээр хангах, эсвэл зээл авахад зуучлах
- алслагдсан нутгаас мал тууварлах, тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, мал амьтны худалдаа эрхлэгчдэд бензин түлшний тэтгэлэг олгох нь орон нутгийн зах зээлд ирэхэд чухал хөшүүрэг болох талтай, мөн гамшигт нэрвэгдсэн нутагт тусламжийн бараа хүргэсэн ачааны хоосон машиныг мал тээвэрлэхэд ашиглах боломж байдаг.
- түр хугацаагаар бууруулсан буюу түдгэлзүүлсэн орон нутгийн татвар, хураамжаас олох орлогыг нутгийн захиргаанд нөхөн олгох.

9. Тусламжийн үйл ажиллагааны тасалдалгүй байдлыг хангах

Шаардлагатай тусламжийг тодорхойлсны дараа хэрэгжүүлэгч байгууллагад үйл ажиллагааны туршид ашиглах хэрэгцээт нөөц байгаа эсэхийг баталгаажуулах хэрэгтэй. Малын тарга хүч зах зээлд борлогдохгүй болтол буурах мэтийн өөрчлөгдөж байгаа нөхцөл байдалд хариу арга хэмжээ нь хангалттай уян хатан байх шаардлагатай.

10. Хяналт

Байгууллагууд нь үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөний үнэлгээний тоон ба чанарын мэдээллүүдийг хадгалах, сайн туршлагыг баримтжуулах нь чухал ач холбогдолтой байдаг. Малын тоог бууруулах үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг *Хавсралт 8.2: Малын тоог бууруулах ажиллагааны мониторинг ба үнэлгээний шалгуур үзүүлэлтийн жишээг харна уу.*



Стандарт 4: Малыг махны хэрэгцээнд зориулан нядалж борлуулах

Гамшигт өртсөн малын үнэ цэнээр нэрвэгдсэн нутгийн иргэдийг бэлэн мөнгө, мах, ажлын байраар хангана.

Үндсэн үйл ажиллагаа

- Нэрвэгдсэн нутгийн иргэдийг хамруулах (*Зааварчилгаа 1-г үзнэ үү*).
- Нутгийн иргэдийн оролцоотойгоор малыг махны хэрэгцээнд зориулан нядалж борлуулах үйл ажиллагааны мал худалдан авах газар, хугацаа зэргийг тодорхойлох ба зарлан мэдээлэх (*Зааварчилгаа 2-г үзнэ үү*).
- Малын төрөл зүйл, насны ялгаатай байдалд тохирсон худалдан авах үнэ, төлбөр хийх аргыг тохиролцох (*Зааварчилгаа 3, 4, 5-г үзнэ үү*).
- Арьс, ширийг боловсруулах боломжийг үнэлэх, тохиролцох (*Зааварчилгаа 6-г үзнэ үү*).
- Хамгийн их нэрвэгдсэн иргэдийг сонгох, буцалтгүй тусламжийн төрөл, оролцогчдыг сонгох шалгуурыг тохиролцох (*Зааварчилгаа 6, 7 ба 8-г үзнэ үү*).
- Махны хэрэгцээнд зориулан нядлах малыг сонгох шалгуурыг тохирох (*Зааварчилгаа 9-г үзнэ үү*).
- Шинэ ба хатаасан махыг тараах шалгуурыг тохирох (*Зааварчилгаа 10-г үзнэ үү*).
- Мал нядлах, мах бэлтгэх, мах нөөшлөн хадгалахдаа орон нутгийн зан заншил, уламжлалыг дагаж мөрдөх ба мал амьтны тавлаг байдлын стандартыг хангах (*Зааварчилгаа 11-г үзнэ үү*).
- Мал нядалгаатай холбоотой үүсэх нийтийн эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх, дүрэм журмыг дагаж мөрдөх (*Зааварчилгаа 12-г үзнэ үү*).
- Хүний хүнсний хэрэгцээнд таарахгүй гулууз махыг аюулгүй байдлыг хангаж устгах (*Зааварчилгаа 13-г үзнэ үү*).
- Малын тоог бууруулах үйл ажиллагаанд шаардагдах тохиромжтой тоног төхөөрөмж ба нөөцөөр хангах (*Зааварчилгаа 14-г үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Орон нутгийн оролцоо

Малыг махны зориулалтаар нядалж борлуулах ажиллагааны төлөвлөлт ба хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зохицуулах бүтцийг малын тоог бууруулах үйл ажиллагааг эхлэхээс өмнө сэргээх буюу шинээр байгуулсан байх хэрэгтэй. Доорх зүйлсийг нарийвчлан тодорхойлсон байх хэрэгтэй.

- нэрвэгдсэн хүмүүсийн өөр өөр бүлэгт тохирсон сонгох шалгуур үзүүлэлт
- Нядлахаар худалдан авах мал амьтныг сонгох шалгуур үзүүлэлт
- Малын түр зуурын захыг байгуулах газар, цаг хугацаа



- Бэлэн мөнгөний оронд эрхийн бичиг, мобайл мөнгө, урьдчилсан төлбөрт карт хэрэглэх
- Шаардлага хангасан мал нядалгааны газар
- Шинэ ба хатаасан махыг хэзээ тараах шалгуур үзүүлэлт

2. Мал худалдан авах газар ба хугацаа

Мал худалдан борлуулах түр зуурын зах нь нэгэнт тарга хүч муудсан малыг хэт хол тээвэрлэх, туухаас сэргийлж гамшигт нэрвэгдсэн нутагт аль болох ойр байх хэрэгтэй. Малыг зах зээл дээр борлуулах хугацааг урьдаас тогтоон сайтар зарлаж, мэдээлэл тараах нь чухал. Мөн байгууллагын ажилтнууд мал борлуулах захуудын хооронд сэлгэн ажиллахад хангалттай хугацаа олгох үүднээс захуудын ажиллах хуваарийг гаргах хэрэгтэй. Боломжит үндсэн дэд бүтэц (малын байр, агуулах, ус, тэжээл гэх мэт) ба үйлчилгээ (мал эмнэлгийн үзлэг хийх, хүмүүнлэгийн байгууллагын ажилчдад үйлчилгээ үзүүлэх)-ээр хангасан байна.

3. Худалдан авах үнэ

Гамшигт нэрвэгдсэн нутгийн иргэдтэй худалдан авах өөр өөр төрөл, зүйлийн малын үнийг тохиролцон зарлан мэдээлэх хэрэгтэй. Бусад хүмүүнлэгийн байгууллагуудтай ижил аргачлалаар малыг худалдан авч нядлах талаар зохицуулалт хийх нь өөр хоорондоо өрсөлдөхгүй байх, үл ойлголцол үүсэхээс сэргийлнэ. Хэрвээ боломжтой бол зах зээлийн бодит үнэ, хүмүүнлэгийн байгууллагын нядлахаар худалдаж авч байгаа малын үнийг хянаж (ямар байгууллага ямар үнэ төлж байна гэх мэт) тэдгээрийг хооронд нь нийцүүлж болно. Хүмүүнлэгийн байгууллагаас нядлахаар худалдан авч байгаа үнэ нь ердийн зах зээлийн үнээс дээгүүр байж болох ч ирээдүйд малаа зарах малчдад бага ашиг олох нөхцлийг үүсгэх талтай. Гэвч хүмүүнлэгийн байгууллагаас мал худалдан авах үнийг хэт өндөр тогтоох нь хэвийн үйл ажиллагаа нь алдагдсан орон нутгийн мал амьтны захыг улам тогтворгүй болгох талтай.

4. Мобайл мөнгө ба эрхийн бичиг

Байгууллага нь өндөр эрсдэлтэй бүсэд бэлэн мөнгө авч очихын оронд мобайл шилжүүлэг эсвэл эрхийн бичиг хэрэглэх талаар тооцон үзэх хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд мобайл технологи өргөн тархаж алслагдсан бүс нутаг руу мөнгийг аюулгүй, амар хялбар, хурдан шилжүүлэх боломж бүрдсэн. Бэлэн мөнгө авч явахын оронд хожим нь эргүүлэн авах боломжтой эрхийн бичиг эсвэл урьдчилсан төлбөрт картыг илүүд үздэг.

5. Худалдан авалт

Хүмүүнлэгийн байгууллагууд мал амьтныг өөрсдөө шууд худалдан авахаас гадна орон нутгийн булгүүд эсвэл хувь хүмүүстэй гэрээлэн гүйцэтгүүлж болдог. Хэрэв боломжтой бол гэрээ байгуулах нь илүү тохиромжтой, учир нь гэрээний дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд амар хялбар, зардал багатай, орон нутгийн байгууллагуудад дэмжлэг болдгоороо давуу талтай байдаг. Хүмүүнлэгийн байгууллагын гэрээлэгчид төлж буй үнэ, гэрээлэгч байгууллагын малчдад төлж буй малын үнэ ил тод ба харилцан тохиролцсон



байх ёстой (Үйл явцын жишээ судлалыг харна уу: Кени улсад нядалж борлуулахаар мал худалдан авах гэрээт худалдан авалт).

6. Тусламж хүлээн авагчдыг сонгох

Малыг махны хэрэгцээнд зориулан нядалж худалдан борлуулах үйл ажиллагаанд нэрвэгдсэн нутгийн иргэдийн янз бүрийн бүлгийг тусламж хүлээн авагчаар тодорхойлж, сонгох хэрэгтэй. Мөн нядалсан мал амьтны арьс, ширийг хэн эзэмшиж ашиглах талаар гэрээнд тусгах хэрэгтэй (Үйл явцын жишээ судлалыг үзнэ үү: Кени улсад малын тоог бууруулах үйл ажиллагааны эрхийн бичгийн тараалт ба мах түгээлт).

7. Мах түгээлт

Мах хүлээн авагч нь айл өрх, орон нутгийн байгууллагууд (сургууль, эмнэлэг, хорих газар) эсвэл түүнчлэн нүүлгэн шилжүүлэлтийн кэмп-д буй хүмүүс байж болно. Мах түгээх шалгуурт харгалзах хүнгүй эсвэл өнчин хүүхэд, өрх толгойлсон хүүхэд гэх мэт эрсдэлт бүлгийн хүмүүсийг оруулах хэрэгтэй. Мах түгээлтийг зохион байгуулах бүлэг, орон нутгийн лидер эсвэл одоо ажиллаж байгаа хүнсний нийлүүлэлтийн сүлжээтэй хамтран зохион байгуулж болох ба эдгээр нь өөр өөрийн сонгох шалгуур үзүүлэлт, түгээлтийн сүлжээтэй байдаг.

8. Биет бус хандив

Малыг махны хэрэгцээнд зориулан нядалж борлуулах үйл ажиллагаанаас үр шим хүртэж буй ихэнх иргэд энэхүү үйл ажиллагаанд ямар нэг байдлаар тодорхой хэмжээний хувь нэмэр оруулах хандлагатай байдаг. Иймээс хэрэгжүүлэгч байгууллагууд эдгээр хувь нэмрийн талаар хэлэлцэн тохиролцох хэрэгтэй ба үүнд аюулгүй байдлыг хангахад үүрэг хариуцлага хүлээх, хөдөлмөр, мөн материаллаг хувь нэмэр оруулах зэрэг орно.

9. Нядлах малыг сонгох

Малыг зах зээлд худалдан борлуулах ажиллагааны адилаар малыг махны хэрэгцээнд зориулан нядалж худалдан борлуулах үйл ажиллагаанд хөгшин, үржлийн бус (ихэвчлэн эр сувай мал сүрэг) малыг хамруулахыг анхаарч, үржлийн цөм сүргийг хамгаалах, улмаар амьжиргааг дэмжихийн тулд аль болох залуу үржлийн малыг үлдээх хэрэгтэй.

10. Шинэ, хатаасан мах

Ихэнх нутгийн иргэд шинэ мах хэрэглэхийг илүүд үздэг, учир нь шинэ мах хатаасан махнаас илүү өлсгөлөнг тайлдаг. Бас шинэ мах тараах нь хамгийн хялбар хувилбар байдаг. Шинэ мах нь хурдан мууддаг бүтээгдэхүүн учраас түгээх, тээвэрлэх, хадгалах боломжоос шалтгаалан нэг дор нядлах мал амьтны тоог хязгаарлах хэрэгтэй. Хатаасан мах нь мал амьтныг олноор нядлан, илүүдэл махаа дараа хэрэглэхээр боловсруулан нөөцөлж болдгоороо давуу талтай. Боловсруулж нөөшилсөн мах нь шинэ махтай харьцуулахад илүү өргөн хүрээтэй түгээх боломжтойн дээр хатаасан мах тараах нь зан заншил, уламжлалын хувьд хүлээн зөвшөөрөхүйц байдаг. Махыг хатааж боловсруулах нь шинэ ажлын байр бий болгох, үр чадвар хөгжүүлэх боломж нээж өгдөгөөрөө давуу талтай. Гэвч махыг аюулгүй



хатаахын тулд бэлтгэл ажлыг хангах, эрүүл ахуйн байгууламж, цэвэр ус, тохиромжтой агуулах сав хэрэгцээтэй болдог.

11. Мал нядлах аргууд

Малыг нядлах, мах бэлтгэх ажлыг орон нутгийн зан заншлын хэм хэмжээ, туршлагад тулгуурлахаас гадна мал амьтны тавлаг байдлын стандартыг хангах хэрэгтэй. Мал амьтныг нядлахад энэрэнгүй байдлаар хандах, аюулгүй байдлыг хангахад (олс дээс, дамар, цахилгаан бороохой (сэргээгч) буу, хутга, хөрөө, хувин сав гэх мэт) үндсэн тоног төхөөрөмж шаардлагатай ба мөн усаар хангагдсан энгийн нядалгааны хавтан, ялааны хамгаалалт, цус, хаягдал цуглуулах устгах цэг зэргийг бэлтгэсэн байх хэрэгтэй. Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд хангалттай ажиллах хүч шаардлагатай болдог бөгөөд хэрвээ шаардлагатай бол тэдэнд сургалт явуулж удирдлагаар хангах хэрэгтэй болдог.

12. Нийтийн эрүүл мэндийн эрсдэл

Боом, рифт хөндийн халуурал ба паразит хорхой (Echinococcus, бэтгийн уйланхай) зэрэг зарим зооноз өвчин хүнд ялангуяа өлсгөлөн ба хоол хүнсний дутагдлаас стресст орсон хүмүүст дамжин халдварладаг. Малыг махны хэрэгцээнд зориулан нядалж борлуулах үйл ажиллагааг санал болгохын өмнө хэрэгжүүлэгч байгууллагууд нийтийн эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ хийх хэрэгтэй. Нядалгаанд орох мал ба гулууз маханд нядалгааны өмнөх ба дараах үзлэгийг мэргэжлийн хүмүүсээр хийлгэсэн байх нь чухал. Ямар нэгэн мал, гулууз мах хүнсний хэрэгцээнд тэнцэхгүй бол аюулгүй байдлаар устгах хэрэгтэй (Зааварчилгаа 13-г үзнэ үү). Сэлгээт мал нядалгааны газар нь өвчин тархах эрсдэлийг бууруулахад тус нэмэр болдог. Мах нь амархан мууддаг бүтээгдэхүүн тул эрүүл ахуй, ариун цэврийн нөхцлийг сайтар хангах нь хоол хүнсээр дамжих өвчний эрсдэлийг бууруулах чухал ач холбогдолтой. Дүрвэгсдийн кэмпэд мал нядлах, мах эвдэж төхөөрөх үйл ажиллагааг маш болгоомжтой төлөвлөх хэрэгтэй ба өвчин тархахаас зайлсхийх, нийтийн эрүүл мэндийг баталгаажуулах үүднээс түр зуурын нядалгааны газар байгуулж ажиллуулах нь чухал.

13. Бохирдсон гулууз мах болон нядалгааны хаягдлыг устгах

Халдварлагдсан гулууз мах, хаягдал бохир ус, нядалсан малын цацга баас зэргийг аюулгүй байдлаар устгах хэрэгтэй. Булж устгах (голдуу хлорын шохойтой), шатаах, сэг зэмийг хорио цээрийн дэглэмд оруулах зэрэг аргыг ихэвчлэн хэрэглэдэг. Бохир ус болон гэдэс дотрын хаягдлыг хүний ундны усны эх үүсвэрийг бохирдуулахааргүй газар хаях ёстой. (Бүлэг 6-г үзнэ үү: Мал эмнэлгийн үйлчилгээний дэмжлэг).

14. Шаардлагатай багаж хэрэгсэл, нөөцөөр хангах

Хэрэгжүүлэгч байгууллагууд нь малыг махны хэрэгцээнд зориулан нядалж борлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа газруудад чухал шаардлагатай багаж хэрэгслүүдээр (олс дээс, хутга, хувин сав, хадаас гэх мэт) хангах талаар тооцож үзэх хэрэгтэй. Эдгээр нь мал нядлахад нэн чухал зүйлс байж болох юм.



Хавсралтууд

Хавсралт 8.1: Малын тоог бууруулах үйл ажиллагааны үнэлгээний шалгах хуудас

Малын тоог бууруулах ерөнхий үйл ажиллагаа:

- Онцгой байдал аль шатандаа хүрчихээд байна?
- Мал амьтны зах дээр зарж байгаа малын тарга хүч ямар байна вэ?
- Малын зах дээр зарахаар авч ирж байгаа мал амьтны тоо нэмэгдэж байна уу?
- Малын зах зээлийн үнэд ямар нэгэн өөрчлөлт гарч байна уу?
- Үйл ажиллагаа хэрэгжүүлэх бүс нутагт ямар оролцогчид ажиллаж байна вэ?
- Гамшигт нэрвэгдсэн хувь хүмүүс, өрх, нийгмийн бүлгүүдээс аль нь хамгийн их эрсдэлтэй байна вэ?
- Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон нийгмийн янз бүрийн бүлгүүдэд гамшиг хэрхэн нөлөөлж байна вэ?
- Малын тоог бууруулах үйл ажиллагаанаас хэн ашиг шим хүртэж байна вэ?
- Зохицуулалт хийх бүлэг байгуулсан уу?
- Мал амьтны тавлаг байдлын стандартыг тооцож үзсэн үү?
- Энэ бүс нутагт мал амьтны хөдөлгөөн хийх, бэлэн мөнгө авч явахад аюулгүй юу?
- Малын тоог бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж чадах уламжлалт болон орон нутгийн ямар байгууллагууд байна вэ? Тэдгээр нь ямар үүрэгтэй вэ?

Малыг зах зээлд худалдан борлуулах ажиллагаа:

- Бүс нутагт малын худалдаачид аль хэдийн ажилласаар байгаа юу?
- Тэнд малын тоог бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх таатай дэд бүтэц байгаа юу?
- Малыг түр хугацаагаар байлгах байр байгаа юу?
- Ачааны машин хөлслөх боломжтой юу?
- Ус ба бэлчээр ашиглах бололцоотой юу?
- Малыг ачааны машинаар ачихтай холбоотой мал амьтны тавлаг байдалд нөлөөлөх асуудал байгаа юу?
- Малын хөдөлгөөн, худалдаатай холбогдолтой бодлого, журам, зохицуулалтын гол бэрхшээл юу вэ?
- Хамгийн эмзэг бүлгийн хүмүүс зах зээлд оролцоход ямар бэрхшээл саад учрах вэ?



Малыг махны хэрэгцээнд зориулан нядалж худалдан борлуулах ажиллагаа:

- Нядалгааны ямар байгууламж байна вэ?
- Малыг нядлахтай холбоотой тухайн орон нутгийн шашны болон соёлын ямар шаардлагууд байгаа вэ? Тэд мал амьтны тавлаг байдлын стандартыг хангахаар зөвшилцсөн үү?
- Мал нядлах, мах бэлтгэх, арьс шир идээлэх гэх мэтийн үйл ажиллагаатай холбоотой орон нутагт жендерийн ямар үүргүүд байдаг вэ?
- Малаа нядалж борлуулснаас ашиг шим хүртэж чадах гамшигт нэрвэгдсэн эрсдэлд буй ямар хувь хүмүүс, өрх, нийгмийн бүлгүүд байна вэ?
- Алслагдсан тосгонд хүрэхийн тулд түр зуурын зах байгуулах хэрэгтэй юу?
- Малыг махны хэрэгцээнд зориулан нядалж борлуулах үйл ажиллагааны хүрээнд ямар эрсдэлт бүлгийг сонгож махаар хангах вэ?
- Малыг нядалж борлуулах ажиллагааг хэрэгжүүлбэл ямар хүмүүс ажиллах хүчний боломжоос үр ашиг хүртэж болох вэ?
- Малыг нядлахын өмнөх болон дараах үзлэгийг хийх чадавх байгаа юу?
- Арьс, ширийг боловсруулах систем байгуулагдсан үү?

Нядалж устгах:

- Гологдсон гулуузны арьс ширийг боловсруулж чадах уу?
- Сэг зэмийг аюулгүй устгах ямар арга хэрэгсэл байна вэ?



Хавсралт 8.2: Малыг тоог бууруулах үйл ажиллагааны хяналт шинжилгээ ба үнэлгээний шалгуур үзүүлэлтийн жишээ

	Үйл явцын шалгуур үзүүлэлт (үйл ажиллагааны хэрэгжилтийг хэмжих)	Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (үйл ажиллагааны үр дүнг хэмжих)
Малыг зах зээлд худалдан борлуулах үйл ажиллагаа		
Үйл ажиллагааг төлөвлөх	Төр захиргааны байгууллага, худалдаачидтай хийсэн уулзалтын тоо; Уулзалтад хамрагдсан өөр өөр оролцогч талууд, хамрах хүрээ Нутгийн иргэдтэй хийсэн уулзалтын тоо; уулзалтад оролцсон хүмүүсийн тоо ба төрөл	Өөр өөр оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөө, уулзалтын тэмдэглэл Зах зээлийн эрэлтээр баталгаажсан малын худалдаачдын дуртай худалдаж авдаг мал амьтны төрөл Тодорхой тогтоосон мал борлуулах газар Төр захиргааны байгууллагуудтай тохиролцсон татвар ба бусад захиргааны асуудал Малын үнэ, төлбөрийн хэлбэр ба систем, мал цуглуулах хуваарь, мал худалдах зэргийг тусгасан нутгийн иргэдийн түвшинд боловсруулсан төлөвлөгөөнүүд
Хэрэгжүүлэлт: Мал худалдан авах	Хамрагдсан худалдаачдын тоо, Өрх ба бүсийн хэмжээнд худалдан авсан тоо, төрөл	Малын борлуулалтаас малчдын олж буй орлого Малын борлуулалтаас олсон орлогын зарцуулалт (хүнс, малын тэжээл худалдан авалт, нүүдлийн зардал, малын эм тариа авах, сургалтын төлбөр төлөх гэх мэт) Бодлогод нөлөөлөх



	Үйл явцын шалгуур үзүүлэлт (үйл ажиллагааны хэрэгжилтийг хэмжих)	Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (үйл ажиллагааны үр дүнг хэмжих)
Малыг махны хэрэгцээнд зориулан нядалж худалдан борлуулах үйл ажиллагаа		
Үйл ажиллагааг төлөвлөх	Нутгийн иргэдтэй хийсэн уулзалтын тоо, уулзалтад оролцсон хүмүүсийн албан тушаал, хүйсийн харьцаа Зорилтот орон нутаг бүрт байгуулсан малын тоог бууруулах үйл ажиллагааг зохицуулах бүлэг	Өөр өөр оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөө, уулзалтын тэмдэглэл Малын тоог бууруулах үйл ажиллагааг зохицуулах бүлгийн зөвшилцсон ажил үүргийн хүрээ Дараах зүйлүүдийг зөвшилцсөн үйл ажиллагааны төлөвлөгөө: - үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа ба давтамж, түр зуурын малын зах байгуулах - Нэрвэгдсэн нутгийн иргэдийг сонгох шалгуур үзүүлэлт - худалдан авах малын төрөл, үнэ, төлбөрийн механизм - түгээж болох махны хэмжээ - орон нутагт малыг цуглуулах, худалдан авах систем, цаг хугацаа - мал нядлах, мах бэлтгэх, арьс шир бэлтгэх зэрэг ажилд нутгийн иргэдийг хөлслөх, тэдний ажлын хөлс гэх мэт
Хэрэгжүүлэлт: Мал нядалгаа ба мах түгээлт	Хамрагдсан өрх ба хүмүүсийн тоо Өрх ба бүс нутгийн хэмжээнд худалдсан малын тоо, төрөл Өрх бүрт тараасан махны хэмжээ Түр ажилд хөлслөгдсөн нутгийн иргэдийн тоо	Малаа зарсан хүмүүс, малчин өрхүүд малын борлуулалтаас орлого олох ба орлогоо зарцуулах Түр ажлын байранд хөлслөгдсөн хүмүүс орлого олох ба зарцуулах Махны тараалтад хамрагдсан хүмүүсийн хоол хүнсний сайжирсан байдал



Эх сурвалж ба цаашид судлах материал

Abebe, D., Cullis, A., Catley, A., Aklilu, Y., Mekonnen, G. and Ghebrehirstos, Y. (2008) 'Impact of a commercial de-stocking relief intervention in Moyale district, southern Ethiopia', *Disasters* 32(2): 167–186, <http://dx.doi.org/10.1111/j.1467-7717.2007.01034.x>

Aklilu, Y. and Wekesa, M. (2002) Drought, Livestock and Livelihoods: Lessons from the 1999–2001 Emergency Response in the Pastoral Sector in Kenya, Humanitarian Practice Network Paper 40, Overseas Development Institute (ODI), London, https://www.unisdr.org/files/1855_VL102122.pdf

Catley, A. (ed.) (2007) Impact Assessment of Livelihoods-based Drought Interventions in Moyale and Dire Woredas, Ethiopia, Pastoralists Livelihoods Initiative, Feinstein International Center, Tufts University, Medford, MA, together with CARE, Save the Children USA, and USAID-Ethiopia, <https://fic.tufts.edu/assets/IMPACT1-2.pdf>

Catley, A. and Cullis, A. (2012) 'Money to burn? Comparing the costs and benefits of drought responses in pastoralist areas of Ethiopia', *Journal of Humanitarian Assistance*, 24 April 2012, <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/05/Catley-and-Cullis-2012.pdf>

FAO (2001) Guidelines for humane handling, transport and slaughter of livestock, <https://www.fao.org/documents/card/en/c/466c5e0e-aa6d-5cdb-8476-43245054c3bf/>

FAO (2016) Livestock-related interventions during emergencies – The how-to-do-it manual. Edited by Philippe Ankers, Suzan Bishop, Simon Mack and Klaas Dietze. FAO Animal Production and Health Manual No. 18. Rome, <https://www.fao.org/3/i5904e/i5904e.pdf> (See Chapter 4)

FAO (2020) Effective disposal of animal carcasses and contaminated material on small to medium-sized farms, FAO Animal Production and Health/Guidelines 23, <https://www.fao.org/publications/card/en/c/CB2464EN/>

Morton, J. and Barton D. (2002) 'Destocking as a drought-mitigation strategy: clarifying rationales and answering critiques', *Disasters* 26(3): 213–228, <http://dx.doi.org/10.1111/1467-7717.00201>

Toulmin, C. (1994) 'Tracking through drought: options for destocking and restocking', in I. Scoones (ed.), *Living with Uncertainty: New Directions in Pastoral Development in Africa*, pp. 95–115, Intermediate Technology Publications, London.

Turner, M.D. and Williams, T.O. (2002) 'Livestock market dynamics and local vulnerabilities in the Sahel', *World Development* 30(4): 683–705, [http://dx.doi.org/10.1016/S0305-750X\(01\)00133-4](http://dx.doi.org/10.1016/S0305-750X(01)00133-4)

See also case studies for livestock offtake in emergencies at: <https://www.livestock-emergency.net/resources/case-studies/>






Бүлэг 9: Малжуулах үйл ажиллагааны техникийн стандарт

- 332 **Танилцуулга**
- 335 **Малжуулах үйл ажиллагааны хувилбарууд**
- 340 **Үйл ажиллагаанууд (тусламж)-ыг хэрэгжүүлэх цаг хугацаа**
- 341 **LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн түншлэлийн стандартууд (ХТС)-тай холбогдох нь**
- 342 **LEGS-н зарчмууд болон бусад анхаарах асуудлууд**
- 348 **Малжуулах үйл ажиллагааны хувилбарыг сонгох шийдвэрийн мод**
- 351 **Стандартууд**
- 362 **Хавсралт 9.1: Малжуулах үйл ажиллагааны үнэлгээний шалгах хуудас**
- 364 **Хавсралт 9.2: Малжуулах үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний жишиг үзүүлэлтүүд**
- 367 **Хавсралт 9.3: Амьжиргааны наад захын хэрэгцээг хангахуйц малын тоо**
- 369 **Эх сурвалж ба цаашид унших материал**



Бүлэг 9: Малжуулах үйл ажиллагааны техникийн стандарт





Танилцуулга

Малжуулах үйл ажиллагаа нь онцгой нөхцөл байдал үүссэний улмаас их хэмжээний мал, амьтан хорогдох тохиолдолд тухайн гамшигт өртсөн хүмүүсийн амьжиргааны эх үүсвэр болох хөрөнгийг эргэн сэргээх, малын гаралтай чанартай хүнсний бүтээгдэхүүнээр хангах үр дүнтэй арга юм.

Онцгой байдлын төрлүүдийн ялгаатай нөхцөлөөс хамааран малын хорогдлын тоо янз бүр байдаг. Жишээ нь: жижиг түвшний үерээр малаа өндөрлөг газарт гаргаснаар хорогдолгүй давах боломжтой ба үерийн ус нь дунд хугацаандаа бэлчээрийн ургамал, тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх боломжтой. Нөгөө талаар томоохон хэмжээний үерийн гамшиг нь олон мянгаар тоологдох мал, амьтан хорогдох үр дагаврыг үүсгэж болно. Үүний нэгэн адил хүчтэй ган, газар хөдлөлтийн улмаас олон тооны мал хорогдох боломжтой. Малын өвс тэжээл хангалтгүй үед галт уулын дэлбэрэлтээс цацагдсан үнс тухайн орчны ургамлыг бүрхдэг ба үүнээс улбаалан бэлчээр, малын тэжээл хомсдож мал өлдөж хорогдох нөхцөл үүсдэг.

Гамшгийн улмаас мал хөрөнгөө алдсан эсвэл үржлийн цөм мал нь хорогдсон иргэд гамшгийн дараах сэргээн босгох үе шатны малжуулах үйл ажиллагааны үр шимийг голлон хүртэнэ. Энэхүү үйл ажиллагаа нь гамшигт өртсөн хүмүүсийн амьжиргааг дэмжих, улмаар эргэн сэргэх боломжийг олгодог. Иргэдэд хуваарилан өгсөн мал тухайн орчиндоо тэсэж зохицон амьдарч, тоо толгой нь өсөн нэмэгдэж, өндөр бүтээмжтэй байснаар гамшигт өртсөн иргэдийн амьжиргаанд хувь нэмэр оруулж байвал тухайн үйл ажиллагаа амжилттай хэрэгжсэнийг харуулна. Бэлчээрийн эсвэл жижиг аж ахуй (фермер) зонхилсон нөхцөлд малжуулах үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь эерэг үр дүнг түргэн хугацаанд үзүүлэх ба үүний үр дүнд сүү, өндөг зэрэг хүнсний хангамж нэмэгдэж өрхийн болон хүүхдийн хоол тэжээл, эрүүл мэнд сайжрахад дэм болно. Ачлагын мал амьтан тухайн өрхийн үйл ажиллагааг хөнгөвчлөх эсвэл орлого олох боломжийг мөн хангана.

Энэ бүлэгт онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний хүрээн дэх малжуулах үйл ажиллагааны талаарх мэдээлэл, хувилбаруудын сонголт тус бүр эдгээрийн үр өгөөж, сорилт, бэрхшээлүүдийн тухай тусгасан. Мөн бусад мэдээллийг *Бүлэг 9: НҮБ-ын ХХААБ-ын малжуулах үйл ажиллагаа (Provision of Livestock in FAO, 2016)*-с үзнэ үү. Техникийн сонголт тус бүр дээр LESG-н стандартууд, үндсэн үйл ажиллагаа болон зааварчилгаагаар хангах бөгөөд үнэлгээний шалгах хуудас, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг энэхүү бүлгийн төгсгөлд хавсралт хэлбэрээр тусгасан. Цаашид уншин судлах материалыг мөн оруулсан ба кейс судалгааг LEGS вэбсайт дээр танилцуулсан. (<https://www.livestock-emergency.net/case-studies>).



LEGS-ийн амьжиргааг дэмжих зорилттой холбогдох нь:

Малжуулах үйл ажиллагаа нь онцгой байдлын нөхөн сэргээх үе шатанд хэрэгждэг ба энэ нь LEGS-н амьжиргааны гурав дахь зорилт болох гамшигт өртсөн иргэдэд мал аж ахуйд суурилсан хөрөнгөө сэргээн босгоход дэмжлэг үзүүлэх гэсэн зорилттой нийцнэ.

Малжуулах үйл явц нь малын тавлаг байдлын таван зарчмыг заавал хангаж байх ёстой (*Бүлэг 1: LEGS танилцуулга*) ба үүний үр дүнд мал, амьтан хорогдохгүй онд орох, улмаар ашиг шим өндөр байж, малчдад амьжиргаагаа сайжруулахад нь тусална.

Гамшгийн хариу арга хэмжээний хүрээн дэх малжуулах үйл ажиллагааны ач холбогдол

Ган, үер, малын халдварт өвчин, галт уулын дэлбэрэлт, газар хөдлөлт, зөрчил мөргөлдөөн, мал амьтныг зэвсэглэн дээрэмдэх гэх мэт онцгой байдлуудын дараа үрэгдсэн мал, амьтныг нөхөн сэргээх нь гамшигт өрсөн өрхүүдийн амьжиргааг сэргээхэд дэм болдог хэдий ч бүхий л боломжтой тохиолдолд гамшгийн үе шатуудад малын хорогдлыг бууруулах нь илүү үр дүнтэйд тооцогдох арга хэмжээ байдаг. Үүнийг малын ус, тэжээлийн хангамжийг сайжруулах, мал эмнэлгийн үйлчилгээгээр дэмжих зэрэг LEGS-н техникийн үйл ажиллагааны хүрээнд хийж болно (*Бүлэг 4, 5 болон 6-г үзнэ үү*).

Хямралын үед болон дараа хоол хүнс, орон байр болон хүн амын эрүүл мэндэд чиглэсэн хангалтууд дээр нэн даруй төвлөрөн ажиллах нь чухал ба Sphere стандартын дагуу тусламжийн үйл ажиллагаануудыг үр дүнтэй хэрэгжүүлснээр гамшигт өртсөн иргэд өөрсдийн суурь хэрэгцээг хангахын тулд үлдсэн малаа зарж борлуулах нөхцлийг бууруулдаг. Энэхүү суурь хэрэгцээ хангагдсаны дараа тэжээл, ус, малын эрүүл мэндийн үйлчилгээ, малын байр зэргээр хангах замаар (*Бүлэг 4–7-г үзнэ үү*) тэдний үлдсэн мал, амьтныг хамгаалах нэмэлт тусламж үзүүлэх боломжтой болно. Харин эсрэг тохиолдолд хорогдсон мал амьтныг нөхөн сэргээх үйл ажиллагааг гамшгийн нөхөн сэргээх үе шат хүртэл хойшлуулах хэрэгтэй. Энэ үе шатанд гамшигт өртсөн иргэд болон үүнд хамаарах байгууллагын ажилтнуудын аль алиных нь хувьд малжуулах үйл ажиллагаа зохимжтой эсэхийг тодорхойлох цаг хугацаа, хэрэгжүүлэх чадавх бэхэждэг. Үнэлгээг богино хугацаанд яаралтай хийх нь чухал биш бөгөөд тухайн үйл ажиллагаа нь малын эрүүл мэнд, өвс тэжээл, ус, байр зэрэг мал аж ахуйг дэмжих хэрэгцээг бүрэн, зөв зохистой хангаж байгаа эсэхийг бүрэн тодорхойлох хэрэгтэй. Тусламжийн байгууллагууд нь техникийн чадавх, нөөцөө хэт олон чиглэлд тараах нь тийм ч зохимжтой бус байдаг.



Малжуулах үйл ажиллагаа нь мэргэжлийн хувьд ихээхэн бэрхшээл, сорилт бүхий арга хэмжээ байдаг ба дараах үүрэг хариуцлагыг хүлээдэг. Үүнд:

- Малын төрөл болон тооны хувьд үнэлгээ хийж, зөвшилцөх;
- Мал, амьтны сонголтыг хийх;
- Мал хүлээн авагчдыг сонгох (бусад хүлээн авагч талуудыг хасах хүндхэн шийдвэр гаргах нь зайлшгүй);
- Дагалдан гарах асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх, жишээ нь: мал хээл алдах, мал алдагдах, малын хулгай гэх мэт

Малжуулах үйл ажиллагаа нь өндөр зардалтай. Ялангуяа онцгой нөхцөл байдал үүссэний улмаас олон тооны мал, амьтан хорогдсон, улмаар мал амьтны зах зээлийн үнэ хэт өссөн үед энэ нөхцөл байдал бодитоор үүсдэг. Хүлээн авагч тал нь үлдсэн мал амьтнаа тэжээн тэтгэх хэрэгцээ шаардлагаас үүдэн цаашид гарах зардал мөн өснө. Зардлын асуудал чухал хэдий ч хүмүүнлэгийн тусламжийг гамшигт нэрвэгдсэн иргэдэд тасралтгүй үзүүлэх нь урт хугацаандаа амьжиргааг эргэн сэргээхэд гарах зардлаас илүү өндөр байх магадлалтай. Тиймээс малжуулах нь хүмүүнлэгийн үйл ажиллагааг дэмжих нийт зардлыг бууруулахад хувь нэмэр оруулах боломжтой.

Малжуулах үйл ажиллагаа ээдрээ төвөгтэй, зардал өндөртэй учир хэрэгжүүлэгч байгууллагууд нь үүнийг харгалзан мал аж ахуйн болон нийгмийн шинжлэх ухааны мэргэшсэн мэргэжилтнүүдтэй байх нь чухал. Үүнээс гадна мөн мал аж ахуйн мэргэжлийн байгууллагатай түншлэн, улмаар шаардлагатай чадавх, ур чадварыг бүрдүүлэх боломжтой. Туршлагатай эсэхээс үл хамааран байгууллагууд нь орон нутгийн мал аж ахуйн эдийн засгийн талаар ойлгосон байх шаардлагатай тулгарах ба энэ нь тэдэнд орон нутгийн малчин, мал бүхий иргэд, уламжлалт байгууллагууд (бэлчээрийн мал аж ахуй бүхий газарт), орон нутгийн фермерүүдийн холбоо, нутгийн захиргааны итгэлийг хүлээхэд чухал юм. Тусламжийн байгууллагууд нь орон нутгийн бүхий л бүлгүүд, жижиг аж ахуй эрхлэгчид, бэлчээр ашиглалтын байгууллагуудад хамаарах эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхэнтэй сайн хамтарч ажиллах нь мөн чухал.

Гамшигт өртсөн бүс нутагт удаан хугацаагаар ажиллаж, олон жилийн туршлага хуримтлуулсан байгууллага нь энэ чиглэлийн үйл ажиллагааг тэргүүлэн ажиллах нь тохиромжтой. Ялангуяа эдгээр байгууллагууд нь орон нутгийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцоо, үүний суурь болж буй нийгмийн тогтолцооны талаар илүү их ойлголттой байх хэрэгтэй. Гэхдээ байгууллагууд нь хэдий их туршлагатай байсан ч зарим суурь алдаа гаргахаас, жишээ нь агро-экологийн хязгаарлагдмал бүс нутагт харь мал, амьтан түгээх зэрэг алдаанаас зайлсхийх боломжгүй байдаг. Харь мал, амьтан тухайн орон нутгийн нөхцөл байдалд дасан зохицох нь



хязгаарлагдмал байдгаас үүдэн ашиг шим муудах, хорогдох зэрэг өндөр эрсдэлд хүргэдэг.

Хорогдсон малыг нөхөн малжуулж буй байгууллагууд нь өөрийн үйл ажиллагааг урт хугацааны хөгжлийн санаачилгууд, зах зээлд суурилсан хандлагыг дэмжих үйл ажиллагаатай уялдуулж өгөх талаар бодож үзэх нь зүйтэй. Жишээлбэл, тусламж хүлээн авагчдыг орон нутгийн малын зах зээл, тэжээлийг хэрэглэх, ашиглахад нь дэмжлэг үзүүлж болно. Эсвэл салбар дундын бэлэн мөнгөний тусламжаар дамжуулан тусламж хүлээн авагчдын хувийн мал эмнэлгийн үйлчилгээг авах боломжийг нь дэмжиж болох юм.

Малжуулах үйл ажиллагааны хувилбарууд

Малжуулах үйл ажиллагааны үндсэн хоёр хувилбар байдаг ба эдгээр нь онцгой байдлын нөхцөл, тухайн орон нутгийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцоо, амьжиргааны стратеги болон үйл ажиллагааны боломж, бэрхшээл, сорилтуудаас хамаарна. Хувилбарууд нь 'мал аж ахуйд суурилсан хөрөнгийг нөхөн сэргээх' болон 'мал аж ахуйд суурилсан хөрөнгийг бий болгох' гэсэн хоёр хувилбараас бүрдэнэ.

Энэхүү үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд доорх асуудлуудад үндэслэн мэдээлэл цуглуулж аль хувилбарыг сонгох шийдвэрийг гаргах нь чухал юм.

- Мал, амьтны сонголт, ялангуяа нас, хүйс, тоо, төрөл, эрүүл мэндийн байдал болон үнэ;
- Тусламж хүлээн авагчдын боломжит тоо, тэдэнд шаардагдах чадавх, жишээ нь ажиллах хүч, туршлага, ур чадвар, сонирхол, мөн аж ахуйд чухал шаардлагатай зүйлс болох тэжээл, ус, байр, малын эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж гэх

Энэхүү бүлэгт танилцуулж буй стандартууд нь хоёр хувилбарын аль алинд нь хамааралтай зааварчилгаагаар хангана.

Хувилбар 1: Алдсан мал хөрөнгийг нөхөн сэргээх

Байгууллагууд нь энэхүү хувилбарын ялгаатай хоёр дэд хувилбарын дагуу амьжиргааны өөр өөр бүлгүүдийг мал, амьтнаар хангаж болно.

Дэд хувилбар 1.1: Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч өрхүүдийг үржлийн цөм сүргийн малаар хангах

Нүүдлийн (мөн агро-нүүдлийн) малчин, аж ахуйн эрхлэгчид нь дэлхийн ногоон ургамал бүхий тал хээрийн бүсэд, Хятад, Монголоос эхлээд Төв Азийг дамнан, Ойрх Дорнод, Судан-Сахелийн бүс болон Өмнөд Африкийг хүртэл тархан амьдардаг. Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид мөн Төв болон



Өмнөд Америк, Европ, Хойд Америк, Австралид ч амьдарч байна. Тэд бүгд хоол хүнс, орлогын хувьд малаасаа хамааралтай байдаг тул мал, амьтан нь тэдний нийгмийн харилцаа холбоонд чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймд мал, амьтан бүх сүргээрээ хорогдоход хүргэдэг онцгой байдал нь бэлчээрийн мал аж ахуйд суурилсан амьжиргаанд маш хор хохирол учруулдаг ба улмаар малчдыг сэтгэл зүйн дарамтад оруулж, ядууралд хүргэх үр дагавартай.

Бэлчээрийн мал аж ахуй нь бүс нутаг бүрт ялгаатай байдаг ба зарим нь зөвхөн нэг төрлийн мал, амьтан (хонь, ямаа, цаа буга гэх мэт) дагнан өсгөх бол зарим нь холимог байдлаар (хонь/ ямаа эсвэл үхэр/сарлаг) өсгөн үржүүлдэг. Энэхүү төрөлжсөн байдлаас шалтгаалан орон нутагт буй мэдлэг, туршлага нь үйл ажиллагааны сонголт, арга аргачлалыг сонгон хэрэгжүүлэхэд чиглэл өгөх мэдээллээр хангадаг. Жишээ нь, зарим орон нутагт тэмээ маш өндөр үнэлэгддэг бол үйл ажиллагааны гол цөм нь энэ төрлийн мал дээр төвлөрөх нь чухал. Мөн орон нутагт буй туршлага, мэдлэгээс үүдэн бог мал, тухайлбал хонь, ямаа ч мөн үнэтэй байж болох ба учир нь олон тоотой болох тусам тэмээгээр сольж арилжаалах боломжтой болдог. Орон нутаг дахь туршлага, мэдлэгийг ийм байдлаар ашиглах нь үйл ажиллагааны зардлыг бууруулах боломжийг бүрдүүлнэ. Тиймээс орон нутгийн мэдээллээр хангах талууд нь “үржлийн цөм сүрэг бүрдүүлэх” тооны доод хязгаарыг тодорхойлон гаргахад тодорхой үүрэг гүйцэтгэнэ (Энэхүү Бүлгийн төгсгөлд буй *Хавсралт 9.3*-г үзнэ үү: Сүргийн боломжит доод хэмжээ)

Гэрлэлт, торгуулийн төлбөр, нөхөрлөлийн бэлгэдэл зэрэг хэлбэрээр мал, амьтан дахин хуваарилагдах нөхцөл байдал болон үүнд хамаарах нийгмийн сүлжээ үүсэх нь нүүдлийн мал аж ахуй бүхий бараг бүх л нийгэмд түгээмэл байдаг. Тиймээс тусламжийн байгууллагууд энэхүү туршлагыг дэмжин ажилладаг механизм, институцуудыг ашиглах нь зүйтэй. Жишээ нь орон нутгийн туршлага, институцууд нь мал, амьтныг хэзээ, хэрхэн ханган нийлүүлэхийг тодорхойлоход туслах боломжтой. (*LEGS Зарчим 2*-г үзнэ үү: Олон нийтийн оролцоо).

Түүнчлэн бэлчээрийн мал аж ахуйн салбартаа эргэн ирэх, үргэлжлүүлэхийг хүсэж буй, бусадтайгаа сайн хэлхээ холбоо бүхий аж ахуй эрхлэгчдэд л зөвхөн дэмжлэг үзүүлэх нь чухал. Учир нь бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид нь бусдаасаа тусгаарлагдмал байдлаар үйл ажиллагаа явуулах боломжгүй ба мал маллагаа, усан хангамж зэрэг дээр заавал хамтрах шаардлагатай байдаг. Эдгээр шалтгааны улмаас тэд бүлгээр эсвэл айл саахалтаар нийлэн хамтрах байдлаар мал аж ахуйгаа авч явдаг байна. Хамтран ажиллах замаар тэд ажиллах хүчээ харилцан хуваалцаж, хээлтүүлэгч малаа ээлжлэн тусдаа хариулж, алслагдсан бэлчээрийн бүс нутагт аюулгүй хүрч чаддаг.



Ийм төрлийн нийгмийн сүлжээ, харилцаа холбоо байхгүй бэлчээрийн аж ахуй эрхлэгчид нь энэхүү үйл ажиллагаанаас тогтвортой өгөөж хүртэх магадлал бага байна.

Дэд хувилбар 1.2: Фермерийн жижиг аж ахуй эрхлэгчдийг дэмжих, орлого олох зорилгоор үндсэн мал хөрөнгөөр хангах

Жижиг хэмжээний аж ахуй эрхэлдэг, ядуу, хот орчмын болон хот суурин газарт амьдарч буй хүмүүс нь нүүдлийн аж ахуйтай харьцуулбал цөөн тооны малтай байдаг. Арай чинээлэг жижиг аж ахуй нь цөөн тооны саалийн үнээ, газар хагалахад зориулсан цөөн тооны шар үхэр, хонь, ямаа, адуу эсвэл луус, цөөн тооны гахай, шувуутай (тахиа, нугас, цацагт хяруул) байдаг ба харин маш ядуу аж ахуй эрхлэгчид нь зөвхөн цөөн тооны тахиатай байх тохиолдол байна.

Цөөн тооны саалийн үнээ, бага хэмжээний сүрэг тахиатай эсвэл уналга, ачлагын цөөн малтай өрхүүдийн амьжиргаа нь тухайн мал, амьтнаас өндөр хамааралтай байдаг. Тэд сүүн бүтээгдэхүүн, өндөг үйлдвэрлэж борлуулах, эсвэл ачлагын малаа бусдад түрээслүүлэх зэргээр орлого олно. Этиоп улсад илжиг, луус нь кофены тариалангийн тээвэрлэлтэд олон жилийн турш ашиглагдаж ирсэн түүхтэй бол Балба улсад уулархаг нутагт амьдарч буй иргэдэд зориулсан тээвэрт ачлагын малыг ашигладаг. Мөн онцгой байдлын үед ачлагын малыг ашиглан хүнсний болон бусад хүмүүнлэгийн тусламжийг хүргэдэг.

Хэдий тооны хувьд цөөн ч хот орчмын, хот суурин газрын мал, амьтан амьжиргааны чухал эх үүсвэр байдаг. Онцгой байдлын улмаас эдгээр мал, амьтан хорогдох нь тухайн өрхүүдийг огцом хүндрэлд хүргэж, хоол хүнс, орлогын эх үүсвэргүй болгодог. Цаг хугацаа өнгөрөх тусам энэхүү хохирол нь үнэт мэдлэг, үр чадвар, туршлагыг хязгаарлаж, тэр байтугай бүрэн мартагдахад хүргэж болно. Онцгой байдалд өртсөн иргэдийн хувьд гамшигт хорогдсон малаа гаднын дэмжлэггүйгээр эргэн нөхөхөөр хичээх нь тухайн гамшгийн үр нөлөөг улам л гүнзгийрүүлэхэд хүргэнэ. Учир нь мал аж ахуйгаа эргэн нөхөн сэргээхэд тухайн иргэдийн нөөц боломж нь хязгаарлагдмал байдаг.

Хувилбар 2: Мал аж ахуйд суурилсан хөрөнгийг бий болгох

Тусламжийн байгууллагууд нь энэхүү хувилбарын хүрээнд өмнө нь мал, амьтангүй байсан, гамшигт өртсөн иргэдэд амьжиргаагаа сайжруулахад нь зориулан мал, амьтан олгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Мал, амьтан нь тэдний амьжиргаанд дараах байдлаар эерэг нөлөө үзүүлнэ:

- Сүү, өндөгний хүртээмж бий болж, хоол тэжээл сайжрах;
- Орлогын нэмэлт эх үүсвэр болох;



- Хадгаламж үүсэж, улмаар цаашид хэрэгцээ гарах тохиолдолд ашиглах, жишээ нь малаа борлуулснаар сургуулийн болон эмнэлгийн төлбөр хийх нөөцтэй болох (хэрэв зарж борлуулж буйгаас илүү тооны төл авч байгаа бол).

Малжуулах үйл ажиллагааны туршид дотоодын шилжин суурьшигчид, дүрвэгчдийн амьжиргааг төрөлжүүлэх үйл явцыг дэмжиж өгдөг ба мөн байгалийн ургамал, тэжээлийн нөөцийг илүү үр дүнтэй ашиглахад нь тусалж болно. Ингэснээр хүний хэрэглээнд үл тохирох орон нутгийн байгалийн нөөцийг өндөр чанарын малын гаралтай уураг болгон ашиглах боломжтой. Түүнчлэн мал, амьтан нь уналга ачлага, газар хагалах зэрэг ажилд хүч нэмж, улмаар орлого олох, газар тариалан эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлнэ. Мөн мал, амьтнаас гарах бууцыг бордооны эх үүсвэр, өрхийн түлш, барилгын материал болгон ашиглах ба зарж борлуулах боломжтой.

Өмнө нь мал маллаж байсан туршлагагүй хүмүүсийг хамруулснаар амжилттай болсон зарим тодорхой жишээ байдаг ч үүний зэрэгцээ амжилтгүй болж, оролдлого нуран унасан тохиолдлууд ч мөн байдаг. Учир нь мал маллах нь өөрийн гэсэн бэрхшээл, сорилтуудтай тулгардаг ба үүнд цаг хугацааны, мэдлэгийн, туршлагын болон малаа гэсэн сэтгэл гэх мэт эрүүл, өндөр ашиг шимтэй мал аж ахуйтай байхад шаардагдах хүчин зүйлүүд байдаг. Хэдий сонирхол өндөр байж болох ч малжуулах үйл ажиллагааг цөөн тоогоор, жишээ нь шувуугаар эхэлбэл илүү зохистой. Учир нь гэрийн шувуу нь үржлийн хугацаа богино, өрхийн хүнс тэжээллэгийн хангамж, баталгаат байдалд шууд хувь нэмэр оруулах эсвэл өндөгний борлуулалтаас орлого олох боломжийг бүрдүүлдэг.

Энэ тохиолдолд эерэг үр дүнг баталгаажуулахын тулд малын хоол тэжээл, арчилгаа, эрүүл мэнд, тавлаг байдлын талаарх сургалтуудыг зохион байгуулах нь чухал. Боломжтой бол мэргэжилтэн ажиллуулах замаар малжуулснаас хойш хамгийн багадаа 2 жилийн туршид дэмжлэг үзүүлж байх ёстой. Ийм арга замаар мал, амьтан хүлээн авсан иргэд нь тухайн аж ахуйг эрхлэхэд шаардлагатай мэдлэг, үр чадварыг бүрэн эзэмших боломжтой.

Эдгээр үндсэн болон дэд хувилбаруудын үр өгөөж, сорилт, нөлөөллийг *Хүснэгт 9.1*-д тоймлон харууллаа.



Хүснэгт 9.1: Малжуулах үйл ажиллагааны хувилбаруудын үр өгөөж, тулгарах сорилтууд

Үр ашиг	Сорилт, бэрхшээл	Зөвлөмж
Хувилбар 1: Мал аж ахуйд суурилсан хөрөнгийг нөхөн сэргээх		
Дэд хувилбар 1.1: Мал аж ахуй эрхлэгч өрхүүдийг үржлийн цөм сүргийн малаар хангах		
Хорогдсон мал сүргийг нөхөн сэргээхэд тусална Хүнс, хоол тэжээлийн баталгаат байдалд хувь нэмэр оруулна Даван туулах чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулна Уламжлалт мал, амьтан солилцоо, сүрэг бүрдүүлэх явцад дэмжлэг үзүүлнэ Амьжиргааны бусад чиглэлээр дэмжих боломжтой (худалдаачид, тээвэрчид, боловсруулах салбар гэх мэт)	Үйл ажиллагааны нэгжийн зардал өндөр, хяналт-шинжилгээ, үнэлгээ болон нөлөөллийн үнэлгээнд тодорхой хичээл зүтгэл, нөөц эх үүсвэр шаардлагатай Мэргэжлийн түвшний техникийн болон шинжлэх ухааны чиглэлийн туслалцаа шаардана	Бэлчээрийн мал аж ахуйн эрхлэгчдийн онцлогт нийцсэн байна Үр шим хүртэгч нь нийгмийн статусаа хадгалж, ус, бэлчээрээ үргэлжлүүлэн ашиглана Мал, амьтан өсөн үржих хугацаанд үр шим хүртэгчдэд амьжиргааны бусад дэмжлэг (хүнс, бэлэн мөнгө) шаардагдана Шинэ сүрэгт бусад хэлбэрийн (мал эмнэлэг, тэжээл, хашаа хороо гэх мэт) туслалцаа шаардагдана
Дэд хувилбар 1.2: Фермерийн жижиг аж ахуй эрхлэгчдийг дэмжих, орлого олох зорилгоор үндсэн мал хөрөнгөөр хангах		
Хорогдсон мал сүргийг нөхөн сэргээхэд тусална Хүнс, хоол тэжээлийн баталгаат байдалд хувь нэмэр оруулна Орлого олоход дэмжлэг үзүүлнэ	Үйл ажиллагааны нэгжийн зардал өндөр, хяналт-шинжилгээ, үнэлгээ болон нөлөөллийн үнэлгээнд тодорхой хичээл зүтгэл, нөөц эх үүсвэр шаардлагатай	Мал, амьтан өсөн үржих хугацаанд үр шим хүртэгчдэд амьжиргааны бусад дэмжлэг (хүнс, бэлэн мөнгө) шаардагдана Шинэ сүрэгт бусад хэлбэрийн (мал эмнэлэг, тэжээл, хашаа хороо гэх мэт) туслалцаа шаардагдана



Үр ашиг	Сорилт, бэрхшээл	Зөвлөмж
Хувилбар 1: Мал аж ахуйд суурилсан хөрөнгийг нөхөн сэргээх		
Үнэ цэнэ бүхий шинэ хөрөнгийг бүрдүүлнэ Хүнс, хоол тэжээлийн баталгаат байдалд хувь нэмэр оруулна Орлого олох чиглэлд дэмжлэг болно	Үйл ажиллагааны нэгжийн зардал өндөр, хяналт-шинжилгээ, үнэлгээ болон нөлөөллийн үнэлгээнд тодорхой хичээл зүтгэл, нөөц эх үүсвэр шаардлагатай Мал, амьтны хэрэгцээний талаар сургалт хийж танилцуулах шаардлагатай	Сургалт, менторинг зэрэг дэмжлэг хоёр жил гаруй хугацаанд үргэлжилнэ

Үйл ажиллагаанууд (тусламж)-ыг хэрэгжүүлэх цаг хугацаа

Малжуулах үйл ажиллагааны хүрээнд өндөр ашиг шимтэй мал, амьтан тараахад зардал, сорилтууд их байдаг тул энэ нь байгууллагуудаас хамгийн боломжит өндөр үр дүн гаргахыг шаарддаг. Мөн авч хэрэгжүүлэх арга хэмжээг гамшгийн эрсдэлийн удирдлагын мөчлөгийн нөхөн сэргээх үе шат хүртэл хойшлуулах тохиолдол ч гардаг (Хүснэгт 9.2-г үзнэ үү). Ийм байдлаар онцгой байдлын үе шатанд амь насыг авран хамгаалах үйл ажиллагаатай давхцах магадлалыг бууруулна. Мөн яаралтай хэрэгцээгээ хангах зорилгоор тараасан мал, амьтныг зарж борлуулах боломж ч мөн буурна. Түүнчлэн мал аж ахуйн салбарын дэмжлэг мал эмнэлэг, тэжээл, ус, байр зэрэг чиглэлд илүү төвлөрөх боломжтой болно.

Хавсарсан гамшгийн онцгой байдлын дараа байгууллага, агентлагууд нь үйл ажиллагааг хэрэгжүүлэх цаг хугацааг хойшлуулж болох ба учир нь энэ үед зэвсэглэсэн бүлгийн зүгээс мал, амьтан болон малчдад аюул занал учруулах эрсдэл их байдагт оршино. Тэр ч байтугай энхийн гэрээ байгуулагдсаны дараа ч энэ нөхцөл байдал үргэлжилж болзошгүй.



Хүснэгт 9.2: Малжуулах үйл ажиллагааны боломжит хугацаа

Хувилбарууд	Гэнэтийн гамшиг		
	Гэнэтийн хор хохирол	Эрт үеийн нөхөн сэргээх	Нөхөн сэргээх
1. Мал аж ахуйд суурилсан хөрөнгийг нөхөн сэргээх	—	—	✓
2. Мал аж ахуйд суурилсан хөрөнгийг бий болгох	—	—	✓

Хувилбарууд	Удаан явцтай гамшиг			
	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээх
1. мал аж ахуйд суурилсан хөрөнгийг нөхөн сэргээх	—	—	—	✓
2. Мал аж ахуйд суурилсан хөрөнгийг бий болгох	—	—	—	✓

LEGS-н бусад бүлгүүд болон Хүмүүнлэгийн түншлэлийн стандартууд (ХТС)-тай холбогдох нь

Малжуулах үйл ажиллагаа нь LESE-н хүрээнд хийгдэх бусад үйл ажиллагаа, үүнд тэжээл, ус, мал эмнэлгийн үйлчилгээ, малын байр зэрэгтэй уялдаатай, харилцан зохицуулсан байх шаардлагатай (*LEGS Бүлэг 4, 5, 6 болон 7-г үзнэ үү*).

Мал хүлээн авагч өрхүүдэд үндсэн хэрэгцээгээ хангахын тулд бусад хэлбэрийн туслалцаа шаардагдах ба тэдэнд өгсөн мал, амьтан амьжиргаанд нь бүрэн хэмжээнд хувь нэмэр оруулж эхлэх хүртэл энэ хэрэгцээ байсаар байна. Жишээ нь 20- 30 тооны үржлийн цөм мал хүлээн авсан бэлчээрийн (агро-бэлчээрийн) аж ахуй эрхлэгч нь нэлээд хэдэн жилийн туршид өрхийн хүнсний баталгаат байдлыг бүрэн хангахуйц хэмжээнд хүрч чадахгүй. Тиймээс тэдэнд мал сүрэг нөхөн сэргэх хугацаанд хүнс, орлого шаардлагатай болно (*Стандарт 4-г үзнэ үү: Нэмэлт тусламж*). Хэрэв энэ чиглэлийн тусламж байхгүй бол тэд өөрийн үндсэн хоол хүнс, орлогын хэрэгцээгээ хангахын тулд хүлээн авсан мал, амьтнаа зарж борлуулахаас өөр аргагүйд хүрнэ. Тиймээс байгууллагууд нь Sphere гарын авлагад тусгасан "Хүнсний баталгаат байдал, хоол тэжээллэгийн минимум стандартууд", мөн "Орон байр, суурьшлын минимум стандартууд" хэсгийг сайтар судлах нь зүйтэй. Ингэснээр мал хүлээн авч буй өрхүүд нь нөхөн сэргээх үе шатанд шаардлагатай бүх хэлбэрийн тусламжийг хүлээн авах боломжтой болно.



LEGS-н зарчмууд болон бусад анхаарах асуудлууд

Мал аж ахуйд суурилсан хөрөнгийг нөхөн сэргээх эсвэл шинээр бүрдүүлэх нь амьжиргааг дэмжих шинэ үйл ажиллагаа болохын хувьд энэ нь гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн амьжиргааг эргэн сэргээн, бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. LEGS Зарчмууд нь Хүснэгт 9.3-д дээр харуулснаар дараах төрлийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллээр хангана.

Хүснэгт 9.3: LEGS-н зарчмууд малжуулах үйл ажиллагаатай уялдах нь

LEGS-н Зарчим	Малжуулах үйл ажиллагаанд LEGS-н зарчмууд хэрхэн хамаарах тухай жишээ
1. Амьжиргаанд суурилсан хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх	Малжуулах үйл ажиллагаа нь амьжиргааг дэмжиж, нөхөн сэргээдэг. Үүнийг бэлчээрийн аж ахуй эрхлэгчдийн үржлийн цөм сүргийг сэргээх эсвэл жижиг фермерүүдийн орлого нь хамааралтай байдаг мал, амьтныг эргэн сэргээх замаар хэрэгжүүлдэг. Зах зээлийн аргыг ашиглах нь мөн орон нутгийн үйлчилгээ ханган нийлүүлэгчид (худалдаачид, тээвэрлэгчид, мал аж ахуйд шаардлагатай зүйлсийг ханган нийлүүлэгчид, малын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид)-ийн амьжиргааг мөн дэмждэг.
2. Орон нутгийн иргэдийн оролцоог хангах	Малжуулах үйл ажиллагааны бүхий л хэсэгт гамшигт нэрвэгдсэн иргэд оролцсон тохиолдолд хамгийн сайн үр дүн гардаг ба өөрөөр хэлбэл анхдагч үнэлгээ, төлөвлөлт, дизайн, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд тэд оролцсон байх шаардлагатай. Ялангуяа гамшигт өртсөн иргэдийн талаарх урьдчилсан үндэслэл судалгаа, тараах малын тоо, төрлийг сонгох, хүлээн авагч талуудыг сонгох, мал амьтны худалдан авалт болон түгээлт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд оролцуулах шаардлагатай.
3. Уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах	Мал амьтныг тараахаас өмнө хийгдэх байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр шинээр нийлүүлэх мал амьтанд шаардлагатай тухайн үеийн байгаль орчны сөрөн тэсвэрлэх чадавх, байгалийн нөөцийн (бэлчээр, ус) боломж зэргийг үнэлнэ. Хот суурин болон хот орчмын онцлог асуудлуудыг мөн боломжтой бүхий л нөхцөлд харгалзан үзнэ. Мал амьтан нь орон нутгийн агро-экологийн нөхцөл байдалд дасан зохицсон орон нутгийн үүлдэр байх, орон нутагт тэсэж үлдэх, өгөөж өгөхүйц байх ёстой.



4. Бэлэн байдал, эрт үеийн арга хэмжээг дэмжих	Анх удаа мал, амьтан хүлээн авч буй нутгийн иргэд юуны өмнө бэлтгэгдэж, мал аж ахуй эрхлэх ур чадварын зохих сургалтад хамрагдсан байх. Тэжээл, ус, бэлчээрийн хүрэлцээ, хүлээн авах талуудын хүсэл эрмэлзлэлийг баталгаажуулахын тулд бэлэн байдлын нарийвчилсан үнэлгээг хийх. Ирээдүйн онцгой байдлын бэлэн байдлыг баталгаажуулах стратеги, жишээ нь гамшгийн эрсдэлийг бууруулах арга техник зэргийг хүлээн авагч талуудад зааж сургах.
5. Уялдаа холбоотой хариу арга хэмжээг хэрэгжүүлэх	Малжуулах үйл ажиллагаанд хамаарах бусад байгууллагуудтай үйл ажиллагааг уялдуулан зохицуулснаар зөрчилдөөнөөс сэргийлнэ. Малыг тээвэрлэх үед бүхий л замын турш малын тавлаг байдлын шаардлагуудыг хангахын тулд тээвэрлэлтийн зохион байгуулалтыг уялдуулан зохион байгуулах зайлшгүй шаардлагатай. Хүмүүнлэгийн тусламжаар хүнс, орлого гэх мэт хүлээн авч буй талуудад үзүүлэх тусламжийн хүрээнд бусад байгууллагуудын тусламжийг зохицуулах, тухайн мал амьтан нь бүтээмж өндөр хэмжээнд хүрэх хүртэл үйл ажиллагааг хэдэн жилийн туршид хэрэгжүүлэх шаардлагатай болж болно. Мал амьтантай хамаарах тэжээл, ус зэрэг нэмэлт үйл ажиллагааг уялдуулан зохицуулах нь тараасан мал амьтан тэсэн үлдэж, өсөн үржиж боломжийг олгоно.
6. Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрийг дэмжих	Үйл ажиллагааг үр дүнтэй байлгахын тулд баялгийн олон ангилалт бүлэгт хамаарах эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс малжуулах үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт болон менежментэд, мөн хяналт-шинжилгээ, үнэлгээ, эргэн тайлагнах хариуцлага, суралцах (ХҮХС) үйл ажиллагаанд бүрэн хэмжээгээр оролцохыг хүсэх хэрэгтэй. Өөрсдийн онцлог хэрэгцээгээ илэрхийлэх хангалттай боломжийг эмэгтэйчүүдэд тусгайлан олгох хэрэгтэй. Эмэгтэйчүүдийн хувьд хөдөлмөрлөх мөн хангалттай цаг хугацаатай, мөн мал амьтан хүлээн авах сонирхлоо илэрхийлсэн бол тэдний тэргүүлэх хэрэгцээг малын төрөл сонголт дээр онцгойлон үнэлэх шаардлагатай. Үйл ажиллагаанд өрх толгойлсон эмэгтэйчүүдийг хамруулах бол тусламжийн байгууллагууд нь шаардлагатай нэмэлт сургалт, менторингийг (зөвлөх) хангаж өгөх шаардлагатай.



7. Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих	Үйл ажиллагаанд орон нутгийн уламжлалт/ засаг захиргааны удирдлага (эрэгтэй, эмэгтэй) манлайлах үүргийг гүйцэтгэнэ. Урт хугацаанд тогтсон, мал амьтан түгээх уламжлалт тогтолцоонд дэмжлэг үзүүлж болох ба энэ нь малжуулах үйл ажиллагааны ач холбогдлыг бууруулахгүй байхад анхаарах хэрэгтэй. Үйл ажиллагаанд орон нутагт бүрдсэн ур чадвар, мэдлэг, туршлага, мал аж ахуйн менежментийн чадавхыг ашиглах ёстой.
8. Хяналт, Үнэлгээ, Хариуцлага, Суралцах (ХҮХС)	Тусламжийн байгууллагууд нь малжуулах үйл ажиллагааны үзүүлж буй нөлөөлөлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байх нь чухал. Энэ нь гамшгийн дараа шууд эсвэл жилийн дараа тараасан мал, амьтан нь үхэж үрэгдсэн эсэх болон өсөн төллөж буй хувь хэмжээнд төвлөрөх нь зүйтэй. Ингэснээр үйл ажиллагаанаас амьжиргаанд үзүүлсэн нөлөөллийг тодорхойлж, суралцах боломжийг бүрдүүлж, ирээдүйн үйл ажиллагаанд чиглэл болох мэдээллээр хангагдана.

Аюулгүй байдал ба зөрчил мөргөлдөөн

Зөрчил мөргөлдөөн бүхий бүс нутагт малжуулах үйл ажиллагаа нь зэвсэгт бүлгүүд, гэмт хэрэгтнүүдийн анхаарлыг ихээр татах тул хамгааллын асуудлыг иж бүрэн хэмжээнд судлан үзэх шаардлага үүснэ. Үйл ажиллагаанд өрх толгойлсон эмэгтэйчүүд, цөөнх эсвэл эмзэг бүлгийнхнийг хамруулж байгаа нь тодорхой асуудлуудыг дагуулдаг. Мөргөлдөөн бүхий зарим нутагт малын хулгай дээрэм нь илүү зэвсэглэсэн шинжтэй байх ба зэвсэглэсэн бүлэг хол замыг туулан, мал амьтан хулгайлдаг. Хэрэв мал, амьтан болон малчид энэ төрлийн хулгайд өртөх эрсдэл өндөр байгаа бол энэ тохиолдолд малжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжгүй. Ямар ч тохиолдолд Sphere гарын авлагын Хамгааллын зарчим 1 буюу “Иргэдийг үргэлжлүүлэн хор хохиролд өртүүлэхээс зайлсхийх” зарчмыг харгалзан үзэх шаардлагатай (*Бүлэг 1 LEGS танилцуулга-г үзнэ үү*).

Дээрхийн нэгэн адил жижиг хэмжээний нүүдлийн болон суурин аж ахуй эрхлэгчид хоорондоо зөрчилдөөнтэй бол байгууллагууд нь аль нэг бүлэгт нь нэмэлт мал, амьтан тараах тал дээр анхаарал болгоомжтой хандах шаардлага үүснэ. Олон төрлийн мал, амьтныг сонгох нь хулгайд өртөх эрсдэлийг бууруулж болно. Жишээ нь малын хулгайчдын хувьд үхэртэй харьцуулбал ямаа сонирхол татахгүй, хол зам тууж явахад ч тохиромжгүй байдаг. Мал, амьтан нийлүүлж буй байгууллагууд ч мөн худалдан авч буй эсвэл худалдан авахаар төлөвлөж буй, эсвэл эрхийн бичиг, бэлэн мөнгөөр дамжуулан тараах мал, амьтан нь хулгайлсан мал, амьтан байхаас



сэргийлэх нь зүйтэй. Хэрэв хулгайн байж болох ямар нэгэн эрсдэл байвал үйл ажиллагааг зогсоох шаардлагатай.

Тусламж хүлээн авагчдыг сонгох нь

Мал, амьтан хүлээн авагчдыг сонгоход болгоомжтой хандах нь чухал. Жишээ нь, бэлчээрийн аж ахуй бүхий нутагт мал хүлээн авагч тал нь зарим нэг малтай эсвэл гамшгийн улмаас мал нь хорогдсон болох нь батлагдсан байх шаардлагатай. Тэд мөн өөрийн хамаарах бэлчээрийн аж ахуй эрхлэгч талуудтай сайтар тогтсон харилцаа холбоотой, үүнийг хадгалан үлдсэн байх шаардлагатай. Зөвхөн энэхүү бат бөх хэлхээ холбоогоор дамжин хүлээн авагч тал нь мал маллагааны нэгж болж эргэн нэгдэж, тухайн орон нутгийн нэгэн хэсэг болж чадна. Ийм арга замаар тэд бэлэг, зээл (жишээ нь үржлийн чиглэлээр) хэлбэрээр малтай болж, цаашид өөрсдийнх нь мал өсөхөд бусдад бэлэглэх, зээлдүүлэх зэрэг харилцаанд орно. Ийм төрлийн солилцоо нь өрхийн урт хугацааны ашигт ажиллагаанд голлох үүрэгтэй (Үйл явцын кейс судалгаа: Нигер улсад гангийн бэлэн байдлын хүрээнд уламжлалт малжуулах үйл явцыг дэмжсэн нь).

Жижиг аж ахуй эрхлэгч фермерүүдийн хувьд хүлээн авч буй мал амьтныг маллахад шаардлагатай ажиллах хүч, чадавх бүрдсэн эсэх нь чухал. Үүнд малын эрүүл мэндийн үйлчилгээ, тохиромжтой бэлчээр, тэжээл, ус, байр, үржлийн эрүүл мал зэрэг хамаарна. Өмнө нь мал, амьтан маллаж байгаагүй эсвэл туршлага багатай өрхүүдэд мал, амьтан олгохдоо сонголтод онцгойлон анхаарал хандуулах шаардлагатай ба сонгох үйл явцын хүрээнд эрүүл, бүтээмжтэй мал сүрэг өсгөн үржүүлэхэд цаг хугацаа, чадавх нь хомс, мөн бодит сонирхолгүй хүмүүсийг тодорхойлж, тэдгээрийг жагсаалтаас хасах боломжтой.

Үндсэндээ малжуулах үйл ажиллагаанаас хамгийн өндөр үр дүнг гаргаж чадах өрхүүд нь хамгийн ядуу, хамгийн их эрсдэлтэй бус харин ихэвчлэн замын ойролцоо эсвэл зах зээлийн эргэн тойронд амьдардаг өрхүүд байдаг. Малжуулах үйл ажиллагааг хамгийн өндөр үр дүнд хүргэх өрхүүдийг олж тогтоохын тулд уламжлалт болон отог омгийн удирдагчдыг оролцуулах шаардлагатай. Гэсэн хэдий ч эхний шалгуураар хасагдсан хэсэг нь ихэнхдээ өрх толгойлсон эмэгтэйчүүд эсвэл цөөнхийн бүлэгт хамаарах хүмүүс байдгийг анхаарах хэрэгтэй. (LEGS зарчим 6: Жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр болон Зарчим 7: Орон нутгийн өөриймшүүлэх чадавхыг дэмжих-2 үзнэ үү).

Харин ядуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан үйл ажиллагааг хэрэгжүүлж буй бол 1-2 тооны өндөглөгч тахиа өгөх нь боломжит тоо байдаг ба өндөглөж эхлэх хүртэлх шаардлагатай байр, тэжээл, мал эмнэлгийн



үйлчилгээний хангамж зэрэгтэй хамт олгох нь зүйтэй. Боломжтой бол жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлж тухайн кейст суурилсан техникийн зөвлөгөө, (жишээ нь гэрийн шувууны эмчилгээнд татаас олгох гэх мэт) дэмжлэгийг малжуулснаас хойш 12 сарын турш өгөх нь чухал.

Өвчний тархалт

Мал амьтнаас хүнд өвчин тархах явдал нь илүү аж үйлдвэржсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцооны үед ихэвчлэн тохиолддог. Гэвч мал амьтан болон хүн харилцан бие биедээ ойр байх ямар ч орчин нөхцөлд энэхүү байдал үүсэж болно. Үүний нүүдэлчин малчид, жижиг аж ахуй эрхлэгчид малаа шөнө гэрийнхээ ойр хашдаг жишээ орно. Жишээ нь, тахиа байшингийн дээврийн хөндийд байх боломжтой бол бог малыг шөнө хашиж байх шаардлагатай гэх мэт. Зарим хот, суурин газар, түүнчлэн дүрвэгсдийн кэмп, дотоодын дүрвэгчдийн байрлаж буй газарт (ялангуяа нүүдэлч малчид, жижиг аж ахуй эрхлэгчид) олон тооны мал хүн амын суурьшилтай ойр төвлөрсөн байдаг (*Бүлэг 7-г үзнэ үү: Малын байр*). Эдгээр орчинд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, ариун цэвэр эрүүл ахуйн нөхцөлийг хангах замаар мал амьтан, хүн амын аюулгүй байдлыг хангана.

Бэлэн мөнгө, эрхийн бичиг болон мал, амьтны үзэсгэлэн худалдааг ашиглах

Малжуулах үйл ажиллагаанд ашигладаг арга барил цаг хугацааны туршид өөрчлөгдсөөр иржээ. 1990-ээд онд ихэнх тусламжийн байгууллагууд нь орон нутгийн худалдаачидтай гэрээлэх замаар үржлийн мал худалдан авч, тараадаг байв. Зарим тохиолдолд хонь, ямааг олон зуугаар нь худалдан авч, иргэдийн амьдарч буй газар хүргэж, улмаар хүлээн авч буй хүн бүр ээлжээр сонголтоо хийж хүлээн авдаг байв. Энэхүү арга зам нь сайн болон тааруу малыг тэгш хуваарилах боломж олгож байжээ.

Өнөөдөр бэлэн мөнгө, эрхийн бичгээр дамжуулан тусламж үзүүлэх нь (CVA) ерөнхийдөө түлхүү хэрэглэдэг арга бөгөөд учир нь хүлээн авагчид нь илүү сайн сонголтыг өөрсдөө хийх, орон нутгийн зах зээлийн боломжийг бүрэн ашиглах (Бэлэн мөнгө, эрхийн бичгийн талаарх Бүлэг 3-г үзнэ үү) уян хатан боломжийг олгодог. Энэхүү аргачлалын хүрээнд, орон нутгийн захын удирдлагатай тохиролцсоны үндсэн дээр хүлээн авагч өрхүүдэд мал, амьтан худалдан авахад зориулан бэлэн мөнгө эсвэл эрхийн бичиг олгодог. (Мал аж ахуйд суурилсан хөрөнгийг нөхөн сэргээхэд зориулан мөнгөн шилжүүлэг ашигласан. Нөлөөллийн кейс судалгаа: Бэлэн мөнгөний эрхийн бичиг ашиглан мал сүргийг нөхөн сэргээсэн Кени улсын туршлага хэсгийг үзнэ үү).



Мөн орон нутгийн захуудад зар түгээснээр мал, амьтны үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, үүнд малчид, мал бүхий иргэд урьдчилан заасан нас, хүйс, төрөл болон үүлдрийн илүүдэл малаа зарж борлуулах зорилгоор авчирч болно. Малын үзэсгэлэн худалдаа болох өдөр тусламжийн байгууллагууд нь урьдчилан тодорхойлсон малын төрөл, тооны дагуу мал, амьтан худалдан авахад зориулан бэлэн мөнгө, эрхийн бичиг тараадаг. Жишээ нь, үйл ажиллагаа нь зөвхөн гунж эсвэл эм хонь, ямааг борлуулахад төвлөрч болно. Аль ч арга замыг сонгосноос үл хамааран мал хүлээн авагчид нь худалдан авч болох мал, амьтны төрөл тооны талаар урьдчилан сайтар ойлгосон байх ёстой. Худалдаа хийгдсэний дараагаар тусламжийн байгууллага нь борлуулагч талд эрхийн бичгийн дагуу төлбөрийг хийнэ. Малжуулах үйл ажиллагааны аль ч хувилбарт мал, амьтны үзэсгэлэн худалдаа нь тохиромжтой байдаг. Зах зээлийн арга хэмжээ, үзэсгэлэн худалдаа нь мөн харилцан мэдээлэл, туршлага, мэдлэг хуваалцах боломжийг бүрдүүлдэг (Нөлөөллийн кейс судалгааг үзнэ үү: Нигер улс дахь мал, амьтны үзэсгэлэн худалдаа).

Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зэргээр дамжуулан бэлэн мөнгө, эрхийн бичгийг ашиглах нь дотоод зах зээлийн тогтолцоо, уян хатан сонголтыг дэмждэг ч хамгийн сайн, шилдэг малаа зарах малчид, аж ахуй эрхлэгчид цөөн байдгийг санах нь чухал. Тиймээс мал хүлээн авагчид нь онцгой байдлын өмнө, тайван цагт эзэмшиж байсан удамшлын сангаа сэргээхийн тулд олон жилийн туршид үржлийн чиглэлд анхаарал хандуулан ажиллах шаардлагатай болдог.

Хуаран (Кемп)

Дотоодын шилжин суурьшигчдын амьдарч буй газрууд, дүрвэгчдийн хуаранд малжуулах ажиллагааг кемп-н удирдлагатай тохиролцсоны үндсэн дээр хэрэгжүүлнэ. Учир нь мал, амьтны төрлөөс хамааран эрүүл мэнд, ариун цэвэр, орон нутаг бэлчээр, усны ашиглалтад ихээхэн нөлөөтэй байдаг. Кемп-н мал, амьтан өвс тэжээл, усны төлөө орон нутгийн мал, амьтан бүхий иргэдийн хооронд маргаан зөрчилдөөн үүсэх магадлалтай. Тиймээс хонь, ямаа, ялангуяа үхэр тараах бол энэ талаар сайтар эргэцүүлж, тухайн орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх шаардлагатай. Энэхүү зөвлөлдөх арга хэмжээ нь ихээхэн чухал ач холбогдолтой бөгөөд хэдий кемпүүд түр хугацаагаар байрлах зориулалттай ч зарим тохиолдолд удаан хугацаанд тухайн нутагт байршдаг. Тиймээс малжуулах үйл ажиллагааг дутуу төлөвлөх нь удаан үргэлжлэх зөрчилдөөний эх үүсвэр болно (*Бүлэг 7-г үзнэ үү: Малын байр*).

Дүрвэгчдийн кемп болон дотооддоо шилжин суурьшигчдад тусламж үзүүлж буй талуудын хувьд тахиа шувуу нь хамгийн эхний сонголт байдаг ба энэ нь орон нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байдагтай холбоотой. Гэрийн



шувуу нь хүлээн авагчийн гэр/ майхны орчмоор хоол тэжээлээ олдог ба энэ нь тухайн орчны иргэд хүнсний ногоо, цэцэг ургамал тариалдаг тохиолдолд л асуудал үүсгэдэг. Тариалангийн бус нутагт зөвхөн гэрийн шувууг байранд хашин тэжээх нөхцөлтэйгөөр үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёстой. Ингэх нь мал, амьтны өтгөн ялгадастай хүүхэд харьцахаас сэргийлэх бөгөөд эрүүл мэндийн хувьд ч мөн оновчтой сонголт юм.


Хаших боломжгүй газар нутагт хүлээн авагч талуудыг кемпийн зах хэсэг рүү нүүлгэж болно. Ингэснээр мал, амьтан нь кемпээс гадагш бэлчиж, байгалийн тэжээлийг иднэ. Ямар ч арга хэмжээг орон нутагтай тохирч зөвшилцсөний дагуу хэрэгжүүлэх ба малын тоо толгойг өрх нэг бүрт мөн төрөл тус бүр дээр тохиролцсон хэмжээнээс хэтрүүлэн өгөхгүй байх нь чухал.

Малжуулах үйл ажиллагааны хувилбарыг тодорхойлох шийдвэрийн мод


Шийдвэрийн мод (*Зураг 9.1*) нь малжуулах үйл ажиллагаанд ямар арга зам нь хамгийн тохиромжтой, аль нь зөв хувилбар болохыг сонгоход харгалзан үзэх гол асуултуудыг тоймлон гаргасан байдаг. Хамаарах стандартууд, үндсэн ажиллагаа, зааварчилгаа нь нарийвчилсан төлөвлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгнө.



Зураг 9.1: Малжуулах үйл ажиллагааны шийдвэрийн мод



*Үр дүн нь 'No action' буюу Үйл ажиллагаа шаардлагагүй гэж гарч буй нь ямар нэгэн үйл ажиллагаа огт хийхгүй гэсэн үг бус харин "Тийм" гэсэн хариулт өгөхийн тулд цаашид сургалт, чадавч бэхжүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэнэ.





Стандартууд

Стандарт 1: Үнэлгээ төлөвлөлт

Малжуулах үйл ажиллагаанд хийх үнэлгээ нь төрөл бүрийн амьжиргааны хэлбэрийн хувьд мал амьтны үүрэг роль, боломжит нөлөөлөл, эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаарх иж бүрэн дүн шинжилгээ юм.

Үндсэн үйл ажиллагаа

- Орон нутгийн амьжиргаанд мал, амьтны үүрэг ролийг харгалзан үзэх (*Удирдамж 1-г үзнэ үү*).
- Үйл ажиллагаа нь орон нутгийн мал аж ахуй, эдийн засаг, түүнчлэн малын тавлаг байдал, байгаль орчин болон аюулгүй байдалд үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг үнэлэх (*Удирдамж 2-г үзнэ үү*).
- Өмнө нь мал, амьтан, маллаж байсан туршлагагүй хүмүүсийг малжуулахаар төлөвлөж буй бол хүлээн авагч талд шаардлагатай бүхий л нөөц байгаа эсэхийг анхааралтай үнэлэх. Эдгээр нөөцөд тэжээл, ус, байр, малын эрүүл мэндийн үйлчилгээ, ажиллах хүч, нийгмийн харилцаа холбоо зэрэг багтана (*Удирдамж 3-г үзнэ үү*).
- Зардалтай холбоотой бүхий л нарийвчилсан үнэлгээг иж бүрнээр нь хийх (*Удирдамж 4-г үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Мал амьтан ба амьжиргаа

Малжуулах үйл ажиллагааг хийхдээ мал аж ахуй нь тухайн хүлээн авагч талын амьжиргаанд “энгийн үед” ямар үүрэг рольтой байдаг талаар нарийвчилсан ойлголт, мэдээлэлтэй байх шаардлагатай. Энэхүү үнэлгээнд мал, амьтны төрөл болон тоо, мал аж ахуйн удирдлагын систем, малчдын үр чадвар, туршлага, мэдлэг зэргийг хамруулах хэрэгтэй.

Хүлээн авагч талууд нь бүтээмжит нөөц болох газар, ус, байр, малын эрүүл мэндийн үйлчилгээ болон зах зээлийн боломжтой нөхцөлд бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид, мөн жижиг аж ахуй эрхлэгчдэд малжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь амжилттай болдог. Мөн хүлээн авагч нь мал аж ахуйгаа амжилттай явуулахад шаардлагатай ажиллах хүч, нийгмийн харилцаа холбоотой байх шаардлагатай. Мал сүргийн амьжиргаа, мал аж ахуйн менежментэд үзүүлэх үүрэг рольд хийх анхдагч үнэлгээний шалгах хуудсыг *Бүлэг 3: Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөлт; Хавсралт 9.1: Малжуулах үйл ажиллагааны үнэлгээний шалгах хуудаснаас* харна уу.



2. Үр дагавар ба эрсдэлийг бууруулах арга хэмжээ

Мал, амьтан худалдан авах, тэр ч байтугай малжуулах үйл ажиллагааны зар тарахад л зах зээлийн үнэнд өөрчлөлт гардаг. Ийнхүү үнийн өсөлт гарах нь гамшгийн дараа өөрийн мал аж ахуйгаа бие даан сэргээж буй чинээлэг өрхүүд, худалдаачдын хувьд санаа зовних асуудал болох ба харин худалдан авч байгаагаас илүү тоогоор борлуулдаг орон нутгийн үйлдвэрлэгчдийн хувьд өгөөжтэй хэрэг болно. Зөвхөн дан ганц үнийн өсөлтөөс шалтгаалан малжуулах үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулахаа зогсоож болохгүй. Ямар нэгэн зөрчилдөөнөөс зайлсхийх зорилгоор тусламжийн байгууллагууд нь худалдан авах ажиллагаагаа шат дараалалтай хийснээр зах зээлд үзүүлэх нөлөөллийг бууруулж болно (НҮБ-ын ХХААБ (2016, х.146) малжуулах үйл ажиллагааны эрсдэл, хувилбаруудыг үзнэ үү).

Гаднаас их хэмжээний мал, амьтан худалдан авах нь орон нутгийн байгаль орчны даацаас хэтрэх тохиолдолд энэ нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж эхэлнэ. Харин тусламжийн байгууллагууд нь мал, амьтныг орон нутгаас худалдан авсан эсвэл гамшигт хорогдсон малын тооноос цөөн тооны мал түгээсэн бол нөлөөлөл нь бага байна. Гэсэн ч байгаль орчныг хамгаалахад бүрэн хэмжээгээр анхаарал хандуулахын тулд байгаль орчинд нөлөөлөх байдлын түргэвчилсэн үнэлгээг хийхийг зөвлөдөг (*LEGS Зарчим 3: Уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчин сэдвийг үзнэ үү*).

Дотоодын шилжин суурьшигчид, дүрвэгчдийн кемп-д буй хүмүүс нь мал хүлээн авагч байх тохиолдолд дээрхийн ижил, нарийвчилсан үнэлгээг хийх шаардлагатай. Учир нь тухайн орчинд эрүүл мэнд, ариун цэвэр, аюулгүй байдлын илүү өргөн хүрээний стандартыг хангах хэрэгтэй болдог.

Үйл ажиллагаа эхлэхээс өмнөх үнэлгээний хүрээнд малын эрүүл мэнд, тавлаг байдал, хамаарах өвчний эрсдэлүүдийг мөн судалж шинжлэх шаардлагатай. Эдгээрийг тусгайлан үнэлэх нь тухайн мал, амьтныг үзэсгэлэн худалдааны өдрөөс өмнө хол замд хөлөөр нь туух эсвэл тээвэрлэн хүргэх, мөн хүлээн авагчдад тууж эсвэл тээвэрлэж хүргэхээс өмнө зах дээр эсвэл өөр газарт бөөгнүүлэн цуглуулах тохиолдлуудад илүү их ач холбогдолтой. Энэ бүх хугацаанд мал амьтан нь хангалттай ус, тэжээл, байраар хангагдсан байхын зэрэгцээ амрах хангалттай хугацаатай байх шаардлагатай (Малын тавлаг байдлын таван эрх чөлөө' нийтлэг зарчмыг *Бүлэг 1: LESG танилцуулга* хэсгээс үзнэ үү).

Эцэст нь энэхүү үнэлгээ нь малжуулах үйл ажиллагаанаас үүдэн гарах аюулгүй байдлын үр дагаврыг судлах ба энэ нь хүлээн авагч өрхүүд нь малын хулгай, зохион байгуулалттай дээрмийн бай болох эсэхийг тогтооход чиглэнэ. Бэлчээр, усны нөөц хомс эсвэл ногоо ургаж эхлэх үед малжуулах



үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зөрчилдөөний эх үүсвэр болж болзошгүй. Тиймээс аюулгүй байдлын асуудалтай, аюул учрах эрсдэлтэй, хулгайд өртөх эсвэл зөрчилдөөнийг үүсгэхээр бол малжуулах үйл ажиллагааг үргэлжлүүлэхийг зогсоох хэрэгтэй.

3. Мал аж ахуй эрхэлдэггүй хүмүүсийг малжуулах

Орон нутгийн амьжиргааны стратегид мал аж ахуй голлох үүрэг гүйцэтгэдэггүй тохиолдолд тусламжийн байгууллагууд нь үйл ажиллагааг төлөвлөхөөс өмнө дэлгэрэнгүй үнэлгээ хийх шаардлагатай.

Мал амьтанд цэвэр ус, чанартай тэжээл, байр, хамгаалалт шаардлагатай байдаг. Хэрэв хүлээн авагч тал нь эдгээр чухал хэрэгцээт зүйлсийг тогтвортой хангаж чадахгүй бол тухайн үйл ажиллагааг төлөвлөх шаардлагагүй. Тэр ч байтугай эдгээр нэн тэргүүнд шаардлагатай зүйлс хүртээмжтэй байсан ч мал аж ахуйг үр дүнтэй эрхлэхэд өдөр тутамд ажиллах хүч, мэдлэг, туршлага, үр чадвар, хүсэл эрмэлзэл ихээхэн шаардагдана.

Малжуулах үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй нөлөөллүүдийг хүлээн авагч өрхүүдийн эрэгтэй, эмэгтэй гишүүд, охид, хөвгүүдийг хамруулан үнэлэх хэрэгтэй ба үүнд хүүхдийн хөдөлмөрт үзүүлж болзошгүй нөлөөллийг мөн анхаарах хэрэгтэй. Түүнчлэн орон нутгийн зах зээлийн үнэлгээг бараа бүтээгдэхүүн борлуулалт болон мал амьтны худалдаанаас олж болох орлого зэргийг хамруулан хийх нь чухал. Үнэлгээгээр ямар нэгэн эргэлзээтэй зүйлс тогтоогдвол үйл ажиллагааг цааш үргэлжлүүлэн төлөвлөхгүй байх хэрэгтэй. (Үйл ажиллагааны кейс судалгаа: Пакистан улсад газар хөдлөлтийн дараа хэрэгжүүлсэн мал амьтан, тэжээл ханган нийлүүлэх үйл ажиллагаа. Мөн НҮБ-ын ХХААБ-ын гарын авлага (2016 х.146)-ын малжуулахтай холбоотой эрсдэл, бууруулах үйл ажиллагаа сэдвийг үзнэ үү). Эдгээр чухал шаардлагууд хангагдсаны дараа үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөж буй орон нутгийн мал хүлээн авагчдын онцлог хэрэгцээнд нийцсэн сургалтыг тодорхойлох, сургалтын үнэлгээг хийж гүйцэтгэх шаардлагатай.

4. Үр ашиг ба зардлын шинжилгээ

Малжуулах үйл ажиллагаанд гарах санхүүгийн болон үйл ажиллагааны зардлуудыг тооцохын зэрэгцээ тусламжийн байгууллагууд нь үр ашиг ба зардлын шинжилгээг нарийвчлан хийсний дараа үйл ажиллагааг хэрэгжүүлэх эсэхээ шийдэх нь зүйтэй.

Мөн түүнчлэн боломжит хувилбар тус бүр дээр үнэлгээ хийх шаардлагатай. Жишээ нь, гамшгийн улмаас цөөн тооны мал сүрэг үлдсэн нутагт малжуулах үйл ажиллагааны нийт зардлын тодорхой хувиар мал сүргийг нөхөн сэргээх түргэвчилсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой байж болох бөгөөд нэмэлтээр малын эрүүл мэнд болон шаардлагатай тохиолдолд чанартай,



нэмэлт тэжээлийн тусламжийг үзүүлж болно (Бүлэг 6: Мал эмнэлгийн үйлчилгээний дэмжлэг тусалцаа болон *Бүлэг 4: Малын тэжээл*).

Зарим бодлого, журмын хязгаарлалтууд үйл ажиллагааны зардалд мөн сөргөөр нөлөөлж болзошгүй. Үүнд гадаад (мал амьтан худалдан авах эсвэл шилжилт хөдөлгөөнтэй холбоотой зах зээлийн, хорио цээр, тээврийн татвар гэх мэт) болон дотоод хүчин зүйлээс хамаарсан (жишээ нь худалдан авч буй байгууллагын худалдан авах ажиллагааны журам гэх мэт) саад тотгорууд багтаж болно. Эдгээр нь үйл ажиллагааны хэрэгжилтийн явцыг сааруулж, улмаар зардал өсөхөд хүргэж болно.

Стандарт 2: Үйл ажиллагааны багцыг тодорхойлох

Мал хүлээн авахаар сонгогдсон хүмүүст эдийн засгийн ашигтай, тогтвортой үр өгөөж хүртээхийн тулд зөв зохистой арга механизмыг ашиглан, өөр өөр төрлийн болон үүлдрийн мал амьтныг хангалттай тоогоор өгөх

Үндсэн үйл ажиллагаа

- Нийлүүлж буй мал, амьтны нас, хүйс, төрөл, тоо, үүлдэр нь тухайн орон нутгийн агро-эдийн засаг, уур амьсгалын нөхцөлд нийцсэн, дасан зохицсон байхыг шалган баталгаажуулах (*Удирдамж 1-г үзнэ үү*).
- Малжуулах үйл ажиллагаанд сонгон авч буй мал нь эрүүл, үр өгөөж өгөхүйц байхыг баталгаажуулах (*Удирдамж 2-г үзнэ үү*).
- Мал хүлээн авагчдыг сонгохдоо орон нутагтай зөвшилцөн гаргасан шалгууруудад үндэслэх (*Удирдамж 3-г үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Мал, амьтныг сонгох

Малжуулах үйл ажиллагааны хүрээнд олгож буй мал, амьтны нас, хүйс, үүлдэр, тоо, төрөл зэрэг нь мал хүлээн авагч талын амьжиргааны шаардлагад нийцэж байх нь чухал. Үүнд мөн эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээ, тэргүүлэх ач холбогдлыг нь мөн харгалзан үзнэ. Үндсэндээ үржлийн насны залуу эм мал, үржлийн эр мал хамгийн өндөр ач холбогдолтой бөгөөд энэ нь мал хүлээн авагчдад өөрийн мал сүргийг сэргээх боломжийг бүрдүүлнэ. Харин газар хагалах зэрэг зориулалтаар мал өгөх тохиолдолд эр мал, амьтан сонгох нь тохиромжтой.

Бэлчээрийн мал аж ахуй бүхий бүс нутагт тодорхой хугацаанд үр өгөөж бүхий сүрэг бүрдэх боломжийг бий болгоход шаардагдах тооны үржлийн цөм малыг хангалттай тоогоор олгох нь чухал (*Хавсралт 9.3-г үзнэ үү*: Сүргийн боломжит доод хэмжээ; Үйл ажиллагааны кейс судалгаа: Этиоп



улс дахь мал сүрэг нөхөн сэргээхэд нутгийн иргэдийн оруулсан хувь нэмэр).

Үндсэндээ мал амьтны тоо хэмжээ нь тухайн хүлээн авагч өрх нэг бүрийн хэрэгцээнд тулгуурласан байх шаардлагатай. Гэвч өмнөх туршлагаас үзвэл өрхийн гишүүдийн тооноос үл хамааран стандарт тооны малыг өрх бүрд түгээх нь илүү түгээмэл байдаг. Ингэснээр бүх өрхөд тэгш хандаж, өрх нэг бүрд хамаарах зардал нь ч ижил байх нөхцөлийг бүрдүүлдэг.

Цаашид тэжээлийн чанар болон аж ахуйн менежментийн хомсдолын улмаас цаг хугацааны туршид ашиг шим нь буурдаг импортын болон харь мал амьтнаас илүүтэйгээр орон нутгийн малчдын сайн мэдэх үүлдэр угсааны мал нь олон тоогоор өсөн үржих боломжтой байдаг (*НҮБ-ын ХХААБ, 2016, хуудас 146–151 мал амьтны үзүүлэлт болон хяналтын шалгуур*). Малыг орон нутгаас худалдан авснаар тус нутгийн малчид болон зах зээлд нь дэмжлэг болно. Мөн түүнчлэн энэ нь хол зайнаас эсвэл хөрш улсаас оруулж ирэх малын шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй тээвэрлэлт, эрүүл мэнд, байгаль орчин, малын тавлаг байдал болон санхүүгийн асуудлуудаас зайлсхийх боломжийг олгоно.

Өргөн хүрээг хамарсан гамшгийн улмаас малын тоо толгой их хэмжээгээр хорогдсон нутагт хангалттай тооны мал амьтныг орон нутгийн зах зээлээс худалдан авах боломжгүй байж болно. Ийм тохиолдолд тусламжийн байгууллагууд нь илүү хол зайд орших зах зээлээс худалдан авалт хийх шаардлагатай болдог ба худалдан авч буй бүх мал амьтан нь орон нутгийн агро-экологийн нөхцөлд, үүнд уур амьсгалын болон улирлын гаралтай өвчлөлийн хэв шинжид зохицсон байх ёстой ба ийм мал амьтан нь цаашид өсөж үржин, илүү үр өгөөж хүртээх нь зайлшгүй.

Тусламжийн байгууллагууд нь зөрчил мөргөлдөөн бүхий нөхцөлд эсвэл дээрэм тонуул түгээмэл гарч буй аюултай орчин нөхцөлд малжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа бол дээрэмдсэн мал амьтан авахаас сэргийлэх шаардлагатай. Хэрэв үүнтэй холбоотой ямар нэгэн эргэлзээ байгаа тохиолдолд мал түгээх ажлыг хойшлуулах хэрэгтэй.

2. Мал эмнэлгийн үзлэг

Малжуулах үйл ажиллагаанд зориулан сонгон авсан мал нь эрүүл, үржил шимтэй, хэрэв залуу мал түгээж буй бол цаашид үр шим өгөхүйц байх шаардлагатай. Худалдан авах үед мэргэжлийн малын эмч эсвэл мал эмнэлгийн техникч малд үзлэг хийх нь зүйтэй. Үзлэгийг үндсэндээ худалдан авч буй цэг дээр буюу жишээ нь зах, малыг хашсан газар эсвэл хорио цээрийн байгууламж зэрэг дээр хийнэ. Үзлэг хийж буй малын эмч нь төрийн мал эмнэлгийн нэгж эсвэл гэрээгээр ажиллаж буй орон нутгийн мал эмнэлэг ч байж болно.



Мал эмнэлгийн үзлэгээр өвчлөлтэй холбоотой гол асуудлуудыг тогтоож, эрүүл мэндийн хувьд тогтворгүй мал, амьтныг малжуулах үйл ажиллагаанаас хасна. Сонгон авсан мал амьтныг чихний ээмэг, зүүлт эсвэл тамга ашиглан тодорхойлно. Ийнхүү ээмэглэх, тэмдэглэх малтай харьцах үйл явц нь малын тавлаг байдлын стандартад нийцсэн байх ёстой. *Бүлэг 1: LEGS танилцуулга- Малын тавлаг байдал*, болон НҮБ-ын ХХААБ (2016, хуудас. 151–152) мал тэмдэглэх зэргийг үзнэ үү.

3. Мал хүлээн авагч талыг сонгох

Хүлээн авагч талыг сонгох үйл ажиллагааны хүрээнд тэдэнд байх шаардлагатай үр чадвар, чадамж, туршлага, шаардлагатай нөөцийн хүртээмж зэргийг үнэлэх шаардлагатай. Өмнө нь мал маллаж байсан туршлагагүй хүмүүсийн хувьд мал хүлээн авах сонирхлоо өндрөөр илэрхийлэх, шаардлагатай нөөцийн хүртээмж нь хангагдсан, суралцах хүсэлтэй буйгаа илтгэн харуулсан байх ёстой.

Мал хүлээн авагч талын сонирхол, хүсэл эрмэлзэл нь ямар нэгэн асуудалтай байвал тухайн өрхийг сонгож болохгүй. Ийм шийдвэр гаргах үйл явцад уламжлалт болон орон нутгийн иргэдийн бүлгийн удирдагчид оролцсон тохиолдолд л үр дүнтэй болдог. НҮБ-ын ХХААБ (2016, х.148) малжуулалтад хамрагдаж буй нутгийн иргэдийн үүрэг, хариуцлагын талаарх сэдвийг үзнэ үү.

Стандарт 3: Түгээлтийн тогтолцоо

Мал амьтныг хүлээн авагч талд түгээх үйл явц нь үр ашигтай байдлыг хангаж, зардлыг хэмнэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэл, бүтээмжид аль болох хурдан хугацаанд өгөөж өгөхүйц байх хэрэгтэй.

Үндсэн үйл ажиллагаа

- Худалдан авах ажиллагаа нь тогтоосон шалгуурт нийцэж, худалдан авалтын талаарх хуульд заасан бүхий л журмыг даган мөрдөх (*Удирдамж 1-г үзнэ үү*).
- Бэлэн мөнгө, эрхийн бичиг, үзэсгэлэн худалдааг бүрэн ашиглах (*Удирдамж 2-г үзнэ үү*).
- Зөвхөн онцгой нөхцөлд л зээлийн систем ашиглан малжуулах. Бусад бүх тохиолдолд мал амьтныг буцалтгүй тусламж хэлбэрээр олгох (*Удирдамж 3-г үзнэ үү*).
- Боломжтой бол мал амьтны уламжлалт түгээлтийн тогтолцоог чиглэл болгон ашиглах (*Удирдамж 4-г үзнэ үү*).
- Малжуулах үйл ажиллагааг улирлын хувьд тохиромжтой, мал өсөх, үр шим өгч эхлэхүйц үед хийх (*Удирдамж 5-г үзнэ үү*).
- Тээвэрлэх үед тулгарах эрсдэл, хорогдлыг бууруулахын тулд малын



тавлаг байдлыг хангах нөхцлийн дагуу тээвэрлэх үйл ажиллагааг урьдчилан төлөвлөх (*Удирдамж 6 дээр үзнэ үү*).

Зааварчилгаа

1. Худалдан авах ажиллагааны журам

Малжуулах үйл ажиллагаанд оролцож буй байгууллагууд нь мал, амьтан худалдан авах болон түгээхтэй холбоотой бүхий л дүрэм журам, үүнд татвар, хорио цээр, хил нэвтрэх журам зэргийг даган мөрдөх нь чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь хэрэгжүүлж буй арга хэмжээний үр ашигтай байдалд нөлөөлнө. Жишээ нь татварын улмаас үйл ажиллагааны зардал нэмэгдэх, хорио цээрийн шаардлагууд (өвчний хяналт, гэрчилгээжүүлэх арга хэмжээ авах үүрэг үүссэн гэх мэт) нь түгээлтийг саатуулж, зардлыг өсгөнө. НҮБ-ын ХХААБ-ын гаргасан (2016, хуудас. 141–144) малын эрүүл мэндийн үйлчилгээ, чанарын хяналтын шаардлагуудыг харна уу.

2. Бэлэн мөнгө, эрхийн бичиг, малын үзэсгэлэн худалдаа ашиглах нь

Боломжтой бол бэлэн мөнгө, эрхийн бичиг олгох эсвэл мал, амьтны үзэсгэлэн худалдаа зохион байгуулах замаар мал, амьтан сонгоход хүлээн авагч өөрсдөө оролцох оролцоог нь хангах нь чухал. Мал, амьтныг хүлээн авагч өөрөө сонгох эсвэл тэднийг төлөөлөх этгээд (орон нутгийн экспертүүд, худалдаачид эсвэл өндөр настнууд гэх мэт) сонгохоос үл хамааран бэлэн мөнгө, эрхийн бичиг, үзэсгэлэн худалдаа ашиглах нь хамгийн тохиромжтой малаа сонгоход дэм болно. Сүүлийн жилүүдэд бэлэн мөнгө, эрхийн бичиг, үзэсгэлэн худалдааг шууд түгээлтээс илүү ихээр хэрэглэх болжээ.

Тухайн түгээлтийн механизмыг хэрэглэхээс өмнө хэрэгжүүлж буй байгууллагууд нь орон нутгийн зах зээлийн үнэнд үнэлгээ хийж, мал амьтны үнэ цэнийг тодорхойлох шаардлагатай. Энэ нь нийт худалдан авалтын үйл ажиллагааг боломжит санхүүжилтээр дэмжих боломжийг олгоно.

3. Бүтээмжид сөргөөр нөлөөлөхгүй зээлийн тогтолцоо

Юуны өмнө тухайн малжуулах үйл ажиллагаа нь зээл эсвэл буцалтгүй бэлэг хэлбэрээр байх эсэх талаар төлөвлөлтийн шатанд шийдвэр гаргасан байх шаардлагатай. Хэрэв зээлээр олгох бол эргэн төлөлтийг ямар хэлбэрээр хийх талаар мөн шийдсэн байх нь чухал бөгөөд үүнийг мал хүлээн авагчидтай нягт зөвлөлдөж, бүхий л оролцогч өрхүүдийн сайтар ойлголт, хүсэл эрмэлзэл дээр үндэслэн хийнэ. Зээлээр малжуулж буй тохиолдолд эргэн төлөлтийг гарсан төлөөр нь эсвэл бэлэн мөнгөөр хийхээр тохиролцож болно. Эргэн төлөлт бэлэн мөнгөөр хийгдэх бол нутгийн иргэдийг зах зээлийн эдийн засагтай уялдуулан нэгтгэхийг шаардана. Тиймээс ихэнх тохиолдолд малаас гарсан төлөөр эргэн төлөлт хийх хэлбэр нь хамгийн



тохиромжтой, уламжлалт тогтолцоонд суурилан хийгдэх боломжтой байдаг.

Эргэн төлөлтийн нөхцөлийг малын төрөл, нөхцөл болон эргэн төлөлтийн хугацаа гэх мэтийг харгалзан анхааралтай, нарийн төлөвлөх ёстой. Үүний зорилго нь тухайн эргэн төлөлт нь малжуулах үйл ажиллагааны үр дүнд бүрдсэн амьжиргааны чанарт нөлөөлөхгүй байхыг баталгаажуулахад оршино. Жишээ нь нийлүүлсэн мал нь бүтээмж муутай бол хүлээн авагч тал нь эргэн төлөлт хийхэд хүндрэлтэй тулгарч өрөнд орж болзошгүй. Мөн анхдагч хүлээн авагч талуудыг тодорхойлохтой зэрэгцэн хоёрдогч хүлээн авагчдыг (бэлэн мөнгө эсвэл анхдагч хүлээн авагчаас төл мал хүлээн авах) тодорхойлж, эргэн төлөлтөд нарийн хяналт хийж байх шаардлагатай. НҮБ-ын ХХААБ (2016, х.136) гаргасан баримт бичиг дээр зээл эсвэл бэлэглэх хэлбэрээр малжуулах сэдвийг үзнэ үү.

4. Дахин түгээлтийн уламжлалт тогтолцоо

Нүүдэлч малчдын нутагт гэрлэлт, гэр бүл найз нөхөд хоорондын харилцаа, олон нийтийн дэмжлэг туслалцааны хүрээнд өндөр ашиг шим бүхий мал хэрэгцээтэй байгаа өрхүүдэд бэлэг, зээл хэлбэрээр малыг шилжүүлэх, солилцоо хийх харилцаа байдаг. Жишээ нь саалийн ингэгүй нэгэндээ ингэ зээлээр хэрэглүүлэх замаар сүүний хангамжийг нь шийдэж байдаг. Тиймээс малжуулах үйл ажиллагаа нь боломжтой бүхий л нөхцөлд дахин түгээлтийн уламжлалт тогтолцоотой нийцэж, үүнийг дэмжиж, зохицож ажиллах ёстой. Жишээ нь хүлээн авах талуудыг сонгоход нутгийн удирдагчидтай хамтрах, үүнд эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхнийг хамруулах талаар зөвшилцсөн байх хэрэгтэй. Ингэснээр уламжлалт дахин түгээлтийн институт, механизм нь малжуулах үйл ажиллагаа дууссаны дараа ч хувь нэмрээ үргэлжлүүлэн оруулсаар байдаг. Боломжтой, зохистой бүхий л тохиолдолд хүлээн авагчдыг сонгох үйл явцыг уламжлалт дахин түгээлтийн тогтолцоо, арга ажиллагаатай холбон уялдуулах хэрэгтэй.

5. Түгээлтийн цаг хугацаа

Ямар ч механизм ашигласан байгалийн тэжээл, усан хангамж элбэгтэй улирлын эхэнд түгээлтээ хийх хэрэгтэй ба үүний тулд орон нутгийн мэдлэг, туршлагыг сайтар ашиглах хэрэгтэй. Ингэснээр мал тарга хүч авах, ашиг шим өгөх боломж нэмэгдэж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл буурна. Өвчлөлийн улирлын хуанлид үндэслэн мал аж ахуйн үйлдвэрлэл, ашиг шимд сөрөг нөлөө үзүүлж болох орон нутагт улирлын чанартай гардаг өвчний эсрэг дархлаажуулалтад хамруулах шаардлагатай.

6. Тээвэрлэлтийн төлөвлөлт

Мал, амьтны тээвэрлэлтийн хүрээнд тээвэрлэх хуваарь, хугацаа, цаг агаарын нөхцөл байдал, зай, гаалийн ажиллах хуваарь, шилжүүлэн ачих



цаг, услах болон тэжээх (мөн саах) хугацаа зэргийг урьдчилан маш сайн төлөвлөсөн байх шаардлагатай. Тэжээх, услах болон саах тоног төхөөрөмж, ханган нийлүүлэлтийг ч мөн төлөвлөх нь зүйтэй. Тээвэрлэлтийн нөхцөл байдал, туулах зам нь малын тавлаг байдлын 5 зарчмыг хангаж байх шаардлагатай (Бүлэг 1-г үзнэ үү: LEGS танилцуулга). Тээвэрлэлт гүйцэтгэж буй тал нь шахалдаж хорогдохоос сэргийлэхийн тулд малын тоог хэтрүүлэн ачихгүй байх, зогсох хангалттай зайтайгаар ачих зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай. Мөн тээвэрлэлтийн үед унахаас сэргийлэн багцлан (төрлөөс нь хамааран) ачсан байна. Ачихын өмнө болон дараа машиныг сайтар ариутгаж, зохих хэмжээнд агааржуулсан байна.

Түгээх цэг ч мөн адил хангалттай хэмжээнд бэлтгэгдэж, ус, тэжээл, байр, хашаа хороо зэрэг нь хангалттай хэмжээнд байх шаардлагатай.

Стандарт 4: Үр шим хүртэгчдэд үзүүлэх нэмэлт тусламж

Амьжиргааны эерэг, тогтвортой байдлыг хангах зорилгоор үр шим хүртэгчдэд мал эмнэлгийн үйлчилгээ, сургалт болон бусад амьжиргаа дэмжих чиглэлийн нэмэлт тусламжийг үзүүлэх.

Үндсэн үйл ажиллагаа

- Түгээлт эхлэхээс өмнө мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх (*Удирдамж 1-г үзнэ үү*).
- Мал эмнэлгийн байнгын тасралтгүй үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх (*Удирдамж 2-г үзнэ үү*).
- Мал аж ахуйн мэдлэг, үр чадварын хүрээнд хийсэн дүн шинжилгээний үр дүнд үндэслэн сургалт, чадавх бэхжүүлэх дэмжлэг тусалцааг үзүүлэх (*Удирдамж 3-г үзнэ үү*).
- Сургалт, чадавхжуулах үйл ажиллагаанд ирээдүйд үүсэж болох хямрал, гамшгийн бэлэн байдлыг тусгах (*Удирдамж 4-г үзнэ үү*).
- Малаа эрт борлуулахаас сэргийлэн Sphere гарын авлагын “Хүнсний баталгаат байдал, хоол тэжээллэгийн минимум стандартууд”-ыг хангах (*Удирдамж 5-г үзнэ үү*).
- Sphere гарын авлагын “Орон байр, суурьшил” стандартын дагуу хэрэгцээг тодорхойлж, малын байр, хүнсний бус тусламжийн хэрэгцээг хангах (*Удирдамж 6-г үзнэ үү*).
- Мал сүргийн хэмжээ эсвэл эдийн засгийн бусад үйл ажиллагаа нь тусламж дэмжлэг шаардагдахгүй нөхцөлд хүрсэн тохиолдолд хүнсний аюулгүй байдалд чиглэсэн тусламжийг зогсоох (*Удирдамж 7-г үзнэ үү*).



Зааварчилгаа

1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ

Мал амьтан түгээж эхлэхээс өмнө тухайн малыг орон нутагт зохилон тохиолддог халдварт өвчний эсрэг вакцинжуулах, угаах болон эрүүл, ашиг шим өндөртэй байхад шаардагдах бусад үйлчилгээ, боловсруулалтыг заавал хийсэн байх шаардлагатай. Үндсэндээ энэхүү үйлчилгээг нэг удаа, үнэгүй хийдэг (Үйл ажиллагааны кейс судалгаа: Пакистан улсад газар хөдлөлтийн дараа эрсдэл бүхий өрхүүдийг малжуулсан туршлага, Нөлөөллийн кейс судалгаа: Иран улсад газар хөдлөлтийн дараа малжуулсан нь хэсгийг үзнэ үү). Мөн Засгийн газрын зүгээс малд вакцинжуулалт, угаалга, боловсруулалт хийлгэхэд тусгай шаардлага тавигддаг байх магадлалтай тул үүнийг нягтлан шалгах нь зүйтэй.

2. Урт хугацааны мал эмнэлгийн үйлчилгээ

Хүлээн авагч өрхүүд нь тухайн мал амьтан нь тэдний амьжиргаанд бүрэн хэмжээнд хувь нэмэр болж эхлэх хүртэл мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх, эмчилгээ үйлчилгээг хүлээн авсан хэвээр байх шаардлагатай. Энэхүү хугацаа нь хэдэн сараар эсвэл үүнээс ч урт хугацаагаар үргэлжилж болно. Үйлчилгээг хүргэхдээ мал эмнэлгийг үйлчилгээ үзүүлдэг ханган нийлүүлэгчдээр дамжуулан хүргэж болох ба үүнд малын эрүүл мэндийн ажилтнууд, хувийн мал эмнэлэг, хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж эсвэл төрийн мал эмнэлгийн нэгж зэрэг байж болно. Энэхүү урт хугацааны үйлчилгээг хэрэгжүүлэгч байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээлэл цуглуулах боломжийг мөн олгох хэрэгтэй. Малын эрүүл мэндийн үйлчилгээ, хамаарах сургалтууд нь Бүлэг 6 буюу Мал эмнэлгийн үйлчилгээний тусламж сэдэвт заасан стандарт, зааварчилгаанд нийцсэн байх шаардлагатай.

3. Сургалт, чадавхыг бэхжүүлэх

Мал хүлээн авагч нь мал аж ахуйн менежментийн чиглэлээр тодорхой мэдлэг, туршлагатай бол энэ чиглэлийн сургалтууд заавал шаардлагагүй байж болно. Гэсэн ч бусад нөхцөлд буюу хүлээн авагч нь мал аж ахуйн хувьд шинэ, эсвэл мэдлэг, үр чадвараа алдсан тохиолдолд мөн шинэ технологи гарч ирсэн бол дасан зохицох чадвар, бүтээмжийг нэмэх зэргийг хамарсан сургалт заавал шаардлагатай. Мал аж ахуйн салбарын зах зээл, нэмүү өртгийн сүлжээний талаарх сургалт, мэдээлэл өгөх нь урт хугацаандаа мал аж ахуйд суурилсан амьжиргааны үр ашгийг баталгаажуулах үр дүнтэй.

4. Ирээдүйд үүсч болзошгүй гамшгийн бэлэн байдал

Мал аж ахуйн менежментийн чиглэлээр туршлага багатай орон нутагт



гамшгийн бэлэн байдлын мэдлэг, үр чадварыг бүрдүүлэх нь тусламжийн байгууллагуудад ихээхэн дэм болно. Ингэснээр ирээдүйд учрах гарз хохирлыг бууруулдаг. Сургалтуудад тэжээл үйлдвэрлэл, малын эрүүл мэндийн үйлчилгээ, мал, амьтны борлуулалтын маркетинг, байр, хашаа хороог сайжруулах, усны эх үүсвэрийн хамгаалалт, ашиглалт зэрэг сэдэв багтаж болно (Бүлэг 4–8-г үзнэ үү).

5. Хүнсний аюулгүй байдлыг хангах тусламж

Мал амьтан хүлээн авагч өрхүүдийн хувьд малын тоо, ашиг шим эсвэл газар тариалангийн үйлдвэрлэл, ургацын хэмжээ нь онцгой байдал үүсэхээс өмнөх буюу хэвийн байдалдаа эргэн хүрэх хүртэл хүнсний хомсдолын түвшин өндөр хэмжээнд байсаар байна. Нөхөн сэргэх үе хүртэл мал хүлээн авагч өрхүүд нь өрхийн хэрэгцээгээ хангахын тулд тусламжийн малаа зарах, хэрэглэхэд хүрнэ.

Энэ шалтгааны улмаас хүлээн авагч өрхүүдийн хүнсний аюулгүй байдлын хэрэгцээнд үнэлгээ хийж, үүнд үндэслэн бүрэн хэмжээнд өгөөж хүртэж эхлэх хүртэл нэмэлт тусламж дэмжлэг үзүүлж байх шаардлагатай. Sphere гарын авлага дээр 'Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээллэгийн минимум стандартыг' заасан байдаг. Энэ төрлийн туламжид бэлэн мөнгө, эрхийн бичиг ашиглах нь тохиромжтой байж болно.

6. Малын байр, хүнсний бус тусламж

Мал хүлээн авч буй өрхүүдэд мөн малын байр, өрхийн нэн яаралтай хэрэгцээт зүйлс болох ор, усны сав гэх мэт, мөн мал аж ахуйд хамаарах хэрэгсэл болох тэрэг, анжис, буулга (оосор) зэрэг олон зүйлс шаардлагатай болно. Эдгээр зүйлсгүйгээр хүлээн авагч өрхүүд нь бусад хэрэгцээгээ хангах зорилгоор мал, амьтнаа зарж борлуулах шаардлага үүсэх тул малжуулах үйл ажиллагааг иж бүрэн үр дүнтэй ашиглаж чадахгүйд хүрнэ. Бэлэн мөнгө, эрхийн бичиг (CVA) ашиглан энэхүү хэрэгцээг хангах нь илүү тохиромжтой ба учир нь тухайн хувь хүн, өрх, иргэд нь авч буй малаа өөрийн тэргүүлэх хэрэгцээндээ нийцүүлэх уян хатан боломжийг олгоно.

7. Хүнсний аюулгүй байдал чиглэсэн тусламжийг зогсоох

Сүргийн тоо толгой өссөн эсвэл амьжиргааны бусад үйл ажиллагаа нь хүлээн авагч өрхийн амьжиргаанд дэмжлэг болж, мал амьтан борлуулах шаардлага үүсэхгүй болсноор тусламжийн байгууллагууд нь хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн тусламжаа зогсоож болно. Сайтар төлөвлөсөн, оролцоонд суурилсан хяналт-шинжилгээний тогтолцоонд энэхүү тусламжийг зогсоох боломжит хугацааг тодорхойлоход чиглэсэн сүргийн өсөлт болон амьжиргааны бусад үзүүлэлтүүдийг хэмжиж, үнэлэх арга замыг тусгаж болно.



Хавсралтууд

Хавсралт 9.1: Малжуулах үйл ажиллагааны үнэлгээний шалгах хуудас

Хувилбар болон үр дагавар

- Онцгой байдал үүсэхээс өмнө мал, амьтан нь ямар үүрэгтэй байсан бэ?
 - Амьжиргааны гол хөрөнгө ?
 - Нэмэлт хоол хүнсний хангамж?
 - Орлого?
 - Тээвэр, ачлага, уналга?
- Ямар төрөл, үүлдрийн мал амьтан үржүүлж байсан бэ? Хэн? Ямар зориулалтаар?
- Ямар төрөл, үүлдрийн мал, амьтан хорогдож, нөхөн сэргээх шаардлагатай болсон бэ?
- Хэрэв мал амьтан нь амьжиргааны стратегийн үндсэн хэсэг байсан бол:
 - Хүнсний нэмэлт хангамж эсвэл орлогын бус хэрэгцээг хангах зорилгоор малжуулах боломж байгаа юу?
 - Ямар төрөл, үүлдрийг түгээхэд хамгийн тохиромжтой байх вэ?
- Малжуулахаас өөр сонголт бүхий, зардлын хувьд хэмнэлттэй хувилбарыг судлаж байгаа юу?
- Мал хөрөнгө дахин хуваарилалтын уламжлалт ямар механизм тухайн орон нутагт байна вэ?
- Тухайн орон нутагт хамгийн багадаа хэдэн тооны мал амьтан нэг өрхийн ашигтай сүргийг бүрдүүлэх вэ?
- Тухайн орон нутагт дээрх хамгийн бага тоогоор тооцон мал амьтан түгээхэд ямар үр дагавар гарах вэ?
 - Тухайн газарт хангалттай хэмжээний бэлчээр, тэжээлийн нөөц байна уу?
 - Усан хангамж хангалттай юу?
 - Малын байр хангалттай бэлэн эсэх эсвэл барьж байгуулах боломжтой эсэх?
 - Мал амьтан аюулгүй байж чадах уу, эсвэл малчид болон/эсвэл мал амьтанд эрсдэл учруулах үйл ажиллагаа байна уу?
 - Тухайн нутагт малын эрүүл мэндийн үйлчилгээ байна уу?



Хүлээн авагч

- Хүлээн авагч өрхүүд ирээдүйд мал аж ахуйгаа амжилттай удирдаж явахад нь зориулан нийгэм, байгаль, амьжиргааны ямар хөрөнгийг бүрдүүлэх шаардлагатай вэ?
- Шаардлагатай тохиолдолд мал аж ахуйн менежментийн сургалт хийх боломжтой юу?
- Мал аж ахуйн менежментэд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд ямар үүрэг рольтой вэ? Мал аж ахуйн үйлдвэрлэлд эмэгтэйчүүд шинэ үүрэг гүйцэтгэх хүсэлтэй байна уу? Малжуулснаар хөдөлмөрлөх үүрэгт ямар үр дагавар үүсэн гарах вэ?
- Мал аж ахуйн менежмент, мал амьтны бүтээгдэхүүний хүртээмжтэй холбоотой эрсдэлтэй бүлгийн тодорхой ямар хэрэгцээ байна вэ?
- Хүлээн авагч өрхүүдэд мал амьтантай холбоотой тусламж үзүүлэх хангалттай нөөц (жишээ нь мал эмнэлгийн үйлчилгээ, тэжээл, байр) байна уу?
- Хүлээн авагч өрхүүдэд үзүүлэх мал амьтантай холбоотой бус тусламжийн хангалттай нөөц (жишээ нь хүнс, сүрэг нөхөн сэргэх хүртэл үзүүлэх бусад амьжиргааны дэмжлэг) байна уу?

Худалдан авах ажиллагаа

- Орон нутгийн зах зээлээс их хэмжээний мал амьтан худалдан авахад ямар үр дагавар гарч болох вэ?
- Хүлээн авагч иргэдэд тээвэрлэн хүргэхэд боломжтой зайд хангалттай тооны худалдан авах мал амьтан байна уу?
- Тээвэрлэх боломжтой эсвэл тавлаг байдлыг нь алдагдуулалгүйгээр мал сүргийг тээвэрлэх боломжтой юу?
- Өөр бүс нутгаас мал амьтан тээвэрлэж авчрахад өвчин тархах эрсдэл хэр байна вэ?



Хавсралт 9.2: Малжуулах үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүдийн жишээ

	Үйл явцын шалгуур үзүүлэлт (үйл ажиллагааны хэрэгжилтийг хэмжих)	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (үйл ажиллагааны үр дүнг хэмжих)
Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах	Нутгийн иргэдийн төлөөлөл болон бусад оролцогч талууд, үүнд шаардлагатай тохиолдолд хувийн хэвшлийн ханган нийлүүлэгчидтэй хийсэн уулзалтуудын тоо Зохион байгуулсан уулзалтууд нь төрөл бүрийн бүлэг, гендер болон насны бүлгүүдийг багтаасан эсэх	Малжуулах хувилбарт хийсэн дүн шинжилгээг багтаасан уулзалт, хурлын тайлангууд Жендер-насны бүлгүүдийн тэргүүлэх чиглэлийг ялган тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөө: • Төрөл бүрийн оролцогч талуудын үүрэг хариуцлага • Хүлээн авагч өрхүүдийг сонгох орон нутгийн үйл явц, шалгуур үзүүлэлт • Мал амьтны төрөл, үүлдрийн талаарх нутгийн иргэдийн тэргүүлэх сонголт • Хүлээн авагч өрхүүдийн оролцоотой гаргасан худалдан авалт, тээвэрлэлт, түгээлтийн төлөвлөгөө, • Мал эмнэлгийн үзлэг, урьдчилан сэргийлэх үйлчилгээ
Мал аж ахуйд суурилсан хөрөнгийг нөхөн сэргээх: Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч өрхүүдийг үржлийн цөм малаар хангах	Өрх бүрд нийлүүлсэн мал амьтны тоо, малын төрлөөр Өрх бүрд үзүүлсэн нэмэлт тусламжийн төрөл, үнийн дүн (жишээ нь хүнсний тусламж, эд хэрэгсэл гэх мэт) Үйл ажиллагааны хэрэгжилт дэх эмэгтэйчүүдийн оролцоо	Нийлүүлсэн малын хорогдлыг өмнөх малын хорогдолтой харьцуулсан байдал Нийлүүлсэн малаас гарсан төлийн тоо, ашиглалт (жишээ нь зарах болон орлого олоход ашиглах) Хүний хоол хүнсний тэжээллэг чанар, мал хүлээн авсан өрхийн хүүхдүүдийн сүүний хэрэглээ Сүргийн өсөлт болон гаднын тусламжаас цаг хугацааны хамааралтай байдал



	Үйл явцын шалгуур үзүүлэлт (үйл ажиллагааны хэрэгжилтийг хэмжих)	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (үйл ажиллагааны үр дүнг хэмжих)
Мал аж ахуйд суурилсан хөрөнгийг нөхөн сэргээх: Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч өрхүүдийг үржлийн цөм малаар хангах (Үргэлжлэл)		<i>Мал маллагааны хувьд эмэгтэйчүүд, хүүхдүүдийн үүрэг рольд гарсан өөрчлөлт (үйл ажиллагааны өмнөх болон дараах үеийг харьцуулах)</i> Эмэгтэйчүүдийн ажлын ачаалалд гарсан өөрчлөлт (жишээ нь ажлын мал олгосны дараа) Мал амьтан хүлээн авагч болон хүлээн авагч бус талуудад үзүүлсэн нөлөөллийг харьцуулахыг анхаарна уу
Мал аж ахуйд суурилсан хөрөнгийг нөхөн сэргээх: Фермерийн жижиг аж ахуй эрхлэгчдийг болон орлого олох зорилгоор үндсэн мал хөрөнгөөр хангах	Өрх бүрд нийлүүлсэн мал амьтны тоо, малын төрлөөр Өрх бүрд үзүүлсэн нэмэлт тусламжийн төрөл, үнийн дүн (жишээ нь хүнсний тусламж, эд хэрэгсэл гэх мэт) Мал аж ахуйн үйлдвэрлэл, менежментийн чиглэлээр шаардлагатай тохиолдолд хийсэн сургалт Үйл ажиллагааны хэрэгжилт дэх эмэгтэйчүүдийн оролцоо	Нийлүүлсэн малын хорогдлыг өмнөх малын хорогдолтой харьцуулсан байдал Нийлүүлсэн малаас гарсан төлийн тоо, ашиглалт (жишээ нь зарах болон орлого олоход ашиглах) Хүний хоол хүнсний тэжээллэг чанар, мал хүлээн авсан өрхийн хүүхдүүдийн сүүний хэрэглээ Мал маллагаан дахь эмэгтэйчүүд, хүүхдүүдийн үүрэг рольд гарсан өөрчлөлт (үйл ажиллагааны өмнөх болон дараах үеийг харьцуулах) Эмэгтэйчүүдийн ажлын ачаалалд гарсан өөрчлөлт (жишээ нь ажлын мал олгосны дараа) Анхаар: Мал амьтан хүлээн авагч болон хүлээн авагч бус талуудад үзүүлсэн нөлөөллийг харьцуулах



	Үйл явцын шалгуур үзүүлэлт (үйл ажиллагааны хэрэгжилтийг хэмжих)	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (үйл ажиллагааны үр дүнг хэмжих)
Мал аж ахуйд суурилсан хөрөнгийг бий болгох	Өрх бүрд нийлүүлсэн мал амьтны тоо, малын төрлөөр Мал аж ахуйн үйлдвэрлэл, менежментийн чиглэлээр хийсэн сургалт Үйл ажиллагааны хэрэгжилт дэх эмэгтэйчүүдийн оролцоо	Нийлүүлсэн малын хорогдлыг өмнөх малын хорогдолтой харьцуулсан байдал Нийлүүлсэн малаас гарсан төлийн тоо, ашиглалт (жишээ нь зарах болон орлого олоход ашиглах) Хүний хоол хүнсний тэжээллэг чанар, мал хүлээн авсан өрхийн хүүхдүүдийн сүүний хэрэглээ Мал маллагаа дахь эмэгтэйчүүд, хүүхдүүдийн үүрэг рольд гарсан өөрчлөлт (үйл ажиллагааны өмнөх болон дараах үеийг харьцуулах) Эмэгтэйчүүдийн ажлын ачаалалд гарсан өөрчлөлт (жишээ нь ажлын мал олгосны дараа) Анхаар: Мал амьтан хүлээн авагч болон хүлээн авагч бус талуудад үзүүлсэн нөлөөллийг харьцуулах



Хавсралт 9.3: Амьжиргааны наад захын хэрэгцээг хангахуйц сүрэгт байх малын тоо

Бэлчээрийн мал аж ахуй бүхий бүс нутагт хэрэгжүүлж буй мал сүргийг нөхөн сэлбэх, шинэчлэх чиглэлийн үйл ажиллагаанд “Амьжиргааны наад захын хэрэгцээг хангах малын тоо (сүргийн ашигтай байх минимум тоо хэмжээ)” хэмээх үзэл баримтлалыг ашигладаг. Энэхүү үзэл баримтлал нь бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид амьдралын хэв маягаа үргэлжлүүлэн авч явахад шаардагдах малын тооны доод хэмжээ болон малын төрлийг тодорхойлдог. Мал аж ахуйн онцгой байдалд баримтлах заавар, стандартууд (LEGS), зааварчилгаанууд нь тухайн малчдад тарааж өгөх малын зохистой тоо, төрлийг шууд дурдах нь тохиромжтой байж болох ч бодит байдалд бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид нь хоорондоо ихээхэн ялгаатай тул мал амьтны тооны хувь ямар нэгэн стандарт тоог шууд заах боломжгүй. Үүний нэгэн адил фермерийн аж ахуй холимог нутагт ч малжуулахад шаардлагатай олон улсад баримтлах тоо хэмжээг тодорхойлоход хүндрэлтэй.

Хэрэв мал аж ахуй эрхлэгчид малаас бүрэн хамааралтай байдаг бол мал амьтны эзлэх байр суурийг баримтлан тооцвол сүргийн хамгийн доод хэмжээ нь халуун уур амьсгалтай бүс нутгийн (TLUs) тооцооллын дагуу нэг насанд хүрсэн хүнд 2.5- 3 мал амьтны нэгж байна. (1 толгой тэмээ = 1 нэгж; 1 толгой үхэр = 0.7 нэгж; 1 толгой хонь эсвэл ямаа = 0.1 нэгж). Орон нутгийн малчидтай зөвшилцөх замаар үүнийг тодорхойлох боломжтой. Хэрэв малжуулах үйл ажиллагаа нь энэ түвшинд хүрэхгүй бол хэрэгжүүлэгч байгууллагууд нь өрхүүдэд бэлэн мөнгө/ хүнсний тусламж нэмэлтээр үзүүлэх шаардлагатай. Эс бөгөөс иргэд малаа тодорхой давтамжтайгаар зарах; эсвэл гэр бүлийн гишүүнээ хамаатнуудындаа амьдруулахаар явуулах; эсвэл байнга бусдаас мөнгө зээлэхээс өөр аргагүйд хүрнэ.

Ямар төрлийн малаас, хэдийг тараах нь тохиромжтойг тодорхойлох хамгийн сайн арга нь оролцооны дүн шинжилгээ, нутгийн иргэдтэй зөвлөлдөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх явдал юм. Энэхүү үйл явцад хүртэх өгөөж, мал амьтны төрөл, үүлдэрээс үүдэх асуудлууд, нутгийн иргэдийн жендерийн болон насны бүлгийг тодорхойлох зэргийг багтааж болно. Үүнд мөн уламжлалт малжуулах тогтолцоонд хийх дүн шинжилгээг ч мөн хамруулах боломжтой. Цаашид судалж үзэх өөр нэгэн зүйл нь “Амьжиргааны наад захын хэрэгцээг хангах малын тоог” дээр дурдсан дүн шинжилгээ, хэлэлцүүлгийн хүрээнд гарган ирж болох ч олон тооны тусламжийн байгууллага малжуулах үйл ажиллагаанд төсвийн хязгаарлалттай нүүр тулдаг ба энэ тохиолдолд нэг өрхөд түгээх малын тоо нэмэгдэх тусам үүнээс үр өгөөж хүртэх өрхийн тоо цөөрнө.

Английн Хүүхдийг ивээх сангийн зүгээс 2002- 2003 онд Этиоп улсын зүүн



хэсэгт ганд нэрвэгдсэн шилжин суурьшсан 500 гэр бүлд зориулан малжуулах төслийг хэрэгжүүлжээ. Төслийн хүрээнд нүүдлийн мал ахуй эрхэлдэг өрх бүрд 30 толгой үржлийн хонь, ямаа олгосон байна. Төслийг Этиопын Засгийн газрын Гамшгийн бэлэн байдал, урьдчилан сэргийлэх хороо, Сомали мужийн мал аж ахуйн газартай хамтран хэрэгжүүлжээ. Нийт 244,500 ам.долларын төсөвтэй төсөл нь нэг өрхөд 489 ам.долларын хэмжээний мал, амьтан түгээсэн байна. Төсөвт хүнсний болон өрхийн хэрэгцээт зүйлсийн тусламж багтаагүй ба үүнийг Христийн тусламж, хөгжлийн холбоо болон НҮБ-ын Хүүхдийн сангаас нийлүүлжээ.

Төсөл дээр хийгдсэн үнэлгээгээр малжуулах үйл ажиллагааны хүрээнд тус төсөл нь маш өндөр хэмжээний үр өгөөж гаргасан хэмээн дүгнэжээ. Гэсэн ч хүлээн авагч өрхөд амьжиргааны үр ашигтай эх үүсвэрийг бүрдүүлэхийн тулд олгож буй багцад багадаа 50 хонь, ямаа багтсан бол илүү үр дүнтэй байх байсан хэмээн үнэлгээгээр тогтоожээ. Ингэх тохиолдолд 500 өрхөд түгээх зорилтоо хадгалсан хэвээр бол төслийн төсөв нь 41% нэмэгдэхээр байжээ. Эсвэл анхлан төсөвлөсөн мөнгө нь хэвээр байх бол 50 малыг 300 өрхөд л хүргэх боломжтой байв. Үнэлгээгээр тухайн зорилтот орон нутгийг үр ашигтай байхуйц хэмжээнд хүргэн малжуулахын тулд өрх бүрд 690 ам.долларын төсөв шаардлагатайг онцолжээ (Wekesa, 2005). Энэхүү жишээ нь хэдэн өрхийг малжуулах, хэдэн мал өгөх тухай шийдвэр гаргахад тусламжийн байгууллагуудад тулгардаг сорилтуудыг харуулжээ. Энэ нь мөн "Амьжиргааны наад захын хэрэгцээг хангах малын тоог" тухайн орон нутгийн онцлогт нийцүүлэн тодорхойлохын ач холбогдлыг харуулж байна.



Эх сурвалж, нэмэлт материал

Ерөнхий

FAO (2016) Livestock-related interventions during emergencies – The how-to-do-it manual. Edited by Philippe Ankers, Suzan Bishop, Simon Mack and Klaas Dietze. FAO Animal Production and Health Manual No. 18. Rome, <https://www.fao.org/3/i5904e/i5904e.pdf> (See Chapter 9)

Heffernan, C., Misturelli, F. and Nielsen, L. (2004) Restocking Pastoralists: A Manual of Best Practice and Decision Support Tools, Practical Action Publishing, Rugby, <https://practicalactionpublishing.com/book/1789/restocking-pastoralists>

Knight-Jones, T. (2012) Restocking in the former Yugoslavia: post-war restocking projects in Bosnia-Herzegovina and Kosovo, World Society for the Protection of Animals (WSPA), London, https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/04/Balkans_Restocking_Final2.pdf

Toulmin, C. (1995) 'Tracking through drought: options for destocking and restocking', in I. Scoones (ed.), Living with Uncertainty: New Directions in Pastoral Development in Africa, pp. 95–115, Intermediate Technology Publications, London.

Уламжлалт малжуулах үйл ажиллагаа

Lotira, R. (2004) Rebuilding Herds by Reinforcing Gargar/Irb among the Somali Pastoralists of Kenya: Evaluation of Experimental Restocking Program in Wajir and Mandera Districts of Kenya, African Union/Interafrican Bureau for Animal Resources, Nairobi, <https://fic.tufts.edu/wp-content/uploads/Lotira-Restocking-evaluation.pdf>

Сүрэг нөхөн сэргээх бэлэн мөнгөний шилжүүлэг

O'Donnell, M. (2007) Cash-based emergency livelihood recovery programme, Isiolo District, Kenya, project evaluation draft report, Save the Children, Nairobi, <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/05/ODonnell-2007.pdf>

FAO (2011) The use of cash transfers in livestock emergencies and their incorporation into Livestock Emergency Guidelines and Standards (LEGS), Animal Production and Health Working Paper No. 1, FAO, Rome, <https://www.fao.org/3/i2256e/i2256e00.pdf>

Impact of herd replacement

Budisatria, I.G.S. and Udo, H.M.J. (2013) Goat-based aid programme in Central Java: an effective intervention for the poor and vulnerable? Small Ruminant Research 109: 76-83, <https://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2020/04/Budisatria-and-Udo-2013.pdf>

Croucher, M., Karanja, V., Wako, R., Dokata, A. and Dima, J. (2006) Initial impact assessment of the livelihoods programme in Merti and Sericho, Save the Children Canada, Nairobi.

Heffernan, C. and Rushton, J. (2000) 'Restocking: A critical evaluation', Nomadic Peoples 4(1):110–124, https://www.researchgate.net/publication/237632191_Restocking_A_Critical_Evaluation

Leguene, P. (2004) Evaluation report: restoration of the livelihood and longer-term food security for the earthquake-affected farmers and agricultural labourers in Bam, south-east Iran, project implemented by ACF-Spain & ACF-UK London.

Sadler, K., Mitchard, E., Abdulahi, A., Shiferaw, Y., Bekele, G. and Catley, A. (2012) Milk Matters:



The Impact of Dry Season Livestock Support on Milk Supply and Child Nutrition in Somali Region, Ethiopia, Feinstein International Center, Tufts University and Save the Children, Addis Ababa, <http://fic.tufts.edu/publication-item/milk-matters/>

Save the Children International (2013) Drought Early Warning and FSL Needs Assessment in Hiran and Puntland; Livestock Baseline for Hiran, DFID Project; Evaluation of Livelihoods/Resilience Activities, Hiran; and Livestock and Cash Grants Project Baseline for Hiran, Save the Children International, Nairobi.

Wekesa, M. (2005) Terminal Evaluation of the Restocking/Rehabilitation Programme for the Internally Displaced Persons in Fik Zone of the Somali Region of Ethiopia, Save the Children UK, Addis Ababa and Acacia Consultants, Nairobi.

Animal diseases and restocking

Knight-Jones, T. (2012) Restocking and Animal Health: A Review of Livestock Disease and Mortality in Post-Disaster and Development Restocking Programmes, World Society for the Protection of Animals (WSPA), London, https://www.researchgate.net/publication/261511178_Restocking_and_animal_health_A_review_of_livestock_disease_and_mortality_in_post-disaster_and_development_restocking_programmes_WSPA

Restocking with exotics

Heffernan, C. (2009) 'Biodiversity versus emergencies: the impact of restocking on animal genetic resources after disaster', *Disasters* 2009, 33(2): 239-252 <https://doi.org/10.1111/j.1467-7717.2008.01072.x>

Donkeys and the provision of livestock

Catley, A. and Blakeway, S. (2004) 'Donkeys and the provision of livestock to returnees: lessons from Eritrea', in P. Starkey and D. Fielding (eds), *Donkeys, People and Development: A Resource Book of the Animal Traction Network for Eastern and Southern Africa (ATNESA)*, pp. 86–92, Technical Centre for Agricultural and Rural Cooperation, Wageningen, The Netherlands, <http://www.atnesa.org/donkeys/donkeys-catley-returnees-ER.pdf>

See also case studies for provision of livestock in emergencies at: <https://www.livestock-emergency.net/resources/case-studies/>



Хавсралтууд

- 373 **Хавсралт А: Нэр томъёоны тайлбар толь**
- 383 **Хавсралт Б: Товчилсон үгс**
- 384 **Хавсралт В: Цаг хугацааны нэгдсэн хүснэгт**
- 385 **Хавсралт Г: Оролцогчид, талархал**
- 388 **Индекс**

Хавсралт А: Үг хэллэг

Acaricide - Акарицид

Хачиг хувалз устгадаг химийн бодис (цацах, дусаах болон угаах байдлаар хэрэглэдэг шингэн бодис).

Accountability - Хариуцлагатай байдал

‘Гамшигт нэрвэгдсэн иргэдийн хувьд хариуцлагатай байдал гэдэг нь эрх мэдлийг хариуцлагатайгаар ашиглах үйл явц юм. Энэ нь төрөл бүрийн оролцогч талууд, ялангуяа тухайн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд нөлөөлж буй талууд хариуцлага хүлээх, эргэн тайлагнах, хариуцлага хүлээхийг хэлнэ.’ (CHS-Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт)

Affected communities - Нэрвэгдсэн (өртсөн) нутгийн иргэд

Гамшигт шууд болон шууд бусаар өртсөн хүмүүс. **Шууд өртсөн хүмүүс нь:** гэмтэл, бэртэл, өвчлөл болон эрүүл мэндийн бусад нөлөөнд өртсөн, нүүлгэн шилжүүлсэн, орон гэргүй болсон эсвэл шилжүүлэн суурьшуулсан; **Шууд бус нь:** эдийн засаг, нийгэм, соёл эсвэл байгаль орчны нөөц хөрөнгөө алдсан хүмүүс байна. (НҮБ Гамшгийн эрсдэлийг бууруулах баримт бичигт үндэслэсэн)

Agencies - Агентлаг (байгууллага)

LEGS нь энэхүү үг хэллэгээр онцгой байдлын үед хариу арга хэмжээ авч буй бүхий л талуудыг илэрхийлдэг. Үүнд төрийн байгууллага, орон нутгийн, үндэсний болон олон улсын байгууллагууд, орон нутгийн иргэдийн бүлгүүдийг багтаана.

Agro-pastoralists - Агро-бэлчээрийн аж ахуй эрхлэгчид

Газар тариаланг бэлчээрийн мал аж ахуйтай хослуулан эрхлэгч.

Alarm phase - Түгшүүрийн шат

Удаан явцтай гамшгийн хоёр дугаар шат

Alert phase - Сэрэмжлүүлэг шат

Удаан явцтай гамшгийн нэг дүгээр шат

Anthelmintic - Антигельминтик (туулга)

Гельментүүдийн эсрэг эм

At risk, at-risk - Эрсдэлтэй, эрсдэл бүхий

Гадаад хүчин зүйлээс үүдэлтэй аюулын хосолмол (байгалийн гамшиг, жендерт суурилсан хүчирхийлэл гэх мэт) нөлөөллөөс хамааран ноцтой хор хохирол учрах (амь нас, амьжиргаа, хөрөнгө, үйлчилгээгээ алдах) эсвэл хувь хүнийг эмзэг байдалд (ядуурал, эмзэг бүлэгт хамаарах) хүргэх магадлалтай аюулууд. (Sphere)

Benefit-cost analysis - Өгөөж, зардлын шинжилгээ

‘Арга хэмжээний зардлыг өгөөжтэй нь харьцуулан судлах арга зүй ба цэвэр зардал болон өгөөжийг түгээмэл хэмжээс (ихэвчлэн мөнгөн дүнгээр) ашиглан тооцоолдог.’ (CALP Сүлжээ)

Cash and voucher assistance (CVA) - Бэлэн мөнгө, эрхийн бичгийн тусламж

‘Бэлэн мөнгө, эрхийн бичгийн тусламж (CVA) гэж бараа, үйлчилгээ худалдан авахад нь зориулан бэлэн мөнгө эсвэл эрхийн бичгийг хувь хүн, өрх, иргэдийн бүлгүүдэд шууд өгөхийг хэлнэ. Хүмүүнлэгийн хариу арга хэмжээний хүрээнд бэлэн мөнгө, эрхийн бичиг нь төр болон төрд хамаарах бусад талууд, үйлчилгээ ханган нийлүүлэгчийн тэтгэлэг, шилжүүлэг, бичил санхүү болон хадгаламж, зээлийн бусад хэлбэрт хамаарахгүй.’ (CALP Сүлжээ)

Cash for work (CFW) - Ажил гүйцэтгэлд бэлэн мөнгө төлөх

‘Тодорхой нэг заагдсан ажил үүргийг гүйцэтгэсний төлөө бэлэн мөнгө төлөх үйл явц. Үндсэндээ ажилласан цагийн тооцоон дээр үндэслэн олгодог (жишээ нь ажилласан өдрийн тоо, өдөр тутмын хөлсний хэмжээ гэх мэт) ч гарцын хэмжээгээр (үйлдвэрлэсэн зүйлийн тоо, ухсан шоо метр газар гэх мэт) тооцон олгож болно. Энэ төрлийн үйл ажиллагаа нь ихэвчлэн нийтэд тустай ажилд ашиглагдах ба мөн гэрийн ажил, бусад хэлбэрийн ажил дээр ашиглаж болно.’ (CALP Сүлжээ)

Chronic/recurring emergency - Ужгирсан/ дахин давтагдах онцгой байдал

Буцан хэвийн хэмжээнд эргэн орохгүйгээр үе шатууд (сэрэмжлүүлэг, түгшүүр, онцгой байдал, сэргээн босголт) нь дахин давтагдаж буй удаан явцтай гамшиг/ онцгой байдал.

Cold chain - Хүйтэн хэлхээ

Хөргөгч болон зөөврийн хөргөлттэй төхөөрөмжийг ашиглан мал эмнэлэг болон хүн эмнэлгийн зориулалтай эм бэлдмэлийг хадгалах, тээвэрлэлтийн шатанд нь тодорхой хэмд хадгалах систем.

Complex emergency - Хавсарсан гамшиг

‘Олон тохиолдлын улмаас улс эсвэл бүс нутагт эрх баригчид нь бүрэн хэмжээнд үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон хүмүүнлэгийн хямрал ба үүнд хүмүүсийн тавлаг байдал, эрхэм чанар өртдөг. Хямралыг хүний үйл ажиллагаа (жишээ нь зөрчил мөргөлдөөн, тогтворгүй байдал), болон/эсвэл байгалийн хүчин зүйлс (жишээ нь ган, үер, хар салхи гэх мэт) бий болгож болно.’ (Sphere)

Conditions/conditional/conditionality - Нөхцөл/нөхцөлт/нөхцөл бүхий

‘Нөхцөл гэж тусламж авахын тулд хүлээн авагч тал биелүүлсэн байх ёстой үйл ажиллагаа эсвэл үүргийг хэлнэ. Үйл ажиллагааны дизайн, зорилтууд дээр үндэслэн нөхцөлийг ямар ч төрлийн ажил гүйлгээнд (бэлэн мөнгө, эрхийн бичиг, үйлчилгээ) хэрэглэж болно. (CALP сүлжээ)

Core breeding animals - Үржлийн цөм мал

Өөрсдийн сүргийг буцаан сэргээхэд чухал үүрэгтэй хэмээн гамшигт нэрвэгдсэн иргэдийн зүгээс үзэж буй сүрэг дэх мал, амьтан. Үүнд хамгийн үржил шимтэй, өгөөжтэй, мөн зан төлөв зэрэг хэв шинжийн хувьд хамгийн тохиромжтой малыг багтаана. Үржлийн цөм сүргийг насаар нь бүтэцлэж болно.

Crisis modifiers - Хямралын тодорхойлогч

Талуудын тохирсон эрт урьдчилан мэдээлэх нөхцөл бүрдэж, яаралтай хариу арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд ашиглаж эхлэх олон жилийн хугацаанд тогтоосон санхүүгийн механизм.

Disaster - Гамшиг

“Онцгой байдал” дээр үзнэ үү.

Disaster risk management (DRM) - Гамшгийн эрсдэлийн удирдлага

Эрсдэлийг бууруулах зорилтыг хангахад чиглэсэн шаардлагатай үйл ажиллагаа. Гамшгийн эрсдэлийн менежментийн мөчлөг нь эрсдэлийг тогтоох, бууруулах, урьдчилан сэргийлэх болон бэлэн байдлын шатууд, мөн нөхөн сэргээх болон сэргээн босгох үйл ажиллагааг гамшгийн дараа авч хэрэгжүүлэх байдлаар тодорхойлогдоно.

Disaster risk reduction (DRR) - Гамшгийн эрсдэлийг бууруулах

‘Үүсгэгч хүчин зүйлсийг шинжлэх, удирдах системтэй арга ажиллагааны хүрээнд гамшгийн [онцгой байдлын] эрсдэлийг бууруулах: [...] аюулд өртөх байдлыг бууруулах, хүн ам болон эд хөрөнгийн эмзэг байдлыг бууруулах, газар болон байгаль орчныг ухаалгаар удирдах, сөрөг нөлөө бүхий үйл явдлын эсрэг бэлэн байдлыг сайжруулах.’ (Sphere)

Drought cycle management model - Гангийн мөчлөгийн удирдлага

Дөрвөн үе шатад (сэрэмжлүүлэг, түгшүүр, онцгой байдал, нөхөн сэргээх) хуваан авч үздэг гангийн эсрэг хариу арга хэмжээний загвар; эдгээрийг МАА-н онцгой байдалд баримтлах заавар болон стандартууд (LEGS)-д удаан явцтай гамшгийн үеийн дөрвөн үе шат хэмээн тодорхойлон хэрэглэдэг.

Dzud - Зуд

Монгол улсад тохиолддог бэлчээр, тэжээлгүйгээс үүдэн олон тооны мал хорогдох үр дагавар бүхий цаг уурын хүндрэлтэй нөхцөл (зун нь гантай байсан нөхцөл байдлыг залгаад хүйтэн өвөл болох).

Early action - Эрт үеийн арга хэмжээ

‘Таамагласан үйл ажиллагаа эсвэл урьдчилсан мэдээнд үндэслэсэн арга хэмжээ хэмээн нэрлэгдэх эрт үеийн арга хэмжээ гэдэг нь гамшиг [онцгой байдал үүсэх] болохоос өмнө урьдчилсан мэдээлэл эсвэл таамаг дээр суурилан хүмүүсийг сэргийлэн хамгаалах арга хэмжээг хэлнэ. Үүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хамгийн эрсдэлтэй бүлгийн бодит оролцоог хангасан байх шаардлагатай.’ (Олон улсын улаан загалмайн холбоо)

Emergency - Онцгой байдал

‘Өргөн хүрээнд тархсан хүн, материал, эдийн засаг эсвэл байгаль орчинд хохирол, сөрөг нөлөөлөл учруулж буй иргэдийн болон нийгмийн амьдралын үйл явцад ноцтой нөлөөлж буй үйл явц. Эдгээр хохирол/нөлөөлөл нь нэрвэгдсэн иргэд, нийгэм олон нийт өөрийн нөөцийн хүрээнд даван туулах боломжгүй гамшигт үйл явдал.’ (Олон улсын улаан загалмайн холбоо)

Emergency phase - Онцгой байдлын үе

Удаан явцтай гамшгийн гуравдугаар үе шат.

Early recovery phase - Эрт үеийн сэргээн босгох шат (Хойшлуулшгүй сэргээн босгох шат)

Гэнэтийн гамшгийн хоёрдугаар үе шат.

Evaluation - Үнэлгээ

Үйл ажиллагааны үр дүнтэй, хамааралтай, үр ашигтай байдал, нөлөөлөл болон тогтвортой байдлыг хянан үзэх зорилгоор тодорхой хугацааны давтамжтай/ төлөвлөлттэй хийгддэг үнэлгээ. Үнэлгээ нь үйл ажиллагааны урдаа тавьсан зорилт хангагдсан эсэх болон үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлд төвлөрөх эсвэл нөлөөллийн үзүүлэлтүүдийг ашиглан амьжиргаанд үзүүлсэн нөлөөллийг хэмжин үнэлж болно.

Gender - Жендер

‘Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн үүрэг роль, хариуцлага, онцлог байдал, эдгээрийг нийгэм хэрхэн үнэлж буй байдал. Энэ нь өөр өөр соёл бүхий орчинд ялгаатай байж, өөрчлөгдөж байдаг. Жендерийн онцлог байдал нь нийгэмд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг хэрхэн хүлээн авдаг, яаж сэтгэх, ямар байхыг хүлээж байдаг болохыг илэрхийлнэ. Жендер, үүрэг роль, хариуцлага, онцлог нь нийгмээс суралцдаг тул өөрчлөгдөх боломжтой.’ (Sphere)

Guidance notes - Зааварчилгаа

Үндсэн үйл ажиллагаа гэсэн ойлголттой хамруулан үзнэ. Зааварчилгаа нь тодорхой асуудлыг тайлбарлаж, LEGS стандартыг баримтлахад тулгарах практик хүндрэлүүдийг хэрхэн шийдэх талаар заадаг.

Hazard - Аюул

‘Амь насаа алдах, гэмтэж бэртэх эсвэл бусад байдлаар эрүүл мэнд хохирох, эд хөрөнгийн хохирол учрах, нийгэм, эдийн засгийн хүндрэл, байгаль орчны доройтолд хүргэж болох үйл явц, үзэгдэл эсвэл хүний үйл ажиллагаа.’ (НҮБ ГЭБ)

Humanitarian crisis - Хүмүүнлэгийн хямрал

Өргөн хүрээнд тархсан хүн, материал, эдийн засаг эвсэл байгаль орчны хохорол, сөрөг нөлөөлөл учруулж буй иргэдийн болон нийгмийн амьдралын үйл явцад ноцтой нөлөөлж буй үйл явц. Эдгээр хохирол/нөлөөлөл нь нэрвэгдсэн иргэд, нийгэм олон нийт өөрийн нөөцийн хүрээнд даван туулах боломжгүй тул яаралтай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг шаарддаг. Хамаарах үг хэллэгүүдэд гамшиг болон онцгой байдал зэрэг үгс багтана.

Immediate aftermath phase - Гэнэтийн хор хохирол

Гэнэтийн гамшгийн нэгдүгээр үе шат бөгөөд энэ нь гамшиг тохиосны яг дараах буюу гамшгийн нөлөөлөл хамгийн өндөр буй үе шат юм.

Impact indicator - Нөлөөллийн үзүүлэлт

Авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд ашиг хүртэгчдэд ямар үр дүн үзүүлснийг тодорхойлох илэрхийлэл.

Inclusion - Хүртээмж

‘Хүртээмж үл хангагдах эрсдэлд байгаа бүхий л хүмүүс нь суурь үйлчилгээг бүрэн тэгш байдлаар хүртэх, үйлчилгээг боловсруулах болон хэрэгжүүлэхэд дуу хоолой, саналаа хүргэж байхыг баталгаажуулах зорилго бүхий эрхэд суурилсан олон нийтийн хөтөлбөрийн үйл явц. Үүний зэрэгцээ үйлчилгээний хүртээмжид тулгарч буй саад тотгорыг арилгах чиглэлээр байгууллагууд нь түсгайлсан хүчин чармайлт гаргаж байх шаардлагатай.’ (Sphere төсөл)
LEGS гарын авлагын хувьд хүртээмж, оролцоо нь хангагдахгүй байгаа хүмүүс хүүхдүүд (ялангуяа харгалзах хүнгүй, өнчин, гэр бүлээсээ тусгаарлагдсан), эмэгтэйчүүд, өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, шашин, гарал үүсэл, каст эсвэл жендерийн үлмээс эмзэгт тооцогдох хүмүүсийг хүртээмж хангагдахгүй байх эрсдэлтэй хэмээн тодруулан авч үздэг.

Indicators - Үзүүлэлтүүд

Үйл ажиллагааны ахиц дэвшлийн хэмжүүр (чанарын болон тоон). LEGS дээр эдгээрийн үйл явцын үзүүлэлт болон нөлөөллийн үзүүлэлт хэмээн хуваан авч үздэг.

Internally displaced person - Дотоодын шилжин суурьшигчид

Өөрийн гэрийг орхин тухайн улс дотроо шилжин суурьших зайлшгүй шаардлагатай болсон хүмүүс.

Intervention - Үйл ажиллагаа

Ямар нэгэн үр дүнд хүрэхэд хувь нэмэр болох багц үйл ажиллагаа. LEGS дээр дурдсан үйл ажиллагаа нь онцгой нөхцөл байдалд хамгийн сайн хариу арга хэмжээ болохоор сонгосон үйл ажиллагааг (тэжээл, ус, мал эмнэлгийн үйлчилгээ, хашаа хороо, малын тоо толгойг цөөлөх) хамааруулж үздэг. Үйл ажиллагаа нэг бүр нь төрөл бүрийн хувилбаруудад хуваагдаж болно.

Key actions - Үндсэн үйл ажиллагаа

LESG Стандартыг хангах зорилго бүхий практик алхам эсвэл үйл ажиллагаа ба стандартууд нь бүхий л нөхцөл байдалд бүрэн нийцэхгүй байж болно.

Learning - Суралцахуй

Хяналт, үнэлгээ болон хариуцлагатай байх үйл явцаас мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээх болон олсон мэдлэгийг өнөөгийн болон ирээдүйн төлөвлөлтөд урьдчилан тусгаж ашиглах үйл явц.

Livelihoods - Амьжиргаа

Амьдралаа залгуулахад шаардлагатай чадавх, хөрөнгө болон үйл ажиллагаа.

Livelihood assets - Амьжиргааны хөрөнгө

Хувь хүн болон айл өрхүүд өөрсдийн амьжиргааг авч явахын тулд ашигладаг нөөц эх үүсвэр, тоног төхөөрөмж, ур чадвар, давуу тал болон харилцаа. Үүнийг нийгмийн, хүний, байгалийн, санхүүгийн болон биет хэмээн ангилдаг.

Livestock offtake - Малын тоог бууруулах

Малыг зарж борлуулах эсвэл өөр бусад аргаар сүргээс хасах арга хэмжээ.

Livestock settlement - Малыг байршуулах

Энэхүү үг хэллэг нь өргөн утгаараа малын хашаа хороо, байрыг илэрхийлэх ба үүнд хашаа хороогоор хангахаас газрын эрх, байгаль орчин, тэжээл, усны хүртээмжид үзүүлэх үр дагавар багтана.

Livestock shelters - Малын байр

Зарим орчин нөхцөлд мал, амьтан амьд үлдэхэд шаардагдах биет бүтэц. Хашаа хороо нь түр эсвэл байнгын байж болно.

Lower- and middle-income countries - Бага болон дунд орлоготой улс орон

Дэлхийн банкны зүгээс улс орнуудыг бага, багаас дунд, дундаас дээш болон өндөр орлоготой улсууд хэмээн ангилдаг. Улс орнуудыг жил тутам ДНБ-ний нэг хүнд оногдох орлогыг доллароор тооцон ангилдаг (Дэлхийн банкны

мэдээллийг үзнэ үү). Энэхүү ангилалд үндэслэн LEGS дээр “бага болон дунд орлоготой улсууд” хэмээх хэллэгийг ашигладаг.

Monitoring - Хяналт

Үйл ажиллагааны явцын үзүүлэлтүүдийг ашиглан шийдвэр гаргах шуурхай мэдээллийг ханган өгөх зорилго бүхий үйл ажиллагааг зорьсон чиглэлд нь хадгалан үргэлжлүүлэх байнгын системтэй үйл явц.

One Health - Нэг эрүүл мэнд

‘Хүн, мал амьтан болон экосистемийн эрүүл мэндийг тогтвортойгоор тэнцвэржүүлэхэд чиглэсэн нэгдсэн, харилцан уялдаат арга хандлага.’ (ДЭМБ, НҮБ ХХААБ, НҮБ БОХ, ДМАЭМБ)

Options - Хувилбарууд

LEGS-д хамаарах техникийн үйл ажиллагаа нэг бүр нь төрөл бүрийн хувилбаруудад хуваагдах ба эдгээр нь техникийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэх ялгаатай арга замуудыг тодорхойлно (жишээ нь ус зөөвөрлөх болон худаг өрөмдөх).

Participatory methods and approaches - Оролцооны арга зүй, хандлагууд

Тодорхойлон гаргасан арга зүй болон системтэй суралцах үйл явцад суурилсан арга техник ба бүхий л оролцогчид хамтран суралцахад төвлөрч, олон хэтийн төлвүүдийг нэгтгэж, бүлгийн суралцах үйл явцыг багтаадаг. (IIED) Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 3.1 дээр үзнэ үү.

Participatory epidemiology - Оролцооны тархвар судлал

Тодорхой өвчний асуудал болон шийдлийг судлахад нутгийн иргэдтэй хамтран ажиллах оролцооны арга хандлага.

Participatory targeting - Зорилтот бүлгийг оролцоотойгоор тогтоох

Оролцооны арга, хандлагыг ашиглан хийгдэж буй үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдтэй тохиролцсоны дагуу хамгийн их хэрэгцээ бүхий хэсэгт төвлөрч буйг баталгаажуулах үйл явц. LEGS нь Хүмүүнлэгийн үндсэн стандартуудыг хангахдаа онцгой байдлын хариу арга хэмжээний шийдвэр гаргахад гамшигт нэрвэгдсэн иргэдийг оролцуулж байхыг шаарддаг.

Pastoralists - Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид

Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид гэж хүнс, орлого нь мал өсгөн үржүүлэх ажлаас бүрэн хамаарал бүхий бүлгийг хэлнэ.

Peri-urban - Хот орчмын бүс

Хот, суурин газрын эргэн тойрны бүс нутаг ба хот, хөдөөгийн газар ашиглалтын заагийг тогтоосон, хот, хөдөө аль алинаас нь хамааралтай, жишээ нь хөдөөгийн бүтээгдэхүүнийг хотын хэрэглэгчдэд борлуулах зах зээл болдог.

Phytosanitary - Ургамал, хорио цээр, ариун цэвэр

Ургамлын ариун цэвэр, био аюулгүй байдалтай хамааралтай; Дэлхийн худалдааны байгууллагын “Ургамал, хорио цээр, ариун цэврийн арга хэмжээг ашиглах гэрээ” нь хүнсний аюулгүй байдал, ургамлын ариун цэвэр эрүүл ахуйн суурь дүрмийг тогтоодог.

Process indicator - Үйл явцын үзүүлэлт

Тодорхойлон гаргасан цаг хугацааны туршид үйл ажиллагааны хэрэгжилтийг хэмжин үнэлэх лавлагаа цэг. Үйл явцын үзүүлэлтүүд нь ихэвчлэн тоон үзүүлэлтүүд байдаг (мөн ахицын үзүүлэлт хэмээн нэрлэдэг).

Prophylactic drugs - Урьдчилан сэргийлэх эм бэлдмэл

Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ашигладаг эм, эмчилгээ.

Protracted emergency - Удаан үргэлжилсэн онцгой байдал

‘Удаан үргэлжилсэн онцгой байдал гэж хүн амын томоохон хэсэг нь удаан хугацааны туршид архаг эмзэг байдалд хүрч, хүмүүнлэгийн тусламжаас хамааралтай байх нөхцөл байдлыг хэлнэ. Ихэнх тохиолдолд энэхүү хугацаа нь тухайн онцгой байдал энгийн нөхцөл байдал болтол удаашран үргэлжилдэг.’ (Данийн дүрвэгчдийн зөвлөл)

Purposive samples - Зорилтот түүвэрлэлт

Тодорхой шинж чанар дээр нь үндэслэн (жишээ нь ганд нэрвэгдсэн малчид; малчин эмэгтэйчүүд; хүнсний хомсдолтой оршин суугчид) “ердийн” төлөөлөх бүлгийг сонгох явц.

Rapid-onset emergency - Гэнэтийн гамшиг

Газар хөдлөлт, үер, цунами зэрэг гэнэт, заримдаа ямар нэгэн анхааруулах шинж тэмдэггүй үүсдэг онцгой нөхцөл байдал. LEGS нь гэнэтийн гамшгийг гамшгийн шууд дараах гэнэтийн хор хохирол, эрт үеийн нөхөн сэргээх болон нөхөн сэргээх гэсэн гурван шатанд хуваан авч үздэг.

Recovery phase - Нөхөн сэргээх үе шат

Гэнэтийн гамшгийн гурав дугаар үе шат эсвэл удаан явцтай гамшгийн дөрөв дүгээр үе шат.

Resilience - Сөрөн тэсвэрлэх (эрсдэл даах) чадвар

‘Байгалийн гамшиг эсвэл бусад шалтгаанаас үүдсэн сөрөг нөлөөллийг хувь хүн, олон нийт, нийгэм эсвэл улс орон урьдчилан харах, тэсэн гарах боломж. Эрсдэлийг сөрөн тэсвэрлэх чадвар нь амьжиргааны төрөлжилт, дасан зохицох механизм болон асуудал шийдвэрлэх зэрэг амьдралын үр чадвар, дэмжлэг эрэн хайх боломж, эерэг хичээл зүтгэл, итгэл үнэмшил, зориг тэвчээр, овсгоо самбаа боломж ашиглах чадвар зэргээс хамаарна.’ (Sphere)

Response - Хариу арга хэмжээ

‘Хүний амь нас аврах, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах, олон

нийтийн аюулгүй байдлыг хангах, хүний эрхэм чанарыг хадгалах, нэрвэгдсэн хүмүүсийн наад захын суурь хэрэглээг хангах зорилго бүхий үйлчилгээ, тусламжийг гамшгийн (онцгой байдлын) үеэр болон дараа үзүүлэх үйл явц.' (Sphere)

Restrictions - Хязгаарлалтууд

'Хүлээн авагч талд өгсөн тусламжийг ашиглах дээр тогтоосон хязгаарлалт. Худалдан авахад тусламжийг ашиглаж болох бараа, үйлчилгээ, хаана худалдан авч болох газар зэрэгт хязгаарлалтууд хамаарна. Эрхийн бичиг нь хаана, хэзээ, хэрхэн ашиглаж болохыг заасан байдаг тул зөвхөн заасан хэмжээнд гүйлгээ хийж болох хязгаарлалттай байдаг.' (CALP сүлжээ)

SMART objectives - УХААЛАГ (SMART) зорилтууд

Хариу арга хэмжээний зорилтууд нь онцлог, хэмжигдэхүйц, хүрэх боломжтой, хамааралтай, цаг хугацаатай (Specific, Measureable, Achievable, Relevant, Time-Bound) байж, тогтоосон хугацаанд амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг тооцон гаргаж ирдэг.

Slow-onset emergency - Удаан явцтай гамшиг

Ган эсвэл хэт хүйтэн улирал зэрэг нөлөө нь шатлан нэмэгддэг гамшиг. LEGS нь энэхүү гамшгийг дөрвөн шатанд авч үзэх ба эдгээр нь сэрэмжлүүлэг, түгшүүр, онцгой байдал болон нөхөн сэргээх үе шатууд багтана.

Standards - Стандартууд

Ямар ч нөхцөлд, ямар ч онцгой байдлын үед хангасан байх минимум нөхцөлийн чанарын тодорхойлолт.

Theory of change - Өөрчлөлтийн онол

Үйл ажиллагаа нь өөрийн зорьж буй эцсийн үр дүндээ хэрхэн хүрч болохыг тайлбарласан, зурагласан байдал. Энэ нь энгийн дүн шинжилгээ, таамгаас үндэслэн цуврал үйл ажиллагаа нь санал болгож буй өөрчлөлтдөө хэрхэн хувь нэмэр оруулахыг харуулдаг.

Veterinary paraprofessionals - Мал эмнэлгийн техникч

Малын эмчийн хяналт доор ажилладаг, тодорхой чиг үүргийг гүйцэтгэх үүрэгтэй, сургалтад хамрагдсан мэргэжилтэн. Зарим улсад "олон нийтэд түшиглэсэн малын эрүүл мэндийн ажилтан" (ОНТМЭА) эсвэл "мал эмнэлгийн техникч" зэргээр нэрлэдэг. LEGS дээр "Мал эмнэлгийн техникч" гэж заасан нь олон нийтийн мал, амьтны эрүүл мэндийн ажилтныг мөн илэрхийлнэ.

Zoonosis - Зооноз

Мал, амьтнаас хүнд дамжин халдварлах өвчин. Хамаарах үг хэллэг: зооноз, зооноз өвчин.

Эх сурвалжууд

CALP сүлжээ – <https://www.calpnetwork.org/resources/glossary-of-terms/>

CHS (Хүмүүнлэгийн Үндсэн Стандарт) – <https://www.chsalliance.org/accountability-to-affected-people/> Дани улсын дүрвэгчдийн зөвлөл – <https://emergency.drc.ngo/crisis/emergency-typologies/>

Олон улсын улаан загалмайн холбоо – <https://www.ifrc.org/early-warning-early-action>

БОХОУХ – <https://www.iied.org/sites/default/files/pdfs/migrate/6021IIED.pdf>

Сфер (Sphere) – <https://spherestandards.org/wp-content/uploads/Sphere-Glossary-2018.pdf>

НҮБ ЭЗНХХ – <https://www.un.org/esa/socdev/rwss/2016/full-report.pdf>

НҮБ ГЭБ – <https://www.undrr.org/terminology>

ДЭМБ, НҮБ ХХААБ, НҮБ БОХ болон ДЗМАЭМБ – <https://www.who.int/news/item/01-12-2021-tripartite-and-unep-support-ohhlep-s-definition-of-one-health>

Дэлхийн банк – <https://datatopics.worldbank.org/world-development-indicators/the-world-by-income-and-region.html>

Хавсралт Б: Товчилсон үгс

ББТ (AMR)	Бичил биетний тэсвэржилт
ОНТМЭА (CANW)	Олон нийтэд тулгуурласан малынэрүүл мэндийн ажилтан
ХЗМ (CCCM)	Хуаран (бааз)-ийн зохицуулалт болон менежмент
АГБМТ (CFW)	Ажил гүйцэтгэлд бэлэн мөнгө төлөх
ЧТХҮС (CHS)	Чанар, тайлагналын хүмүүнлэгийн үндсэн стандарт
ХХМС (CPMS)	Хүүхэд хамгааллын минимум стандарт
БМЭБТ (CVA)	Бэлэн мөнгө, эрхийн бичгийн тусламж
ГЭМ (DRM)	Гамшгийн эрсдэлийн менежмент
ГЭБ (DRR)	Гамшгийн эрсдэл бууруулах
ХХААБ (FAO)	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ГЗИС (GIS)	Газар зүйн мэдээллийн систем
ХХС (HIS)	Хүмүүнлэгийн хүртээмжийн стандарт
ХСТ (HSP)	Хүмүүнлэгийн стандартуудын түншлэл
ОСГХЭ (HLP)	Орон сууц, газар, өмчийн эрх
ББ (ID)	Баримт бичиг
ДШС (IDP)	Дотоод шилжин суурьшигчид
ОБУБХС (INEE)	Онцгой байдлын үеийн байгууллага хоорондын сүлжээ
ОНУМАЧҮАБЗС (LEGS)	Мал аж ахуйн онцгой байдалд баримтлах заавар, стандартууд
ХҮХС (XYXC)	Хяналт, үнэлгээ, хариуцлага, суралцахуй
ЭЗСМС (MERS)	Эдийн засгийг сэргээх минимум стандартууд
ЗЗШМС (MISMA)	Зах зээлийн шинжилгээний минимум стандартууд
ЭЗХАХБ (OECD)	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ХАХОТМ (PRIM)	Хариу арга хэмжээг оролцоотойгоор тодорхойлох матриц
ОБУГТАДС (SEADS)	Онцгой байдлын үед газар тариалангийн амьжиргааг дэмжих стандарт
УХААЛАГ (SMART)	Өвөрмөц, хэмжигдэхүйц, хүрэхүйц, хамааралтай, цаг хугацаатай (үзүүлэлтүүд)
ӨО (ToC)	Өөрчлөлтийн онол
УХАЦЭА (WASH)	Усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуй
ДЭМБ (WHO)	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ДМАЭМБ (WOAH)	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага

Хавсралт В: Цаг хугацааны нэгдсэн хүснэгт

Зураг А.1: Цаг хугацааны нэгдсэн хүснэгт

Техникийн үйл ажиллагаа болон хувилбарууд	Гэнэтийн гамшиг			Удаан явцтай гамшиг			
	Шууд хор хохирол	Эрт үеийн нөхөн сэргээх	Нөхөн сэргээх	Сэрэмжлүүлэх	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээх
Тэжээл							
Суурин тэжээх	✓	✓	—	—	✓	✓	—
Тэжээлийн баазад тэжээх	✓	✓	—	—	✓	✓	—
Ус							
Уст цэг: менежментийг өөрчлөх	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Уст цэг: сэргээн босгох	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Уст цэг: байгуулах	—	—	✓	✓	✓	—	✓
Ус зөөвөрлөх	✓	—	—	—	—	✓	—
Мал эмнэлгийн үйлчилгээ							
Мал эмнэлгийн эмнэл зүй	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Улсын мал эмнэлгийн чиг үүрэг	—	—	✓	—	—	—	✓
Малын байр							
Түр хашаа хороогоор хангах	✓	—	—	—	✓	✓	—
Удаан эдэлгээтэй хашаа хороогоор хангах	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Байршуулах үйл ажиллагаа	—	✓	✓	✓	✓	✓	✓
Малын тоог бууруулах							
Малыг арилжаалан тоог бууруулах	✓	—	—	✓	✓	—	—
Малыг хэрэгцээлэн тоог бууруулах	✓	—	—	—	✓	✓	—
Малжуулах							
Хорогдсон мал хөрөнгийг нөхөх	—	—	✓	—	—	—	✓
Малтай болгох	—	—	✓	—	—	—	✓

Хавсралт Г: Оролцогчид, талархал

Редакцын зөвлөл (LEGS Техникийн зөвлөх групп)

Andy Catley (Тафтсын их сургуулийн Тэжээллэгийн шинжлэх ухаан, бодлогын сургуулийн Файнштейн олон улсын төв)

Wendy Fenton (ОДИ бодлогын судалгааны хүрээлэнгийн Хүмүүнлэгийн бодлогын групп)

Guido Govoni (Олон улсын улаан загалмайн хороо)

David Hadrill (Хараат бус зөвлөх)

Vikrant Mahajan (Sphere Энэтхэг) Rosanne Marchesich (НҮБ ХХААБ)

Emmanuella Olesambu (НҮБ ХХААБ)

Piers Simpkin (Хараат бус зөвлөх)

Гарын авлагыг хянан тохиолдуулсан

Helen de Jode (Редактор)

Cathy Watson (LEGS Зохицуулагч)

Бүлгүүдийн хянан тохиолдуулсан зохиогчид

Гарын авлагыг хэрхэн ашиглах вэ? – Helen de Jode

Бүлэг 1: LEGS Танилцуулга – David Hadrill

Бүлэг 2: LEGS Зарчмууд – Andy Catley

Бүлэг 3: Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөлт – Cathy Watson, Polly Bodgener, David Hadrill and Andy Catley

Бүлэг 4: Малын тэжээл – Adrian Cullis

Бүлэг 5: Усаар хангах – Mathias Frese

Бүлэг 6: Мал эмнэлгийн тусламж – Andy Catley

Бүлэг 7: Малын байр, байршуулалт – James Kennedy

Бүлэг 8: Малын тоог бууруулах – Yacob Aklilu

Бүлэг 9: Малжуулах үйл ажиллагаа – Raphael Lotira and Adrian Cullis

Зөвлөлдөх үйл явц

Нэрийг нь энд дурдаж баршгүй олон тооны хүмүүс энэхүү гарын авлагын 3 дугаар хэвлэлтийг бэлтгэхэд өөрийн мэдлэг чадвараа дайчлан хувь нэмэр оруулсан болно. LEGS-н зүгээс үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан доор дурдсан болон бусад бүхий л талуудад гүн талархал илэрхийлж байна:

Хянан тохиолдуулсан гарын авлага дээр онлайн хэлбэрээр 2022 онд хийсэн зөвлөлдөх арга хэмжээнд оролцож, өөрийн саналыг өгсөн бүхий л хүмүүс 2021 онд хийгдсэн 2 дугаар хэвлэлтийн онлайн судалгаанд оролцогчид

Энэтхэг, Пакистан, Кени, Мали, Никарагуа, Филиппин улсуудад 2020- 2021 онуудад зохион байгуулагдсан 5 удаагийн зөвлөлдөх семинарын оролцогчид 2020 оны хэлэлцүүлгийн 5 баримт бичгийн зохиогчид (жендер, хоол тэжээллэг, эрсдэл даах чадвар, малын даатгал, Ковид-19, институт, малын эмийн чанар) болон хамаарах семинарын оролцогчид.

Техникийн зөвлөгөө

Xavier Argoud – Онцгой байдлын хариу арга хэмжээ

Julia Ashmore – Малын байр, байршуулалт

Suzan Bishop – Онцгой байдлын хариу арга хэмжээ

Pauline Gitonga – Мал эмнэлгийн тусламж

Kate Hart – Бэлэн мөнгө, эрхийн бичгийн тусламж

Racey Henderson – SEADS

Diane Hiscock – Хүртээмж

Karin de Jonge – Жендер

Emma Jowett – Бэлэн мөнгө, эрхийн бичгийн тусламж

Simon Kihu – Мал эмнэлгийн тусламж

Tanya Lutvey – Жендер

Lucy Maarse – Жендер

Genene Regassa – Тэжээл

Abdirashid Saleh – Хот орчмын бүсийн хариу арга хэмжээ

Kebadu Simachew Belay – Тэжээл

Редакцийн дэмжлэг туслалцаа

Англи хэл дээр хяналт: Jane Lanigan/Editors4Change Ltd

Эцсийн редакц: Cordelia Lily

Индекс: Pierke Bosschieter

Дизайн

www.truedesign.co.uk

Өрөлт

River Valley Technology

LEGS Ажлын алба

Cathy Watson (LEGS Зохицуулагч)

Suzan Bishop (LEGS Техникийн болон Төслийн менежер)

Lucy Margetts (LEGS Захэргaa, санхүүгийн менежер)

Brianne Miers (LEGS Мэдээлэл харилцааны ажилтан)

Донор байгууллагууд

LEGS гарын авлагын 3 дугаар хэвлэлтийг дахин шинэчлэх, бүтээхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн АНУ-ын ОУХА-ын Хүмүүнлэгийн туслалцааны товчоонд гүн талархал илэрхийлж байна. Мөн өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд дэмжлэг (мөнгөн болон мөнгөн бус) дараах байгууллагуудад талархал илэрхийлж байна. НҮБ ХХААБ, ОУУЗХ, ОДИ, PRODEL, Сфер, Сфер Энэтхэг, The Brooke, Тафтсын их сургууль болон VSF Бельги.

Индекс

Тодруулсан (bold) хуудасны дугаар нь зургуудыг заана. Тодруулсан (bold) текст нь LEGS-н техникийн арга хэмжээг заана. Доогуур нь зурсан текст нь LEGS Зарчмуудыг заана.

А (А)

Хариуцлагатай байдал
Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөлтийн 103 болон ХҮХС 66
үзэх хяналт, үнэлгээ, хариуцлага, суралцах (ХҮХС)
захэргааны тогтолцоо 154
нөлөөлөл бодлого/ нөлөөллийн нөхцөл байдал хэсгийг харах
хямд өртөгтэй байх, мал эмнэлгийн түслэмжийн 222–223
ББТ (бичил биетийн тэсвэржилт) 35
мал аж ахуйн, сургалт 350
малын тавлаг байдал 22, 40
мал, амьтан (үржлийн мал, гэрийн мал ажлын зориулалттай, мал амьтан хэсгийг харах антибиотик 35
бичил биетийн тэсвэржилт (ББТ) 35, 41
зөгийн аж ахуй 43
загасны аж ахуй 43
үнэлгээний арга зүй 80
үнэлгээний баг 80–81
үнэлгээ
оролцооны 229
эрсдэлийн 268(анхдагч үнэлгээ хэсгийг харах)
үнэлгээ/төлөвлөлт
ус тээвэрлэх, үргэлжлүүлэх 195
усны эрэлтийн 190
захэран зарцуулах хэрэгцээний 238
малын өвчний 228
малын тэжээлийн 154–155 мал цөөлөх 315
малжуулах үйл ажиллагааны 352–353
малын байр, байршуулалт 270–272, 282
орон нутгийн зах зээлийн 272
мал эмнэлгийн 241
уст цэгийн 199
зооноз өвчний 236
эрсдэлтэй бүлэг
уур амьсгалын өөрчлөлт 56
нутгийн иргэдийн оролцоо 53
малын байр, байршуулалт 271
малын тэжээлд 145
мал эмнэлгийн үйлчилгээний 231–232

В (Б, В)

банкны данс 121
өгөөж- зардлын шинжилгээ 103, 134–135, 343–344
өгөөж/сорилтууд
ерөнхий 92
тэжээлийн цэгт яаралтай тэжээх 140–141
тэжээл хангамжийн хувилбаруудын 140–141
өрхөд суурилсан яаралтай тэжээх 140
амьжиргаанд суурилсан хөтөлбөрийн 48
малын тэжээлийн 137
малын тоог бууруулах 295
малжуулах үйл ажиллагааны 329
малын байр, байршуулалт 258–259
ХҮХС-н 66
мал эмнэлгийн үйлчилгээний 214–216
ус хангамжийн 175–177
хөвгүүд 62
үржлийн мал 135–136, 142, 323, 326–327, 329, 355
төсөв 157–158, 358

С

ОНМЭМА (орон нутгийн малын эрүүл мэндийн түслах ажилтан) 209, 230, 232–234
хуанли, улирлын 105
хуаран
амьдарч буй хүмүүсийг малжуулах 337–338
мал эмнэлгийн үйлчилгээ 223
тэжээх хуаран хэсгийг харах
сэг зэм, хорогдсон 314
бэлэн мөнгө, эрхийн бичгийн түслэмж (CVA)
ерөнхий 25, 119–120
нөхцөл байдал 86
шийдвэрийн мод 122
түгээх механизм 120
цаашид уншин судлах 127
малын тэжээл дээр 156
малын тоог бууруулах дээр 311
малжуулах дээр 337, 346–347
болон малын хашаа хороон дээр 265
болон хариу арга хэмжээний хэлбэр дээр 94
мал эмнэлгийн үйлчилгээ дээр 223, 244
усан хангамж дээр 173
бэлэн мөнгө 120
шалгах хуудсууд
тэжээлийн хангамжийн 161–162
анхдагч үнэлгээний 81, 81–86, 106–107, 109

Малын тоог бууруулах 315–316 малжуулах 352
 малын байр, байршуулалт 282–283
 байгаль болон гамшгийн нөлөөлөл 83–85
 амьжиргаанд малын үүрэг роль 82
 нөхцөл байдлын шинжилгээ 85–86
 мал эмнэлгийн үйлчилгээ 241
 уст цэг 199
 архаг/ давтан үүсэх гамшиг 28
 ЧХХҮС (Чанар болон хариуцлагатай байдлын хүмүүнлэгийн үндсэн стандартууд) 37, 39, 70–72
 уур амьсгалын өөрчлөлт 55–57
 цаашид унших 73
 нөлөөлөл 56
 мал амьтан 35, 55–56
 болон малын тэжээл 144 болон
 малын тоог бууруулах 299
 болон малжуулах 332
 болон малын байр, байршуулалт 262
 болон мал эмнэлгийн үйлчилгээ 219
 болон усан хангамж 180
 мал эмнэлгийн клиник үйлчилгээ
 ерөнхий 208–210
 үр ашиг/ сорилтууд 214–215
 дизайн 230–234
 мал үзлэг/ эмчилгээ 210
 масс эмчилгээ/ вакцинжуулах хөтөлбөр 210
 төлбөрийн хувилбар 222–223, 233–234
 үүрэг роль, хариуцлага 235
 хамтран орших, мал болон хүн 253, 277
 орон нутгийн манлайлал
 болон ус хангамж
 орон нутгийн өөрөө удирдах, эзэмших эрхийг
 дэмжих хэсгийг харах
 Иргэдийн оролцоо 52–55
 идэвхтэй 53–55, 59
 болон CHS 70
 болон шууд харилцаа холбоо 54
 гамшгийн үеийн МАА-н төслүүд 52–53
 цаашид унших 73
 малын тэжээл 143
 мал цөөлөх 299, 306, 311
 малжуулах 332
 болон малын хашаа хороо/ суурьшил 262,
 271–273
 төрлүүд 54–55
 мал эмнэлгийн тусламж 218
 болон усан хангамж 179–180
 өргөн хүрээний оролцогч талууд 272–273
 нийтийн хашаа хороо 275
 орон нутгийн МЭ-ийн туслах ажилтан
 (ОНМЭТА) 209–210, 230, 232–234
 олон нийтэд суурилсан хандлага 232
 гэрийн мал амьтан 44
 холбоотой стандартууд 37

нэмэлт хөтөлбөр, болон малыг тэжээлээр
 хангах үйл ажиллагаа 156
 хавсарсан гамшиг 28, 30–32, 36, 117, 211–212
 агуулга, LEGS гарын авлага 15
 бэлэн байдлын төлөвлөлт
 болон ГЭБ 58–59
 мал эмнэлгийн туслалцаа 226
 Тэмцэх малын өвчний 240
 мал амьтны 62–63
 чанарын 159
 зооноз өвчний 236–237
 зохицуулалттай хариу арга хэмжээ 59–61
 Ялгаатай үйл ажиллагаануудын хооронд 61
 Малжуулах үйл ажиллагааны хооронд 60
 болон Хүмүүнлэгийн үндсэн стандарт 71–72
 цааш унших 74
 малын тэжээл 144
 малын тоог бууруулах 300
 малжуулах 333
 малын байр, байршуулалт 262
 мал эмнэлгийн үйлчилгээ 219
 усан хангамж 180
 зохицуулах бүлэг
 бүлгүүдийн хооронд, малын тоог
 бууруулахдээр 307
 даван туулах стратегийн 108, 151–152
 Чанар, хариуцлагатай байдлын хүмүүнлэгийн
 үндсэн стандартууд (CHS) 37, 39, 70–72
 зардал нөхөх 193, 203, 222
 зардлын үр ашигтай байдал 212
 Ковид-19 цар тахал 34
 ХХМС (Хүүхэд хамгааллын минимум стандарт)
 61
 зээлийн тогтолцоо 347
 хямрал тодорхойлох үзүүлэлтүүд 58, 227, 304
 БМЭБТ хэсгийг харах Бэлэн мөнгө, эрхийн
 бичгийн тусламж (CVA)
 циклоны эсэргүүцэл 269

D

өгөгдөл/дата үзэх мэдээлэл
 үхсэн мал 238
 шийдвэрийн мод
 БМЭБТ дээр 122
 малын тэжээлд 148, 149
 малын тоог бууруулахад 301, 302
 малжуулахад 339
 малын байр, байршуулалт 265, 266
 мал эмнэлгийн туслалцаа 224, 225
 ус хангамжид 183, 184
 Түгээх механизм, БМЭБТ дээр 94–95, 120–121
 дизайн
 малжуулах 354
 малын байр, байршуулалт 275
 мал эмнэлгийн туслалцаа 230, 243

Хавсралтууд

ХБИ 277

задаргаатай, мэдээллийн 102

ГЭМ (DDR) мөчлөг 28–29

ГЭБ (DDR) 58

устгах, үхсэн мал 238, 314

тараах

малын тэжээл 154, 161

хугацаа, малжуулахад 348

болон ус тээвэрлэх 198

илжиг 361

ГЭМ (гамшгийн эрсдэл бууруулах) 58

хянан шинжлэх хандлага 264

Е (Е, Э)

Эрт үеийн арга хэмжээ

Малын тоо бууруулах 304

бэлэн байдал/ эрт сэрэмжлүүлэх систем хэсгийг харах 59, 303

газар хөдлөлтөд тэсвэрлэх 268

өндөр настан 54

онцгой байдал

нөлөөлөл 32

үе шатууд 31, 30–31

онцлог нөхцөл Онцгой байдлын үеийн зах

зээлийн зураглалын шинжилгээ (ЕММА)

хэсгийг харах 298

хариу арга хэмжээний төлөвлөлт ерөнхий 78–79

хариуцлагатай байдал 103

техникийн арга хэмжээний шинжилгээ 90–95

ХҮС 70

нөлөөллийн үнэлгээ 103

анхдагч үнэлгээ 79–86, 105–111

хяналт-шинжилгээ 103

хариу арга хэмжээг тодорхойлох 87–90

арга хэмжээний төлөвлөгөө 96–98

сургамжаа хуваалцах 104

онцгой байдлын төрлүүд 28–30

ЕММА (Онцгой байдлын зураглалын шинжилгээ) 298

орчны эрүүл мэнд 35

байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл

үнэлгээ 108

малын байршуулалтын 278

болон малын байрны/271–272

усны нөөц ашигласны 187

байгаль хамгаалал 55–57

ерөнхий 55–57

цаашид унших 73

малын тэжээл 144

мал цөөлөх 299

малжуулах 332

малын байр, байршуулалт 262

мал эмнэлгийн туслалцаа 219

усаар хангах 180

тоног төхөөрөмж, мал амьтны 351

тоног төхөөрөмж, мал амьтны 314

зовиургүйгээр устгах 235

нүүлгэн шилжүүлэлт 269, 278

үнэлгээ ерөнхий 66

Хяналт, үнэлгээ, хариуцлага, суралцахуй

хэсгийг харах

хариу арга хэмжээний төлөвлөлт 103

малын тэжээлийн 163

малын тоог бууруулах 317

малжуулах 354–357

малын байр, байршуулалт 284

тэргүүлэх нөлөөлөл 67

мал эмнэлгийн туслалцаа 243

нотолгоонд суурилсан, сайн туршлага 21

усны нөөцийн өнөөгийн хэрэглэгчид 195

гарах стратеги, малын тоог бууруулах дээр 306

Ү (Ф)

Тэжээл, малын тэжээл хэсгийг харах

кэмп-д тэжээх 91, 139, 156, 162

галын аюулгүй байдал 278

үерийн нөлөөллийг бууруулах 268

фокус бүлгийн хэлэлцүүлэг 105, 109, 110

хүнсний эрүүл ахуй 237

хүнсний баталгаат байдал 350–351

санхүүжилт 58–59, 227

цааш унших

анхдагч үнэлгээ дээр 126

LEGS зарчим дээр 73

малын тэжээл дээр 165–166

малын тоог бууруулах дээр 319

малжуулах дээр 360–361

малын байр/байршуулалт дээр 287

оролцооны аргачлал дээр 128

мал эмнэлгийн үйлчилгээ дээр 245–247

ус хангамж дээр 203

Г (Г, Ж)

жендер, болон эрх мэдлийн динамик 107

жендерт суурилсан хүчирхийлэл 277

жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр

ерөнхий 62

болон ХҮС 71

цаашид унших 74–75

болон малын тэжээл 145

болон малын тоог бууруулах 300

болон малжуулах 334

болон малын байр, байршуулалт 262

болон ХҮХС (ХҮХС) 68

техникийн үйл ажиллагаа 62–63

болон мал эмнэлгийн туслалцаа 220

болон ус хангамж 181

сайн туршлага, нотолгоонд суурилсан 21

хүлэмжийн хийн ялгарал 35

Н (Х)

сүргийн хэмжээ 358–359
 орон сууц, газар, хөрөнгийн эрх (НLP) 264
 ХСТ (Хүмүүнлэгийн стандартын түншлэл) 37,42
 хүний эрүүл мэнд 35–36
 хүний эрх 21
 Хүмүүнлэгийн тунхаг 37–38
 Хүмүүнлэгийн стандартын түншлэл (ХСТ) 37, 42
 Хүний эрүүл мэнд 35–36
 Хүний эрх 21
 Хүмүүнлэгийн charter 37–38
 хүмүүнлэг-хөгжил-энх тайвны уялдаа 36

I (И)

шууд түргэн өгөөж, мал амьтнаа ашиглах замаар 26, 133, 171, 291
 нөлөөллийн үнэлгээ 66–67
 нөлөөллийн үнэлгээ 67, 103
 нөлөөллийн үзүүлэлт 98
 нөлөөлөл
 уур амьсгалын өөрчлөлтийн 56
 онцгой байдлын 32
 болон бууруулах арга хэмжээ 342
 цар тахлын 33, 34
 байгаль орчинд нөлөөлөх байдал хэсгийг харахмөнгөн бус (материаллаг) хувь нэмэр 312
 БМС- INEE (Боловсролын минимум стандарт) 61
 мэдээлэл
 загасны аж ахуй 43
 гэрийн мал амьтан 44
 задаргаа 102
 малын өвчин, шимэгч 43
 малын даатгал 44
 тоон 102
 оролцооны арга болон бусад 101–102
 бүртгэл, дүн шинжилгээ 86
 судлан үзэх 80
 тогтвортой амьжиргаа 40
 техникийн хариу арга хэмжээ 39
 мал эмнэлэг 41
 анхдагч үнэлгээ
 дэмжих нэмэлт арга зүй 107–108
 шалгах хуудас 81, 81–86, 106, 107, 109–110
 цаашид унших 126
 жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр 63
 тойм 79
 оролцооны арга зүй 105
 бэлтгэл 80–81
 мэдээлэл бүртгэх, шинжилгээ хийх 86
 бүртгэлийн маягт 111

даатгал, малын 36
 Дотоодын шилжин суурьшигч (IDPs) 147
 ярилцлагын аргууд 105, 241–242(хор хөнөөл
 учруулагч төрөл зүйл 56
 хөрөнгө оруулалт, ХҮХС 67

К

үндсэн үйл ажиллагаа
 ерөнхий 93
 малын тэжээл
 үнэлгээ/ төлөвлөлт 154–155
 тэжээлийн аюулгүй байдал 158–159
 тэжээх түвшин 157
 бэлэн байдал 151
 малын тоог бууруулахүнэлгээ/төлөвлөлт 304–305
 арилжих зорилгоор малын тоог цөөлөх 307
 бэлэн байдал 303
 хэрэглээнд нядлах 310
 малжуулах
 үнэлгээ/төлөвлөлт 344
 үйл ажиллагааны багцыг тодорхойлох 344–345
 түгээлтийн тогтолцоо 346
 хүлээн авагчийг дэмжих 349
 малын байр, байршуулалт дээр үнэлгээ/ төлөвлөлт 270
 бат бэх хашаа хорооны шийдэл 280
 бэлэн байдал 268
 байршуулалт 276
 малын байр 273
 мал эмнэлгийн тусалцаа үнэлгээ/ төлөвлөлт дээр 228–229
 клиник үйлчилгээ 230–231
 өвчний тандан судалгаа 239
 үхсэн малзайлуулахх 238
 үзлэг эмчилгээ 234
 бэлэн байдал 226
 хүнсний эрүүл ахуй, ариун цэвэр 237
 зооноз өвчин 236
 усан хангамж
 үнэлгээ/төлөвлөлт 188
 бэлэн байдал 186
 уст цэг 190–192
 үс тээвэрлэх 194–196

Л (Л)

газрын хүртээмж 278–279
 газрын эрх 57, 264
 суралцахуй, хуваалцах 66–67, 104
 Хяналт-шинжилгээ, үнэлгээ, эргэн тайлагнал, суралцахуй хэсгийг харах
 эрх зүйн хүчин зүйл, болон мал эмнэлгийн тусалцаа 226–227
 LEGS Зарчмууд 49

Хавсралтууд

ерөнхий 22–23, 48–49
болон ХҮС-ын амлалт 70–72
уур амьсгалын өөрчлөлт уур амьсгалын
өөрчлөлт хэсгийг харах
нутгийн иргэдийн оролцоо нутгийн иргэдийн
оролцоо хэсгийг харах
зохицуулалттай хариу арга хэмжээ
зохицуулалттай хариу арга хэмжээ хэсгийг
харах
жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр 62
амьжиргаанд суурилсан хөтөлбөр
амьжиргаанд суурилсан хөтөлбөр хэсгийг
харах
орон нутгийн удирдах, эзэмших эрхийг
дэмжихорон нутгийн удирдах, эзэмших эрхийг
дэмжих хэсгийг харах
ХҮХС үзэх Хяналт-, үнэлгээ, хариуцлагатай
байдал, суралцахуй
бэлэн байдал/эрт үеийн арга хэмжээ
бэлэн байдал/эрт үеийн арга хэмжээ хэсгийг
харах
LEGS Гарын авлага
Хүмүүнлэгийн үндсэн стандартууд (CHS) 39
үр дүнгээс үүдсэн ялгаа 16
нотолгоонд суурилсан сайн туршлага 21
болон ХСТ 37
хүний эрхийн суурь 38
Хүмүүнлэгийн тунхаг 38
Амьжиргааг дэмжих 20
бусад эх сурвалжууд 16
зориулалт 14
эрх-д суурилсан хандлага 21
болон Сфер гарын авлага 37
хэн ашиглах ёстой 14–15
амьжиргааны хөрөнгө
тодорхойлолт 25
мал амьтан 25
мал хөрөнгө болох нь хэсгийг харах
Амьжиргаа уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө
56 тодорхойлолт 20
мал амьтны үүрэг роль 341
дэмжих 20–21
тогтвортой байдал 40
эмэгтэйчүүдийн 23
Амьжиргааны зорилтууд
ерөнхий 51
үндсэн мал хөрөнгийг хамгаалах 26, 27, 133,
171, 207, 251, 291
үндсэн мал хөрөнгийг сэргээх 26, 27, 133,
171, 207, 323
ухаалаг (SMART) зорилтууд 97
одоо байгаа үлдсэн мал хөрөнгийг ашиглах
26, 133, 171, 291
амьжиргаанд суурилсан хөтөлбөр 48–52
өгөөж 48–51

болон Хүмүүнлэгийн үндсэн стандарт (CSH)
70
цаашид унших 73
хүмүүнлэгийн болон хөгжлийн тусламж 51–52
болон малын тэжээл 143
болон малын тоог бууруулах 298
болон малжуулах 332
болон малын байр, байршуулалт 261
орон нутгийн үйлчилгээ, зах зээл 51
болон ХҮХС 67
болон мал эмнэлгийн тусалцаа 218
болон усан хангамж 179
мал, амьтан
өртсөн иргэд үргэлжлүүлэн эрхлэх 155
амьжиргааны хөрөнгө 25
мал хөрөнгө
худалдан авагчид 308
болон уур амьсгалын өөрчлөлт 35, 55–56
хорогдсон, сэг зэм устгах 238, 314
тодорхойлолт 23
зовиургүйгээр устгах 235
нүүлгэн шилжүүлэх 269, 278
үзлэг, эмчилгээ 214
болон санхүүгийн капитал 50
болон галын аюулгүй байдал 278
болон хүний капитал 50–51
гамшгийн нөлөөлөл 32
даатгал 36
хорогдол 268
масс эмчилгээний хөтөлбөр 210, 215
масс вакцинжуулалтын хөтөлбөр 211, 215
болон сүргийн (ашигт доод) хэмжээ 358
шилжилт хөдөлгөөн 146
хорогдол 107
шилжилт хөдөлгөөн 57
төлсөн үнэ 308, 311
худалдан авалт 346, 353
хангах (малжуулах хэсгийг харах)
хасах (мал цөөлөх хэсгийг харах)
амьжиргаа дахь үүрэг роль 341
аюулгүй байдал 263, 276
сонголт 308, 312, 344–345
Байршуулалт (мал амьтны байршуулалт,
малын хашаа/хороо/ байршуулалт хэсгийг
харах)
хашаа хороо (малын хашаа/хороо/
байршуулалт хэсгийг харах)нийгмийн
капитал 50
тогтвортой суурьшил 279
зорилтот бүлэг 155–156
тээвэрлэлт 348
чөлөөлөх 269–270
хаягдал 57
болон усны чанар 189
мал хөрөнгө болох нь

үлдсэн мал хөрөнгө ашиглахын үр дүн 26, 133, 171, 291
 барих 328, 330, 357
 хамгаалах 26–27, 207, 251, 291
 сэргээн босгох 26–27, 133, 207, 323
 хорогдол нөхөх 326–329, 355
 мал амьтан худалдан авагч 308
 малын өвчин/хортон шимэгч үнэлгээ 228
 гамшгийн үеийн хөтөч 43
 эпидемик буюу цар тахал 208
 болон малжуулах 361
 бууруулах 147
 тандан судалгаа 213–214, 216, 239–240
 халдвар/ дамжих 336
 мал амьтны үзэсгэлэн худалдаа 346–347
 малын зах зээл хэсгийг харах
 малын тэжээл ерөнхий 87, 91, 133
 захэргааны систем 154 үнэлгээ/ төлөвлөлт 154
 эрсдэлтэй бүлэг 145
 өгөөж/ сорилт 137–138, 140, 141
 төсөвлөлт 157–158
 хуаранд 147–148
 шалгах хуудас 161–162
 шийдвэрийн мод 148–149
 тэжээл гаднаас худалдан авах 153
 болон тэжээлийн цэг 139, 156
 өрхөд суурилсан 138–139
 ач холбогдол 27, 134–135
 болон LEGS зарчмууд 143–145
 болон амьжиргааны зорилтууд 133
 орон нутгийн чадавх/даван туулах стратеги 146
 орон нутгийн зах зээл 147
 хяналт-шинжилгээ, үнэлгээ 163–164
 тэжээллэгийн чанар 157
 хангалт баталгаажуулах хувилбар 136–137
 ХСТ-ийн бусад стандарт 142–143
 бусад LEGS бүлгүүд 142–143
 хортон шавж/ өвчин 147
 болон Оролцооны аргаар хариу арга хэмжээ тодорхойлох матриц (ОАХАХТМ) 114, 116, 118
 хангах, БМЭБТ схем 156
 тэжээл нөхөн хангах 158
 аюулгүй байдал 158
 болон баталгаат байдал 153
 худалдан авах/ түгээх 161–162
 цаг хугацаа 141–142
 малын даатгал 44
 малд чиглэсэн үйл ажиллагаа
 хамтын зохицуулалт 60
 бусад үйл ажиллагаа 61
 тусгай үйл ажиллагаа хэсгийг харах
 МАА эрхлэгчид амьжиргааны өөр хэлбэрүүд 25

шилжин суурьшсан 147–148
 орон сууц, газар, өмчийн эрх 264
 гамшгийн нөлөө 32
 орон нутгийн байгаль орчны менежмент 56–57
 нүүдэлч (нүүдлийн аж ахуй хэсгийг харах)
 болон малын байр хангах 253
 баталгаат байдал 277
 тогтвортой суурьшил 279
 төрлүүд 24
 эрсдэлтэй бүлэг, жижиг фермер хэсгийг харах
 мал, амьтны зах зээл
 хяналт-шинжилгээ 303
 тусалцаа 309
 ойлголт 301, 307
 малын үзэсгэлэн худалдаа, худалдан авах газар хэсгийг харах
 малын тоог бууруулах ерөнхий 87, 91, 290–291
 үнэлгээ/төлөвлөгөө 304–306
 өгөөж/ сорилт 295–296
 шалгах хуудас 315–316
 төрлүүдээс сонгох 305
 арилжааны 292–293, 307–310, 315, 317
 зохицуулалтын бүлгүүд 307
 уламжлалт арга ажиллагаа 305 шийдвэрийн мод 301, 302
 эрт үеийн арга хэмжээ 304
 жишээ 125
 болон тэжээл хангамж 136–137, 142 цаашид унших 319
 ач холбогдол 291–292
 институцын нөхцөл байдал 306
 үйл ажиллагааны бүс нутаг 308
 болон LEGS зарчмууд 298
 болон амьжиргааны зорилтууд 291
 хяналт, үнэлгээ 317–318
 болон ХСТ-ийн бусад стандарт 298
 болон бусад LEGS бүлэг 298
 болон Оролцооны хариу арга хэмжээ тодорхойлох матриц 115–118
 худалдан авалт 312
 худалдан авах газар 311
 материал хүлээн авагчид 312
 мал амьтан сонгох 305
 хэрэглээнд нядлах 293–294, 310–316, 318
 нядлах/заазлах 294–295, 316
 техникийн стандартууд 290
 цаг хугацаа 296, 304
 шилжүүлгийн зардал 309
 мал аж ахуйн үйлдвэрлэлийн систем, том хэмжээний 35, 56
 мал амьтны байршуулалт
 ерөнхий 257–258
 үнэлгээ 283
 өгөөж/ сорилт 259

орон зайн өөрчлөгдөж буй хэрэгцээ 281
тодорхойлолт 251
тойм 276–280
малын байр, байршуулалт хэсгийг харах
Малын байр, байршуулалт 273–276
ерөнхий 255–256
үнэлгээ 282
өгөөж/ сорилт 258
болон уур амьсгалын 255, 274, 285–286
нутгийн иргэд 256
дизайн 274
гамшгаас ангид 273
болон байгаль орчны доройтол 274
болон орон нутгийн зах зээл 264
болон баталгаат байдал 263
тогтвортойд шилжих 275, 280–281
малын байр, байршуулалт хэсгийг харах
малын байр, байршуулалт
ерөнхий 27, 87, 115, 118, 251
үнэлгээ/ төлөвлөлт 270–272
өгөөж/ сорилт 258–259
шалгах хуудас 282–283
шийдвэрийн мод 265, 266
шилжин суурьшсан болон суурьшаагүй хүн ам
254–255
цаашид унших 287
ач холбогдол 252
болон LEGS зарчмууд 261–263
амьжиргааны зорилтууд 252
малын хорогдол 268–269
хяналт, үнэлгээ 284
хувилбарууд 254
болон ХСТ-ийн бусад стандарт 261
болон LEGS бусад бүлэг 260–261
болон бэлэн байдал 268–270
Оролцооны аргаар хариу арга хэмжээг
тодорхойлох матриц (PRIM) 115, 118
техникийн хувилбарууд 91
цаг хугацаа 259–260
малын байршуулалт, малын байр
мал, малжуулах
ерөнхий 87, 91, 323
үнэлгээ/ төлөвлөлт 341–343
өгөөж/ сорилт 329–330
шалгах хуудас 352–353
шийдвэрийн мод 338–339
үйл ажиллагааны багц тодорхойлох 344–345
түгээлтийн систем 346
жишээ 27
цааш унших 360
нөлөөлөл, бууруулах арга хэмжээ 342
ач холбогдол 324–325
болон LEGS Зарчмууд 332
болон амьжиргааны зорилтууд 323–324
болон сүргийн ашигтай доод хэмжээ 358–359

хяналт-шинжилгээ, үнэлгээ 354–357
малчин бус талууд 343
болон ХСТ-ийн бусад стандарт 331
болон LEGS бүлгүүд 331
болон Оролцооны хариу арга хэмжээ
тодорхойлох матриц 115, 117
хүлээн авагч 335, 345–346
цаг хугацаа 330–331, 348
мал амьтанд суурилсан арга хэмжээ
нэмэлт 24, 25
үзэх тодорхой мал амьтанд суурилсан арга
хэмжээ
мал аж ахуй эрхлэгч иргэд
онцгой байдлын нөлөөлөл 32
сөрөн тэсвэрлэх 33
дэмжлэг 20
орон нутгийн чадавх 70, 88, 146, 152
орон нутгийн зах зээл
ерөнхий 51
хөндлөнгийн 147
болон малын байр 264, 272
мал амьтны зах зээл хэсгийг харах
Орон нутгийн өөрөө удирдах, эзэмших эрхийг
дэмжих ерөнхий 64
болон Хүмүүнлэгийн үндсэн стандарт 70
цаашид унших 75
дэмжлэг үзүүлэх LEGS хандлага 65
болон малын тэжээл 145
болон малын тоог бууруулах 301
болон малжуулах 334
болон малын байр, байршуулалт 263
болон ХҮХС 68
өмнөх туршлага 64
мал эмнэлгийн туслалцаа 220–221
болон ус хангамж 181
орон нутгийн үйлчилгээ 51
нутагшуулах үзэл баримтлал 64
логистик
бусад салбартай зохицуулалт хийх 61
тэжээлийн цэгийн 162
ус тээврийн 196

М (М)

менежментийн систем, усны нөөцийн 189, 194
зураглал 105
зах зээлийн шинжилгээ 126–127
масс эмчлэх хөтөлбөр 210–211
масс вакцинжуулах хөтөлбөр 211
матрицын оноо 106
ХҮХС Хяналт, үнэлгээ, хариуцлага, суралцахуй
хэсгийг харах
Мах
түгээлт 312
шинэ болон хатаасан 313
хяналт шалгалт 237

Зах зээлийн шинжилгээний минимум стандарт (MISMA) 297, 298
 Хүүхэд хамгааллын минимум стандарт (CPMS) 61
 Боловсролын минимум стандарт (INEE) 61
 MISMA (Зах зээлийн шинжилгээний минимум стандарт) 297, 298
 Эрдэст шахмал тэжээл (multi-nutrient blocks) 136, 153
 хөдөлгөөнт мөнгө 121, 311
 хэлбэрүүд 94
 хяналт-шинжилгээ
 ерөнхий 66–67
 гамшгийн хариу арга хэмжээний төлөвлөлт 103
 мал амьтны нөхцөл байдал 304
 малын тэжээл 163
 мал амьтны зах зээл 303
 малын тоог цөөлөх 310, 317
 малжуулах 354–357
 малын байр, байршуулалт 284
 мал эмнэлгийн туслалцаа 243
 ус хангамж 201
 Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хариуцлага, суралцахуй хэсгийг харах
 Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хариуцлагатай байдал, суралцахуй 66–68
 ерөнхий 99
 өгөөж 66
 болон ХҮС 71
 болон иргэдийн оролцоо 67
 хариу арга хэмжээний төлөвлөлтийн 99–104
 цаашид унших 75, 127
 жендерийн мэдрэмжтэй хөтөлбөрийн 68
 нөлөөллийн үзүүлэлтүүд 100
 хэрэгжилтийн 67
 болон малын тэжээлийн 145
 болон мал тоог цөөлөхөд 301
 болон малжуулахад 334
 болон малын байр, байршуулалт 263
 болон орон нутаг өөрөө удирдах, эзэмших 68
 болон бусад LEGS зарчмууд 67–68 оролцооны аргууд 101–102
 үйл явцын үзүүлэлтүүд 100
 ухаалаг (SMART) зорилтууд 99–100
 болон мал эмнэлгийн туслалцаа 221
 болон ус хангамж 182
 эрдэст шахмал тэжээл (MNBs) 136, 153

N (Н)

хэм хэмжээ, соёлын/ нийгмийн 233
 тэжээллэг 107
 шимт чанар 157, 161

O (О, Ө)

өндөр настан 54
 Нэг эрүүл мэнд хандлага 35–36

P (П)

цар тахал 33–34, 41
 оролцооны үнэлгээ, мал эмнэлгийн тусламж 229
 оролцооны зураглал 241
 оролцооны аргачлал
 сонголтот арга хандлага 102
 цаашид унших 128
 анхдагч үнэлгээ 105–107
 бусад өгөгдөл 101–102
 Оролцооны аргаар хариу арга хэмжээ тодорхойлох матриц (PRIM) 70, 88, 89, 112–118
 Зорилтот бүлгийг оролцоотойгоор тогтоох 98
 түншлэл, малын тоог цөөлөх 308
 бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч ерөнхий 24
 болон БМЭБТ 95
 болон малын шилжилт хөдөлгөөн 146
 болон малжуулах 326–327, 329, 355 vs. жижиг фермерүүд 335
 хувийн аюулгүй байдал
 малын тэжээл 153
 мал аж ахуй эрхлэгчийн 277
 болон малын тоог цөөлөх 306
 болон малжуулах 335
 малын байр, байршуулалт 263
 болон Сфер хамгааллын зарчим 69
 мал эмнэлгийн ажилтнуудын 221, 233
 ус хангамжийн 182, 191, 198
 хортон шавж, малын өвчин/хортон шимэгч хэсгийг харах
 хувь тэнцүүлсэн (пропорцоор тооцсон) 106, 110
 бодлого/ нөлөөллийн нөхцөл байдал 154, 226
 урьдчилсан төлбөрт карт 120
 бэлэн байдал/эрт үеийн арга хэмжээ ерөнхий 58–59
 болон Хүмүүнлэгийн үндсэн стандарт 70–71
 гамшгийн эрсдэлийн удирдлагын мөчлөгт 28
 цааш унших 74
 ирээдүйн гамшгийн 350
 малын тэжээл 144, 151–154
 малын тоог цөөлөх 300, 303–304
 малжуулах 333
 малын байр, байршуулалт 262, 268–270
 мал эмнэлгийн туслалцаа 212, 219, 226–228
 усан хангамж 180
 үнэ, мал амьтны 308, 311
 PRIM (Оролцооны аргаар хариу арга хэмжээ тодорхойлох матриц) 70, 88, 89, 112–118
 үйл явцын үзүүлэлт 100

Хавсралтууд

худалдан авалт, мал амьтны 312, 346, 353
Хамгааллын зарчмууд 37–38
Удааширсан гамшиг/ онцгой байдал 28, 31
хангалт/ нийлүүлэх
мал амьтан, малын усан хангамж хэсгийг
харах
Ус, Ус хэсгийг харах
олон нийтийн мэдлэг, хүнсний аюулгүй
байдлын 237–238
нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, малын
суурьшлын 279–280
нийгмийн эрүүл мэндийн эрсдэл, малын тоог
цөөлөхөөс үүсэх 313–314
төрийн мал эмнэлгийн чиг үүрэг
ерөнхий 208–209, 211–212
өгөөж/ сорилтууд 216
худалдан авах газар, малын тоог цөөлөхөд
311
мал амьтны зах зээл хэсгийг харах

Q (К)

Чанарын хяналт, тэжээлийн 159
чанарын шалгуур 70–72
чанар, усны 189, 196
тоон судалгаа 102

R (P)

эрэмблэх арга зүй 106
гэнэтийн гамшиг 28, 30–32, 112, 114, 269
хүлээн авагч
мал, амьтан
нэмэлт тусламж 349–351
шалгах хуудас 353
сонгон авах 335–336, 336
малын тоог цөөлснөөс гарах мах 312
дахин түгээлтийн систем 347–348
тайлагнах, өвчний тандан судалгаанд 240
сөрөн тэсвэрлэх чадвар 33
сөрөн тэсвэрлэх чадварын үнэлгээ 33
нөөц эх үүсвэр, LEGS гарын авлага 16
хариу арга хэмжээг тодорхойлох
тойм 87
болон Оролцооны аргаар хариу арга хэмжээ
тодорхойлох матриц 88–90
хариу арга хэмжээний хэлбэр, болон БМЭБТ
119
арга хэмжээний төлөвлөгөөний агуулга 98
малын тоог цөөлөх жишээ 125 тойм 96
ухаалаг (SMART) зорилтууд 97
маягт 124
өөрчлөлтийн онол 96–97 малжуулах үзэх
малжуулах
эрхэд суурилсан хандлага 21
ерсдэлийн үнэлгээ 268

S (C)

аюулгүй байдал
малын тэжээлийн
шалгах хуудас 161
болон чанарын хяналт 159
болон эрсдэлийн үнэлгээ 159
болон ариун цэвэр эрүүл ахуйн журам 159–
160
үзэх хувийн аюулгүй байдал, аюулгүй байдал
дээж, Оролцооны аргаар хариу арга хэмжээ
тодорхойлох матриц 114–118
дээж авах 102
эрүүл ахуйн журам 159, 237
оноо өгөх арга 106
SEADS (Онцгой байдлын үед тариаланд
суурилсан амьжиргааг дэмжих стандарт) 24,
61
аюулгүй байдал
мал, амьтны 263, 276
үзэх personal security, safety selection
мал амьтны 308, 344
мал хүлээн авагчийн 345–346
мал цөөрүүлж, мах хүлээн авагчийн 312
бие даан шилжих 55
хашаа хороо, орон байр
хүний 351
мал амьтны үзэх малын хашаа хороо/
суурьшил
нядалгаа
хэрэглээний 293, 310, 315–316, 318
захэран зарцуулах 316
тоног төхөөрөмж 314
байгууламжууд 237
арга зүй 313
хаягдал 314
удаан явцтай гамшиг 28, 29, 31–32, 113, 116
жижиг фермерүүд 24, 327–329, 335, 356
ухаалаг карт 120
ухаалаг (SMART) зорилтууд 97, 99, 125
худалдан авах, тэжээл 161
Сфер сан 37, 49, 69–72
Sphere Гарын авлага 37
стандартууд үзэх техникийн стандартууд
Онцгой байдлын үед тариаланд суурилсан
амьжиргааг дэмжих стандарт (SEADS) 24, 61
нөөцлөх 153
нийлүүлэх маршрут, ус тээврийн 197
тогтвортой амьжиргаа 40, 272

T (T)

зөөврийн цистерн 196
техникийн үйл ажиллагаа 49, 90
шийдвэрийн мод 93
жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр болон 62–
63

хувилбарууд, тойм 92
 тойм 90–91
 практик зөвлөгөө 39–40
 стандарт болон удирдамжууд 93 тойм 91
 цагалбар хүснэгт 92–93
 техникийн стандартууд
 малжуулах 322
 малын тэжээлийн 132
 малын хашаа хорообайршуулалтын 250
 тойм 129
 мал эмнэлгийн үйлчилгээний 206
 усны 170
 стандартын тусгай субъект хэсгийг харах
 Загвар , Оролцооны аргаар хариу арга хэмжээ
 тодорхойлох матриц 112–113
 өөрчлөлтийн онол 96–97
 хугацаа, түүхэн 105
 цаг хугацаа
 ерөнхий 92
 хавсарсан арга хэмжээ 375
 малын тэжээл 141
 мал тоог цөөлөх 296–297, 304
 малжуулах 330–331, 348
 малын байр/ байршуулалт 259
 масс вакцинжуулалтын хөтөлбөрийн 211
 мал эмнэлгийн туслалцаа 216–217
 ус хангамжийн 177
 сургалт, мал ахуйн 350
 шилжүүлгийн зардал, малын тоог цөөлөхөд
 309
 тээвэр төлөвлөлт, малжуулахад 348–349
 цунамигийн нөлөөллийг бууруулах 269

U (Y, YU)

хот суурин болон хот орчмын 257–258

V (B)

вакцин 211
 Венн диаграмм 105
 малын эмч 234–235
 мал эмнэлгийн үзлэг 239
 малын эм
 мэдээлэл 41
 худалдан авалт, хадгалалт 232
 хамгаалал 233
 нийлүүлэлт 244
 хангалт, чанар, хадгалалт 228
 мал эмнэлгийн техникч 209, 222, 230, 234
 мал эмнэлгийн ажилтан 221, 232–233
 мал эмнэлгийн нийтийн эрүүл мэнд 36, 212–
 213, 216
 мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч 227, 229–
 230
 мал эмнэлгийн тусламж дэмжлэг
 ерөнхий 27, 57, 87, 91, 114–115, 206–207, 345

олон нийтийн хүртээмж 221
 үнэлгээ/төлөвлөлт 228–230
 өгөөж/ сорилтууд 214–216
 шалгах хуудас 241–242
 клиник мал эмнэлгийн үйлчилгээ 209–211
 шийдвэрийн мод 224–225
 дизайн 227, 243
 үзлэг, эмчилгээ 210, 234–235
 уян хатан санхүүжилт 227
 цаашид унших 245–247
 ач холбогдол 208
 болон LEGS зарчмууд 218–221
 болон амьжиргааны зорилтууд 207–208
 урт хугацааны 350
 хяналт-шинжилгээ, үнэлгээ 243–244
 болон бусад ХСТ-ийн стандартууд 217
 болон бусад LEGS бүлгүүд 217–218
 болон бэлэн байдал 212, 226
 урьдчилан сэргийлэх 349
 эрэмбэлэх 212
 төрийн мал эмнэлгийн чиг үүрэг 211–214
 үйлчилгээ үзүүлэгчид 227
 хугацаа 216–217
 болон мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэнд
 212
 мал эмнэлгийн сургалт 244
 дүрсжүүлэх арга зүй 105
 галт уулын нөлөөлөл 269
 эрхийн бичиг
 БМЭБТ харах

W (B)

ус
 эрэлтийн үнэлгээ 190
 зөрчилдөөн 182
 цаашид унших 203
 болон амьжиргааны зорилтууд 171
 болон хувийн аюулгүй байдал 182, 191
 ханган нийлүүлэх
 ерөнхий 27, 87, 91, 170–171, 173
 хангалттай байдал 190–191
 үнэлгээ/ төлөвлөлт 188–189
 өгөөж/ сорилтууд 175–177
 шийдвэрийн мод 183, 184
 байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл 187
 ач холбогдол 172–173
 болон LEGS зарчмууд 179–182
 хяналт-шинжилгээ, үнэлгээ 201
 болон бусад ХСТ-ийн стандарт 178–179
 болон LEGS бусад бүлэг 178
 болон бэлэн байдал 186–187
 болон Оролцооны аргаар хариу арга хэмжээ
 тодорхойлох матриц (PRIM) 114, 116, 118
 цаг хугацаа 177–178
 ус зөөвөрлөх байдлаар

Хавсралтууд

ус тээвэрлэх хэсгийг харах
чанар 189, 196
эх үүсвэр
одоогийн эх үүсвэр ашиглан хувилбаруудад
шинжилгээ хийх 188
бохирдол 189
боловсруулах 187
хүний хэрэглээний 189, 195–196
менежментийн тогтолцоо 186–187, 189
зураглал хийх 186
уст цэг 190–191, 194
уст цэг
шалгах хуудас 199–200
болон зардал нөхөх 193, 203
байршил 190
менежментийн бүтэц 194, 202
сэргээх/ байгуулах 191–194
ерөнхий 173–174
өгөөж/ сорилт 175–176
хэрэгцээ 192–193
тохёрох байдал 192
техникийн үндэслэл 193

хариуцлага 193–194
ус тээвэр
ерөнхий 174–175
богино хугацааны арга хэмжээ байдлаар
194–195
үргэлжлүүлэх боломжийн үнэлгээ 195
өгөөж/сорилтууд 177
түгээлтийн цэг 198
логистик болон түгээлт 196–198 үйлчилгээ,
шатахуун хангамж 197
хөдөлгөөнт мал амьтан 198
эх үүсвэр ба чанар 194–196
ашигласан эх үүсвэр 195
ажилтан, боловсон хүчин 197
татаас олгох 198
болон хангалтын маршрут 197
ажлын мал амьтан 23–24
мал амьтан хэсгийг харах

Z (З)

зооноз өвчин 33–34, 208, 212–213,
236–237, 277

МАН-н онцгой байдалд баримтлах заавар, стандартууд



МАН-н онцгой байдалд баримтлах заавар, стандартууд (LEGS) хэмээх гарын авлага нь хүмүүнлэгийн хямралд өртөөд буй мал аж ахуй эрхлэгч нутгийн иргэдэд төвлөрсөн баримт бичиг юм. Нотолгоонд суурилсан сайн туршлага багтаасан энэхүү гарын авлага нь онцгой байдлын үйл ажиллагааг загварчлах, төлөвлөх чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүдэд туслах зорилготой.

Онцгой байдлын үед тэжээл, ус, мал эмнэлгийн тусламж, малын байраар хангах, малын тоог бууруулах болон малжуулах гэсэн мал хөрөнгийг хамгаалан үлдээх зургаан гол үйл ажиллагаа байдаг. Нэрвэгдэж буй иргэдийн амьжиргааг хамгаалахын тулд эдгээл үйл ажиллагаа нь тохиромжтой, зохистой, цагаа олсон байх ёстой. LEGS гарын авлага нь анх 2009 онд хэвлэгдэн гарснаас хойш мал, амьтны хорогдол үүсгэх онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чанар, нөлөөллийг сайжруулахад хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Өргөн хүрээнд явагдсан олон нийтийн зөвлөлдөх үйл явцын үр дүнд LEGS стандартууд, үндсэн үйл ажиллагаа, удирдамжуудыг шинэчлэн, энэхүү хэвлэлтэд тусгасан. Гарын авлагын үндэслэл болж буй LEGS Зарчмууд дээр төвлөрч, 2014 онд гарсан хоёр дугаар хэвлэлтээс хойш үүссэн асуудлууд дээр LEGS хэрхэн хандах талаар тайлбарыг багтаасан.

Алхам алхмаар нь тусгасан зөвлөмж, удирдамжууд нь онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахад LEGS арга хэрэгслийг хэрхэн ашиглахыг тусган харуулсан. Гарын авлага нь гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, сэргээн босголтын чиглэлээр ажиллаж буй мал аж ахуйн чиглэлийн мэргэжилтнүүд, хүмүүнлэгийн ажилтнуудын хөтөч болно.

Хүмүүнлэгийн стандартын түншлэл (HSP) нь баримт нотолгоо экспертийн дүгнэлт, сайн туршлагуудыг бататгах замаар хүмүүнлэгийн хариу арга хэмжээний чанар, эргэн тайлагнах байдлыг сайжруулах зорилго бүхий стандартын санаачилгуудын хамтын ажиллагаа юм.



**Practical
ACTION
PUBLISHING**

ISBN 978-1-78853-246-4



9 781788 532464

